Кур'ан-и Кэримийн Туяанд
Пайгамбарчуудын Цуваа

Хазрат-и Мухаммед Мустафа

-Саллаллаху Алэйхи вэ Сэллэм-

Осман Нури Топбаш

2 [medina period]

ЭРКАМ НИЙТЛЭЛ

Истанбул 2012 / 1433

© Эркам Нийтлэл 2013 / 1433

Эркам Нийтлэл
İkitelli Organize Sanayi Bölgesi Mahallesi
Atatürk Bulvarı Haseyad 1.Kısım No:60/3-C
Başakşehir / Истанбул, Түрк Улс
Утас: (90-212) 671-0700 pbx
Факс: (90-212) 671-0717
E-mail: worldpublishingscom@gmail.com
Web site: www.islamicpublishing.net

ISBN :

Номын Түрк хэлний эхний жинхэнэ нэр:
Hazreti Muhammed Mustafa (Medine Devri) – 2 [Moğolca]

Зохиолч нь : Осман Нури Топбаш
Найруулсан нь : Нямын Заяа
Хавтас : Расим Шакироглу
Хэвлэсэн газар : Расим Шакироглу (Wordgraphics)
Хэвлэсэн газар : Эркам хэвлэл

Кур’ан-и Кэримийн Туянд
Пайгамбарчуудын Цуваа

Хазрат-и Мухаммед Мустафа

-Саллаллаху Алэйхи вэ Сэллэм-

- 2 -

Осман Нури Топбаш

ЭРКАМ НИЙТЛЭЛ

Аллах Таала айлдана:

وَمَا أَرْسَلْنَاكَ إِلَّا رَحْمَةً لِّلْعَالَمِينَ

“Расул минь! Бид Чамайг орчлонгуудад рахмат болох тулд л илгээв.” (эл-Энбияа, 107)

لَقَدْ جَاءكُمْ رَسُولٌ مِّنْ أَنفُسِكُمْ عَزِيزٌ عَلَيْهِ مَا عَنِتُّمْ حَرِيصٌ عَلَيْكُم بِالْمُؤْمِنِينَ رَؤُوفٌ رَّحِيمٌ

“Тангараглая, танд таны дундаас нэгэн Пайгамбар ирсэн нь, таны хувьд бэрхшээлтэй тааралдсан нь Түүнд маш хэцүү санагдана. Гэвч тэр танд дуртай, итгэгчдэд маш их халамжтай, энэрэлтэй нэгэн мөн.” (эт-Тавба, 128)

قُلْ إِن كُنتُمْ تُحِبُّونَ اللّهَ فَاتَّبِعُونِي يُحْبِبْكُمُ اللّهُ وَيَغْفِرْ لَكُمْ ذُنُوبَكُمْ وَاللّهُ غَفُورٌ رَّحِيمٌ

“Расул минь! Ингэж хэл: Хэрэв Аллахад хайртай байвал намайг дагацгаа, тэгвэл Аллах ч таныг хайрлаж нүглийг тань өршөөнө. Аллах нь хэтэрхий өршөөгч ба хамгаалагч мөн.” (Ал-и Имран, 31)

قُلْ أَطِيعُواْ اللّهَ وَالرَّسُولَ فإِن تَوَلَّوْاْ فَإِنَّ اللّهَ لاَ يُحِبُّ الْكَافِرِينَ

“Ингэж хэл: Аллах болон Элчийнх нь үгэнд орцгоо. Хэрэв эргэвэл, Аллах кафирчуудад дургүйг мэдэцгээг.” (Ал-и Имран, 32)

مَّا كَانَ مُحَمَّدٌ أَبَا أَحَدٍ مِّن رِّجَالِكُمْ وَلَكِن رَّسُولَ اللَّهِ
وَخَاتَمَ النَّبِيِّينَ وَكَانَ اللَّهُ بِكُلِّ شَيْءٍ عَلِيماً

“Мухаммед нь таны хэний ч аав биш. Гэхдээ Тэр нь Аллахын Элч ба пайгамбаруудын сүүлч юм. Аллах бүгдийг ёсоор нь мэдэгч мөн.” (эл-Ахзаб, 40)

وَالَّذِينَ آمَنُوا وَعَمِلُوا الصَّالِحَاتِ وَآمَنُوا بِمَا نُزِّلَ عَلَى مُحَمَّدٍ
وَهُوَ الْحَقُّ مِن رَّبِّهِمْ كَفَّرَ عَنْهُمْ سَيِّئَاتِهِمْ وَأَصْلَحَ بَالَهُمْ

“Итгэж үнэмшээд зөв үйл хийгчдийн, Раббынхаа үнэнээр нь Мухаммедад буулгасанд итгэгчдийн нүгэлийг Аллах далдалсан ба байдлыг нь зассан байдаг.” (Мухаммед, 2)

Расулаллах -саллалахү алэйхи вэ сэллэм- айлдана:

“Би танаас Кэвсэрийн шалбаагт анх хөл тавихад чинь таныг тэнд угтана! Тантай уулзах газар маань энэ Шалбааг мөн. Би одоо түүнийг харж байна. Би таны тухай гэрчилнэ. Одоо надад газрын сан баялгийн түлхүүрүүдийг гардуулж өгөв. Валлахий таныг надаас хойш мүшрикийн замд буцаахаас айхгүй. Гэтэл би таныг дэлхийн хүслэнд автаж нэг нэгэндээ атаархаж, нэг нэгийгээ алдаг танаас өмнөх үеийнхэн үгүй болж одсон шиг та ч үгүй болж одно гэж айна!” (Бухарий, Жэнаиз, 73; Мүслим, Фэдаил, 31)

“Намайг танаас өмнө очоод таныг хүлээж байхыг сайн мэдэцгээ. Анхаарцгаа; (маргааш ахиратад) тантай уулзах газар маань Кэвсэр Шалбааг юм. Маргааш надтай уулзахыг хүсэгчид гар болон хэлээ нүгэлээс татаг!” (Бухарий, Салат, 80; Ибн-и Са’д, II, 227)

ХИЖРЭТИЙН АНХНЫ ЖИЛ

Расулаллах Мадина-и Мүнэввэрэд Анх Суурьшсан нь

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Мадинад нүүснээр Ислам болон мусульманчуудын хөгжлийн нэгэн шинэ шат ба түүхийн шинэ эрин эхэлсэн юм.

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- Мадинад дүрвэгч цагаач байгаагүй. Харин эсрэгээр Тэр ирээдүйн дэлхийн тэргүүн архитектор, удирдагч, шинээр байгуулсан Ислам Гүрний тэргүүн, товчдоо бүх юмны эзэн байв. Түүний Мадинад суурьшсан нь Исламыг тэблиг ба мусульманчуудын хандлагад том хүч болов.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь “Мэсжид-и Нэбий”г барьтал Эбү Эйюб эл-Энсарий -радъяллахү анх-ын гэрт долоон сар зочин болов. Расулыг хүндэт зочин болгон хүлээн авсан Эбү Эйюб эл-Энсарий Хазратын гэрт ингэж зочлох нь хэдэн зууны өмнө нэг тохиолдсон байв:

Долоон зуун жилийн өмнө, Мадинад (тэр үеийн нэрээр Есрибт) ирсэн Йемений эздээс Түбба’ Эбү Кэриб нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн Маккад илэрч Мадинад нүүхийг нь Еврей эрдэмтдээс мэдэж аваад тэнд нэгэн байр бариулжээ. Бас нэгэн захидал бичээд алтан тамгаар тамгалсны дараа Мадинагийн эрдэмтдээс хамгийн томд нь гардуулж,

өөрөө хүрч чадахгүй бол үе үеэр залгамжлуулан Орчлонгийн Эзэнд өргөхийг тушаав.[1]

Түбба' нь тэр үеэс Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д итгэж мусульман болсон байв.[2]

Уг гэр нь аавaас хүүд залгамжлуулан Мадинагийн эрдэмтдээс нэгний удам асан Эбү Эйюб Халид бин Зэйд -радъяллахү анх-ад хүрсэн байв. Тэр ариун гэр нь Мэсжид-и Нэбэвийгийн дорнод талд байв.

Түбба'гийн захидлыг хадгалсан хүмүүс нь Аллахын Элчийн Мадинад ирж буйг мэдээд, захидлыг Түүнд хүргэхээр Сүлэйм аймгийн итгэмжтэй хүн Эбү Лэйлаг илгээв. Эбү Лэйла нь Маккагийн замд Пайгамбар Эзэн -саллаллахү алэйхи вэ сэллэм-тэй таарaлдав. Аллахын Элч түүнийг хармагц дуудаад:

"–Чи Эбү Лэйла, мөн үү?" хэмээн асуув.

Эбү Лэйла:

"–Тийм!" гэхэд нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Чамд Түбба'гийн захидал бий! Тэр захидлыг нааш аваад ир!" хэмээв.

Эбү Лэйла нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэмийг танихгүй тул Ихээр гайхаж:

"–Чи хэн бэ? Би чиний царайнаас илбэчний шинж тэмдэг харахгүй байна. Чи надад захидал буйг яаж мэдээ вэ?!" гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

1. Ибн-и Асакир, III, 334-335; Сэмхүдий, I, 188-189.
2. Ахмад, V, 340.

"–Би Мухаммед мөн! Авчирсан, захидлыг надад өг!" хэмээв.

Эбү Лэйла нь захидлыг далдаас гаргаж Пайгамбар Эзэнд маань өргөн барив. Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх- захидлыг уншихад, Орчлонгуудын Эзэн гурван удаа:

"–Мэрхаба салих дүү Түбба'!" хэмээв.

Эбү Лэйлад ч Мадинад буцахыг нь тушаав. Эбү Лэйла нь Мадинад эргэж, тэдэнд Оршигчдын Туяаг ирж буйг мэдээлэв. Мадиначууд хүн бүр энэ мэдээг сонсоод түүнийг дайлав.[3]

Михмандар-и Расул: Эбү Эйюб эл-Энсарий -радъяллахү анх-

Пайгамбарчуудын Хааныг гэртээ долоон сарын турш зочлуулах завшааныг хүртсэн Эбү Эйюб эл-Энсарий -радъяллахү анх- нь эхэнд Аллахын Элчийг гэрийн дээд давхарт суухыг хэдий их хүссэн ч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эзэн маань:

"–Аяа Эба Эйюб! Гэрийн доод давхарт байх нь надад илүү зохимжтой," хэмээгээд доод давхарт суув.

Хүндэт зочин Аллахын Элчдээ ижилгүй хайр ба хүндэтгэлээр үйлчилсэн Эбү Эйюб -радъяллахү анх- болон гэрийнхэн нь Пайгамбар Эзэнтэй маань зэрэгцэж хэвтэхээс эмээсэндээ гэрийн хаяа руу хананд шахан унтдаг байв.

Нэгэн өдөр тэдний ваар хагарч ус нь шал дээр асгарав. Хүндэт зочноо ус хүргэж цочоохоос айж сандарсан Эбү Эйюб Хазрат нь шууд өөрийн хилэн хөнжлөөрөө шалыг арчжээ. Өглөө босоод Оршигчдын Туяа -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг дээд давхарт гарахыг хэдэн дахин гуйв. Расулаллах Эзэн маань:

3. Ибн-и Асакир, III, 335; Айний, IV, 176.

“–Доод давхар нь илүү зохимжтой!” хэмээн хэлсэн ч Эбү Эйюб -радъяллахү анх-:

“–Таныг доод давхарт байхад бид дээд давхарт гарч чадахгүй!” гэв. Тэгэхлээр нь газраа солилцов.[4]

Эбү Эйюб эл-Энсарий болон гэрийнхэн нь Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг зочин болгосон өдрүүдэд хоол хийж Түүнийг дайлдаг байв. Хоолны үлдсэн хэсгээс, Орчлонгуудын Эзний хуруугаараа барьсан эсэхийг хайж, идсэн үгүйг мэддэг байв. Нэгэн удаа сонгино, сармистай хоол хийж, харин Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь идээгүй байв. Эбү Эйюб -радъяллахү анх- нь хоолонд Эзний гар хүрээгүйг анзаарч, санаа зовж хажууд нь очоод:

“–Аяа Расулаллах аа! Тэр хоол нь харам юм уу?” гэж асуув.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Үгүй үгүй! Харин үнэр нь таалагдаагүй. Учир нь би мэлэкчүүдтэй ярьдаг,” хэмээв.

Тэгэхлээр нь Эбү Эйюб -радъяллахү анх-:

“–Таны дургүй юмд би ч дургүй!” гэв.

Гэтэл Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Та түүнийг идээрэй!” хэмээв.

Үүнээс хойш Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм-д тийм ногоотой хоол дахиад хийгээгүй. [5]

4. Мүслим, Эшрибэ, 171; Ибн-и Хишам, II, 116.

5. Мүслим, Эшрибэ, 170-171; Ибн-и Хишам, II, 116.

Энэ байдал нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хүмүүсийг ба мэлэкчүүдийг хэзээ ч үймүүлээгүй тухай эелдэг сайхан зангийн маш гоё илэрхийлэл юм.

Эбү Эйюб эл-Энсарий Хазратын Аллахын Элчид үйлчлэх нь Пайгамбар Эзний маань зочлох хугацаа дууссаны дараа ч үргэлжлэв. Энэ үүднээс, гагцхуу Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн:

"Истанбулыг заавал эзэлж авна; түүнийг эзэлсэн дарга нь ямар гоё дарга вэ, түүнийг эзэлсэн цэрэг ямар гоё цэрэг вэ!" (Ахмад, IV, 335; Хаким, IV, 468/8300) хэмээсэн мэдээллийн үе ирэхэд ная гаруй настай байхдаа хоёр удаа Истанбулын бүслэлтэд оролцсон, дараа нь хэрэгжих ялалтын анхны цэргээс болоод бууж өгсөн байв. Нас барахаасаа өмнөхөн, түүний дараа эзлэхээр ирэх Исламын цэрэгт ариун шарилаараа ч зорилгоо үзүүлэхээр эргэн тойрныхондоо:

"–Шарилыг минь хөл гишгэсэн эцсийн цэгт булаарай!" гэж хэлэв. [6]

Энэс бин Малик -радъяллахү анх- Манай Эзэнд Үйлчилсэн нь

Энэс -радъяллахү анх- ярихдаа:

"Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Мадинад ирэхэд нь миний хойд аав Эбү Талха түүний гарыг бариад намайг Аллахын Элчид аваачиж:

«–Аяа Расулаллах аа! Энэс ухаантай хүүхэд, танд үйлчлэг!» гэв. Ингээд би Расулаллахын үйлчлэгч болов. Гэрт ба аян замд арван жил үйлчилжээ. Валлахи миний хийсэн ямар нэгэн алда-

6. Хар. Ибн-и Са'д, III, 484-485.

анаас болж: «Яагаад ингээ вэ?» эсвэл хийгээгүй ажлаас болж: «Үүнийг яагаад хийгээгүй вэ?» гэсэн удаагүй юм.” (Мүслим, Фэдаил, 52)

Өөр нэгэн ярианд Хазрат-и Энэсийн Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн үйлчлэгч болсон тухай ингж байдаг:

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Мадинад ирэхэд эр-эмгүй хамаг олноороо Түүнд зарим нь бэлэг барьж бас зарим нь дайлж байв. Үммү Сүлэйм өгөх юмгүй тул санаа зовоод байв. Дараа нь хүү Энэсийнхээ гарыг барьж Аллахын Элчид өгөөд:

“–Аяа Расулаллах аа! Энэс танд үйлчилбэл та зөвшөөрөх үү?” гэв. Пайгамбар Эзэн маань ч хүлээн зөвшөөрөв. (Сэмхүдий, I, 271)

Энэс -радъяллахү анх- ингэж ярьжээ:

“...Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэг өдөр намайг нэг газар луу явуулсан юмсан. Би : «Валлахид явахгүй,» гэлээ. Харин үнэндээ дотроо явахаар шийдсэн байсан. Учир нь тушаал өгсөн нь Аллахын Нэбий байв. Замд гараад, гудамжинд тоглож байсан хүүхдүүдийн дэргэд очоод нэлээд уджээ. Гэтэл Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- хойноос минь ирээд хүзүүг минь барив. Намайг эргээд харахад Тэр мишээж байв.

«–Энэс минь! Миний хэлсэн газар очив уу?» хэмээн асуув. Би:

«– Одоо шууд очлоо аяа Расулаллах!» гэлээ.” (Мүслим, Фэдаил, 54)

Энэс -радъяллахү анх- өөр нэгэн дурсамжаа бас ингэж ярьдаг:

"Нэгэн өдөр, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д үйлчилсний дараа: «Пайгамбарыг зүүрмэглэж байна гэж бодоод» гарч хүүхдүүдийн дэргэд очлоо. Намайг тэдний тоглоомыг үзэж байхад Расулаллах -алэйхиссалатү вэссэлам- ирэв. Тоглож байсан хүүхдүүдтэй мэндлэв. Дараа нь намайг дуудаж нэгэн газар илгээв. Би ч явсан. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- намайг харьж иртэл сүүдэр доор суув. Би гэртээ их оройтож ирлээ. Харин ээж надаас:

«–Яагаад оройтов?» гэж асуухад би:

«–Аллахын Элч намайг ажилд илгээсэн» гэв. Ээж минь:

«–Тэр ямар ажил ?» гэж асуув. Тэгэхлээр нь би:

«–Расулаллахын нууц ?» гэлээ. Ээж минь:

«–Тэгвэл Расулаллахын нууцыг хадгал!» гэв."

Энэ хадисыг дамжуулсан Сабит ингэж ярьдаг:

"–Энэс надад: «Хэрэв тэр нууцыг хэн нэгэнд хэлж болох бол чамд л хэлэхсэн Сабит аа!» гэв." (Ахмад, III, 195)

Үүнээс харснаар, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- хүүхдүүдтэй адил тэгш бүр чацуу юм шиг хандаж тэдэнд зарим нууцыг ч хэлдэг байжээ. Тэр бүх амьдралын туршдаа хүүхдүүдэд хайр ба халамж үзүүлсэн ба тэднийг чухалчилж, тэдэнтэй хамт байж, тэдний сэтгэл зүрхэнд хүрсэн байв. Хадис-и шарифдаа:

"Хэн нэгэн хүүхэдтэй байвал түүнтэй адил хүүхэд болог!" (Дэйлэмий, III, 513)

"Хүүхдүүдийг гэдэс цатгалан байлгаж, сайхан боловсрол олго!" (Ибн-и Мажэ, Эдэб, 3) хэмээн айлдаж хүүхдүүд болон багачуудаа яаж хандах хэрэгтэйг бидэнд заасан байв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн үлгэр жишээ амьдрал нь хүүхдүүдийг яаж хүмүүжүүлэх тухай бидэнд арга зам болдог. Жишээ нь түүний дэргэд байсан Энэсийг нэг ч удаа загнаж зандарч байгаагүй гэдэг. Тавь хол гарсан Расулаллах -алэйхиссалатү вэссэлам- нь арваадхан настай Энэсийн сэтгэл зүрхийг яаж эзэмдээд түүнтэй анд шиг тоглож чаддаг, хэрэгтэй нууцаа хадгалуулдаг байсныг юу гэх вэ? Аллахын Элчийн хүмүүжлээр өссөн Энэс -радъяллахү анх-ч хүүхэд байсан ч идэр хүн шиг хандаж Расулаллахын нууцыг хэнд ч хэлэлгүй түүний хамт булшинд орсон байв. Хазрат-и Энэсийг ийнхүү идрийн төвшинд дээшлүүлсэн нь, аргагүй Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн бүтээж чадах ухаанд багтаашгүй давуу хүмүүжлүүлэх арга мөн.

Мухажир болон Энсарын Хоорондох Найрамдлын Гэрээ: Муахат

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэблиг эхэлсэн мөчөөс Исламд орогсдыг үндэс угсаа, гарал үүсэл, зүс царай ялгахгүй үзэж, Исламын найрамдлыг байгуулав. Нэг нь хижрэтээс өмнө, нөгөөх нь дараа болоод тэдний хооронд хоёр удаа “муахат” буюу “найрамдлын гэрээ” хийв. Макка дахь муахат нь Курайшийн харъяа зарим мусульманчуудыг чөлөөлсөн боолчуудтай ах-дүү болохыг зарлах байв. Жишээлбэл Зэйд бин Харисэ ба Хазрат-и Хамза, Эбү Хүзэйфэгийн чөлөөлсөн Салим ба Эбү Үбэйдэ бин Жэррах, Билал-и Хабэший ба Үбэйдэ бин Харис ах-дүү болсон байв.[7]

Исламын анхны жилүүдээс эхлэн ийнхүү дараалан хижрэтийн дараа найрамдлын хоёр дахь жишээг толилуулав.

7. Ибн-и Сэйединнас, I, 321; Ибн-и Хабиб, х. 70; Ибн-и Абдилбэр, *эд-Дүрэр, х.* 90.

Мухажирчуудыг Мадинад анх ирсэн өдрөөс эхлэн Энсар тэднийг гэртээ авахаар бусадтай өрсөлдөж байв. Гэтэл зочноо авч чадалгүй, хоорондоо сугалаа адил булаацалдаж байв.[8] Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- Мадинад ирснээс таван сарын дараа Мухажирчууд болон Энсарыг ах-дүү болгов. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- энэ найрамдлын гэрээг Энэс бин Маликын гэрт хийсэн юм.[9]

Жишээлбэл Хазрат-и Эбү Бэкир нь Харижэ бин Зэйдтэй; Хазрат-и Умар нь Утбан бин Маликтай; Эбү Үбэйдэ нь Са'д бин Муазтай; Хазрат-и Усман нь Эвс бин Сабиттай;[10]Хазрат-и Билал нь Абдуллах бин Абдуррахмантай;[11]Хазрат-и Салман нь Эбү'д-Дэрдатай;[12]Салим нь Муаз бин Маизтай;[13]Аммар ч Хүзэйфэтэй -радъяллахү анхүм эжмаин- ах-дүү болцгоов.[14]Найрамдахад хоёр тал нэг нэгэнтэйгээ адил төсөөтэй зан чанартай байхыг ч анхаарсан байв.

Мухажирын гэр бүл тус бүрийг Мадинагийн нэгэн гэр бүл хажуудаа авав. Ингээд хооронд нь найрамдлын гэрээ хэрэгжсэн сахабийчууд хамт ажиллах, олсон ашгаа ч хуваалцах болов. Энсар нь илүү хөрөнгөө Расулаллах Эзэнд маань бэлэглэж, Пайгамбар Эзэн маань ч эдгээрийг Мухажирчуудад хуваав. Энсар нь үүгээр ч зогсолгүй ийм өгөөмөр саналаа илэрхийлэв:

"–Аяа Расулаллах аа! Хасарвааны хөрөнгийг маань ч Мухажир ах дүү нар бидэнд хувааж өг!"

8. Бухарий, Жэнаиз, 3; Мэнакибу'л-Энсар, 46.
9. Бухарий, Эдэб, 67.
10. Ибн-и Хишам, II, 124-125.
11. Ибн-и Са'д, III, 233, 234.
12. Бухарий, Эдэб, 67.
13. Ибн-и Абдилбэр, II, 567.
14. Хаким, III, 435/5657.

Пайгамбар Эзэн маань:

“–Үгүй, тэгж болохгүй!” хэмээн эсэргүүцэхлээр нь Энсар нь Мухажирчуудад:

“–Тэгвэл модыг хариуцах ба усжуулах ажлыг та хийж, тунш болцгооё!” гэсэн саналаа оруулав. Пайгамбар Эзний маань ч зөвшөөрлөөр хоёр тал нь:

“–Сонсоод таны үгэнд орлоо!” гээд энэ саналыг хүлээн авцгаав. (Бухарий, Харс, 5)

Тус найрамдал нь хамаг юмаа Маккад орхиж амьдралыг тэгээс эхлэхээр Мадинад нүүж ирсэн мусульманчуудтай тэдэнд өврөө нээсэн Энсарын эд-бараа болон сэтгэлийн дэм хамгийн чухал тулгуур байлаа. Шашныхаа төлөө нутгаасаа салсан Мухажирчуудын гунигт байдлыг өөрчилж, тэднийг Мадинад дасгаад мусульманчуудын хооронд эв-эе ба нэгдмэл байдлыг хүсч байв.

Аяндаа хэрэгжсэн ба зөвхөн итгэлийн хайраас үүссэн муахатын гэрээ нь өвийн хуулийн хамт хоёр талын харилцан эрх, эрх тэгш байдал ба тулалцах мэтийн олон шинэ санааг агуулсан байв.[15]Төрсөн ах дүү хэр нэг нэгийнхээ хамгаалагч ба өв залгамжлагч нь байв. Найрамдлын уг гэрээ зарчмаар дараа нь үргэлжлүүлсэн боловч, бараа хөрөнгөө өвлөхтэй хамаатай дүрэм нь Бэдирийн дайны дараа вахийтай хамт цуцалсан, өвлөгч болох нь зөвхөн нэг угсаа гаралтай төрөл садан байхаар хязгаарласан байв.[16]

Ибн-и Аббас -радъяллахү анхүмаа- энэ тухай ингэж ярьдаг:

15. Бухарий, Кэфалэ 2, Эдэб 67.

16. Хар. эл-Энфал, 72-75; Бухарий, Фэраиз, 16.

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн байгуулсан найрамдлын үр дүнд нэгэн Мухажир нь Энсарын хувьд цусан төрлийн хамаатан саднаас урьд найрамдсан дүүдээ өмч хөрөнгө өвлүүлж болох байв. Гэтэл:

وَلِكُلٍّ جَعَلْنَا مَوَالِيَ مِمَّا تَرَكَ الْوَالِدَانِ وَالأَقْرَبُون

«Ээж, аав ба садан хамаатны үлдээсэн бүхний төлөө бид нэгэн өвлөгч томилов...» (эн-Ниса, 33) гэсэн аетаар энэ үйлийг цуцлав. Аетын үргэлжлэлд явсан:

وَالَّذِينَ عَقَدَتْ أَيْمَانُكُمْ فَآتُوهُمْ نَصِيبَهُمْ

«…Тангаргийн гэрээгээр өвлөгч болгосон хүмүүсийн хувийг ч өгцгөө…» гэсэн үгээр Энсар Мухажир хоёрын хоорондын найрамдлын хууль нь тусламж, түшиг, сургамж ба буянаа хуваалцахтай хамаатай болов. Ингээд хуулийн талаар өвлөхийг цуцлав. Харин тухайн хүн, өөрийнхөө дураар өмч хөрөнгийнхөө гуравны нэгийг өвлүүлж болдог байв.” (Бухарий, Тэфсир, 4/7; Эбү Давуд, Фэраиз, 16/2922)

Муахатаар Исламаас өмнө Мадинад Эвс Хазраж хоёр аймгийн хооронд олон жил үргэлжилсэн цусан өшөө авалтыг нь цуцалж, төрсөн ах дүүгийн харилцаанаас ч хүчтэй найрамдал байгуулав. Тэд нэг нэгийгээ харахын тулд тэсэн ядан өглөө болохыг хүлээдэг байв. Уулзахдаа дотны хайраар; “Намайг харалгүй удлаа сайн байна уу?” гээд мэнд эрдэг байцгаав. Ердөө нэг нэгээ хараад мэнд эрэлгүй гурав хонодоггүй байв. Тэнгэрлэг магтаалт хүртсэн уг найрамдлыг Кур’ан-и Кэрим ч шагшсан байдаг.[17]

17. Хар. эл-Хашр, 9.

Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- Мадинад Исламын нийгэм болон улс төрийн суурийг тавьж байв. Үүний төлөө хийх хэрэгтэй анхны ажил нь нийгмийн эв ээ ба нэгд-лийг хангах байв. Учр нь нйигмийн дотор эв санааны нэгдлийг хамгийн сайн хангасан зүйлс нь хайр, найрамдал ба тусалцаа мөн. Ийм л учраас Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн Энсар болон Мухажирчуудын хооронд хэрэгжүүлсэн уг найрамдал нь, дэлхийн түүхэнд давтагдаагүй нэгэн нийгмийг байгуулахад хамгийн чухал хэрэг болов.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- байгуулж бай-сан нйигмийг аймаг, үндэстэн, ураг, боолчлол-чөлөөлөх, баялаг-ядуурал мэтийн ангийн суурь дээр биш, ерөөсөө Исламын най-рамдлын суурь дээр барив. Ингээд нийгмийн харилцааны том ялгааг үзүүлсэн хүний хэсгүүдийг бараг нэгэн вааранд хайлах мэт Исламын нийгмийг бүтээв.

Мухажирчууд болон Энсарын Эрдмүүд

“Нэгэн газраас нөгөө газар нүүсэн” гэсэн утгын “Мухажир” гэсэн үг нь ерөнхийдөө дарамт харгислалыг тэвчих аргагүй болсноос Мадинад нүүсэн Маккагийн мусульманчуудад олго-сон өөр нэгэн нэр юм.

Мухажирчууд нь хажуудаа аваачиж чадахаас гадна хамаг бараагаа хаян нүүцгээв. Мүшрикчүүд нь Мухажирчуудын орхи-сон эдгээр барааг шууд эзэмшиж авцгаав. Мусульманчуудын барааны алдагдал маш том байв. Гэтэл тэдний нүд барааг харахгүй, тэд ч дэлхийн ямар нэгэн ашгийг тоохгүй байв. Учир нь асхаб-и зирам итгэл үнэмшлийн амтыг авсан байв. Ийм учраас Аллахын замд хамаг юмаа зориулахдаа бэлэн байцгаав.

Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг тэдэнд ямар нэгэн юм тушаахад; “Аав ээж минь Чамд золиос болтугай аяа

Расулаллах!” гээд, Эзний маань хамгийн өчүүхэн гуйлтыг ч тушаал гэж үзэн тушаалыг нь шууд дагадаг байцгаав. Мадинад явахад нь саад болмоор байсан мүшрикчүүдэд Маккад хөрөнгөө нуусан газрыг хэлээд нүүдлээ хийсэн Сүхэйб бин Синан буюу алдаршсан нэрээрээ Сүхэйб-и Румий -радъяллахү анх- үүний хамгийн гоё жишээний нэг юм:

Аллахын замд хүнд харгислалд орсон мусульманчуудаас нэгэн байсан Сүхэйб -радъяллахү анх- нь Хазрат-и Али -радъяллахү анх-ын дараа Мадинад нүүхээр замд гарав. Маккачуудаас зарим нь гүйцэж:

“–Чи энд ирэхдээ ядуу хүчгүй байсан. Одоо элбэг баялаг олов! Энэ баялагаа авч явмаар байна биз! Валлахи үүнийг зөвшөөрөхгүй!” гэцгээв.

Сүхэйб шууд унаанаас буугаад, Саадгаасаа нум сумаа гаргаж:

“–Курайшийнхан! Та ч сайн мэднэ, би танай хамгийн сайн харваачдын нэг. Валлахи хоромсоготой бүх сумаа харваж, дуусаад сэлмээ сугална. Эдгээрээс нэгэн миний гарт байхад надад дөхөж чадахгүй. Харин тэд миний гараас гарсны дараа л хүссэн юмаа хийж чадна. Одоо би танд хөрөнгийнхөө газрыг мэдүүлж чамд орхивол, та миний замыг нээж, намайг орхих уу?” гэв.

Мүшрикчүүд энэ саналыг хүлээж авав. Тэгээд Сүхэйб -радъяллахү анх- өөрийн хөрөнгө болох газрыг тэдэнд үлдээж, замдаа гарав. Рабиул эввэл сарын дундуур Зубад хүрч Расулаллахтай учрав. Тэр хооронд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд Хазрат-и Эбү Бэкир ба Умар -радъяллахү анх- харгалзан байж байв. Тэдний өмнө Күлсүм бин Хидмийн авчирсан Үммү Жизраны хасарваанаас нэгэн хонгорцог байв. Замдаа Сүхэйб -радъяллахү анх-ын нүд

чилж ходоод нь ч их өвдөж байв. Хасарваанаас идэж эхлэв. Хазрат-и Умар -радъяллахү анх- тоглож:

"–Аяа Расулаллах аа! Сүхэйбийг харж байна уу? Нүд нь өвдөөд, усан хасарваань идэж байгаа юм ?!" гэхэд Оршигчдын Туяа Эзэн маань Мүхэйбэд:

"–Нүд чинь өвдөөд, усан хасарваань идээд байна уу даа?!" хэмээв.

Сүхэйб ч:

"–Би чинь тэрийг нүдний өвдөөгүй талаар л иднэ!" гэв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- мишээж (Сүхэйбийн бараагаа өгөөд Маккачуудаас амиа аварсныг дурдан):

"–Сүхэйб олов! Сүхэйб олов! Еэ Эбү Яхяа! Худалдаа нь ашигтай болов! Худалдаа нь ашигтай болов!" хэмээв. (Ибн-и Са'д, III, 226-230; Хаким, III, 450, 452)[18]

Мухажирчуудыг ийм олон бэрхшээл туулан Мадинад нүүхийг хичээж байхад Мадинагийн мусульманчууд ч тэдний итгэл үнэмшлийг дэмжин том итгэл хайраар дүүрэн тэднийг халуунаар тосохоор хүлээж байв. Өөрт нь дотроо нээж хамаг юмаа хуваалцахад сэтгэл ханамжтай бэлэн байсан Энсар дүү нартаа дараа болмооргүй байсан зарим Мухажирчууд ч хариуцлагатай хандаж, хариултгүй өгсөн юмыг авдаггүй, заримнь зөвхөн Энсарын хасарвааны цэцэрлэгт ажиллаж өөрийнхөө хөлс хүчээр мөнгө олохыг хүлээж авдаг байв. Зарим Мухажирчууд худалдаа наймааг сонгосон байв. Жишээлбэл Абдуррахман бин

18. Мөн Хар. I боть, х. 332

Авф -радъяллахү анх- эдний нэгэн байв. Түүнтэй ах дүү болсон Са'д бин Рэбий -радъяллахү анх- түүнд ингэж хэлэв:

"–Энэ бол миний хөрөнгө бараа, түүний талыг чамд өглөө."

Абдуррахман бин Авф -радъяллахү анх- бол:

"–Аллах чиний бараа таваарыг элбэг болгох болтугай. Чиний гэр бүлийнхэнд ч амар тайвныг хайрлах болтугай. Чи надад Мадинагийн худалдааны захыг заагаад өгвөл боллоо," гэж хариулав. Ингээд наймаа хийж эхэлсэн Абдуррахман -радъяллахү анх- их удалгүй баян болов. (Бухарий, Мэнакибу'л-Энсар, 3)

Вахийн анх хандсан, хамаг бэрхшээлийг зориглон давж Аллахын Элчид итгэсэн, хэцүү хүнд харгислалд өртөж дараа нь нутгаасаа хөөгдсөн Мухажирчууд нь Аллах Таалагийн магталыг хүртэв. Учир нь энэ амьдралын, энэ насны ямар ч ашиг байгаагүй ч зөвхөн шашныхаа төлөө, итгэл бишрэлийнхээ төлөө хамаг юмаа орхисон байцгаав. Мухажирчууд ингэхдээ зөвхөн харамгүй сэтгэл гаргаснаар үл барам, мөн шашны шаардлагыг ч хэрэгжүүлж байв. Учир нь Кур'ан-и Кэрим хэрэгтэй байхдаа үлдэгсэдийг буруушааж байв.[19]

Аугаа Эрх Кур'ан-и Кэримд Мухажирчуудын нүглийг өршөөх ба тэднийг диваажингаар шагнахаа мэдүүлнэ:

فَالَّذِينَ هَاجَرُواْ وَأُخْرِجُواْ مِن دِيَارِهِمْ وَأُوذُواْ فِي سَبِيلِي وَقَاتَلُواْ وَقُتِلُواْ لأُكَفِّرَنَّ عَنْهُمْ سَيِّئَاتِهِمْ وَلأُدْخِلَنَّهُمْ جَنَّاتٍ تَجْرِي مِن تَحْتِهَا الأَنْهَارُ ثَوَابًا مِّن عِندِ اللّهِ وَاللّهُ عِندَهُ حُسْنُ الثَّوَابِ"...

19. Хар. эн-Ниса, 97.

Нүүгсэд, нутгаасаа хөөгдөгсөд, Миний замд харгислалд автагсад, байлдагсад ба алагсдын нүглийг заавал далдлаж, тэднийг доогуур мөрний урсгалтай диваажинд оруулсугай. Тэд Аллахын талаар таны мөрөөдөж ч чадахгүй шагналд хүрнэ. Шагналын хамгийн гоё нь Аллахын онгонд байдаг.” (Ал-и Имран, 195)

ثُمَّ إِنَّ رَبَّكَ لِلَّذِينَ هَاجَرُواْ مِن بَعْدِ مَا فُتِنُواْ ثُمَّ جَاهَدُواْ
وَصَبَرُواْ إِنَّ رَبَّكَ مِن بَعْدِهَا لَغَفُورٌ رَّحِيمٌ

“Дараа нь андашгүй Раб чинь, харгислагдсаны дараа нүүсэн, дараа ч жихад хийсэн ба тэвчсэн хүмүүсийн туслагч мөн. Энэ бүхний дараа Раб чинь мэдээж их өршөөл, их энэрэлээ хайрлана.” (эн-Нахл, 110)

Энэ тухай Пайгамбар Эзэн маань ингэж айлдана:

“Мухажирчууд хүмүүсээс далан жилийн өмнө диваажинд ороод түүнийг шимийг хүртэх болно. Харин хүмүүс тооцоогоо өгөхөөр хүлээж байх болно.” (Хэйсэмий, X, 15)

Мухажирчууд ахиратад маш том шагналд хүрэхээс үл барам, мөн энэ ертөнцөд ч үзүүлсэн тус элбэгээрээ Раббын хэд олон шимд хүртсэн байв. Ает-и кэримэ ингэж айлдана:

وَالَّذِينَ هَاجَرُواْ فِي اللّهِ مِن بَعْدِ مَا ظُلِمُواْ لَنُبَوِّئَنَّهُمْ فِي الدُّنْيَا
حَسَنَةً وَلَأَجْرُ الآخِرَةِ أَكْبَرُ لَوْ كَانُواْ يَعْلَمُونَ

“Тамлалыг даван туулж дараа Аллахын тааламжийн төлөө нүүсэн итгэгчдийг дэлхийд хамгийн сайхан газар

суурьшуулна. Ахиратын шагнал улам бүр том юм. Тэд нэг мэдээсэй.” (эн-Нахл, 41)

Аллах Таала нь Мухажирчуудын учирсан бэрхшээлийн хариугаар тэдэнд олзноос бусад хүмүүсээс илүү хувь хуваасан байдаг. Кур’ан-и Кэрим энэ тухай ингэж айлдана:

لِلْفُقَرَاء الْمُهَاجِرِينَ الَّذِينَ أُخْرِجُوا مِن دِيارِهِمْ وَأَمْوَالِهِمْ
يَبْتَغُونَ فَضْلًا مِّنَ اللَّهِ وَرِضْوَانًا وَيَنصُرُونَ اللَّهَ
وَرَسُولَهُ أُوْلَئِكَ هُمُ الصَّادِقُونَ

“Олзны уг бараанд, ялангуяа нутаг болон хөрөнгө өмчөөсөө салсан, Аллахын тусламж ба тааламжийг хүссэн, Аллах(ын шашин)**ба Элчид нь тусалсан ядуу Мухажирчуудын эрх байдаг. Жинхэнэ дотно сэтгэлийн хүмүүс нь тэд юм.”** (эл-Хашр, 8)

Мухажирчууд Мадинад ирээд хагацал мэдэрснээс гадна Мадинагийн агаарт удаан хугацаагаар дасч чадахгүй, хижиг мэтийн аюултай өвчинд нэрвэгдэж байв. Хазрат-и Аиша -радъяллахү анха- нь аав Эбү Бэкир Сиддийк болон Билал-и Хабэший -радъяллахү анхүмаа-гийн хижгийн халуунд санаа зовсныг харахлаараа үүнийг Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д мэдээлсэн, Орчлонгуудын Эзэн ч ингэж залбирсан байв:

“Аяа Раббий! Маккаг бидэнд хайрлуулсны шигээ Мадинаг ч хайрлуул! Макаагаас ч илүү хайрлуул! Ургамалд нь элбэг дэлбэгийг хайрлаж өг! Аяа Раббий! Мадинагийн агаарыг сайжруул,

хижиг болон хумхааг нь Жүхфэд[20] *хүргэ!”* (Бухарий, Фэдаилү’л-Мадина, 12; Мүслим, Хажж, 480)

Маккагаас нүүсэн тэвчээртэй Мухажирчуудад өврөө нээж тэдэнтэй хамаг боломжоо өгөөмөр зөнгөөрөө хуваалцсан, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д ойр дотны сэтгэл үзүүлж зорилгод нь түшиг болсон Мадинагийн мусульманчуудад “туслагчид” гэсэн утгаар “Энсар” гэсэн нэр олгосон байдаг. Энсараас ганц нэгэн хүнийг илэрхийлэхээр “энсарий”; тэд бүхнийг эсвэл олон тоогоор нэрлэхдээ “Энсарийюн” гэсэн үгийг хэрэглэдэг.

Гайлан бин Жэрир -радъяллахү анх- ингэж хэлнэ:

Намайг Энэс -радъяллахү анх-аас:

“–Та энсар гэсэн өөрөө сонгов уу, эсвэл уг нэрийг танд Аллах олгов уу?” гэж асуухад минь, тэр:

“–Уг нэрийг бидэнд Аллах л олгов” гэлээ. (Бухарий, Мэнакибу’л-Энсар, 1)

Энсар нь Эвс болох Хазраж хэмээн Мадинагийн ах дүү хоёр аймгаас бүрддэг байв. Номлолын арван нэгдүгээр жилд Хазраж аймгаас зургаан хүний хамт олон, байлдаж байсан Эвсийн эсрэг Курайшийнхнаас түшиг олох зорилгоор Маккад ирэв. Энд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-тэй таарaлдаж Түүний тэблиг болон боловсролын дүнгээр Исламыг

20. Жүхфэ нь тэр үед еврей эсвэл мүшрикчүүд оршсон тойрог байв. Оршин суугчид нь мусульманчуудын эсрэгээр күфүрийн хүмүүст тусалж, замбараагүй байдал гаргаж байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Аллахад ингэж залбиран тэдний тахал өвчинтэй тэмцэж кафирчуудад туслах завшаан олохгүйг нь хүссэн байдаг. (Айний, X, 251)

хүлээн авцгаав. Хазражчууд Мадинад харихлаараа, хоорондын өшөөг энэ үнэн шашны ачаар үгүй болгоод хэвээрээ ах дүү шиг болохоо найдан Эвс аймгийг ч Исламд урив. Ингээд хэдэн олон жил үргэлжилсэн дайны зовлон, Исламын нэрийн “слм” буюу энх тайвнаар нэгдэлд эргэж хувирав. Ах дүү хоёр аймаг дахиад нэгдэж номлохын арван хоёр ба арван гуравдугаар жилд Маккад төлөөлөгчид илгээж Хазрат-и Пайгамбартай уулзаад, Акабагийн Нэг дэх ба Хоёр дахь Бий’атыг хийцгээв.

Акабагийн Хоёр дахь Бий’атад, тэдний нутагт нүүсэн тохиолдолд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- болон Маккагийн мусульманчуудыг хамгаалж тэдэнд туслахаар ам өгцгөөв. Ингээд хижрэт болон Исламын түүхэнд шинэ нэгэн эрин нээгдэх учир болцгоов.

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Мухажирчууд болон Энсарыг хоёр хоёроор ах дүү болгож зарлахад, Энсар нь Мухажир дүү нараа Мадина дахь гэртээ, ажилдаа ба цэцэрлэгтээ тунш болгож төрсөн дүүгийн харилцаанаас ч дээр, ижилгүй нэгдэл ба түшгийн жишээг үзүүлэв. Кур’ан-и Кэрим нь Энсарын ийм дотно үйлсийг ингэж магтана:

وَالَّذِينَ تَبَوَّؤُوا الدَّارَ وَالْإِيمَانَ مِن قَبْلِهِمْ يُحِبُّونَ مَنْ هَاجَرَ إِلَيْهِمْ وَلَا يَجِدُونَ فِي صُدُورِهِمْ حَاجَةً مِّمَّا أُوتُوا وَيُؤْثِرُونَ عَلَى أَنفُسِهِمْ وَلَوْ كَانَ بِهِمْ خَصَاصَةٌ

“Өмнө нь Мадинад нутагласан ба сэтгэлд нь итгэл үнэмшил суурьшсан хүмүүс, тэдэнд нүүж ирэгсдэд дурлана, тэдэнд өгсөн бараанаас болж дотроо ямар нэгэн дутагдал

мэдрэхгүй, өөрсдөө хэрэгцээтэй байсан ч тэднийг өөрсдөөсөө илүүд үзнэ...” (эл-Хашр, 9)

Энэ ает буусны учир гэж бичсэн энэ явдал нь Энсарын бие харамгүй зангийн гоё нэгэн жишээ юм:

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д өлссөнөөсөө турсан нэгэн ирээд тусламж гуйв. Орчлонгийн Хүндэт Эзэн маань:

“–Энэ дүүгээ хэн нь зочлуулмаар байна вэ?” хэмээн асуув. Энсараас Эбү Талха -радъяллахү анх-:

“–Би зочлуулна, аяа Расулаллах аа!” гээд тэр ядууг гэртээ аваачив. Гэртээ хүрээд эхнэрээсээ:

“–Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн зочныг дайлцгаая! Гэрт идэх юм бий юү?” гэж асуув. Эхнэр нь:

“–Байхгүй, зөвхөн хүүхдүүдийн идэх жаахан юм бий,” гэв. Сахабий:

“–Тэгвэл хүүдүүдийг саатуулаарай. Ширээнд ирмээр бай-вал тэднийг унтуул. Зочныг маань дотогш ороход гэрлийг нэгэн шалтгаанаар унтраа. Ширээнд бид идэх юм шиг сууцгаая,” гэв.

Тэд ширээнд суув. Зочны ходоод цадав; харин тэд бол өлссөн хэвээрээ хэвтэв. Өглөө Эбү Талха нь Пайгамбар Эзний маань дэргэд очив. Аллахын Элч түүнийг харахлаараа:

“–Өнөө шөнө зочиндоо хандсанаас тань Аллах Таала таа-тай болов,” хэмээв. (Бухарий, Тэфсир, 59/6; Мүслим, Эшрибэ, 172-173)

Пайгамбар Эзнийг маань Мадинад ирэхэд Мухажирчууд:

“–Аяа Расулаллах аа! Нутагт нь нүүсэн энэ аймгийнхан шиг өгөөмөр буянтай хүмүүс бид үзээгүй. Бараа ихтэй нь ихээр өгнө, багатай нь бие сэтгэлээ зориулж тусалж байна. Бидний

хоолны хамаг хэрэгцээг тэд хангаж биднийг бараадаа тунш болгоцгоов. Бидний хамаг буяныг тэд авч явна гэж бид айна," гэцгээв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

"–Үгүй, тэдний төлөө Аллахад залбираад, тэдний хийснэ-эс болж тэднийг магтвал буяныг хүртэнэ." (Тирмизий, Киямат, 44/2487)

Сабир -радъяллахү анх- ярина:

"Энсар нь хасарваанаа хураагаад үүнийг хоёр хэсэг хувааж нэг талд их нөгөө талд бага хасарваана тавьдаг байв. Дараа нь Мухажирчуудад; «алийг нь сонгохоо өөрөө мэдээд аваа-рай,» гэдэг байв. Тэд ч илүү харагдсан овоог нь Энсар дүү ав хэмээсэн ч ихэнх нь тэднийх болдог байв. Энсар бага хэсгийг өөрсдөө авдаг байв. Хайбарыг эзэлтэл Энсарын ийм өгөөмөр зан нь ингэж үргэлжлэв." (Хэйсэмий, X, 40)

Энсарын Мухажирчуудад үзүүлсэн харамгүй сэтгэл зан-гийн өөр нэгэн жишээ ч ийм байна:

Нэбий -саллаллахү алэйхи вэ сэллэм- Бахрайны хөрөнгийг бүлэг бүлгээр янзалж тараахаар эхлээд Энсарыг урьсан байв. Энсар нь татгалзаж:

"–Аяа Расулаллах аа! Тухажио дүү нарт маань үүний нэг дахин илүүг бэлэглэхгүй байхдаа бидэнд юм битгий өгөөрэй!" гэцгээв. Тэгэхлээр нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэл-лэм-:

"–Энсар аа! Та бусдыг өөрсдөөсөө илүүд үзээд авмааргүй байвал; Кэвсэрийн нуурт надтай учиртлаа тэвчээрэй! Учир нь надаас хойш бусдыг танаас илүүд үзэх цаг болохгүй юм," хэмээв. (Бухарий, Мэнакибу'л-Энсар, 8)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Энсарын гавьяаг ингэж магтсан байдаг:

"Миний харснаар та шашны дайн болон ядуу зүдүүнд тус-лахаар дуудахад ихэсч, ахин ахин ирдэг; энэ насны эд хөрөнгө юм өгөхөөр дуудахад бол татгалзаж, баян сэтгэлээр ханда-на." (Али эл-Муттакий, XIV, 66)

Энсар-т кирам нь хотод нь ирсэн Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- болон Мухажирчуудад үзүүлсэн халамжтай зангийн хариугаар диваажинд, түүнээс ч чухал нь Аллахын тааламжид хүртсэн байдаг.

Ает-и кэримэ нь ингэж айлдана:

وَالسَّابِقُونَ الأَوَّلُونَ مِنَ الْمُهَاجِرِينَ وَالأَنصَارِ وَالَّذِينَ اتَّبَعُوهُم بِإِحْسَانٍ رَّضِيَ اللّهُ عَنْهُمْ وَرَضُواْ عَنْهُ وَأَعَدَّ لَهُمْ جَنَّاتٍ تَجْرِي تَحْتَهَا الأَنْهَارُ خَالِدِينَ فِيهَا أَبَدًا ذَلِكَ الْفَوْزُ الْعَظِيمُ

"Исламд анх **түрүүлж орсон Мухажирчууд болон Энсар ба тэднийг сайхнаар дагагчид бий биз, Аллах тэдэнд таатай болсон, тэд ч Аллахад таатай болсон байдаг. Аллах тэдэнд үүрд мөнх суухаар, дэргэдүүр нь мөрөн урсдаг диваажин бэлтгэсэн байдаг. Энэ нь том аврал мөн."** (эт-Тавба, 100)

Энсар нь Ислам шашин болон Оршигчдын Туяа Эзнийхээ төлөө амиа золиослохоос татгалзаагүй. Бэдир Газвад маш том ашиг тус үзүүлэв. Ухуд Дайнд мусульманчууд дараалан цохиг-дож хүнд байдалд орсон бүслэлтийн үед, Расулаллахыг эргэж тойрон биеэрээ хамгаалж байв. Орчлонгийн Эзнийг хамга-алахыг хичээгсдээс ихэнх нь Энсараас байв. Тэд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д чин зүрхнээс хайртай ба

үнэнчээрээ ижилгүй байцгаав. Тэдний Пайгамбар Эзэнд маань хайрын тухай Энэс -радъяллахү анх-ын ярьсан дурсамж сэтгэл хөдөлгөхгүй байх аргагүй юм:

“Жэрир бин Абдуллахын[21] хамт аянд гарсан байлаа. Надаас ах байсан ч Жэрир надад үйлчилж байв. Намайг түүнд:

«–Битгий ! хэрэггүй гэхээр надад:

«–Би Энсарын Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д маш их үйлчилснийг хараад өөртөө “Хэрэв Энсараас хэн нэгэнтэй найзалбал би ч түүнд үйлчилнэ,” гээд тангарагласан юм,» гэж билээ” (Бухарий, Жихад, 71; Мүслим, Фэдаилү’с-Сахаба, 181)

Расулаллах -алэйхиссалату вэссэлам-:

“Хэрэв хижрэт байгаагүйсэн бол би Энсар болохсон,” (Бухарий, Мэнакибу’л-Энсар, 2) хэмээж Энсарын сайхан сэтгэлийн үнэ цэнийг илэрхийлэв.

Энсар -радъяллахү анхүм эжмаин-ын эрдмийн тухай Пайгамбар Эзний маань илэрхийлсэн зарим санаа нь ийм л байдаг:

“Аллах болон ахиратад итгэсэн хүн нь Энсарийг голуузай.” (Тирмизий, Мэнакиб, 25/3906)

“Тэдэнд зөвхөн итгэгчид дуртай бөгөөд тэдэнд зөвхөн мүнафикчууд л өшөөтэй юм. Энсарт дуртайд Аллах ч дуртай, тэдний дургүйд Аллах ч дургүй.” (Тирмизий, Мэнакиб, 25/3900)

---

21. **Жэрир бин Абдуллах** -радъяллахү анх- Йемен дэх Бэжилэ аймгийн тэргүүн байв. Хижрэтийн 10 оны Рамазан сард буюу Пайгамбар Эзнийг маань таалал төгсөхөөс гурав орчим сарын өмнө 150 хүний хамт Мадинад ирээд мусульман болсон байв. Пайгамбар Эзэнд маань их хайртай байв. Аллахын Элч ч түүнийг хайрласан ба түүнийг харах бүрдээ мишээдэг байв.

“Аяа хүмүүс ээ! Хүмүүс нь ихэсч, Энсар нь багасч байна. Тэд хоолны давс шиг багасна ...” (Бухарий, Мэнакибу’л-Энсар, 11)

“Та нарт Энсарт сайнаар хандахыг санал болгоё. Тэд миний хамт олон, нууц хадгалагч ба итгэмжтэй андууд мөн. Тэдэнд даасан үүргээ ёсоор нь хийцгээв. Үүргийнхээ хариу бол арай бүтнээр нь төлөөгүй юм. (Ахиратад илүү ихээр нь төлнө.) Ийм учраас тэдний сайнд сайнаар хандаж, муу юм хийснийг ч өршөөгөөрэй.” (Бухарий, Мэнакибу’л-Энсар, 11)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Энсар, Мухажир , хамаг асхабдаа гүн хайртай байв. Тийм учраас хамаг асхаб нь хэнээс ч илүү өөрт нь хайртай байсныг боддог байв.

Ка’б бин Үжрэ -радъяллахү анх- сургамжтай ийм байдал ярина:

“Нэгэн өдөр Мэсжид-и Саадатад Аллахын Элчийн онгонд хэдүүлээ сууж байлаа. Энсараас, Мухажирчуудаас бас Хашимынхнаас хэсэг хүмүүс байв. «Хүндэт Элч Эзэн маань бидний дундаас хэнийхэнд их дуртай вэ?» гэж мөрий тавьцгаалаа. Бид Энсарынхан:

«–Бид Аллахын Элчид итгэж, Түүнд бууж өгөөд, дайсны эсрэг дэргэд нь байлдав. Ийм учраас Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- бидэнд илүү хайртай,» гэцгээлээ.

Мухажир дүү нар маань ч:

«–Бид нар Аллах ба Расулынхаа төлөө хижрэт хийж, ийм учиртай эхнэр болон хүүхдүүдээ орхиж, бараагаа хаяад, таны оролцсон дайнд бид ч оролцов. Ийм учраас Аллахын Элч бидэнд илүү хайртай,» гэцгээв.

Хашимынхнаас дүү нар маань бол:

«–Бид Пайгамбар Эзний маань хамаатан юм, таны оролцсон дайнуудад бид ч оролдлоо. Ийм учраас Эзэн маань бидэнд илүү хайртай,» гэцгээв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- бидний дэргэд ирээд:

«–Та зарим юм ярьж байсан, юу юм бэ?» хэмээв.

Тус бүр маань юу хэлснээ дахив. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- бүгдэд нь:

«–Зөв хэлжээ! Үүний эсрэгийг хэн хэлж чадах вэ?» хэмээв. Дараа нь:

«–Та нар тодорхой хариулт хүсч байна уу?» хэмээн асуув.

«–Хүснэ, аяа Расулаллах! Манай аав ээж бүгд Чамд золиос болог,» гэцгээлээ. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Та нар, Энсарууд аа! Би та нарын хамаатан мөн,» хэмээв.

Энсар баясч:

«–Аллахү экбэр! Кабагийн Раббаар Түүнийг бид олов,» гэцгээв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«– Би Мухажируудын! Хэсэг мөн,» хэмээв.

Мухажирчууд ч баясч:

«– Аллахү экбэр! Кабагийн Раббаар Түүний бид олов,» гэцгээв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Еэ Хашимынхаан! Та нар бол, минийх, би бол та нарынх» хэмээв.

Хашимынхан ч баясч:

«– Аллахү экбэр! Кабагийн Раббаар Түүний бид олов,» гэцгээв. Бүгдээрээ сэтгэл таатай босов. Хамт олон тус бүр нь Аллахын Элчийн магтаалаар баяссан байв.” (Хэйсэмий, X, 14)

Мадинад байгуулсан ба дөрвөн зуун өрхөөс бүрдсэн Исламын жижиг хотхон гүрний хил даван арван жилд Ирак болон Палестинд хүрэв. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг өөд болоход Византи ба Ираны дайн үргэлжилж байв. Гэтэл асхабын арван жилийн өмнөх байдал, хандлага, амьдрах арга, аж ахуй ба орон гэр өөрчлөгдөөгүй байв. Гэвч Тэд амьдралдаа байнга сэтгэл ханамжтай байв. Маш бага зардлаар, хэтэртлээ идэхгүйгээр, нүд хуурах ганган хээнцэрийг эрхэмлэхгүй, тансаг сайхнаас татгалзан амьдарч арга байв. Тэд бүгд “Маргааш ч үхэж болно гэдгийг ухаарсан байв. Ийм учраас дэлхийн шимийг өөрсдийн нэфстэй зориулах ба хэт их эдлэхээс байнга татгалцав. Итгэл үнэмшлийн амт ба бишрэлийн эдгээр шимүүдийг хүн төрөлхтний аврал ба аз жаргалын төлөө зориулав. Амьдралаа Аллахын тааламжид хүргэхээр чиглүүлэв. Ингээд Исламын шашин ертөнцөд дарлагдсан, мөлжигдсөн олны дунд -үүрийн туяа шиг- хурдан тарсан бөгөөд гол учирын нь, асхабын хүрсэн газар бүрт Исламын занг төгс төгөлдөр толилуулсан нь байв. Учир нь Аллахын Элчийн шилмэл шавь байсан асхаб-и кирам нь, Аллахын боолчуудад Тэрээрийн халамж ба энэрлээр хардаг, уяхан сэтгэлтэй, шударга, эрх тэгш, өгөөмөр зантай ба номлохын туяагаар дүүрсэн ижилгүй хүмүүс байв.

Мадинатү’н-Нэбий ба Мадинагийн Баримт

Мадина-и Мүнэввэрэ нь Макка-и Мүкэррэмэгийн умарт зүгт, гурван талдаа уулаар хүрээлсэн, өмнөд тал нь тэгш тал-

тай нэгэн хот юм. Тариаланд зохимжтой хөрсөөр баялаг, цэвэр агаар ба хасарваанаар баян, арвин их ургамалтай нов ногоон сайхан орон юм.

Расулаллах Эзнийг маань нүүсэнд Мадинад Эвс ба Хазраж гэсэн Араб хоёр аймаг ба Кайнука, Надир ба Курайзагийнхан гэсэн Еврей гурван аймаг байв. Араб аймгууд нь энд “Сэйлү’л-Арим” гэсэн үерийн гамшгийн араас Йеменээс; Еврейчүүд бол Римийн эзлэлт, даралт ба сүйдлийг дараа Күдүс буюу Иерусалимаас ирсэн байв.

Цаг өнгөрөх тусам Арабчуудтай Еврейчүүдийн харилцаа эвдрээд, эцэст нь Арабчууд Еврейчүүдийг ялж Мадинад хүчийг эзэмшжээ. Гэтэл хэсэг хугацааны дараа еврейчүүдийн ов мэхээр ах дүү аймгууд ч эвдрээд олон жил байлджээ. Эдгээрийн хамгийн сүүлийнх нь Буас Дайв юм. Завсарлагаатай 120 жил үргэлжилсэн ба Хижрэтээс ойролцоогоор 5 жилийн өмнө дуусахад дайнд оролцогч хоёр тал маш их хохирол амсаж, туйлдсан байв. Ийм учраас Хижрэт болоход еврейчүүд ялангуяа эдийн засгийн талаар Мадинаг удирдаж байцгаав.

Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн Мадинад хүрснээр ба Аллахын хайрласнаар энэ хоёр аймгийн хоорондын өс өшөө нь барагдав.

Аугаа Эрх ингэж айлдана:

وَاعْتَصِمُواْ بِحَبْلِ اللّهِ جَمِيعًا وَلاَ تَفَرَّقُواْ وَاذْكُرُواْ نِعْمَتَ اللّهِ
عَلَيْكُمْ إِذْ كُنتُمْ أَعْدَاء فَأَلَّفَ بَيْنَ قُلُوبِكُمْ فَأَصْبَحْتُم بِنِعْمَتِهِ
إِخْوَانًا وَكُنتُمْ عَلَىَ شَفَا حُفْرَةٍ مِّنَ النَّارِ فَأَنقَذَكُم مِّنْهَا كَذَلِكَ
يُبَيِّنُ اللّهُ لَكُمْ آيَاتِهِ لَعَلَّكُمْ تَهْتَدُونَ

“Хамтдаа Аддахын ёс журам, заншлыг бат барьцгаа. Бүү тарж бутар. Аллахын та нарт хүртээх ивээлийг бодоцгоо. Та нарыг дайсагналцан байхад Тэр та нарын зүрхийг эвлүүлж байв. Түүний ачаар л та нар ах дүү болсон байв. Мөн таныг тамын галд унах гэж байхад, тэндээс ч таныг Тэрээр аварсан байв. Аллах таныг зөв замд хүрээрэй гэж аетуудаа ингэж тайлбарлаж мэдүүлжээ.” (Ал-и Имран, 103)

Хижрэтийн дараа Маккагийн мүшрикчүүд нь мусульманчуудын Мадинад суурьшиж хүч олоход саад болох тулд Мадинагийн мүшрикчүүд болон еврейчүүдэд сүрдүүлэх ба өдөөх захидал илгээсэн байв. Жишээлбэл нэгэн захианд Абдуллах бин Үбэй болон Эвс ба Хазражаас түүнтэй хамт буй мүшрикчүүдийг ингэж сүрдүүлцгээв:

“Та манай хүнийг хажуудаа байлгавал, түүнийг ална, эсвэл нутгаасаа гаргана! Эс тэгвээс бид Арабын хамаг нийтийн хамт тань дээр явж, таны дайчдыг алж, эмэгтэйчүүдийг тань эрхшээлдээ оруулна!”

Тэгэхлээр нь Абдуллах бин Үбэй ба түүний хамт хандагч Мадинагийн мүшрикчүүд нь Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-тай тулалдахаар цуглараав. Үүний мэдээллийг авсан Аллахын Элч тэдний дэргэд очоод:

“Курайшийн сүрдүүлэх үг нь танд ихээр нөлөөлсөн бололтой. Тэдний танд хүргэх аюул нь таны бидэнтэй байлдаж өөрсдөө хүргэх аюулаас их биш! Тэгэхээр та өөрсдийн хөвүүд ба дүү нартайгаа байлдаж тэднийг алмаар байна уу?!” хэмээв. Тэгээд тэд ч тарж явцгаав. (Эбү Давуд, Хараж, 22-23/3004; Абдүррэззак, V, 358-359)

Маккагийн мүшрикчүүдийн энэ сүрдүүлэх ба өдөөх захидал нь үр дүнгүй болов. Нөгөө талаас, хүсэл нь биелээгүй

Курайшийн Мадинад ерөнхий нэгэн дайралт хийж, тэнд мусульман, мүшрик ба еврей гэж ялгахгүйгээр хамаг ардыг алах боломжтой байв. Энэ дундын аюул, мусульман бус Мадиначуудын ч Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм-д дөхөөд Түүний удирдлага доор хурахын учир болов.

Үүнээс гадна дээр үеэс эхлэн Эвсчүүд, Хазражчууд ба еврейчүүдээс тус бүр нь Мадинагийн гагцхуу эзэн болохыг хүсдэг байв. Жишээлбэл Хазражчууд нь тэргүүн Абдуллах бин Збэйгээ Мадинагийн эзэн хан болгохоор бэлтгэл хийж байв. Гэтэл Эвсчүүд нэгэн Хазражийг, эсвэл Хазражчууд нэгэн Эвсийг эзэн ханаар хүлээн зөвшөөрөх талд байгаагүй. Ийм учраас Эзэн -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь хамаг Мадиначуудыг нэгдүүлэх нэр болсон байв.

Ийм шалтгаан дор Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Мадинагийн удирдлагыг дааж авав. “Муахат” гэдэг Энсар-Мухажирын найрамдлаар Мусульманчуудын хооронд нийгмийн эмх цэгцийг тогтсон Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь цаг алдалгүй Мадинад амьдарч байсан еврейчүүдийг ч бичиг баримтаар иргэн гэж хүлээж аваад Мадина хотын гүрний нэгэн төрлийн эх хууль болох зарим зарчмыг зарлиг буулгав. **“Мадинагийн Баримт”** гэсэн нэр олгосон ба Ислам Гүрнийг зохион байгуулсны албан ёсны баталгаа байсан уг баримтын зарим зүйлс нь ийм л байв:

“Бисмиллахиррахманиррахим.

1. Курайш ба Есрибийн (Мадинагийн) итгэгчид ба тэднийг дагаж бүлд нь орогсод ба тэдний хамт Жихад хийгчид -бусад хүмүүсээс тустай- нэгэн үммэт мөн.

2. Бусниулах ба хүчирхийлэх үйлс хийж үл болно. Таква эзэмшсэн итгэгчид нь дундаасаа догширсон, харгислал ба эрх

бусаар хандмаар буй, нүгэл хийдэг, өшөөтөн болдог ба итгэгчдийн дунд замбараа алдуулсан хүний эсрэг хамтдаа тэмцэж -тухайн хүн өөрсдийн хүү байсан ч- бүгдийн гар түүний эсрэгээр өргөх юм.

3. Хүн алж үл болно. Энэ нь хэрэгжсэн тохиолдолд Мухажирчууд ба Мадинагийн өрх бүр нь цусны мөнгийг хоорондоо хуваалзаж хамтдаа ёсоор нь төлнө. Баг бүр нь олзны хүнийг аврах зоосыг ч -итгэгчдийн хооронд мэдэгдсэн эрх тэгш зарчмын ёсоор- хамтдаа төлнө.

4. Итгэгчид нь өртэй ба өнөр гэр бүлтэй хүнийг өөрийнх заяанд орхихгүй, тэдний аврах зоос, эрсдэл цусны мөнгийг -хоорондоо тохирсон эрх тэгш зарчмын ёсоор- төлнө.

5. Мадинагийн дотуур ба гадуур аюулгүй байдлыг хангана. Мадинагаас гарсан нь ч Мадинад суусан нь ч аюулгүй байх болно. Ямар нэгэн харгислал ба гэмт хэрэг хийсэн хүн эндээс гаргах болно.

6. Еврейчүүд нь шашны эрх чөлөөтэй болно. Еврейчүүд нь өөрийнх шашиндаа, мусульманчуууд ч өөрийнх шашиндаа байх болно. Биднийг дагасан еврейчүүд ч, ямар нэгэн харгислалтай тааралдалгүй ба тэдний эсрэг ямар нэгэн холбоо болохгүйгээр тусламж үзэх болно. Ямар нэгэн дайн гарвал, талууд нэг нэгэндээ туслах болно. Еврейчүүд мусульманчуудын талд байлдаж дайны зардлыг хуваалцах болно.

7. Хоёр тал аль аль нь мүшрикчүүдийг хамгаалахгүй. Курайшчууд ч тэдэнд туслагчид ч ямар ч тохиолдолд хамгаалалтад орохгүй.

8. Мадинагийн дотор байлдахыг хориглоно. Зсрибийн Хөндийн дотор нь, энэ хуудасны эздэд харам (буюу дархалсан) тойрог мөн. Гаднаас ямар нэгэн довтолгоо болбол, талу-

уд тойргоо хамгаална. Нэг талын хийсэн энх тайвны гэрээг нөгөө тал ч зөвшөөрнө. (Дайны үед) еврейчүүдийн зардал өөрсдийн, мусульманчуудын зардал ч өөрсдийн байх болно. Зөвхөн, энэ хуудасны эздэд дайн зарлагчдын эсрэг хоорондоо тусалцах ба нэг нэгэндээ муу муухайгаас байтугай сургаал хэлээд, сайн сайхныг чухалд авна. Хэн ч холбоотнуудаа муу муухай хийхгүй, дарагдсанд заавал тусламж үзүүлнэ.

9. Зөрөлдөөн гарвал, асуудлыг Аллах болон Элчид нь өргөж, Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн гаргасан шийдвэрт бууж өгнө.

10. Аллахын амлалт ба баталгаа нь нэг юм (бүгд зэрэг байдаг); тэдний хамгийн доор харсан хүнийг ч агуулна. Учир нь бусдаас тустайгаар итгэгчид нэг нэгнийхээ мавла буюу холбоот ба анд байдаг .

11. Тэднээс (еврейчүүдээс) хэн ч, Хазрат-и Мухаммед -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн зөвшөөрөлгүйгээр цэрэг дайнд явж үл болно.

Андашгүй нь Аллах Таала энэ гэрээнд бичсэнийг зөрчихөөс татгалзсан, зөвийг ба сайн сайхныг зарчим болгосон хүмүүст таатай байх болно. Энэ бичиг хэн хэгэн харгис эсвэл гэмт хэрэгтнийг яллахад огт саад болохгүй.

Аллах нь сайн сайхныг хийсэн ба муу муухайгаас татгалзсан хүмүүсийг хамгаална. Мухаммед -саллаллахү алэйхи вэ сэллэм- Аллахын Элч мөн.” (Ибн-и Хишам, II, 119-123; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 263-264; Хамидуллах, *эл-Вэсаик,* х. 57-64)

Эдгээр зүйлсийн нийгэмд Исламын дүрэм журмыг хэрэгжүүлэхийн тулд шаардсан зарчмууд буй нь нэлээд тодорхой юм.

Иргэний харъяаллын гэрээ байсан Мадинагийн Баримт нь Исламын хуульгүй шашин бөгөөд, хуулийн шийдвэр тогтоогүй, зөвхөн залбирал үйлчилгээг янзалсныг санал болгосон бодлын хамгийн лав хариу нь мөн.

Мадинагийн Баримт нь улс төрийн, эдийн засгийн, нийгмийн ба шашны талаар агуулгаар олон зүгт хандсан нэгэн гэрээний шинжтэй байдаг. Уг баримт нь мусульманчуудын нэгдлийг хангасан ганц зүйл Ислам буйг, тэднийг хоорондоо тусалцах ба хоорондоо эрх тэгш байдлыг үзээд ямар нэгэн зөрчилдөөн илэрвэл Аллах болон Элчээс нь лавлах хэрэгтэйг илэрхийлнэ.

Уг баримт нь Арабчуудын хооронд хүчтэй байсан аймгийн хамаатны харилцааг, эрх тэгшийг хангах зарчмаар хиллэж янзалсан, эрхгүйгээр хандсан хүнийг, садан хамаатан байсан ч яллахыг тушаасан байдаг.

Уг гэрээ нь еврейчүүдэд хөрөнгө олох ба шашны эрх чөлөөг олгосон буйгаараа Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тэдэнд эрх тэгшээр хандсаны гайхамшигт нэгэн баримт мөн. Хэрэв еврейчүүд өөрсдийн гараар эвдээгүйсэн бол, мусульманчуудтай тэдний хооронд энэ эрх тэгш гэрээ нь үргэлж хүчинтэй болох байв.

Мадинад Харам Зарласан нь

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- эдгээр шийдвэрүүдийн араас Мадинагийн Харамын хилийг ингэж тогтов:

“Ибрахим -алэйхиссэлам- Маккаг харамаар зарласан байв; би ч Мадинагийн хоёр давааны хоорондыг харамаар зарлая.” (Ахмад, IV, 141)

Уг тушаалын дагуу, тогтсон газар дээр чулуу босгож Мадинагийн харамын хилийг тогтоцгоов. Ингэж хиллэсэн Мадинаг "Харам-и Расул" гэж нэрлэцгээв. Мадинагийн Айр болон Сэвр[22] гэсэн хоёр давааны хоорондох гурван фарсах (ойролцоогоор арван долоон км) зайд булан бүрийг ой мод болгов. (Бухарий, Фэдаилү'л-Мадина, 1; Мүслим, Хаж, 471-472)

Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- Мадинаг харам болгож зарласны дараа ингэж айлдав:

"Түүний модыг огтож үл болно, тэнд нүгэл хийж үл болно. Хэн нь тэнд Судар ба Сүннэтийн эсрэг үйл хийвэл, Аллахын, мэлэкчүүдийн ба хамаг хүн төрөлхтний хараал түүнд хүрэх болно!" (Бухарий, Фэдаилү'л-Мадина, 1)

Үүний дараа Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- хоёр гараа өргөж энэ нутгийн төлөө залбирав. Энэ залбирлын элбэгээр Мадина нь тэр үеэс нааш хамаг итгэгчдийн амар амгалан, баяр баясгалан, энэрлийн орон бөгөөд Исламын шашны голт зүрх, жаргалын орон болов.

Асхаб-и кирам нь Мадинагийн харамд хэт анхаарал үзүүлдэг байцгаав. Жишээлбэл Эбү Хүрэйрэ -радъяллахү анх- энэ тухай мэдрмжээ ингэж илэрхийлнэ:

"Хэрэв би Мадинад бэлчиж буй буга харвал түүнийг ерөөсөө үймүүлдэггүй байлаа! Учир нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-: *«Мадинагийн хоёр хар чулуутын хооронд нь харам юм,»* хэмээн айлдсан байв." (Мүслим, Хажж, 471)

22. Зүлхүлэйфэгийн хавь дахь Айр (эсвэл Аир) Уул ба Ухуд Уулын хойд талын жижиг Сэвр давааны хоорондын хэсэг. Энэ Сэвр давааг Макка дахь Сэвр Уултай андуурах ёсгүй.

Асхаб-и кирам нь хүүхдүүдийн ч үүний эсрэгээр хандахыг зөвшөөрдөггүй байв. Абдуллах бин Убадэ -радъяллахү анх- ингэж ярина:

“Би Эбү Ихабын худгийн хавьд шувуу агнаж байлаа. Аав Убадэ намайг хараад барьсан шувууг орхиулж:

«–Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Ибрахим -алэйхиссэлам-ын Маккаг харам болгосон шиг Мадинагийн хоёр хар чулуутын хооронд харам болгов,» гэлээ.” (Ибн-и Эсир, *Үсдү'л-Габэ,* III, 159)

Мадинагийн Зах ба Худалдааны Харилцааг Зохицуулсан нь

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Мадинад ирсэн мусульманчуудад еврейчүүдээс тусгай нэгэн газар зааж, наймаагаа тэнд хийхийг зөвшөөрөв. Учир нь наймааны талаар ирээдүйг олохын тулд тусгай захтай байхын чухал тал нь хүн бүрийн мэдсэн үнэн юм.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- захтай ойрын анхаарал үзүүлж, наймаачид болон наймааны барааг байнга хуваадаг байв.

Нэгэн өдөр Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- захад нэгэн наймаачин дээр очив. Өмнөх буудайн шуудайнд гараа оруулаад нойтон байсныг мэдрэхлээрээ:

“–Энэ юу вэ?” гэж асуув.

Эр нь:

“–Бороонд норов, аяа Аллахын Элч ээ!” гэв.

Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-:

“–Энэ нойтон хэсгийг нь дээр нь хийж хүн бүрт үзүүлж чадахгүй байна уу? Хууравгдсан нь би биш,” хэмээв. (Мүслим, ман, 164)

Кайс бин Эбий Гарэзэ -радъяллахү анх- ярина:

“Биднийг Расулаллахын үеэр «Зуучлагчид» гэж нэрлэдэг байв. Нэгэн өдөр Орчлонгийн Хүндэт Эзэн маань манайд ирээд илүү гоё нэр буй “Наймаачин” гэсэн нэр өгөөд ингэж айлдав:

“–Еэ наймаачид аа! Худалдаанд заавал худал ба тангараг орно. Тйим учраас та ч түүнд садака холиорой!” (Ахмад, IV, 6; Эбү Давуд, Бүюү’, 1/3326)

Хүн хэдий анхаарсан ч мартаад буюу санаандгүйгээр худалдаанд эрх бусын байдал илэрч мэднэ. Ийм учраас хамаг магадлалыг бодож тооцоотой хандаад ашгаасаа хандивыг элбэгээр өгөөд тусламж тараах хэрэгтэй. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- дээрх хадис-и шарифдаа үүнд анхаарал татна.

Рифаа бин Рафий -радъяллахү анх- ингэж хэлнэ:

“Бид Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хамт Мусалла[23] руу явж байлаа. Эзэн маань хүмүүсээс заримыг худалдаа хийж байхад харав. Тэдэнд:

«–Наймаачид аа!» хэмээн дуудав. Тэд ч Аллахын Элчийн дуудсанд сонордон анхаарч Түүн өөд харж эхлэв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

23. **Мусалла:** Нэгэн нутгийн хүмүүсийн жума, баяр ба оршуулгийн мөргөлийг хамтдаа үйлдэхээр зориулсан өргөн оронд олгосон нэр. Анхны үед ердөө хотын гадаа хамтын мөргөлийн төлөө мусалла бэлтгэж баяр, жума мэтийн хамтын мөргөлийг өнөөдрийнх шиг тус тустай мэсжидүүдэд биш, зөвхөн эдгээр мусаллануудад үйлддэг байв. Ингэхдээ хотын хамаг иргэнийг долоо хоногт нэг удаа цуглах боломж хангасан болж байв.

«–Андашгүй нь наймаачид киямат өдөр фажир болоод сэрнэ. Зөвхөн Аллахаас айсан, сайн сайхныг хийсэн ба хандив өгсөн нь үүнээс гадна үлдэнэ,» хэмээв.” (Тирмизий, Бүюү’, 4/1210)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь наймааны ёс суртахуун ба эрдмийн тухай Бэний Исраилын салих хүмүүсээс хоёр хүний хооронд болон ийм нэгэн явдлыг өгүүлжээ:

“Эрт нэгэн эр амьдарч байжээ. Тэр эр нэгэн наймаачнаас хэсэг шороо худалдаж авчээ. Гэтэл шороон дотроос ваартай алт олов. Нөгөө эр худалдаачин дээр буцаж очоод ‘–Май энэ алтаа ав. Би чамаас шороо авсан алт аваагүй’ гэхэд худалдаачин ‘-Би шороо зарсан, тэгэхээр шороон дотор байгаа бүхэн чинийх’ гэв. Ингээд тэд шүүгч дуудаж шүүлгэхээр болжээ. Шүүгч заргыг сонсоод та нар хүүхэдтэй юу гэж асуув. Тэдний нэг нь хүүтэй нөгөө нь охинтой юмсанжээ. Тэгээд шүүгч та хоёр хүүхдүүдээ гэрлүүл. Тэдний хуримд хамтран хөрөнгө зарцуул, бас адилхан хандив тараа гэжээ.” (Бухарий, Энбияа, 54; Мүслим, Акдия, 21; Ибн-и Мажэ, Луката, 4)

Залуудаа наймааны жингээр хол аянд явсан авъяастай наймаачин байсан Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Мадинад ирэхдээ энэ зарим зарчим тогтов. Наймааны чухал талын тухай ингэж айлдав:

“Ашгийн аравны ес нь наймаанд байдаг.” (Сүюүтий, I, 113)

“Хүний идсэн юмын хамгийн халал ба сайхан нь, өөрөө олоод идсэн нь юм.” (Ибн-и Мажэ, Тижарат, 1)

Учир нь идээний эдийн нөлөөнөөс гадна бас сүнсний нөлөө ч байдаг. Умх нь халал, харам эсвэл сэжигтэй замаар ирсэн нь, бидний сүнсийг нөлөөнд оруулна. Өөрөөр хэлбэл идсэн умхны маань сүнсний байдал нь бидний мэдрэмжийг нөлөөнө.

Хамаг залбирлын зэрэг ялангуяа хажжийг үйлчилгээнд халал мөнгөний чухал талыг хадис-и шарифдаа ингэж тайлбарлав:

"Хэн нь уг Бэйтийг харам ашгаар олсон мөнгөөр зочилбол Аллахын үгнээс халсан байх болно. Ийм хүн хажжийн зорилго хийж, ихрамаа нөмөрч, дөрөө гишгэн тэмээгээ хөдлүүлсний дараа «Лэббэйк Аллахүммэ лэббэйк» гэвэл тэнгэрээс нэгэн ингэж дуудна: «Чамд лэбээйк ч Жа'дэйк ч үгүй. Учир нь чиний ашиг чинь харам, хоол чинь харам, унаа чинь харам юм. Ямар ч буян ололгүй, нүгэлтэн буйгаараа харь! Дургүй юмтайгаа уулзах тул гунь!»

Гэтэл хүн халал мөнгөтэйгөөрөө хажийн аянд гарч, унааны дөрөөг гишгэж тэгж малаа хөдлүүлээд «Лэббэйк Аллахүммэ лэббэйк» гэвэл тэнгэрээс нэгэн дуудна: «Лэббэйк ба Жа'дэйк. Чамайг би хариуллаа. Учир нь чиний унаа чинь халал, хувцас чинь халал, хоол чинь халал юм. Одоо маш том буян олсон, нүгэлд огт ороогүй буйгаараа харь! Чамайг хангалуун таатай болгох зүйлстэй уулзах тулдаа баяс!»" (Хэйсэмий, III, 209-210)

Идээ ба ашигт халал ба харамын сэдэв нь маш чухал ба ихээр зөрдөг хэргүүд буй тул, Бакара Сурад тэнгэрлэг дүрэм журмаар, түм ширкийн дараа энэ хаалгыг хаасан байдаг. Түүнчлэн их дүрэм агуулсангүй Эн'ам, А'раф, Юүнүс ба Нахл мэтийн Маккий сурануудад ч дүрэм журамтай хамаатай аетуудын дэргэд шууд идээ ба мөнгөний ашгийн халал-харам шинжийг тайлбарласан байдаг.[24]

Аллахын Элч нь наймаанд шударга ба зоригтой хандах хэрэгтэйг мэдүүлэн ингэж айлдав:

24. эл-Эн'ам, 136-152; эл-А'раф, 32-33, 169; Юүнүс, 59-60; эн-Нахл, 95, 115-116. Хар. Драз, *эн-Нэбэү'л-Азим, х.* 193.

“Бараагаа худалдаанд дайлсан зоригтой наймаачин нь мэрзүк (ризикжүүлсэн), мүхтэкир (дамлагч) бол хараалт болсон юм.” (Ибн-и Мажэ, Тижарат, 6)

“Айсан наймаачин нь алдана, зориг наймаачин нь олно.” (Дэйлэмий, II, 79)

Пайгамбар Эзний маань наймааны тухай илэрхийлсэн зарчмын зарим нь ч ийм байдаг:

“Худалдаа хийсэн хоёр хүн, нэг нэгээсээ салаагүй байхдаа эсвэл салтлаа больж болно. Хэрэв шударга худалдаа хийиж хамаг юмыг буйгаар нь тайлбарлавал, тэдний худалдаа элбэгтэй байх болно. Хэрэв зарим үнэнийг нууж худал хэлбэл тэдний худалдаа элбэг болохгүй.” (Бухарий, Бүюү’, 19; Мүслим, Бүюү’, 8)

“Тангараг нь малд анхаарал татаад, харин элбэгийг холдуулна.” (Бухарий, Бүюү’, 26; Мүслим, Мүсакат, 13)

Пайгамбар Эзэн маань наймааны барааг захад авчрахаас өмнө замд нь угтахыг, худалдаж авсан юмыг бүрэн гардаж аваахаас өмнө зарахыг эсвэл хажууд үгүй барааг захаас худалдаж аваад авагчдад зарахыг, хүмүүсийн наймаан дээр юм зарахыг, авагчдыг өдөөхийг г.м. хориглосон байдаг.[25]

Худалдааг хялбаршуулан хандах хэрэгтэйг мэдүүлсэн Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

“Зарахдаа, авахдаа, өрөө төлөхдөө өгөөмөр ба ойлголттой хандсан хүнд Аллах энэрлээ ихээр өгөх болтугай!” (Бухарий, Бүюү’, 16)

“Аллах танаас өмнө амьдарсан хэн нэгэнд энэрлээрээ хандав. Учир нь уг эр зарсандаа, авсандаа, авлагаа нэхсэндээ

25. Хар. Бухарий, Бүюү’, 70-72; Мүслим, Бүюү’, 29.

(бүдүүлэг хатуу зан биш ойлгомж ба) хялбаршил үзүүлдэг бай.” (Тирмизий, Бүюү’, 75/1320)

Эд барааны шунал ба дэлхийн ашгаар хуурагдан Расулаллах Эзний маань тогтсон эдгээр зарчмуудыг эс дагаж илүү ихийг олохоо бодогчид нь ахиратын ядуу болох аюултай учралдана. Аллахын тааламж ба ахиратын шимийг олох зорилготой буй шударга наймаачид бол Пайгамбар Эзний маань энэ гоё мэдэ-энд хүртэнэ:

“Итгэмжтэй, шударга үгтэй ба мусульман наймаачин нь киямат өдөрт шэхидчүүдийн хамт байдаг.” (Ибн-и Мажэ, Тижарат, 1)

Мэсжид-и Нэбий ба Жаргалын Гэр

Эхэнд Мадинад мэсжид байгаагүй. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- хаана таарвал мөргөлөө тэнд үйлддэг байв. Их удалгүй Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- Кубагийн дараа хоёр дахь мэсжидийг ч бариулав. Энэ нь одоогийн Мэсжид-и Нэбий мөн.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Мадинад орохдоо, Нэжжарынхны гэрийн ойролцоо ирэнгээ тэмээ нь Кавса мэсжидийг барих газар сөхрөв. Уг хөрөнгө нь тэр үеэр Нэжжарынхнаас Сэхл ба Сүхэйл гэсэн хоёр өнчний хасарваан хатаах газар байв. Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- Касвагаас бууж:

“–Иншаллах энд мөн!” хэмээв. Дараа нь:

“–Энэ хөрөнгө хэнийх вэ?” хэмээн асуухлаар нь Муаз бин Афра -радъяллахү анх-:

"–Аяа Расулаллах аа! Амрын хөвүүд Сэхл ба Сүхэйлийн юм!" гэсэн байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэднийг дуудаж энэ газрыг тэднээс худалдаж авах гэсэн юм:

"–Энэ хөрөнгөний үнийг надад хэлцгээ?" хэмээв.

Залуус:

"–Үгүй, аяа Расулаллах! Бид тэрийг Чамд бэлэглэнэ! Валлахи бид түүний үнийг авахгүй!" гэцгээв.

Пайгамбар Эзэн маань тэднээс хөрөнгөө бэлэглэхийг зөвшөөрсөнгүй, үнийг нь төлөөд худалдаж авав. (Бухарий, Мэнакибу'л-Энсар 45, Салат 48; Мүслим, Мэсажид 9)

Уг газар мүшрикчүүдийн булш, жалга, хамар ба хасарвааны моднууд байв. Аллахын Элч тушаал өгөөд, мүшрикчүүдийг булшийг нээж, ясыг нь өөр газар шилжүүлээд, замбараагүй хэсгийг засуулж хасарвааныг огтлуулав.[26] Дараа нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- тоосго бэлтгэхийг шаардав.[27]

Мэсжидийг барихад Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч асхабынхаа хамт тоосго зөөж, нэг талаас ч:

هٰذَا الْحِمَال لاَ حِمَالَ خَيْبَرْ

هٰذَا أَبَرُّ رَبَّنَا وَأَطْهَرْ

«Энэ нь ачаа биш. Энэ нь Рабдаа үйлчлэх хамгийн сайн ба хамгийн цэвэр ажил мөн,» гэж байв. (Бухарий, Мэнакибу'л-Энсар, 45)

Пайгамбар эзэн маань энэ үгээрээ зөөж буй ачааны дэлхийн ашигтай хамаатай байгаагүйг, хүмүүсийн наймааны зорилгоор

26. Мүслим, Мэсажид, 9.

27. Ибн-и Са'д, I, 239.

авчирсан хасарваана ба хатсан үзэм мэтийн эд бараанаас илүү буянтай ба таатай буйг илэрхийлж байв.

Шороо зөөгч нэгэн эр Орчлонгуудын Эзэнтэй тааралдаад Түүнд:

«–Аяа Аллахын Элч ээ! Та зөвшөөрвөл тоосгыг тань би зөөе!» гэв. Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- хариулахдаа:

«–Чи очоод өөр нэгийг ав! Учир нь чи Аллахад надаас илүү хэрэгцээтэй биш юм!» хэмээв.” (Сэмхүдий, I, 333)

Пайгамбар Эзэн маань сүнсний хариуцлагаас болоод ч мусульманчуудыг ажиллахад урамшуулахын төлөө ч өөрөө ажиллаж байв.[28]Тэгсэнд нь асхаб-и кирамаас нэгэн энэ шүлгийг хэлэв:

لَئِنْ قَعَدْنَا وَالنَّبِىُّ يَعْمَلُ
لَذَ اكَ مِنَّا الْعَمَلُ الْمُضَلَّلُ

28. Орчлонгийн Хүндэт Эзэн маань ингэж хандсанаараа удирдах орны хүмүүсийн хариуцлагыг маш сайхан илрүүлсэн байдаг: Ажил бүрт өмнө гарах ба хийх ажил юу байсан ч бага гэж үзэхгүй, их зан гаргахгүй байв… Аллахын Элчийн үсвэ-и хасэнэгээс ашиг авсан Султан I-р Ахмад Хан Хазрат ч өөрийнх нэрээ алдаршсан урлагийн гайхамшиг буй мэсжидийн барилгын ажиллагаанд багажаа бариад ажилласан байв. Өөд болсны дараа Гэвхэр Нэсибэ Хатан түүнийг зүүдэндээ диваажинд содон нэгэн оронд хараад сонирхож асуужээ:
“–Аав аа, ямар үйлээрээ энэ сайхан орыг хүртсэн вэ?”
Султан Ахмад:
“–Миний охин, энэ мэсжидийг хийлгэхдээ би чулууг үүрч зөөв. Түүний улмаас би энэ орныг хүртэв!” гэжээ.
I-р Ахмад Хан нь Исламын ийнхүү ёс суртахууныг толилуулсанд, Османт Гүрэн газар талбайгаараа хамгийн өргөн хил хязгаартай байв. Дэлхийн эзэн хаад нь энэ гүрний содны өмнө бөхийж, ерөнхий сайдынх нь гараар титэм зүүдэг байв.

"Пайгамбарыг ажиллаж байхад бид суувал, андашгүй нь уг үйл бидний хувьд зөвхөн алмайрал байх болно!" (Ибн-и Хишам, II, 114)

Мэсжидийг барилга барих үед Хадрамуутаас, шаврыг сайн хутгадаг нэгэн эр ирэв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэр хүнд:

"–Урлагаа сайн ба бат хийгч хүнд Аллах энэрлээ буулгах болтугай! Чи энэ ажлаа үргэлж хий, миний харснаар чи ажлаа сайн хийдэг," хэмээв. (Сэмхүдий, I, 333; Диярбэкрий, I, 344)

Аугаа Эрх ч мусульманчуудын ажил сайн болохыг хүсч ает-и кэримэд; " وَأَحْسِنُوٓاْ : **Хийснээ сайхан хий, ажлаа сайн хий!"** хэмээн тушаана. Яг араас нь ч **"Аллах нь ажлаа сайхан хийгчдэд дуртай,"** хэмээн айлдаж байв. (эл-Бакара, 195)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- мэсжидийг барихад асхабынхаа хамт тоосго зөөж байхдаа, нэгэн мусульманы зохиосон энэ дууг ч дуулдаг байв:

اَللّٰهُمَّ إِنَّ الْاَ جْرَ اَجْرُالْاٰخِرَهْ

فَارْحَمِ الْاَنْصَارَ وَالْمُهَاجِرَهْ

"Аллах минь! Жинхэнэ шагнал нь ахиратын буян юм. Энсар болон Мухажирчуудад энэрлээ буулга!" (Бухарий, Мэнакибу'л-Энсар, 45)

Хүн бүр нь тоосгыг нэг нэгээр зөөж байхад Аммар бин Яасир -радъяллахү анх- нэгийг өөрийнхөө, нөгөөг нь Пайгамбар Эзний маань төлөө хоёр хоёроор зөөж байв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнийг харж, тоосыг нь сэгсэрч:

"–Аммар аа! Чи тоосгыг яагаад найзууд шигээ нэг нэгээр зөөхгүй байна вэ?" хэмээн асуув.

Тэр ч:

"–Аллахаас буяныг хүсч байна!" гэв.

Тэгэхлээр нь Пайгамбар Эзэн маань дал мөрийг элэгсэг алгадан:

"–Еэ Сүмэйегийн хүү! Бусад хүмүүст нэгэн буян бий, чамд бол хоёр буян бий!" хэмээв. (Ахмад, III, 91; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 256)

Энэ дамжуулсан үг ч мусульманчуудын эр-эмгүй Мэсжид-и Нэбийгийн барилгад дуртай ажилласныг харуулдаг юм:

"Абдуллах бин Эвфа -радъяллахү анх- эхнэр нь нас барахад арддаа ингэж хандав:

«–Түүний авсыг зөөцгөө, дуртай зөөцгөө! Учир нь тэр ба боолчууд нь, таква дээр баригдсан Пайгамбарын маань мэсжидийн чулууг шөнө зөөдөг байв. Бид (эрчүүл) ч өглөө хоёр хоёроор зөөж байлаа." (Хэйсэмий, II, 10)

Мэсжид-и Нэбий нь дөрвөлжин хэлбэртэй бөгөөд урт ба эн нь ойролцоогоор зуун зира',[29] өндөр нь ч гурван зира' нь чулуу, дээд тал нь тоосгоор болоод тав эсвэл долоон зира' орчим байв.[30] Барилгад нь шавар зуурмаг хэрэглэв.[31] Мэсжидийн кибла талд багана болгож хасарвааны модод жагсаав. Тааз ба бусад багана нь ч хасарвааны мөчрөөр хийв.[32] Нэгэн гонхтой ба гурван хаал-

29. Нэг зира' нь 75 см. юм.
30. Ибн-и Са'д, I, 239.
31. Диярбэкрий, I, 344.
32. Бухарий, Салат, 62.

гатай байв. Гонх нь Бэйтү'л-Макдисийн (Иерусалим) зүгт байв. Киблаг Бэйтү'л-Макдисаас Каба руу эргэхэд, Пайгамбар Эзэн маань анхны хаалгыг хаалгав. Түүний оронд Дамаскын ханад өөр нэгэн хаалга нээлгэв.[33]

Мэсжидийг дэргэд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ба гэр бүлийн орон сууц болох хоёр өрөө барив.[34] Дараа нь энэ өрөөний тоо ихсэв.

Ээж нь Үммү Сэлэмэ эхийн маань шивэгчин байсан бөгөөд ийм учраас бага насаа Аллахын Элчийн жаргалын гэрийн ойр хавьд өнгөрөөсөн Хасан-и Басрий Хазрат нь тэр үед эдгээр өрөөнүүдийн таазад гараа хүргэж чадсанаа илэрхийлэв.[35] Үүнээс өрөө нэг их өндөр байгаагүй нь ойлгомжтой. Эзний маань өрөөний хаалга бол хар хялгасаар хийсэн эсгий үүд байлаа.[36]

Табииний том имамчуудаас Саид бин Мүсэйеб нь Эмэбийчүүдийн эринд эдгээр өрөөнүүдийг нурааж Мэсжид-ии Нэбэвийд нэмсний тухай мэдэрсэн гомдлоо ингэж илэрхийлэв:

"Валлахи эдгээрийг ингэж байх болохыг маш их хүсэх байлаа! Ингээд шинээр өсөх үеийнхэн болон энэ газраар зочлохоор ирэх хүмүүс Аллахын Элчийн амьдралдаа юунд ханасныг үзээд, бараа нэмж үүнтэйгээ бахархахыг илүүд үздэггүй байв." (Ибн-и Са'д, I, 499-500)

Мэсжидийг дээврийг хасарвааны мөчир ба навчаар бүтээсэн тул, бороо ороход дотуур нь шавар болдог байв. Пайгамбар Эзэн маань Рамазанд итикафад татагдсанд орсон

---

33. Диярбэкрий, I, 346.
34. Ибн-и Са'д, I, 240.
35. Ибн-и Са'д, VII, 161; Сүхэйлий, I, 248.
36. Ибн-и Са'д, I, 499.

бороо нь мэсжидийн дотор урссан, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- өглөөний мөргөл үйлдүүлэхэд дух болон царайнд шаврын мөр харагддаг байв.[37]

Дахиад нэгэн шөнө бороо ороод, шал нь битүү ус болов. Нэгэн хүн хувцастайгаа элс зөөж мэсжидийг шалан дээр дэвсэж асгав. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- мөргөл үйлдэхлээрээ:

“–Энэ нь маш сайхан байна!” хэмээж таaламжаа илэрхийлэв. (Эбү Давуд, Салат, 15/458)

Тэмим-и Дарий -радъяллахү анх- Дамаскаас Мадинад буцахдаа, олон дэн, тос ба утас авчирсан байв. Мадинад хүрэхэд нь Баасан гариг байв. Үйлчлэгчдээсээ Эбү’л-Бэррадад босоод утсыг уяж, дэнг өлгөж, нар жаргасны дараа дэнг асаав. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- мэсжидэд ирээд дотуур гэрэлтэй буйг харангаа:

“–Үүнийг хэн хийсэн бэ?” хэмээн асуув.

Тэндэх хүмүүс:

“–Этмим хийсэн, аяа Аллахын Элч ээ!” гэцгээв. Үүнд нэлээд баяссан Орчлонгийн Хүндэт Эзэн маань ингэж айлдав:

“–Исламыг туяаруулж, мэсжидийг нь чимэглэжээ. Аллах ч чамайг дэлхий болон ахиратад туяаруулах болтугай!” (Сэмхүдий, II, 596-597; Ибн-и Хажар, *эл-Исаба,* II, 18)

Мэсжид-и Нэбэвий нь Пайгамбар эзний маань илэрхийлснээр залбирах ба зочлоход хүрэмжтэй гурван мэсжидийн нэгэн юм. (Бухарий, Фадлу’с-Салат, 1; Мүслим, Хаж, 505-510) Жишээлбэл нэгэн хадис-и шарифдаа ингэж айлдав:

37. Бухарий, Итикаф, 1.

"Миний гэр ба гонх хоёрын хооронд диваажингийн цэцэрлэг нэгэн юм. Надад гонхноос шалбааг минь дээр юм." (Бухарий, Фадлу'с-Салат 5, Фэдаилү'л-Мадина 11; Мүслим, Хажж 502)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Мэсжид-и Нэбэдийд үйлдсэн мөргөлийн, Мэсжид-и Харамаас гадна бусад газар үйлдсэн мөргөлөөс мянган дахин эрдэмтэй буйг мэдээлнэ. (Бухарий, Фадлу'с-Салат, 1; Мүслим, Хаж, 505-510)

Энэс -радъяллахү анх-ын ярьснаар Орчлонгуудын Эзэн хасарвааны нэгэн дүнзийг налаад чуулганд ханддаг байв. Хэрэг гарснаар нэгэн донх бариад, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- яриагаа тэрэн дээр хийж эхлэв. Аллахын Элчийн өмнө нь хутба уншиж байсан хасарвааны дүнз нь -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эзнийг маань түүнээс орхисонд нь тэмээ буйлахтай төсөөтэй дуу гарган уйлж эхлэв. Тэгсэнд нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эзэн маань гонхноос бууж дүнзийг илэв. Дүнз нь гунганахаа байж тайвшрав. (Бухарий, Жума, 26; Тирмизий, Мэнакиб, 6/3627)

Пайгамбар Эзэн маань:

*"Тэр нь хажууд нь хийсэн зикруллахаас холдсондоо уйлав!"*хэмээв. (Бухарий, Мэнакиб, 25; Ахмад, III, 300)

Дараа нь гонхон доор нэгэн нүх малтаад дүнзийг тэнд булсан ажээ. Хазрат-и Усманы үеэр мэсжидийг дахиад барихаар нураахад, уг дүнзийг Үбэй бин Ка'б -радъяллахү анх- аваад, хорхой бүгдийг нь идтэл гэртээ хадгалсан байв.[38]

Аугаа Эрхийн агуу анд Мавлана -күддисэ сиррух- нь хасарвааны энэ гайхалтай дүнзний байдлыг хэлээр яриулж, үүнийг *Мэснэдий*дээ ингэж илэрхийлэв:

38. Ибн-и Са'д, I, 251-252.

“Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- гонхноос бууж ариун гараараа хасарвааны дүнзийг илээд:

«–Хасарвааны дүнз ээ! Юу хүсээ вэ? Яагаад уйлж байна вэ? Би чамайг яах вэ?» гээд гүн хүндэтгэлтэй асуув. Хасарвааны дүнз нь хүний хэлээр ярьж эхлээд халуун нулимсаар ингэж хэлэв:

«–Аяа Расулаллах аа! Чамаас хагацах нь намайг зовоохын ихээр зовоож байна. Дотор минь тайлбарлашгүй гуниг, зовлон ба үгүйллээр дүүрэв. Өмнө нь хутбагийн цагаар Чиний түшдэг тэр аз жаргал, баяр баясгалантай багана нь би байлаа. Одоо бол Чи намайг орхив; нэгэн гонхонд өгсөв. Одоо Чиний түшиг чинь тэр гонх мөн. Харин аяа Аллахын Элч ээ! Надад хэлээч, дэлхийд хэн ямар оршигч чамаас хагацахыг тэсэх вэ?»

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- хасарваана ингэж гүнээр гашуудсаны хариуд түүнийг тайтгаруулахаар ингэж айлдав:

«–Хасарвааны дүнз ээ! Ийм хагацлын гашуудлаасаа болж орилсон бол, надад юу хүссэнээ хэл!.. Аллахад чамайг өрнөд ба дорнодын хамаг хүмүүст жимс ургуулах, ногоон, чийрэг мод болгох тухай залбирахыг минь хүсэх үү? Эсвэл чамайг диваажинд агарын соёолж болгож, чи үүрд мөнх хамгийн гоё биенүүд шиг залуу байх болоорой!..»

Энэ магтаалыг хүртсэн хасарваана дүнз нь, халуун хайрынхаа илрэлээр Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс үүнийг гуйв:

«–Аяа Расулаллах! Би өөр юу ч хүсэхгүй. Миний ганцхан хүсэл минь, Энд үхэх юм. Тэгэхэд Чи намайг булаад, уг түр зуурын биеэс минь аврах мөн. Учир нь нэгэн мод хэдий ногоо ба гоё байсан ч, идээгээ нар уснаас л авдаг. Гэтэл миний амь-

драл Чиний туяаны туяагаар тэжээгдсэн. Чамд түшиг болох, Чиний халуунаар халах ба гуниглахын амтыг амсав. Би одоо уг таатай сэтгэлээс салж чадахгүй. Би байнга амьд байхыг л хүснэ. Чи намайг булж үгүй болгож, тэгээд би Чамд ба Чний гагцхуу туяанд сэрж үүр мөнх болъё.»

Хасарвааны тэр дүнзийг киямат өдөр хүн шиг сэхэг гэж хөрсөнд булав."

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн Мадинад ирэхэд, нэг нэгэндээ угсарсан Исламын бат нэгэн нийгэм бие болгох тулд гишгэсэн анхны алхмын нэг нь Мэсжид-и Нэбэдийгийн барилга болсон байв. Учир нь мусульманчуудын эв найрамдал бий болоод, эд бараа, орон гэр ба нэр алдрын ялгаа арилж, хоногт таван удаа Аллахын гэрт цуглах л маш чухал байдаг. Ийм учраас Исламын хотууд ердөө төвөөс гадагшаа өргөдсөн байдлаар байгуулсан, төвд нь мэсжид оршиж, гэр байрнууд түүний эргэн тойронд байдаг.

Жаргалын Эринд мэсжид нь сүм болохоос гадна мөн түүнчлэн сургууль, зөвлөх хурал цугласан орон, удирдлага ба цэргийн хэрэг ярилцах төв, эмнэлэг ба амралтын газар шиг байв. Мэсжиддэх хичуул, яриа ба зикир цуглалтад байнга оролцсон, эхнэр-гэргүй сахабийчуудын байрших газар ч мэсжидийн сүффэ байв. Түүгээрээ Мэсжид-и Нэбэдий, нэг талаар зочны байр мэт бас үйлчилгээний газар шиг байв.


Абу Бэкирийн нэрэмжит хаалга
ЗҮҮН
Энэрлийн хаалга
УРД
ХОЙД
Минбэр
Равда-и Мутаххара
Михраб
Асхаб- и Суффэ
БАРУУН
Усманы нэрэмжит хаалга
Пайгамбарын өрөө

Хамтын Мөргөлийн Урам

Нийгмийн хүмүүжил Исламын хамгийн гол зарчим юм. Мусульманы нийгмийн анхны хүмүүжил хамт нийтээрээ мөргөл үйлдэж эхлэнэ. Исламын нийгмийг босоо байлгах анхны гол түшиг ба сайн үйл нь энэ юм. Хаана ч хамтаар мөргөл үйлдэж байвал, тэнд Исламын сүнсний болон нийгмийг ухаарч эхэлсэн гэсэн үг. Гишүүдийнхээ хооронд эв ээ ба нэгдэл байгуулахыг хүссэн Ислам нь мусульманы ялгах тэмдэг буй мөргөлийг хамт үйлдэхийг хүссэн бөгөөд мэсжид явахыг итгэгч болохын баталгаа гэж үзсэн байдаг. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж айлдана:

"Хэн нэгний мэсжидэд очихыг заншил болгосныг харвал түүний итгэл үнэмшилтэй буйг гэрчлээрэй. Учир нь Аллах Таала ингэж айлдав:

إِنَّمَا يَعْمُرُ مَسَاجِدَ اللّٰهِ مَنْ آمَنَ بِاللّٰهِ

«Аллахын мэсжидүүдийг зөвхөн Аллахад итгэн үнэмшигчид л дүүргэнэ...» (эт-Тавба, 18)" (Ибн-и Мажэ, Мэсажид, 19)

Үүнээс харвал мэсжидийг эд бараагаар баяжуулах нь тийм ч чухал биш итгэгчидээр дүүрэх нь чухал юм. Эбү Хүрэйрэ -радъяллахү анх-аас дамжуулсан нэгэн үгэнд ингэж хэлдэг:

"Энэ ертөнцийн гурван хачин юм байна:

Кур'аныг сайн мэдэх боловч харгис хэрцгий байх хүн, мусульман оронд боловч дотор нь мөргөлгүй мэсжид, судар мэсжид байхгүй боловч бас шүтлэггүй хүмүүсийн дунд амьдарч буй сайхан сэтгэлтэй хүн." (Дэйлэмий, III, 108/4301)

Аугаа Эрх нь мөргөлийг хамтаар үйлдэхийг маш их чухалчилдаг. Дайнд ч гэсэн цэргүүд хамтаар мөргөл үйлдэхийг тушаасан ба яаж үйлдэхийг нь ч Кур’ан-и Кэримд заасан байдаг.

Эбү Хүрэйрэ -радъяллахү анх- ингэж ярина:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэгэн дайнд явж байхдаа Дажнан Усфан хоёрын хооронд хоносон байв. Мүшрикчүүд:

«–Тэдэнд нэгэн мөргөл, тэдний хувьд ааваас болон хүүхдүүдээс ч илүү үнэтэй юм. Энэ нь оройн мөргөл юм. Бэлтгэлээ хийж, тэдэн рүү бүгдээрээ довтолцгоо!» гэцгээв. Тэгэхлээр нь Жэбраил -алэйхиссэлам- нь Аллахын Элчид ирээд дайны үед мөргөлийг яаж үйлдэхийг тайлбарласан Ниса Сурагийн 102-р аетыг авчрав.” (Тирмизий, Тэфсир, 4/21) [39]

Өөрөөр хэлбэл ямар нөхцөлд байсан ч мусульманчуудын хувьд мөргөлийг хойшлуулах эсвэл хамтаар үйлдэхийг орхих нь ерөөсөө боломжгүй юм.

Пайгамбар Эзний маань хамтаар мөргөл үйлдэхийг урамшуулсан зарим хадис-и шариф нь ийм юм:

“Хамтаар үйлдсэн мөргөл нь хүний ганцаараа үйлдсэн мөргөлөөс хорин долоон дахин илүү эрдэмтэй юм.” (Бухарий, Эзан, 30)

“Хэн нь өглөө-үдэш мэсжидэд яваад ирвэл, явах бүрт нь Аллах Таала тухайн хүний диваажин дахь шагналын бэлтгэнэ.” (Бухарий, Эзан, 37)

“Танаас хэн нэгэн абдэст аваад үүнийг сайхан хийж мөргөл явахаар гарвал, мэсжидэд ойр байсан ч хол байсан ч,

39. Хар. хуудас: 264

баруун хөлөө өргөх бүрт нь Аллах Таала түүний нэрээр нэгэн сайхан үйл бичээд, зүүн хөлөө гишгэх бүрт нь ч нэгэн нүгэлийг арилгана. Мөргөлд ирээд хамтын мөргөл үйлдвэл нүгэлийг нь өршөөнө. Хэрэв мэсжидэд ирэхэд нь бусад нь мөргөлийн хэсгийг үйлдсэн байвал тэднийг дагаж, дараа нь амжаагүй рэкатуудыг нөхвөл ижил шийдвэл хэвээрээ хүчинтэй юм. Хэрэв мэсжидэд ороход нь хүмүүс мөргөлөө үйлдэж дууссан бөгөөд, уг хүн мөргөлөө өрөө үйлдвэл, дахиад ижил дүрэм хүчинтэй юм.” (Эбү Давуд, Салат, 50/563)

“Хэн нэгэн мэсжидэд ороход төргөлийг хүлээсэн хугацаа мөргөлийн цагт тоологдоно.” (Ибн-и Мажэ, Мэсажид, 14)

Эбү Хүрэйрэ -радъяллахү анх- ингэж дамжуулна:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Аллах алдааг арилгаж төвшинийг дээшлүүлсэн юмыг танд мэдүүлж өгөх үү?» хэмээв.

Асхаб-и кирам:

«–Тийм аяа Расулаллах аа!» гэцгээв.

Аллахын Элч ингэж үргэлжлэв:

«–Бэрхшээл байсан ч абдэстыг бүтнээр авах, мэсжидэд (хүрэхээр) гишгэсэн алхмаа ихэсгэх ба нэгэн мөргөлийн дараа нөгөө мөргөлийг хүлээх. Жинхэнэ рибат[40] *нь эдгээр юм.»”* (Мүслим, Тахарэт, 41)

Езид бин Амир -радъяллахү анх- ярина:

---

40. **Рибат**: Нэфсийг үгэнд оруулах, хил хязгаарт манах ба Аллахын замд жихад хийх мэтийн утга агуулна. Ает ба хадиснуудад рибат ихээр магтсан ба түүнд том шагналууд амласан байдаг.

“Аллахын Элчийг мөргөл үйлдэхэд би дэргэд нь очив. Тэндээ суугаад олны мөргөлд орсонгүй. Эзэн маань мөргөлийн дараа бидэн рүү эргэж намайг хажууд суусныг хараад:

«–Езид ээ, чи мусульман болоогүй юу?» хэмээв.

Би:

«– аяа Расулаллах аа, мусульман болсон!” гэлээ.

Аллахын Элч:

«–Тэгээд яагаад олны мөргөлд ордоггүй билээ?» хэмээв.

«–Таныг мөргөлөө үйлдсэнийг тааж гэртээ үйлдсэн байлаа,» гэв.

Тэгэхлээр минь Пайгамбар Эзэн маань:

«–Хэрэв мөргөлд ирээд хүмүүсийг мөрглх болбол тэдний хамт үйлд. Хэрэв өмнө нь үйлдсэн байвал энэ нь чиний хувьд нафилэ байх болно. Гэртээ үйлдсэн нь ч фарзын тоонд орно,» хэмээв.” (Эбү Давуд, Салат, 56/577)

Орчлонгийн Хүндэт Эзэн маань хамтын мөргөл үйлдэхгүй байх тухай ямар ч шалтгааныг зөвшөөрсөнгүй, мусульманчуудаас байдал ба нөхцөлөө эзаны дагуу тааруулахыг шаарддаг байв. Жишээлбэл Абдуллах бин Үмм-и Мэктүм -радъяллаху анх- нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-д ирээд:

“–Аяа Расулаллах аа! Миний нүд сохор гэр ч мэсжидээс хол. Надад нэг таяг бий тэр ч надад туслахгүй. Надад мөргөлөө гэртээ үйлдэх зөвшөөрөл олгоно уу?” гэж асуув.

Эзэн маань -алэйхиссалату вэссэлам-:

“–Эзаныг сонсдог уу?” хэмээн асууж “тийм” гэсэн хариулахад нь:

"–Чамд хамтын мөргөлд ирэхгүй байх зөвшөөрөл өгч чадахгүйнээ," хэмээв. (Эбү Давуд, Салат, 46/552)

Пайгамбар Эзэн маань хол газраас мөргөлд оролцох тухай ч ингэж айлдав:

"Мөргөлийн хамгийн том ач буян ологчид нь холоос алхаж ирэгчид мөн. Имамын хамт үйлдэе гэж мэсжидийг зорин ирсэн, хүлээсэн хүн гэртээ шууд үйлдэж эхэлсэн хүнээс илүү ач буяныг хүртэнэ." (Бухарий, Эзан, 31)

"Хэн нэгний буй газар нь мэсжидээс хэдий хол байвал, мөргөлд очихдоо төдий олон ач буян олно." (Эбү Давуд, Салат, 48/556)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- хамтын мөргөлийг дагадаггүйчүүдийн тухай зарим сануулга хэлсэн байдаг. Үбэй бин Ка'б -радъяллахү анх- ингэж ярина:

"Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэгэн өдөр бидэнд өглөөний мөргөл үйлдүүлж:

«–Тэр хүн мөргөлд ирээгүй юу?» хэмээн асуув.

«–Ирээгүй,» гэцгээв.

«–Тэр нь ирэв үү?» хэмээн асуув. Дахиад:

«–Ирээгүй,» гэцгээв. Тэгэхлээр нь:

«–Өглөө ба шөнийн мөргөл мүнафизчуудад хамгийн хэцүү санагдах хоёр мөргөл юм. Та нар эдгээрт хэр их ач буян буйг мэдсэнсэн бол, мөлхөөд ч гэсэн ирэхсэн. Эхний эгнээ нь мэлэкчүүдийн эгнээ гэсэн үг. Тэндэх эрдмийг мэдсэнсэн бол тэнд уралдаж очихсон. Хэн нэгний өөр нэгэнтэй хамт буй мөргөл нь ганцаараа үйлдсэн мөргөлөөс илүү элбэг ба илүү ач буянтай байдаг. Хоёр хүнтэй хамт үйлдсэн мөргөл ч нэг

хүнтэй хамт үйлдсэнээс илүү элбэг ба давуу талтай байдаг. Хамт үйлдэгчдийн тоо хэдий олон байвал, Аллах Таалад төдий их таалагдана,» хэмээв." (Эбү Давуд, Салат, 47/554)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- өөр нэгэн хадистаа:

"Мэсжидээс хол гадуур үйлдсэн мөргөл, зөвхөн бүрэн төгс гүйцэтгэсэн тохиолдолд мөргөлд үйлдсэний тоонд орно," хэмээн айлдав. (Ибн-и Эбий Шэйбэ, I, 303)

Дараа нь хүмүүс Хазрат-и Алигаас уг хадис-и шарифад дурдсан мэсжидийн хөрш нь хэн бэ гэж асуувал тэр:

"–Мүэззийнийг сонссон хүн бүр нь," гэсэн хариуг өгсөн байдаг. (Бэйхакий, *эс-Сүнэнү'л-Кубра,* III, 57)

Пайгамбар Эзний маань уг хадис-и шариф бол чуулгыг орхигчдын тухай маш хүнд сүрдүүлэг агуулдаг:

"Нэгэн тосгон эсвэл хээрт гурван хүн болж мөргөлөө хамт үйлдэхгүй бол, чөтгөр тэднийг бүсэлж ялна. Тийм байхад хамтын мөргөлөө орхиузай. сүргээс салсан хонийг чоно барих мэт адил юм гэжээ" (Эбү Давуд, Салат, 46/547)

"Нэг бол зарим хүмүүс хамтын мөргөлөө орхихоо болино, эсвэл Аллах тэдний зүрхийг тамгалж тэд төөрөгчид байх болно." (Ибн-и Мажэ, Мэсажид, 17)

Анхны Эзан

Мөргөлийн цагийг нийтэд дуулгахаар эхлээд зөвхөн "Мөргөлдөө, мөргөлдөө!" гэж хэлдэг байцгаав. Дараа нь бол Эзан-и Мухаммедий хайрлагдав.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ард түмнийг мөргөлд урих арга яаж болох хэрэгтэйн тухай асхабтайгаа зөвлөлцөж байв.

Зарим нь “Мөргөлийн үе эхлэхэд нэгэн далбаа босгоё, мусульманчууд тэрийг харахлаараа бие биедээ мэдүүлэг,” гэв. Гэтэл энэ санаа нь Пайгамбар Эзэнд маань таалагдаагүй.

Еврей бүрээ дуудахыг санал болговол, тэр ч таалагдаагүй: *“Тэр нь еврейчүүдийн багаж юм,”* хэмээв.

Цан цохихыг санал болгов. Пайгамбар Эзэн маань: *“Тэр ч христчүүдийн үйл юм,”* хэмээв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн бодлоор бодогширсон, Түүний зовлонгоор зовсон Абдуллах бин Зэйд[41] -радъяллахү анх- тэндээс салж явав. Нойр сэрүүн хоёрын хооронд байхад түүнд Эзан-и Мухаммедийг бэлэг болгож хайрлав. Шууд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд очоод:

41. **Абдуллах бин Зэйд бин Асим эл-Энсарий** нь Ухудын Газвад Пайгамбар Эзнийг маань ойроос хамгаалсан учраас Түүний магтаалыг хүртэв. Энэ дайнд зөвхөн Абдуллах биш, түүний хамаг гэр бүл том баатарлаг тэмцэлдсэн билээ. Аллахын Элч ч тэднийг диваажинд өөртөө хөрш болохын тулд залбирав. Пайгамбар Эзэн маань заримдаа Абдуллах бин Зэйдийн гэрт ирээд тэнд абдэст аваад мөргөл үйлддэг байв. Абдуллах бин Зэйд эл-Энсарий -радъяллахү анх- нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д их дуртай сахабийчуудын нэг байв. Эзний маань таалал төгссөний мэдээг сонмогцоо энэ гашуун мэдээгээр их хөдөлсөн Хазрат-и Абдуллах: “Аллах минь! Нүдийг минь ав, ганц хайр минь Хазрат-и Мухаммед -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дараа хэнийг ч би эс харъя,” гэж залбираад тэр мөчид сохров. (Куртубий, V, 271)
Абдуллах -радъяллахү анх- нь Харрэгийн Хэрэг гэж мэдэгдсэн дайнд хоёр хөвүүнийхөө хамт шэхид бодов.

“–Намайг унтаа сэрүүн хоёрын хооронд байхад хэн нэгэн ирээд надад эзаныг заалаа” гэв.

Хазрат-и Умар -радъяллахү анх- ч ижил зүүдийг харсан байв… Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Еэ Билал аа, босоод Абдуллах бин Зэйдийн заасныг хий!” хэмээв.

Билал -радъяллахү анх- ч Абдуллахын хэлснийг тэр чигээр нь хийж эзан уншив. (Эбү Давуд, Салат, 27/498)

Ингээд эзан нь важибын төвшинд хүчтэй нэгэн сүннэт болов. Учир нь тэр үнэнч зүүд, Пайгамбарын сүннэт, бас тэнгэрлэг вахийгаар тогтсон байдаг. Ает-и кэримэ:

وَإِذَا نَادَيْتُمْ إِلَى الصَّلاَةِ

“Тэднийг мөргөлд дуудахад...” (эл-Маида, 58) хэмээдэг.

Эзаныг зохиоход хэдий арга нь Абдуллах бин Зэйд -радъяллахү анх- байсан ч, вахий болон нууцын эрдмийг олсон нь байнга Оршигчдын Туяа Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эзэн маань байв. Эзан нь Түүний баталснаар хүчинтэй болоод хүмүүсийг мэсжидэд дуудаж эхлэв. Билал-и Хабэший нь анхны эзаныг уншихад Мадинагийн нэг захаас нөгөө захад хүрэв. Эзаны дуугаар тэнгэр цуурайтав. Итгэгчид агуу их жаргалтайгаар мэсжид рүү гүйв.

Оршигчдын Туянд мөргөлд урих тулд янз бүрийн арга санал болгосон боловч эдгээрээс аль нь ч Түүнд таалагдаагүй, эзаныг бол дуртай зөвшөөрсөн байв. Учир нь эзан нь Исламын Аллах, пайгамбар, залбирал үйлчилгээ ба аж ахуйн аргыг сургамжтай товчилж хооронд нь бат холбоо бариулна. Тийм

болохоор Аллахын Элч мөргөлд урих тухай хамгийн оновчтой аргыг илүүд үзсэн байдаг.

Эзан нь ает болон хадистайгаар тогтсон бөгөөд мянга дөрвөн зуун гаруй жилийн турш итгэгчдэд агуу урилга болж үргэлжилжээ. Мөргөлийн түгээмэл дуудлага юм. Ийм учраас жинхэнэ үгээс өөрөөр унших болдоггүй. Тэр нь бараг тэнгэрийн ая шиг байдаг.

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж айлдсан байдаг:

“Эзаныг сонсонгоо мүэззиний хэлснийг (үг үгээр нь) давтацгаа. Дараа нь надад салат ү сэлам илгээцгээ. Учир нь надад хэн ч салат ү сэлам илгээвэл Аллах ч түүнд арван дахинаар энэрэл буулгана. Дараа нь надаас Вэсилэ нэхэцгээ. Тэр нь диважинд нэгэн цол бөгөөд, заавал Аллахын боолчуудаас нэгний байх болно. Би түүнд хүртэх хүн болохыг найдна. Хэн ч миний төлөө Аллахаас Вэсилэг нэхвэл, миний шэфаат түүнд важиб байх болно.” (Мүслим, Салат, 11; Эбү Давуд, Салат, 36/523)

Дахиад Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- өөр нэгэн хадис-и шарифдаа мүэззиний хамт эзаныг давтсан хүний диваажинд орохыг мэдээлсэн байдаг.[42] Эзаны дараа хэлэх залбирлын тухай бол ингэж айлдав:

“Хэн ч эзаныг сонсохдоо:

اَللّٰهُمَّ رَبَّ هٰذِهِ الدَّعْوَةِ التَّامَّةِ وَالصَّلاَةِ الْقَائِمَةِ اٰتِ مُحَمَّدًا نِ

الْوَسِيلَةَ وَالْفَضِيلَةَ وَابْعَثْهُ مَقَامًا مَحْمُودًا نِ الَّذِي وَعَدْتَهُ

42. Мүслим, Салат, 12.

«Аяа энэ дутуугүй урилга болон үйлдэх мөргөлийн Раб аа! Хазрат-и Мухаммед -алэйхиссалатү вэссэлам-д Вэсилэ болон эрдмийг хайрлаж, Түүнийг амласан Макам-и Махмуд дээр сэргэх болтугай!» гэвэл, түүнд киямат өдөр би заавал шэфаат хийнэ.” (Бухарий, Эзан, 8; Эбү Давуд, Салат, 37/529)

Тэнгэрлэг нэгэн дуу буй эзаны эрдмийн тухай маш олон хадис-и шариф хэлсэн байдаг. Эдгээрээс заримыг дурдвал:

“Хоёр залбирал байдаг бөгөөд огт татгалздаггүй эсвэл маш ховор татгалзна: Эзаныг уншихад хийсэн залбирал ба Аллахын замд жихад хийж байхдаа хүмүүс бие биедээ довтолсон мөчийн залбирал.” (Эбү Давуд, Жихад, 39/2540)

“Хүмүүс нь эзан унших ба мөргөлд анхны эгнээнд суухын буяныг мэдсэнсэн ба эдгээрийг хийж чадахаар хонжвор татаж чадахсан бол, заавал тэгэх байв.” (Бухарий, Эзан, 9, 32; Мүслим, Салат, 129)

“Мөргөлд эзан уншихад чөтгөр дуу чимээтэй хий гарган холдож эзаныг дуулахгүй газар хүртэл зугтана. Эзаныг дуусахлаар буцаж ирнэ. Камэтыг эхлэхлээр дахиад холдож, дуусахлаар нь буцаж хүн ба зүрхнийх нь хооронд орж: «Үүнийг бод, түүнийг сана!» гээд ухаанд нь өмнө нь огт байгаагүй зүйлсээр хардлага олгоно. Тэгээд үүнд автсан хүн хэдэн рэкат үйлдсэнээ мэдэхгүй байх болно.” (Бухарий, Эзан, 4; Мүслим, Салат, 19)

Асхаб-и Сүффэ: Ухаан ба Хүмүүжлийн Сургууль

Мэсжид-и Нэбэвийгийн нэг талд эргэн тойрон нь нээлттэй ба дээрээ хасарвааны мөчрөөр хаасан нэгэн сүффэ[43] хийцгээв. Гэр хөрөнгөгүй ядуу мусульманчууд энд хоноод тэднийг

43. Сүффэ нь гэр орнуудад буйдан шиг өндөр суудлыг нэрлэх үг юм. Цаг хугацааны турам “софа” гэгч хэрэглэдэг болсон байдаг.

“Асхаб-и Сүффэ” эсвэл “Эхл-и Сүффэ” гэдэг байв.[44] Тэдний дундаас гэрлэсэн, дайнд явсан, өөр газар суурьшсан эсвэл нас барсан нь байхад тоо нь өөрчилж, заримдаа ихэсч, заримдаа багасдаг байв. Нэгэнтээ тэдний тоо дал орчим хүрсэн удаатай.

Зарим номын эхэнд Сүффэгийн хүмүүсээс зуу гаруй сахабийгийн нэрийг дурддаг. Тэдний хүнсийг Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- хангаж, боломжтой сахабийгийн тэдэнд туслахыг гуйдаг байв.

Асхаб-и Сүффэгээс байсан Эбү Хүрэйрэ -радъяллахү анх- ингэж хэлдэг:

“Сүффэгийн хүмүүс нь Исламын зочид байв. Тэдэнд хорго-дох гэр бүл, эд бараа ч, хамаатан садан хэн ч байгаагүй. Садака ирвэл Пайгамбар Эзэн маань тэдэнд илгээж, өөрөө түүнээс юм авдаггүй байв. Хэрэв ирсэн нь бэлэг бол өөрөө түүнээс хэсэг аваад бусдыг дахиад Асхаб-и Сүффэд илгээдэг байв. Ингэж ирсэн бэлгийг тэдэнтэй хуваалцдаг байв.” (Бухарий, Рикак, 17)

Дахиад Эбү Хүрэйрэ Хазрат ингэж хэлэв:

“Би Сүффэгээс далан хүнийг харсан. Тэдний аль нэгэнд ч хамаг биеэ далдалсан хувцас байгаагүй. Нэг бол нуруугаас доош өмсдөг изар буюу хормойтой эсвэл нуруунаас дээш өмсдөг рида буюу нөмрөгтэй байцгаав. Хувцсаа хүзүүндээ уядаг байв. Эдгээрээс зарим нь шилбэнд, зарим нь бол өсгийд нь хүрдэг бөгөөд ичгүүрийн газар харагдахгүйн тулд хувцсаа гараараа барьдаг байв. (Бухарий, Салат, 58)

Фэдалэ бин Үбэйд -радъяллахү анх- бол ингэж хэлэв:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг асхабдаа мөргөл үйлдүүлж байхад зарим нь өлсгөлөнгийн хүч тэнхээ

44. Ибн-и Са’д, I, 255.

алдсанаасаа босоо байж чадалгүй ухаан балартаж унадаг байв. Эд нар Сүффэгийн Хүмүүс байв. Цөлөөс ирсэн бадавийчууд: «Эд нар галзуу!» гэдэг байв. Аллахын Элч мөргөлөө дуусангаа өлссөнөөсөө ухаан балартагсдын дэргэд очоод тэднийг тайтгаруулан:

«Аллах Таалагийн онгонд таны төлөө юу бэлтгэснийг мэдсэнсэн бол, бүр илүү ядуу зүдүү болохыг хүсэх байцгаав,» хэмээн айлддаг байв.” (Тирмизий, Зүхд, 39/2368)

Абдуррахман бин Эбү Бэкир -радъяллахү анхүмаа- ч энэ байдлыг дамжуулна:

“Сүффэгийн Хүмүүс үнэхээр ядуу хүмүүс байв. Нэгэн удаа Нэбий -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

«–Хоёр хүний хоолтой нь (Сүффэгийн хүмүүсээс) гурав дахийг; дөрвөн хүний хоолтой нь тав дахь, түүнчлэн зурга дахийг хоолонд урьж аваг!»

Аав Эбү Бэкир маань тэднээс гурван хүнийг манайд авчрав. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч арван хүнийг жаргалын гэртээ аваачаад хооллов … Аллахад тангараг өргөе, бидний идсэн умх бүрийн араас хоол нь улам ихэсч байв. Эцэст нь зочид цадав. Хоол ч анх ирснээсээ илүү болсоор байв. Эбү Бэкир хоол руу хараад эхнэртээ хандаж:

«–Еэ Бэний Фирасын охин минь! Энэ юу вэ?» гэв.

Тэр ч:

«–Нүдний хараагаараа тангараг өргөе, хоол нь одоо өмнөхөөсөө гурван дахин илүү!» гэв.” (Бухарий, Мэвакит 41, Мэнакиб 25, Эдэб 87-88; Муслим, Эшрибэ 176-177)

Энэ үзвэр нь цэвэр сэтгэл ба өгөөмөр зангийн олгосон элбэгийн бодит нэгэн жишээ юм.

Сүффэгийн Хүмүүс ажил олбол ажилладаг, бусад үедээ мэсжидэд шинжлэх ухаан ба залбирал үйлчилгээнд оролддог байв. Хүч бяр сайтай байсан Сүффэгийнхэн, уулнаас мод үүргэж авчрах, ус зөөх мэтийн чадах хамаг ажлыг хийдэг, олсон мөнгөөрөө найзууддаа хоол авдаг байв.[45] Нэр алдартаа хайртай тул буруу хазгай юм огт хийдэггүй. Хэнээс ч юм гуйдаггүй байв.

Сахаб-и Сүффэ нь жаргалын булагт хамгийн ойр, Расулаллахын цуглалтыг хамгийн ихээр дагадаг хүмүүс байв. Ийм учраас тэд илүү хурдан боловсорч байв. Тэдний багш нар Хазрат-и Пайгамбараар тэргүүлсэн Үбэй бин Ка'б, Ибн-и Мэс'үд, Муаз бин Жэбэл ба Убадэ бин Самит мэтийн эрдэмтэн сахабийчууд байв.

Эхл-и Сүффэ нь дээд төвшний ба бараг хурдавчилсан боловсрол үздэг байв. Тэгээд хамгийн олон хадис-и шариф дамжуулсан сахабийчууд (мүксирүүн) ердөө тэдний дундаас гарсан байдаг. Эднийг түрүүлсэн Эбү Хүрэйрэ Хазрат үүнийг хэлжээ:

"Хүмүүс нь «Эбү Хүрэйрэ их олон хадис дамжуулна,» гээд гайхдаг... Мухажир ах дүүс маань захад худалдаатай, Энсар ах дүүс талбайдаа газар тариалантайгаа оролдож байхад, Эбү Хүрэйрэ нь ходоодоо цатгахаар Аллахын Элчийн дэргэд байж байгаад, тэдний гэрчлээгүй хамаг олон зүйлсийг гэрчилж, цээжилж чадаагүй зүйлсийг цээжилдэг байв." (Бухарий, Илим, 42)

Исламыг сурахаар богино хугацаагаар Мадинад ирсэн хамт олнууд нэг талаас Оршигчдын Туяатай уулзаж байхдаа, нөгөө талаас ч Асхаб-и Сүффэгээс мэдээгүй зүйлсийг мэдэж авдаг байцгаав. Мадинагаас гадна шинээр мусульман болсон

45. Бухарий, Мэгазий 28, Жихад 9; Ибн-и Са'д, III, 514.

аймгуудад Исламыг сургахаар багш илгээх хэрэгтэй болоход, эдний дундаас сонгодог байв.

Асхаб-и кирамын хооронд эрдмийн талаар Хулафа-и Рашидийн, Ашара-и Мүбэшшэрэ ба Асхаб-и Бэдирийн дараа Асхаб-и Сүффэ нь ирдэг байв. Аллах Таала тэдний зарим аетуу-уддаа шагшсан байдаг. Аугаа Эрх ингэж айлдана:

لِلْفُقَرَاء الَّذِينَ أُحصِرُواْ فِي سَبِيلِ اللّهِ لاَ يَسْتَطِيعُونَ ضَرْبًا فِي الأَرْضِ يَحْسَبُهُمُ الْجَاهِلُ أَغْنِيَاء مِنَ التَّعَفُّفِ تَعْرِفُهُم بِسِيمَاهُمْ لاَ يَسْأَلُونَ النَّاسَ إِلْحَافًا وَمَا تُنفِقُواْ مِنْ خَيْرٍ فَإِنَّ اللّهَ بِهِ عَلِيمٌ

“Таны ач буян **өөрсдийгөө Аллахын замд зориулсан, ийм учраас дэлхий даяар ашгийн төлөө явдаггүй ядуучуудад хүрэг. Мэдэхгүй хүмүүс, төлвөөс нь болж тэднийг баян гэж бодно. Чи тэднийг царайгаар нь танина. Учир нь тэд царай алдаж гуйдаггүй. Таны хийсэн хамаг ач буяныг Аллах заавал мэддэг.”** (эл-Бакара, 273)

Хаббаб -радъяллахү анх- ингэж ярина:

“Мүшрикчүүдийн томчуудаас Акра бин Хабис ба Үейнэ бин Хясн нь Аллахын Элчийн дэргэд ирцгээв. Түүнийг Билал, Сүхэйб, Аммар, Хаббаб мэтийн ядуу ба хэн хүнгүй мусульманчуудын дунд суухад олцгоов. Эргэн тойрны энэ хүчгүй мусульманчуудыг дооромжилж Эзэнд маань:

«–Бидний төлөө эднээс тустай нэгэн цуглаан хийхийг чинь нэхнэ. Ингэж Арабчууд биднийг эднээс давуу буйг ойлгог. Чиний ч мэдсэнээр бидэнд Араб аймгуудаас зарим элч ба хамт олнууд ирдэг. Тэдний биднийг энэ боолчуудын хамт харснаас бид ичнэ. Тэгэхээр биднийг ирэхэд тэндийг хажуугаасаа хол-

дуул. Бидний Чамтай ажил дууссаны дараа, хүсвэл тэдэнтэй дахиад суу,» гэцгээв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Болно,» хэмээв.

Тэд бол:

«–Болно гэсэн чинь хүрэмжгүй! Бидэнд үүнийг бичээд өг,» гэцгээв.

Тэгэхлээр нь Аллахын Элч -алэйхиссалатү вэссэлам-Хазрат-и Алиг дуудаж, бас бичүүлэхээр хуудас нэхэв. Бид нэгэн буланд сууж байцгаалаа. Тэр хооронд Жэбраил -алэйхиссэлам-эдгээр ает-и кэримэчүүдийг авчрав:

وَلاَ تَطْرُدِ الَّذِينَ يَدْعُونَ رَبَّهُم بِالْغَدَاةِ وَالْعَشِيِّ يُرِيدُونَ وَجْهَهُ مَا
عَلَيْكَ مِنْ حِسَابِهِم مِّن شَيْءٍ مَا مِنْ حِسَابِكَ عَلَيْهِم
مِّن شَيْءٍ فَتَطْرُدَهُمْ فَتَكُونَ مِنَ الظَّالِمِينَ

«Өглөө-үдэшгүй Аллахын тааламжийг ерөөж Рабдаа залбирагсдыг хажуудаасаа огт холдуулуузай! Тэдний тооцооноос Чамд ямар ч хариуцлага үгүй. Чиний тооцооноос ч юу ч тэдэнд харьяалахгүй. Хэрэв тэндийг холдуулбал Чи ч харгисчуудаас байх болно!» (эл-Эн’ам, 52)

وَكَذَلِكَ فَتَنَّا بَعْضَهُم بِبَعْضٍ لِّيَقُولواْ أَهَـؤُلاء مَنَّ اللّهُ
عَلَيْهِم مِّن بَيْنِنَا أَلَيْسَ اللّهُ بِأَعْلَمَ بِالشَّاكِرِينَ

«Бид тэдний хэсгийг бусадтайгаар нь: “Аллах бидний дундаас эднийг илүүд үзэв үү?” гэцгээг гэж ингэж шалгав. Аллах талархагчдыг хамгийн сайн мэдсэн нь биш үү?» (эл-Эн’ам, 53)

وَإِذَا جَاءكَ الَّذِينَ يُؤْمِنُونَ بِآيَاتِنَا فَقُلْ سَلاَمٌ عَلَيْكُمْ
كَتَبَ رَبُّكُمْ عَلَى نَفْسِهِ الرَّحْمَةَ

«Аетуудад маань итгэгсдийг Чамд ирэхэд ингэж хэл: “Та бүхэнд мэнд! Раб тань рахмат ба энэрэл хийхийг амлав.”…» (эл-Эн’ам, 54)

Орчлонгуудын Эзэн нь гэрээг бичүүлэхээр авчруулсан хуудсыг нэг талд тавиад биднийг хажуудаа дуудав. Биднийг онгонд нь орохлоор:

سَلاَمٌ عَلَيْكُمْ كَتَبَ رَبُّكُمْ عَلٰى نَفْسِهِ الرَّحْمَةَ

«…Та бүхэнд мэнд! Раб тань рэхмэт ба энэрэл хийхийг амлав…» хэмээж байв.

Бид Түүнд дөхөөд, өвдгөө Түүний өвдгөнд тулав. Уг ает буусны дараа, бид хэвээрээ Эзний маань дэргэд суусаар байв. Харин Тэр дуртай цагтаа босч явдаг байв. Хэзээ ч:

وَاصْبِرْ نَفْسَكَ مَعَ الَّذِينَ يَدْعُونَ رَبَّهُم بِالْغَدَاةِ وَالْعَشِيِّ يُرِيدُونَ
وَجْهَهُ وَلَا تَعْدُ عَيْنَاكَ عَنْهُمْ تُرِيدُ زِينَةَ الْحَيَاةِ الدُّنْيَا

«Өглөө-үдэш тааламжийг нь гуйж Рабдаа залбираг-чдын хамт чин сэтгэлээрээ тэвч! Дэлхийн амьдралын чимэ-

глэлийг хүсээд нүдээ тэднээс салгуузай!..» (эл-Кэхф, 28) ает-и зэримэ нь бууснаас хойш тэгж хандаагүй. Үүний дараа бид илүү нямбай хандаж эхлэв. Хамт суухдаа цаг нэлээд өнгөрөхөд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг санаа амар босч чадахын тулд бид эелдэг хандаж эртхэн босоод Түүний дэргэдээс холддог байв. (Ибн-и Мажэ, Зүхд, 7; Табэрий, *Тэфсир,* VII, 262-263)

Уг сүүлийн ает-и кэримэг буухлаар Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- шууд босоод тэр ядуу сахабийчуудаа хайж тэднийг мэсжидийн хойд талд Аллахыг дурдаж байхад олов. Тэгээд:

“Амийг минь авахаас өмнө үммэтээсээ энэ хүмүүсийн хамт тэвчихийг тушаасан Аллахад хамд болог! Одоогоос хойш миний амьдрал ч үхэл ч таны хамт юм,” хэмээв. (Вахидий, х. 306)

Эбү Саид -радъяллахү анх- ярина:

“Мухажирчуудын ядуучуудаас заримын хамт сууж байлаа. Эднээс хэсэг нь хамаг биеэ далдлах хувцас үгүй тул бусадын сүүдэр дүрсийг ашиглан сайхан далдлахыг хичээж байв. Нэгэн ч бидэнд Кур’ан уншиж байв. Гэтэл Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- гарч ирээд бидний дэргэд зогсов. Аллахын Элчийг ирэхлээр Кур’ан уншигч нь уншихаа байв. Расулаллах ч мэнд хүргэж:

«–Юу хийж байна вэ?» хэмээн асуув.

«–Аяа Аллахын Элч ээ! Тэр нь бидний багш юм, бидэнд Кур’ан уншина. Бид ч Аллах Таалагийн номыг сонсоно,» гэцгээлээ.

Тэгэхлээр маань Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Үммэтийн минь дэргэд, тэдний хамт тэвчихийг минь тушаасан хүмүүсийг туурвисан Аллахад хамд болог!» гэв.[46]

Дараа нь Аллахын Элч өөрийгөө бидэнтэй хамт суув. Гараараа зааж:

«–Ингэж (чагт болцгоо!)» хэмээв.

Хамт олон маань эргэн тойронд нь чагт хийж, нүүрээ Түүн өөд эргүүлэв. Эцэст нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- бидэнд ийм сайхан мэдээ хүргэж өгөв:

«–Еэ ядуу мухажирчууд, сонин сайхан бий! Танд киямат өдөрт бүхэл нэгэн туяа мэдээлье. Та нар диваажинд баячуудаас хагас өдөр өмнө орцгооно. Уг хагас өдөр (дэлхийн өдрөөр) таван зуун жилтэй тэнцүү мөн.»" (Эбү Давуд, Илим, 13/3666)

Пайгамбар Эзэн Хазрат-и Аиша Эхтэй Гэрлэсэн нь

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ба Аиша эхийн маань гэрлэх гэрээ нь хижрэтээс өмнө Маккад болсон ч, харин хурим нь Мадинад хэрэгжсэн байдаг.

Хазрат-и Аиша -радъяллахү анха- ингэж ярина:

Аллахын Элчийг Мадинад нүүсэнд бид болон охидоо Маккад үлдээсэн байв. Дараа нь Зэйд бин Хариса ба Эбү Рафийг хоёр тэмээ ба хэрэгцээтэй юмыг авахаар 500 дирхэм мөнгөтэй Маккад илгээв. Аав минь Эбү Бэкир Абдуллах бин Урайкитыг хоёр гурван тэмээтэй тэдний хамт илгээв. Миний

46. Пайгамбар Эзэн маань энэ үгээрээ сая дурдсан Кэхф сурагийн 28-р аетыг сануулдаг. Энд Аллах Таала нь Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д Исламд түрүүлэн орсон ядуу зүдүүчүүдтэй хамт тохиолдох боломжтой бэрхшээлийг тэвчиж, тэдэнд маш нэлээд зөөлхөн хандахыг тушаасан байдаг.

дүү Абдуллахад ээж Үммү Руманыг, намайг, охин дүү Эсмаг тэмээ унуулж илгээсэн тухай мэдээ явуулав.

Эбү Рафий нь Фатимаг, Үммү Гүлсүм ба Сэвдэ бинт-и Зэм'аг; Зэйд ч Үммү Эймэн ба хүү нь Үсамэг тэмээ унуулав. Бүгдээрээ замдаа гарлаа.[47] Минагаас Бэйз гэсэн газар хүрээд тэмээгээ алдав . Бид хэвдэжийн[48] дотор явж байлаа. Манай ээж "Ёоё охин минь! Ёоё бэр минь!" гээд дэвэлж байв. Аллах Таала тэмээг маань тайвшруулж биднийг аюулгүйд хүргэв.

Эцэст нь мэнд сайхан Мадинад хүрцгээлээ. Аллахын Элчтэй гэрээ Маккад хийсэн боловч би гэр бүлийнхээ хамт сууж байв. Тэр хооронд мэсжид болон хавийнх нь өргөтгөлийг барьсан байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн гэр бүл өөрсдийн өрөөнүүдэд суурьшив. Хэсэг хугацааны дараа аав:

"–Аяа Расулаллах аа! Хүнтэй суухыг чинь саатуулсан нь юу вэ?" гэж асуув.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Мэхир юм" хэмээв.

Тэгсэнд нь аав Эбү Бэкир туслахаар арван хоёр хагас укайя[49] илгээж, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- мэхрийг минь өгөөд Шэввал сарын дотор надтай суув.[50] Хуримд тэмээ ч хонь төхөөрөөгүй. Зөвхөн Са'д бин Убадэ -радъяллахү

---

47. **Хазрат-и Зэйнэб** бол арай мусульман болоогүй нөхөр Эбү'л-Ас бин Рэбий зөвшөөрөөгүй тул хэсэг хугацаагаар Маккад үлдэв.

48. **Хэвдэж:** Эмэгтэйчүүд унах тулд тэмээн дээр тавьдаг сүйх.

49. **Укайя:** Хуучний мөнгөн зоосны нэгж. 1 укайя нь ойролцоогоор 128 грамтай тэнцэнэ. Укайяг жингийн хэмжүүрээр ч хэрэглэдэг.

50. Ибн-и Са'д, VIII, 58, 62-63.

анх- нь[51] Расулаллах -алэйхиссалатү вэссэлам-д том саваар хоол илгээв.[52]

Мадинагийн Байдал

Ислам болон мусульманчуудын эзэмшсэн Мадинагийн эрин, хамаг хорвоог гийгүүлсэн ил шашны түгээмэл зарчим тогтсон ба газа хэмээдэг дайнд шэхид ба газийчуудын цусаар төгс төгөлдөр болсон, хэт үйл ажиллагаатай нэгэн эрин мөн.

Аллахын Элч болон мухажирчуудад хамаг боломжоороо тээврээ нээсэн Мадинагийн нөхцөл, эхэнд нь иж бүрэн тухтай тоонд орохгүй байв. Зарим аюул нь хэвээрээ үргэлжилсээр байв. Учир нь Мадинад Энсар ба Мухажирчуудаас гадна бас "мүнафикчууд ба еврейчүүд" байсан бөгөөд, эд нар завша-ан бүрийг ашиглан Исламын ялалтад саад болохын хичээдэг байв.

51. **Са'д бин Убадэ** -радъяллахү анх- Акабагийн Хоёр дахь Бий'атад мусульман болов. Тэнд сонгосон 12 төлөөлөгчийн нэгэн байв. маш баян ба өгөөмөр хүн байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Халид бин Зэйдийн гэрт долоон сар зочин болсонд, Хазрат-и Са'д өдөр бүр хоол илгээв. Хэрэм шиг гэртэй байв. Тэнд суурьшсан ба өдөр бүр энд өргөн хоол дайлдаг байв. хүн бүр нь тэнд идэж уудаг байв. Асхаб-и Сүффэг өдөр бүр цатгадаг байв. Олон дайнд Хазраж аймгийн далбааг барив. Зүү Карэдын Газвад цэрэгт идээгээр арван тэмээний ачаагаар хасарваан олгов. Түүний уг үйлчилгээний дараа Пайгамбар маань:
"Аллах минь! Са'д болон гэр бүлд нь энэрэл олго!" хэмээн залбирав. Бэний Курайзагийн Газвад ч хамаг цэрэгт идээ хангав. Өөд болтлоо амь болон бараагаараа байнга үйлчилгээ ба жихад хийв. Мадинагийн хавьд олон хөрөнгө ба цэцэрлэгтэй байв. Гэр нь Мадинагийн эргийн хорооллын нэгэнд байв. Мэсжид-и Нэбийгээс хол байсан тул тэнд нэгэн мэсжид хийлгэсэн байв. Хазрат-и Эбү Бэкирийн калиф үеийн дараа Дамаскын хавь дахь Хавранд очив. 635 оны тэнд өөд болов. Гута тосгонд оршуулав.

52. Ахмад, VI, 211.

Мүнафикчууд гаднаас Исламд орсон шиг харагдсан ч дотроо баримал шүтлэгийг барьсаар байв. Туяагаа заавал бүтээх Аллах Таала нь тэднийг маш хүнд үгсээр сүрдүүлэв:

وَمِمَّنْ حَوْلَكُم مِّنَ الأَعْرَابِ مُنَافِقُونَ وَمِنْ أَهْلِ الْمَدِينَةِ مَرَدُواْ عَلَى النِّفَاقِ لاَ تَعْلَمُهُمْ نَحْنُ نَعْلَمُهُمْ سَنُعَذِّبُهُم مَّرَّتَيْنِ ثُمَّ يُرَدُّونَ إِلَى عَذَابٍ عَظِيمٍ

“Таны эргэн тойрны бадавийчуудын дунд мүнафикчууд ба Мадиначуудын дунд ч мүнафик болохоор эсэргүүцсэн хүмүүс байдаг. Тэднийг Чи мэдэхгүй, харин Бид мэднэ. Бид тэднийг хоёр удаа тамлана; тэд дараа хэцүү тамлалтай учирна.” (эт-Тавба, 101)

Үнэхээр мүнафикчууд нь нифакдаа маш их авьяастай болсон байгаад, тэдний ийм байдлыг заримдаа Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч мэдэж чаддаггүй, зөвхөн Аугаа Эрх мэдээлбэл мэддэг байв. Учир нь мүнафикчууд өөрсдөд хүрэх боломжтой шүүмжлэлийн хамгийн өчүүхэн замыг ч мэдэрч, түүний дагуу сэмээр хандаж байв.

Энэ хооронд Хүндэт Элч Эзнийг маань ба итгэгчдийг нүүхээс аргагүй болгосон Маккагийн мүшрикчүүд ч хоосон суухгүй, Мадина дахь мүшафикчуудын асаасан хан голомтыг хөөрөгдөөд байв. Исламын тэнд суурьшиж торнихыг үнэмшиж чадахгүй, Ислам болон мусульманчуудыг үгүй болгохоор байн-га мүнафикчуудад мэдээ илгээж байв. Тэгэхгүй тохиолдолд хамаг Арабчуудыг цуглуулж тэдний дээр довтолж, итгэгч, мүнафик, мүшрик ялгахгүйгээр хамаг Мадиначуудыг сэлэмдэж цавчихаар сүрдүүлж байцгаав. Түүнчлэн тэднийг айлгаж итгэг-

чдийн эсрэг улам бүр өдөөх зорилгоор нэгэн бүлэг этгээд илгээж тэдний Мадина дахь мал сүргийг ч дээрэмдүүлсэн байв.

Байдал маш хэцүү ба нэлээд аюултай болсон байв. Мусульманчууд шөнө Мадинагийн гудамжаар харуулд гарч,довтлох магадгүй бол тохирох арга хэмжээг авдаг байв. Түүнчлэн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эзэн ч шөнийг унталгүй өнгөрөөдөг байв. Мадинагийн гадаа цэргийн ангиуд илгээж бүх талыг хяналт доор байлгаж байв.

Нөгөө талаас мусульманчуудын хамгийн ширүүн дайсан байсан бөгөөд байнга завшаан хүлээсэн еврей аймгууд байв. Өмнө нь шашны тухай мэдлэг агуулдаг байсан тул итгэгчидтэй ихэнхдээ тэд маргалддаг ба олон төвөг гаргадаг байцгаав. Ийм учраас Мадинад буусан анхны суга буй Бакара Сура нь еврейчүүдийг Исламд урихыг ихээр чухалчилсан байдаг. Ердөө хамаг хүн төрөлхтнийг урьсны дараа 40 болон 162-р аетын хооронд, 123 аетад ялангуяа Исраилынхныг дурдсан, сурагийн бараг талаас илүү хэсэг нь тэдэнд зориулсан байдаг. Энд заримдаа тэдэнд хандсан, заримдаа тэднийг нууцаар дурдсан, заримдаа тэдний саналыг татгалзаж, заримдаа ч тэдэнд хайрласан шимийг сануулж сэтгэлд нь итгэлийн хүсэл төрүүлэхийг хүссэн байдаг.[53]

Еврей шүлэгч Ка'б бин Эүрэф нь Хазрат-и Пайгамбарыг шоолж Курайшийн мүшрикчүүдийг Түүний эсрэг өдөөдөг байв. Курайшийн мүшрик шүлэгчид ч Аллахын Элчийн эсрэгээр шүлэг хэлдэг байцгаав. Энсарын хамгийн хүчтэй шүлэгч Хассан бин Сабит -радъяллахү анх- Маккагийн мүшрикчүүдийг

53. Хар. Драз, *эн-Нэбэү'л-Азим,* х. 178.

шоолохоор Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс зөвшөөрөл эрэв. Тэр ч зөвшөөрөл олгов.[54]

Тэр үед шүлэг нь өнөөдрийн хэвлэл мэдээлэл шиг хүчтэй нөлөөтэй байв. Аллахын Элч нь шүлэгч Хассан бин Сабитын төлөө мэсжидэд тусгай нэгэн суудал тавиулсан байв. Хассан тэнд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг үгээрээ гомдоосон хүмүүсийг шоолдог байв. Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-:

"Аллахын Элчийг хамгаалах хугацаагаар Руху'л-Кудс (Жэбраил) нь Хассаны хамт юм," хэмээдэг байв. (Эбү Давуд, Эдэб, 87/5015)

Еврейчүүд ба мүшрикчүүд Хүндэт Элч Эзэн маань болон асхабт нь ингэж харгислаж байхад Аллах Таала нь Хайртдаа тэвчээр ба өршөөлийг тушаасан байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Бэдирийн Дайнаас өмнө нэгэн өдөр бие өвдсөн Са'д бин Убадэг зочлохооор илжиг унасан, Үсамэ бин Зэйдийг сундалласан байв. Замдаа Абдуллах бин Збэй бин Сэлүл ч суусан хэсэг хүмүүстэй учрав. Абдуллах бин Үбэй тэр үеэр арай мусульман болсон гэж бий'ат хийгээгүй байв. (Өөрөөр хэлбэл күфүрээ ил зааж байв.) Тэд нар мусульманчууд, еврейчүүд, баримал шүтсэн мүшрикчүүд мэтийн тус тустай шүтлэгтэй хүмүүсээс бүрдсэн байв. Абдуллах бин Рэваха ч тэдний дунд байв. Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн унааны тоос тэдэнд хүрэхлээр, Абдуллах бин Үбэй хамраа хормойгоороо хааж:

"–Биднийг тоосоороо дарахнээ," гэв.

Аллахын Элч тэдэнд мэндийг эрж зогссон, унаанаасаа бууж, тэднийг Аллахад итгэх үнэмшихэд урьж Кур'ан уншив.

54. Бухарий, Мэнакиб, 16; Мүслим, Фэдаилү'с-Сахаба, 156-157.

Абдуллах бин Үбэй: За нөхөр минь! Эдгээрийг хэлээд сайн хийхгүй. Хэрэв Чиний хэлсэн нь үнэн юм бол биднийг битгий зовоо, гэртээ очоод, Чамайг сонсохоор ирэгсдэд эдгээрийг ярь!" гэв.

Абдуллах бин Рэваха:

"–Яг эсрэгээр нь аяа Аллахын Элч ээ! Чи бидэн дээр ир, бид их дуртай," гэв.

Мусульманчууд, мүшрикчүүд ба еврейчүүд маргалдаж эхлэв. Бараг нэг нэгэндээ дайрах болсонд нь Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам- тэндийг тайвшруулав. Энэ түгшүүртэй байдлыг өнгөрөхөөр Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- унаагаа унаж, замдаа яваад Са'д бин Убадэгийн дэргэд хүрэв. Түүнд болсон сониноос ярив. Са'д:

"–Аяа Расулаллах аа! Түүнийг өршөө. Чамд номыг буулгасан Аллахаар тангараг өргөе, Аллах Чамайг пайгамбар болгож илгээсэнд, энэ нутгийн хүмүүс түүнийг тэргүүн болгож толгой дээр нь вангийн титэм тавихаар тохирсон байв. Аллах Чамайг үнэн шашинтайгаар илгээж, түүний ван цол хүчингүй болохоор маш их гуньсан, дэлхий түүнд давчуудаж, амьсгаа авч чадахгүйгээр болов. Тэгсэн нь тийм учиртай бололтой," гэв.

Аллахын Элч ч Абдуллах бин Үбэйгийн уг хандлагыг өршөөв. Тэгэхлээр нь:

لَتُبْلَوُنَّ فِي أَمْوَالِكُمْ وَأَنفُسِكُمْ وَلَتَسْمَعُنَّ مِنَ الَّذِينَ أُوتُواْ

الْكِتَابَ مِن قَبْلِكُمْ وَمِنَ الَّذِينَ أَشْرَكُواْ أَذًى كَثِيراً

وَإِن تَصْبِرُواْ وَتَتَّقُواْ فَإِنَّ ذَلِكَ مِنْ عَزْمِ الأُمُور

“Мэдээж та, эд хөрөнгө болон аминыхаа талаар шалгагдана. Танаас өмнө ном олгосон хүмүүс ба мүшрикчүүдээс зовоох олон үг сонсоно. Хэрэв тэвчиж Аллахаас ёсоор нь айвал, энэ нь зорих хэрэгтэй алдар ихтэй үйлс мөн,” (Ал-и Имран, 186) гэсэн ает-и оэримэ нь буув. Пайгамбар Эзэн маань ба асхаб нь киталын аетыг буухаас өмнө мүшрикчүүд болон эхл-и китабаас үзсэн ийм төрлийн тамлалаас болж тэднийг -тушаалаар- өршөөдөг байв.[55]

Дайнд Зөвшөөрөл Олгосон нь:
“Танд Дайн Зарлавал Та ч Дайн Зарла!”

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д эхэнд мүшрикчүүдтэй байлдах зөвшөөрөл олгоогүй байв. Тэр нь мүшрикчүүдийг Аллах Таалагийн цорын ганц буйг хүлээж авахад урих, учрах харгислалд тэсэх, мунхагчуудын зохимжгүй үйлсэд тэвчээд үл тоох үүрэгтэй байв. Курайшийн мүшрикчүүд бол Аллахын Элчийн үгэнд орогчдыг шашнаас нь гаргахаар янз янзын харгислал хийдэг байцгаав. Мусульманчуудаас зарим нь дийлж чадахааргүй тамлалтайгаар шашнаас нь халсан, зарим нь ч шашныхаа учиртай Абиссинид, зарим нь ч Мадинад нүүсэн, төрж өссөн нутаг ба гэрээ орхихоос аргагүй болсон байв.

Байдлууд нь нэг тусгай явж эхлээд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тэр өдөр хүртэл явуулсан “тэвчээрийн” бодлоготойгоор энх тайвныг хамгаалах бүр боломжгүй болсон байв. Тэгээд Пайгамбар Эзэн маань тэвчээрийн дараа бат барьсан хамгаалах зэвсэг ч хүрэмжтэй болоогүйг хараад Рабдаа хоргодов. Тэрээрийн вахийг хүлээв.

55. Бухарий, Тэфсир, 3/15.

Эцэст нь мүшрикчүүдийн бүр догширсон, Аллахын тэдэнд хайрласан шимийг үл тоож Элчийг нь үгүйсгэсэн, мусульманчуудад ширүүн тамлал хийж, нутагт нь эмээлгэсэн энэ цагт, шашнаа, орон нутгаа ба итгэгчдийг хамгаалахаар өөр аргаггүй болсон Жихадад зөвшөөрөл олгох ает-и кэримэчүүд буув:

أُذِنَ لِلَّذِينَ يُقَاتَلُونَ بِأَنَّهُمْ ظُلِمُوا وَإِنَّ اللَّهَ عَلَى نَصْرِهِمْ لَقَدِيرٌ
الَّذِينَ أُخْرِجُوا مِن دِيَارِهِمْ بِغَيْرِ حَقٍّ إِلَّا أَن يَقُولُوا رَبُّنَا اللَّهُ
وَلَوْلَا دَفْعُ اللَّهِ النَّاسَ بَعْضَهُم بِبَعْضٍ لَّهُدِّمَتْ صَوَامِعُ وَبِيَعٌ
وَصَلَوَاتٌ وَمَسَاجِدُ يُذْكَرُ فِيهَا اسْمُ اللَّهِ كَثِيراً وَلَيَنصُرَنَّ اللَّهُ مَن
يَنصُرُهُ إِنَّ اللَّهَ لَقَوِيٌّ عَزِيزٌ

“Мусульманчууд итгэгчдэд, **харгислалд автсаны улмаас** байлдах **зөвшөөрөл олгов. Мэдээж Аллах заавал тэдэнд туслах хүчтэй юм. Тэд, өөр биш, гагцхуу «Раб маань Аллах мөн» гэсэн тулд эрхгүйгээр нутгаасаа хөөгдсөн хүмүүс мөн. Хэрэв Аллах хэсэг хүмүүсийг өөр хэсэгтэйгээр зайлуулаагүйсэн бол, андашгүй нь дотуур нь Аллахын нэр ихээр дурдсан хийд, чиркев, хавра болон мэсжидүүд нураад унах байв. Аллах өөртөө** шашиндаа **туслагчдад заавал тусална. Андашгүй нь Аллах нь хүчит, ялагч мөн.”** (эл-Хаж, 39-40)

وَقَاتِلُواْ فِي سَبِيلِ اللّهِ الَّذِينَ يُقَاتِلُونَكُمْ
وَلاَ تَعْتَدُواْ إِنَّ اللّهَ لاَ يُحِبِّ الْمُعْتَدِينَ

“Таны эсрэг дайн зарлагчдад, та ч Аллахын замд дайн

зарлацгаа! Харин хилээ битгий давцгаа! Андашгүй нь Аллах эрхгүйгээр дайрагчдад дургүй юм.” (эл-Бакара, 190)

Аугаа Эрх нь дайн ямар учир ба зорилгоор хийж болох тухай шийдвэрээ ч ингэж мэдүүлэв:

وَقَاتِلُوهُمْ حَتَّى لاَ تَكُونَ فِتْنَةٌ وَيَكُونَ
الدِّينُ كُلُّهُ لِلّهِ فَإِنِ انتَهَوْاْ فَإِنَّ اللّهَ

“Тэгээд өөр фитнэ (самуун) **эс үлдтэл ба шашин бүрэн Аллахынх болтол тэдэндтэй байдацгаа!..”** (эл-Энфал, 39)

Дайтах зөвшөөрөл гарсан нь Ислам болон мусульманчуудад өстэй хандсаны нэгэн үр дүн юм. Нийгмийг бий болгож хамгаалахын тулд шаардлагатай бөгөөд “зарурат-и хамсэ” хэмээн нэрлэдэг таван үнэ цэнэ буюу “амь, бараа, угсаа, ухаан ба шашныг” хамгаалах ба дайсны довтолгооноос хамгаалахын тулд Жихадыг фарз болгосон байдаг. Энэ тэнгэрлэг тушаалаар шашнаас төөрүүлэгчдэд ял олгох ба тэнгэрлэг үнэнийг тэблиг хийхийг саад бүхнийг үгүй болгохыг зорьсон байдаг.

Орчлонгуудад рахмат болж илгээгдсэн Пайгамбарчуудын Хааны хамаг хүн төрөлтхнийг хамарсан уудам энэрлийн эсрэг, том ба ширүүн дайн хийсэн нь нийгмийн энх тайвныг хангах болон тэвхидийн төлөө хичээх шаардлагатай хамаатай байв. Ийм учраас Хайрт Пайгамбар маань нэгэн хадис-и шарифдаа:

“Би энэрэл болон дайны пайгамбар мөн!” (Ахмад, IV, 396) хэмээн айлдсан байдаг.

Аугаа Эрх нь Жихадын зөвшөөрлийг мэдүүлсэн аетуудын зэрэг, Элч болон итгэгчдээ энэ тэнгэрлэг тушаалд урамшуулах ает-и кэримэчүүд ч буулгав:

يَا أَيُّهَا النَّبِيُّ حَسْبُكَ اللّٰهُ وَمَنِ اتَّبَعَكَ مِنَ الْمُؤْمِنِينَ

يَا أَيُّهَا النَّبِيُّ حَرِّضِ الْمُؤْمِنِينَ عَلَى الْقِتَالِ

“Аяа Пайгамбар аа! Чамд болон Чамайг дагасан итгэгчдэд Аллах хүрэмжтэй мөн! Дайснуудаасаа битгий ай! **Пайгамбар аа! Итгэгчдийг** тэдний эсрэг **дайнд урамшуул!..”** (эл-Энфал, 64-65)

أَلاَ تُقَاتِلُونَ قَوْمًا نَّكَثُواْ أَيْمَانَهُمْ وَهَمُّواْ بِإِخْرَاجِ الرَّسُولِ وَهُم بَدَؤُوكُمْ أَوَّلَ مَرَّةٍ أَتَخْشَوْنَهُمْ فَاللّٰهُ أَحَقُّ أَن تَخْشَوْهُ إِن كُنتُم مُّؤْمِنِينَ قَاتِلُوهُمْ يُعَذِّبْهُمُ اللّٰهُ بِأَيْدِيكُمْ وَيُخْزِهِمْ وَيَنصُرْكُمْ عَلَيْهِمْ وَيَشْفِ صُدُورَ قَوْمٍ مُّؤْمِنِينَ وَيُذْهِبْ غَيْظَ قُلُوبِهِمْ

“ Итгэгчид ээ! **Амласандаа хүрээгүй, пайгамбарыг** нутгаас нь **хөөсөн, дайныг эхэлж өдөөсөн тэр этгээдүүдтэй та байлдахгүй байж чадах уу? Тэднээс айх уу? Үгүй ээ, Хэрэв итгэсэн бол Аллахаас л айх ёстой гэдгээ мэдэж байгаа бизээ. Тэдэнтэй та байлд, тэгээд Аллах таны гараар тэднийг яллаг, тэднийг дooромжлог, таныг тэднээс давуу болгог, итгэгчдийн сэтгэлийг амруулаг. итгэгчдийн зүрхнээс** харисчуудын эсрэг цугласан буй **хилэнг** тэднийг мөхөөх аргаар **гаргаж аваг!”** (эт-Тавба, 13-15)

Эдгээр ает-и кэримэчүүдийн хамт Жихадаас хоцрохгүйн тухай ч сануулга ирэв:

كُتِبَ عَلَيْكُمُ الْقِتَالُ وَهُوَ كُرْهٌ لَّكُمْ وَعَسَى أَن تَكْرَهُواْ

شَيْئًا وَهُوَ خَيْرٌ لَّكُمْ وَعَسَى أَن تُحِبُّواْ شَيْئًا
وَهُوَ شَرٌّ لَّكُمْ وَاللّهُ يَعْلَمُ وَأَنتُمْ لاَ تَعْلَمُونَ

"Дайн нь, танд таалагдаагүй ч танд фарз болов. Танд таалагдаагүй нэгэн юм ихэнхдээ танд илүү буянтай байж мэднэ. Тэгээд танд таалагдсан нь ч ихэнхдээ танд муу байж мэднэ. Аллах мэднэ, та мэдэж чадахгүй." (эл-Бакара, 216)

مَا كَانَ لِأَهْلِ الْمَدِينَةِ وَمَنْ حَوْلَهُم مِّنَ الأَعْرَابِ أَن يَتَخَلَّفُواْ
عَن رَّسُولِ اللهِ وَلاَ يَرْغَبُواْ بِأَنفُسِهِمْ عَن نَّفْسِهِ

"Мадинагийн ард түмэн ба тэдний эргэн тойрны бадавийчуудад, дайнд Аллахын Пайгамбараас хойно үлдэх ба Түүний аминаас өмнө өөрсдийнхөө амийг бодох нь зохихгүй!.." (эт-Тавба, 120)

قُلْ إِن كَانَ آبَاؤُكُمْ وَأَبْنَآؤُكُمْ وَإِخْوَانُكُمْ وَأَزْوَاجُكُمْ وَعَشِيرَتُكُمْ
وَأَمْوَالٌ اقْتَرَفْتُمُوهَا وَتِجَارَةٌ تَخْشَوْنَ كَسَادَهَا وَمَسَاكِنُ تَرْضَوْنَهَا
أَحَبَّ إِلَيْكُم مِّنَ اللهِ وَرَسُولِهِ وَجِهَادٍ فِي سَبِيلِهِ فَتَرَبَّصُواْ حَتَّى
يَأْتِيَ اللهُ بِأَمْرِهِ وَاللهُ لاَ يَهْدِي الْقَوْمَ الْفَاسِقِينَ

"Аяа Расул минь ээ! **Ингэж хэл: Хэрэв танай аав, хүү, дүү, эхнэр, садан хамаатан, олсон бараа, ховордохоос нь айсан наймаа, дуртай байрнууд тань, танд Аллахаас, Расулаас нь ба Аллахын замд Жихад хийхээс илүү таатай байвал, одоо**

Аллахын тушаалыг иртэл хүлээцгээ! Аллах нь фасикчуудын авралтад хүргэхгүй!" (эт-Тавба, 24)

Энэ тэнгэрлэг зарлалын дараа Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- ба Түүнийг дагасан итгэгчид нь мүшрикчүүдийн эсгэр байлдахаар бүх талаараа чухал бэлтгэл хийж эхлэцгээв.

Аллахад хүрэх жихад зам

Ерөнхий утгаараа Жихад нь хүний өөрийн хэфсийг засах ба хүмүүжүүлэхийг хичээж, Аллахын тушаалыг чин сэтгэлээр хэрэгжүүлж, харамаас холдох,[56] мусульман ах дүү нартаа сургаал хэлэх, мусульман бус хүнд Исламыг нотлон ярьж ятгах[57] ба шашнаа, ариун алдраа, амиа, нутгаа, удмаа, бараа хөрөнгөө хамгаалах, Исламыг дэлгэрүүлэх ба үүний эсрэг тэрс үзэлтнүүдийг үгүй болгохын тулд амь, бараа, хэл ба бусад хамаг боломжоороо хичээх ба байлдах гэсэн утга агуулдаг.[58]

Ийм учраас Жихад гэсэн үг нь нэфисчүүдийг боловсруулж Аллах Таалагийн тааламжийн дагуу, и'лай-и кэлимэтуллахыг буюу Аллахын шашныг мандуулах учиртай бие хүн ба нийгмээр Исламын аж ахуйд амьдрахаар хийсэн хамаг үйлсийг илэрхийлнэ. Энэ талаараа Аллахын Элчийн хорин гурван жилийн номлох амьдралын бүхэл ийм учиртай өнгөрснийг хэлбэл хэтрүүлэхгүй.

---

56. Нэсаи, Хаж, 4.
57. Ахмад, III, 456.
58. Энэ тухай аетуудыг Хар. эн-Ниса, 95; эл-Энфал, 72; эт-Тавба, 20, 41, 44, 81, 88. Хадис-и шарифуудыг Хар. Бухарий, Мэзалим, 33; Мүслим, Иман, 226; Эбү Давуд, Сүннэт, 28-29.

Аллах Таала амь ба бараа гэсэн шимийг шалгалтын учир болгосон бөгөөд эдгээрээр Тэрээрийн замд Жихад хийхээр бидэнд олон сануулга илэрхийлсэн байдаг. Жишээлбэл, энэ тухай ает-и кэримэчүүдэ ингэж айлдана:

لَكِنِ الرَّسُولُ وَالَّذِينَ آمَنُواْ مَعَهُ جَاهَدُواْ بِأَمْوَالِهِمْ وَأَنفُسِهِمْ وَأُوْلَئِكَ لَهُمُ الْخَيْرَاتُ وَأُوْلَئِكَ هُمُ الْمُفْلِحُونَ

“Пайгамбар ба Түүний хамт итгэгчид бараа болон амиараа Жихад хийцгээв. Хамаг буян тэднийх ба тэд л авралтад хүрэгчид мөн.” (эт-Тавба, 88)

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُوا هَلْ أَدُلُّكُمْ عَلَى تِجَارَةٍ تُنجِيكُم مِّنْ عَذَابٍ أَلِيمٍ تُؤْمِنُونَ بِاللهِ وَرَسُولِهِ وَتُجَاهِدُونَ فِي سَبِيلِ اللهِ بِأَمْوَالِكُمْ وَأَنفُسِكُمْ ذَلِكُمْ خَيْرٌ لَّكُمْ إِن كُنتُمْ تَعْلَمُونَ

“Аяа итгэгчид ээ! Таныг гашуун зовлонгоос аврах наймааг зааж өгөх үү? Аллах болон Расулд нь итгэж, бараа болон амиараа Аллахын замд Жихад хийнэ. Хэрвээ мэдвэл, энэ таны хувьд илүү буянтай юм.” (эс-Сафф, 10-11)

Нэгэн өдөр Асхаб-и кирам нь Оршигчдын Туяа Хайрт Пайгамбараас маань:

“–Аяа Расулаллах аа, буянт хүн нь хэн бэ?” гэж асууцгаав.

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч:

“–Амь болон эд хөрөнгөөрөө Аллахын замд Жихад хийсэн итгэгч мөн,” хэмээв. (Бухарий, Жихад, 2; Мүслим, Имарэт, 122)

Ает-и кэримэ болон аетуудад илэрхийлсэн бараа болон амиараа Жихадын зорилт нь зөвхөн зэвсгээр байлдах биш юм. Учир нь зэвсэг нь харгислалыг устгах, эрхийг олгох мэтийн шаардлагатай байдалд ашигласан нэгэн багаж юм. Жинхэнэ ялалт бол сэтгэлийн ялалт бөгөөд, тэрийг бол амь болон бичгийн тэблигээс эхлэн маш олон аргаар хэрэгжүүлж болно.

Жишээлбэл Жихад аетуудын ихээр буусан Маккагийн эринд итгэгчдэд дайны чухал хүч арай байгаагүй. Тэд мунхаг хүмүүсийн дайралтын эсрэг Исламыг буюу , хүн төрөлхтнийг, эрх тэгшийг олгох ба тэблиг зорилгоор зөвхөн итгэгчийн занг толилууж чадах байв. Кур’ан-и Кэрим тэдний энэ байдлыг “их Жихад” хэмээн нэрлэсэн байдаг. Ает-и кэримэ ингэж айлдана:

فَلَا تُطِعِ الْكَافِرِينَ وَجَاهِدْهُم بِهِ جِهَادًا كَبِيرًا

“Кафирчуудад огт бөхийгүүзэй! Мөн энэ (Кур’анаар) **тэдний эсрэг том эсэргүүцэл үзүүл!”** (эл-Фуркан, 52)

Аетад дурдсан “ جِهَادًا كَبِيرًا ” гэсэн үг нь Исламын ялалтаар хүн төрөлхтнийг аврах ба энх тайван олох зорилгоор хамаг боломжийг эдлэх ба Аллахын шашныг мандуулахаар байдал ба яриагаараа тэблиг хийх гэсэн утгатай юм. Үнэхээр ч тэблиг хийгээд Жихадад болох нь дайсны эсрэг зэвсэгтэйгээр байлдахаас илүү чухал ба ашигтай байдаг. Пайгамбар Эзэн маань ч анхны жилүүдэд Жихадаа зөвхөн Кур’ан-и Кэримээр хийж байв.

Кур’ан-и Кэримд хүмүүсийг авралд хүргэх зорилгоор “Аллахын замд Жихад хийх” тухай маш олон үг байдаг. Харин эдгээрээс маш жижиг хэсэг нь халуун байлдаан гэсэн утгыг дурдсан бөгөөд, тэр ч зөвхөн шаардлага гарахад хүчинтэй байж мэднэ.

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн оролцсон газанууд ердөө хамгаалах дайн байдаг. Бэдир, Ухуд ба Хэндэкэд (Шуудуунд) болсон шигээ... Мүтэ ба Тэбүк боломжийн нэгэн довтолгоон хариулахаар хийсэн нэгэн хамгаалалт юм. Маккагийн ялалт бол мусульманчуудын хүчээр булаагдсан эрхийг буцааж авах санаагаар ба Маккачуудын мусульманчуудтай хийсэн гэрээний нөхцөлийг зөрчсөний дараа хэрэгжсэн байдаг. Өөрөөр хэлбэл "Энэрлийн Пайгамбар" байсан Аллахын Элчийн хамаг дайны суурьд уудам нэгэн энэрлийн бодол оршсон ба хүн төрөлхтөнд нэгэн энэрэл хайрласан байдаг. Учир нь, Исламд дайны гол зорилго бол хүн алах,[59] олз олох, дэл-

59. Орчлонгуудад энэрлээр илгээгдсэн Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- 29 нь газва ба 91 нь аян болж зохиосон цэргийн нийт 120 хөдөлгөөнд барьсан энэрлийн бодлогоор, Арабын хамаг хойгийг эзэлсэн боловч, мусульманы цэргээс ч дайсны цэргээс ч их цус урсгахыг саатуулсан байдаг. Аллахын Элчийн 11 жилийн хугацаанд элдэв учиртай хэрэгжүүлсэн их багагүй цэргийн 120 үйлд -итгэмжтэй дамжуулсан үгсийг харвал- мусульманчууд ойролцоогоор 340 гаруй шэхид өгсөн байдаг. Дайсны алдагдал бол ойролцоогоор 800 гаруй хүн юм. Өөрөөр хэлбэл их бага хэмжээний 120 дайнд үгүй болсон тоо нь нийт зөвхөн 1200 орчим хүн байдаг. Пайгамбар Эзний маань өөрөө оролцсон газвануудыг гол авбал, хийсэн 29 газвагийн 16нд ямар ч тулалдаан гараагүй, харин зорьсондоо хүрсэн байдаг. 13 газвад бол тулалдаан болсон ба мусульманчуудаас ойролцоогоор 140 хүн шэхид болоод дайснаас бол ойролцоогоор 335 хүн алагдсан байдаг.
Орчлонгийн Хүндэт Эзэн маань олон газрыг дайны талбай болгоогүй, оюун ухааны бодлогын ухааныг даган өөртөө нэгтгэсэн байдаг. Мөн бусад олон газрыг ч тухайн ардын авралд хүрснээр буулгаж авсан ба үүнийг илүүд үзээд зэвсэг хэрэглэхээс боломжоороо болгоомжилсон байдаг. Заримдаа бодлогоо хүчит мэдээллийн бүтцээр нэгдэж дайсныг байлдахаа болиулахыг амжсан ба ингэхдээ асгасан цусыг хамгийн бага хэмжээнд болгохыг хангасан байдаг. Дайныг эерэгээр цэглэхийн тулд цэргийн даргыг дайн болох нутгийн хүмүүсээс ба дайсан аймгаас болохыг нь ялангуяа илүүд үзсэн байдаг. Мөн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- цэрэгтээ амалснаа биелүүлэхийг, хэтрэхгүй байхыг, гэрээг

хийг мөхөөх, хувийн эсвэл эд барааны ашиг олох эсвэл өшөө авах биш; эдгээрийн эсрэгээр харгислалыг үгүй болгох, итгэл үнэмшлийн эрх чөлөөг хангах, хүмүүсийг авралд хүргэх ба хамаг эрх тэгшгүй байдлыг үгүй болгох юм.

Аллахын Элчийн хамаг дайнуудыг ерөнхийд нь шинжилбэл, Исламд хамгаалалт ба и'ла-и кэлимэтуллах буюу Аллахын шашныг мандуулах зорилгоос гадна хийж чадах дайн үгүйг үзнэ. Гагцхуу газар нутгийг эзлэхээр хийсэн дайнууд хүний хар царайны харгислал юм. Харин Исламд дайн нь, заавал эрхийг олгох, авралтын учир болох ба харислалыг үгүй болгох мэтийн агуу зорилго дээр оршдог. Кур'аны илэрхийлснээр:

مَن قَتَلَ نَفْسًا بِغَيْرِ نَفْسٍ أَوْ فَسَادٍ فِي الأَرْضِ
فَكَأَنَّمَا قَتَلَ النَّاسَ جَمِيعًا

"…Хэн нэгэн гэмгүй буруугүй нэгний амийг хороовол хамаг хүн төрөлхтнийг алсантай адил. Хэн нэгний амийг өршөөвөл хамаг хүн төрөлхтөнд амь хайрласантай адил…" (эл-Маида, 32)

Ийнхүү хэмжээс дотор ба Исламын зорилгын төлөө итгэгчдийн бараа ба амиараа хийх хамаг чармайлт нь Аугаа Эрхийн онгонд диваажинг худалдаж авах мэт том нэгэн тэнгэрлэг шагналтад хүртэнэ. Харин бусад үйлсэд буй шигээ энэ хэрэгт

алдаж харгислахгүй байхыг, хүмүүсийг дэмий алахгүй байхыг, ялангуяа боол, хүүхдүүд, эмэгтэйчүүд, ахмадууд ба хийдэд хоргодсон хүмүүст гар хүргэхгүй байхыг, хасарваны талбайнуудад аюул хүргэхгүй, модыг огтлохгүй ба байшингуудыг нураахгүй байхыг сургасан байдаг. (Хар. Элшад Махмудов, *Sebep ve Sonuçları İtibâriyle Hazret-i Peygamber'in Savaşları,* 2005, M.Ü.S.B.E. Хэвлээгүй Докторантын Ажил.)

ч дотно сэтгэл маш чухал юм. Энэ тухай Абдуллах бин Амр -радъяллахү анх-:

“–Аяа Расулаллах аа! Надад Жихад болон газагийн тухай мэдээлэл өгөөрэй,” гэхлээр Пайгамбар Эзэн маань:

“–Абдуллах аа! Хэрэв чи Аллахын тааламжийг найдан ба бэрхшээлийг дийлж байлдвал, Аллах ч чамайг киямат өдөрт тэр байдал дээр сэргээнэ. Хэрэв чи бахархалынхаа төлөө байлдвал, Аллах ч чамайг киямат өдөр тэр байдал дээр сэргээнэ,” хэмээв. (Эбү Давуд, Жихад, 24/2519)

Дахиад Пайгамбар Эзэнд маань нэгэн бадавий ирээд:

“–Нэр алдар олж, олз авахаар эсвэл үзэсгэлэнгийн төлөө байлдсан хүний тухай юу айлдах вэ?” гэж асуув.

Өөр нэгэн ч:

“–Аяа Расулаллах аа! Аллахын замд байлдах гэж юу вэ? Зарим нь уурласнаасаа, зарим нь хамгаалахаар байлдана,” гэж асуув.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Хэн нь зөвхөн Аллахын шашныг хамгийн агуу болог гэж байлдвал, тэр л Аллахад хүрэх Жихад зам юм!” хэмээв. (Бухарий, Илим, 45; Мүслим, Имарэ, 149-150)

Нэгэн ч:

“–Аяа Расулаллах аа! Нэгэн эр Аллахын замд байлдах ба мөн дэлхийн бараанаас юм олохыг ч хүсвэл, энэ тухай юу айлдах вэ?” гэж асуухлаар нь Пайгамбар Эзэн маань:

“–Түүнд ямар нэгэн ач буян байдаггүй!” хэмээв.

Уг хариулт Асхаб-и кирамд маш хэцүү санагдав. Учир нь ийм дотно сэтгэлтэй болох нь маш хэцүү бай вАсхаб нь асуултыг асуусан сахабийд:

“–Чи Расулаллахаас дахиад асуудаа. Магадгүй хариултыг сайн ойлгоогүй юм,” гэцгээв. Учир нь асхаб илүү хялбархан хариу авахыг хүсч байв. Тэр Эр ийм санаагаар асуултаа гурав дахин асуув. Эзэн маань түүнд удаа бүрт:

“–Түүнд ач буян үгүй!” гэсэн хариуг өгөв. (Эбү Давуд, Жихад, 24/2516)

Пайгамбар Эзний жаргалын амнаас Аллахад хүрэх Жихадын эрдмийн тухай маш олон хадис-и шариф илэрсэн байдаг. Эдгээрээс зарим нь ийм байдаг:

“Нэгэн өдөр ба нэгэн шөнө хил манах нь өдрийг мацагтай, шөнийг залбиралтай өнгөрөөсөн нэгэн сараас ч буянтай юм. Хэрэв тухайн хүн энэ мануулд нас барвал, хийж байсан үйлийн ач буян нь киямат хүртэл үргэлжилнэ, шэхид болоод шим нь ч үргэлжлэх бөгөөд булш дахь асуултын мэлэкчүүд ч хамгаална.” (Мүслим, Имарэ, 163)

“Аллахын замд нэгэн өдөр хилийг манах нь дэлхий болон дэлхий дээрх зүйлсээс буянтай юм. Танаас нэгний ташуурын диваажин дахь газар нь дэлхий болон дэлхий дээрх зүйлсээс буянтай. Боолын Аллахын замд үдэш эсвэл өглөө эрт цагийн алхам нь ч дэлхий болон дэлхий дээрх зүйлсээс буянтай юм.” (Бухарий, Жихад 6, 73, Рикак 2; Мүслим, Имарэ 113-114)

“Аллах Таала Жихадын замаар явсан хүнд: «Түүнийг над руу жихад замаар явж, надад итгэж үнэмшдэг, нь миний расулчуудыг нотлох замд гарна,» хэмээн батлан даана. Аллах тэр хүнийг шэхид болбол диваажинд хийхээр, газий болбол сүнсний буян ба дэлхийн олзонд хүрсэн буйгаар гэрт нь хариу-

лахаа батлан даана. Мухаммедын амийг хүчит гараараа барьсан Аллахад тангараг өргөе, Аллахын замд олсон нэгэн шарх нь киямат өдөрт хэвээрээ ирнэ: өнгө нь цусны өнгөтэй, үнэр нь анхилуун үнэртэй болно.” (Мүслим, Имарэ, 103; Нэсаи, Иман, 24)

“Диваажинд орсон хэн ч дэлхийд буцахыг хүсэхгүй. Дэлхийд буй бүх юм олон дахин илүүгээрээ тэнд ч байдаг. Харин шэхид нь олсон дайлалтаас болон дэлхийд арван дахин буцаж, удаа бүрт нь шэхид болохыг ерөөнө.” (Бухарий, Жихад, 21; Мүслим, Имарэ, 108-109)

Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эзэн маань Аллахын замд үзүүлсэн чармайлт болон хийсэн дайны зорилгыг ингэж тайлбарлав:

“Аллахаас өөр бурхан үгүйг ба Мухаммедын ч Аллахын Элч буйг гэрчилтэл, мөргөл үйлдэж зэкат өгтөл нь хүмүүстэй байлдах надад тушаал болов. Тэд үүнийг хүлээн авахад, Исламын тушаасан ялаас гадна амь ба бараагаа миний гараас аварсан байх болно.” (Бухарий, Иман, 17)

Ийм л учраас Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- шөнө дайралгүй өглөөг хүлээдэг, эзаны дуу сонсох болбол зогсдог байв.[60] Илгээсэн харуулдаа ч:

“Нэгэн мэсжид харсан буюу мүэззиний дууг сонссон тохиолдолд тэнд хэнийг ч бүү алцгаа!” хэмээн айлддаг байв. (Эбү Давуд, Жихад, 91/2635; Ахмад, III, 448-449)

Мүслим бин Харис -радъяллахү анх- ингэж ярина:

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- биднийг харуулаар илгээсэн байв. Довтлох газартаа хүрэхлээрээ би морио

60. Бухарий, Эзан, 6; Мүслим, Салат, 9.

хурдлуулж найзуудаасаа түрүүлэв. Орилж буй эмэгтэй ба хүүхдүүдтэй тааралдлаа. Тэднээс:

“–Амиа аврмаар байна уу?” гэж асуулаа. Тэд “Тийм” гэцгээв.

“–Тийм байвал «Ла илахэ иллаллах Мухаммедүн Расулаллах» гээд авргдаарай,” гэлээ. Тэд үүнийг давтан хэлэв. Зарим найзууд:

“–Чи бидэнд олзыг харам болгов,” гээд ингэсэнд намайг буруушаав. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд харихад миний хийсэн үйлийг Түүнд мэдээлцгээв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- намайг дуудаж шагшаад:

“–Андашгүй нь Аллах чамд тэднээс хүн бүрийн төлөө төдий олон буян бичив,” хэмээв. (Эбү Давуд, Эдэб, 100-101/5080)

Бүрэйдэ -радъяллахү анх- ярина:

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эзэн маань цэргийн ямар нэгэн ангийг Жихадад илгээхдээ даргадаа, Аллахад такватай, хажуугийн мусульманчуудад буянтай болохыг ба сайнаар хандахыг зөвлөж, дараа ч ингэж айлддаг байв:

“Аллахын нэрээр, Аллахын замд дайнд яваарай. Аллахыг үл танигчидтай байлдаарай. Олзын бараанд битгий урваарай. Харгислал битгий хийгээрэй. Хамар, чих битгий огтлоорой. Хүүхдүүдийг битгий алаарай. Мүшрикчүүдээс буй дайснуудтай тааралдвал, тэднийг уг гурваас нэгийг хүлээж авахад уриарай:

1.Тэднийг Исламд уриарай. Орвол чөлөөлж орхиорой.

2. Хэрэв мусульман болохгүй бол, тэднийг жизье гэдэг татвар төлөхөд уриарай. Үүнийг дагавал тэднийг чөлөөлж орхиорой.

3. Хэрэв жизье төлөхийг ч хүлээн зөвшөөрөхгүй бол, Аллахаас тустамж ерөөж тэдэнтэй байлдаарай!..” (Муслим, Жихад, 3; Тирмизий, Сиер, 48/1617; Ахмад, V, 352, 358)

Зарим Харуул

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- Мадина дахь мусульманчуудын үймүүлсэн, үмрэ хийхэд саад болсон ба мүнафикчуудыг итгэгчдэд өдөөсөн Маккачуудын Сири лүү явсан наймааны замыг хааж,[61] тэднийг худалдаа болон эдийн засгийн талаар төвөгт оруулаад мусульманчуудын эсрэг хүч олоход нь саад болох юмсан.[62] Аллахын Элч -алэйхиссалатү вэссэлам- ийм зорилгоор хижрэтээс долоон сарын дараа Рамадан сард Хазрат-и Хамза -радъяллахү анх-ын тушаалд 30 Мухажир өгөөд Сифү’л-Бахр[63] гэсэн газар илгээв (Рэжэб 8 / 629 оны 11 сар).

Дамаскаас Маккад харьж буй наймааны жин нь 300 морьтны хамгаалалт доор Сифү’л-Бахрад ирсэн байв. Тэдний хооронд Эбү Жэхил ч байв. Байлдахаар эгнээнд орж байхад, хоёр талын ч анхдагч холбоотон нь байсан Мэждий бин Амр тэдний дунд ороод байлдахыг болиулав. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Мэждийг хооронд ороод байлдаанд саад бол-

61. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- анхны өдрүүдэд Курайш мүшрикчүүдийн өшөөг дуусгахаар тэдэнд зориулан эдийн засаг ба улс төрийн бодлогын эмбарго хэрэгжүүлэв. Ийм зорилгоор ойр хавийн аймгуудтай дипломат харилцаа барьж, элдэв гэрээ хийгээд Маккагийн худалдаа ба эдийн засгийн голыг бүрдсэн мүшрик Курайшийн жингүүдийг мөрдөхөөр зарим газва ба аян зохиов.

62. Бухарий, Мэгазий, 2; Эбү Давуд, Хараж, 22-23/3004.

63. **Сифү’л-Бахр**: Ийс сумд оршдог бөгөөд Жүхэйнэчүүдийн хөрөнгөд байдаг. Тэнгисийн дэргэд байсан тул ийм гэр авсан байдаг.

сонд дурлаж энэ тухай амжилтыг нь шагшив. Түүний илгээсэн элч нарт ч хувцас бэлэглэв.[64]

Пайгамбар Эзэн маань хижрэтийн тооллын 8 оны эхээр Шэввал сарын дотор Үбэйдэ бин Харис -радъяллахү анх-ыг ижил зорилгоор Рабигт[65] илгээсэн байв. Тушаалд нь 60 эсвэл 80 орчим Мухажио байв.

Курайшчууд нь Эбү Сүфьяны тушаал доор 200 хүн байв. Байлдахаар дахиад эгнээнд ч ороогүй, сэлмээ ч сугалаагүй. Харин хоорондн нь хөнгөн нэгэн тулалдаан ба сум харвах үзүүлбэр хийцгээв. Са’д бин Эбий Ваккас -радъяллахү анх- тэр өдөр анхны сумыг харваж Исламд анхны сум харвагчийн алдрыг хүртэв. Мзүрикчүүд мусульманчуудад туслагч хүч ирж буйг бодоод айсан ба хоёр тал нэг нэгнээсээ салцгаав.

Мусульман болсон боловч тэр өдөр хүртэл Аллахын Элчийн дэргэд очиж чадсангүй Микдад бин Амр ба Үтбэ бин Газван хүссэндээ хүрэх найдвартайгаараа мүшрикчүүдийг дагаж замд гарсан байв. Мусульманчуудыг харангаа мүшрикчүүдээс авраг-даад итгэгчдийн эгнээнд орцгоов.[66]

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Мадинад хиж-рэтээс 9 сарын дараа буюу Зилкадэ сард Са’д бин Эбий Ваккас -радъяллахү анх- болон 8 эсвэл 20 хүнийг Харрарт[67] илгээв (Зилкадэ 1 / 623 оны 5 сар).

Са’д -радъяллахү анх- ингэж ярина:

---

64. Вакидий, I, 9-10; Ибн-и Са’д, II, 6.

65. **Рабиг:** Хажийчуудын Маккад очихдоо давж өнгөрсөн, Эбва Жүхфэ хоёрын хооронд оршдог нэгэн хөндий бөгөөд Жүхфэгээс 3 милийн зайтай байдаг.

66. Ибн-и Хишам, II, 224-225; Вакидий, I, 10; Ибн-и Са’д, II, 7.

67. **Харрар:** Хижазад Жүхфэд ойрхон нэгэн усны нэр. Жүхфэгээс Макка руу явахдаа Махажжагийн зуун гар талд ба Гадир-и Хумд ойрхон байдаг.

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- надад:

«– Са’д аа! Харрар хүртэл яв! Курайшийн жин түүгээр өнгөрч явна,» хэмээв.

Өдөр нуугдаад шөнө яваад урагшиллаа. Биднийг тав дугаар өдрийн өглөөгүүр тэнд хүрэхэд, жин нь түрүүний өдөр тэндээс өнгөрсөн байв. Аллахын Элч Харрараас цааш явахгүйг тушаасан байв. Тэгээгүйсэн бол тэдэнд хүрч чадахсан байж магадгүй.”

Мүжахидчууд ямар ч байлдахгүйгээр Мадинад харьцгаав.[68]

Хижрэтийн тооллын арван нэгдүгээр сарын эхээр, Сафэр сард, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- өөрөө Эбва (Вэддан)[69] Дайнд явав (2 оны Сафэр сар / 623 оны 8 сар). Энэ нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн оролцсон анхны дайн байв. Энсараас Са’д бин Убадэ -радъяллахү анх-ыг Мадинад төлөөлөгчөөрөө томилж орхив.

Уг газвад мүшрикчүүдтэй тааралдаагүй, харин Кинанэ аймгаас Дамрагийнхантай нэгэн гэрээ хийв. Үүгээр, Пайгамбар Эзнийг маань тэдэндтэй байлдахгүй шигээ, тэд ч Пайгамбартай маань байлдахгүй, мусульманчуудын эсрэг бэлтгэл хийхгүй, дайсанд ч тусламж өгөхгүй байв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- энэ тухай хоорондоо нэгэн бичиг ч бичүүлэв. Эбвагийн аян 15 хоног үргэлжлэв.[70]

---

68. Ибн-и Хишам, II, 238; Вакидий, I, 11; Ибн-и Са’д, II, 7.

69. **Эбва:** Фүрү’ Жүхфэ хоёрын хооронд нэгэн тосгон бөгөөд Мадинагаас 23 мил орчим зайтай байдаг. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн эх Хазрат-и Аминагийн булш нь энд байдаг. **Вэддан** бол Мадина Макка хоёрын хооронд бөгөөд Эбвагаас 8 мил зайтай ба Жүхфэгийн ойрт Дамра, Гифар ба Кинанэчуудын хөрөнгөд ордог.

70. Ибн-и Хишам, II, 223-224; Вакидий, I, 12; Ибн-и Са’д, II, 8.

Үүнээс харвал, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- завшаан бүрт энх тайвныг сонгосон, хүмүүст байнга энэрлээр хандсан байв.



ХИЖРЭТИЙН ХОЁР ДАХЬ ЖИЛ

Зарим Газванууд ба Батн-и Нахлэгийн Аян Дайн

Хижрэтийн арван гурав дахь сарын эхээр, Рабиулэввэл сарын дотор, зуун хүнтэй хүчний хамгаалсан хоёр мянга таван тэмээтэй Курайшийн жинтэй тааралдах зорилгоор Буватын[71] Газва хэрэгжив (Рабиулэввэл 2 / 623 оны 9 сар). Энсараас Са'д бин Муаз -радъяллахү анх-ыг Мадинад орондоо төлөөлөгчөөр үлдээсэн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- хоёр зуун мусульманыг дагуулан замд гарав. Ямар нэгэн уулзалт буюу байлдаан бололгүй Мадинад харьцгаав.[72]

Тухайн өдрүүдэд Мадинад гурван мил зайтай Акик тосгоны Жэмма Ууланд бэлчиж байсан тэмээ ба үхрийг авч явсан Күрз бин Жабирыг барихаар Сэфэваны[73] Газваг хийв (Рабиулэввэл 2 / 623 лны 9 сар). Үүнийг "Бэдрү'л-Ула: Анхны Бэдирийн Аян" ч гэдэг. Зэйд бин Хариса -радъяллахү анх-ыг орондоо төлөөлөгчөөр үлдээж аянд гарсан Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-нь Сэфэван хүртэл явсан ч Күрзийг зугтсан учраас буцав. Энэ хүн бол дараа нь Исламд ороод сайн нэгэн мусульман болов.[74]

---

71. **Буват**: Жүхэйнэчүүдийн нутгийн нэгэн уул бөгөөд Мадинагаас 36 мил орчим зайтай байдаг.

72. Вакидий, I, 12; Ибн-и Са'д, II, 8-9.

73. **Сэфэван:** Бэдир сум дахь нэгэн хөндийн нэр.

74. Ибн-и Хишам, II, 238; Ибн-и Са'д, II, 9; Ибн-и Эсир, Үсдү'л-Габэ, IV, 468.

Хижрэтийн арван зурга дугаар сард Жэмазиелахир сарын дотор ч Зү'л-Үшэйрэгийн Газвад гарцгааж (Жэмазиелахир 2 / 623 лнй 11 сар), Мүдлижийнхэн болон тэдний холбоотнуудтай гэрээ хийцгээв.[75]

Энэ хооронд байдлыг хянахаар илгээсэн ба Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн авга эгчийн хүү Абдуллах бин Жахш -радъяллахү анх-ын тэргүүлсэн нэгж нь "Батн-и Нахлэ" гэсэн газар Маккачуудын жинг дарав. Ийм завшааныг ашиглаж байнга Мадина дээр дайрахаар шатлгаан хайж байсан Маккагийн мүшрикчүүд сэтгэл догдлов.

Хазрат-и Пайгамбар ба мусульманчуудын эсрэгээр шуугисан мүшрикчүүд нь Батн-и Нахлэгийн явдлын харам саруудаас Рэжэб сард тохиолдсоны улмаас ч:

"–Мухаммед харам сарыг халал болгож цус асгав. Олз аваад бараа дээрэмдэв," гэцгээв.

Үнэндээ энэ тулалдааныг Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- тушаагаагүй, дараа нь сонсохлоороо Абдуллахад:

"–Би танд харам сард байлдахыг тушаагаагүй!" хэмээн айлдаж олзноос хэсэг авахгүй байв. Тэгэхлээр нь мүжахидчууд ихээр санаа зовж, бодсон байв.[76] Гэтэл мүшрикчүүдийг үүнийг нэлээд хэтрүүлж эсрэг сурталчилгаа хийж эхлэхлээр нь уг ает-и кэримэ нь буув:

يَسْأَلُونَكَ عَنِ الشَّهْرِ الْحَرَامِ قِتَالٍ فِيهِ قُلْ قِتَالٌ فِيهِ كَبِيرٌ وَصَدٌّ

عَن سَبِيلِ اللّٰهِ وَكُفْرٌ بِهِ وَالْمَسْجِدِ الْحَرَامِ وَإِخْرَاجُ أَهْلِهِ

75. Ибн-и Са'д, II, 9-10.

76. Ибн-и Хишам, II, 241.

مِنْهُ أَكْبَرُ عِندَ اللهِ وَالْفِتْنَةُ أَكْبَرُ مِنَ الْقَتْلِ وَلاَ يَزَالُونَ
يُقَاتِلُونَكُمْ حَتَّى يَرُدُّوكُمْ عَن دِينِكُمْ إِنِ اسْتَطَاعُوا

“Чамаас асууя,харам сард байлдах нь нүгэл бишүү? Ингэж хэл: Тэр сард байлдах нь том нүгэл мөн. Гэтэл хүмүүсийг **Аллахын замаас буцаах, Аллахыг үгүйсгэх, Мэсжидэд зочлоход саад болох ба мөргөлчдийг тэндээс гаргах нь харам сард байлдахаас илүү том нүгэл юм. Фитнэ ч хүн алахаас илүү том нүгэл юм.** Расул минь ээ! **Хэрэв тэдний хүч хүрвэл, таныг шашнаас буцаатлаа** харам сар болон халалыг тоохгүйгээр **тантай байлдсаар байх болно...”** (эл-Бакара, 217)

Аетыг бууснаар санаа амарсан Абдуллах бин Жахш ба найзууд нь:

“–Аяа Расулаллах аа! Мүжахидчуудад олгосон ач буян шиг ач буяныг бидэнд ч олгох уу?” гэж асууцгаав. Тэгэхлээр нь уг ает буув:

إِنَّ الَّذِينَ آمَنُواْ وَالَّذِينَ هَاجَرُواْ وَجَاهَدُواْ فِي سَبِيلِ اللّهِ
أُوْلَئِكَ يَرْجُونَ رَحْمَتَ اللّهِ وَاللّهُ غَفُورٌ رَّحِيمٌ

“Тэд итгэж үнэмшээд, нүүсэн ба Аллахын замд байлдав. Тэд нар Аллахын рахматад найдаж мэднэ. Аллах нь ихээр өршөөдөг, ихээр энэрдэг юм.” (эл-Бакара, 218)

Эдгээр тэнгэрлэг зарлалууд нь итгэгчдийг сүнсний талаар дэмжиж байхдаа, мүшрикчүүдийг ч мусульманчуудын эсрэг улам бүр өдөөж байцгаав. Угаасаа эдгээр аетууд буугаагүй бай-

сан ч мүшрикчүүд итгэгчдэд хилэнэдэг байв. Учир нь мусульманчууд өдөр тутам өсч, Исламын Гүрэн ч хүчирхэгжиж байв. Түүнчлэн тэр хооронд Аллахын Элчийн Мадинад хийлгэсэн хүн амыг тооллогоор, итгэсэн эрчүүдийн тоог мянга таван зуу гэж тогтсон байв.[77] Энэ тоог улам нэмсээр байгаа нь, мэдээж мүшрикчүүдийн талаар аажим аажмаар мүшрикчүүдийн хувьд аюул болж эхэлсэн байв. Бас Мадина нь Маккагийн мүшрикчүүдийн амин гол байсан наймааны зам дээр оршиж байв. Тийм учраас аюулыг томсрохоос өмнө дарах арга бодоцгоов. Эцэст нь Мадина руу дайрахаар шийдвэр гаргав.

Абдуллах бин Жахш -радъяллахү анх-ын авсан олзнуудын хооронд Хакэм бин Кэйсан ч байв. Хорвоогийн Хүндэт Эзэн маань Хакэмыг Исламд урив. Исламыг хамаг дэлгэрэнгүй зүйлээр нь урт удаан ярьж өгөв. Сэжгийг нь үгүй болгохоор олон удаа давтав. Аллахын Элчийг хэдий ихээр хичээсэн ч Хакэмийн мусульман болоогүйд хилэгнэсэн Хазрат-и Умар -радъяллахү анх-:

“–Аяа Расулаллах аа! Үүнтэй юунд яриад байна вэ? Валлахи тэр хэзээ ч мусульман болохгүй! Надад зөвшөөр, би хүзүүг нь цавчиж тэр тамд очиг!” гэсэн ч Пайгамбар Эзэн маань Хакэмд Исламыг яриад үргэлжлэв. Хакэм анхаарлаа хандуулан:

“–Ислам гэж юу вэ?” гэж асуув. Хүндэт Элч Эзэн маань:

“–Аллахыг ижилгүй гэж зөвшөөрөөд, Мухаммедыг Түүний боол ба Элч гэдгийг гэрчлэхийг хэлнэ!” хэмээв.

Хакэм:

77. Бухарий, Жихад, 181.

"–Би мусульман боллоо" гэв.

Тэгэхлээр нь Пайгамбар Эзэн маань асхаб руугаа эргэж:

"–Хэрэв би сая таны хэлснийг дагасансан бол, тэр одоо тамд очсон байх байв!" хэмээв.

Хазрат-и Умар -радъяллахү анх- хэлнэ:

"Хакэмийн мусульман болсныг харангаа бараг өнгөрсөн ба ирээдүйн хамаг зүйлс намайг давчдав! Өөртөө: «Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам- надаас сайн мэддэг байхад би яаж Түүнээс юм нэхэж чадах вэ?!» гэлээ. Дараа ч: «Миний зорилго минь зөвхөн Аллах ба Элчийнх тааламжийг олох л байв,» гээд өөрийгөө тайтгаруулав. Хакэм мусульман болов. Валлахи шүтлэгээ ч сайжруулав. Аллахын замд Жихад хийгээд Би'р-и Маунэд шэхид болов." (Ибн-и Са'д, IV, 137-138; Вакидий, I, 15-16)

Энэ явдлаас Исламыг хилэгнэхгүйгээр, зөөлхөн хэлээр, тэвчээртэй ба сайхан сургаалаар тэблиг хийх хэрэгтэй нь ойлгомжтой юм.

Киблаг Өөрчилсөн нь

Хижрэтийн дараа мусульманчууд Мэсжид-и Аксагийн чигээр мөргөл үйлдэж байв. Энэ нь хижрэтийн арван зургаа эсвэл арван долдугаар сар хүртэл ингэж явав. Гэтэл Еврейчүүд энэ байдлаас өөртөө хувь гаргаж давуу буйгаа илэрхийлсэн нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ариун сэтгэлийг гомдоодог байв. Учир нь Түүний сэтгэл дэх кибла нь Каба байв. Энэ нь ингэж хэрэгжвэл, мөн Маккаг эзлэхийн анхны алхамыг гишгэсэн болох байцгаав. Үүний төлөө тэнгэрлэг зөвшөөрөл ирэхийг үгүйлэн хүлээж байв. Арай л зөвшөөрөл ирээгүй тул Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хүсэл ч бодлоос цааш явдаггүй, тэвчээд л хүлээж байв. Эцэст нь Рэжэб сарын

дундуур нэгэн Даваа гаригт Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Сэлимэгийнхний мэсжидэд үдшийн мөргөлийг үйлдүүлж байхад Аугаа Эрх вахийгаа илгээв:

قَدْ نَرَى تَقَلُّبَ وَجْهِكَ فِي السَّمَاء فَلَنُوَلِّيَنَّكَ قِبْلَةً تَرْضَاهَا فَوَلِّ وَجْهَكَ شَطْرَ الْمَسْجِدِ الْحَرَامِ وَحَيْثُ مَا كُنتُمْ فَوَلُّواْ وُجُوِهَكُمْ شَطْرَهُ وَإِنَّ الَّذِينَ أُوْتُواْ الْكِتَابَ لَيَعْلَمُونَ أَنَّهُ الْحَقُّ مِن رَّبِّهِمْ وَمَا اللّهُ بِغَافِلٍ عَمَّا يَعْمَلُونَ

“ Аяа Расул минь! **Бид Чиний царайг** дээрээс мэдээ хүлээж **тэнгэр өөд хэчнээн их харж хүлээснийг харж байна. Одоо л Чамайг кибла руу эргүүлье. Одооноос царайгаа Мэсжид-и Харамын тийш эргүүл!** Аяа мусульманчууд! **Та ч хаана байсан ч,** мөргөхдөө **тийшээ эргэж хар! Мэдээж агуу номыг Раббаасаа ирсэн үнэн буйг маш сайн мэддэг. Аллах ч бүгдийг мэдэж байсан.”** (эл-Бакара, 144)

Энэ хооронд хоёр дахь рэкатын сүүлд хүрсэн байсан Хүндэт Элч Эзэн маань чиглэлээ шууд Каба руу эргүүлэв. Чуулга ч эгнээгээрээ эргэв. Бүгдээрээ шинэ кибла руу чиглүүлэв. Ингээд мөргөлийн бусад хоёр рэкатыг Кабагийн тийш хараад үйлдэв. Ийм учраас тэр мэсжидийг хоёр киблатай мэсжид гэсэн утгаар “Мэсжидү’л-Киблатэйн” гэцгээв.[78]

Уг мөргөлийг Орчлонгуудын Эзний хамт үйлдэгчдийн нэг нь тэндээс салсны дараа өөр нэгэн мэсжидэд очив. Чуулга нь мөргөл үйлдэж байсан бөгөөд яг бөхийсэн байцгаав. Тэдэнд:

78. Ибн-и Са’д, I, 241-242.

“–Би гэрчлэе, Хазрат-и Пайгамбарын хамт Каба руу мөргөл үйлдлээ!” гэж дуудав. Тэгэхлээр нь чуулга байсан газартаа Каба руу чиглэцгээв.

Кибла өөрчилсөн нь итгэгчдийн хооронд сайхан дүгнэсэн боловч, мүшрик, мүнафик ба еврейчүүдийн хооронд зарим хов яриаы учир болов. Исламын дайснууд ухаан утгагүй яриад эхлэв. Тэгсэнд нь уг ает-и кэримэнүүд буув:

سَيَقُولُ السُّفَهَاء مِنَ النَّاسِ مَا وَلاَّهُمْ عَن قِبْلَتِهِمُ الَّتِي

كَانُواْ عَلَيْهَا قُل لِّلّهِ الْمَشْرِقُ وَالْمَغْرِبُ يَهْدِي

مَن يَشَاء إِلَى صِرَاطٍ مُّسْتَقِيمٍ

“Хүмүүсээс хэсэг тархигүйчүүд: «Чиглэж байсан кибла-гаас тэднийг эргүүлсэн нь юу вэ?» гэцгээнэ. Ингэж хэл: «Дорно ч өрнө ч Аллахын юм. Тэрээр хүссэнээ зөв замд хүргэнэ.»” (эл-Бакара, 142)[79]

Ибн-и Аббас -радъяллахү анх- ингэж хэлдэг:

“Ает-и зэримэг тунгааснаар Хазрат-и Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам- киблаг Каба руу эргүүлэхдээ мусульманчууд:

«–Аяа Аллахын Элч ээ! Бэйтү’л-Макдис руу чиглэж мөргөл үйлдээд ба одоо өнгөрсөн буй дүү нарын маань мөргөл юу болох вэ?» гэж асууцгаав.

Тэгэхлээр нь Аугаа Эрх энэ аетыг буулгав:

79. Бухарий, Иман 30, Салат 31; Мүслим, Мэсажид 11.

وَكَذَلِكَ جَعَلْنَاكُمْ أُمَّةً وَسَطًا لِّتَكُونُواْ شُهَدَاء عَلَى النَّاسِ وَيَكُونَ الرَّسُولُ عَلَيْكُمْ شَهِيدًا وَمَا جَعَلْنَا الْقِبْلَةَ الَّتِي كُنتَ عَلَيْهَا إِلاَّ لِنَعْلَمَ مَن يَتَّبِعُ الرَّسُولَ مِمَّن يَنقَلِبُ عَلَى عَقِبَيْهِ وَإِن كَانَتْ لَكَبِيرَةً إِلاَّ عَلَى الَّذِينَ هَدَى اللّهُ وَمَا كَانَ اللّهُ لِيُضِيعَ إِيمَانَكُمْ إِنَّ اللّهَ بِالنَّاسِ لَرَؤُوفٌ رَّحِيمٌ

“Ингээд таны хүн төрөлхтөнд гэрч болох тань, Расул ч танд гэрч болох тулд Бид таныг ядуу нэгэн үммэт болгов. Чиний одоо **чиглэсэн киблаг** (Кабаг) **Бид Пайгамбарыг л дагасныг, өсгий дээрээ хойш эргэснээс ялгахаар кибла болгов. Энэ нь Аллахын аврал олгосноос бусдад мэдээж хүнд санагдана. Аллах таны итгэлийг ерөөсөө зарцуулахгүй. Учир нь Аллах хүнд халамжтай, энэрэлтэй мөн.”** (эл-Бакара, 143)[80]

Кибла өөрчилсөн нь маш чухал үйл явдал юм. Агуулга нь түрүүний киблаг цуцлах шинжээрээ ялангуяа чөтгөрийнхний фитнэ гаргаж хүмүүсийг хуурах шалтгаан болгох маш нарийн нэгэн хэрэг юм. Ийм учраас киблагийн тухай тушаал хэд олон дахисан, нэг удаа Хазрат-и Пайгамбарт, нэг удаа итгэгчдэд, нэг удаа ч хоёр талд зэрэг, суурьшсан эсвэл аянд байхдаа хаана байсан ч энэ киблад тогтох нь шүүмжлэлтэй ба дэлгэрэнгүйгээр тушаасан байдаг.[81]

80. Тирмизий, Тэфсир, 2/2964.

81. Хар. эл-Бакара, 148-149.

Доорх аетад зарим нууц учрыг нь тайлбарлаад энэ тухай шүүмжлэл ч тусгай утга агуулсан байдаг. Аугаа Эрх айлдана:

وَمِنْ حَيْثُ خَرَجْتَ فَوَلِّ وَجْهَكَ شَطْرَ الْمَسْجِدِ الْحَرَامِ وَحَيْثُ مَا كُنتُمْ فَوَلُّواْ وُجُوهَكُمْ شَطْرَهُ لِئَلاَّ يَكُونَ لِلنَّاسِ عَلَيْكُمْ حُجَّةٌ إِلاَّ الَّذِينَ ظَلَمُواْ مِنْهُمْ فَلاَ تَخْشَوْهُمْ وَاخْشَوْنِي وَلأُتِمَّ نِعْمَتِي عَلَيْكُمْ وَلَعَلَّكُمْ تَهْتَدُونَ

“Хаанаас замд гарсан ч, мөргөхдөө **Мэсжид-и Харамын тийш эргэж хар. Хаана байсан ч нүүрээ тийш эргүүлээд, хоорондоо** зөрүүдчүүдээс **гадна хүмүүсийн таны эсрэг** ашиглах **баталгаа нь эс болог. Тэднээс огт айгуузай! Зөвхөн Надаас л айцгаа! Ингээд танд буй шимээ Би дүүргэе, тэгээд та нар зөв замыг олго.”** (эл-Бакара, 150)

Дурдсан тэнгэрлэг зараас эдгээр эрдмүүдийг мэдэж авна:

1. Ает-и кэримэгийн хэлснээр кибла өөрчилсний нэг дүгээр учир нь эхл-и китаб болон мүшрикчүүдэд мусульманчуудын эсрэг ямар ч баталгаа үлдээхгүй юм. Учир нь, хуучин номуудад амласан сүүлчийн пайгамбарын бэлгэ тэмдэгт киблаг Каба руу эргүүлэх гэж байдаг.

Жишээлбэл Хуучин Гэрээслэлийн Ешаягийн Ном гэсэн хэсэгт Маккагийн ирээдүйн тухай зарлалууд үүнийг илээр заадаг. Ийм учраас эхл-и китаб “Сүүлийн Пайгамбарын кибла нь Макка болох байв. Мухаммед ба асхаб нь бол хэвээрээ Бэйт-и Макдис (Мэсжид-и Акса) руу эргэнэ,” гээд сэжих боломжтой байв.

Дараа нь Хазрат-и Ибрахимын киблаг эсэргүүцэх нь, Аллахын Элчийн “Ибрахим Улс” дээр байх тухай зарлалтай зөрөхсөн. Мүшрикчүүд үүнийг ухааны баталгаа болгож илэрхийлж мэдэхсэн. Гэтэл кибла өөрчилсний дараа харгис зөрүүдээс гадна хэн ч ийм эсэргүүцэл илэрхийлж чадахгүй байв.[82]

2. Кибла өөрчилсний өөр нэгэн учир бол, Аллахын итгэгчдэд шимээ бүтээх юм. Үүний ачаар тэд авралд хүрээд зөв замаар явж хүссэн зорилтод хүрч чадах байв. Угаасаа жинхэнэ шим нь зөв замд хүрэх юм. Кибла ч зөв замын нэгэн хэсэг мөн.

3. Пайгамбар Эзний маань анхны саруудад Бэйтү’л-Макдис руу мөргөл үйлдсэний нэгэн учир ч тэнгэрлэг шашнуудын нэг гаралтай буйг дурдаж, еврей эсвэл христчүүдийн сэтгэлийн Исламд дасгах байв. Мөн ингэсэн нь Исламын нийгэм ба улс төрийн байгуулах шатад еврей болон христчүүдийн эсрэг зорилогыг зөөлрүүлсэн буйг бодох ч боломжтой.

Энэ байдал нь мөн түүнчлэн Кур’ан-и Кэримд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн огт оролдоогүйг баталсан тэмдгээс нэгэн юм. Учир нь Хазрат-и Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам- киблаг Каба руу болохыг бүр эхнээс нь маш их хүсдэг байв. Харин энэ тухай тэнгэрлэг тушаал буусан хижрэтийн арван зурга дугаар сар хүртэл хүлээхээс өөр аргагүй байв.

Мацаг, Фитр Хандив ба Зэкат

Оролцсон дайны зэрэг нэг талаас улс төрөө бэхжүүлсэн Ислам нь нөгөө талаас ч өөрийнх тусгай сүнсний амьдралыг ч шат шатаар нь дэвшүүлж байв. Үүнтэй хамаатай “Рамазаны

82. Хар. Элмалылы, I, 537.

мацгийг" итгэгчдэд фарз болгов. Мацаг нь, Хайрт Пайгамбарын маань Мадинад нүүсний арван найм дугаар сард, киблаг Каба руу эргүүлснээс дараа, Шабан сарын хугацаанд тушаал болов.[83]

Аугаа Эрх нь Рамазаны мацгийг фарз болгосноо уг ает-и кэримэгээр мэдээлэв:

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُواْ كُتِبَ عَلَيْكُمُ الصِّيَامُ كَمَا
كُتِبَ عَلَى الَّذِينَ مِن قَبْلِكُمْ لَعَلَّكُمْ تَتَّقُونَ

"Аяа итгэгчид ээ! Мацаг нь танаас өмнөх үммэтүүдэд фарз болсон шигээ танд ч фарз болов. Таныг өөрийгөө хамгаална гэдэгт найдна." (эл-Бакара, 183)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч ингэж айлдав:

"Ислам нь таван үндсэн дээр байгуулсан байдаг: Аллахаас өөр бурхан үгүй ба Мухаммед Аллахын Элч буйд гэрчлэх, мөргөл үйлдэх, зэкат өгөх, хаж явах ба Рамазаны мацгийг барих." (Бухарий, Иман 1, 2; Тэфсир 2/30; Мүслим, Иман 19-22)

Хүндэт Элч Эзэн маань мацгийн эрдмийг ийнхүү хадис-и шарифдаа маш сайхан илэрхийлэв:

"Азиз ба Жэлил буй Аллах:

«Хүний мацгаас гадна хамаг үйл нь өөрийнхөө төлөө юм. Мацаг бол Миний л төлөө юм, ийм учраас түүний шагналыг ч Би л олгоно,» хэмээн айлдав.

83. Ибн-и Са'д, I, 248.

Мацаг нь бамбай юм. Танаас хэн нэгэн мацаг барьсан өдөр муу үг эс хэлэг, бүү хэрэлдэг. Хэрэв хэн нэгэн түүнд харааж эсвэл үймүүлбэл:

«Би мацагтай,» гэж хэл.

Мухаммедын амийг хүчит гараараа барьсан Аллахад тангараглая, мацагтын амны үнэр, Аллахын онгонд анхилуунаас ч гоё юм. Мацагтын санаа амрах баяр баясгалангийн хоёр цаг байдаг: Нэгэн хоол идсэн цаг, нөгөө нь ч мацгийн буянаар Рабтайгаа учирсан цаг юм.” (Бухарий, Савм, 9; Мүслим, Съям, 163)

“Хүний үйл бүрт нь олон дахин ач буян хайрладаг. Нэгэн сайн үйл нь арваас долоон зуун дахин хүртэл өсдөг. Аллах Таала:

«Харин мацаг нь өөр. Тэр нь Миний л төлөө юм, шагналыг нь ч Би л олгоно. Учир нь мацаг баригч нь хүсэл ба идэхээ Миний төлөө л орхино,» хэмээн айлдав.” (Мүслим, Съям, 164)

“Аллахын замд хандив өргөсөн байнга тусламж тараадаг хүнийг диваажингийн тус тусгай хаалгаар:

«Еэ Аллахын хайрт боол оо! Энд буян ба элбэг байдаг,» хэмээн дуудна.

Байнга мөргөл үйлдэгсэд нь мөргөлийн хаалгаар, мүжахидчууд жихадын хаалгаар, мацагтнууд Рэйяан хаалгаар, хандив өгөх дуртайчууд ч хандивын хаалгаар диваажинд орохоор уригдана.”

Эбү Бэкир -радъяллахү анх-:

“–Аав ээж минь Чамд золиос болоосой, аяа Аллахын Элч ээ! Үнэндээ эдгээр хаалгануудын нэгнээс урьсан хүнд бусад хаалгаар дуудах нь огт хэрэггэй боловч, эдгээр хаалгануудын бүгдээс нь дуудах хүн байдаг уу?” гэв.

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Тийм, байдаг. Чамайг ч жаргалтнуудаас олохыг найдна,” хэмээв. (Бухарий, Савм 4, Жихад 37; Мүслим, Зэкат 85, 86)

Мацаг нь бидний олсон тоогүй шимүүдийн үнэ цэнийг мэдүүлэх, тухайн шимийг хайрласан Аллахад талархлын мэдрэмж төрүүлэх, махбодийн хүсэл ба эрмэлзлийг дарах, сэтгэлийг эдийн даралтаас авраад “тэвчээр” гэгч ёс суртахууны хамгийн өндөр гавьяат хүргэх нэгэн үйлчилгээ юм. Мацаг нь ядуучуудын байдлыг ойлгох мэдэл олгосон шигээ, зүрхийг энэрлийн мэдрэмжээр л дүүргэнэ. Жишээлбэл сангууд тушаалд нь орсон боловч Юүсүф -алэйхиссэлам- нь ядуучуудын байдлыг мартахгүйн төлөө хэзээ ч цадталаа идээгүй байдаг.

Ийм олон нууц учраараа мацаг нь нийгмийн амьдралын хилэн, өшөө, атаархал мэтийн тав тухгүй сөрөг занг үгүй болгоход хамгийн их нөлөөтэй тэнгэрлэг нэгэн тушаал юм. Түр зуурын амтаас больж үүрд мөнхийн амтад хүртэхийн нууцыг, Аугаа Эрхийн тушаасан мацгийн шимээр л олдог. Энэ үйлчилгээ нь нэфсийн идэх, уух ба махбодийн тааламжийн талаар ерөөсөө дуусдаггүй хүслийн эсрэг хүний нэр алдрыг хамгаалсан нэгэн бамбай юм.

Өдөр мацгаар хүндэлсэн Рамазан сарын шөнийг ч тэравих мөргөлөөр элбэгдүүлэх нь Оршигчдын Туяа Эзний маань сүннэт юм. Тэр нь нэгэн хадис-и шарифдаа:

“Аллах Таала Рамазанд мацгийг фарз болгов; би ч (тэравих) мөргөлийг сүннэт болголоо,” хэмээн айлдав. (Ибн-и Мажэ, Салат, 173)

Рамазаныг хамгийн сайнаар ашиглахын тул өдөр мацаг барихын зэрэг шөнийг ч залбиран хүнлэх, бүх төрлийн хэрэггүй зүйлсээс болгоомжилж Аллахыг дурдан хэлээ, өршөөл гуйх ба

нулимсаараа ч зүрхээ угаах хэрэгтэй. Сүүлчийн арван хоногт итикафад орох бол чухал нэгэн сүннэт-и сэнийе юм. Рамазан шөнийг хүндлэх нь энэрэл ба өршөөлийн учир болно. Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эзэн маань ингэж айлдав:

"Хэн нь итгэж ба ач буяныг нь Аллахаас найдан Рамазаны шөнүүдийг хүндэлбэл, өнгөрсөн нүгэлээ өршөөлгөнө." (Бухарий, Тэравих, 46)

Хазрат-и Аиша эх маань ингэж хэлнэ:

"Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Рамазан сард нэгэн шөнө мэсжидэд нафила мөргөл үйлдсэн байв. Олон хүн ч түүний дагаж мөргөл үйлдэв. Өглөө болоход нь асхаб:

«–Расулаллах шөнө мэсжидэд мөргөл үйлдэв,» гэж ярилцав.

Хүндэт Нэбий -саллаллахү алэйхи вэ сэллэм- дараа шөнө ч мөргөл үйлдэв. Ард нь дахиад үүнийг л ярив; дагагчдын тоо ч нэлээд өсөв. Гурав дахь эсвэл дөрөв дэх шөнө хүмүүс дахиад цуглав. Тэгээд мэсжид тэднийг багтаахааргүй болов. Харин Аллахын Элч дараа шөнө тэдний дэргэд гараагүй. Өглөө болохлоор Эзэн маань:

«–Таны яасныг би харлаа. Таны дэргэд гарахаас намайг буцаасан нь, би уг мөргөл та нарт фарз болохоос айна,» хэмээв." (Бухарий, Тэравих, 1; Мүслим, Мүсафирийн, 177)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэравих мөргөлийг чуулгаар үйлдээгүй юм. Хүн бүрийн хүч чадлаараа боолчлохыг илүү зохимжтой үзсэн байв. Тэравих мөргөл нь Хазрат-и Эбү Бэкирийн калиф байсанд ч ганц биеэрээ үйлдсэн, Хазрат-и Умарын эринд бол чуулгаар үйлддэг болов.

Орчлонгуудын Эзэн -алэйхиссалатү вэссэлам- Рамазан сард хамаг залбирал үйлчилгээ ба сайхан үйлсээ арвижуулдаг, Рабтайгаа ханашгүй харилцааны улиралд ордог байв. Үүний тухай Ибн-и Аббас -радъяллахү анхүмаа- ингэж хэлнэ:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- хүмүүсийн хамгийн өгөөмөр нь байв. Түүний хамгийн өгөөмөр болсон үе бол Рамазанд Жэбраил -алэйхиссэлам-ын Түүнтэй уулзсан цагууд байв. Жэбраил -алэйхиссэлам- Рамазаны шөнө бүрт Пайгамбар Эзэнтэй маань уулзаж, хамтдаа Кур’ан уншдаг байв. Ийм учраас Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Жэбраилтай уулзахдаа ямар ч саад танилгүй үлээсэн энэрлийн салхинаас ч өгөөмөр ханддаг байв.” (Бухарий, Бэд’ү’л-Вахй 5, 6, Савм 7; Мүслим, Фэзаил 48, 50)

Мацгийн дараа **“Баярын мөргөл”** ба **“Фитр Хандив”** тушаал болов. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Фитр Хандивын мусульманчуудаас бага том, эр эм, чөлөөт ба боол дээр нэгэн са’[84] хасарваан эсвэл нэгэн са’ арвайн хэмжээгээр фарз болсныг мэдүүлэв.[85]

Хэрэгцээтэй хүмүүсийн тухай ч:

“Тэднийг энэ баярын өдөрт өлөн явахаас хамгаалаарай!” хэмээв. (Ибн-и Са’д, I, 248)

Фитр Хандив нь баярын мөргөлөөс өмнө өгвөл зүйтэй болж, мөргөлийн дараа өгвөл фитрээс гадна өөр нэгэн хандивын тоонд орно.[86]

---

84. **Са’:** 1040 дирхэм хүндтэй буудай эсвэл арвайг багтаахуйц ээзлхүүний хэмжээс юс. 1 са’ нь хуулийн дирхэмээр ойролцоогоор 2,917 кг; заншлын дирхэмээр бол 3,333 кг. Жинтэй тэнцэнэ.
85. Бухарий, Зэкат, 70-78; Мүслим, Зэкат, 13.
86. Ибн-и Мажэ, Зэкат, 21.

Хазрат-и Энэс -радъяллахү анх- ярина:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Мадинад ирэхэд Мадиначуудад хоёр баярын өдөр байв. Тэр өдрүүдэд бүжиглэж жаргадаг байцгаав. Аллахын Элч:

«–Энэ хоёр өдрийн утга юу вэ?» хэмээн асуув.

Тэд:

«–Бид мунхаглалын үеэр эдгээр өдрүүдэд жаргадаг байлаа!» гэцгээв.

Эзэн маань:

«–Аллах энэ хоёр өдрийн баярыг тань тэднээс илүү буянтай хоёр өдөртэй солив: Тахилын Баяр ба Фитр Рамазан Баяр!» хэмээв.” (Эбү Давуд, Салат, 239/1134; Нэсаи, Ийдэйн, 1)

Пайгамбар Эзэн маань тухайн жилийн Зилхижжэ сарын аравны өдөр баярын мөргөл үйлдүүлсний дараа мусульманчуудад тахил барихыг тушаав. Пайгамбар Эзэн маань Мадинад арван жил амьдарсан ба жил бүр тахил барив.[87] Аллахын Элч тахилаа хосоор нь бариад, нэгийг тахил барьж чадаагүй үммэтийнхээ төлөө, нөгөөг ч өөрийнхөө болон гэр бүлийнхээ төлөө байв.[88]

Ханэш -радъяллахү анх- хэлнэ:

“Хазрат-и Алиг хоёр хуцаар тахил барихыг хараад:

«–Яагаад ингэж байна вэ?» гэлээ:

«–Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- өөд болсны дараа өөрийнх төлөө ч тахил барихыг надад гэрээс болгов.

87. Ибн-и Са’д, I, 248-249.

88. Эбү Давуд, Эдахий, 3-4/2792; Ибн-и Са’д, I, 249.

Ингэж би Түүний гэрээсийг хэрэгжүүлэхээр барьж байна! Үүний дараа ч барьсаар байх болно!» гэв.” (Эбү Давуд, Эдахий, 1-2/2790; Ахмад, I, 107)

Тахилын Баярын Битүүний өдөр өглөөний мөргөлөөс баярын дөрөв дэх өдрийн оройн мөргөл хүртэл, мөргөлийн 23 удаа ганцаараа эсвэл хамтаар үйлдсэн фарз мөргөлийн дараа нэгэн удаа:

اَللّٰهُ اَكْبَرُ اَللّٰهُ اَكْبَرُ لاَ اِلٰهَ اِلاَّ اللّٰهُ وَاللّٰهُ اَكْبَرُ اَللهُ اَكْبَرُ وَلِلّٰهِ الْحَمْدُ

гээд тэкбир авчрах, эр-эм, имам-чуулга, суурьшмал-зочин мусульман бүрт важиб мөн. Үүнийг тэшрикийн тэкбир гэдэг.[89]

Фитр хандиваас хэсэг хугацааны дараа ч **“Зэкат”** тушаал болов. Ает-и кэримэд ингэж айлдав:

وَفِي أَمْوَالِهِمْ حَقٌّ لِّلسَّائِلِ وَالْمَحْرُومِ

“Саилын хүсэгчийн **ба махрумын** нэр хүндээс болж гуйж чадаагүйн**, хөрөнгө баялагт тодорхой хэсэг байдаг.”** (эз-Зарияат, 19)

وَالَّذِينَ هُمْ لِلزَّكَاةِ فَاعِلُونَ

“Зэкат өгөгчидийн нүгэл нь арилж аврагдав.” (эл-Мү’минүн, 4)

خُذْ مِنْ أَمْوَالِهِمْ صَدَقَةً تُطَهِّرُهُمْ وَتُزَكِّيهِم بِهَا
وَصَلِّ عَلَيْهِمْ إِنَّ صَلاَتَكَ سَكَنٌ لَّهُمْ

89. *Муватта*, Хаж, 205.

“ Аяа Пайгамбар! **Тэдний бараанаас хандив ав; тэднийг** нүгэлээс **цэвэрлэн, тэднийг арилгаж дэвшүүлнэ! Тэдний төлөө залбир! Учир нь Чиний залбирал тэдний хувьд тайван байх нь** тайвны үүсвэр юм**...”** (эт-Тавба, 103)

Зэкат нь Кур’ан-и Кэримд хорин зургаан газар мөргөлийн хамт дурдсан байдаг. Дөрвөн газар бол ганц биеэрээ явна. Эдгээрээс Мү’минүн Сура дахь, мөргөлөөс тустай өнгөрсөн боловч, тэнд ч мөргөл үйлдэгчдийн зэкатаа өгсний үнэнийг илэрхийлнэ. Үүний учир нь “бие” болон “эдийн” болоод хоёр хуваагдсан үйлчилгээнд, энэ хоёр нь нэгдүгээр байранд ба ижил үнэ цэнэд орсон нь юм. Жишээлбэл нэгэн хадис-и шарифад:

“Мөргөл үйлдсэн боловч зэкат өгдөггүй хүний мөргөлд буян үгүй!” хэмээдэг. (Хэйсэмий, III, 62)

Зэкатыг сургалтын төв, эмнэлэг мэтийн хуулийн хүнд өгч болдоггүй. Учир нь тэр Аугаа Эрхийн тушааснаар найман ангийн хэрэгцээт харьяалсан нэгэн эрх юм.[90] Ийм байгууллагууд, тэдэнд олгосон зэкатыг ядуучуудын гол хэрэгцээнээс гадна зарцуулж болохгүй. Харин сургалтын төв суралцагчдад ба и’лай-и кэлимэтуллах зорилгоор эрдэм сурч буй шавь нарын төлөө зарцуулж болно. Учир нь зэкатыг аж ахуйн талаар тааруу ядуучуудын гол хэрэгцээг хангахаар өгөх нь түүний хүчинтэй болох шалтгаанаас юм. Ийм учраас зэкат хурааж авсан байгууллагууд энэ зарчмыг нямбай дагах ёстой байдаг. Эс тэгвээс Аугаа Эрхийн онгонд хариуцлагаа хүлээнэ.

Кур’ан-и Кэримд зэкатыг ямар хүмүүст өгч болохыг ингэж ангилсан байдаг:

إِنَّمَا الصَّدَقَاتُ لِلْفُقَرَاءِ وَالْمَسَاكِينِ وَالْعَامِلِينَ عَلَيْهَا وَالْمُؤَلَّفَةِ

90. Хар. Тавба, 60.

قُلُوبُهُمْ وَفِى الرِّقَابِ وَالْغَارِمِينَ وَفِى سَبِيلِ اللّٰهِ وَابْنِ السَّبِيلِ
فَرِيضَةً مِنَ اللّٰهِ وَاللّٰهُ عَلِيمٌ حَكِيمٌ

“Хандив зэкат **нь Аллахаас нэгэн фарз болж зөвхөн ядуу** амьдралаа авч явж чадахгүй эсвэл маш хэцүү байдалд буй хүмүүст **, мэсакинд** ямар ч эд бараагүй хүмүүст**, ийм үүргээр томилогдсонд** зэкат цуглуулах албанд**, мүэллэфэ-и күлүбт** зүрхийг нь Исламд дасгах хэрэгтэй хүмүүст**, боолчлол дор буй хүмүүст, өртэй хүмүүст, Аллахын замд буй хүмүүст** (мүжахидчууд, шашны эрдэм сурч буй шавь нар г. м.) **ба замд үлдсэн хүмүүст л олгодог. Аллах маш сайн мэддэг, эрдмийн эзэн мөн.”** (эт-Тавба, 60)

Холбоо ба сан мэтийн хуулийн хүмүүст ч зөвхөн аетад дурдсан найман газар хүргэх нөхцөлөөр л зэкат өгч болно. Энэ нь анхаарах хэрэгтэй чухал нэгэн хэрэг юм.

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- зэкатын тухай тэнгэрлэг тушаал ирэхлээр зэкатыг юугаар, ямар хэмжээнд өгөх ба хэдий хөрөнгөтэй хүнд фарз болсны тухай нэгэн баримт бичүүлээд үүнийг сэлэмдээ уяв. Өөд болтлоо энэ бичгийг хажуудаа байлгаж түүнийг мөрдөв. Аллахын Элчээс хойш Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх- ба түүний дараа ч Хазрат-и Умар -радъяллахү анх- ч түүний дагуу ажиллав.[91]

Зэкат хандив нь баян хүмүүсийн хөрөнгө мөнгөөрөө гайхуулах, баярхах санааг дарж, ядуу зүдүүчүүдийн тэдэнд атаархаж хорсохыг үгүй болгодог, нийгмийн дотор оршин байгаа нийт олны нэг нь нийтийн төлөө нийт нь нэгийн төлөө байх сайхан сэтгэлийн үрийг тарьж байдаг юм. Ядуу баян хоёрын хоорон-

91. Бухарий, Зэкат, 38; Ахмад, II, 14.

дын тэгш ба хайрыг хангах талаар Ислам нийгмийн бүтцэд “зэкат ба инфак” гэдэг үйлчилгээ нь маш чухал байр эзэлнэ.

Зэкат ба инфак буюу хөрөнгөнөөсөө хэрэгцээт хүмүүст тараах үйлийн нэгэн нууц учир ч хувийн хөрөнгийн ер бус өсөхөд ба ингээд хүчгүйчүүдийг мөлжих эсвэл хооронд нь хилэн ба өшөө илрэхэд саад болох юм. Учир нь хэрэв баялагаараа бахархах ба их зан гаргах учир болбол, түүний үр дүн нь гунигтай байх болно. Харин нэгэн нийгэмд тусалсан эсвэл тусламж авсан бүх хүмүүс, эд бараа ба сүнсний талаар нэг нэгэндээ хэрэгцээт байдаг юм.

Хөрөнгө чинээлэг нэгэн ч Аллахад харьяалагдсаныг мэдэх хэрэгтэй. Хүний хөрөнгө дээр эзэн болох нь бол манай эрин саяхан нээсэн хувьцаат хөрөнгийн аргатай төсөөтэй юм. Өөрөөр хэлбэл баялаг нь Аллахын боолдоо түр зуур өгсөн нэгэн хамгаалалт юм. Ийм учраас хүмүүсийн түүний хэрэглэх нь зарим тэнгэрлэг хэмжээтэй холбоотой байдаг. Түүний жинхэнэ эзнийх нь тушаасан чиглэлд ашиглаж эсвэл зарцуулах хэрэгтэй. Хэрвээ хөрөнгөө тэнгэрлэг тушаалын эсрэгээр ашиглавал, хүмүүсийг догшруулах, янз бүрийн их зан, харгислал ба эрх тэгшгүй байдал гарахад нөлөөлөх юм. Ийм нэгэн гамшигт автагсдад өмч хөрөнгө зүрхэнд суурьшина. Аугаа Эрхийн дэлхийн шим дотор зөвхөн хөрөнгө ба хөвүүдийг “фитнэ” гэж дурдсан нь, эд нар зүрхэнд ороод бараг баримтат шүтээн болсонтой холбоотой юм. Ийм гутамшигт автагчдыг сануулахаар Аллах Таала ингэж айлдана:

وَالَّذِينَ يَكْنِزُونَ الذَّهَبَ وَالْفِضَّةَ وَلاَ يُنفِقُونَهَا فِي سَبِيلِ اللّهِ
فَبَشِّرْهُم بِعَذَابٍ أَلِيمٍ يَوْمَ يُحْمَى عَلَيْهَا فِي نَارِ جَهَنَّمَ
فَتُكْوَى بِهَا جِبَاهُهُمْ وَجُنوبُهُمْ وَظُهُورُهُمْ هَذَا

مَا كَنَزْتُمْ لأَنفُسِكُمْ فَذُوقُواْ مَا كُنتُمْ تَكْنِزُونَ

“...Алт мөнгийг хураагаад түүнийг Аллахын замд зарцуулдаггүй хүмүүст, тэдэнд гунигтай нэгэн зовлонг мэдүүл! Тэр өдөр тамын галд (цуглуулсан энэ алт мөнгө нь) **улайж хайлж тэдний духыг, нуруу сээрийг тамгална.** (Тэгээд тэдэнд ингэж хэлнэ:) **«Энэ нь нэфсийнхээ төлөө цуглуулсан хөрөнгө юм. Одоо бусдаас харамлан хураасан юмныхаа** зовлонг **амсаарай!»”** (эт-Тавба, 34-35)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч зэкатыг хойш тавигчдын гашуун дүгнэлтийг ингэж илэрхийлсэн байдаг:

“Зэкатыг нь өгөөгүй алт мөнгө бүр киямат өдөр галд шатаж тамга болоод эзнийхээ хажуу тал, дух ба сээрийг нь тамгална. Тамга хөрөвч эзнийг нь тамлахаар дахиад халаана. Тамын нэг өдөр энэ насны тавин мянган жилийн хугацаатай бөгөөд шийдвэр гартал энэ нь ингэж үргэлжилнэ. Эцэст нь тухайн хүн замынхаа диваажинд эсвэл тамд унасныг харна.”

Асхаб:

“–Аяа Расулаллах аа! Тэгвэл зэкатыг нь өгөөгүй тэмээний байвал ямар вэ?” гэж асуухад Хазрат-и Нэбий -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

“–Тэмээнийхээ эрхийг төлөөгүй тэмээний эзэн бүрийг нь -усан дээр ирэхлээр нь сүүг нь сааж сүүнээс нь хэрэгцээт хүмүүст тараах нь ч энэ эрхэнд багтдаг- киямат өдөр хавтгай өргөн нэгэн талбайд хэвтүүлнэ. Тэд тэмээнүүд ч, нэгэн ботго дуталгүй хамгийн тарган байдлаараа ирээд тухайн хүнийг хөлөөрөө гишгэж шүдээрээ хазна. Өмнөөс ирэгчид нь өнгөрөхөөр хойнох нь ирнэ (ижлээр хийнэ). Тавин мянган жилийн хугацаат буй нэгэн өдөрт хүмүүсийн хорронд шийдвэр

гартал энэ нь ингэж үргэлжилнэ. Эцэст нь тухайн хүн замынхаа диваажинд эсвэл тамд унасныг харна."

Асхаб-и кирам нь үхэр ба хонины зэкатыг төлөөгүй хүмүүсийн байдлыг асуухлаар ч Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ижил хариу олгов. (Мүслим, Зэкат, 24; Бухарий, Жихад, 48)

Зэкат ба хандив өгөхдөө эелдэг хандахад ч их анхаарал үзүүлэх хэрэгтэй. Залхаах, муугаас нь өгөх мэтийн зэкат болон хандивыг вэмий болгох хандлагаас холдох хэрэгтэй. Ялангуяа өгсөн нь түүнийг фарз болсон уг өрөөс нь аварч буянд хүргэж авсанд нь талархалаа илэрхийлэх байдалтай байх хэрэгтэй. Олгосон хандив бол, мөн өгсөн хүнийг өвчин ба гай гамшгаас хамгаалах нэгэн халхавч юм. Ядуу зүдүү ба аргагүй хүмүүс үнэндээ эд баялагтай хүмүүсийн хувьд нэгэн шим мөн. Учир нь диваажингийн хаалга нь тэдний залбирлаар л онгойлно.

Садака буюу хандив өгөхдөө анхаарах хүмүүжлийг сургасан аетууд ингэж айлдана:

الَّذِينَ يُنفِقُونَ أَمْوَالَهُمْ فِي سَبِيلِ اللّهِ ثُمَّ لاَ يُتْبِعُونَ مَا أَنفَقُواُ
مَنًّا وَلاَ أَذًى لَّهُمْ أَجْرُهُمْ عِندَ رَبِّهِمْ وَلاَ خَوْفٌ عَلَيْهِمْ وَلاَ هُمْ
يَحْزَنُونَ قَوْلٌ مَّعْرُوفٌ وَمَغْفِرَةٌ خَيْرٌ مِّن صَدَقَةٍ يَتْبَعُهَا أَذًى وَاللّهُ
غَنِيٌّ حَلِيمٌ يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُواْ لاَ تُبْطِلُواْ صَدَقَاتِكُم بِالْمَنِّ وَالأذَى
كَالَّذِي يُنفِقُ مَالَهُ رِئَاء النَّاسِ وَلاَ يُؤْمِنُ بِاللّهِ وَالْيَوْمِ الآخِرِ

"Хөрөнгөө Аллахын замд зарцуулж, ядуу зүдүүгийн сэтгэлийг нь гомдоогоогүй хүмүүс буй биз, тэдэнд Аллахын

шагнал байгаа. Тэдэнд айх юм үгүй, бас тэд гунглах ч үгүй. Сайхан үг ба өршөөл нь, араас нь тамлал ирсэн хандиваас илүү буянтай юм. Аллах ямар ч юмыг хэрэглээний үүднээс биш, уяхан сэтгэлийн угаас мэдэрдэг. Аяа итгэгчид ээ! Аллах болон ахират өдөрт итгээгүй боловч хөрөнгө мөнгөө зөвхөн бусдад үзүүлэх сайн болж харагдах зорилгоор инфак ба хандиваа дэмий битгий өргө!..” (эл-Бакара, 262-264)

Итикаф

Итикаф нь толь бичигт өгүүлснээр өөрийгөө нэгэн газар хорьж хүлээх, эд хөрөнгө болон сүнсний, эерэг сөрөг нэгэн зүйл дээр салшгүй бодох гэсэн утга агуулна. Хүмүүжилд бол боолчлол болон Аллахад ойртох зорилгоор мэсжидэд тодорхой хугацаагаар байх (оршин суух) гэсэн утгатай юм. Үүнээс өөр зорилгогүй тул, энэ хүлээлт нь нэг цаг байсан ч итикаф нь хүчинтэй байх болно. Үүнийг нафила итикаф гэдэг. Гэтэл:

وَلاَ تُبَاشِرُوهُنَّ وَأَنتُمْ عَاكِفُونَ فِي الْمَسَاجِدِ

“...Мэсжидэд залбиралд орохдоо эмэгтэйчүүдтэй битгий нийл!..” (эл-Бакара, 187) аят нь итикафад мацаг шаардлагатай буйг, ийм учраас итикаф хугацааг нэгэн өдрөөс бага болохгүйг заадаг бөгөөд энэ бол шашны жинхэнэ итикаф мөн. Ийм учраас итикаф ердөө Рамазан сард ба мацагтай байхдаа мэсжидэд хүлээх аргаар хэрэгжүүлдэг. Тэгэхээр нь итикаф нь өдөр нь мацагтай, шөнийг залбирлаар өнгөрөөж, жинхэнэ утгаар нь Аллахын боол гэдгээ мэдрэхэд гол зорилго оршино.

Рамазаны сүүлийн арав хоногт хийдэг итикаф нь жинхэнэ мүэккэдэ сүннэт юм. Нэгэн газар энэ сүннэт хэрэгжсэн бол, бусад мусульманчууд хамаарахгүй. Итикафыг зорьсон тохиол-

долд бол сүннэт биш важиб болно. Эд Рамазан бусар сар мацаг барих үед залбирлаар хийдэг итикаф бол мүстэхаб юм.

Итикаф нь абдэст мэтийн шаарлагаас гадна ямар ч шаардлагатай байсан мэсжидээс гарахгүй байхыг шаардана.

Пайгамбар Эзний маань эхнэрүүд өрөөндөө итикаф хийдэг. Эзэн маань түүний эхнэрүүдэд зориулан мэсжидэд барьсан итикафын майхныг буулгасан байв. Ийм учраас ч мусульман эмэгтэйчүүдийн мэсжидэд биш, гэртээ мэсжидэд байгаа мэт тусгай буланд итикаф хийхийг зохимжтой гэж үздэг.

Хазрат-и Аиша -радъяллахү анха- ингэж хэлнэ:

“Рамазан сарын сүүлийн арван хоног эхлэхэд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- шөнийг хүндэтгэж, гэрийнхнээ сэрээж, өөрийгөө залбирал үйлчилгээнд зориулаад, ханиудтайгаа эр эмийн харилцаагаа түр тасалдаг байв.” (Бухарий, Фадлу Лэйлэти’л-Кадр, 5; Мүслим, Итикаф, 7)

Дахиад Аиша эхийн маань мэдүүлснээр Хүндэт Нэбий -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь өөд болтлоо Рамазаны сүүлийн арван хоногт итикаф хийдэг, өөд болсон жилийн Рамазан сард бол итикафад хорь хоносон байв. Түүнийг өөд болсны дараа ч эхнэрүүд нь энэ сүннэтийг үргэлж хийдэг байцгаав.[92]

Энэ байдал нь итикафын хэр их чухал ба эрдэмтэй буйг мэдүүлсэн бөгөөд, нөгөө талаас хувийн ба нийгмийн үүргээ ч мартаж болохгүйг маш сайхан илэрхийлнэ:

Ибн-и Аббас -радъяллахү анх- нэгэн өдөр Мэсжид-и Нэбэдийд итикафад байхад нэгэн түүний дэргэд ороод мэнд хүргэж суув. Ибн-и Аббас:

92. Бухарий, Итикаф, 1, 17; Мүслим, Итикаф, 5.

"– Дүү минь би чамайг маш их ядарсан бас гунигтай байгааг харж байна!" гэв.

"–Тийм ээ, авга ах минь, гунигтай юм! намайг бараагаар төлөх шаардлагаар чөлөөлсөн байв, харин уг булшийн эзэн Аллахын Элчийн эрхээр хэлье, түүнд буй өрөө төлж чадахгүй байна," гэв.

Ибн-и Аббас -радъяллахү анх-:

"–Чиний тухай түүнтэй би ярих уу?" гэхэд нь нөгөө хүн:

"–Чи л мэд !" гэж хариулав. Ибн-и Аббас -радъяллахү анх-гутлаа аваад мэсжидээс гарав. Тэр эр нь түүнд:

"–Итикафад буйгаа мартав уу?" гэж асуув.

Ибн-и Аббас -радъяллахү анх- бол:

"–Үгүй! Би энэ булшид хэвтсэн буй ба Пайгамбар Эзнээс маань ингэж сонслоо (Ибн-и Аббас эдгээрийг хэлэхдээ нүднээс нь нулимс гоожоод байв):

"–Хэн нэгэн шашин нэгт дүүгийнхээ нэгэн ажлыг мөрдөж тэр ажлыг шийдвэл, энэ нь түүний хувьд арван жил итикафад хүлээхээс буянтай юм. Хэн нэгэн Аллахын тааламжийн төлөө нэгэн өдөр итикафад орвол Аугаа Эрх тэр хүний тамын галын хооронд гурван жалга туурвина. Жалга бүрийн хооронд өрнөд дорнын хооронд шиг зайтай юм." (Бэйхакий, *Шуабу'л-Иман,* III, 424-425)

БЭДИРИЙН ТОМ ГАЗВА (Хижрэтийн тооллын 2 оны Рамазан сарын 17 / 624.3.13)

Хижрэтийн хоёр дахь жилд Курайшаас эр эм хүн бүрийн оролцсон, ойролцоогоор 50.000 динарын ачаа бараатай, мянган

тэмээгээр бүрдсэн наймааны том нэгэн жинг, Дамаскын Газа захад илгээсэн байв. Жингийн хамт Маккагийн алдартнаас Эбү Сүфьяан, Мухаммед бин Нэвфэл ба Амр бин Ас зэрэг гуч эсвэл дөчин мүшрик явж байв.

Курайшийн мүшрикчүүд мусульманчуудын хаж хийхэд саад болох санаагаар, Дамаскын наймааны замыг хаах санаатайг мэддэг байв. Ийм учраас Дамаскаас айдастайгаар замд гарав. Эбү Сүфьяан жинд буй Дамдам бин Амрыг хорин мискал алтаар хөлсөлж Тэбүкээс маш яаралтай Макка руу илгээв.[93]

Аллахын Элчийн авга эгч Атикэ нь Дамдамыг Маккад ирэхээс гурван хоногийн өмнө нэгэн зүүд зүүдэлж маш их айв. Дүү Аббастаа:

“–Миний дүү! Харсан зүүд намайг маш их зовоож байна. Ард олонд нэгэн гамшиг тохиохоос айна! Чамд ярих энэ зүүдийг нууц байлга, хэнд ч битгий хэл!” гэв.

Хазрат-и Аббас:

“–Юу зүүдлээ вэ, яриач?” гэв.

Хазрат-и Атикэ:

“–Тэмээ унасан нэгэн эр ирээд Эбтахад (Мухассаб Макка хоёрын хооронд) зогсоод чанга дуугаараа:

«–Еэ урвагчидаа! Гурван өдрийн дараа байлдах тул, та бүхэн ойчих газар амжаарай!» гээд гурван удаа хашхирав. Түүнийг харсан хүмүүс хажууд нь цуглаpав. Тэгээд тэр хүн Мэсжид-и Харамд оров. Ард түмэн ч түүнийг дагаж байв. Хүмүүс түүнийг тойрсон байхад Кабагийн ар талд дахиад тэр чигээр гурван удаа хашхирав. Дараа нь Эбү Күбэйс Уулан дээр

93. Ибн-и Хишам, II, 244; Вакидий, I, 27-28.

гараад тэнд ч ижил юмыг хийв. Дараа нь нэгэн хадыг бариад өнхрүүлэв. Хад нь дээрээс доош өнхөрч уулны ёроолд бутрав. Маккагийн байрнуудаас тэдгээр өөдөснүүд тааралдаагүй гэр ч, орон ч үлдээгүй!” гэв.

Хазрат-и Аббас:

“–Валлахи энэ нь маш чухал зүүд юм! Зүүдээ ерөөсөө хэнд ч битгий ярь!” гэв.

Хазрат-и Аббас нь Хазрат-и Атикэнаас салахдаа анд Вэлид бин Үтбэтэй дайралдав. Түүнд зүүдийг яриад нууц байлгахыг нь хэлэв. Вэлид ч аавдаа дамжуулав. Ингээд зүүд нь Маккад тарав. Курайшчуудын цуглалтад ярихаар болов.

Хазрат-и Аббас ингэж ярина:

“Эбү Жэхил надад:

«–Ее Абдүлмутталибынхан! Таны тэр эмэгтэй бас пайгамбар болж байна уу?! Та эрчүүдийн пайгамбар болоод ханаагүй, эмэгтэйчүүдийн пайгамбартай болмоор байна уу?! Тэгээд Атикэ зүүдэндээ хэн нэгний «Гурван хоногийн дараа харвуулаад ойчих газар амжаарай!» гэснийг сонсчээ. Гурван хоног хүлээцгээе. Хэрэв түүний хэлсэн нь үнэн байвал мэдээж нэгэн юм илрэх нь. Хэрэв гурван хоног өнгөрч ямар нэгэн юм илрэхгүй бол таны тухай нэгэн бичгээр Араб орон даяар таны эмэгтэйчүүдээс худалч нэгэн байгаа мэдээг тараацгаана» гэв.

Би тийм юм болоогүйг хэллээ. Валлахи миний хувьд үүнийг үгүйсгэхээс хүнд үйл болоогүй юм. Атикэгийн зүүдэлсний гурав дахь өдөр өглөөгүүр, алдсан завшаанаа олж үзэхээр маш хилэнтэйгээр Мэсжид-и Харам орлоо. Өмнө нь хэлсэн үгсийн заримыг давтаж Эбү Жэхилийг загнах байлаа. Тэр нь Мэсжид-и Харамын Сэхмийнхний үүднээс ухасхийн гарвал би өөртөө: «Аллах чамайг гэсгээмээр, намайг түүнийг дооромжлоно гэж

айгаад надаас зугтав,» гэлээ. Үнэндээ тэр Дамдамын дууг дуулжээ! Би түүнийг сонсоогүй байлаа. Нэг харвал Дамдам тэмээнийхээ хамрыг зүссэн, тохшийг буруу тавьсан, цамцаа урсан, Маккагийн хөндийн дунд чанга дуугаараа хашхирна:

«–Еэ Курайшчууд аа! Жин! Жин! Мухаммед ба асхаб нь Эбү Сүфьяаны дэргэд жингийн цуваа руу дайрав! Түүнд амжиж туслаарай! Туслаач! Туслаач!» гээд хашхирч байв. Бидэнд тохиолдсон энэ үйл, намайг ч түүнийг ч хэн нэгэнтэй маргалдахаас холдуулав.” (Ибн-и Хишам, II, 244-247; Вакидий, I, 29-31)

Курайшчууд яаралтай бэлтгэв. Бэлтгэлээ хоёр эсвэл гурван хоногт бүтээв. Зэвсэггүйчүүддээ зэвсэг худалдаж авав. Баячууд хүчгүйчүүдэд чадах тусламжаа үзүүлэв. Сүхэйл бин Амр, Зэм’а бин Эсвэд мэтийн агуу хүмүүс:

“–Тэмээ хүссэнд тэмээ, май тэмээ! Идээ хүссэнд идээ, май идээ! Бүгдээрээ байлдахаар гарцгаа! Танаас хэн ч хойно битгий үлд! Хэрэв Мухаммедийн наймааны жинг маань эзэлбэл, тэдэнтэй заавал бидэн дээр дайраад Маккад орно!” гэцгээв.

Дайны аянд хамаг эрчүүл оролцож, оролцоогүйчүүд ч орондоо хүн түрээсэлж илгээв. Бэдирт гарах болсон өдөр, Эбү Жэхил хүмүүст; “Тэмээгээ унацгаа!” тушаалыг олгоход Үмэйе бин Халэф нь Маккагаас гарахыг хүсээгүй. Учир нь тэр харгис мүшрик өөрийгөө мусульманчуудын алахыг Амласандаа Үнэнч буй Аллахын Элчийн мэдээлснийг дуулсан:

“–Валлахи Мухаммед ярихдаа хэзээ ч худал хэлдэггүй!” гээд ширүүн нэгэн айдсанд автсан байв.

Эбү Жэхил ирээд түүнийг өөрийнхөө хамт явахаар ятгатлаа хажуугаас нь салаагүй. Тэр ч яаралтай бэлтгэж аянд гарав.

Үтбэ бин Рэбиа ба дүү нь Шэйбэ дайны багажийг янзалж эхлэхэд тэдний боол Аддас:

“–Юу хийж байцгаана?” гэж асуув.

“–Таиф дахь усан үзмийн багт маань усан үзмээр дайлсан хүнийг мэдэх үү?” гэцгээв.

Аддас -радъяллахү анх-:

“–Тийм, мэднэ!” гэв.

“–Бид яваад Түүнтэй байлдана!” гэцгээв.

Аддас үсэрч тэдний хөлийг бариад:

“–Битгий яв! Андашгүй нь Тэр пайгамбар мөн! Та харвагдаад ойчих газар луу л явна!” гээд уйлаад, нулимс нь хацраар нь урсав. Гэтэл Үтбэ ба Шэйбэ сонсолгүй явав.

Мүшрикчүүдийн тоо есөн зуун тавь эсвэл мянга байв. Нэг эсвэл хоёр зуу нь морьтой, бусад нь тэмээтэй байв. Ихэнх нь хуягтай байв. Курайшийн хамаг томчууд ирсэн байв. Хажуудаа дуучин шивэгчдээ ч дагуулаад, хэнгэрэг цохиулж мусульманчуудыг муудуулах шүлэг хэлүүлж замдаа гарав.[94]

Хижрэтийн хоёр дахь жил, Рамазан сарын арван хоёрон байв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Абдуллах бин Үмм-и Тэктүмийг мөргөл үйлдүүлэхээр Мадинад төлөөлөгчөөр үлдээж, 313 хүнтэй хотоос гарав. Эд нараас 64 нь Мухажир, бусад нь Энсар байв. Гурав нь морьтой, дал нь тэмээтэй, бусад нь ч явган байв.[95]

94. Вакидий, I, 31-39; Бухарий, Мэнакиб, 25; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 294-295.

95. Вакидий, I, 23-24; Ибн-и Хишам, II, 250-251; Ибн-и Са’д, II, 12.

Пайгамбар Эзэн маань Мадинад нэгэн мил зайтай оршдог Буюуту'с-Сукъяд мужахирчуудыг зогсоов. Бага настангуудыг буцаав. Са'д бин Эбий Ваккас -радъяллахү анх- ингэж ярина:

"Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн бага настайчуудыг буцаахаас өмнө би дүү Үмэйрээ өөр байхыг харлаа:

«–Миний дүү, чи яагаа вэ?» гэлээ.

«–Аллахын Элч намайг бага гэж үзээд буцаана гэж айж байна! Гэтэл би энэ аянд явахыг их хүсч Аллахын надад шэхид цол авахыг хүсч байна!» гэв. Үнэхээр миний дүүг Расулаллахад үзүүлэхээр түүнийг маш бага байсныг хараад:

«–Чи буц!» хэмээв. Үмэйр уйлж эхлэв. Тэгэхлээр нь Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- ч зөвшөөрөл олгов. Үмэйрийг бага байсан тул сэлмийг нь би зүүлгэж байв. Бэдирт шэхид болохдоо 16 орчим настай байв." (Вакидий, I, 21; Ибн-и Са'д, III, 149-150)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- асхабынхаа хамт замд гарахад тэмээний тоо хүрэмжгүй байсан тул нэгэн тэмээг ээлжээр гурван хүн унадаг байв. Орчлонгийн Хүндэт Эзэн маань ч тэмээгээ Хазрат-и Али ба Эбү Лүбабэ -радъяллахү анхүмаагийн хамт ээлжээр унаж байв. Алхах ээлж нь Пайгамбар Эзэнд маань таарахад найзууд нь:

"–Аяа Расулаллах аа! Та морд! Бид таны оронд алхана," гэцгээв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- бол:

"–Та алхахад надаас тэвчээртэй биш. Мөн би ч буян олох тухай танаас ялгаатай биш юм," хэмээв. (Ибн-и Са'д, II, 21; Ахмад, I, 422)

Хүндэт Элч Эзэн маань ингэхдээ Аллахад мэдэрсэн уужим хайраа, залбирал ба үйлчилгээгээр Аугаа Эрхэд ойртоход хэр

их сонирхолтой буйгаа заасан байдаг. Мөн түүнчлэн -хэн байсан ч- хүн бүрийн төлөө эрх тэгш болон хуулийг хэт оновчтой дагах хэрэгтэйг сургав.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- хэсэг хугацааны дараа Эбү Лүбабэ -радъяллахү анх-ыг өөртөө төлөөлөхөөр Мадинад буцааж илгээв.[96]

Аллахаас өөр хадгаламж таньсангүй ба хамаг хэрэгцээгээ Тэрээрт илэрхийлсэн Орчлонгийн Хүндэт Эзэн маань Бэдир яваа үммэтээ хүч тэнхээ багатай харахлаараа, тэсэн ядан ингэж залбирав:

“Аллах минь ээ! Эд нар унаагүй, Чи тэдэнд унах мал хайрла! Аллах минь! Эд нар нүцгэн, Чи тэдэнд хувцас өмсгө! Аллах минь! Эд нар өлөн юм, Чи тэднийг цатга!”

Үнэхээр Аллах Таалаг Бэдирт ялалтыг хайрлаж олгохлоор тэдний тус бүр нь нэг эсвэл хоёр тэмээтэйгээр буцаж, хувцас өмсөөд ходоодоо цатгав. (Эбү Давуд, Жихад, 145/2747)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Рамазан сард таарсан ийм хэцүү өдрүүдэд цэрэгт мацгаа эвдэхийг тушаав. Учир нь мусульманчууд дайнд биеэрээ ч хүчтэй болох хэрэгтэй. Тэгээд аянд явсан хамаг итгэгчид, дараа нь нөхөх мацаг бариагүй.

Исламын энэ анхны цэрэг Бэдир лүү урагшлав. Цэрэг нь Акийк Хөндийд хүрсэн байв. Тэр хооронд Хүбэйб бин Есаф ба Кайс бин Мухаррис гэсэн хоёр хүн дайнд оролцоод олзноос хувь авах зорилгоор цэрэгт ирсэн байв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- энэ хоёроос Хүбэйбээс:

“–Та надтай хамт гарав уу?” хэмээн асуув.

96. Ибн-и Хишам, II, 251.

Хүбэйб:

“–Үгүй, Чи бидний охин дүүгийн хөвүүн ба хөрш юм. Бид олзны төлөө ардынхаа хамт дайнд гарав!” гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- энэ удаа:

“–Чи Аллах болон Элчид нь итгэж үнэмшив үү?” хэмээн асуув.

Хүбэйб:

“–Үгүй!” гэж хариулахад нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Тийм бол буцаад яв! Бид мүшрикийн тусламжийг хүсэхгүй!..” хэмээв.

Хүбэйб шахан зүтгэв:

“–Миний ард танд их ашигтай ба дайсныг ялах баатар буйг минь сайн мэднэ. Мусульман болоогүй ч олзны төлөө Чиний дэргэд байлдвал болохгүй юу?” гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Үгүй, чи эхлээд мусуьман бол, дараа нь байлд!” хэмээж замдаа явав.

Хэсэг хугацааны дараа Хүбэйб дахиад ирэв. Дахиад ижил юмыг санал болгов. Гэтэл хариу ч ижил байв. Хүбэйб үүнд маш их гайхав. Учир нь өөрөө Арабчуудын дунд баатар дайнчин гэж алдаршсан байв. Харин Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнийг мүшрик байсны улмаас цэрэгт орохыг нь зөвшөөрөөгүй байв. Мүшрикчүүдийн хүн ихтэй цэргийн өмнө, цөөн цэрэгтэй Расулаллахын ингэсэн нь Хүбэйбийг хэт их гайхуулав. Сэтгэлийнхээ гүнд өмнө нь огт анзаараагүй нэгэн хорвоогийн өнгийг үзэв. Сэтгэл хөөрөөд дахиад Аллахын Элчийн

араас гүйв. Энэ удаагийн санал түрүүнээс өөр байв. Тэгээд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн:

“–Аллах болон Элчид нь итгэж үнэмшив үү, еэ Хүбэйб?” хэмээн асуултад бишрэлтэйгээр хариу өгөв:

“–Итгэсэн аяа Расулаллах!..”

Тэгсэнд нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- их баясч:

“–Одоо хүссэнээ хийж болно!” хэмээн айлдав. (Мүслим, Жихад, 150; Тирмизий, Сиер 10/1558; Вакидий, I, 47; Ибн-и Са’д, III, 535)

Энэ явдал нь шашны зорилтод хүрэхээр, нөхцөл нь хэдий хэцүү байсан ч шашны бус арга хэрэглэж болохгүйн тухай нэгэн хэмжүүр толилуулна. Боол нь хэрэгтэй арга хэмжээгээ авсны дараа Аугаа Эрхэд итгэх бөгөөд Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- ч Хүбэйбийн итгэл үнэмшилгүй цэрэгт орохыг зөвшөөрөлгүй итгэлийн ийм нарийн мэдрэмжийг үзүүлсэн, үммэтдээ ч энэ талаар сайхан нэгэн жишээ бүрдсэн байдаг. Учир нь Тэр агуу Пайгамбар үйл бүртээ зөвхөн Аллахад хоргодож, зөвхөн Тэрээрт чиглэж, хамаг тусламжийг зөвхөн Аугаа Эрхэд буйг мэдээд мэдүүлдэг байв. Оршигчдын Туяа -алэйхиссалатү вэссэлам- ингэснээрээ:

حَسْبُنَا اللّٰهُ وَنِعْمَ الْوَكِيلُ

“…Аллах бидэнд хүрэмжтэй, Тэрээр маш гоё төлөөлөгч мөн!” (Ал-и Имран, 173) гэсэн аетын илэрхийлсэн бууж өгөхийн хамгийн гоё ба амьд жишээг толилуулав.

Хүзэйфэ -радъяллахү анх- ингэж ярина:

“Аав Хүсэйлийнхээ хамт замд гарсан байлаа. Курайшийн кафирчууд биднийг бариад:

«–Та лав Мухаммедын талд орох санаатай,» гэцгээв.

Бид ч:

«–Үгүй, Мадинад ийм учиртай биш, өөр нэгэн ажлын төлөө явна,» гэцгээлээ. Тэгэхлээр биднээс Аллахын Элчийн талд ороод Түүний хамт байлдахгүйн төлөө Аллахын нэрээр ам авцгаав. Мадинад ирээд үүнийг Расулаллахад мэдүүлэхээр Орчлонгуудын Хаан Эзэн маань:

«–Одоо явцгаа. Бид таны өгсөн амлалыг хадгалж, тэдний эсрэг ч Аллахаас тусламж гуйна!» хэмээв. Миний Бэдирийн Дайнд оролцоогүйн учир нь ийм юм.” (Мүслим, Жихад, 98)

Энэ явдал нь Хүндэт Элч Эзний маань дайснаа ч хүндэлсэн үнэнч сэтгэлийнх нь хамгийн гоё жишээний нэгэн юм.

Бэдирийн Дайнд эмэгтэйчүүдээс ч оролцмоор байгсад байлаа. Эд нараас нэгэн асан Үммү Варака нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д гүйгээд:

“–Аяа Аллахын Элч ээ! Надад зөвшөөрөл өгөөч, би шар-хтнуудыг асарч, өвчтөнүүдийг сахина. Магадгүй Аллах надад ч шэхид болохыг хайрлана!” гэсэн байв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч түүнд:

“–Чи гэртээ сууж Кур’ан унш; Аллах чамд заавал шэхид болохыг заяаж хайрлана!” хэмээв.

Үүнээс хойш Үммү Варака -радъяллахү анха- нь асхабын дунд “Шэхидэ” гэсэн нэрээр алдаршив. Шэхид болохыг маш

их хүсдэг байв. Эцэст нь Хазрат-и Умарын эринээр үйлчлэгчид нь дээр нь хилэн дэвсэж түүнийг шэхид болгов. Үүнийг мэдсэн Хазрат-и Умар -радъяллаху анх-:

"–Аллах ба Элч нь зөв хэлжээ!" гэж гэмт хэрэгтнүүдийг олоод яллав. (Эбү Давуд, Салат, 61/591; Ибн-и Хажар, *эл-Исаба,* IV, 505)

Эбү Сүфьяан мусульманчуудын Бэдирт зорьсныг ойлгонгуутаа жингийн чиглэлийг эргүүлэв. Бэдирийг зүүн гар талдаа аваад тэнгисийн эргийн тийш хурдлав.[97] Наймааны жинг аврахлаараа Курайшийн цэрэгт хүн илгээж:

"–Та жингээ, ажилчдаа ба ачаа бараагаа хамгаалахаар замд гарсан байв. Ингээд Аллах тэднийг аврав. Одоо хариарай!" гэв.

Эбү Сүфьяаны мэдээгээр Ахнэс бин Шэрикийн зөвөлгөөгөөр түүний ард Күхрэгийнхэн ба Адийй бин Ка'бынхан харьцгаав. Эбү Жэхил:

"–Бид Бэдирт хүрэлгүйгээр харихгүй! Бид тэнд гурав хононо. Тэмээ төхөөрч, идэж ууна. Эмэгтэйчүүд бүжиглэж дуу дуулна. Ойр хавийн Арабчууд биднийг дуудаж, түүний дараа байнга биднээс айх болно! Явцгаая!" гэв.

Эбү Сүфьяан нь Курайшийн цэрэг Эбү Жэхилийг даган хариагүйг нь сонсохлоор:

"–Хайран ард минь! Энэ нь Амр бин Хишамын (Эбү Жэхилийн) ажил бололтой! Харихгүй догшроод хүмүүсийн тэргүүн болохыг хүссэн юм! Догширсон нь бол дутагдал ба азгүйдэл юм!" гэв. (Вакидий, I, 43-45; Ибн-и Хишам, II, 258)

97. Ибн-и Хишам, II, 57.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- явдлыг алхам алхмаар нь мөрдөж байсан тул, одоо зайлшгүй үхэх сэхэхийн дайнтай тааралдсанаа ойлгож асхабаа цуглуулан асуув:

“–Таны бодлоор жинг дагасан нь дээр үү, Курайшийн цэрэгтэй уулзсан нь дээр үү?”

Мухажирчуудыг төлөөлөн Хазрат-и Эбү Бэкир ба Хазрат-и Умар -радъяллахү анхүмаа- босоод Курайшийн цэрэгтэй уулзахдаа бэлэн буйгаа илэрхийлэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Энсарын бодлыг ч мэдэх юмсан. Тэгэхэд нь Энсараас Микдад бин Эсвэд -радъяллахү анх- босоод ийм үг хэлэв:

“–Аяа Аллахын Элч ээ! Бид нар еврейчүүдийн Хазрат-и Мусад хэлсэн шиг **«Чи ба Раб чинь очоод байлдацгаа!»** (эл-Маида, 24) гэхгүй. Бид нар Чамд Акабад ам өгсөндөө үнэнч хандаж Чиний баруун, зүүн талд, өмнө ба ард дайсантай эцсээ хүртэл байлдахад байнга бэлэн байна!..”[98] (Бухарий, Мэгазий, 4; Тэфсир, 5/4)

Хазрат-и Микдадын дараа Са’д бин Муаз -радъяллахү анх- босов:

“–Аяа Аллахын Элч ээ! Бид нар Чамд итгэлээ. Чиний авчирсан Кур’ан үнэн гэдгийг гэрчиллээ. Дураараа бай! Хэрэв Чи тэнгист живбэл, бид ч Чинйи хамт живнэ. Энсараас ганцхан хүн ч буцахгүй!”

---

98. Ибн-и Мэс’үд -радъяллахү анх- ингэж хэлнэ:
“Микдат бин Эсвэдийн нэг бат үг хэлснийг би сонссон. Тэр үгийг хэлсэн байх нь надад (буяны талаар) түүнтэй тэнцэх хамаг үнэт үгсээс илүү энхрий санагдана…” (Бухарий, Мэгазий, 4; Тэфсир, 5/4)

Ийм үнэнч ба бууж өгөлтөөр дүүрэн үгсийн дараа Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ариун царай нь мишээлээр дүүрч, буянт залбирал хэлээд ингэж айлдав:

“–Тийм байвал Аллахын зүг алхацгаа! Танд сайхан мэдээлэл болог, Аллах хоёр талаас нэгэнд нь ялалтыг амлав.[99] *Валлахи би, бараг Курайшчуудын дайны талбайд мөхөх газрыг харах юм шиг...”* (Муслим, Жихад, 83; Вакидий, I, 48-49; Ибн-и Хишам, II, 253-254)

Исламын цэргийн Бэдирт ирсэнд, Курайшийн цэрэг түрүүлэн ирээд элсэн давааны ард Ельл Хөндийн Мадинад хамгийн хол талд нь буусан байв. Усны худаг бол хөндийн Мадинад хамгийн ойрхон талд байлаа.[100]

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- мүжахидчуудын хамт Бэдирт хамгийн ойр байсан усан дээр ирэхдээ, удирдах төвийг тогтох тухай Энсартай зөвлөлцөв. Хубаб бин Мүнзир -радъяллахү анх-:

“–Аяа Расулаллах аа! Энд нь удирдах төвд зохимжтой биш. Курайшчуудад хамгийн ойр буй усан дээр очоод тэнд бууцгаая. Дээр нь буусан уснаас гадна бүгд худгийг хаацгаая. Тэр усан дээр нэгэн сан хийгээд дотрыг нь усаар дүүргэе,” гэв.

Орчлонгуудын Эзэн энэ саналыг зөвшөөрөв.[101] (Ибн-и Хишам, II, 259-260; Ибн-и Са’д, II, 15)

---

99. Энфал Сурад амласан хоёр хамт олноос нэг нь Курайш өөрөө буюу тэднийг хожигдож боолчлох нь бөгөөд нөгөөх нь бол Курайшийн Дамаскаас ирэх наймааны том жин юм.

100. Ибн-и Хишам, II, 259.

101. Бэдирийн оршин суугчдын ярьснаар Бэдирт буй элсний бусад даваанууд таваас арван жилд нэг байраа сольдог болович Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хуарангаа барьсан элсний даваа нь тогтмол байж, байраа сольдоггүй юм.

Хаким бин Хизамын хамт зарим мүшрикчүүд мусульманчуудын усан сангаас ус уухаар ирцгээв. Мусульманчуудыг тэдэнд саад болоход нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Уухад нь саад болуузай!” хэмээв. Тэд ирээд ууцгаав. Хакимаас бусад ус уугсад бүгд Бэдирт алагдав. Хаким дараа нь мусульман болов. Хаким хэлэх үгээ тангараглан хүч нэмэхдээ:

“–Намайг Бэдирт алагдахаас аварч иманы ивээл хүртээсэн Аллахад тангараглая!” гэдэг байв. (Ибн-и Хишам, II, 261)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- их удахгүй байлдах дайсандаа ус уухад зөвшөөрөл олгож бидэнд ч хүн чанарын сайхан үлгэр жишээг үзүүлэв. Учир нь ийм хүндэтгэлтэй хандлага нь харгис хатуу зүрхийг зөөлрүүлж, дараа нь тэр зүрхэнд авралын гэрэл асах шалтгаан болсон байдаг.

Исламын цэрэг удирдах төвд суурьшсаны дараа Са’д бин Муаз Хазрат:

“–Аяа Аллахын Элч ээ! Бид Чамд нэгэн сүүдрэвч хийцгээе. Хүлгийг чинь ч хажууд нь байлгая. Тэгээд бид дайсантай байлдана. Хэрэв Аллах хүч өгөөд ялалт хайрлавал маш сайн! Эс тэгвээс Чи морио унаад хойно үлдээсэн дүү нарын маань дэргэд оч! Аяа Аллахын Пайгамбар аа! Тэд ч Чамд бидэн чинээ их хайртай. Хэрэв Чамайг дайнд орохыг мэдсэнсэн бол ерөөсөө хойно үлдэхгүй байв. Аллах Чамайг тэднийг хамгаал. Тэд Чамд чин сэтгэлээрээ холбоотой бөгөөд Чиний дэргэд жихад болно,” гэв.

Пайгамбар Эзэн маань Хазрат-и Са’дыг магтаж түүний төлөө буянтай залбирав. Са’д -радъяллахү анх- илдээ сугалж сүүдрэвчийн үүдэнд манав. (Ибн-и Хишам, II, 260; Вакидий, I, 49)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хазрат-и Умар -радъяллахү анх-ыг сүүлийн удаа ч Курайшчуудад илгээж:

“–Буцаад явцгаа! Танаас бусадтай байлдах нь надад тантай байлдахаас илүү санагдана!” хэмээв.

Хаким бин Хизам:

“–Энэ нь энэрэлтэй нэгэн санал юм! Даруй хүлээж аваарай! Валлахи үүнээс хойш танд хэн ч энэрэлтэй хандахгүй!” гэв.

Эбү Жэхил бол:

“–Тангараглая, Аллах[102] бидэнд завшаан олгосны дараа өшөөгөө авахгүйгээр буцаж явахгүй! Тэдэнд хязгаарыг нь мэдүүлээд, тэд үүнээс хойш харуул ч гаргаж чадахгүй, манай жинг ч дагаж чадахгүй!” гээд мүшрикчүүдийг дайнд урамшуулав. (Вакидий, I, 61-65)

Курайш нь Үмэйр бин Вэхб ба морьтонгуудаас Эбү Үсамэг Исламын цэргийг хянуулахаар илгээв. Исламын цэргийг тойрч явсан энэ хоёр хянагч үүнийг мэдэв:

“Валлахи бид олон тэмээ, адууны, тоогоороо илүү цэргийн хүч эсвэл илүү хүч бэлтгэл ч хараагүй! Харин бидний харсан хамт олон нь гэртээ харихыг биш, үхэхийг хүснэ! Сэлмээсээ гадна өөрсдийгөө хамгаалах багаж ямар нэгэнд хоргодох аргагүй!” (Вакидий, I, 62)

102. Исламаас өмнө мунхаглалын Арабчууд Аллах бий гэдгийг хүлээн зөвшөөрдөг байв. Гэтэл тэд Аллахын дэргэд бусад бурхадыг ч шүтдэг байсан улмаас тэвхидийн шүтлэгээс гарсан, мүшрик болцгоов. Ийм учраас энэ жишээнд байсан шигээ Аллахын нэрийг дурдаж Тэрээрийн агуу бэлгийг илэрхийлэх үгс хэрэглэдэг байцгаав. Тэдний мүшрик болсны учир нь Аллахад дөхөх, Аллахын онгонд туслагч олох эсвэл өөрөө нэр алдар олох зорилгоор хэтрүүлж баримлыг шүтсэн нь байв. (Хар. эл-Анкэбут, 61; эз-Зүмэр, 3)

Хазрат-и Умар -радъяллахү анх- ингэж хэлнэ:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Бэдирт орой болоход:

«–Тэнд бурхан өршөөг, маргааш түүний харвуулж унах газар юм!» гэж мүшрикчүүдийг тэргүүлэгчдийн алагдах газрыг нэг нэгээр үзүүлэв. Түүнийг үнэн пайгамбар болгож илгээсэн Аллахад тангараглая, тэднээс хэн ч Аллахын Элчийн заасан хилийг давж чадаагүй. Дараа нь тэднийг нэгэн худагт овоолон хаяв.” (Мүслим, Жэннэт 76, Жихад 83)

Мусульманчуудын Бэдир дэх удирдах төв нь элст газар байсан тул алхахад амар байгаагүй. Мөн бэлэн ус багассан учраас ус ховордож бэрхшээлтэй болж байв. Абдэст ба гүсүлд хүрэмжтэй ус олддоггүй байв. Чөтгөр ч үүнийг мэдээд мүшрикчүүдийн олон ба хүчтэй болсны улмаас итгэгчдийн зүрхэнд аймшиг оруулахыг хичээж байв.

Тэр шөнө Аллах Таала бороо оруулав. Хөндийд үер урсав. Мусульманчууд сав суулгаа дүүргэж, абдэст гүсүл аваад, малаа услав. Орсон бороо мөн тоосыг гийлгэж шалыг бэхжүүлэв. Курайш болон мүшрикчүүд бороонoос болж газраа орхиогүй, хөдөлгөөнгүйгээр байж байв. Түүнчлэн Аллах Таала тайвны олгогч, тайтгаруулагч нойрмог байдал хайрлаж өгөв.[103]

Аугаа Эрх энэ тухай ингэж айлдана:

إِذْ يُغَشِّيكُمُ النُّعَاسَ أَمَنَةً مِّنْهُ وَيُنَزِّلُ عَلَيْكُم مِّن السَّمَاء مَاء
لِّيُطَهِّرَكُم بِهِ وَيُذْهِبَ عَنكُمْ رِجْزَ الشَّيْطَانِ وَلِيَرْبِطَ
عَلَى قُلُوبِكُمْ وَيُثَبِّتَ بِهِ الأَقْدَام

103. Табэрий, *Тэфсир,* IX, 256-261.

“Аллах өөрийн онгоноос аюулгүйн тэмдэг болох таныг хөнгөн нэгэн нойрт автуулсан байв. Бид таныг ариутгах, таныг чөтгөрийн хорлолоос холдуулах, зүрхийг тань бэхжүүлэх ба тэвчээрийг тань ихэсгэх тулд тэнгэрээс танд ус буулгасан байв.” (эл-Энфал, 11)

Пайгамбар Эзэн маань бол шөнөжингөө мөргөл үйлдэж Аллахад залбирав. Энэ тухай Хазрат-и Али -кэррэмаллаху вэжхэх- ингэж хэлнэ:

“Би маш сайн мэднэ, Бэдирийн өдөр Аллахын Элчээс гадна бид бүхэн унтсан байлаа. Хүндэт Элч Эзэн маань өглөө хүртэл нэгэн модон доор мөргөл үйлдэж уйлж байв.” (Ибн-и Хүзэймэ, II, 52)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- үүр цайхад ч:

“Аяа Аллахыг боолчууд аа! Мөргөлдөө!” хэмээн дуудаад өглөөний мөргөлийг үйлдүүлж мусульманчуудыг жихадад урамшуулав. (Ахмад, I, 117)

Курайшийн мүшрикчүүд мусульманчуудын өөдөөс гарахаас өмнө Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- гар дахь сумаараа мүжахидчуудыг, *“Нааш ир, цааш яв!”* мэтийн зааварчилан эгнээнд оруулсны дараа тоолуулав. Энэ хооронд эгнээнээс урагш гарсан Сэвад бин Газийг гэдрэг түлхэж:

“–Сэвад аа! Эгнээндээ!” хэмээв. Сэвад бол:

“–Аяа Расулаллах аа, ёо ёо! Аллах Чамайг үнэнээр илгээв. Хариугаа нэхье!” гэв. Пайгамбар Эзэн маань хэвлээ нээв. Энсар:

“–Сэвад аа! Тэр нь Аллахын Элч юм!” гэцгээв. Сэвад:

“– Бид бүгд адил тэгш эрхтэй!” гэв. Аллахын Элч:

“–За, хар!” хэмээв.

Сэвад тонгойн Оршигчдын Туяаны хэвлийг үнсэв.

Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Сэвад аа! Яагаад ингээ вэ?” хэмээн асуув. Сэвад:

“–Таны ч харснаар бид дайнд бэлэн байна! Би сүүлийн мөчид Чамтай нэгэн дурсгалтай болохыг хүслээ!” гэв. Тэгсэнд нь Орчлонгуудын Эзэн түүний төлөө буянт залбирал хийв. (Ибн-и Хишам, II, 266-267; Ибн-и Са’д, II, 15-16)

Хоёр талын цэрэг Рамазан сарын 17нд нэгэн Баасан гариг Бэдирийн талбайд өөд өөдөөсөө харан эгнээнд оров. Хэт халуун өдөр байв. Тэр үе хүртэл Арабчууд байнга угсаа, ураг ба садан хамаатантай холбоотой байлддаг байв. Одоо бол үндэстний байрыг шашин эзэлсэн байв. Шашинд харьяалагдах мэдрэмж нь Арабчуудад маш хүчтэй байсан садан хамаатны харилцааг дийлсэн байв. Тэгээд одоо аав, авга ах, нагац ах, хүү, дүү мэтийн ойр хамаатнууд ч өөр өөр талд орсон байцгаав. Тэр өдөр Хазрат-и Эбү Бэкир хөвүүнтэйгээ; Эбү Үбэйдэ бин Жэррах аавтайгаа; Хазрат-и Хамза дүүтэйгээ байлдав. Маш том сургамж болов.

Аллах Таала айлдана:

قَدْ كَانَ لَكُمْ آيَةٌ فِي فِئَتَيْنِ الْتَقَتَا فِئَةٌ تُقَاتِلُ فِي سَبِيلِ اللهِ وَأُخْرَى
كَافِرَةٌ يَرَوْنَهُم مِّثْلَيْهِمْ رَأْيَ الْعَيْنِ وَاللهُ يُؤَيِّدُ بِنَصْرِهِ مَن يَشَاء
إِنَّ فِي ذَلِكَ لَعِبْرَةً لَّأُوْلِي الأَبْصَار

“Бэдирт өөд өөдөөсөө тулсан тэр хоёр талын байдал бидэнд нэгэн том сургаал болсон. Нэг нь Аллахын замд байлдсан хамт олон, нөгөө нь бол тэднийг илээр өөрсдийнхөө

хоёр дахин харсан кафир хамт олон. Аллах хүссэнээ тусламжтайгаараа түшнэ. Мэдээж үүнд ухаантай хүмүүст том нэгэн сургаал байдаг.” (Ал-и Имран, 13)

Дайны талбайд ихэмсэг зангаараа ирсэн мүшрикчүүд сагсуурч, өөрсдийгөө ялагдашгүй хэмээн бодож байцгаав. Аллах Таала нь мүшрикчүүдийн энэ байдлыг ает-и кэримэчүүдэд ингэж мэдүүлнэ:

وَلاَ تَكُونُواْ كَالَّذِينَ خَرَجُواْ مِن دِيَارِهِم بَطَرًا وَرِئَاء النَّاسِ وَيَصُدُّونَ عَن سَبِيلِ اللّهِ وَاللّهُ بِمَا يَعْمَلُونَ مُحِيطٌ وَإِذْ زَيَّنَ لَهُمُ الشَّيْطَانُ أَعْمَالَهُمْ وَقَالَ لاَ غَالِبَ لَكُمُ الْيَوْمَ مِنَ النَّاسِ وَإِنِّي جَارٌ لَّكُمْ فَلَمَّا تَرَاءتِ الْفِئَتَانِ نَكَصَ عَلَى عَقِبَيْهِ وَقَالَ إِنِّي بَرِيءٌ مِّنكُمْ إِنِّي أَرَى مَا لاَ تَرَوْنَ إِنِّيَ أَخَافُ اللّهَ وَاللّهُ شَدِيدُ الْعِقَابِ

“Чамирхах, хүмүүст маяг гарган нүд хуурах ба хүмүүсийг **Аллахын замаас холдуулахын төлөө нутгаасаа гаргасад шиг хандуузай! Аллах тэдний үйлсийг бүрэн бүсэлсэн байдаг** бүх талаар нь мэддэг. **Чөтгөр тэдэнд тэдний үйлсийг сайхан үзүүлээд: «Өнөөдөр хүн төрөлхтнөөс таныг ялах хэн ч үгүй.** Битгий айцгаа! **Андашгүй нь би ч таны туслагч юм,» гэв. Харин хоёр талыг өөд өөдөөс нь байхад харахдаа хойшоо эргэж: «Би танаас хол юм! Би таны хараагүй** мэлэкчүүдийг **харах ба Аллахаас айна. Аллахын тамлал нь ширүүн байдаг,» гэв.”** (эл-Энфал, 47-48)

Тэдний сүр хүчийг ч тэнгэрлэг шийдвэр агуу хүчээрээ мөхөөв:

إِذْ تَسْتَغِيثُونَ رَبَّكُمْ فَاسْتَجَابَ لَكُمْ أَنِّي مُمِدُّكُم بِأَلْفٍ مِّنَ
الْمَلآئِكَةِ مُرْدِفِينَ وَمَا جَعَلَهُ اللّهُ إِلاَّ بُشْرَى وَلِتَطْمَئِنَّ بِهِ
قُلُوبُكُمْ وَمَا النَّصْرُ إِلاَّ مِنْ عِندِ اللّهِ إِنَّ اللّهَ عَزِيزٌ حَكِيمٌ

“Андашгүй нь үгүйсгэгчид бараагаа, Аллахын замаас холдуулахаар зарцуулдаг. Илүүг нь зарцуулна. Гэтэл эцэст нь энэ нь тэдэнд зүрхний өвчин болох ба эцэст нь тэд ялагдана. Кафирчуудын хамт албадсан хүмүүс тамд унана.” (эл-Энфал, 36)



Мэлэкүүдийн Тусламж

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- мүшрикчүүд рүү харав; тэд мянга орчим байв. Асхаб нь бол гурван зуун

арван гурвуулаа байв.[104] Шууд кибла руу чиглэж хоёр гараа өргөв. Рабдаа чимээтэйгээр ингэж залбирч эхлэв:

“Аяа Аллах минь ээ! Надад амласнаа биелүүл! Надад ялалтыг хайрла! Аяа Аллах минь! Хэрэв Исламын энэ нийгмийг мөхөөвөл, дэлхий даяар Чиний боол өөр хэн ч үлдэхгүй!”

Пайгамбар Эзэн маань гараа тэнгэр өөд дэлгэж маш удаан залбирсан тул, нөмрөг нь мөрнөөс нь унав. Үүнийг харсан Эбү Бэкир -радъяллахү анх- хажууд нь ирээд нөмрөгийг нь дахин нөмөргөөд:

“–Аяа Аллахын Элч ээ! Рабдаа залбирсан чинь хангалттай. Аллах Таала Чамд амласнаа заавал хэрэгжүүлнэ,” гэв.

Итгэгч сэтгэлтэй хүн бүр залбираад байв. Аллахын бэлэг тэнгэрлэг үг нь ингэж зарлав:

إِذْ تَسْتَغِيثُونَ رَبَّكُمْ فَاسْتَجَابَ لَكُمْ أَنِّي مُمِدُّكُم بِأَلْفٍ مِّنَ
الْمَلآئِكَةِ مُرْدِفِينَ وَمَا جَعَلَهُ اللّهُ إِلاَّ بُشْرَى وَلِتَطْمَئِنَّ بِهِ
قُلُوبُكُمْ وَمَا النَّصْرُ إِلاَّ مِنْ عِندِ اللّهِ إِنَّ اللّهَ عَزِيزٌ حَكِيمٌ

“Та нар Раббаасаа тусламж гуй, Тэрээр ч; «Андашгүй нь Би танд мэлэкчүүдээс дараалуулан мянга мянгаар нь илгээж **тусална,» таны залбирлыг хүлээн авна Аллах үүнийг зөвхөн сайхан мэдээ болоод таныг сэтгэлийг тайт-гаруулахаар ингэж хийив. Угаасаа тусламж зөвхөн Аллахаас**

104. Бэра -радъяллахү анх- ингэж хэлэв:
“Бид, Мухаммед -алэйхиссэлам-ын асхаб нь хоорондоо Бэдирийн Асхабын тоог Талутын хамт мөрнийг гатлагчдын тоотой тэнцүү буюу гурван зуун арван гурав буйг ярьдаг байв.” (Бухарий, Мэгазий, 6; Тирмизий, Сиер, 38/1598)

л ирдэг . Учир нь Аллах байнгын ялагч, ганц шийдвэрлэгч ба эрдэм чадлын эзэн мөн.” (эл-Энфал, 9-10)

وَلَقَدْ نَصَرَكُمُ اللهُ بِبَدْرٍ وَأَنتُمْ أَذِلَّةٌ فَاتَّقُواْ اللهَ لَعَلَّكُمْ تَشْكُرُونَ
إِذْ تَقُولُ لِلْمُؤْمِنِينَ أَلَن يَكْفِيكُمْ أَن يُمِدَّكُمْ رَبُّكُم بِثَلاَثَةِ آلاَفٍ
مِّنَ الْمَلآئِكَةِ مُنزَلِين بَلَى إِن تَصْبِرُواْ وَتَتَّقُواْ وَيَأْتُوكُم مِّن فَوْرِهِمْ
هَذَا يُمْدِدْكُمْ رَبُّكُم بِخَمْسَةِ آلافٍ مِّنَ الْمَلآئِكَةِ مُسَوِّمِي

“Тангараглая, та нарыг хүчгүй байхад Аллах танд Бэдирт тусалсан байв. Аллахаас болгоомжил, тэгээд Тэрээрт талархсан байх болно. Тэгээд Чи итгэгчдэд; «Раб тань буулгасан гурван мянган мэлэкийн хамт тусалсан нь танд хүрэмжгүй юү?» гэж байв. Тийм, тэвчээд (Аллахаас) **айвал, тэд гэнэтхэн таны дээр дайрсан ч, танай Раб танд тэмдэгт гурван мянган мэлэктэйгээр тусална.”** (Ал-и Имран, 123-125)

Аллах -жэллэ жэлалүхү- тэр өдөр итгэгчдэд мэлэкүүд туслав.[105] Итгэгчдийн чин сэтгэлийн дагуу мэлэкчүүдийн тоог мянга, гурван мянга, тэгээд таван мянга хүртэл нэмэв.

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- өмнө нь мүшрикчүүдийн тэргүүлэгчдээс хэнийг хаана алагдахыг мэдүүлсэн ч ба Аллахын тэдэнд ялалт хайрлахыг тэнгэрлэг бэлгээр мэдсэн боловч, шөнө өглөө болтол өөрийгөө эцэж ядартал Аллахад залбирсан байв. Энэ байдал нь Аллахын боол гэдгээ ухаарсан чухал илрэлийн нэгэн юм. Аллах Таала ч биднээс боолчлолоос өөр юм нэхдэггүй. Аллахад ойртохын тулд өөрийгөө даран Тэрээрт залбирах чинээ бат өөр зам байдаг үгүй.

105. Бухарий, Мэгазий, 4, 6; Мүслим, Жихад, 58.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Бэдирийн өдөрт:

“Жэбраил энд! Морьтойгоо, зэр зэвсэгтэйгээ бидэнд туслахаар иржээ!” хэмээв. (Бухарий, Мэгазий, 11)

Хувайтиб бин Абдүлузза ингэж хэлнэ:

“Би Бэдирт мүшрикчүүдийн хамт байхдаа болсон, сургаалтай олон юм гэрчилсэн ба мэлэкчүүдийн харсан билээ. Тэд тэнгэр газар хоёрын хооронд Курайшчуудыг алж, баривчилж байв. Тэгэхэд би өөртөө «Энэ хүнийг Пайгамбар Эзнийг маань мэдэж Аллах хамгаалдаг!» гэлээ. Харсан юмыг хэнд ч яриагүй.” (Хаким, III, 562/6084)

Эбү Давуд эл-Мазиний ингэж хэлнэ:

“Бэдирийн өдөрт мүшрикчүүдээс нэгийг алахаар дагаж явлаа. Сэлмээрээ нэгнийг арай цавчаагүй байтал толгойг газар унасныг харлаа! Түүнийг надаас өөр мэлэк хийснийг ойлголоо!” (Ахмад, V, 450)

Энэс -радъяллахү анх-ын мэдүүлснээр мүшрикчүүдийг дөхөхөд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Тэнгэр газрын хооронд үргэлжлэн байгаа өргөн диваажинд орохоор босцгоо!” хэмээв. Энсараас Үмэйр бин Хүмам -радъяллахү анх-:

“–Аяа Расулаллах аа! Тийм өргөн тэнгэр газар хооронд диваажин байна уу?” гэж асуув. Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-:

“–Тийм,” хэмээв. Үмэйр:

“–Ямар сайхан юм бэ!” гэв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Яагаад тэгж хэлээ вэ?” хэмээн асуув. Үмэйр -радъяллахү анх-:

“–Аллахад тангараглая, аяа Расулаллах аа, диваажингийн хүмүүсийн нэг болмоор буйдаа тэгж хэлсэн, өөр зорилго үгүй,” гэв. Хүндэт Элч Эзэн маань:

“–Мэдээж чи диваажингийнх,” хэмээв.

Үмэйр ийм үгсийг сонсоод уутнаасаа хэдэн хасарваана гаргаж идэж эхлэв. Дараа нь:

“–Хэрэв энэ хасарвааныг идэж дуустал амьдарвал үнэхээр урт удаан нэгэн амьдрал юм,” гээд хасарвааныг хаяад жихадад гүйв. Дараа нь шэхид болтлоо мүшрикчүүдтэй байлдав. (Мүслим, Имарэ, 145; Ахмад, III, 137)

Бэдирийн байлдаан халз тулалдаанаар эхлэв. Мусульманчуудын гаргасан эрчүүд асан Хазрат-и Хамза, Хазрат-и Али ба Хазрат-и Үбэйдэ өрсөлдөгчдөө ялав. Гэтэл Үбэйдэ -радъяллахү анх- хөлөө тасартал тулалдаад харьсан тул, их удахгүй Аллахын Элчийн:

“–Чи тэр агуу оронд хүрнэ!” гэхийг сонсоод шэхид болов. (Вакидий, I, 69-70)

Үүний дараа хоёр талын цэрэг аажим аажмаар нэг нэгэндээ дөхөж эхлэв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- асхабынхаа гэнэтхэн дайрахыг зөвшөөрөхгүй. Учир нь Курайшийн мүшрикчүүдийн дунд чөтгөрийн аюулыг давсан тул байдахыг хүсдэггүй хүмүүс ч байв. Мусульманчуудын шууд дайраагүй байхад, тэдний энэ дургүй байдал бүр ихэсч, мүшрикчүүдийн байлдах шийдвэрийг донсолгож эргэлзээтэй

болгож байв. Анхны халз тулалдаанд гарсан дайчид хожигдсон нь тэднийг нэлээд түгшээсэн байв. Харин хараалт Эбү Жэхил нь хамаг хилэнтэйгээр хашхираад:

"–Ганц нэг хүн үхэх юу ч биш урагшаа дайраад!" гэж байв. (Вакидий, I, 71)

Тэгээд мүшрикчүүд ч довтолж эхлэв. Мусульманчуудын дундаас Эрхийн онгонд хүрэхийн сайхан ерөөлүүд, үгүйсгэгчдийн дундаас аймшигтай орилоон "Тэкбир ба Аллахын нэрийг дурдсан" дуу нь огт зогсохгүй үргэлжилж шүтлэг бишрэлтэй Аллахад итгэлтэй зүрх сэтгэлтнүүдийг улам бүр хөөрүүлж байв.

Эцэст нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч довтлох тушаал өгөв. Хоёр талын цэрэг халз тулан нэвтрэв. Тулалдаан ширүүн эхлэв. Цааш үргэлжлэн бүр ширүүсэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Аугаа Эрхэд хоргодоод асхабынхаа итгэлийг ихэсгэхээр тэдний дунд ийш тийш гүйж олон удаа:

سَيُهْزَمُ الْجَمْعُ وَ يُوَلُّونَ الدُّبُرَ

"Тэд нар удахгүй мөхөж буцаж зугтана!" (эл-Камэр, 45) гэсэн ает-и кэримэг уншаад байв. Араас нь сайхан мэдээ олгож:

"–Хэн нэгэн өнөөдөр ямагт урагшлан довтолсоор шэхид болбол, Аугаа Эрх түүнийг заавал диваажиндаа оруулна. Өнөөдөр шэхид бологчдод Жэннэтү'л-Фирдэвс нь бэлэн юм. Урагшаа дайраад! Гэж уриалж байв" (Ибн-и Хишам, II, 267-268)

Үүний дараа хажууд нь байсан Эбү Бэкир -радъяллахү анх- руу эргэн:

“–Сайхан сайхан. Жэбраил ба мэлэкчүүд туслахаар амжиж ирэв,” хэмээв.

Газраас нэгэн жижиг чулуу барьж аваад; *«Царай нь хар болог!»* хэмээж дайсан руу шидэв.[106] Тэр мөчид дайсны тийш ширүүн нэгэн хар салхи гарав. Айхтар шуураад; бие биеэ харахааргүй болов.

Бэдирийн Арслангууд

Хазрат-и Али -радъяллахү анх- ингэж хэлэв:

“Бид Бэдирт Аллахын Элчид хоргодож байлаа. Тэр өдөр өөрөө бидний дундаас дайсанд хамгийн ойртсон, хүмүүсээс хамгийн зоригтой нь байв.” (Ахмад, I, 86)

Хүндэт Элчийн зоригийн тухай Бэра -радъяллахү анх- ч:

“Валлахи дайныг нэг ширүүсвэл бид Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д хоргодож байлаа. Бидний хамгийн зоригт маань Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- байж чадсан нь юм,” гэлээ. (Мүслим, Жихад, 79)

Асхаб-и кирам нь уг газвад маш том өгөөмөр ба баатарлаг зан гаргав. Ялангуяа Аллахын Арслан Хазрат-и Хамза -радъяллахү анх- том нэгэн тэсвэр ба байлдагчийн үлгэр жишээ толилуулав. Тэгээд мүшрикчүүдийн алдартнуудаас Үмэйе бин Халэф нь асхабаас Абдуррахман бин Авфаас:

“–Дайнд цээжиндээ тэмдэг болгож тэмээн хяруулын жигүүр зүүсэн хүн хэн билээ?” гэж асуужээ.

“–Тэр нь Хамза бин Абдулмутталиб юм!” гэсэн хариулахад:

106. Ибн-и Хишам, II, 267.

“–Бидэнд юу хийсэн бол тэр л хийлээ!” гэсэн байв. (Ибн-и Хишам, II, 272)

Хазрат-и Али -радъяллахү анх- ч авга ах Хамза шигээ баатарлаг тэмцэж мүшрикчүүдийн толгойг цавчиж унагаасан байв.[107]

Эбү Жэхил морин дээрээс рэжэз[108] уншиж өөрийнхөө ямар ч дайнд гавьяа байгуулах боломжтойг дурдаж :

“Ээж намайг ийм ажилд зориулан төрүүлсэн!” гээд бахархаж байв. (Ибн-и Хишам, II, 275)

Абдуррахман бин Авф -радъяллахү анх- ингэж хэлнэ:

“Бэдирийн өдөрт хоёр тийшээ харвал би Энсарын хоёр залуугийн дунд байлаа. Харин илүү хүчтэй хүмүүсийн дунд байхыг хүсдэг байлаа. Тэднээс нэгэн нөгөөд нь дуулгалгүй надаас:

«–Ах аа! Чи Эбү Жэхилийг таних уу?» гэж асуув. Би ч:

«–Тийм, танина! Тэр яагаа вэ?» гэлээ. Залуу:

«–Минйи сонссоноор тэр Расулаллахыг зүхдэг байжээ! Миний биеийг хүчит гараараа барьсан Аллахад тангараг өргөе, түүнийг нэг харвал, бид хоёрын нэг нь үхээгүй цагт түүнээс салахгүй!» гэв.

Би түүний энэ үгэнд гайхлаа. Нөгөө залуу ч ижил утгатай үг хэлж байв. Би тэдний дэргэд байхдаа маш баяр баясгалан

107. Ибн-и Эсир, *Усдү’л-Габэ,* IV, 97.

108. **Рэжэз**: Арабын шүлгийн аруз хэмжээсэнд нэгэн бахрын нэр юм. Энэ үг “чичрэх” гэсэн утгатай бөгөөд рэжзэ буюу “босохдоо турснаасаа чичирдэг ингэ”тэй төсөөт тул энэ нэр өгсөн байдаг. Эсвэл “рэжэз: хүрхрэх” дээр үед ердээ дайны дууг энэ хэмжээсийг хэрэглэж дуулсны утгатай байж мэднэ. (Жэхандэ, А.-Чэтин, Н. (икмал), *M.E.B İA,* “recez” зүйл, IX, 657)

мэдэрлээ. Их удахгүй Эбү Жэхилийг дайны талбарт эргэлдэж байхыг нь хараад:

«–Хар, таны хайсан дайсан тэр!» гэлээ.

Залуус даруй сэлмээ сугалав. Эбү Жэхил рүү гүйж очоод түүнтэй цавчилдав. Энэ залуус Муаз бин Афра ба Муаз бин Амр байв.” (Бухарий, Мэгазий, 10; Мүслим, Жихад, 42)

Муаз бин Амр ингэж ярина:

“Намайг Эбү Жэхилийг цавчихад түүний хүү Икримэ ч намайг цавчиж гарыг минь гэмтээв. Гар минь арьсанд минь өлгөөтэй мэт үлдэв! Өдөржингөө энэ хэвээрээ санжигануулсаар байлдаж явлаа. Ийм байдал нь үнэхээр хүнд хэцүү байсан тул өөрөө өөрийнхөө хөлөөр гишгэн тасдаж хаялаа!” (Ибн-и Хишам, II, 275-276)

Нэгэнд Пайгамбар Эзэн маань:

“–Эбү Жэхил яасан бэ? Хэн нь очиж харах вэ?” хэмээв. Абдуллах бин Мэс’үд -радъяллахү анх- хайж яваад түүнийг газар хэвтэж байхыг олов. Үргэлжлэлийг нь өөрөө ингэж ярив:

Би түүнийг сүүлийн хоромд нь олж танилаа. Хөлөөрөө хүзүүн дээр нь гишгэж:

“–Еэ Аллахын дайсан минь! Аллах чамайг дорой болгоо биз?” гэлээ.

“–Аллах намайг юугаар дорой болгоо вэ, та нарын алсан хүмүүсийн дундаас надаас давуу нь хэн бэ? Хоньчин минь Чи хүрэхэд маш хэцүү нэгэн газар гарсан байна! Чи одоо тэрийг болиод надад хэлээд өг, өнөөдөр баяр хэнийх вэ?” гэв. Би:

“–Аллах болон Элчийнх нь!” гэлээ. Түүнийг өөрийнх нь сэлмээр алсны дараа Расулаллах -алэйхиссалатү вэссэлам-ын дэргэд очлоо:

“–Эбү Жэхилийг алсан!” гэлээ. Тэр ч Аллахад хамд хийгээд:

“–Тэр энэ үммэтийн Фарон байв,” хэмээв. (Бухарий, Мэгазий, 12; Ахмад, I, 444; Ибн-и Хишам, II, 277; Вакидий, I, 89-90)

Үммү Харисагийн хүү Бэдирийн Газвад дайсны тэнэсэн суманд оногдон шэхид болсон байв. Тэгээд ээж нь Аллахын Элчийн онгонд ирээд:

“–Аяа Расулаллах аа! Хэрэв миний хүү Хариса диваажинд байвал би тэвчээд буяныг нь найдна, үгүй бол хамаг хүчээрээ уйлна,” гэв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнд ийм сайхан мэдээ өгөв:

“–Үммү Хариса, диваажинд маш олон түвшин байдаг. Чиний хүү эдгээрээс хамгийн өндөр түвшин буй Фирдэвс-и А’лад хүрэв.” (Бухарий, Жихад, 14; Ахмад, III, 272)

Ийм сайхан мэдээ сонссон Харисагийн ээж мишээж эргэн явахдаа өөртөө:

“–Хараач! Чиний энэ агуу хувь тавиланг харлаа, Хариса минь!” гэж байлаа. (Ибн-и Эсир, *Усдү’л-Габэ,* I, 426)

Бэдирийн Газва нь бас Исламчуудын итгэлийг буй болох тулалдаан байсан тул, уг анхны том жихадад оролцсон асхаб нь мусульманчуудын хамгийн эрдэмтэй байх нэр хүндэд хүртэв. Эрх Таала нь уг дайнд мэлэкчүүдийн цэргийг залав. Бэдир дэх агуу тулаанд оролцсон мэлэкчүүд ч бусад мэлэкчүүдээс

илүү хүндэтгэл олов. Энэ тухай Жэбраил -алэйхиссэлам- нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс:

“–Аяа Расулаллах аа! Бэдирийн дайнд оролцогсдын тухай юу бодож байна вэ?” хэмээн асуусанд, Оршигчдын Туяа Эзэн маань:

“–Бид тэднийг мусульманчуудын хамгийн эрдэмтэй нь гэж тоолно,” гэсэн хариулт өгөв.

Жэбраил -алэйхиссэлам- ч ингэж хариулав:

“–Бид ч мэлэкчүүдээс Бэдирийг дайнд оролцогсдыг, тэр чигээр нь мэлэкчүүдийн хамгийн буянтай нь гэж тоолно.” (Бухарий, Мэгазий, 11)

Тэр өдөр их үд болоход дайн мусульманчуудын ялалтаар дуусав. Арван дөрвөн мусульман шэхид болоод, харин Эбү Жэхилийн хамт далан мүшрик алагдсан, дал орчим нь бол олз-логдсон байв. Ингээд аз жаргалгүй мүшрикчүүд, мэдээж Бэдирт ирэх зориг үзүүлсэн боловч хүссэн ялалтын дарсны оронд хувь заяаны хундаганаас үхэл залгив. Тэдний шивэгчид дуу сонсоод, уйлж гашуудав. Өөрийн талын Арабчуудыг цатгах байтугай, тэднийг өлсгөлөнгийн тамын нүхэнд унагав.

Пайгамбар Эзэн маань хуяг өмссөн байхдаа:

سَيُهْزَمُ الْجَمْعُ وَ يُوَلُّونَ الدُّبُرَ

“Тэд нар мөхөөд буцаж зугтах болно” (эл-Камэр, 45) гэсэн аетыг уншаад майхнаасаа гарав. (Бухарий, Жихад, 89)

Хазрат-и Умар -радъяллахү анх- ингэж хэлнэ:

“Уг аетыг Маккад буухад өөртөө; «Хэнийхэн нь мөхөөд зугтах вэ?» гэж санаашир байлаа. Бэдирийн өдөр ирээд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн уг аетыг уншсаныг сонсоод, мөхөхийг нь мэдээлсэн хүмүүс нь Курайшийн мүшрикчүүд мөн буйг ойлголоо. Аетын тэфсирийг тэр өдөр л мэдэж авлаа.” (Ибн-и Са’д, II, 25; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 312)

Ибн-и Аббас -радъяллахү анхүмаа-:

أَلَمْ تَرَ إِلَى الَّذِينَ بَدَّلُواْ نِعْمَةَ اللّهِ كُفْرًا وَأَحَلُّواْ قَوْمَهُمْ دَارَ الْبَوَارِ

“Аллахын ивээлийг үгүйсгэсэн ба эцэст нь ардаа мөхлийн оронд чирэгдэгчидийг хараагүй юу?” (Ибрахим, 28) гэсэн аетыг тэфсир хийхдээ:

“Валлахи тэд бол Курайшийн кафирчууд мөн. Үгүйсгэлтэй хариусан шим бол Мухаммед -алэйхиссалатү вэссэлам- мөн. Ардаа мөхөх оронд чирэх нь бол Бэдирийн өдөрт тэднийг галын оронд аваачсан нь юм,” гэсэн байв. (Бухарий, Мэгазий, 8; Тэфсир, 14/3)

Ислам болон итгэл үнэмшлийн ялалтаар дууссан Бэдирийн дайн нь Аллахын дотно, итгэлтэй ба болгоомжтой боолчуудаа тусламжийг үзүүлсэн том олон гайхамшиг ба тэднээс авах олон сургаалаар дүүрэн байдаг.

Энэ содон ялалтын дараа Аугаа Эрх мусульманчуудад ужуб буюу өөрөөрөө бахархах байдлыг дэмжих, нүгэл хийсэн хэмээн гэмшүүлэхгүйн тулд уг aeт-и кэримэг буулгав:

فَلَمْ تَقْتُلُوهُمْ وَلَكِنَّ اللّهَ قَتَلَهُمْ وَمَا رَمَيْتَ إِذْ رَمَيْتَ وَلَكِنَّ اللّهَ
رَمَى وَلِيُبْلِيَ الْمُؤْمِنِينَ مِنْهُ بَلاء حَسَناً إِنَّ اللّهَ سَمِيعٌ عَلِيمٌ

“ Аяа Пайгамбар! **Тэднийг та нар алаагүй, харин Аллах л алав. Харвахдаа Чи харваагүй, харин Аллах л харвав. Мөн итгэгчдийг сайхан нэгэн аргаар шалгасан хэрэг гэдгийг дурджээ. Андашгүй нь Аллах сонсдог, мэддэг.”** (эл-Энфал, 17)

Хүний эзэмшсэн хүч чадал нь тэнгэрлэг заяагаар хүрээлдэг. Ийм л учраас;

لاَ حَوْلَ وَلاَ قُوَّةَ اِلاَّ بِا اللهِ الْعَظِيمِ

“Азим ба аугаа Аллахаас өөр хэнд ч хүч чадал байдаггүй,” хэмээн айлдсан байдаг. Учир нь эртэд байгаагүй байсан ч гаг-цхуу Аллахын дайлснаар бий болсон хамаг оршигчдын эзэмш-сэн бүх юм Аллах Таалагаас үүсдэг. Ийм учраас бүхэл шийдвэр хамаг байдал явдал оршигчид л байдаг. Энэ бол шийдвэр ба чадлын гол нь Туурвигчид харьяалдаг гэсэн утгатай юм. Гэтэл хүн энэ хорвоод шалгагдахаар илгээсэн тул, түүнд хязгаартай боломж олгосон бөгөөд буян ба нүгэлтэй болгосон байдаг. Уг хүч чадлаа ашиглахыг тэр өөрөө шийдэх хариуцлагатай юм.

Бэдирээс Харьсан нь

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- дайснаа ялахдаа, тухайн тойргийн нээлттэй талбайд нь гурав хонох заншилтай байв. Бэдирийн Дайны гурав дахь өдөр болоход ч Пайгамбар Эзэн маань тэмээг нь авчрахыг тушаав. Тэмээгээ жингийн тэмээнээс уяад, Аллахын Элч явган явж эхлэв. Асхаб нь ч араас нь алхаж нэг нэгэндээ:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ямар нэгэн шалтгаанаар алхаж буй бололтой,” гэцгээв. Эцэст нь Пайгамбар Эзэн маань мүшрикчүүд хаягдсан худгийн дэргэд зогсч тэдэнд нэрээр нь хандаж:

“Эбү Жэхил ээ! Үмэйе бин Халэф аа! Үтбэ бин Рэбиа! Шэйбэ бин Рэбиа!” хэмээн дуудаж:

“–Та Аллах болон Элчийг нь дагасансан бол илүү сайн болохгүйсэн үү? Бид Раббынхаа бидэнд амласныг зөв ба үнэн олов! Та ч Раббынхаа танд амласныг үнэнээр олов уу?” хэмээв.

Умар -радъяллахү анх-:

“–Аяа Расулаллах аа! Цогцостой яриад байна уу?! Тэд амьгүй болсны дараа яаж сонсч танд хариулах вэ?” гэв.

Пайгамбар Эзэн маань:

“–Мухаммедын нэфсийг хүчит гараараа барьсан Аллахад тангараг өргөе, тэд миний хэлснийг танаас ч сайн сонсоно! Харин хариу өгч чадахгүй!” хэмээв. (Бухарий, Мэгазий, 8; Мүслим, Жэннэт, 77)

Бэдирт дайн дууссаны дараа Жэбраил -алэйхиссэлам- нь Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-д ирээд:

“–Аяа Мухаммед аа! Аллах Таала намайг Чамд илгээж Чамайг дуртай болтол бидний тусламж таалагдтал Чамаас салахгүйг тушаав. Чи таатай болов уу?” хэмээв.

Орчлонгуудын Эзэн:

“–Тийм ээ! надад таатай!” хэмээн хариу өгөхлөөр Жэбраил -алэйхиссэлам- салаад одов. (Вакидий, I, 113; Ибн-и Са’д, II, 26-27)

Энэ том ялалтаар Мадина-и Мүнэввэрэ нь баяр хөөрт автахад Макка нь гашуудалд автав. Ингээд Эбү Лэхэб гунигаасаа болж үхчихэв.[109] Ингээд тэнгэрлэг амлалт хэрэгжсэн болов.

109. Ибн-и Хишам, II, 289.

Гэтэл тэр хооронд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хүндэт охин Хазрат-и Рукайяг өөд болсны улмаас мусульманчуудын Бэдирийн ялалтын баяр хөөр их удаагүй.

Олзны Хүмүүст Хандах нь

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Бэдирт гурав хоносны дараа Мадинад харив. Олзлогдсон хүмүүсийн байдлыг Хазрат-и Эбү Бэкир, Хазрат-и Али ба Хазрат-и Умар -радъяллахү анхүм эжмаин-тай зөвлөлцөв. Эбү Бэкир -радъяллахү анх-:

“–Аяа Аллахын Элч ээ! Эд нар бидний садан ба дүү нар мөн. Би тэднээс барьцааны мөнгө авахыг тань зохимжтой гэж үзнэ. Тэднээс авах мөнгө, кафирчуудын эсрэг бидэнд нэгэн хүч байх болно. Магадгүй Аллах тэднийг авралтад хүргэж, тэд ч бидэнд түшиг байх болно,” гэв.

Пайгамбар Эзэн маань Хазрат-и Умараас:

“–Еэ Хаттабын хүү! Чиний бодол юу вэ?” хэмээн асуув. Тэр бол:

“–Үгүй! Валлахи аяа Расулаллах аа! Би Эбү Бэкир шиг бодохгүй! Тэдний хүзүүг цавчихад зөвшөөрөл олго! Надад зөвшөөрөл өг, энэ хүний хүзүүг би цавчъя. Аль зөвшөөрөл өг, (дүү нь) Акилын хүзүүг тэр цавчиг. Хамзад зөвшөөрөл өг, дүүгийнхээ (Хазрат-и Аббасын) хүзүүг тэр цавчиг. Ингээд Аллах бидний зүрхэнд мушрикчүүдэд ямар нэгэн зөөлөн мэдрэмж байдаггүйг илрүүлэг! Энэ олзныхон бол мушрикчүүдийн тэргүүлэгч, күфүрийн дарга нар мөн!” гэв.

Орчлонгийн Хүндэт Эзэн маань Хазрат-и Эбү Бэкирийн үзлийг барив. (Мүслим, Жихад, 58; Тирмизий, Сиер, 18/1567; Ахмад, I, 30-31, 383-384; Вакидий, I, 107; Ибн-и Са’д, II, 22)

Учир нь тэднийг авралд хүрэх ба тэднээс Аллахад боолчлогдох удам гарахыг найдаж байв.

Олзолсон хүмүүсийг, хэрхэхийг зөвлөлдөөд чөлөөлөх мөнгөний хариугаар чөлөөлөв. Төлөх арга үгүй хүмүүсийг ч тиймэрхүү байдлаар чөлөөлөв. Харин тэднээс уншиж бичиж чаддаг аль нэгэнд Мадинагаас арван хүүхдэд уншиж-бичих сургахыг даалгав. Тэд ч чөлөөлөх мөнгөө ингэж төлж болох байв. Вахийн нарийн бичигч байсан ба дараа нь Кур'аныг цуглуулсан буй Зэйд бин Сабит -радъяллахү анх- ч бичгийг тэднээс сурсан байв. (Ахмад, I, 247; Вакидий, I, 129; Ибн-и Са'д, II, 22)

Аллах Таала олзныхон болон тэднээс авсан мөнгөний тухай ингэж айлдав:

مَا كَانَ لِنَبِيٍّ أَن يَكُونَ لَهُ أَسْرَى حَتَّى يُثْخِنَ فِي الأَرْضِ تُرِيدُونَ عَرَضَ الدُّنْيَا وَاللّهُ يُرِيدُ الآخِرَةَ وَاللّهُ عَزِيزٌ حَكِيمٌ لَّوْلاَ كِتَابٌ مِّنَ اللّهِ سَبَقَ لَمَسَّكُمْ فِيمَا أَخَذْتُمْ عَذَابٌ عَظِيمٌ فَكُلُواْ مِمَّا غَنِمْتُمْ حَلاَلاً طَيِّبًا وَاتَّقُواْ اللّهَ إِنَّ اللّهَ غَفُورٌ رَّحِيمٌ

"Ямарч пайгамбар, дэлхийд байхдаа олзтой болох нь зохимжгүй юм. Та дэлхийн барааг хүсдэг, гэтэл Аллах ахиратыг олохыг танаас хүснэ. Аллах нь Азиз юм, Хаким юм. Хэрэв Аллахаас нэгэн шийдвэр **байгаагүйсэн бол, авсан чөлөөний мөнгөнөөс болж танд заавал нэгэн тамлал хүрнэ. Одоо гардсан олзноос халал таатай хүртээд Аллахыг эсэргүүцэхээс болгоомжил. Андашгүй нь Аллах өршөөгч ба энэрэлт мөн."** (эл-Энфал, 67-69)

Хазрат-и Умар ингэж хэлнэ:

“Өглөө намайг Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд ороход, Тэр ба Эбү Бэкиртэй хамт суугаад уйлж байв.

«–Аяа Расулаллах аа! Чамайг ба найзыг чинь юу нь уйлуулаа вэ? Надад мэдүүлээрэй! Түүнийг уйлмаар юм гэж ойлговол би ч уйлъя, уйлмаар юм гэж үзэхгүй бол таны уйлсанд оролцохыг хичээе?» гэлээ. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Тэр найз нарын чинь олзны хүмүүсээс авсан барьцааны мөнгөнөөс болоод надад тохиолдсон нь хайран юм! Тэдний учрах тамлал энэ миний дэргэдэх модноос ч ойр буйг нь надад үзүүлэв!» хэмээв.” (Ахмад, I, 31; Мүслим, Жихад, 58)

Аллах Таала нь дайсныг бүр дараад шашин нэр хүндээ олох ба эмх журам тогтохоос өмнө олз авах ба барьцааны мөнгөний хариунд тэднийг чөлөөлөх санааг сайшаасангүй, ийм учраас мусульманчуудад сануулга илгээсэн байв. Барьцааны мөнгө авахад энэ насны эд хөрөнгөтэй холбоотой хэсэг хүсэл ч байдаг. Харин Аллах ахиратын жаргалыг илүүд үзэхийг хүсдэг. Шашны дайсдыг бүрэн дарахаас өмнө олзолж авах нь, итгэгчдийн ахиратын жаргалыг аюулд оруулж мэдэх байв.

Бэдирийн Дайнд оролцогсдыг эс тамлах эсвэл ил далангүй нэгэн үйлийг хийснийг эс яллах мэтийн тэнгэрлэг нэгэн шийдвэр Лэвх-и Махфузад бичсэн байсан тулд, Аллах Таала итгэгчдийг өршөөсөн, авсан олзыг халал болгож тэднийг яллаагүй юм.

Аугаа Эрх нь олзныхон ба боолчуудад сайнаар хандахыг тушаав.[110] Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эзэн

110. Хар. эн-Ниса, 36.

маань энэ тухай маш олон мэдээ зарласан байдаг. Түүнчлэн өөд болохдоо сүүлийн үгс нь:

"Мөргөлд, ялангуяа мөргөлд анхаарцгаа. Гар доор буй хүмүүсийн тухай ч Аллахаас болгоомжил," болсон юм. (Эбү Давуд, Эдэб, 123-124/5156; Ибн-и Мажэ, Васаяа, 1)

Ма'рур бин Сүвэйд ярина:

"Би Эбү Зэрр -радъяллахү анх-ыг дээрээ үнэт нэгэн хувцастай харав. Ижил хувцаснаас үйлчлэгч нь ч өмссөн байв. Түүнээс үүний учрыг асуулаа. Эбү Зэрр бол хариулан, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дээр үед нэгэн хүнийг ээжийнхээ тухай буруушаасныг, ийм учиртай ингэж айлдахыг хэлэв:

«Чи мунхаг үеийн ёс сухтахуунтай хүн! Тэд таны үйлчлэгчид бөгөөд мөн таны дүү юм. Аллах тэднийг таны хамгаалалтад олгов. Хэн нэгний хамгаалалтдаа нэгэн дүү нь байвал, өөрийнхөө идсэнээс түүнд идүүлэг, өмссөнөөс түүнд ч өмсгөг. тэдэнд хүч нь хүрэмжгүй ажил бүү даалга. Даалгах болбол тэдэнд туслаарай.»" (Бухарий, Итк, 15; Мүслим, Эйман, 40)

Мус'аб бин Үмэйрийн дүү Эбү Азиз сургаалт уг байдлыг ярив:

"Бэдирийн Дайнд би ч олзлогдсон, Энсараас нэгэн нийгэмд гардуулсан байлаа. Аллахын Элч:

«–Олзны хүнд сайхан хандаарай!» хэмээсэн байв. Түүний уг тушаалыг хэрэгжүүлэхээр хажууд нь байсан Энсарын нийгэм өглөө-орой тэдний хувьд орсон талхыг надад өгдөг, өөрсдөө хасарваан идээд ханадаг байв. Би бол ичээд талхыг тэднээс нэгэнд өгөөд, тэр ч гараа огт түрхэлгүй буцааж надад өгдөг байв." (Хэйсэмий, VI, 86; Ибн-и Хишам, II, 288)

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- ба асхабынхаа ийм их зангийн үйлс, Дундаж зууных шиг харгислалын нэгэн үед хүн төрөлхтний нэрээр киямат хүртэл үлгэр жишээ болох эрдмийн сургаал болсон байдаг. Аллахын Элч нь хүмүүст сайн сайхнаар хандаад, тэдэнд өөрийнхөө байдлаараа тэблиг хийдэг, ингэхдээ тэдний сэтгэлийг зөөлрүүлсний дараа ч Исламыг таниулан ярьдаг байв. Бэдирийн олзныхон ихэнх нь ийм сайхан хандлагын ачаар мусульман болсон байв.

Ислам нь боолчлолыг[111] үгүй болгоогүй ч, хүмүүсийг үүнд бас дагуулаагүй юм. Харин түүнийг муугаар хэрэглэхгүй байхаар зарим дүрэм журмаар зохицуулсан байдаг. Ингээд боолчлолын хуулийг хамгийн хувилбарт оруулав.

Улсуудын хооронд дайн болж байдаг ба киямат хүртэл ч байх болох юм бол, эрх чөлөөгөө алдсан хүмүүстэй хамаатай дүрэм журам ч байнга хэрэгтэй байх болно. Үүнээс үзвэл үүнийг цуцалснаас, дүрэм журмыг нь тогтоож боолын хуулийг янзлах хэрэгтэй гэж үзсэн байдаг.

Ислам нь авчирсан зарчмаараа боол эзэн хоёрыг нэг нэгэнд ойртуулж, боолчуудыг аврахыг хичээдэг. Жишээлбэл хэн нэгэн хүн алдаа хийгээд санаандгүйгээр хүн албал, ийм тохиодолд батлан даалтаар эхлээд нэгэн боол чөлөөлөхийг тушаана. Хоёр дугаарт нь тэр өрхийн нөхцөл байдалд тохируулан тодорхой хэмжээнд мөнгө эсвэл тэмээний үнээр торгуул төлөхийг шаардана. Нэгэн мусульман жишээлбэл хаж хийж байхдаа нэгэн алдаа хийвэл дахиад даалтын анхны арга нь боол чөлөөлнө. Тангараг өргөвөл, зихар[112] хийвэл, мацгаа эвдвэл, эдгээрийг ч

---

111. Энд олз ба боолыг хамт шинжилсэн байдаг. Учир нь боолчлолын эх нь олз болох юм. Дайнд олзолсон хүмүүс боол болгодог байв.

112. **Зихар** нь хэн нэгэн хүний эхнэртээ: “Чи надад эх шигээ санагдана!” гээд түүнийг өөртөө харам болгох нь юм. Ислам мунхаглалын энэ занг хориглож ингэсэн хүмүүсийн батлан даалт төлөхийг тушаасан байдаг.

эхлээд нэгэн боол чөлөөлөхийг шаардана. Зарим үйлсийн ач буяны хэмжээг тайлбарлахдаа:

“Төдөн боолыг чөлөөлөхтэй адил юм!” гээд хүмүүсийг эрх чөлөөнд хүргэхийн хэр том үйл буйг мэдүүлнэ. Гэтэл, эрхгүйгээр хэн нэгний боолчлох ч хамгийн том нүгэлийн тоонд ордог. Хувь заяаны эрхээр боол болсон хүмүүст ч сайнаар хандахыг тушаана.

Ислам нь боолын эзэнд байнга “Идсэнээсээ идүүл, ууснаасаа уулга, мацагтай байхад илүү ачаа ба ажил бүү даалга, түүний хэрэгцээг ханга!” гэснийг санал болгоно. Боол чөлөөлөхийг мусульман авралын сайхан заншил гэж заана. Боолчуудын төлөө маш чухал эрх зүй авраад, эдгээрийг дагавал боолгүй болох нь бараг боолтой болохоос буянтай болоод, боолтой болох нь ч нэг төрлийн боол болох гэсэн утга агуулна.

Ийм байхад Ислам нь боолчлолын хаалгыг чадах чинээгээрээ хаасан ба гарах хаалгыг ч дэлгэн нээсэн бөгөөд ийнхүү байдлын хүмүүсийг чөлөөлөхийг завшаан бүрт урамшуулсан байдаг.

Орчлонгийн Хүндэт Эзэн маань, олзныхны дунд буй авга ах Аббастаа:

“–Аббас аа! Чи хөрөнгөтэй баян хүн. Өөрийнхөө, дүүгийн хүү Акил, Нэвфэл бин Харич ба хоорондоо гэрээ хийсэн Үтбэ бин Амрын чөлөөлөхийн төлөө мөнгө төл!” хэмээв.

Аббас бол:

“–Аяа Расулаллах аа! Би мусульман байсан, Курайш намайг албадан аянд гаргав!” гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Чиний мусульман байх эсэхийг зөвхөн Аллах мэднэ. Чиний хэлсэн нь зөв байвал Аллах заавал шагналыг нь өгнө. Харин чиний байдлыг харвал бидний эсрэг байлаа. Тийм учраас барьцааны мөнгөө төлөх хэрэгтэй,” хэмээж түүний дэргэд байсан 800 дирхэм алтыг ч дайны олз болгож эзэмшив.

Аббас:

“–Аяа Расулаллах! Ядаж үүнийг барьцааны мөнгөөр тоол!” гэв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Үгүй! Тэр Аллахын бидэнд өгсөн олз юм,” хэмээв.

Аббас:

“–Аяа Расулаллах! Миний үлдсэн амьдралыг гуйлгачин болгомоор байна уу? гэв.

Тэгсэнд нь Аллахын Элч:

“–Аббас аа! Эхнэр Үммү’л-Фадлад чинь байгаа алт яасан?” хэмээн асуухад нь Аббас:

“–Ямар алт?” гэв.

Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-:

“–Нөгөө, чиний Маккагаас гарах өдөр таны дэргэд Аллахаас өөр хэн ч байгаагүй байхад эхнэр Үммү’л-Фадлдаа: «Энэ удаа надад юу болохыг би мэдэхгүй. Хэрэв ямар нэгэн гамшигтай тааралдвал энэ нь чинийх, тэр нь Үбэйдуллахынх, нөгөө нь Фадлынх, энэ хэсэг нь............ тэр хэсэг нь Абдуллахынх юм!» гэж хуваасан алт чинь!” хэмээв.

Гайхаж алмайрсан Аббас:

"–Чамайг пайгамбар болгож илгээсэн Аллахад тангараг өргөе, үүнийг би болон Үммү'л-Фадлаас гадна хэн ч мэдэхгүй байв. Андашгүй нь Чи Аллахын Элч мөн!" гэлээ. (Ахмад, I, 353; Ибн-и Са'д, IV, 13-15)

Бэдирийн олзны хүмүүсийн дунд Оршигчдын Туяаны хүргэн, Хазрат-и Зэйнэбийн нөхөр Эбү'л-Ас бин Рэбий ч байлаа. Эбү'л-Ас нь Маккад баялаг ба наймаанд тэргүүлсэн итгэмжтэй нэгэн хүн байлаа. Ээж нь Халэ бинт-и Хүвэйлид Хазрат-и Хатижагийн охин дүү байв. Хатижэ эх маань зээ Эбү'л-Асыг хөвүүн шигээ үздэг байв.

Курайшийн мүшрикчүүд Эзний маань хүргэнүүдэд:

"–Та нар Мухаммедын охидыг аваад Түүний ачаанаас хөнгөллөө гэтэл зовлон нэмлээ! Охидыг нь буцааж өг," гэцгээв. Тэр чигээр нь Эбү'л-Аст ч:

"–Эхнэрээсээ сал! Курайшийн эмэгтэйчүүдээс хэнийг хүсвэл чамайг түүнтэй гэрлүүлье!" гэцгээв. Харин Эбү'л-Ас:

"–Үгүй! Валлахи би эхнэрээсээ салахгүй ба түүний оронд Курайшийн эмэгтэйчүүдээс хэнийг ч хүсэхгүй!" гэв.

Маккачууд олзонд баригдсан хүмүүсийн төлөө барьцааны мөнгө илгээж эхлэхэд, Хазрат-и Зэйнэб ч Эбү'л-Асын төлөө хуримын үед Хатижа ээжийнхээ бэлэглэсэн зүүлтийг илгээсэн байв. Аллахын Элч зүүлтийг харангуутаа сэтгэл нь хөдөлж:

"–Хэрэв Зэйнэбийн хүнийг чөлөөлж төлбөр барааг нь ч буцааж өгөхийг та нар ч зохимжтой гэж үзвэл тэгье!" хэмээв.

Мусульманчууд:

“–Болно, аяа Расулаллах аа!” гээд Эбү’л-Асыг чөлөөлөв. Илгээсэн бараа болон зүүлтийг ч Хазрат-и Зэйнэбт буцааж өгөв.

Хазрат-и Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам- охин Зэйнэбийг Мадинад илгээх тухай Эбү’л-Асаас ам авч, түүнийг чөлөөлж байхдаа түүнээс ийм юмыг шаардсан байв. Харин энэ нь Аллахын Элчтэй түүний хооронд нууц болж, үүнийг хэнд ч хэлэхгүй байв. (Ибн-и Хишам, II, 296-297; Эбү Давуд, Жихад, 121/2692; Ахмад, VI, 276)

Үмэйр бин Вэхбийн хөвүүн Вэхб ч Бэдирт олзолсон хүмүүсийн дунд байв. Үмэйр нь Курайшийн мүшрикчүүдийн зальт баатруудын нэгэн байв. Маккад Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- болон асхабт нь их харгисласан байв. Нэгэн өдөр Үмэйр нь Хижр гэсэн газар Сафван бин Үмэйегийн хамт суугаад Бэдирт худагт хаягдагсад болон тэдэнд тохиолдсон гамшгийг ярихлаар Сафван бин Үмэйе:

“–Валлахи тэднийг ийм юмтай тааралдсаны дараа амьд байхын учир утга үгүй!” гэв.

Үмэйр:

“–Валлахи чиний зөв! Хэрэв өртэй ба миний дараа өлсөхөөс нь айсан гэр бүлийнх маань байгаагүйсэн бол заавал одоод Мухаммедыг алахсан. Бас би хэлбэл тэдний ойлгох шалтгаан ч бий; «Олз болсон хүүгийнхээ төлөө л ирсэн» гэх болно. Миний сонссоноор Тэр зах зээлээр ч алхаж явдаг гэнэ,” гэлээ.

Үмэйрийн ийм үгс Сафваныг баясгав:

“–Чиний өр минийх болог. Чиний өмнөөс би төлнө! Чинйи гэр бүлийнхийг ч өөрийнхөө гэр бүлийн хамт, тэднийг амьд байхад сахиж хамгаалж, сайхан өсгөнө!” гэв.

Тэгсэнд нь Үмэйр сэлмээ маш сайхан билүүдэв. Сафван ч унаа ба хүнсийг нь бэлтгүүлэв. Үмэйр Мадинад ирээд мэсжидийг үүдэнд зогсч, тэмээгээ уяж сэлмээ бүслэв. Хазрат-и Умар -радъяллахү анх- түүнийг харахлаараа:

“–Энэ бол Аллахын дайсан Үмэйр юм! Валлахи зөвхөн муу муухайн төлөө л ирсэн бололтой! Бидний эв эеийг эвдсэн, Бэдирийн өдөрт ч Курайшчуудад бидний тоог таасан нь тэр биш билүү?” гэсний дараа Аллахын Элчийн дэргэд оров:

“–Аяа Расулаллах аа! Алах дайсан тэр Үмэйр сэлмээ бүсэлж иржээ!” гэв.

Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-:

“–Түүнийг миний дэргэд авчир!” хэмээв. Умар -радъяллахү анх- буцаж гарав. Түүний сэлмийг хураав. Энсараас дэргэд байсан хүмүүст ч:

“–Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд суугаад, Түүнийг сайн хамгаалцгаа! Энэ нөхөр итгэмжтэй хүн биш юм!” гэв.

Пайгамбар Эзэн маань бол:

“–Умар аа, түүнийг орхи! Чи ч, Үмэйр ээ, над руу дөх!” хэмээж дараа нь Үмэйрээс яагаад ирснийг асуув. Үмэйр:

“–Таны олзонд байгаа хүүгийнхээ төлөө ирлээ! Түүний тухай соёрхоно уу!” гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Тийм бол сэлэм агсаж ирэхийн учир юу билээ?!” хэмээн асуув.

Үмэйр:

“–Аллах сэлмүүдийг гэсгээг! Тэд бидэнд ямарч ашиг болсонгүй?” гэв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- дахиад:

“–Надад үнэнийг хэл, чи энд яах гэж ирээ вэ?” гэж асуув.

Үмэйр:

“–Би, , зөвхөн таны гарт олзолсон хүүгээ авахаар л ирлээ!” гэв.

Пайгамбар Эзэн -алэйхиссалатү вэссэлам-:

“–Чиний Хижрэд Сафванд хэлсэн шаардлага юу билээ?” хэмээн асуухад нь Үмэйр айгаад:

“–Би түүнээс юу шаардах юм бэ?” гэв.

Пайгамбар Эзэн маань тэдний яриаг үг үгээр нь дамжуулан:

“–Аллах чиний хийх ажилтай чиний хооронд ороод чамд саад болов!” хэмээв.

Тэгэхлээр нь Үмэйр:

“–Би чамайг андашгүй Аллахын Элч мөн гэдгийг гэрчлэе! Аяа Расулаллах аа! Бид тэнгэрээс ирсэн мэдээ ба Чамд буусан вахийн тухай Чамайг үгүйсгэдэг байлаа. Энэ ажлыг Сафван бид хоёроос өөр хэн ч мэддэггүй байв. Валлахи энэ мэдээллийг Чамд зөвхөн Аллах л өгсөн юм! Намайг Исламд аварч энд авчирсан Аллахад хамд хийе!” гэсний дараа шэхадэт үгийг хэлэв. Тэгэхлээр нь Аллахын Элч:

"–Дүүдээ шашныг нь сайхан ойлгуулаарай! Түүнд Кур'ан уншаад сургаарай! Чөлөөлье, аваад яв!" хэмээн айлдав.

Орчлонгуудын Эзний тушаал шууд хэрэгжив. Үмэйр:

"–Аяа Расулаллах аа! Би Аллахын туяаг унтраахыг хичээсэн ба мусульманчуудад ширүүн харгисласан нэгэн байлаа. Зөвшөөрөл олговол Маккад очоод Маккагийн мүшрикчүүдийг Аллах, Элч нь ба Исламд урья! Аллахын тэдэнд аврал хайрлахыг найдъя," гэв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнд зөвшөөрөл олгов.

Тэр хооронд Сафван бин Үмэйе юу болсныг мэдэлгүй Маккагийн мүшрикчүүдэд:

"–Хэдхэн хоногийн дотор ирэх мэдээгээр та бүхэн баясна. Тэр нь танд Бэдирийн гашууныг мартуулна!" гээд, ирсэн жинчдээс мэдээ асуугаад байв. Эцэст нь нэгэн морьтон түүнд Үмэйрийн мусульман болсныг мэдээлэв.

Үмэйр бин Вэхб -радъяллахү анх- нь Маккад ирээд хүмүүсийг Исламд урьж эхлэв. Эсэргүүцэгсдэд ч хязгаараа мэдүүлэв. Түүний ачаар олон хүн мусульман болов. Хазрат-и Үмэйр нэгэн өдөр Кабагийн дэргэд Сафван бин Үмэйетэй таараалдаад түүнд:

"–Чи бидний эрхэмчүүдээс нэг! Бидний чулуунд залбиран тэдний төлөө тахил барьж буйг харахгүй байна уу? Шашин гэдэг нь энэ юм уу? Би Аллахаас өөр бурхан үгүйг гэрчилнэ! Мухаммед ч Аллахын боол ба Элч мөн!" гэв. Сафван түүнд ганц үг ч хэлж чадаагүй, чимээгүйгээр байж байв. (Ибн-и Хишам, II, 306-309; Вакидий, I, 125-128; Ибн-и Са'д, IV, 199-201)

Энэ явдал нь "Чамайг алахаар ирсэн нэгийг өөрчилсөн!" хамгийн сайхан жишээний нэг болоод итгэгчдийн сэтгэлд шингэв.

Бэдирт мүшрикчүүдийн тэргүүнүүд алагдаад, олзныхон гар нь хүзүүндээ уясан буйгаар Мадинад ирэхэд, Аллах Таала Мадина дахь мүшрик, мшнафик ба еврейчүүдийг ч эзэмшсэн болов. Абдуллах бин Үбэй ба түүний хамд хандсан Мадинагийн мүшрикчүүд “Одоогоос хойш ялалт нь Түүнд чиглэсэн!” гээд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д Ислам дээр бий’ат хийхээс аргагүй болцгоов.[113]

Олзны Хүмүүсийн Тухай Шийдвэр

Олз омгийн тухай Исламын зарчим арай мэдэгдээгүй тул Бэдирт авсан олз омгийн талаар маргалдаан гарав. Бас Бэдирт дүү нь шэхид болсон Са’д бин Эбий Ваккас ч өөрөө алсан Саид бин Асын сэлмийг аваад Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д ирж үүнийг өөртөө авахыг хүсэв. Ийнхүү нэхэмжлэлийн дараа, арай Бэдирээс салахаас ба олз омгийг хуваалцахаас өмнө Энфал Сурагийн анхны ает буув:

يَسْأَلُونَكَ عَنِ الأَنفَالِ قُلِ الأَنفَالُ لِلّهِ وَالرَّسُولِ فَاتَّقُواْ اللّهَ
وَأَصْلِحُواْ ذَاتَ بِيْنِكُمْ وَأَطِيعُواْ اللّهَ وَرَسُولَهُ إِن كُنتُم مُّؤْمِنِينَ

“Чамаас олз омгийг асууна. Ингэж хэл: Олз омог нь Аллах ба Элчид нь харьяалагдана. Тийм учраас, та үнэн итгэгч байвал Аллахаас айгаад нэг нэгэнтэй харьцаагаа засаад, Аллах болон Элид нь бууж өгөөрэй!” (эл-Энфал, 1)

113. Бухарий, Тэфсир, 3/15; Вакидий, I, 121.

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- энэ олз омгийг Мадинад ойрхон нэгэн газар дайнд оролцсон мүжахидчуудад тэгшээр хуваав.[114]

Дараа нь дайны олз омгийн тухай дэлгэрэнгүй шийдвэр агуулсан, тус сурагийн 41-р ает буув:

وَاعْلَمُوٓا اَنَّمَا غَنِمْتُمْ مِنْ شَيْءٍ فَاَنَّ لِلّٰهِ خُمُسَهُ وَلِلرَّسُولِ وَلِذِي الْقُرْبٰى وَالْيَتَامٰى وَالْمَسَاكِينِ وَابْنِ السَّبِيلِ اِنْ كُنْتُمْ اٰمَنْتُمْ بِاللّٰهِ وَمَآ اَنْزَلْنَا عَلٰى عَبْدِنَا يَوْمَ الْفُرْقَانِ يَوْمَ الْتَقَى الْجَمْعَانِ وَاللّٰهُ عَلٰى كُلِّ شَيْءٍ قَدِيرٌ

“Үүнийг ч мэдээрэй, олз омгоор авсан ямар нэгэн зүйлийн тавны нэг нь заавал Аллахын төлөө юм. Тэрийг ч Пайгамбар ба Түүнд ойр, өнчин, гэр ажилгүй ба замд үлдсэн хүмүүс л ашиглана. Хэрэв та Аллахад итгэн үнэмшсэн бөгөөд үнэн худал хоёрыг ялгасан тэр өдөр хоёр цэргийн уулзсан тэр (Бэдирийн) **өдөр бидний боолдоо буулгасан аетудад итгэсэн бол, үүнийг ингэж мэдээрэй. Мөн Аллахын бүхэнд хүч чадалтайг мэдээрэй.”** (эл-Энфал, 41)

Энэ аетаас үзвэл олз омгийн тавны нэгийг Аллахад, Элчид нь, Түүний садан хамаатанд, өнчдөд, ядуучуудад ба замд үлдсэн зорчигчдод харьяалагдана.

Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- өөрийнхөө хувиараа гэр бүлийнхээ хэрэгцээг хангасны дараа бусад хэс-

114. Ахмад, I, 178; V, 323-324; Эбү Давуд, Жихад, 144-145/2737-2744.

гийг улс төрийн санд хийсэн ба үүнийг мусульманчуудын хэрэгцээ болон цэргийн зардалд хэрэглэсэн байдаг.[115]

Амр бин Абэсэ -радъяллахү анх- ярина:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- киблагийн чигт сүтрэ[116] болох олзны нэгэн тэмээг хэвтүүлж бидэнд мөргөл үйлдүүлэв. Мөргөл үйлдсэний дараа малын хажуунаас нэгэн хялгас татаж аваад чимхэн бидэнд зааж:

«–Таны олзноос ийм хумсын чинээ нь ч надад халал биш юм. Угаасаа иймийг ч танд буцааж өгнө таны төлөө зарцуулна,» хэмээв.” (Эбү Давуд, Жихад, 149/2755)

Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- гардаа юу байсан ч асхабынхаа хэрэгцээтэйд нь өгдөг байв. Харин ихэнхдээ өөрөө гэртээ хэдэн олон хоног гал асаадаггүй, хоол хийдэггүй байв. Тэр болон гэр бүлийнх нь ихэнхдээ нэгэн өдрийн хүнс ч үгүй байсан нь дамжуулсан ярианаас ойлгомжтой. Түүний энэ тухай ёс суртахууныг энэ үг маш сайхан илрүүлнэ:

Энэс -радъяллахү анх- ярина:

“Расулаллах -алэйхисалату вэссэлам-д Бахрейнээс бараа ирэв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Түүнийг мэсжидэд асга!» хэмээн айлдав. Энэ бараа нь одоо хүртэл Аллахын Элчид ирсэн хамгийн их нь байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- мөргөлд очоод бараг огт хараагүй. Мөргөлийг дуусахад ирээд барааны дэргэд зогсов. Харсан хүн бүрт түүнээс өгөөд байв… Расулаллах

115. Бухарий, Фэраиз 3, Хумус 1, Нафакат 3; Мүслим, Жихад 49.

116. **Сүтрэ:** Хөшиг, халхавч гэсэн утгатай. Мөргөл үйлдэх хүний өмнө тавиад, энэ хооронд өмнөөс нь явагч хүмүүсийн мөргөлийг хохируулахыг саатуулах зүйл.

-саллаллахү алэйхи вэ сэллэм- ганцхан дирхэм ч үлдээгүй байтал бүгдийг тараасаар тэндээс салаагүй.” (Бухарий, Салат 42, Жизье 4, Жихад 172)

Кур’ан-и Кэрим дэх Энфал Сура нь Мадинад нүүсний хоёр дахь жилд буусан байдаг. Ихэнх хэсэг нь Бэдирийн Газвагийн тухай ба Бэдирийн өдөрт буусан тул тус сураг **“Бэдирийн Сура”** ч гэдэг.

Шэхадэт Цол

Шэхид болох төвшин нь нэгэн итгэгчийн хүрч чадах хамгийн дээд ба аугаа ор байдаг. Диваажингийн хамгийн доорх төвшин ч дэлхийн бүхнээс илүү буянтай байсан ч шэхид нь тус ор маш агуу ба диваажин дахь шагнал нь маш том тул дэлхийд олон удаа хариад олон удаа шэхид болохыг хүснэ. Аугаа Эрх ингэж айлдана:

وَلَئِن قُتِلْتُمْ فِي سَبِيلِ اللّٰهِ أَوْ مُتُّمْ لَمَغْفِرَةٌ مِّنَ اللّٰهِ
وَرَحْمَةٌ خَيْرٌ مِّمَّا يَجْمَعُونَ

“Хэрэв та Аллахын замд алагдах буюу үхвэл, Аллахын өршөөл ба энэрэл тэдний хураасан бүхнээс ч илүү буянтай буйг сайн мэдээрэй.” (Ал-и Имран, 157)

Са’д бин Эбий Ваккас -радъяллахү анх- ингэж ярина:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- бидэнд мөргөл үйлдэж байхад нэгэн хүн ирэв. Эгнээнд орохдоо:

«–Аллах минь, надад салих боолчууддаа өгснийхөө хамгийн эрдэмтийг нь өг!» гэж залбирав. Хүндэт Нэбий Эзэн маань мөргөлийг дуусахад:

«–Сая залбирсан нь хэн байв?» хэмээн асуув. Тэр хүн:

"–Би байлаа, аяа Расулаллах!" гэв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Тэгвэл чиний морь сөхөрч чи шэхид болно," хэмээн айлдав. (Хаким, I, 325/748)

Пайгамбар Эзэн маань асхабаасаа заримын шэхид болохыг өмнөөс мэдээлсэн зэрэг, дайнд явахдаа тухай нь Аллахаас энэрэл ба өршөөл ерөөж залбирсан хүмүүс ч шэхидийн цолыг хүртсэн байдаг. Жишээлбэл Амир бин Эква -радъяллахү анхын төлөө ч ижил залбирал хийсэн, их удалгүй тэр ч Хайбарт шэхил болсон байв.[117]

Пайгамбар Эзний маань залбирал дахь өршөөл гуйж шэхид болоод хэрэгжсэн нь шэхадэт цолын хэр их хүчтэй байсны өөр нэгэн баталгаа юм. Эзний маань залбирлын ингэж дүгнэснийг харсан Асхаб-и кирам ч ийм залбирлыг шэхид болохын сайхан мэдээ гэж ойлгодог байв.

Эбү Катадэ -радъяллахү анх-ын дамжуулснаар нэгэн өдөр Пайгамбар Эзэн маань асхабын дунд босоод:

"Аллахын замд жихад ба Аллахад итгэх үнэмших нь үйлсийн хамгийн эрдэмт нь юм," хэмээн сануулав. Тэгэхлээр нь нэгэн эр босоод:

"–Аяа Расулаллах! Хэрэв би Аллахын замд алагдвал, энэ нь миний нүгэлийн даалтын мөнгө байх болох уу?" гэж асуув.

117. Мүслим, Жихад, 123, 132; Бухарий, Мэгазий, 138.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнд:

"–Тийм, хэрэв чи тэвчээд, ач буяныг нь зөвхөн Аллахаас найдан, дайны талбайгаас зугталгүй дайсанд эсэргүүцэж Аллахын замд алагдвал, нүгэлд чинь даалт болно. Харин чиний өр үүнд орохгүй. Үүнийг надад Жибрийл хэлэв," хэмээв. (Мүслим, Имарэ, 117; Тирмизий, Жихад, 33/1712)

Өөр нэгэн дамжуулсан үгэнд:

"Шэхидийн боолын эрхээс гадна хамаг нүгэлийг Аллах өршөөнө" хэмээв. (Мүслим, Имарэ, 119)

Дахиад Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэгэн өдөр асхабтаа ингэж айлдав:

"Өнөө шөнө зүүдэндээ хоёр эрийг харлаа. Тэд Миний дэргэд ирээд намайг нэгэн модон дээр гаргаж дараа нь нэгэн гэрт аваачив. Тэр гэр орд одоо хүртэл миний харaагүй гоё тансаг ба үнэт байв. Дараа нь тэр хоёр хүн надад:

«–Энэ ижилгүй гэр нь шэхидчүүдийн ордон юм,» гэв." (Бухарий, Жихад, 4; Жэнаиз, 93)

Пайгамбар Эзэн маань асхабаас нь шэхид бологсодод ойр дотноос сонирхол үзүүлсэн, тэдэнд тусгай анхаарал үзүүлсэн, тэдний диважинд буйг мэдээлсэн, садан хамаатныг нь ч тайгаруулсан, сахаба-и кирамд шэхид болох орыг урамшуулсан байдаг.

Жабир -радъяллахү анх- ингэж хэлнэ:

"Аавын минь мүслэ[118] хийсэн шарилыг авчраад Хүндэт Нэбийгийн өмнө тавьцгаав царайг нь харахаар би очлоо. Тэгэхлээр нь Нэбий -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

118. **Мүслэ:** Алсан хүний хамар, чих эсвэл бусад эрхтнийг зүсээд нүдийг нь

«–Мэлэкчүүд таслалтгүй түүнийг далавчаараа сүүдэрлэдэг,» хэмээв.” (Бухарий, Жэнаиз 3, 35, Жихад 20; Мүслим, Фэдаилү’с-Сахаба 129-130)

Шэхид болох нь үнэндээ үхэх биш, бидний анзаараагүй нэгэн чанараар үүрд мөнхийн хувийг хүртэх юм. Үүнээс үзвэл Аллах Таала шэхид боолчуудынхаа тухай “үхсэн” гэж ярихыг хориглов. Ает-и кэримэнүүдийн айлдсанаар:

وَلاَ تَقُولُواْ لِمَنْ يُقْتَلُ فِي سَبيلِ اللّهِ أَمْوَاتٌ
بَلْ أَحْيَاء وَلَكِن لاَّ تَشْعُرُون

“Аллахын замд алагдагчдыг «үхсэн» гэж бүү хэл. Тэд амьд юм, харин та ойлгохгүй.” (эл-Бакара, 154)

وَلاَ تَحْسَبَنَّ الَّذِينَ قُتِلُواْ فِي سَبِيلِ اللّهِ أَمْوَاتًا بَلْ أَحْيَاء عِندَ رَبِّهِمْ
يُرْزَقُونَ فَرِحِينَ بِمَا آتَاهُمُ اللّهُ مِن فَضْلِهِ وَيَسْتَبْشِرُونَ بِالَّذِينَ لَمْ
يَلْحَقُواْ بِهِم مِّنْ خَلْفِهِمْ أَلاَّ خَوْفٌ عَلَيْهِمْ وَلاَ هُمْ يَحْزَنُونَيَسْتَبْشِرُونَ
بِنِعْمَةٍ مِّنَ اللّهِ وَفَضْلٍ وَأَنَّ اللّهَ لاَ يُضِيعُ أَجْرَ الْمُؤْمِنِين

“Аллахын замд алагдагсдыг амьгүй гэж огт бодуузай. тэд амьд юм! Аллахын хайрлан дайлснаар тэдэнд өгснөөр тэд баяр баясгалантайгаар Раббынхаа дэргэд олон төрлийн хувь хишиг хүртэнэ. Хойноос нь ирэх ба арай тэдний хамт

ухах юм. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- хүнд ба мөн амьтадад ч мүслэ хийхийг хатуу хориглосон байдаг. (Бухарий, Мэзалим 30, Зэбаих 25; Эбү Давуд, Жихад 110)

ирээгүй дүү нартаа ч ямар ч аймшиг ба гуниг хүрэхгүйг ба тэдний огт санаа зовох хэрэггүйг дамжуулан хэлмээр байцгаадаг. Тэд бол Аллахын хайрласан энэрэл элбэг дэлбэг хишиг буяныг эдэлдэг ба Аллахад итгэгчдийн ач буяныг хэзээ ч өөр бусдад зарцуулахгүйг хэлмээр байна.” (Ал-и Имран, 169-171)

Киямат өдөрд шэхидчүүд нь шинэхэн шархнаас нь урсах цэвэр цус ба үүнээс тарсан анхилуун үнэрээр танигдана. Хүмүүс тэдний нэр хүнд ба эрдмийг гэрчилнэ. Ийм учраас шэхидчүүдийн цус ба шарилыг угаадаггүй.

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Эрх Таалагийн шэхид болоход боолдоо үзүүлсэн хялбаршлыг ингэж илэрхийлнэ:

“Танаас хэн нэгэн шоргоолж хазахад хэдий өвдвөл, шэхид болсон хүн ч үхэхэд төдий бага өвдөнө.” (Тирмизий, Фэдаилү’л-Жихад, 26/1668; Нэсаи, Жихад, 35; Ибн-и Мажэ, Жихад, 16)

Аллах Таала боолчуудаа шэхид болоход урамшуулах үүднээс ингэж айлдана:

فَلْيُقَاتِلْ فِي سَبِيلِ اللّٰهِ الَّذِينَ يَشْرُونَ الْحَيَاةَ الدُّنْيَا بِالآخِرَةِ وَمَن يُقَاتِلْ فِي سَبِيلِ اللّٰهِ فَيُقْتَلْ أَو يَغْلِبْ فَسَوْفَ نُؤْتِيهِ أَجْرًا عَظِيمًا

“Тийм байвал түр зуурын **дэлхийн амьдралын** мөнхийн **ахиратын амьдралын хариунд зарах бологчид нь Аллахын замд байлдаг. Хэн ч Аллахын замд байлдаад алагдах буюу ялбал, хоёр тохиолдолд ч Бид түүнд маргааш маш том нэгэн шагнал хайрлана.”** (эн-Ниса, 74)

Хамаг чин сэтгэлээрээ шэхид болохыг хүссэн Орчлонгийн Хүндэт Эзэн маань энэ сэтгэлээ ингэж илэрхийлэв:

“Үммэтэд минь хэцүү санагдахгүй бол би ямар ч аянаас хойно үлдэхгүй, бүгдэд нь оролцох байсан. Аллахын замд шэхид болж, дараа нь дахиад сэргээж дахиад шэхид болж, дахиад сэргээж дахиад шэхид болохыг хүсэх байв.” (Бухарий, Иман, 26; Мүслим, Имарэ, 103, 107)

Нэгэн өдөр Хүндэт Элч Эзэн маань Хазрат-и Умарын нэгэн цамцыг харав:

“–Энэ цамц чинь шинэ үү, эсвэл угаасан уу?” хэмээн асуув.

Хазрат-и Умар -радъяллахү анх-:

“–Үгүй шинэ биш, угаасан цамц аяа Расулаллах!” гэхлээр нь:

“–Шинийг өмс, хамд хийгээд амьдар, шэхид болоод өнгөр!” хэмээв. (Ахмад, II, 89)

Хүндэт Нэбий Эзэн маань ингэхдээ Хазрат-и Умарт мэдээг хүргэсэн болов.

Дахиад нэгэн өдөр Хүндэт Нэбий Эзэн маань Хазрат-и Эбү Бэкир, Умар ба Усман -радъяллахү анхүм эжмаин-ы хамт Ухуд Ууланд гарсан байв. Тэр хооронд уул нь найгаж эхлэв. Орчлонгуудын Эзэн хөлөөрөө газрыг цохиод ингэж айлдав:

“–Ухуд аа, тайвшир! Чиний дээр нэгэн пайгамбар, нэгэн үнэнч ба хоёр шэхид байна.” (Бухарий, Амхабу’н-Нэбий, 6; Тирмизий, Мэнакиб, 18/3703; Нэсаи, Ахбас, 4)

Хазрат-и Умар -радъяллахү анх- ч:

“Аллах минь, намайг замд чинь шэхид болох ба Элчийн чинь нутагт амиа өргөж баярлуулах болтугай!” гэж хүсэн ерөөдөг байв. (Бухарий, Фэдаилү’л-Мадина, 12) Аллах түүнд иим шагнал хайрлав. Хазрат-и Умарын охин Хафса эх маань ингэж хэлнэ:

“Аавынхаа энэ залбирлыг сонсохдоо би ихээр гайхаад:

«–Энэ нь яаж болох вэ? Мадинад нас бармаар ч шэхид болмоор ч байна!» гэлээ.

«–Аллах хүсвэл чадна,» гэв.”

Хазрат-и Умарыг шэхид болтол хүмүүсийн гайхалт нь үргэлжилсэн ба үүнийг яаж хэрэгжихийг байнга сонирхсоор байв. (Ибн-и Хажар, *Фэтху’л-Барий,* IV, 101)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- мусульман бүрийн шэхид болохыг хүсэх хэрэгтэйг зааж ингэж айлдав:

“Аллах Таалагаас чин сэтгэлээрээ шэхид болохыг хүссэн хүн орондоо нас барсан ч Аллах түүнд шэхидийн байр суурийг хайрлаж өгнө.” (Мүслим, Имарэ, 157; Нэсаи, Жихад, 36)

“Шэхид болохыг чин сэтгэлээрээ хүссэн хүн, шэхид болохгүй байсан ч ач буянд нь хүрнэ.” (Мүслим, Имарэ, 156)

Мөн түүнчлэн Аллахын Элч хэсэг хүмүүсийг ч шэхид гэж үздэг байв. Жишээлбэл нэг удаа асхабтаа:

“–Та хэнийг шэхид гэж тоолдог вэ?” хэмээн асуусан байв.

Сахабийчууд:

“–Аяа Расулаллах аа! Хэн нь Аллахын төлөө амиа алдвал, тэр нь шэхид юм!” гэцгээв.

Пайгамбар Эзэн маань:

“–Тэгвэл миний үммэтийн шэхид нэлээд бага юм,” хэмээв.

Асхаб-и кирам:

“–Тийм байвал хэн нь шэхид вэ, аяа Расулаллах?” гэцгээв.

Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Аллахын төлөө үрэгдэгсэд нь шэхид мөн; Аллахын замд нас барсан нь шэхид мөн; тархалтаас нас барсан нь шэхид мөн; гэдэс гүйлгэж нас барсан нь шэхид мөн; уйлж нас барсан нь шэхид мөн,” хэмээв. (Мүслим, Имарэ, 165; Ибн-и Мажэ, Жихад, 17)

Бусад дамжуулсан ярианд ч Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- бараа, цус, шашин ба гэр бүлийнхээ төлөө алагдсан хүн ч шэхид болохыг мэдүүлсэн байдаг.[119]

Пайгамбарын маань Охин Хазрат-и Зэйнэб Мадинад Ирсэн нь

Бэдирт олзноос чөлөөлөгдсөн Пайгамбар Эзний хүргэн Эбү’л-Ас нь Мадинад харьсны дараа эхнэр Зэйнэб -радъяллахү анха-гийн Мадинад очихыг зөвшөөрөв. Бэдирээс сар орчмын дараа Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Зэйд бин Харисагийн хамт Энсараас нэгийг илгээж тэдэнд:

“–Зэйнэбийг таны дэргэд иртэл Е’жиж Хөндийд байж байцгаа. Тэнд Зэйнэбтэй уулзаад түүнийг надад авчирна,” хэмээв.

Эбү’л-Ас нь Зэйнэб -радъяллахү анха-д аавынх нь дэргэд очихыг хэлэв. Тэр ч бэлтгэлээ хийв. Эбү’л-Асын дүү Кинанэ

119. Хар. Бухарий, Мэзалим, 33; Мүслим, Иман, 226; Эбү Давуд, Сүннэт, 28-29; Тирмизий, Дият, 21.

унах тэмээг авчрав. Хазрат-и Зэйнэб бүхээгтэй тэмээ унаж, Кинанэ нум саадгаа мөрөндөө өлгөж, өдрөөр тэмээний ногтыг гилж Маккагаас гарав.

Энэ явдалд Маккагийн мүшрикчүүд дургүйцэж, зарим нь Хазрат-и Зэйнэбийг буцаахаар хөдлөв. Зитува гэдэг газар түүнийг гүйцэж. Хэббар бин Эсвэд нь хэвтэш дотор буй Зэйнэб -радъяллахү анха-д жадаараа цохиж түүнийг нэгэн хадан дээр унагаав. Хазрат-и Зэйнэб тэр үед бие давхар байв. Цус алдаж үрээ тэнд алдав. Хазрат-и Зэйнэб нь маш их зовж байв. Кинанэ сөхөөд саадгаасаа сум гарган:

“–Бүү ойрт! Эсвэл харвана шүү!” гэхлээр ирэгсэд мөрдөхөө болиод харив.

Эбү Сүфьяан нь Курайшийн мүшрикчүүдээс заримын хамт тэнд очоод Кинанэд:

“–Биднийг харвахаа боль! Чамтай ярилцъя!” гэв.

Кинанэ харвахаа байж, Эбү Сүфьяан нь Кинанэгийн дэргэд очоод:

“–Чиний буруу! Нэгэн эмийг ардын нүдний өмнө ил тод замд гаргалаа. Харин чи биднийг Мухаммедаас болж хэчнээн зовсныг мэднэ! Охиныг нь олон түмний нүдэн дээр ийм илэн далангүй бидний дундаас гаргаж Түүн рүү явуулбал тэд биднийг ялагдсан хүчгүйдлийн тэмдэг гэж ойлгох болно. Амиараа тангараг өргөе, Зэйнэбийг хаана байлгах нь бидэнд огт чухал биш. Үүнд бид өшөө авахыг ерөөсөө бодох ч үгүй. Чи намайг сонсоод түүнийг одоо буцааж Маккад аваач! Олны шуугиан хэл ам дарагдсаны дараа түүнийг буцаасан гэж ойлгосны дараа нууцаар Маккагаас гаргаж аавд нь хүргэж өг!” гэв.

Кинанэ ч зөвшөөрчээ. Маккад хэд хоноод эсэргүүцэл намдсаны дараа нэгэн шөнө Хазрат-и Зэйнэбийн хамт замд гарав.

Түүнийг Е’жижид хүлээж байсан Зэйд бин Хариса ба найзад нь гардуулж өгөв. Тэд ч Хазрат-и Зэйнэбийг хүндэт аавынх нь дэргэд авчрав.[120]

Эбү’л-Ас нь хижрэтийн тооллын зургаан онд тэргүүлж байсан Курайшийн нэгэн жингийн хамт дахиад олзлогдов. Үүрийн үеэр Аллахын Элчийн охин Хазрат-и Зэйнэбт мэдээ илгээж; “Аваасаа миний төлөө итгэмж ав!” гэв. Орчлонгийн Хүндэт Эзэн маань мусульманчуудтай өглөөний мөргөл үйлдэж байхад, Зэйнэб толгойгоо өрөөнийхөө үүднээс шагайж:

“–Хүмүүс ээ! Би Расулаллахын охин Зэйнэб юм! Эбү’л-Асыг хамгаалалтдаа авлаа!” гээд дуудав. Пайгамбар Эзэн маань:

“–Чиний хамгаалалтдаа авсан хүнийг бид ч хамгаалалтдаа авлаа!” хэмээв. Аллахын Элчийг дэргэд нь ирэхлээр Зэйнэб -радъяллахү анха-:

“–Эбү’л-Ас манай хамаатан, мөн миний хүүхдүүдийн аав юм. Ийм учраас түүнийг хамгаалалтдаа авлаа!” гэв.

Пайгамбар Эзэн маань мүжахирчуудад:

“–Хэрэв түүнд барааг нь буцааж өгөхийг зохимжтой гэж үзвэл, өгөөрэй! Өгмөөргүй байвал тэд угаасаа таны л эрх юм!” хэмээв.

Мүжахидчууд:

“–Үгүй, аяа Расулаллах аа! Бид барааг түүнд буцааж өгнө!” гэцгээв.

120. Ибн-и Хишам, II, 297-299; Ибн-и Абдилбэр, IV, 1854; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 362-363.

Эбү'л-Ас авсан барааны хамт Маккад харив. Хүн бүрт барааг нь гардуулж ажлаа дуусгасны дараа:

"–Курайшийн нийгэм ээ! Барааг нь өгөөгүй хэн нэгэн бий юү?" гэж асуув.

"–Үгүй! Валлахи байхгүй!" гэцгээв.

Эбү'л-Ас:

"–Би танд амласнаа биелүүлэв үү?" гэж асуув.

"–Тийм! Үнэхээр биелүүлэв! Аллах чамайг буянаар шагнаг! Бид чамайг эрэлхэг ба үнэнч болов!" гэцгээв.

Эбү'л-Ас:

"–Валлахи, таны дэргэд ирэхээс өмнө Мадинад мусульман болоход минь саад болсон нь, намайг таны барааг гардахаар Исламд орсныг бодохоос айж байсан нь юм. Би Аллахаас өөр бурхан үгүй гэрчилнэ, бас Мухаммед Аллахын боол ба Элч буйг ч гэрчилнэ!" гээд Мадинад, Аллахын Элчийн дэргэд буцав.

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- түүнд Зэйнэбийг дахин шинээр гэрлүүлж буцааж өгөв. (Вакидий, II, 553-554; Ибн-и Са'д, VIII, 32-33)

Еврейчүүд ба Бэний Кайнука Газва (2 оны Шэввал / 624 оны 4 сар)

Мадинагийн хавьд нэлээд олноороо байсан еврейчүүд, өмнө нь Арабчуудад нэгэн пайгамбар ирэхийг хэлсээр байв. Түүнийг өөрсдийнхөө дундаас гарахыг бодсон тулд энэ мэдээллийг бишрүүлэн тараахаас татгалздаггүй байв. Харин Төгсгөл Үеийн Пайгамбар Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн тэдний дундаас биш, Арабчуудын

дундаас төрж хүлээн зөвшөөрүүлсэнд атаархалд автацгаав. Тэгээд өмнөх Яриагаа гэнэтхэн өөрчилж Түүний номлолыг үгүйсгэцгээв. Аллах Таала тэдний тухай ингэж айлдана:

وَإِذْ أَخَذْنَا مِيثَاقَ بَنِي إِسْرَائِيلَ لاَ تَعْبُدُونَ إِلاَّ اللّهَ وَبِالْوَالِدَيْنِ إِحْسَاناً
وَذِي الْقُرْبَى وَالْيَتَامَى وَالْمَسَاكِينِ وَقُولُواْ لِلنَّاسِ حُسْناً وَأَقِيمُواْ
الصَّلاَةَ وَآتُواْ الزَّكَاةَ ثُمَّ تَوَلَّيْتُمْ إِلاَّ قَلِيلاً مِّنكُمْ وَأَنتُم مِّعْرِضُونَ

“Дээр үед Бид Исраилынхнаас зөвхөн Аллахад боолчлох, аав-ээждээ, ойр хамаатандаа, өнчдөд, ядуучуудад сайнаар хандана гэж ам авсан ба: «Хүмүүст сайхан үг хэлээд, мөргөлөө үйлдэж, зэкатыг өгцгөө!» хэмээн тушаасан байв. Эцэст нь маш цөөнөөс гадна ихэнх нь нүүр буруулан одов.” (эл-Бакара, 83)

بِئْسَمَا اشْتَرَوْاْ بِهِ أَنفُسَهُمْ أَن يَكْفُرُواْ بِمَا أنَزَلَ اللّهُ بَغْياً أَن
يُنَزِّلُ اللّهُ مِن فَضْلِهِ عَلَى مَن يَشَاء مِنْ عِبَادِهِ فَبَآؤُواْ
بِغَضَبٍ عَلَى غَضَبٍ وَلِلْكَافِرِينَ عَذَابٌ مُّهِينٌ

“Аллахын боолчуудаасаа хүссэн пайгамбарын үүрэг хайрласныг атаархаад Аллахын буулгасан Кур’аныг **үгүйсгэж өөрсдөө ингэж авирласан нь ямар муухай үйл юм бэ! Энэ нь тэдэнд тамлал дээр тамлалтай авчирна. Түүнчлэн кафирчуудад доромжлох харгислал байдаг.”** (эл-Бакара, 90)

Еврейчүүдийн ингэж хандсаны өөр нэгэн учир ч, энэ нас энэ дэлхийн амьдралд шунаж буй нь юм. Уг шинжийг нь ает-и кэримэ ингэж мэдээлнэ:

وَلَتَجِدَنَّهُمْ أَحْرَصَ النَّاسِ عَلَى حَيَاةٍ وَمِنَ الَّذِينَ
أَشْرَكُواْ يَوَدُّ أَحَدُهُمْ لَوْ يُعَمَّرُ أَلْفَ سَنَةٍ

“Расул минь ээ! **Тангараглая, Чи тэднийг хүмүүсийн хооронд дэлхийн амьдралд хамгийн шуналтайг нь олно. Тэд мүшрикчүүдийг ч давж, мянган жил амьдармаар байдаг!..”** (эл-Бакара, 96)

Мөн наймааны зах зээлийг ч эзэлсэн тулдаа эд барааны хүчээрээ ихээр задарсан еврейчүүд өөрсдийгөө давуу үндэстэн гэж үзэж:

نَحْنُ أَبْنَاءُ اللّهِ وَأَحِبَّاؤُهُ

“…Бид Аллахын хүүхдүүд ба амрагууд мөн…” (эл-Маида, 18) гэцгээдэг байв.

Хийсэн муу муухайнаас болж тэдэнд тэнгэрлэг тамлалыг сануулбал ингэж хариулдаг байцгаав:

لَن تَمَسَّنَا النَّارُ إِلاَّ أَيَّاماً مَّعْدُودَةً

“…Тоотой хэдхэн хоногоос гадна гал бидэнд хүрэхгүй юм!..” (эл-Бакара, 80)

Гэтэл Аугаа Эрх үүнийг ингэж болохгүйг уг ает-и кэримэд мэдүүлэв:

بَلَى مَن كَسَبَ سَيِّئَةً وَأَحَاطَتْ بِهِ خَطِيئَتُهُ
فَأُوْلَـئِكَ أَصْحَابُ النَّارِ هُمْ فِيهَا خَالِدُونَ

“Үгүй! Хэн нэгэн муу муухай юм хийж муу муухай нь түүнийг бүрхвэл, тэр нь тамын хүн болно; тэд тэнд үүрд мөнх үлдэгчид мөн.” (эл-Бакара, 81)

Макинагийн еврейчүүд хэдий ч Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-тэй гэрээ хийсэн ч, санаатайгаар Түүнд дайсагнан хандаж байв. Аймгуудын хоорондын маргалдааныг өдөөж, нийгмийн замбарааг эвдэхийг хичээдэг байв. Тэдний энэ байдлыг Аугаа Эрх Элч болон итгэгчддээ ингэж мэдээлэв:

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُواْ لاَ تَتَّخِذُواْ بِطَانَةً مِّن دُونِكُمْ لاَ يَأْلُونَكُمْ خَبَالاً وَدُّواْ مَا عَنِتُّمْ قَدْ بَدَتِ الْبَغْضَاء مِنْ أَفْوَاهِهِمْ وَمَا تُخْفِي صُدُورُهُمْ أَكْبَرُ قَدْ بَيَّنَّا لَكُمُ الآيَاتِ إِن كُنتُمْ تَعْقِلُونَ. هَاأَنتُمْ أُوْلاء تُحِبُّونَهُمْ وَلاَ يُحِبُّونَكُمْ وَتُؤْمِنُونَ بِالْكِتَابِ كُلِّهِ وَإِذَا لَقُوكُمْ قَالُواْ آمَنَّا وَإِذَا خَلَوْاْ عَضُّواْ عَلَيْكُمُ الأَنَامِلَ مِنَ الْغَيْظِ قُلْ مُوتُواْ بِغَيْظِكُمْ إِنَّ اللّهَ عَلِيمٌ بِذَاتِ الصُّدُورِ. إِن تَمْسَسْكُمْ حَسَنَةٌ تَسُؤْهُمْ وَإِن تُصِبْكُمْ سَيِّئَةٌ يَفْرَحُواْ بِهَا وَإِن تَصْبِرُواْ وَتَتَّقُواْ لاَ يَضُرُّكُمْ كَيْدُهُمْ شَيْئًا إِنَّ اللّهَ بِمَا يَعْمَلُونَ مُحِيطٌ

“Еэ итгэгчид ээ! Өөрсдөөс гадны хүнтэй нууцаа хуваагуузай! Учир нь тэд танд муу муухай учруулахаас огт буцахгүй, байнга таныг төвөгт учруулахыг хүснэ. Үнэхээр тэдний өшөө нь амнаас нь гарсан үг бүхэнд **тодорхой болдог. Тэдний зүрхэндээ хадгалсан** өшөө хорсол нь **түүнээс ч түм юм. Хэрэв бодоод ойлгож байвал, Бид аетуудаа танд тайлбарласан байна.**

Та нар, тэднийг танд дургүй байхад тэдэнд хандаж мусульман болохыг хүснэ**. Та хамаг номуудад итгэнэ; тэд бол тантай тааралдахдаа, «Итгэлээ!» гэнэ; өөрсдөө бол танд атаархсандаа хурууны өндгөө хазна. Ингэж хэл: «Өширч** хорсож **үхэх нь үү!» Андашгүй нь Аллах зүрхэн доторх юмыг ёсоороо мэддэг.**

Танд нэгэн сайн сайхан тохиолдвол, энэ тэднийг зовооно; танд ямар нэгэн төвөг тусбал үүнд баясна. Хэрэв тэвчээд ба өөрсдийгөө хамгаалбал, тэдний мэх танд ямар ч аюул хүргэхгүй. Андашгүй нь Аллах тэдний хийснийг бүрэн мэдэж байдаг.” (Ал-и Имран, 118-120)

Ает-и кэримэнүүдийн мэдүүлснээр мусульманчуудад нууц өшөө ба хилэнгээр дүүрэн буй еврейчүүд нь мусульманчуудыг Бэдирийн Дайнд ялахад үнэхээр их сэтгэл санаа гонсойв. Түүнчлэн Бэний Кайнука еврейчүүд энэ тухай эвгүй санаагаа бүр урагшуулан мусульманчуудтай байлдахаар шийдэв. Түрүү нь хийсэн иргэний гэрээг цуцлав.

Тэдний хамгийн дотно анд, мүшрикчүүдийн тэргүүн буй Абдуллах бин Үбэйгийн хамт еврейчүүдийн зах, мусульманчуудын эсрэг төлөвлөсөн мэхээр бузрын төв болсон байв. Тэд мусульманчуудын төлөө ямарч сайн юм бодохгүй байцгаав. Түүнчлэн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн амийг хорохыг ч төлөвлөж байцгаав.

Хэрүүлч зангаа бүр хэтрүүлсэн еврейчүүд нэгэн өдөр тэдний захад үнэт эдлэлийн дэлгүүрээс бараа авсан мусульман нэгэн эмэгтэйг үймүүлэв. Ёсгүй дооромжлох үг хэлцгээв. Тэр эмэгтэйг хашхирахлаар, түүгээр яваад өнгөрч үүнийг гэрчилсэн нэгэн мусульман ч эмэгтэйг хамгаалахаар шууд еврей хүн рүү дайрав. Ингээд хэрэлдэж эхлэв. Мусульман нь дийлж еврейг алав. Тэнд цугласан еврейчүүд ч мусульманыг шэхид болгов. Тэр хавьд эмх замбараагаа нэлээд алдсан байв. Хийсэн иргэний гэрээ бүрэн зөрчсөн байв. Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- еврейчүүдийг цуглуулж:

"–Аяа еврей нийгэм ээ! Тэрээрийн Курайшид хийсэн шигээ танд нэгэн гамшиг буулгахаас болгоомжилж мусульман болцгоо! Та угаасаа намайг илгээсэн нэгэн пайгамбар буйг мэддэг. Үүнийг судартаа ба Аллахын танд өгсөн амлалтад үздэг," хэмээв.

Ингээд тэдэнд хийсэн алдааныхаа хариуг төлөхийг ч энх тайвныг эвдмээргүй буйг ч илэрхийлэв. Араас нь гэрээг шинэчлэхийг санал болгов. Харин еврейчүүд хариугаа их зан гаргаж өгөв:

"–Мухаммед аа! Чи биднийг дайн гэдгийг мэдэхгүй Курайшчуудтай нэг гэж бодов уу? Бид тэднээс ширүүн байлдагчид юм. Бидэнтэй байлдах болбол дайн ямар буйг үзээд ойлгох болно!" гэцгээв.

Тэгэхлээр нь Аугаа Эрх уг аетыг буулгав:

قُل لِّلَّذِينَ كَفَرُواْ سَتُغْلَبُونَ وَتُحْشَرُونَ إِلَى جَهَنَّمَ
وَبِئْسَ الْمِهَادُ قَدْ كَانَ لَكُمْ آيَةٌ فِي فِئَتَيْنِ الْتَقَتَا

"Тэр үгүйсгэгч кафирчуудад ингэж хэл: «Та заавал хожигдох ба цугларч тамыг дүүргэнэ. Тэнд нь маш их хэцүү

юм.» (Бэдирт) **дайралдсан энэ хоёр талын байдалд танд том нэгэн сургаал байдаг...”** (Ал-и Имран, 12-13)[121]

Еврейчүүд дээр үед Хазрат-и Муса -алэйхиссэлам-д:

فَاذْهَبْ أَنتَ وَرَبُّكَ فَقَاتِلا إِنَّا هَاهُنَا قَاعِدُون

“…Чи болон Раб чинь яваад байлд! Бид энд сууна!” (эл-Маида, 24) гээд тэнгэрлэг ялалтыг хүртэх нэгэн жихадыг үгүйсгэсэн байхад, одоо яг эсрэгээр нь өөрсдийн эсрэг болох нэгэн дайныг бараг сандрангуй ба мунхаг зоригоор хүсдэг байв.

Ингээд гэрээг цуцлангуутаа мусульманчуудад дайн зарласнаар еврейчүүдийн хандлага өшөөтэй зорилтоо бүрэн ил гаргасан байв. Ийм тохиолдолд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хазрат-и Алиг туг баригч болгож Кайнука еврейчүүд рүү дайрав. Тэд хэрэмдээ хаагдав. Мүнафикчуудын хамт мусульманчуудын эсрэг олон юм төлөвлөсөн боловч, хэрмээс ч гарч чадаагүй, ганцхан нум сум ч харваж чадаагүй. Учир нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэг талаас тэднийг бат бүсэлснээр үл барам, нөгөө талаас мүнафикчуудын эсэргүүцэх магадлалыг бодон хамаг арга хэмжээгээ авсан байв.

Еврейчүүдэд хэрэмдээ хадгалахыг, тэргүүн мүнафик Абдуллах бин Үбэй хэлсэн ба өөрсдийнхөө ч тэдэнтэй хамт болохыг мэдүүлсэн байв. Харин мүнафикчуудын тэргүүн айснаасаа энэ амлалтаа биелүүлж чадаагүй ба тэднийг ганцаар нь үлдээв.

121. Хар. Эбү Давуд, Хараж, 21-22/3001.

Бүслэлт арван таван хоног үргэлжлэв. Эцэст нь ямар ч арга олсонгүй еврейчүүдийн зүрхэнд том нэгэн айдас унав. Найдан хүлээсэн тусламж ч ирээгүй байхад өршөөл гуйхаас өөр аргагүй болцгоов. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн олгох ялыг үг дуугүй дагав.

Кайнукачууд өмнө нь Хазраж аймагтай гэрээтэй байсан тул, мүнафикчуудын тэргүүн Хазраж Абдуллах бин Үбэй тэд-ний төлөө өршөөл гуйв. Учир нь ёс заншлаар бодвол тэднийг алах хэрэгтэй байв.

Харин хүмүүс олон дахин өршөөл гуйсан тул Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэднийг алаагүй. Ял олгож тэднийг Сирийн тийш цөлөв. Вади’л-Курад очихоор тэд нэг сар сууцгаав. Вади’л-Курагийн еврейчүүд тэдний алхагчдад унаа, тэдэнд хоол хүнс олгов. Дараа нь замдаа үргэлж явсан Кайнукачуудын амьдрал нь тэдний очсон газар ч их удаагүй.[122]

Сэвикийн Дайн (2 оны Зилхижжэ / 624 оны 5 сар)

Эбү Жэхилийг алагдахад Эбү Сүфьяан Курайшийн тэргүүн болов. Бэдирийн ялагдлын өшөөг авахын тулд тангараг өргөж, даруй хоёр зуун морьтны хамт айдастайгаар Маккагаас замд гарав. Мадинагаас цагийн зайтай газар хүрч ирэв. Шөнийн харанхуйг ашиглан Бэний Надир еврейчүүдийн нутаг хүртэл явав. Тэднийг тэргүүн ба сангийн хамгаалагч Сэллам бин Тишкэмийг гэрт хүргэв. Сэллам нь Эбү Сүфьяаныг идүүлж уулгаад сайхан дайлав. Мусульманчуудын зарим нууц шин-жийн тухай зарим мэдээ ярьж өгөв.

Эбү Сүфьяан тэндээс салж найзуудынхаа дэргэд очив. Энсараас Са’д бин Амрыг алж хасарвааны хэдэн талбайд

122. Ибн-и Хишам, II, 426-429; Вакидий, I, 176-180; Ибн-и Са’д, II, 28-30.

түймэр гаргав. Эбү Сүфьяан үүнтэйгээр тангаргаа биелүүлснээ бодож ба мөрдөгдөхөс айгаад шууд буцаад явав. Байдлыг дуулсан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнийг мөшгөж эхлэв. Мүшрикчүүд амархан зугтаж чадахын тулд олон олон шуудайн хуурсан гурил (сэвик үлдээсэн байв. Ийм учраас энэ дайныг “Сэвикийн Дайн” гэцгээв.[123]

Хазрат-и Али ба Хазрат-и Фатимагийн Гэрлэсэн нь

Хижрэтийн тооллын хоёр онд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн охин Фатима -радъяллахү анха- ба Хазрат-и Али -радъяллахү анх- гэрлэв.

Хазрат-и Фатимад өмнө нь Хазрат-и Эбү Бэкир ба Хазрат-и Умар мэт Курайшийн хүндэт хүмүүсээс олон нь нэр оруулаад, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Би түүний тухай тэнгэрлэг шийдвэрийг хүлээнэ,” хэмээсэн байв. Ийм учраас Хазрат-и Али -радъяллахү анх- хамаатан Хашимынхны санаачилсан ч тэгэхэд зориглож чадаагүй байв. Хэсэг хугацааны дараа хамаатныхаа албадсанаар Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн онгонд гарав.[124]

Хазрат-и Али -радъяллахү анх- цаашийг нь ингэж ярина:

“Эцэст нь би Аллахын Элчийн онгонд гарлаа. Өөрөө хамаг хүндэтгэмээр дүр төрхөөрөө сууж байв. Би өмнө нь суугаад чимээгүй байв. Ярьж чадаагүй. Надад:

«–Яагаад ирээ вэ, ямар нэгэн хэрэгцээ бий юү? Фатимаг гуйх нь уу!» хэмээв. Би зөвхөн; «Тийм!» гэж чадлаа.” (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* III, 379)

123. Ибн-и Хишам, II, 422-423; Вакидий, I, 181-182; Ибн-и Са’д, II, 30.
124. Ибн-и Са’д, VIII, 19.

Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-ын зөвшөөрснөөр Хазрат-и Али -радъяллахү анх- зарим бараагаа зараад 480 дирхэм мэхир бэлтгэв. Аллахын Элч үүний гуравны хоёроор сайхан үнэр, гуравны нэгээр ч хувцас авахыг нь хэлэв.[125]

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Фатима -радъяллахү анха-д инж болгож хилэн нэгэн дэвсгэр, усны сав ба өвсөөр чихсэн нэгэн дэр өгөв.[126] Билал Хабэшийд ч:

"–Билал аа! Би гэрлэхэд хоол идүүлэхийг миний үммэт заншихыг хүснэ!" хэмээж хоол бэлтгэхийг хүсэв. Тэгэхлээр нь Хазрат-и Али хуягаа нэгэн еврейд барьцаа болгож хагас хэмжээний арвай авав. Хуримын хоол нь "хайс"[127] гэж мэдсэн амтат нэгэн төрлийн хоолоор бүрдсэн байв. Мухажирчууд ба Энсар нь хэсэг хэсгээр ирээд хоол идэж тарав. (Ибн-и Са'д, VIII, 23; Абдүррэззак, V, 487; Диярбэкрий, I, 411)

Оршигчдын Туяа нь нэгэн саваар ус авчраад абдэст авав. Хазрат-и Алиг дуудав. Абдэстын уснаас түүний цээж болон хоёр далны дунд нь цацав. Дараа нь Фатима -радъяллахү анха-г дуудав. Түүнд тэр чигээр хийсний дараа түүнийг гэрийн хамгийн буянтай нь гэрлүүлснээ илэрхийлэв. Фатима ба Алигийн тухай өмнө ба араас нь:

"Аяа Аллах минь ээ! Тэр ба удмынх нь тухай хөөгдсөн шэйтанаас Чамд хоргодъё!" хэмээн залбирав. (Ибн-и Са'д, VIII, 24; Диярбэкрий, I, 411)

125. Ибн-и Са'д, VIII, 19.

126. Нэсаи, Никах, 81.

127. Энэ нь ясыг нь гаргасан хасарваан, цэвэр тос ба шүүсэн таргыг холиод хийдэг хоол байв. Заримдаа хуурсан гурил ч нэмдэг байв.

Пайгамбар Эзэн маань охин Фатимад гэрийн ажлыг, хүргэн Алид ч гадны ажлыг зөвлөв.[128]

Үсамэ бин Зэйд -радъяллахү анх- ярина:

“Би Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд сууж байлаа. Али ба Аббас -радъяллахү анхүмаа- ирээд онгонд нь орох зөвшөөрөл эрэв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Яагаад ирснийг нь мэднэ үү?» хэмээв.

«–Үгүй, би мэдэхгүй!» гэлээ.

«–Харин би мэднэ, тэдэнд зөвшөөрөл олго!» хэмээв. Би дотогш дуудаад, тэд оров.

«–Аяа Аллахын Элч ээ! Гэрээсээ хэнийг Чамд илүү энхрий дотно болохыг асуухаар ирлээ!» гэцгээв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Фатима бинт-и Мухаммед,» хэмээв.

«– гэр бүлээсээ хэнд хайртай буйг чинь асуугаагүй. Тэднээс гаднах хамаатнаас хэнд хайртай буйг чинь асуулаа,» гэцгээв.

«–Миний гэрээс надад хамгийн хайртай санагдсан нь, Аллахын хайрласан минйи чөлөөлж өргөн аваад дайлсан Үсамэ мөн!» хэмээв.

«–Тэгвэл дараа нь хэн?» гэцгээв.

«–Али!» хэмээв. Тэгэхлээр нь авга ах нь Аббас -радъяллахү анх-:

«–Аяа Аллахын Элч ээ! Авга ахаа хамгийн сүүлд үлдээв!» гэлээ.

128. Касаний, IV, 24.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Али хижрэтэд чамаас өмнө хандав!» гэсэн хариу өгөв.” (Тирмизий, Мэнакиб, 40/3819)

Ибн-и Аббас -радъяллахү анхүмаа- ингэж ярина:

“Пайгамбар Эзэн маань газар дээр дөрвөн зураас татаад:

«–Энд юу зурсныг минь мэдэв үү?» хэмээн асуув.

Сахабийчууд:

«–Аллах болон Элч нь сайн мэднэ,» гэцгээв.

Тэгэхлээр нь Пайгамбар Эзэн маань:

«–Диваажингийн эмэгтэйчүүдээс хамгийн эрдэмт нь Хатижа бинт-и Хүвэйлид, Фатима бинт-и Мухаммед, Мэрьем бинт-и Имран ба Фароны хатан Асия бинт-и Музахим юм,» хэмээв.” (Ахмад, I, 293)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- гэр бүлийнхээ боловсрол, сүнсний хүмүүжил ба мөнхийн амьдралд бэлтгэх тухай чамбай ханддаг байв. Жишээлбэл Ахзаб Сурагийн:

يَا نِسَاء النَّبِيِّ لَسْتُنَّ كَأَحَدٍ مِّنَ النِّسَاء إِنِ اتَّقَيْتُنَّ فَلَا تَخْضَعْنَ بِالْقَوْلِ فَيَطْمَعَ الَّذِي فِي قَلْبِهِ مَرَضٌ وَقُلْنَ قَوْلًا مَّعْرُوفًا. وَقَرْنَ فِي بُيُوتِكُنَّ وَلَا تَبَرَّجْنَ تَبَرُّجَ الْجَاهِلِيَّةِ الْأُولَى وَأَقِمْنَ الصَّلَاةَ وَآتِينَ الزَّكَاةَ وَأَطِعْنَ اللهَ وَرَسُولَهُ إِنَّمَا يُرِيدُ اللهُ لِيُذْهِبَ عَنكُمُ الرِّجْسَ أَهْلَ الْبَيْتِ وَيُطَهِّرَكُمْ تَطْهِيرًاوَقَرْنَ فِي بُيُوتِكُنَّ وَلَا تَبَرَّجْنَ تَبَرُّجَ

الْجَاهِلِيَّةِ الْأُولَى وَأَقِمْنَ الصَّلَاةَ وَآتِينَ الزَّكَاةَ وَأَطِعْنَ اللّٰهَ وَرَسُولَهُ
إِنَّمَا يُرِيدُ اللّٰهُ لِيُذْهِبَ عَنكُمُ الرِّجْسَ أَهْلَ الْبَيْتِ وَيُطَهِّرَكُمْ تَطْهِيرًا

“Аяа Пайгамбарын хатнууд аа! Та эмэгтэйчүүдээс хэн нэгэн биш юм. Хэрэв Аллахаас **айж байвал,** гадны эрчүүдэд **сэтгэл татам байдлаар битгий ярь; тэдний зүрхэнд найдвар төрнө. Сайхан үг хэлээрэй! Мөн нэр хүндээрээ гэртээ байж байгаад, түрүүний мунхаг үеийн гарах шиг чимэглэж битгий гараарай! Мөргөл үйлдэж, зэкат өгч Аллах болон Элчийн х нь үгэнд ороорой. Аяа гэрийн хүмүүс! Аллах танаас нүгэлийг арилгаж таныг цэвэр цэмцгэр болгомоор байна,”** (эл-Ахзаб, 32-33) ает нь буусны дараа Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- зургаан сарын турш өглөөний мөргөл явахдаа Хазрат-и Фатимагийн үүдэнд очоод:

“*–Мөргөлд босоорой аяа Эхл-и Бэйт! **«Аллах танаас нүгэлийг арилгаж таныг цэв цэвэр болгомоор байна,»**”* хэмээдэг байв. (Тирмизий, Тэфсир, 33/3206)

Дахиад мөнхийн амьдралын хамгийн чухал хөрөнгөөс нэгэн буй тэхэжжүд мөргөлийн төлөө Пайгамбар Эзэн маань зарим шөнө Хазрат-и Али ба Фатимагийн хаалгыг тогшиж:

“–Мөргөл үйлдэхгүй юу?” хэмээдэг байв. (Бухарий, Тэхэжжүд, 5)

Энэ тухай Хазрат-и Али -радъяллахү анх- анхаарал татам энэ байдлыг дамжуулна:

“Фатима гэртээ аавдаа хамгийн хайртай нь байв. Тээрэм эргүүлсэн тул гарт нь, дутмаар ус зөөсөн тул хүзүүнд нь шарх гараад, гэрийг шүүрдсэн тул хувцас нь тоосоор булдаг байв. Нэг удаа Аллахын Элчид зарим боол авчруулсан байв. Фатимад:

«–Аавдаа очоод нэгэн боол гуйхгүй юү!» гэлээ.

Фатима очоод -алэйхиссалатү вэссалам- Эзнийг маань хажуугийн зарим хүмүүстэй ярьж буйг хараад буцав. Дараах өдөр Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Фатимад ирээд:

«–Миний охин, чиний хэрэгцээ юу байв?» хэмээн асуув. Фатима дуугаа байж хариу өгөөгүй. Би хооронд нь ороод:

«–Би яриад өгье, аяа Аллахын Элч ээ!» гээд ярилаа. Тэгэхлээр минь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Еэ Фатима! Аллахаас ай! Аллахын фарзыг хэрэгжүүл! Гэрийнхээ ажлыг хий! Орондоо хэвтэхдээ гучин гурван удаа сүбханаллах, гучин гурван удаа эл-хамдү лиллах, гучин гурван удаа Аллаху экбэр гэ! Ингээд нийт зуу болно. Энэ нь чиний хувьд үйлчлэгчээс илүү буянтай," хэмээв.

Фатима -радъяллахү анха-:

«–Би Аллах болон Элчид талархаж байна!» гэв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнд үйлчлэгч өгөөгүй." (Эбү Давуд, Хараж, 19-20/2988)

Өөр нэгэн ярианд Оршигчдын Туяаг эдгээрийг хэлснийг ч дамжуулна:

"–Валлахи Эхл-и Сүффэ өлссөнөөсөө хэвэлдээ чулуу уяад би ч тэдэнд зарцуулах юм олж чадахгүй байхдаа танд үйлчлэгч олгож чадахгүй. Боолчуудын хариунд төлбөр аваад энэ орлогыг Асхаб-и Сүффэгийн төлөө л хэрэглэнэ." (Ахмад, I, 106)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн чөлөөлсөн Сэвбан -радъяллахү анх- ярина:

Аллахын Элч аянд гарахдаа гэр бүлээсээ хамгийн сүүлд охин Фатима -радъяллахү анха-тай салалцдаг байв. Харихдаа бол анх уулзсан нь дахиад Фатима болдог байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- дахиад нэгэн аялалаас харьсан байв. Фатима ч үүдэндээ нэгэн хөшиг өлгөсөн, бас Хасан Хүсэйн хоёрт мөнгөн хоёр бугуйвч зүүсэн байв. Пайгамбар Эзэн маань Фатимагийн гэрт ирээд, харин ороогүй байв. Фатима нь Расулаллах гэртээ орохгүйн учрыг, Түүний харсан зүйл буйг ойлгов. Зууд хөшгийг урж, хүүхдүүдийн гараас мөнгөн бугуйвчийг тайлж гаргав. Эдгээрээс нэгийг хоёр хүүдээ хуваалцав. Хасан Хүсэйн хоёр уйлаад Расулаллахын дэргэд очив. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- энэ хоёр бугуйвчийг аваад:

“–Сэвбан аа! Эдгээрийг тэр айлд аваач. Хасан ба Хүсэйн нь миний Эхл-и Бэйтээс юм. Аугаа Эрхийн тэдэнд хайрлах гоо сайхныг дэлхийн амьдралд идээд барахыг нь би хүсэхгүй. Сэвбан аа! Фатимад ясаар хийсэн нэгэн зүүлт ба (хүүхдүүдэд) дахиад ясаар хийсэн хоёр бугуйвч худалдаж ав!” хэмээв. (Эбү Давуд, Тэрэжжүл, 21/4213)

Эхл-и Бэйт ба Эхл-и Бэйтийн Хайр

Эхл-и Бэйт нь нэг гэрт амьдарч буй гишүүн гэсэн утгатай. Пайгамбар Эзний маань гэр бүлийн гишүүдийн бүхнийг илэрхийлнэ. Энэ талаараа Эхл-и Бэйт нь Хүндэт Элч Эзний маань гэр бүл, Али, Жафар, Акил, Аббас ба тэдний гэр бүлийнхэн юм. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-п салат ү сэлам хэлэх нь хамаг итгэгчдийн үүрэг буй шигээ Эхл-и Бэйтийг хүндэтгэх ба хайраар холбох нь ч хамаг итгэгчдийн үүрэг юм.[129]

129. Ахмад, VI, 323.

Аллахын Элчийн Эхл-и Бэйтэд зэкат авах нь харам юм. Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- нэгэн өдөр Хазрат-и Хасаны Бэйтүлмал буюу улсын сангийн зэкат хасарваанаас нэгэн ширхэгийг амандаа хийснийг харав. Яаралтай түүнийг амнаас нь гаргаж:

"–Мухаммедын гэр бүл зэкат иддэггүйг мэдэхгүй юү?" хэмээв. (Бухарий, Зэкат, 57; Ахмад, I, 200)

Зэйд бин Эркам -радъяллахү анх- ингэж хэлэв:

"Нэгэн өдөр Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Макка Мадина хоёрын хоорондох Хумын усан дээр босоод бидэнд үг хэлэв. Аллахад хамд магтаал хийсний дараа бидэнд сургаал хэлэв. Дараа нь ингэж айлдав:

«–Хүмүүс ээ! Би ч нэгэн хүн мөн. Удахгүй Раббын минь элч надад ч ирээд би түүний урилгыг дагаж явна. Танд чухал хоёр юм үлдээнэ. Нэг нь хүнийг зөв хүргэх удирдамж ба туяа буй Аллахын Судар Кур'ан юм. Түүнд наалдаад бат бариарай!..»

Хазрат-и Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам- Кур'ан-и Кэримийг барих ба түүнд холбогдох тухай сургаал хэлэд өгөв. Дараа нь яриагаа ингэж үргэлжлүүлэв:

«–Танд Эхл-и Бэйтийгээ үлдээнэ. Аллахаас айгаад Эхл-и Бэйтэд минь хүндэтгэн хандаарай! Аллахаас айгаад Эхл-и Бэйтэд минь хүндэтгэн хандаарай!»"

"–Пайгамбарын Эхл-и Бэйт хэн бэ, Зэйд ээ!? Хатад нь ч Эхл-и Бэйтээс нь биш үү?" гэж асуувал Зэйд:

"–Хатад нь ч Эхл-и Бэйтээс нь мөн. Харин Түүний жинхэнэ Эхл-и Бэйт нь Түүний дараа ч хандив авах нь харам буй хүмүүс юм," гэв.

"–Хандив авах нь хориотой хүмүүс хэн бэ?" гэж асуув.

"–Али, Акил, Жафар ба Аббасын гэр бүл юм," гэж хариулав. (Мүслим, Фэдаилү'с-Сахаба, 36)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

"Аллахыг шимээ буулгасны тулд хайрла. Намайг ч Аллахыг хайрласан тулдаа хайрла. Эхл-и Бэйтийг минь ч намайг хайрласны тулдаа хайрла!" (Тирмизий, Мэнакиб, 31/3789)

Дахиад нэгэн өдөр Пайгамбар Эзэн маань ариун зээ Хасан Хүбэйн нарын гараар барьж ингэж айлдав:

"Хэн нь намайг, энэ хоёрыг, энэ хоёрын аав ба ээжийг хайрлавал киямат өдөрт надтай хамт байх болно." (Тирмизий, Мэнакиб, 20/3733)

Асхаб-и кирам нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн садан хамаатанд агуу хайраар ханддаг байв. Учир нь хайрт нь хайрынхаа хэрээр түүний андуудыг, үйлчлэгчдийг, идсэн хоолыг, өмссөн хувцсыг, товчоор хэлбэл түүнтэй хамаатай ба түүнийг сануулах хамаг юмыг хайрлана. Хайр нь ихсэхэд энэ амрагийн эргэн тойргийн хамаг юмд нэвтэрнэ.

Аллахын Элчийг аминаасаа илүү хайрласан шилмэл сахаба хазрат ч Аллахын Элчийн ойроос нэгэн унаандаа унах болбол шууд дөрөөг нь барьдаг байв.[130] Киямат өдөрт бүхний хамаатны холбоо тасарч зөвхөн Түүний хамаатны холбоо нь үргэлжлэхийг мэдсэн тулдаа, Хазрат-и Пайгамбарын хамаатнаас хэн нэгэнтэй гэрлээд Түүнтэй хамаатны холбоотой байхыг чин сэтгэлээрээ хүсдэг байв.[131]

Аллахын Элчийн ариун удмын хүмүүс манай өдөрт Исламын тусгай газруудад амьдардаг. Хүсэйн -радъяллахү анх-

130. Хэйсэмий, IX, 348.

131. Хэйсэмий, IX, 173.

ын удмынхныг “Сэйид”, Хасан -радъяллахү анх-ын удмынхныг ч “Шэриф” гэдэг. смант Гүрнийхэн сэйидчүүдэд ноён гэсэн утгаар “эмир”, толгойд ороосон ногоон ороолтыг ч “эмирийн ороолт” гэдэг байв. Оршигчдын Туяаны удмаас ирсэн эмэгтэйчүүд ч толгойдоо ногоон нэгэн им зүүдэг байв.

Усмантчууд нь Эхл-и Бэйтэд үйлчлэхийг үнэт нэгэн үүрэг гэж үзсэн бөгөөд үүний төлөө албан нэгэн орон зориулсан байв. Усмантын Гүрэнд Эхл-и Бэйтийн хэргийг хариуцах албатан нь Пайгамбар Эзний маань удмаас сонгогдож Эхл-и Бэйтийн хамаг хэргийг хариуцдаг; удмын дэвтэрийг барьдаг, төрөх ба нас барахыг нь дэвтэрт оруулаад, тэдний хамаагүй ажилд ороход нь саад болж, олзноос тэдний хувьд таарсныг нь тарааж, эмэгтэйчүүдтэй асуулгүй дураар гэрлэхийг зөвшөөрөхгүй байв.[132]

Эхл-и Бэйтийн албатан нь Пайгамбарын хүүхдүүдийн ерөнхий хамгаалагчийн оронд бөгөөд, хариуцсан үүргийнхээ нэр алдраас болж хамгийн өндөр зэргээс нэгийг эзэмших ба ёслолд калифын дараа хоёр дахь дараалалд оршдог байв. Шинэ хаан ширээнд өргөгдөхөд эзэнд эхлээд энэ хүн бий’ат хийж залбирдаг, дараа нь бусад хүмүүс бий’атаа илэрхийлдэг байв. Баярын мэнд айлтгах ёслолд ч энэ албатан түрүүлдэг байв. Энэ хоёр ёслолд ч хаан нь энэ хүнийг ороход босдог байв.

Сэйид ба шэрифчүүдийг хууль ба заншлын эсрэг хандсан тохиолдолд, Истанбул дахийг нь уг албатан, бусдыг бол сумын дарга нар ялладаг байв. Яллах болоход эхлээд толгой дахь ногоон ороолтыг нь аваад үнсдэг; яллах үйл дууссаны дараа ороолтыг дахиад буцааж өгдөг байв.

132. Мэхмэт З. Пакалын, II, 647.

ХИЖРЭТИЙН ГУРАВ ДАХЬ ЖИЛ

Сургаалаар Дүүрэн Нэгэн Дайн: УХУДЫН ГАЗВА
(3 Оны Шэввал сарын 7 / 625.3.23)

Ухудын[133] Газва ч Бэдир шиг Маккагийн мүшрикчүүдтэй хийсэн аймшиг нэгэн дайн бий. Хижрэтийн гурав дахь жилийн Шэввал сард болсон билээ.

Маккагийн мүшрикчүүд Бэдирт ялагдсаны дараа уй гашуудлаар дүүрэн байв. Хүн бүр нь нэгэн хамаатнаа алдсан байв. Түүний өшөөг авах хилэнгээр дүүрэн байв. Курайшийн шинэ тэргүүн Эбү Сүфьяны эхнэр Хинд ч эднийг тэргүүлж байв. Эцэст нь их удалгүй зүрх нь өшөөний галаар ассан мүшрикийн гурван мянгат цэрэг бэлдэв. Цэргийн хэрэгцээнд Эбү Сүфьяны Бэдирийн Газвагаас аварч чадсан жингийн барааг хэрэглэв. Ойр хавийн Арабчуудаас ч тусламж нэхэв.[134]

Энэ хооронд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн авга ах Аббас, энэ бүхнийг Маккад мэдээлэв.[135] Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч даруй дайны хурлыг цуглуулав. Мадинагийн дотор байж байгаад хамгаа-

133. Ухуд нь Мадинагийн хойд талд оршдог бөгөөд зай нь нэгэн мил орчим байдаг.

134. Вакидий, I, 199-203.

135. Ибн-и Са’д, II, 37.

лалт дайн эсвэл хотоос гараад довтолгооны дайн хийх тухай зөвлөлцөв. Өөрөө бол хамгаалах дайн хийх санаатай байв.[136]

Харин Бэдирийн Газвад оролцоогүй залуус ба Хазрат-и Хамза мэт зоригтнуудын саналаар хотоос гараад довтолгоо хийх шийдвэр гарав.[137] Түүнчлэн тэдний зарим нь:

“–Бид ийм нэгэн өдрийг тэсэн ядан хүлээж байлаа!” гэцгээв.

Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- жаргалын өргөөндөө ороод хуягаа өмсөв. Харин энэ хооронд Мадинад байж байгаад хамгаалах дайн хийхийг дэмжигчид бусдыг ятгасан байв. Са’д бин Муаз ба Үсэйд бин Худайр:

“–Мадинагаас гармааргүй байхад та Аллахын Элчийг албадаад байлаа. Харин Түүний тушаал тэнгэрээс буудаг. Та энэ шийдвэрийг Түүнд үлдээгээрэй. Түүний тушаасныг хийцгээ!” гэцгээв. (Вакидий, I, 213-214)

Тэд ч шууд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- рүү гүйгээд:

---

136. Энэ нь Эзний маань харсан нэгэн зүүдтэй холбоотой байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- дараа нь ингэж айлдсан байдаг: *“...Зүүдэндээ өөрийгөө сэлэм цавчиж байхдаа харсан. Сэлмийн үзүүр тасархай байв. Энэ нь Ухудын Дайнд мусульманчуудын автсан төвгийн бэлгэ тэмдэг ажээ. Дараа нь сэлмээ дахиад цавчив. Энэ удаа сайн байдалд оров. Энэ ч Аугаа Эрхийн ялалт хайрлах ба мусульманчуудыг нэг доор цуглуулах талаар хайрласан шимийн бэлгэ тэмдэг болов. Ижил зүүдэндээ үхэр ба Аллахын (олгосон өөр нэгэн) буяныг ч харлаа. Үнэр нь Ухудын өдөрт итгэгчдээс хэсэг хүмүүст таарав, (тэд шэхид болов. Миний харсан) буян бол Аллахын Бэдирийн дараа хайрласан ялалтын буян ба Раббынхаа бидэнд хайрласан (Бэдирт Тэвчих) үнэнчийн буянаар илрэв.”* (Бухарий, Табир, 39, 44; Мэнакиб, 25; Мүслим, Рүяа, 20)

137. Ибн-и Хишам, III, 6-7.

“–Аяа Расулаллах аа! Бид таны саналыг эсэргүүцэхгүй. Бид алдаа хийлээ. Та хүссэнээрээ хандаарай!” гэцгээв.

Аллахын Элч лав хариу өгөв:

“–Нэгэн пайгамбар хуягаа өмссөний дараа байлдахгүйгээр тайлахгүй! Намайг танд юу тушаавал тэгэхийг бодцгоо! За, одоо Аллахын нэрээр явцгаа! Хэрэв тэсээд шиpгээ хийвэл Аллах Таала ялалтыг дахиад танд хайрлах болно!” (Вакидий, I, 214; Ибн-и Са’д, II, 38)

Тэгээд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- жума мөргөлийн дараа Мадинад Абдуллах бин Үмм-и Мэктүмийг төлөөлөгчөөр үлдээж мянгат цэргээрээ замд гарав. Харин замд мүшрикчүүдийн тэргүүн Абдуллах бин Үбэйгийн гурван зуун дэмжигчдийн хамт харихад нь Исламын цэргийн тоо долоон зуунд хүрэв. Аугаа Эрх үүн тухай уг ает-и кэримэг буулгав:

وَمَا أَصَابَكُمْ يَوْمَ الْتَقَى الْجَمْعَانِ فَبِإِذْنِ اللّهِ وَلِيَعْلَمَ الْمُؤْمِنِينَ.
وَلْيَعْلَمَ الَّذِينَ نَافَقُواْ وَقِيلَ لَهُمْ تَعَالَوْاْ قَاتِلُواْ فِي سَبِيلِ اللّهِ
أَوِ ادْفَعُواْ قَالُواْ لَوْ نَعْلَمُ قِتَالاً لاَّتَّبَعْنَاكُمْ هُمْ لِلْكُفْرِ
يَوْمَئِذٍ أَقْرَبُ مِنْهُمْ لِلإِيمَانِ يَقُولُونَ بِأَفْوَاهِهِم
مَّا لَيْسَ فِي قُلُوبِهِمْ وَاللّهُ أَعْلَمُ بِمَا يَكْتُمُونَ

“Хоёр ангийн тааралдсан өдөр танд тохиолдсон нь зөвхөн Аллахын зөвшөөрлөөр болсон бөгөөд, энэ бол итгэгчдийг ялгах ба мүнафикчуудыг ил гаргах учиртай байв. Тэдэнд:

«–Ирээд Аллахын замд байлд эсвэл ядаж хамгаалалт хийцгээ!» гэхлээр:

«–Байлдахыг мэдсэнсэн бол, мэдээж таны араас явах байлаа!» гэцгээв. Тэд тэр өдөр күфүрт итгэлээс ойр байцгаав. Амаараа сэтгэлдээ байгааг нууж хэлж байцгаав. Гэтэл Аллах тэдний дотроо нуусныг илүү сайн мэддэг.” (Ал-и Имран, 166-167)

وَإِذْ غَدَوْتَ مِنْ أَهْلِكَ تُبَوِّئُ الْمُؤْمِنِينَ مَقَاعِدَ لِلْقِتَالِ
وَاللّٰهُ سَمِيعٌ عَلِيمٌ. إِذْ هَمَّت طَّآئِفَتَانِ مِنكُمْ أَن تَفْشَلاَ
وَاللّٰهُ وَلِيُّهُمَا وَعَلَى اللهِ فَلْيَتَوَكَّلِ الْمُؤْمِنُونَ

“ Расул минь ээ! **Чи өглөө эртхэн итгэгчдийг байлдах байранд суулгахаар гэр бүлээсээ салсан байв. Аллах ёсоороо сонсдог, мэддэг. Тэр үед таны дундаас хоёр бүлэг эвдрэх болсон байв. Харин Аллах тэдний туслагч байв. Итгэгчид зөвхөн Аллахад найдаж итгэг!”** (Ал-и Имран, 121-122)

Мүнафикчуудын цэргээс салсан нь нэг талаар тэнгэрлэг нэгэн бэлэг болсон байв. Тэдний ингэснээр цэрэг хүчээ алдаагүй, эсрэг нь дотуур буй хоёр нүүртэй ба эргэгч зүрхнүүдээс арилсан, ингээд сүнсний талаараа бүр чийрэг байдалд орсон байв. Учир нь тэдний байлдааны үед урвасан нь илүү аюултай байж мэдэх ба итгэгчдийг зоригийг донсолгож мэдэх байв.

Асхабын Шэхид Болох Хайр

Энсараас Сэлимэгийнхний тэргүүн Амр бин Жэмүх нь доголон хүн байв. Өөрөө дөрвөн хөвүүнтэй бөгөөд Аллахын Элчийн

хамт дайнд оролцдог байцгаав. Хүндэт Элч Эзэн маань Ухудын Газвад гарах болсонд Амр ч аянд явах юмсан. Хөвүүд нь:

"–Чи жихадын хариуцлага үгүй. Аллах Таала чамайг шалтгаантай гэж хүлээж авав. Бид чиний байранд явна," гэцгээв.

Амр:

"–Та Бэдирийн өдөр миний диваажинд ороход саад болов. Валлахи би өнөөдөр амьд үлдсэн ч нэгэн өдөр заавал шэхид болж диваажинд орно!" гэв. Дараа нь эхнэртээ ч:

"–Хүн бүр нь шэхид болоод диваажинд орж байхад би таны дэргэд суугаад байх юм уу?" гээд зэмлэв. Шууд бамбайгаа аваад:

"–Аллах минь! Намайг гэртээ битгий хариул!" гэж залбирсны дараа Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд очив. Пайгамбар Эзэнд маань:

"–Миний хөвүүд намайг Мадинад үлдээмээр байна. Надад Чамтай хамт байлдахыг хориглоно. Валлахи би энэ доголон хөлөөрөө диваажинд гишгэхийг хүсч байна," гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Аллах Таала чамайг уучлав. Жихад нь чамд фарз биш юм," хэмээв.

Амр -радъяллахү анх-:

"–Аяа Расулаллах аа! Чи намайг Аллахын замд үхтлээ байлдаж шэхид болоод, энэ доголон хөлөөрөө диваажинд алхахыг минь зохимжтой гэж үзэхгүй юү?" гэв. Цуутай Нэбий Эзэн маань:

"–Тийм, зохимжтой гэж үзнэ," хэмээв. Амрын хөвүүдэд ч:

"–Одоогоос хойш аавдаа саад битгий болцгоо. Аллах түүнд шэхадэт хайрлах нь найдвартай," хэмээв.

Амр кибла руу эргэж:

"Аллах минь! Надад шэхадат хайрла! Намайг алдсан ба гуньсан буйгаар гэртээ битгий хариул!" гээд залбирч жихадад оролцов.

Ухудын Дайнд оролцсон, шэхид болох бишрэлтээр дүүрэн уг сахабий нь жихад болж байхад "Валлахи би диваажинг үгүйлэв," гэсэн, эцэст нь түүнийг хамгаалахыг хичээсэн хүүгийнхээ хамт дайнд шэхид болсон байв. Дараа нь Хайрт Пайгамбар маань түүний тухай:

"Намайг хүчит гараараа барьсан Аллахад тангараг өргөе, Амрыг диваажинд доголоод алхаж буйг харна!" хэмээв. (Вакидий, I, 264-265; Ибн-и Эсир, *Усдү'л-Габэ*, IV, 208)

Хүндэт Элч Эзэн маань Ухудын дайнд гарахаар цэргээ шалгаж байв. Дайнд оролцохуйц насны залууст зөвшөөрөл олгож, боломжгүйг бол буцааж байв. Сэмүрэ бин Жүндэб ба Рафий бин Хадиж ч буцагсдын дунд байв. Зүхэйр бин Рафий:

"–Аяа Расулаллах аа! Рафий нь сайн харвагч!" гээд түүнийг байлгахын гуйв. Рафий бин Хадиж цаашийг нь ингэж ярина:

"Би хөлдөө мэстээ өмссөн байв. Хурууны үзүүрт гишгэж урт харагдахыг хичээлээ. Расулаллах ч намайг цэрэгт оролцохыг зөвшөөрөв. Сэмүрэ бин Жүндэб нь намайг зөвшөөрөл авчныг сонсонгоо хойд аав Мүрэй бин Синандаа:

«–Аав аа! Расулаллах -алэйхиссалатү вэссэлам- Рафийд зөвшөөрөл олгов. Намайг бол буцаав. Харин би барилдвал түүнийг хожиж чадна,» гэв. Мүрэй -радъяллахү анх-:

«–Аяа Расулаллах аа! Та миний хүүг буцааж Рафий зөвшөөрөл олгов. Харин миний хүү барилдахдаа Рафий хожно,» гэв. Аллахын Элч нь Сэмүрэ бид хоёрт:

«–За, тэгвэл нэг барилд!» гэв.

Барилдаад Сэмүрэ намайг давав. Тэгээд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнд ч зөвшөөрөл олгов.” (Табэрий, *Тарих*, II, 505-506; Вакидий, I, 216)

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- цэргийн ард Ухуд Уулыг үлдээв. Айнэйн Даваанд ч дайсны энэ хоорондын хөндийгөөр довтлох магадлалын эсрэг тавин харвагч байрлуулав. Тэднийг тэргүүлэхээр Абдуллах бин Жүбэйрийг томилж тэдэнд ингэж айлдав:

“–Та бидний ардыг хамгаална. Дайсан ялсан ч ялагдсан ч надаас мэдээ аваагүй байхдаа байрлалаасаа бүү салцгаа!” (Ибн-и Хишам, III, 10; Ахмад, I, 288)

Дайн нь, заншсанаар нь дахиад мүбарэзэ буюу нэг нэгний байлдаанаас эхлэв. Аллахын Арслан Хазрат-и Али нь мүшрикчүүдийн туг баригч Талхад нэг цавчаад газар дэвслэв. Курайшийн тугийг авсан Талхагийн дүү Усманыг Хазрат-и Хамза, гурав дахь туг баригчийг бол Са’д бин Эбий Ваккас алав.

Эцэст нь дайн улам ширүүсэв. Тулалдааныг бүрэн улайрсан үед Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- дээр нь:

“Айхдаа ичгүүр ба гутамшиг, довтлохдоо алдар ба хүндэтгэл бий!” гэсэн үг бичсэн сэлмээ үзүүлэн:

“–Үүнийг надаас хэн нь авах вэ?” хэмээн асуув.

Сахабийчууд:

“–Би, би!” гээд авахаар гараа өргөцгөөв.

Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-:

“–Энэ сэлмийг ёсоор нь хэрэглэхээр хэн авах вэ?” хэмээн асуухад нь бүгд нь татгалзав. Энсараас Эбү Дүжанэ -радъяллахү анх- босоод:

“–Аяа Аллахын Элч ээ, түүний ёс нь юу вэ?” гэж асуув.

Пайгамбар эзэн маань:

“–Түүний ёс нь, тахийтал нь дайсантай тулалдах юм...” хэмээв.

Эбү Дүжанэ:

“–Би түүнийг ёсоор нь авна, аяа Расулаллах!” гэв.

Эбү Дүжанэ сэлмийг аваад, улаан даавуу гарган толгойдоо ороож, Ислам ба мүшрик хоёр цэргийн эгнээний дундуур ихэмсэгээр дүр үзүүлэн алхаж эхлэв. Пайгамбар Эзэн маань түүнийг ийм ихэмсэг зангаар алхсаныг хараад:

“–Аллах ингэж алхахад, үүнээс өөр тохиолдолд дургүйцнэ!” хэмээв. (Ибн-и Хишам, III, 11-12; Вакидий, I, 259; Мүслим, Фэдаилү’с-Сахаба, 128)

Дайн болоход еврей эрдэмтдээс Мухайрик мусульман болов. Тэр нь Пайгамбар Эзнийг маань Тэвратад дурдсан бэлгэ тэмдгээр нь маш сайн таньдаг байв. Шинжлэх ухаанаараа

олсон үнэнийг Ухудын дайн хүртэл илэрүүлж чадаагүй байв. Орчлонгуудын Эзнийг Ухудын Дайн явахад еврейчүүдэд:

"–Еврей нийгэм ээ! Валлахи та Мухаммед пайгамбар буйг ба Түүнд туслах ёстой буйгаа мэддэг!" гэв.

Еврейчүүд:

"–Өнөөдөр Шэбт (Бямба гариг) юм; ямар ч ажил оролдож болохгүй!" гэцгээв.

Мухайрик:

"–Таны хувьд шэбт гэсэн юм байдаггүй!" гэв. Сэлэм ба хэрэгтэй үйлсээ аваад хамаатнаасаа нэгэнд:

"–Хэрэв би алагдвал миний хамаг бараа минь Мухаммедынх юм. Тэр нь тэднийг Аллахын зааснаар хэрэглэнэ!" гээд гэрээсээ хэлэв. Ухудад байлдахаар очоод шэхид болов. Үлдээсэн хасарвааны долоон талбайг Пайгамбар -алэйхиссалатү вэссэламгардаж аваад сан болгож:

"–Мухайрик еврейчүүдийн хамгийн буянтай нь мөн!" хэмэээв. (Ибн-и Хишам, III, 38; Вакидий, I, 263; Ибн-и Са'д, I, 501-503)

Ухудад энэ мэт сэтгэл хөөрмөөр үзэгдэл илэрч байв:

Мадинагаас Кузман гэсэн нэртэй нэг нь дайнд долоон хүнийг алсан, өөрөө ч хүнд шарх аваад өнгөрсөн байв. Гэсэн ч Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Кузсан нь тамынх юм!" хэмээв.

Учир нь тэр сүүлийн удаа амьсгалахдаа түүнд:

"–Чиний шэхадэт чинь ариун байх болтугай Кузман аа!" гэсэн Катадэ бин Нуманд:

“–Би аймгийнхаа төлөө л байлдсан, шэхид болохоор биш!” гэсэн ба сэлэм тулаад амиа алдсан байв. (Вакидий, I, 263)

Харин аймгийнхныхаа Исламд ороход эхлээд эсэргүүцэж, дараа нь гэмшээд Усайрам нь бүрэн зэвсгээ бүсэлсэн буйгаараа Нэбий -саллаллахү алэйхи вэ сэллэм-д ирээд:

“–Аяа Расулаллах аа! Эхлээд тантай хамт дайнд оролцох уу, эсвэл мусульман болох уу?” гэв.

Хүндэт Элч Эзэн маань:

“–Эхлээд мусульман бол, дараа нь байлд!” хэмээн айлдав. Тэгэхлээр нь Усайрам мусульман болоод, дараа нь байлдаад шэхид болов. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Бага ажиллаад ихийг олов!” хэмээв. (Бухарий, Жихад, 13; Мүслим, Имарэ, 144)

Шархтнуудын дунд хэвтэж буйд нь түүн рүү гайхан харсан хүмүүст сүүлийн амьсгалдаа:

“–Би мусульман болохоор ирлээ. Аллах ба элчийнх нь төлөө байлдаад шархтлаа!” гэж байв.

Эбү Хүрэйрэ -радъяллахү анх- нь энэ хүнийг оньсого шиг сахаби байв:

“–Надад хэлээрэй, амьдралдаа ганц удаа мөргөл үйлдэлгүй диваажинд орсон хүн хэн бэ?” гэдэг байв. Хүмүүс хариултыг нь мэдэлгүй, өөрөө хэлэхийг хүсдэг байв. Эбү Хүрэйрэ ч:

“–Тэр нь Усайрам буюу Амр бин Сабит мөн!” гэдэг байв. (Ибн-и Хишам, III, 39-40; Вакидий, I, 262)

Дайн болоход Абдуллах бин Жахш -радъяллахү анх-ын сэлэм хугарчээ. Оршигчдын Туяа Эзэн маань түүнд хасарвааны мөчир гардуулж өгөв. Хасарвааны мөчир Хазрат-и Абдуллахын

гарт сэлэм болчхов. Абдуллах шэхид болтлоо уг сэлмийг хэрэглэв. “Уржун” гэж нэрлэсэн энэ сэлмийг Абдуллах бин Жахшын өвчүүдэд байхад Түрк ноёдоос нэгэн хүн хоёр зуун динараар (алт) худалдаж авав.[138]

Мусульманчуудын баатар зоригтой дайсан руу дайрсан нь богино хугацаанд ялалтанд хүргэв; цэргийн тоо болон зэр зэвсэг тоног төхөөрөмжөөрөө давуу байсанч дайсан зугтаж эхлэв. Харин мусульманчууд хэсэг хугацаа дайсныг хөөсний дараа ялсандаа бүрэн итгэж олз цуглуулж эхлэв. Түүнчлэн Аллахын Элчийн үгийг саналгүй, дарга нь ч цэрэг ч харвагчид ч байраа орхиж олз цуглуулахаар гүйв. Даваан дээр зөвхөн харвагчдын дарга Абдуллах ба долоон найз нь үлдсэн байв.

Тэгээд бүгд нь үүний дараа л болов. Дайсны сэргэлэн ухаалаг дарга Халид бин Вэлид нь морьт ангиараа хүлээж байсан завшааныг олсон байв. Тушаасан морьтдын хамт шууд харвагчдын байрласан давааны араас тойрч Абдуллах ба бусад харвагчдыг богино хугацаанд шэхид болгов. Олз цуглуулж байсан мусульманчуудын араас ширүүн нэгэн довтолгоо эхлүүлэв. Таран зугтаж буй дайсны цэрэг ч үүнийг харангаа шууд буцаж ирээд, мусульманчууд руу дахиад довтолж эхлэв. Исламын цэрэг хоёр галын хооронд үлдэв. Эмх цэгцээ алдав.

Шэхидчүүдийн Тэргүүн Хазрат-и Хамза

Исламын зоригт баатар Хазрат-и Хамза -радъяллахү анхнь Вахшигийн шидсэн жаданд оногдон шэхид болов. Арай боол байсан Вахши нь үүнийг Хиндийг түүнд амласан эрх чөлөөндөө хүрэхээр хийсэн байв. Аймшигт хүслэнгээрээ аль хэдийн ийм завшаан хүлээж байсан Хинд нь Хамза -радъяллахү

138. Ибн-и Эсир, *Усду’л-Габэ,* III, 195; Диярбэкрий, I, 433.

анх-ын элгийг гаргаж хазах зэрэг догширсон байв. Ийм учиртай түүнийг "Акилэтү'л-Экбад" буюу "Элэг Идэгч" гэсэн хоч өгөв.

Хазрат-и Хамзагийн шэхадэт нь мусульманчуудын дотор хүчтэй гашуудлын салхи үлээлгэв. Угаасаа замбараа алдсан эгнээ нь бүр эвдрэв. Аллах Таала энэ байдлыг ингэж илэрхийлэв:

وَلَقَدْ صَدَقَكُمُ اللّٰهُ وَعْدَهُ إِذْ تَحُسُّونَهُم بِإِذْنِهِ حَتَّى إِذَا فَشِلْتُمْ
وَتَنَازَعْتُمْ فِي الأَمْرِ وَعَصَيْتُم مِّن بَعْدِ مَا أَرَاكُم مَّا تُحِبُّونَ مِنكُم
مَّن يُرِيدُ الدُّنْيَا وَمِنكُم مَّن يُرِيدُ الآخِرَةَ ثُمَّ صَرَفَكُمْ عَنْهُمْ
لِيَبْتَلِيَكُمْ وَلَقَدْ عَفَا عَنكُمْ وَاللّٰهُ ذُو فَضْلٍ عَلَى الْمُؤْمِنِينَ

"Та Аллахын тушаалаар дайснаа алж байхад, Аллах танд амласнаа хэрэгжүүлсэн байв. Эцэст нь нэгэн хором ирээд, Аллахыг таны хүссэнийг (ялалтыг) **танд үзүүлсний дараа та тэвчээрээ алдав;** (Пайгамбарын олгосон) **тушаалын тухай маргалдаж эхлээд дуулгаваргүй хандав. Танаас дэлхийг хүссэн нь ч байв, ахиратыг хүссэн нь ч байв. Дараа нь Аллах сорихоор таныг тэднээс** (тэднийг ялахаас) **холдуулав. Тангараг болог Тэрээр таныг өршөөв. Угаасаа Аллах итгэгчдэд агуу ихийг хайрлагч мөн."** (Ал-и Имран, 152)

Аугаа Эрх уг ает-и кэримэд харвагчдаас байраа орхисныг **"Зарим нь дэлхийг хүсч байв"** хэмээн сануулж байхдаа тэр газрыг орхилгүй шэхид бологсдыг ч **"Зарим нь ахиратыг хүсч байв"** хэмээж магтан шагшсан байдаг.

Мүшрикчүүд тэр өдөр олон итгэгчийг шэхид болгов. Түүнчлэн хэсэг мүшрик нь шууд Аллахын Элчид зорьж дайрч эхлэв. Орчлонгуудын Эзэн\ рүү хийсэн дайралтын тоо ихсэв. Талха бин Үбэйдуллах ингэж хэлнэ:

“Расулаллахын асхабыг тарахаар мүшрикчүүд дайраад Аллахын Элчийг бүрэн бүслэв. Түүнийг дайралтаас өмнөөс нь үү, араас нь уу, баруун эсвэл зүүн гар талаас нь уу хамгаалахаа би мэдэхгүй байлаа. Сэлмээ сугалж нэгэн удаа өмнөөс нь, нэгэн удаа араас нь ирэгсдийг холдууллаа, тэгээд тэд тарав.” (Вакидий, I, 254)

Мүшрикчүүдийн мэргэн харвагч Малик бин Зүхэйр нь Расулаллахыг сум харвасан байв. Талха бин Үбэйдуллах нумын Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д онохыг ойлгохлоо-роо гараа сумын өмнө өргөв. Сум нь хуруунд нь оноод гарыг нь эрэмдэг болгов.[139]

Мухажир ба Энсараас хэсэг сахабий нь Аллахын Элчийг тойрч эргэв; Түүний өмнө шэхид болохоор бий’ат хийгээд:

“–Нүүр минь нүүрний чинь өмнө халхавч, бие минь Чиний биеийн золиос юм! Аллахын сэлам нь байнга Чамд дээр байх болтугай! Бид хэзээ ч Чамаас салахгүй,” гээд дуустал нь байлдав. (Ибн-и Са’д, II, 46; Вакидий, I, 240)

Эбү Талха нь нумаа маш мэргэн харвагч байв. Ухудын өдөрт гараараа хоёр эсвэл гурван нум хугалсан байв. Аллахын Элч хажуугаар нь саадгаар явсан хүн бүрт:

“–Саадгаа Эбү Талхагийн дэргэд хоосруул!” хэмээн тушааж байв. Пайгамбар Эзэн маань түүний хойноос мүшрикчүүдийг харахаар толгойгоо өндийлгөн харах бүрт Эбү Талха:

---

139. Ибн-и Са’д, III, 217.

“–Аяа Расулаллах аа! Аав-ээж минь Чамд золиос болог! Толгойгоо битгий өндийлгө! Магадгүй мүшрик сумаас нэгэн ононо. Миний цээж Чиний цээжинд халхавч болог. Чамд хүрэх сум надад хүрэг!” гэж байв. (Бухарий, Мэгазий, 18)

Катадэ бин Нуман -радъяллахү анх- ч Аллахын Элчийг хамгаалахаар өмнө нь зогсоод нумыг нь эвдэртэл мүшрикчүүдэд сум харвав. Эцэст нь таарсан нэгэн сум нүдэнд нь онов. Нүдний шингэн нь хацарт нь урсав. Катадэг ингэж харахлаараа Аллахын Элчийн нулимс гоожив. Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- Катадэгийн нүдийг барьж аваад байранд нь оруулав. Үүний дараа тэр нүд нь нөгөөнөөс илүү гоё болж илүү хүчтэй хараатай болов.[140]

Эмэгтэй сахабийчуудаас Үммү Умарэ -радъяллахү анха- ч Ухудын Дайнд оролцоод нум сумаараа байлдсан нэгэн байдаг. Дайны дараа Мадинад харьсан Аллахын Элч:

“–Байлдаж явахдаа эргэн тойрноо харвал байнга Үммү Умарэ нь миний яг дэргэд тулалдаад байв,” хэмээв. (Ибн-и Хажар, *эл-Исаба,* IV, 479)

Ийм учиртай Эзний маань зарим магтаал ба залбирлыг хүртсэн Үммү Умарэ Хатан нь Аллахын Элчид:

“–Аллахад залбираарай, тэгээд бид диваажинд Чиний хөрш болцгооё,” гэв.

Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-:

“–Аллах минь! Эд нарыг диваажинд надад хөрш ба найз болгох болтугай!” хэмээн залбирав. Тэгэхлээр нь Үүмү Умарэ -радъяллахү анха-:

140. Хаким, III, 334/5281; Хэйсэмий, VI, 113; Ибн-и Са’д, III, 453.

“–Одоогоос хойш дэлхийд ямар ч төвөг таарсан ч би тоохгүй!” гэв. (Вакидий, I, 273; Ибн-и Са’д, VIII, 415)

Дайн улайрсан үед Аллахын Элчрүү хийсэн довтолгооны нэгэнд Са’д бин Эбий Ваккасын мүшрик дүү Үтбэ нь Пайгамбар Эзэнд маань нэгэн чулуу шидэв. Шидсэн чулуугаар тэнгэр газар хоёрыг чичрүүлсэн байдлаар Расулаллахын хуягаас хоёр чагт ариунд нүүрэнд нь тусч хацрыг нь яраад нэг шүдийг нь хугалав.[141] Хүндэт Элч Эзэн маань фасик Эбү Амирын мусульманчуудад зориулан малтсан нүхнээс нэгэнд унав. Хазрат-и Али -радъяллахү анх- нь Аллахын Элчийн гарыг барьж, Талха бин Үбэйдуллах ч босгож нүхнээс гаргав. Эбү Үбэйдэ бин Жэррах нь Эзний маань нүүрэнд хадсан чагтаас нэгийг шүдээрээ татаад гаргав. Ингэхдээ өөрийнхөө үүдэн шүд ч хугарав. Нөгөө чагтыг гаргахдаа дахиад нэгэн шүд нь хугарав. Тэр мөчид шилмэл сахаба ба түүнчлэн мэлэкчүүд гүн гунигт автав. Энэ нь асхабт маш хэцүү санагдаад Эзэнд маань:

“–Курайшийн мүшрикчүүдийг хараахгүй юу?!” гэцгээв.

Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- бол:

“–Би хараагч болохоор илгээгдээгүй. Эсрэг нь зөв замд уригч ба энэрэл болохоор л илгээгдлээ. Аллах минь! Ардад минь авралтыг хайрла. Учир нь тэд мэддэггүй,” хэмээж залбирав. (Бухарий, Мэгазий, 24; Хэйсэмий, VI, 117; Вакидий, I, 244-247; Кади Ияаз, I, 95)

Оршигчдын Туяа Эзэн маань:

“–Аллах нь Элчийг нь гархадсан ардад маш их хилэгнэв!” хэмээв.

---

141. Үтбэ бин Эбий Ваккас урвагчийн удмын бүгд хүүхдүүд, тэнгэрлэг нэгэн сургаал болохоор өмнөх шүд нь нүхтэй эсвэл хугархай буйгаар төрсөн байдаг. (Рамазаноглу Махмуд Сами, *Ухудын Газва,* х. 26)

Са’д бин Эбий Ваккас -радъяллахү анх- ингэж хэлсэн байдаг:

“–Валлахи би, Расулаллахын энэ үгийг сонсонгуутаа, дүү Үтбэ бин Эбий Ваккасыг алахаар мэдэрсэн хүсэл шиг хэнийг ч алахыг хүсээгүй!”

Тэгээд Са’д -радъяллахү анх- үүний төлөө мүшрик эгнээг яраад олон удаа үүнийг хичээсэн, харин Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Са’дын дүүгээ алахад саад болсон байдаг.[142]

Са’д бин Эбий Ваккас -радъяллахү анх- нь Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд мүшрикчүүдэд зогсолгүй сум харваад, Оршигчдын Туяа Эзэн маань ч:

“–Харав Са’д аа! Аав ээж минь чамд золиос болог!” хэмээв. Үүнийг гэрчилсэн Хазрат-и Али -радъяллахү анх-:

“Би, Нэбий -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн Са’даас гадна хэний ч төлөө; *«Аав ээж минь чамд золиос болог!»* хэмээснийг сонсоогүй,” гэсэн байдаг. (Тирмизий, Эдэб 61, Мэнакиб 26; Ахмад, I, 92)

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- замбараагүй байдал илэрсэн ийм тохиолдолд ч итгэл найдвараар Эрхэд итгэж, нэг талаас цус болсон ариун царайгаа гараараа арчиж, нөгөө талаас ч Аугаа Эрхэд хоргодон:

“Аяа Раббий! Миний ард яахаа мэдэхгүй мунхаг ард байна. Тэдэнд аврал хайрлаж өгөөрэй!” хэмээн залбирсаар байв.

Сэхл бин Са’д -радъяллахү анх- ярина:

142. Вакидий, I, 245.

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Ухудын Дайны үед Фатима -радъяллахү анха- ариун царайн дахь цусыг угааж эхлэв. Хазрат-и Али ч Фатимад ус асгаж байв. Хазрат-и Фатима ус цусыг бүр ихэссэнийг хараад гэнэт ухаарч; түүнийг шатаасан үнсийг шархан дээр дарав. Ингээд цус нь тогтов.” (Бухарий, Жихад, 80; Мэгазий, 24; Мүслим, Жихад, 101)

Ухудын Дайны үед ийм гунигтай явдал болж байв. Дайн эхлэхэд итгэгчдийн талд байгаад, тушаалд орохгүй учраар гэнэтхэн мүшрикчүүдийн талд эргэсэн байв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн эргэн тойронд зөвхөн арван дөрвөн хүн үлдсэн байв. Орчлонгуудын Эзэн нь айн мэгдсэн хэсэг итгэгчдэд:

“–Аяа Аллахын боолчууд аа! Надад ирцгээ, би Аллахын Элч мөн!” хэмээн дуудаж эхлэв. (Вакидий, I, 237)

Энэ байдлыг Кур’ан-и Кэрим ингэж илэрхийлэв:

إِذْ تُصْعِدُونَ وَلاَ تَلْوُونَ عَلَى أحَدٍ وَالرَّسُولُ يَدْعُوكُمْ فِي
أُخْرَاكُمْ فَأَثَابَكُمْ غُمَّاً بِغَمٍّ لِّكَيْلاَ تَحْزَنُواْ عَلَى مَا فَاتَكُمْ
وَلاَ مَا أَصَابَكُمْ وَاللّهُ خَبِيرٌ بِمَا تَعْمَلُونَ

“Тэгээд Пайгамбар араас тань дуудсан ч та зогсолгүй (дайны талбайнаас) **холдож, эргээд хэнийг ч харж чаддаггүй байцгаав.** (Аллах) **таныг гараасаа алдсандаа ч, өөрсдөө тохиолдсонд ч санаа зовохгүйн төлөө гашуун дээр гашуун өгөв. Аллах таны хийснийг мэддэг.”** (Ал-и Имран, 153)

Мусульманчуудын хэсэг нь ч Хазрат-и Пайгамбарын шэхид болсныг сонсоод, итгэл алдран донсолсон байв. Тэгэхэд “Аллахын Элч өөд болсны дараа бид энд юунд зогсох вэ!” гээд дайны талбайг орхиж байцгаав. Эд нар үнэндээ Мадинаг хамгаалахаар харьсан боловч мусульман эмэгтэйчүүд тэднийг буцааж илгээсэн байв.

Зарим нь бол “Аллахын Элч өөд болсон ч Аллах нь бакий мөн!” гээд байлдаад байв. Эднээс Энэс бин Надр -радъяллахү анх- (алдарт Энэс бин Маликын авга ах), гашуудаад яахаа мэдээгүй хэсэг итгэгчдээс Орчлонгуудын Эзний өөд болсны мэдээг сонсохдоо, бууж өгөх ба тэсээд:

“–Расулаллах шэхид болсны дараа та нар амьдраад яах вэ? За, одоо та нар ч Түүн шиг байлдаад шэхид болцгоо!” гээд хашхираад мүшрикчүүд рүү довтлов. Хэсэг хугацааны дараа ная гаруй шархтаж шэхадэтийн ундааг залгив. (Ахмад, III, 253; Ибн-и Хишам, III, 31)

Энэс -радъяллахү анх- ингэж ярина:

“Авга ах Энэс бин Надр маань -радъяллахү анх- Бэдирийн Дайнд оролцож чадаагүй байв. Энэ нь түүнд маш хэцүү санагдаж байв:

«–Аяа Аллахын Элч ээ! Таны мүшрикчүүдтэй хийсэн анхны дайнд би орж чадаагүй. Хэрэв Аллах Таала мүшрикчүүдтэй хийх нэгэнд дайнд оролцуулбал, намайг юу хийхийг мэдээж үзэх болно,» гэв.

Ухудын Газвад тэр дайнд оролцов. Мусульманы эгнээгээ алдахад, найзуудынхаа тухай: «Раб минь! Эдний хийсний төлөө Чамаас уучлал гуйя!», мүшрикчүүдийн тухай ч: «Эдний хийснээс бол би хол, аяа Раббий!» гээд урагшлав. Са’д бин Муазтай учраад:

«–Са’д аа! Би диваажинг хүснэ. Кабагийн Рабт тангараг өргөе, Ухудын хормойгоос наашбайнга тэр диваажинг үнэртэж байна,» гэв.

Са’д үүнийг дараа нь Пайгамбар Эзэнд маань дамжуулахдаа:

«–Би түүний хийснийг хийж чадаагүй, аяа Расулаллах!» гэсэн байв.

Авга ахыг минь шэхид болсноор нь олов. Биендээ ная гаруй сэлэм, жад ба сумын шархтай байв. Мүшрикчүүд мүслэ хийж, зарим эрхтэнийг нь зүсч авсан байв. Тийм учраас түүнийг хэн ч таньж чадаагүй. Зөвхөн охин дүү нь хурууны үзүүрээр нь танив. Уг ает нь миний авга ах ба төсөөтийн тухай буув:

مِنَ الْمُؤْمِنِينَ رِجَالٌ صَدَقُوا مَا عَاهَدُوا اللّٰهَ عَلَيْهِ فَمِنْهُمْ مَنْ
قَضٰى نَحْبَهُ وَمِنْهُمْ مَنْ يَنْتَظِرُ وَمَا بَدَّلُوا تَبْدِيلًا

«Итгэгчдийн дунд зарим зоригтууд буй бөгөөд, Аллахад өгсөн амлалтдаа үнэнчээр хандав. Тэднээс зарим нь амласнаа хэрэгжүүлж байлдаж, шэхид болов **зарим нь ч** ээлжээ **хүлээдэг. Эд нар амлалтаа огт өөрчлөөгүй.»** (эл-Ахзаб, 23)” (Бухарий, Жихад, 12; Мүслим, Имарэ, 148)

Дайныг итгэгчдийн эсрэгээр эргэхлээр нь дайны талбараас зугтагсад -тэнгэрлэг нууц учир- ердөө хотоос гараад байлдахыг хүсэгчдээс байв. Аллах Таала нь тэдэнд хандан ингэж айлдав:

وَلَقَدْ كُنْتُمْ تَمَنَّوْنَ الْمَوْتَ مِنْ قَبْلِ أَنْ
تَلْقَوْهُ فَقَدْ رَأَيْتُمُوهُ وَأَنْتُمْ تَنظُرُونَ

“Тангараглая, үхэлтэй тааралдахаас өмнө та түүнийг хүсдэг байв. Одоо бол түүний өөдөөс харцгаа!” (Ал-и Имран, 143)

Үхэлд бэлэн байснаа хэлээд, дараа нь Оршигчдын Туяаг өөд болсон гэж сонсоод хойш эргэн зугтагчдад ирүүлсэн тэнгэрлэг сануулга ширүүн болов:

وَمَا مُحَمَّدٌ إِلاَّ رَسُولٌ قَدْ خَلَتْ مِن قَبْلِهِ الرُّسُلُ أَفَإِن مَّاتَ أَوْ قُتِلَ انقَلَبْتُمْ عَلَى أَعْقَابِكُمْ وَمَن يَنقَلِبْ عَلَىَ عَقِبَيْهِ فَلَن يَضُرَّ اللّهَ شَيْئًا وَسَيَجْزِي اللّهُ الشَّاكِرِينَ

“Мухаммед зөвхөн нэгэн Элч л юм. Түүнээс өмнө ч пайгамбарчууд ирээд өнгөрсөн байдаг. Одоо түүнийг өөд болоход, эсвэл алагдвал, буцаж (хуучин шашиндаа орох) **Хэн нэгэнд Аллахад ямар ч хохирол хүргэж чадахгүй. Аллах зөвхөн талархагчдыг шагнана.”** (Ал-и Имран, 144)

Тэр аймшигт өдөр яасан ч Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь алтан гадас шиг байраа огт орхилгүй номлогчийн шийдвэрт тулав. Тэвчээр, зориг ба тайван зангаараа асхабтаа баатар болохоор ч агуу нэгэн жишээ болов. Энэ тухай Аугаа Эрх ингэж айлдав:

وَلاَ تَهِنُوا وَلاَ تَحْزَنُوا وَأَنتُمُ الأَعْلَوْنَ إِن كُنتُم مُّؤْمِنِينَ. إِن يَمْسَسْكُمْ قَرْحٌ فَقَدْ مَسَّ الْقَوْمَ قَرْحٌ مِّثْلُهُ وَتِلْكَ الأيَّامُ نُدَاوِلُهَا بَيْنَ النَّاسِ وَلِيَعْلَمَ اللّهُ الَّذِينَ آمَنُوا وَيَتَّخِذَ مِنكُمْ شُهَدَاء وَاللّهُ لاَ يُحِبُّ الظَّالِمِينَ

“Дайсны өмнө хүчээ бүү сулруул, ялагдах нь гэж **санаа ч битгий зов!** Аллахад **итгэж байвал, та заавал давуу, тэгээд** эцэст нь та ялна**! Хэрэв та** Ухудад **шархдаад зовсон бол** (Бэдирт **тэгж зовсон. Бид эдгээр өдрүүдийг хүмүүсийн дунд ээлжээр эргүүлнэ.** Заримдаа та ялна, заримдаа дайсан нь ялна!)**…”** (Ал-и Имран, 139-140)

Аугаа Эрхийн Пайгамбартаа ба итгэгчдэд энэрэл ба хайраар Ухудын өдөр, замбараа алдсан ч мүшрикчүүд зорьсондоо хүрч чадаагүй. Энэ хооронд Асхаб-и кирам хазрат нь Расулаллахыг хараад аажим аажмаар цугларч эхлэв. Мүшрикчүүдийн довтолгоог хариулав. Итгэгчид нь маш их зориг тэвчээрээр Аллахын Элчийг хамгаалав. Маккагийн мүшрикчүүд дахиад хүн хүчээ алдаж эхлэв. Хохирлоо багасгахын тулд жаахан ухарцгаав. Уг завшааныг үнэлсэн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч Ухуд Ууланд ухрав. Энэ удаа ч Эбү Сүфьяан уулан дээрээс итгэгчид рүү дайраад ч амжилттай болоогүй.

Ийм аймшигт үед Аллах Таала итгэгчдэд нойрмог байдал хайрлаж , тэд байсан газартаа таатай тайван унтаж эхлэв. Зарим нь гараасаа сэлмээ олон дахин унагаав. Энэ нойр нь зөвхөн итгэгчдийн хувьд тохиолдсон юм. Мусульманчуудын дундах мүнафик ба сэжигтнүүдийн хувьд нойрмоглоогүй байв. Тэд нь тэр хооронд эргэлзэж, мүшрикчүүдийн ирээд өөрсдийгөө алахаас айж байцгаав.[143]

Нэгэнд, Эбү Сүфьяан ба Хазрат-и Умарын хооронд богино нэгэн маргаан гарав.[144] Үүний дараа буцахаар хөдөлсөн Эбү Сүфьяан хүссэн хангалттай дүнг олоогүйдээ хилэнтэйгээр хамгийн сүүлд нь:

143. Бухарий, Мэгазий, 18, 20; Вакидий, I, 295-296.

144. Ибн-и Хишам, III, 45.

“–Ирэх жил Бэдирт уулзъя!” гэв.

Хазрат-и Умар -радъяллахү анх- зогсоод Пайгамбар Эзний маань үүнд юу гэхийг хүлээв. Оршигчдын Туяа Эзэн маань:

“–Болно! Тэнд бурхан өршөөг бидний уулзах газар болту-гай!” хэмээв. (Ибн-и Хишам, III, 45; Ибн-и Са’д, II, 59)

Үнэндээ бол мүшрикчүүдийн дотор нэг айдас бий болж тийм учиртай буцаж байв. Угаасаа Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д олгосон гайхамшгийн нэгэн ч, дайсны сэтгэлд хол зайнаас ч аймшиг төрүүлсэн байв. Аугаа Эрх айл-дана:

سَنُلْقِي فِي قُلُوبِ الَّذِينَ كَفَرُواْ الرُّعْبَ بِمَا أَشْرَكُواْ بِاللّهِ مَا لَمْ يُنَزِّلْ بِهِ سُلْطَانًا وَمَأْوَاهُمُ النَّارُ وَبِئْسَ مَثْوَى الظَّالِمِينَ

“Аллахын ямар ч нотолгоо буулгаагүй юмыг Аллахын түнш гэж хүлээж авсан учраас бид удахгүй кафирчуудын зүрхэнд айдас оруулна. Тэдний очих газар ч там юм. Харгисчуудын очих газар нь ямар муухай гээч!” (Ал-и Имран, 151)

Мүшрикчүүд зүрхэндээ төрсөн айдсаас мусульманчуу-дын хамгалаалалтгүй Мадинаг эзлэхээр хөдөлж чадаагүй. Түүнчлэн хажуудаа ганцхан мусульман олз ч авалгүй буцац-гаав. Андашгүй нь энэ Аллахын Пайгамбартаа ба итгэгчдэд хайрласан нэгэн бэлэг байв.

Ухудад мүшрикчүүдийн буцаж явахад, Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Эгнээнд орцгоо, Рабдаа залбирал ба магтаал өргөе!” хэмээв.

Асхаб-и кирам нь Аллахын Элчийн арын эгнээнд орцгоов. Пайгамбар Эзэн маань ингэж залбирлав:

“Аллах минь! Хамаг хамд ба магтаал нь Чамд харъяалагдана! Аллах минь! Чиний дэлгэж өргөтгөснийг нарийсгах нь үгүй, Чиний нарийсгасныг дэлгэж өргөтгөх нь ч үгүй! Чиний төөрүүлснийг зөвлөх нь үгүй, Чиний аврал хайрласныг ч төөрүүлэх нь үгүй! Чиний өгөөгүйг өгөх нь үгүй, Чиний өгснийг ч саатуулах нь үгүй! Чиний холдуулсныг дөхүүлэх нь үгүй, Чиний дөхүүлснийг ч холдуулах нь үгүй!

Аллах минь! Энэрэл ба элбэгээ, эрдмээ бидэнд дээр цац! Аллах минь! Чамаас огт өөрчлөгдөхгүй ба хэзээ ч үгүй болохгүй мөнхийн шимийг гуйя. Аллах минь! Чамаас ядуурлын өдөрт шим, айдаст өдөрт аюулгүйдлийг ерөөе! Аллах минь! Чамайг өгсөн ч өгөөгүй ч Чамд хоргодъё!

Аллах минь! Итгэлийг бидэнд хайрла, сэтгэлийг маань түүгээр чимэглэ! Биднийг куфур, догшрол ба Чамайг эсэргүүцэхээс холдуул! Биднийг шашин ба дэлхийн төлөө ашигтай зүйлсийг мэдэгчид, зөв замаар явагчид болго!

Аллах минь! Биднийг мусульман буйгаар алаад, мусульман буйгаар амьдруул! Нэр алдраа алдалгүй, фитнэд авталгүй, салихчуудын эгнээнд оруул!

Аллах минь! Чиний пайгамбарчуудыг үгүйсгэсэн, хүмүүсийг Чиний замаас холдуулсан кафирчуудыг гэсгээ! Тэдэн дээр төвөг ба тамлалаа буулга. Аллах минь! Ном олгосон кафирчуудыг ч гэсгээ! Аяа үнэн ба жинхэнэ буй Бурхан аа! Амин!” (Ахмад, III, 424; Хаким, I, 686-687/1868; III, 26/4308)



Шалтгааныг Хаасан Сахабий: Са’д бин Рубий

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Са’д бин Рэбий -радъяллахү анх-ыг олоод ямар байдалд буйг нь мэдэхээр асхабаасаа нэгийг дайны талбайд илгээв. Сахабий нь Са’д -радъяллахү анх-ыг хэдий их хайсан ч олж чадаагүй, хэдий их дуудсан ч хариу авч чадаагүй. Эцэст нь сүүлийн найдвараа:

“–Еэ Са’д аа! Намайг Расулаллах илгээв. Аллахын Элч нь чамайг амьдын хооронд уу, эсвэл шэхидчүүдийн дундаас уу гэснийг мэдээлэхийг тушаалаа!” гэж шархтай ба шэхидчүүд байсан тийш дуудав.

Тэр үед сүүлийн амьсгаагаа авч ба хариу өгөх хүч үлдээгүй байсан Са’д -радъяллахү анх- нь өөрийгөө Аллахын Элчийн шохоорсныг сонсонгуутаа, хамаг хүчээ шавхан бүдэг гэнгэнэх дуугаар:

"–Би одоогоос амьгүйчүүдийн дунд орлоо!" гэж чадлаа. Одоо цаашаа юу ширтэж байсан нь тодорхой байв. Сахабий нь Са'д -радъяллахү анх-ын дэргэд гүйв. Түүнийг биеийг слмээр сийчжээ. Түүнээс дөнгөж шивнэх шиг дуугаар гарсан ийм гайхалтай үгсийг сонсов:

"–Валлахи таны нүд хөдөлж байвал Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-ыг дайснаас нь хамгаалахгүй ба Түүнд ямар нэгэн төвөг тааралдах учир болбол, таны хувьд Аллахын онгонд илэрхийлэх ямар ч шалтгаан үгүй юм!" (*Муватта*, Жихад, 41; Хаким, III, 221/4906; Ибн-и Хишам, III, 47)

Са'д бин Рэбий -радъяллахү анх- нь үммэтэд бараг гэрээс болох эдгээр үгсээрээ түр зуурын амьдралаас хагацав.

Ухудын Шэхидчүүд

Мүшрикчүүд Ухудыг бүгд орхисны дараа Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- дайны талбарт бууж шэхидчүүдийг оршуулав. Нийт далан шэхид байв. Эдний хооронд Хазрат-и Хамза -радъяллахү анх- шиг баатрууд ба Мус'аб бин Үмэйр -радъяллахү анх- шиг зоригтнууд ч байв.

Мусульманчуудын туг баригч асан Мус'аб бин Үмэйр -радъяллахү анх- нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг хамгаалсаар шэхид болсон байв. Тэгэхлээр нь нэгэн мэлэк Мус'абын дүрсэнд ороод тугийг гардсан, Пайгамбар Эзэн маань ч арай түүнийг шэхид болсныг мэдээгүй тулд тугч баригчийг хандан:

"–Урагшаа яв, еэ Мус'аб!" хэмээсэн байв.

Гэтэл мэлэк нь эргэж Аллахын Элч рүү харсан, ингээд түүний нэгэн мэлэк буйг анзаарсан Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- Мус'абын шэхид болсныг ойлгосон байв. Дараа нь

Мус’абын ариун шарилыг олоод, харин түүнийг ороох кэфэн олдоогүй байв. (Ибн-и Са’д, III, 121-122)

Ариун шэхидийн байгаа хувцас нь толгойн талыг дал-далбал хөл нь, хөлийг нэ далдалбал толгой нь ил гарч байв. Асхаб нь яахаа асуухаар Аллахын Элчээс лавлав. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- шэхидийн толгойг далдлах ба хөлийг ч сайхан үнэртэй өвсөөр хучихыг тушаав.

Үнэндээ Мус’аб -радъяллахү анх- Маккагийн хамгийн язгуурт ба баян айлын хүү байв. Маккагийн хамаг залуус түүний амьдралыг дуурайдаг байв. Мөн бүсгүйчүүд түүний өнгөрсөн зам дээр сарнай цацдаг байв. Тэр бол мүшрик гэр бүлийнхэн хэдий их албадсан ч тэдний дэлхийн боломж ба завшааныг, түүнчлэн өвийг нэг тийш хаяад Аллахын Элчийн замд боло-хыг сонгов. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д маш том хайраар шагшин биширч холбогдоод, шэхид болоход нь үүний хариугаар нэгэн мэлэк түүний дүрсэнд оров. Ингэхдээ Мус’абын тэвчсэн бэрхшээлийг тэнгэрлэг бэлгээр маш сайхан хариу өгсөн болов.

Энэ гунигтай явдал нь сэтгэлд маш гүн мөр үлдээж, олон жилийн дараа мусульманчууд хүч олоод нэр хүндэд хүрсэн эринд, агнияа-и шакирийгаас асан Абдуррахман бин Авф -радъяллахү анх- ын өмнө, мацагтай байсан нэгэн өдөр хөвүүн нь хэдэн төрлийн хоол тавьсан байв. Тэр бол үүнд санаа зовоод:

“–Мус’аб нь Ухудын дайнд шэхид болов. Тэр надаас эрдэм-тэй байв. Харин кэфэн болохоор нэгэн хүрмээс өөр юм нь байгаагүй. Түүгээр толгойг нь далдалбал хөл нь, хөлийг нь далдалбал толгой нь ил үлдэж байна. Дараа нь дэлхийд бидэнд бүх юм хайрлагдав. Үнэндээ ач буяныхаа хариу бүхнийг дэл-хийд олсноосоо айж байна,” гэсэн байв. Дараа нь Абдуррахман

-радъяллахү анх- уйлж эхлээд хоолыг орхиод ширээнээс босов. (Бухарий, Жэнаиз, 27)

Ухудын шэхидчүүдийн дунд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- болон хамаг итгэгчдийн сэтгэлийг гунигт автуулсан нь бол, Исламын цэргийн ижилгүй баатар, Аллахын Арслан Хазрат-и Хамза -радъяллахү анх- болов.

Хазрат-и Сафийе дүү Хамза -радъяллахү анх-ыгаа харахаар шэхидчүүд буй тийш чиглэв. Хөвүүн Зүбэйр нь түүнийг угтаж:

“–Расулаллах буцахыг чинь тушаана,” гэв. Тэр ч:

“–Яагаад? Дүүгээ харахгүй юү? Би түүнийг зүсэгдсэнийг угаасаа мэдсэн. Тэр нь Аллахын төлөө энэ бүхнийг давсан. Угаасаа биднийг үүнээс гадна нь тайтгаруулахгүй. Бурхан минь буяныг нь Аллахаас хүлээнэ,” гэв.

Зүбэйр очоод ээжийнхээ хэлснийг Хүндэт Элч Эзэнд маань мэдүүлэв. Орчлонгуудад Энэрэл Эзэн маань:

“–Тэгвэл хараг!” хэмээв. Сафийе ч дүү нь Хазрат-и Хамзагийн ариун шарилын дэргэд очоод залбирав. (Ибн-и Хишам, III, 48; Ибн-и Хажар, эл-*Исаба,* IV, 349)

Ухудад хэрэгжсэн ухаанд багтамгүй шашны явдлыг Зүбэйр бин Аввам -радъяллахү анх- ингэж ярина:

“Миний ээж Сафийе хажуудаа авчирсан хоёр хүрмийг гаргаж:

«–Эдгээрийн миний дүү Хамзад кэфэн болгоорой гэж авчирсан,» гэв. Тэднийг аваад Хамзагийн дэргэд очицгоов. Түүний дэргэд Энсараас кэфэнгүй өөр нэгэн шэхид байв. Хоёр хүрмийг ч Хамзад ороож Энсарийг кэфэнгүй үлдээхээс ичээд:

«–Хүрмийн нэг нь Хамзад, нөгөө нь ч Энсарийд кэфэн болог!» гэцгээлээ. Хүрмээс нэг нь том, нөгөө нь жижиг байсан тул сольж хэрэглэв.” (Ахмад, I, 165)

Уг мэдрэмжтэй явдлыг илэрхийлснээр, одоо садан хамаатны харьцаа нь итгэгч сэтгэлд байраа итгэлийн галыг орхиж байв. Киямат хүртэл ирэх бүх итгэгчдэд шашны найрамдлын бишрэлтийг толилуулж байв.

Шэхидчүүдийн мөргөлийг үйлдэхээр Хазрат-и Хамза -радъяллахү анх-аас эхлэн арван шэхид авчраад, мөргөлийн дараа есийг нь оршуулж байцгаав. Хазрат-и Хамзагийн дэргэд дахиад есөн шэхид авчраад, дахиад оршуулах мөргөл үйлдэж байв. Ингээд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь авга ах, элэг нь ба шэхидчүүдийн эзэн болсон уг ариун шэхидийн оршуулах мөргөлийг олон дахин үйлдсэн байв.[145]

Жабир -радъяллахү анх-аас дамжуулснаар, Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- Ухудын Газвад шэхид бологсдыг булш бүрт нь хоёр хүн оршуулахаар :

“–Эд нараас аль нь Кур’аныг илүү мэддэг байв хэмээн асуусан ба шэхидчүүдээс заавал түүнийг киблагийн талд оршуулж байв. (Бухарий, Жэнаиз, 73, 75)

Хазрат-и Аиша -радъяллахү анха- нь Ухудад болсон явдлын тухай мэдээ авахаар эмэгтэйчүүдийн хамт замд гарсан байв. Харра гэсэн газар, салиха эмэгтэй Хинд бинт-и Амр -радъяллахү анха-тай тааралдав. Хинд нь нөхөр Амр бин Жэмүх, хүү Халлад ба дүү Абдуллахынхаа шарилыг тэмээнд ачаад ирж байв. Хазрат-и Аиша түүнээс:

“–Хойноос ямар мэдээ байна вэ?” гэж асуув. Хинд:

145. Ибн-и Мажэ, Жэнаиз, 28.

“–Буян. Расулаллах нь сайн. **Түүнийг байхад хамаг бэрхшээл юу ч биш,**” гэв.

Хазрат-и Аиша тэмээн дээрх шарилыг үзүүлэн:

“–Эд нар хэн бэ?” гэж асуув. Салиха эмэгтэй Хинд:

“–Миний дүү Абдуллах, хүү Халлад ба миний нөхөр Амр юм,” гэв.

Хазрат-и Аиша :

“–Тэднийг хааш аваачих нь вэ?” гэж асуув. Хинд:

“–Мадинад аваачна. Тэнд оршуулна,” гэв. Алхахад нь жаахан албадвал тэмээ нь сөхрөв. Хазрат-и Аиша:

“–Тэмээ ачааны хүндээс болж сөхрөв үү?” гэж асуув.

Хинд:

“–Яагаад сөхөрсөнийг би мэдэхгүй. Харин бусад үед хоёр тэмээний ачааг ачдаг байв. Одоо бол түүнд ялгаатай нэгэн байдал харж байна,” гэв.

Албадвал тэмээ нь боссон, харин Мадина руу чиглүүлбэл дахиад сөхрөв. Чигийг нь Ухуд руу эргүүлбэл гүйж эхлэв. Хинд нь Хүндэт Элч Эзний маань дэргэд очоод үүн тухай ярив. Цуут Нэбий Эзэн маань түүнд:

“–Тэмээ нь үүрэгтэй юм. Амрын ямар нэгэн гэрээс байсан билүү?” хэмээн асуув.

Хинд:

“–Амр Ухудад очихоос өмнө кибла руу эргэн: «Аллах минь! Надад шэхид болохыг хайрла! Намайг гунигтай ба дутуу буйгаар гэр бүлд минь битгий хариул!» гэж залбирсан байлаа,” гэв.

Тэгэхлээр нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэмүүнийг хэлэв:

“–Ийм л учраас тэмээ нь явахгүй байжээ.

Аяа Энсарын нийгэм ээ! Танаас хэн нь Аллахад тангараг өргөсөн байвал түүнд үнэнч байг.

Еэ Хинд ээ! Чиний нөхөр Амр үнэнч хүний нэг юм. Түүнийг шэхид болсоноос нааш мэлэкчүүд далавчтайгаараа дээр нь сүүдэр хийсэн ба хаана оршуулахыг хайж байв. Хинд ээ! Чиний нөхөр Амр, хүү Халлад ба дүү Абдуллах нар диваажинд уулзаад анд байх болно.”

Уг сайхан мэдээгээр Хинд нь үнэнч нөхөртэйгөө үүрдийн амьдралд хамт болохыг хүсээд:

“–Аяа Расулаллах аа! Аллахад залбирч ажаамуу, намайг тэдэндтэй уулзуулах болтугай,” гэж гуйв. (Вакидий, I, 264-265; Ибн-и Хажар, *Фэтху’л-Барий,* III, 216; Ибн-и Абдилбэр, III, 1168)

Өөр нэгэн сургаалтай явдал нь ийм юм:

Ухудын өдөр Мадина гашуун мэдээллээр дүүрэв. “Мухаммед алагдав!” гэхээр нь хашхирал дүүрч, орилоон нь огторгуйд хүрэв. Түүнчлэн Энсараас Сүмэйра Хатанд хоёр хүү, аав, нөхөр ба дүүгийн шэхид болсны мэдээ хүргэсэн ч тэр огт тоолгүй шууд Аллахын Элчийн байдлыг асуув:

“–Түүнд ямар нэгэн юм тохиолдов уу?” гэв.

Сахаба-и кирам хариулран:

“–Сайн юм, Аллахад хамд болог, Тэр нь чиний хүссэнээр амьд юм!” гэцгээв.

Сүмэйра Хатан:

“–Түүнийг надад харуулаарай, тэгээд сэтгэл ханана,” гэв. Харуулахлаар нь шууд очоод хувцасны үзүүрийг барин:

“–Аав ээж минь Чиний золиос болог, аяа Расулаллах аа! Чамайг амьд байхад өөр юунд ч санаа зовохгүй!” гэв. (Вакидий, I, 292; Хэйсэмий, VI, 115)

Бэшир бин Акраба -радъяллахү анх- хэлнэ:

“Минйи аав Акраба нь Ухудын дайнд шэхид болоход би уйлаад Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-д очлоо. Надад:

«–Еэ хонгор оо! Чи юунд уйлаа вэ? Битгий уйл! Чиний аав би болбол, ээж чинь ч Аиша болбол, хүлээн зөвшөөрөхгүй юу?» хэмээв.

Би бол:

«–Аав ээж минь Чиний золиос болог аяа Расулаллах, мэдээж хүлээж авна!» гэлээ. Тэгэхлээр минь Эзэн маань гараараа толгойг минь илэв. Одоо миний үс гэзэг цайсан боловч, Расулаллахын ариун гараараа хүрсэн хэсэг нь хэвээрээ хар байна.” (Бухарий, *эт-Тарихуʼл-Кэбир,* II, 78; Али эл-Муттакий, XIII, 298/36862)

Тэнгэрлэг учралын бишрэлд толилуулсан өөр нэгэн явдлыг ч Жабир -радъяллахү анх- ингэж ярина:

“Ухудын Дайны өмнөх шөнө аав намайг хажуудаа дуудаж:

«–Нэбий -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн асхабаас анхны шэхид болох хүнийг би болно гэж бодож байна. Расулаллах -алэйхиссалатү вэссэлам-аас гадна миний хувьд хойноо үлдээх хамгийн үнэт хүн минь чи юм. Би өртэй, тэднийг төл. Дүү нартаа байнга сайнаар ханд!» гэв.

Өглөө миний аав анхны шэхид болсон хүн болов. Өөр нэгэн шэхидийн хамт түүнийг нэгэн булшид оршууллаа. Дараа нь түүнийг тусгай нэгэн газар оршуулах юмсан. Зургаан сарын дараа булшаас нь гаргалаа. Миний нүд юу хараа вэ: Чихний хэсгээс бусад хамаг бие нь түүнийг булшилсан өдрийнх шиг байв! Тэгээд түүнийг ганцаар нь нэгэн булшид оршууллаа." (Бухарий, Жэнаиз, 78)

Ухудын шэхидчүүдийг дурдахад Оршигчдын Туяа Эзэн маань, тэд ариун шэхидчүүдийн эрдмийг илэрхийлэх учраар:

"Валлахи асхабынхаа хамт би ч шэхид болоод Ухуд Уулны ёроолд хонохыг маш их хүснэ!" хэмээн айлдсан байдаг. (Ахмад, III, 375)

Дахиад Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэгэн өдөр Ухудын шэхидчүүд дээр очоод:

"–Тэдний иман ба үнэнчийг би гэрчилнэ" гэв.

Эбү Бэкир -радъяллахү анх-:

"–Аяа Аллахын Элч ээ, бид тэдний ахан дүүс биш үү? Тэд яаж мусульман болсон бол бид ч мусуьман болов, тэдний жихад хийсэн шиг бид ч жихад хийлээ!" гэв.

Хүндэт Элч Эзэн маань ингэж хариулав:

"–Тийм, чиний хэлсэн нь зөв, гэтэл мний хойно ямар бид'атууд гэр бүл мэт холбоо гаргахыг тань би мэдэхгүй."

Хазрат-и Эбү Бэкир уйлж уйлж:

"–Тэгэхээр бид Чамаас хойно үлдэх юм уу?" гэж санаа зовов. (*Муватта*, Жихад, 32)

Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх-ын энэ байдал нь, Хайрт Пайгамбарт маань мэдэрсэн ижилгүй хайрынх төвшнийг

ба түүнийг, **Аллахын элч гэдгийг** үзүүлэх маш гоё нэгэн жишээ юм.

Асхаб-и кирам нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн бүхнээс, түүнчлэн аминаасаа илүү хайрладаг байв. Гэртээ сууж байхдаа ухаанд нь Орчлонгуудын Эзэн ороход гэр нь давчуу санагдана, шууд босоод тэргэд нь очдог, Түүний ариун, сарнаас саруул царайнд нь хараад сэтгэл амраад, яриа нь тайвнаа олдог байв.[146] Түүний хараагүй байхдаа амь нь бараг биендээ багтахааргүй болдог байв. Диваажинд Түүнтэй хамт байж чадахгүй байх вий гэсэн айдас нь түүний царайг цонхийлгож, яахаа мэдэхгүй болгодог байв.[147] Жишээлбэл Түүнд үйлчилж байсан Рэбиа -радъяллахү анх- нь нэгэн өдөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн; *"Надаас юу хүссэн бол хэлчих!"* хэмээн айлдсанд нь диваажинд Түүтэй хамт байхаас өөр юм хүсээгүй байв.[148] Асхаб нь нас барахдаа Аллах болон Элчид нь хүрэхэд маш баяр баясгалантай болдог байв.[149] Ийм л учраас тэд –Исламын шимийн дараа- *"Хүн хайртынхаа хамт юм,"* гэсэн номлогчийн сайхан мэдээнд баяссан шигээ өөр юунд ч баяссангүй байв.[150]

Ал-и Имран Сурагийн жаран ает нь Ухуд Дайнтай хамаатай байдаг. Мисвэр бин Махрамэ Ухудын тухай асуусанд Абдуррахман бин Авф:

146. Касталланий, II, 104.
147. Куртубий, V, 271.
148. Мүслим, Салат, 226; Ахмад, III, 500.
149. Ахмад, I, 8; Ибн-и Мажэ, Жэнаиз, 4.
150. Бухарий, Эдэб, 96.

“Ал-и Имран Сурагийн 120-р аетаас нь унш; бидэндтэй Ухудад очсон шиг байх болно!” гэсэн байв. (Ибн-и Хишам, III, 58; Вакидий, I, 319)

“Бид Ухудад Хайртай, Ухуд ч Бидэнд Хайртай!”

Ухуд нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн сэтгэлд тусгай нэгэн байр эзэлдэг байв. Орчлонгийн Хүндэт -алэйхи экмэлү’т-тахийят- Эзэн маань амьралынхаа турш Ухуд болон Ухудын шэхидчүүдийг олон удаа зочилсон байдаг. Заримдаа ч:

“Бид Ухудад хайртай, Ухуд ч бидэнд хайртай!” хэмээдэг байв. (Бухарий, Жихад, 71; Мүслим, Хажж, 504) Номлогчийн ийм магтаалыг хүртсэн шэхидчүүдийн орон Ухуд нь Аллахын Элчийн хайраар бүрэн дүүрсэн нэгэн газар буйгаараа киямат хүртэл ирэх үммэтэд хүндэт дурсамжаар дүүрэн зочлох газар болсон байдаг.

Пайгамбар Эзэн маань дайны дүнгээс болж Ухудын тухай муухай тэмдэг олгож мэдэхээс санаа зовсон, итгэгчийн сэтгэл орших магадтай ямар нэгэн өшөө хорслын мэдрэмжид саад болохоор:

“Бид Ухудад хайртай, Ухуд ч бидэнд хайртай!” хэмээж энэ газрын тухай хайраа илэрхийлсэн байдаг. Пайгамбар Эзний маань энэ хайрын элбэгээр Ухуд ялагдсан газар шиг биш, Эзний маань чин сэтгэлийн хайраар холбогдсон, элгэнд нь ариун шэхидчүүд олшруулсан хүндэт нэгэн газар буйгаараа дурдсаар байдаг.

Нөгөө талаас Ухудын Пайгамбар Эзнийг маань таньж хайрласан нь үнэндээ хамаг оршигчдын Хүндэт Элч Эзнийг маань мэдээд нотлосны үнэн ил нэгэн жишээ юм. Энэ тухай Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“Чөтгөр сүнс ба хүмүүсийн босогчоос гадна, тэнгэр газар хоёрын хооронд буй бүх юм намайг Аллахын Элч буйг мэддэг,” хэмээсэн байдаг. (Ахмад, III, 310)

Ухудын Газванаас Гаргах Учир Ухаан

Ухудын Газвад аймшигтай гунигт явдлын хамт амьдралын олон гашуун ба таатай тал нь боолчлолын том нэгэн эрдэм төгс байдлаар туршсан байв. Нэг талаас итгэлийн сайхан мэдрэмжээр тэвчээр, бууж өгөх ба хувь заяагаа хүлээн зөвшөөрөхийг толилуулж байхад, нөгөө талаас хоромхон хугацаанд дэлхийд эрмэлзэх мэтийн нэфсийн дутагдлаас болж амьдралын маш гашуун шалгалттай бас тааралдсан байв.

Аллахын Элчийн тушаалыг хэрэгжүүлэхдээ бодолгүй хандах нь дайны хувь заяаг гэнэтхэн өөрчилж, ялалтыг хойшлуулсан байв. Цөөн хэдэн хүний алдаа нь ердийг яллахаар дүгнэсэн, бүгд хамтдаа төвөгтэй тааралдсан байв. Учир нь сүннэт нь ийм л байдаг. Тэдний дунд Аллахын итгэгч байсан нь ч ийм заншлыг өөрчлөөгүй юм.

Гэтэл Асхаб-и кирам нь Бэдирт Аллахын Элчийг маргалдаангүйгээр дагаж бууж өгсөн байцгаав. Түүнд:

“–Аяа Аллахын Элч ээ! Бид Чамд итгэсэн, Аллахаас авчирсан Кур’аны чинь үнэн буйд чин сэтгэлээрээ итгэн үнэмшсэн ба Чамайг байнга дагахаар ам өгцгөөлөө. Юу хүсвэл тэгж хөдөл, бидэнд тушаа, бид Чамтай хамт. Чамайг илгээсэн Аллахын эрхээр Чи тэнгист орвол бид ч Чиний хамт орно, бидний хэн ч хоцрохгүй!..” (Ибн-и Хишам, II, 253-254) гэсэн асхаб нь тэнгэрлэг бишрэлийн оргил байв.

Ухудын Дайн дахь тэнгэрлэг шалгалтын учир бол, зарим мэдрэмжтэй ба чухал хэргээр үзүүлсэн гэнэтхэн санаандгүй хандлагаас итгэгчдэд сануулга олгоход байв.

Ухудын хамгийн чухал нууц нь итгэгчдийн дунд холилдсон мүнафикчуудаас арилгах нь юм.

Өөр нэгэн нууц учир бол мүшрикчүүдэд үнэндээ ямар ч ашиг болохгүй хуурмаг нэгэн ялалт олгож, тэдний сэрээгүй байдалд хөдөлгөөнгүй болохыг хангах байв. Уг хуурмаг ялалтаар Бэдирээс нааш мүшрикчүүдийн сэтгэлд цугларсан өгөө тайвширсан, өнгөрсөн хугацаанд тэдний Исламд мэдэрсэн голох мэдрэмж нь багассан байв.

Асхаб-и кирамын их бага гэлгүй бүгдээрээ Ухухын Газвад оролцохоор өрсөлдсөн нь анхаарал татмаар юм. Арван таван насны хүүхэд гэмээр залуус нь Расулаллахын цэрэг болох тулд ямар ч хамаагүй аргыг ашигласан байв. Нас бүрийн хүний иймэрхүү үхэл рүү зүтгэсний нууц бол, тэдний зүрх хүчтэй нэгэн имантай байсан бөгөөд орчлонг туурвисны учир буй Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д сэтгэлдээ мэдэрсэн домгийн хайрын мэдрэмж байдаг юм. Энэ итгэл үнэмшил ба хайр хаа байсан ч тэнд бүх төрлийн зориг байдаг. Хаа ч багассан ч, тэнд залхуурал, дорой байдал ба айдас илэрнэ. Энэ хайрын арга бол зикир буюу Аллахын гэрийн дурдахыг ихэсгэх, Расулаллахад ихээр салават хэлэх, Аллахын ивээлийн тухай бясалгах ба Расулаллахын аж байдал арга ба ёс суртахуунаар чиглэхийг хичээх юм.

Ухудад Оршигчдын Туяа шархтсан ба шэхид болсон гэсэн *хуурамч* мэдээ тарсан нь итгэгчдийн талаар чухал нэгэн нууц учиртай. Тэд тэр хооронд итгэл ба ухааны шалгалтаа өгнө. Ингээд Аллахын Элч ч нэгэн хүн буйг, цаг болоход Түүний ч Рабдаа үнэнч үлдэх, Түүнийг нас барсны дараа итгэгчдээс эргэж буцалгүй Пайгамбарын маань заасан замд үргэлж явах хэрэгтэйг сураад, ийм байдалтай тааралдахаас өмнө, нэг талаар зүрхээрээ бэлдсэн болцгоов.

Товчоор нь хэлбэл Ухудад мусульманчуудад дайсантай хийсэн дайнд ялалтад яаж хүрэх ба ялагдах гамшгаас яаж аврагдах мэтийн маш чухал хичээл толилуулсан байдаг.

Хамрау'л-Эсэд
(3 оны Шэввал сарын 8 / 625 оны 3 сарын 24)

Сэтгэлд нь хурсан айдсаас болж Ухудаас салж Маккагийн замд орсон мүшрикчүүдэд, Аллах -жэллэ жэлалүхү- том нэгэн хайнга байдал олгосон байв. Тэдэн замдаа арай л ухаан орж чадлаа. Дахиад эргээд итгэгчид рүү дайрахыг бодоцгоов.

Тэр хооронд Мадинад харьсан буй Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч дайсандаа нэг айдас төрүүлэх хэрэгтэй гэсэн санаатай байв. Аллах Таала энэ тухай огт ухамсаргүй байж болохгүй хэрэгтэйг мэдүүлсэн уг аетаа буулгав:

وَلاَ تَهِنُواْ فِي ابْتِغَاء الْقَوْمِ إِن تَكُونُواْ تَأْلَمُونَ فَإِنَّهُمْ يَأْلَمُونَ كَمَا
تَأْلَمونَ وَتَرْجُونَ مِنَ اللّهِ مَا لاَ يَرْجُونَ وَكَانَ اللّهُ عَلِيمًا حَكِيمًا

"Дайсныг дагахдаа ухамсаргүйгээр бүү ханд. Хэрэв та өвдөж байвал, андашгүй нь тэд ч таны өвдсөн шиг өвдөж байна. Харин та Аллахаас тэдний найдаж чадахааргүй юманд найддаг. Андашгүй нь Аллах бүхнийг мэдэгч, учрын эзэн юм." (эн-Ниса, 104)

Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм- асхабаасаа:

"–Дайсныг хэн нь дагаж явмаар байна вэ?" хэмээн асуув.

Даруй хооронд нь Хазрат-и Эбү Бэкир ба Зүбэйр -радъяллахү анхүмаа- ч оролцсон нэгэн анги бэлдэв. Дайсныг

дагаж явахаар гарсан энэ аянд оролцогчид нь бараг бүгдээрээ шархтай байв. Энэ шархтай мүжахидчууд бэлтгэлээ хийгээд Эбү Инэбэгийн худгийн дэргэд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн эгнээнд оров.[151]

Үсэйд бин Худайр -радъяллахү анх- нь шархтнуудад туслахаа байж:

"Би Аллах болон Элчийнх нь урилгыг сонсоод бууж өглөө!" гэсэн ба шууд зэвсэглээд Пайгамбар Эзний маань дэргэд ирэв.

Са'д бин Убадэ -радъяллахү анх- ч яаран бэлдэж аймагтаа ч даруй хөдлөхийг тушаав. Тэд ч шууд зэвсгээ бүсэлж ирцгээв.[152]

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ч оролцсон энэ анги нь удахгүй дайсны араас явж эхлэв.

Абдуллах бин Сэхл ба дүү нь Рафий -радъяллахү анхүмаа-нар Ухудад Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм-тэй хамт байлдсан ба шархтай хэвээрээ Мадинад харьсан байв. Аллахын Элчийн дайсныг дагахаар мусульманчуудыг урьсныг сонсоод:

"–Валлахи бидэнд нэг ч унаа үгүй, шарх ч маш хүнд. Харин Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн оролцсон аянаас хэзээ ч алдахгүй!" гээд шууд замд гарцгаав. Шарх нь хөнгөн байсан нь хүнд шархтад нэг алхахад тусалж, нэг үүрч явав. Ингэж Орчлонгуудын Эзнээс салаагүй.[153]

Ийм үнэнч зангаа толилуулсан итгэгчид нь тэнгэрлэг магтаалыг хүртэв:

151. Вакидий, I, 334-335.

152. Вакидий, I, 334-335.

153. Ибн-и Хишам, III, 53.

لِّذِينَ اسْتَجَابُواْ لِلّهِ وَالرَّسُولِ مِن بَعْدِ مَا أَصَابَهُمُ
الْقَرْحُ لِلَّذِينَ أَحْسَنُواْ مِنْهُمْ وَاتَّقَواْ أَجْرٌ عَظِيمٌ

“Шархтсаны дараа дахиад Аллах болон Пайгамбарыг дагагсад, ялангуяа **тэдний дундаас сайн сайхан хийгчид ба такватай байгчдын төлөө маш том шагнал байдаг.”** (Ал-и Имран, 172)

Тус анги нь Мадинагаас найман километр зайтай оршдог бөгөөд энэ аяны нэр болсон “Хамраү’л-Эсэд” гэдэг газар хүртэл явав. Туг нь Хазрат-и Али -радъяллахү анх-ын гарт байв. Шөнө болохлоор Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь таван зуун тус тус газар гал түлэхийг тушаав. Гайхамшигт нэгэн явдал илрэв. Эргэн тойрноос харагсад нь тэнд хэт том ба гайхалтай нэгэн арми байсныг боддог байв. Жишээлбэл тэр хооронд Макка руу явж байсан ба арай мусульман болоогүй Мабэд гэсэн нэртэй нэг нь, мүшрикчүүдийн цэрэгт гүйцэж мусульманчуудын тэднийг дагаж буйг мэдээлэв. Тэдний өнөр буйг ойлгуулахаар ч:

“–Би насаараа ийм олон цэргийг харсан биш юм,” гэв. Энэ байдлыг мэдсэн мүшрикчүүдийн зүрхэнд агуу нэгэн айдас төрүүлээд:

“–Мусульманчуудад хөдлөх тэнхээ ч үлдээгүй байв. Үүнийг яаж ингэж байдаг юм бэ?” гээд бие бие рүүгээ харцгаав. Дараа нь учрыг нь ойлгож чадаагүй тул:

“–За, эндээс холдож явцгаая! Гай зовлон хол өнгөрөг” гэцгээв.

Мүшрикчүүд яасан ч эргэж байлдахаар бодож чадаагүй. Эцэст нь хурдхан Макка руу замдаа гарцгаав. Тэднийг ингэж

холдож явахлаар нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч асхабынхаа хамт дахиад Мадинад харив.[154]

Өв Хөрөнгийн Тухай

Энэ хооронд өв хөрөнгө хуваахад хамаатай ает-и кэримэнүүд буув. Учир нь, Ухудын дараа энэ талаар зарим эмх цэгцгүй байдал бий болсон байв. Ухудад шэхид болсон Са'д бин Рэбий -радъяллахү анх-ын эрэгтэй дүү нь, түүний хоёр охинд юу ч үлдээлгүй хамаг өвийг нь авсан байв. Энэ бол мунхаг үеийн зан байв. Харанхуй засгийн үед эмэгтэйчүүд болон охидод үнэ цэнэгүй байсан тул, тэдэнд өв хөрөнгийн эрх ч байгаагүй. Ислам нь энэ эрхгүй заншлыг өөрчлөв:

يُوصِيكُمُ اللّهُ فِي أَوْلاَدِكُمْ لِلذَّكَرِ مِثْلُ حَظِّ الأُنثَيَيْنِ فَإِن كُنَّ
نِسَاء فَوْقَ اثْنَتَيْنِ فَلَهُنَّ ثُلُثَا مَا تَرَكَ وَإِن كَانَتْ وَاحِدَةً فَلَهَا
النِّصْفُ وَلأَبَوَيْهِ لِكُلِّ وَاحِدٍ مِّنْهُمَا السُّدُسُ مِمَّا تَرَكَ إِن كَانَ لَهُ
وَلَدٌ فَإِن لَّمْ يَكُن لَّهُ وَلَدٌ وَوَرِثَهُ أَبَوَاهُ فَلأُمِّهِ الثُّلُثُ فَإِن كَانَ لَهُ
إِخْوَةٌ فَلأُمِّهِ السُّدُسُ مِن بَعْدِ وَصِيَّةٍ يُوصِي بِهَا أَوْ دَيْنٍ آبَآؤُكُمْ
وَأَبناؤُكُمْ لاَ تَدْرُونَ أَيُّهُمْ أَقْرَبُ لَكُمْ نَفْعاً فَرِيضَةً مِّنَ اللّهِ
إِنَّ اللّهَ كَانَ عَلِيما حَكِيمًا

"Аллах танд хүүхдүүдийн тань тухай; эрэгтэйд эмэгтэйн хувийн хоёр дахин (өв хөрөнгө өгөхийг) **тушаана. Хэрэв**

154. Ибн-и Хишам, III, 52-56; Вакидий, I, 334-340.

охид хоёроос дээш байвал, өнгөрсөн хүний үлдээсэн өвийн гуравны нэг нь тэднийх болно. Хэрэв (өв залгамжлагч нь) **зөвхөн нэг охин байвал, тал нь түүнийх юм. Өнгөрсөн нь хүүхэдтэй байвал, аав ээжээс аль нэг нь ч өвөөс зургааны нэг хувь байдаг. Хэрэв хүүхэдгүй бөгөөд аав ээж нь түүнд өв залгамжлагч болсон байвал ээжид нь гуравны нэг** (үлдэнэ). **Хэрэв өнгөрсөн хүний дүү байвал, ээжид нь зургааны нэг** (үлдэнэ. Энэ бүхэн хувиуд өнгөрсөн хүний) **хийх гэрээс ба өрийн нь төлсний дараа л юм. Аав болон хөвүүдээс алиныг танд буянаараа илүү ойр буйг та мэдэж чадахгүй. Эдгээр нь Аллахын тогтоосон фарз** (хувь) **юм. Андашгүй нь Аллах, оюун ухааны эзэн мөн.”** (эн-Ниса, 11)

Ингээд Исламд анхны өв хуваах ажил нь Са’д бин Рэбий -радъяллахү анх-ын өв залгамжлагчдын хооронд болов.[155]

Исламын өвийн хуульд, хувь ба хариуцлага хоёрын хооронд эрх тэгш байдал байдаг. Зардал ихтэй эрэгтэйд, эмэгтэйтэй харьцуулбал илүү хувь олгосон байдаг. Учир нь гэрлэхдээ мэхир өгөөд хуримын зардлыг даахаар үл барам, гэрийн аж ахуйтай хамаатай хамаг зардлыг гэр бүлд эрэгтэй хүн хариуцана.

Өөрөөр хэлбэл Исламын өвийн хууль дахь эр-эмийн ялгаа нь хариуцлагын ялгаатай холбоотой юм. Энэ хоёрын хооронд нэгэн тэгш байдал хангасан байдаг. Эмэгтэй нь удмыг хамгаалах, үүний төлөө хүүхэд төрүүлж өсгөх ба гэрийн эмх цэгцийг хангах мэтийн хүнд хариуцлагаас нь болж гэрийн зардлыг авч явахаар хариуцуулаагүй. Ийм учраас өвийн хагаст буулгасан байдаг. Уг хувь ч зарим эмэгтэйчүүд гэрлээгүй эсвэл салсан мэтийн тохиолдлыг бодон түүнд олгосон байдаг.

155. Ахмад, III, 352, 375.

Эмэгтэйчүүдэд мөн гүн мэдрэмж, нарийн бодол, энэрэл, сайхан ааль, халамж, хүүхдийг өсгөж хүмүүжүүлэх ба удмыг хамгаалах мэтийн гавьяа олгосон байдаг. Тэдний биеийн бүтэц нарийн, мэдрэл нь хэт хүчтэй ба энэрэл өндөр буй тул амьдралын тустай үед зарим содон зүйлстэй тааралдахдаа заримдаа бие болон сүнсний талаараа хүч хүрч чадахгүй нь магад. Ийм л учраас Исламд эмэгтэй хүний гэрчилгээ нь тал юм. Үүнийг хэлэндээ эргүүлэн Исламд дайрагчид Исламын туурвилтай хамаатай ба өөрчлөгдөхгүй шинжид анхаарал үзүүлснээс үүссэн энэ дүрмийн төгс талыг харахгүйгээр хандацгаана.

Үнэндээ, Аугаа Эрх нь оршигч бүр болон тэх оршигчийн хэсэг бүрийг нэгэн зорилгоор туурвисан бөгөөд тэдэнд зорилгоо хэрэгжүүлэхэд зохимжтой физикийн (биологийн) ба сүнсний (сэтгэл зүйн) бүтэц хайрласан байдаг. Эрэгтэйг амьдралыг авч явах ба гэрийн зардлыг хангах хариуцлага даасан Туурвигч Таала Хазрат нь түүнийг уг үүргээ ёсоор нь хэрэгжүүлэхээр биеэрээ илүү хүчтэй, сүнсээрээ ч илүү тэвчээртэй болгосон байдаг. Эмэгтэй бол удмыг хамгаалах, хүүхэд хүмүүжүүлэх ба хүүхдийг хамгийн хэрэгтэй үед нь сахин хамгаалах ба туслахаар томилогдсон байдаг. Ийм л учраас түүний үүрэг биеийг нь сүнсийг нь илүү гүн мэдрэлээр төхөөрөмжлөхийг шаардана. Үүнээс болж хүүхдийг анхны хүчгүй эринд түүнийг гүнзгий энэрэл ба хайраа тэврэч өсгөхийн тулд эмэгтэй тэнгэрлэг шинж болох хэтэрхий гэмээр мэдрэмж хайрласан байдаг.

Ийм мэдрэмжтэй энэрлийн булаг буй ээжид, туурвилын зорилгоос гадна өөр нэгэн үүрэг даалгавал, сөрөг үр дүн гарна. Тийм учраас эмэгтэй хүн гэмт хэрэгтнийг өрөвдөөд хуулийг хуурах магадлал өндөр байдайг. Энэ бол түүний гэрчлэх ба тэнгэрлэг шийдвэрийн нууц учрын нэгэн юм.

Нөгөө талаас Ислам нь гэрчилгээг хүний сэтгэлийн байдлаар ч зохицуулна. Хэрэгтэй үед эр хүний хүсэлд анхаарал үзүүлэхгүй байхад, зарим тохиолдолд эмэгтэй хүний хүслийг бүтнээр нь хүлээж авна. Жишээлбэл эрэгтэйчүүд байхгүй газарт зөвхөн эмэгтэйчүүд нь хангалттай гэж тоолдог.[156]

Гэрчилгээний тухай эмэгтэй хүнийг дутуу гэж үзсэнийг санал бологсод нь Исламын ийм дутагдлаас хол буйг, Түүний эрх ба хариуцлага хоёрын хооронд эрх тэгш байдал хангахдаа хүний өөрчилдөггүй туурвилын шинжийн хамт нийгэмд бүтнээр нь анхаарал хандуулсныг ойлгодоггүй эсвэл ойлгомоор байдаггүй юм.

Эмэгтэй хүний төгс төгөлдөр нь Аллахын олгосон сайхан гавъяагаа хамгаалахаар хэрэгжинэ. Хэрэв эмэгтэй нь шинжүүдээ тэнгэрлэг томилолтын эсрэгээр чиглүүлж, өөрийнх үнэнтэй зөрчвөл, үнэ цэнээ мөхөөнө; тайвангүй ба аз жаргалгүй байх болно. Гэр бүл, голомтоо сөнөөнө. Ингээд нийгмийн амьдралаас шоовдорлогдоно.

Бидний үед эмэгтэй эрэгтэй хоёрын хооронд хиймэл ба эрхгүй нэгэн тэгш байдлын уралдаан эхэлсэн мэт байдаг. Эмэгтэй хүний туурвилын шинжийн эсрэг буй энэ уралдаан нь, ээжийн үүргийг эвдээд гэр бүлийг шархдуулдаг. Ийм учраас манай эринд ихээр болдог үр хөдлүүлэх байдал нь, мунхаглалын үе дэх охин хүүхдүүдийг амьд буйгаар нь булахын орчин цагийн маяг бөгөөд манай эриний хүн амь хороох хэрэг юм. Энэ эриний ядарч туйлдсан эмэгтэй ба мунхаглалын үеийн эмэгтэйн хооронд гагцхуу хувцасны шүүгээний ялгаа, өөрөөр хэлбэл хувцас хунарын ялгаа үлдсэн байдаг. Энэ бол сүнсгүй материалист боловсролын хэрэгжүүлсэн нйигмийн гамшиг мөн.

---

156. *Мэжэллэ,* зүйл. 1685.

ХИЖРЭТИЙН ДӨРӨВ ДЭХ ЖИЛ

Рэжий Явдал нь (4 оны Сафэр / 625 оны 7 сар)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Исламын тэблиг хийх ба сургах зорилгоор эргэн тойрны аймгуудад муаллим буюу багш нар илгээдэг байв. Харин илгээсэн зарим багш нар нь урвасан байв. Эдгээрийн хамгийн томоос нэг нь "Рэжий Явдал" юм:

Мадинагийн хавийн Адал ба Карэ аймгууд нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс өөрсдөө ИСламыг сургах багш нар нэхэцгээв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч Асим бин Сабитаар тэргүүлсэн арван хүний хамт олныг илгээв.

Хамт олон нь Усфан ба Маккагийн хооронд оршдог бөгөөд Хүдат гэдэг газар хүрэв. Хүзэйл аймгийн тойрог дахь Рэжий гэдэг усан дээр хонов. Мусульман багш нарын энэ хавьд ирсэн нь Хүзэйл аймгийн салбар буй Лихъяанчуудад мэдээлсэн байв. Лихъяаныхан зуун шахам харвагчдаар бүрдсэн хамт олноор тэднийг дагаж эхлэв. Асим ба найзууд нь мөрдөхийг анзаарангуутаа өөрсдийгөө хамгаалах өндөр нэгэн газар хоргодов. Дайсан ч тэднийг бүслэв:

"–Доош уруудаад, барьсан зэвсгээ орхиж бууж өгцгөө. Танаас хэн нэгийг ч алахгүйгээр амлаж байна!" гэцгээв.

Тэгэхлээр нь Асим:

“–Найз нар аа! Би нэгэн кафирын үгэнд итгээд доош уруудахгүй!” гэв. Араас нь ч:

“–Аллах минь, бидний байдлыг Элчдээ мэдүүл!” хэмээн залбирав. Дараа нь дайснууд нь Асим болон түүний хамт зургаан хүнийг харваад шэхид болгов.

Асим бин Сабит шархадсандаа:

“–Аллах минь! Би өдрийн эхэнд Чиний шашныг хамгааллаа; Чи ч өдрийн адагт миний шарилыг хамгаал!” гэж залбирсан байв.

Курайшийн чухал хүмүүсээс зарим нь, түүний шэхид болгосны мэдээлэл авахдаа, Бэдирийн Дайнд тэдний нэгийг алсан учраас, түүнийг таниулах хэсгийг авчрахаар хүн илгээв. Харин Аллах Таала нь Асим -радъяллаху анх-ыг хамгаалахаар зөгийн сүрэг илгээв. Зөгийн энэ үүл нь Асимын шарилыг бүрхэв. Курайшийн хүмүүс түүний шарилаас ямар ч хэсэг тасалж чадаагүй. (Бухарий, Жихад, 170; Мэгазий, 10, 28; Вакидий, I, 354-363)

Орой болоод зөгий тарахыг хүлээсэн дайсан, огт санаандгүй тохиолдолтой тааралдав: Гэнэтхэн бороо орж, үер урсаад Асимын шарил ч тэр хооронд алга болов. Дайсан ч Асимын шарилаас ямар ч хэсэг таслах завшаан олж чадаагүй. Үүний дараа Асим нь “Зөгийн Хамгаалсан Шэхид” гэсэн нэрээрээ дурдав. (Ибн-и Хишам, III, 163)

Мүшрикчүүд нумынхаа хөвчийг тайлж, бууж өгсөн мусульманчуудыг хөдөлгөөнгүй хүлэхийг хичээвэл найм дахь нь :

“– Валлахи би танд ерөөсөө бууж өгөхгүй. Энэ шэхидчүүд надад сайхан үлгэр жишээ юм!” гээд эсэргүүцэв. Мүшрикчүүд

түүнийг хүчээр чирээд авмаар байсан ч тэр ширүүн эсэргүүцэв. Тэгсэнд түүнийг ч шэхид болгов.

Энэ арван сахабийгаас хойно хоёр нь үлдэв: Хүбэйб ба Зэйд -радъяллахү анхүмаа-. Мүшрикчүүд тэднийг аваачаад Маккад зарав. Хүбэйбийг Бэдирийн Газвад алсан Харис бин Амирын хөвүүд худалдаж авав. Хүбэйб нь тэдний түүнийг алахаар шийдсэн өдөр хүртэл тэдний дэргэд боол хэвээрээ үлдэв.

Гэр бүлээс нэгэн эмэгтэй ингэж хэлнэ:

“Аллахад тангараглая, би насаараа Хүбэйбээс сайн боол үзээгүй. Валлахи би түүнийг гинжээс уяатай байсан ба Маккад ямар ч жимс олдоогүй нэгэн өдөр шинэ усан үзэм идэхийг харсан. Энэ нь Аллахын Хүбэйбэд хайрласан нэгэн хишиг шим байв. Хүбэйб нь Кур’ан уншдаг, тэхэжжүд мөргөл үйлддэг байв. Түүний уншсан Кур’аныг сонссон эмэгтэйчүүд, сэтгэл зөөлөрч уйлдаг байв. Түүнээс би:

«–Хүбэйб ээ! Чамд ямар нэгэн хэрэгцээ бий юү?» гэж асуусан байлаа.

«–Үгүй! Надад амтат ус уулгахаас, баримлын нэрээр төхөөрсөн малын мах идүүлэхгүй байхаас, бас намайг хэзээ алахыг надад мэдүүлэхээс өөр юм надад хэрэггүй!» гэв.

Харам саруул дуусч, түүнийг алах шийдвэр гарсныг түүнд мэдүүлэхэд минь, валлахи түүнийг ийм учиртай айсан эсвэл санаа зовсныг харж үзээгүй. Харисын хөвүүд түүнийг алахаар Харамын гаднах Хилл хэмээдэг газар аваачихад нь Хүбэйб тэдэнд:

«–Та нарыг зөвшөөрвөл би хоёр рэкат мөргөл үйлдэе,» гэв. Тэд зөвшөөрөв. Хүбэйб нь хоёр рэкат мөргөл үйлдсэний дараа:

«–Аллахад тангараг өргөе, та намайг үхэхээс айсныг бодохгүй байвал би энэ мөргөлийг илүү удаан үйлдэх байлаа,» гэв. Ингэхдээ Хүбэйб нь цаазлах мусульман бүрийн хоёр рэкат мөргөл үйлдэх заншлыг анх эхлүүлсэн хүн болов.

Дараа нь:

«Аллах минь! Эд нараас аль нэгийг ч, нэг нэгээр мөхөө, амийг нь нэг нэгээр ав, аль нэгийг ч амьд битгий үлдээ!» гэж залбираад[157] ийм утгын шүлэг уншив:

«Мусульман буйгаараа нас барсны дараа яаж үхсэндээ санаа огт зовохгүй. Энэ бүх нь андашгүй нь Аллахын төлөө л юм. Тэрээр хүсвэл хэсэглэсэн биеэрээ Эрхийн тааламжид хүрэх минь маш амархан болно!»

Хүбэйб -радъяллаху анх- дараа нь Аллах Таалагаас ингэж хүсэн ерөөв:

«Илахий (Бурхан минь)! Энд дайсны царайгаас өөр царай харж чадахгүй! Чиний Элчид илгээх хүн ч алга! Түүнд миний мэндийг Чи хүргэж өгөөрэй!»

Тэр хооронд асхабынхаа хамт Мадинад бууж байсан Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн:

157. Хүбэйбийг залбирч байхад тэндэх хүн бүр айсан, залбирлын нөлөөнөөс биеэ хамгаалахаар ийш тийш гүйж нуугдахыг хичээсэн, амьд үлдэхгүйгээ бодсон байцгаав. Сар гаруй хугацаагаар Курайшийн цуглалтуудад Хүбэйбийн хараалаас өөр юм яригдаагүй байв. Саид бин амир нь заримдаа ухаан балартдаг байв. Умар -радъяллаху анх- калиф байсан эриндээ түүний энэ байдлыг сонсоод ямар нэгэн өвчин бий эсэхийг асуусанд Саид:
"–Аяа итгэгчдийн ноён оо! Надад ямар нэгэн өвчин үгүй. Харин би Хүбэйб алагдсанд тэнд байсан, түүний хараалыг сонссон байв. Валлахи үүнийг санавал, би ухаан алдана!" гэв. (Вакидий, I, 359-360)

«Тэр мэнд байх болтугай!» гэсэн утгаар; وَعَلَيْهِ السَّلَامُ хэмээс-нийг эргэн тойрныхон нь дуулав. Асхаб-и кирам гайхан:

«–Аяа Расулаллах аа! Хэний мэндийг хариулаа вэ?» гэж асуухад:

«–Таны дүү Хүбэйбийн мэндийг. Жибрийл нь энд байна, Хүбэйбийн мэндийг хүргэж өгөв!» хэмээв. Ингээд Нэбий -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь энэ сахабийчуудын шэхид болсныг асхабтаа шууд мэдүүлэв.” (Бухарий, Жихад, 170; Мэгазий, 10, 28; Вакидий, I, 354-363)

Цаазын дүүжлүүрээс уяатай байхад нь Хүбэйбээс асууц-гаав:

“–Чиний оронд чамаайг аврахаар Пайгамбарыг чинь авчи-рахыг хүснэ үү?”гэхэд

Хүбэйб нь хашхиран хариу өгөв:

“–Хэзээ ч болохгүй! Түүний одоо энэ миний байранд авчи-рах байтугай, одоо Мадина-и Мүнэвээрэд ариун хөлд нь өргөс хатгахыг ч миний сэтгэл хүлээн зөвшөөрөхгүй!”

Ийм хариуд гайхсан Эбү Сүфьяан:

“–Би дэлхийд найзуудын Мухаммед чинээ хайрласан өөр хүнийг харж үзээгүй!” гэхээс аргагүй болов. (Вакидий, I, 360; Ибн-и Са’д, II, 56)

Түүнийг дүүжлэхдээ царайг нь Мадина руу эргүүлцгээв. Хүбэйб -радъяллахү анх-:

“–Аллах минь, хэрэв энэ хийсэн минь Чиний онгонд нэгэн буян байвал царайг минь кибла руу чиглүүл!” гэж залбирав. Аллах Таала түүнийг кибла руу чиглүүлэв. Мүшрикчүүд хэдий

их хичээсэн ч царайг нь киблагаас өөр тийш эргүүлж чадаагүй. Энэ ариун сахабийгийн тухай:

يَا أَيَّتُهَا النَّفْسُ الْمُطْمَئِنَّةُ. ارْجِعِي إِلَى رَبِّكِ رَاضِيَةً مَّرْضِيَّةً فَادْخُلِي فِي عِبَادِي وَادْخُلِي جَنَّتِي

“Аяа сэтгэл хангалуун болсон нэфс! Чи Тэрээрт, Тэрээр ч чамд таатай болоод Рабдаа харь, (салих) **боолчуудын минь дунд оролцож, диваажинд минь ор!”** (эл-Фэжр, 27-30) аетууд буув. (Куртубий, XX, 58; Алусий, XXX,133)

Хүбэйб -радъяллахү анх-ын дараа шэхид болгосон Зэйд -радъяллахү анх- ч итгэлийн ижил тэвчээрээр дүүрэн байв. Шөнө тэхэжжүд мөргөл үйлдээд, өдөр мацаг барьдаг байв. Баримал бурханы нэрээр төхөөрсөн махан хоол иддэггүй байв. Түүний оронд сүүг илүүд үздэг байв. Сүүгээр мацаг барьж, сүүгээр амаа нээдэг байв. Шэхид болохоор нь **Тэн’им** гэсэн газар очиж байхдаа Хүбэйбтэй тааралдахдаа, тэдэнд таарсан ийнхүү төвгийн тухай нэг нэгэндээ тэвчээрийг зөвлөв. Зэйд -радъяллахү анх- ч хоёр рэкат мөргөл үйлдэв.

“Чиний байранд Мухаммед болохыг хүснэ үү?” асуултыг яг Хүбэйб -радъяллахү анх- шиг хариулав. (Вакидий, I, 361-362)

Түүнд мусульман болохоо байвал чөлөөлөгдөхийг нь хэлсэн тэнэг мүшрикчүүдэд:

“–Мусульман буйгаараа үхэх нь, шашнаа сольж амьдрахаас мянган дахин сайн юм!” гэсэн хариу өгөөд, итгэгчийн хүндээр шэхадэт сархадыг таатай залгив.

Итгэл үнэмшлийн ийм амтыг ухаарсан, Пайгамбарын хайртуудаас Юүнүс Эмрэ Хазрат нь Аллах болон Элчийнх нь төлөө амиа өгч чадах бишрэлтээрээ ахиратад шэфаатын хүртэх хүслээ мөртдөө ингэж илэрхийлэв:

Миний амь Чиний төлөө золиослог,
Гоё нэртэй, гоё царайтай Мухаммед!
Ирээд шэфаат олго төвөгтэй үйлчлэгчдээ,
Гоё нэртэй, гоё царайтай Мухаммед!..

Би'р-и Маунэ Явдал (4 оны Сафэр / 625 оны 7 сар)

Рэжий Явдалтай ижил өдрүүдэд, Нэжидийн нутгийн тэргүүлэгчдээс Эбү Бэра нь аймгаа боловсруулахаар Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс багш нар гуйв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүний энэ хүслийг зөвшөөрөхийг хүсээгүй. Түүнчлэн өөртөө ирсэн бэлгийг ч аваагүй:

"–Би анд нарынхаа тухай Нэжидийн хүмүүсээс (тэдний урвахаас) айна!.." хэмээв.

Тэгсэнд нь Эбү Бэра аймгийнхаа өмнө мусульманчуудын амины талаар баталгаа өгөв. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч Эбү Бэрагийн нэрээр, Нэжид дэх аймгуудыг удирдаж байсан ач нь Амирт хандан тусгай удаан нэгэн захиа бичүүлэв. Дараа нь Асхаб-и Сүффэгээс "Курра" гэгч нэрлэсэн далан хүний багш нарын хамт олныг бэлтгэж Эбү Бэрагийн хамт илгээв.

Багш нарын хамт олон нь, Мадинагаас дөрөв хонох зайд оршдог Би'р-и Маунэд очихдоо, айхтар нэгэн урвалттай тааралдав. Эбү Бэрагийн ач Амир нь өнөр цэргээрээ дайрч, Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн захиаг ч уншаагүй байв. Өөрийнхөө аймаг нь Эбү Бэраг мусульманчуу-

дыг хамгаалсны учраас байлдмааргүй байхад ч, Усайяа, Ри'л, Зэкван, Бэний Лихъяан аймгуудыг хуураад мусульманчуудыг цавчив. Тэдний дундаас зөвхөн Амр бин Үмэйе амиа аварч чадав.[158]

Уг гамшгийн өдөр дайрсан хүмүүсийн дунд байсан Жэббар бин Сүлма үүнийг ярихдаа:

"Мусульманчуудаас намайг Исламд урьсан Амир бин Фүхэйрэд жадаа хатгалаа! Жадын минь түүний цээжийг цоолсныг харлаа! Тэр бол ийм байхдаа:

«–Валлахи би хожлоо!» гэж байв. Би өөртөө:

«–Юуг хожлоо?! Би түүнийг алаагүй байв уу?!» гэлээ. Тэр хооронд шарил нь тэнгэрт өөд өгсөн хараанаас алдрав. Гэрчилсэн энэ байдал миний мусульман болохын учир болов." (Ибн-и Хишам, III, 187; Вакидий, I, 349)

Жэбраил -алэйхиссэлам- нь Хүндэт Элч Эзэнд маань ирээд Ислам боловсролын нэгдлийн шэхид болоод Рабдаа хүрснийг, Раббынхаа тэдэнд таатай болж, тэднийг ч таатай болгосныг мэдээлэв.[159]

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- эдгээр явлуудаас болж ихэд санаа зовов. Ариун гараа тэнгэрлэг орон өөд дэлгэн:

"Аяа Аллах минь ээ! Аллах болон Элчид нь эсэргүүцсэн Ри'л, Зэкван ба Усайяа (аймгуудыг) гэсгээ!" хэмээн сарын турш өглөөний мөргөлийн дараа гуйв. (Бухарий, Жихад 9, 19, Мэгазий 28; Мүслим, Мэсажид, 297)

158. Ибн-и Хишам, III, 184; Хэйсэмий, VI, 125-130.

159. Бухарий, Жихад, 9.

Итгэгчид нь гунигийн нулимсаа урсгав. Мүнафикчууд ба еврейчүүд баяр баясгалан болж, Ухудаас наааш болсон явдалд сэтгэл ханамжтай байцгаав. Мөн мусульманчуудын эсрэг Ухудад ямар нэгэн үйл хийж чадаагүй байхдаа, дотор хадгалсан хилэнгээ илрүүлж, урвагч сурталчилгаагаа хурдуулсан байв. Дайнд явахдаа хийсэн урвалт ба мэхээ том нэгэн авъяас юм шиг үзүүлээд, олон шэхид болсон мусульманчуудад:

"–Тэр үхэгсэд бидний үгийг сонссонсон бол, одоо амьд байж болох байв," гэцгээв. Тэдний ийм байдалд Кур'ан-и Кэримийн хариу нь маш хатуу ба сүрдүүлэх маягтай болов:

الَّذِينَ قَالُواْ لإِخْوَانِهِمْ وَقَعَدُواْ لَوْ أَطَاعُونَا مَا قُتِلُوا قُلْ فَادْرَؤُوا عَنْ أَنفُسِكُمُ الْمَوْتَ إِن كُنتُمْ صَادِقِينَ

"(Гэртээ) **суугаад дүү нарынхаа тухай: «–Биднийг дагасансан бол үхэхгүй байв,» гэгсдэд: «–Хэрэв үнэнярианы хүмүүс байвал амиа үхэхээс авраарай!» гэв!"** (Ал-и Имран, 168)

وَمَا كَانَ لِنَفْسٍ أَنْ تَمُوتَ إِلاَّ بِإِذْنِ اللّهِ كِتَابًا مُّؤَجَّلا

"Үхэхийг Аллахын зөвшөөрлөөс гадна хэн ч өгөхгүй. (Үхэл нь) **тодорхой хугацаанд заясан байдаг..."** (Ал-и Имран, 145)

Энэс -радъяллахү анх-:

"Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн Би'р-и Маунэд шэхид болсон асхабтаа санаа зовсон шиг юунд ч

санаа зовсныг би хараагүй!” гэсэн байдаг. (Мүслим, Мэсажид, 302) Учир нь Би’р-и Маунэгийн шэхидчүүд бараг бүгдээрээ Асхаб-и Сүффэгээс бөгөөд, Аллахын Элчийн сүнсний боловсролыг үзсэн Кур’ан ба сүннэтийн багш нар байв.

Рэжий ба Би’р-и Маунэ явдлууд нь тэблиг ба боловсруулах үүргийн мусульманчуудын хувьд хэр их чухал шаардлага буйг үзүүлдэг. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь асхабынхаа хамгийн шилмэлүүдийг, сонгож аюулыг сөрөн Исламын тэблигчин ба багш болохоор илгээсэн байв. Ийм чухал үүргийн төлөө шэхид болсон мүжахидчуудыг Аугаа Эрх магтсан, тэдэнд таатай буйгаа ба тэднийг Рабтаа таатай буйг илэрхийлсэн байдаг.[160]

Бэний Надирын Урвагч Төлөвлөгөө

Би’р-и Маунэ Явдлаас амиа аварсан Амр бин Үмэйе нь Мадинад харих замдаа, тэдэн рүү дайрсан аймгийн харъяа хоёр хүнийг унтаж байхад нь дарж алав. Харин тэд нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хамгаалалт доор байв. Мадинад зочилж, одоо харьж байцгаав. Үүний төлөө диет гэдэг мөнгө төлөх хэрэгтэй байв. Өмнө нь тогтсон буй гэрээний дагуу, диетийн хэсгийг Бэний Надир төлөх хэрэгтэй байсан тул, Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- хэдэн асхабыг дагуулан тэдний оронд одов.

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ийм цөөн хүний хамт дэргэд нь очсоныг харсан Бэний Надир еврейчүүд нь энэ байдлыг өөрсдийн талаар олдошгүй завшаан гэж бодоод Аллахын Элчийн амийг хороохоор төлөвлөв. Нөхөн төлөөсийг тэдэнд оносон хувийг төлөхөө илэрхийлэн, мөнгийг

160. Бухарий, Мэгазий 28, Жихад 9; Мүслим, Мэсажид, 297.

бэлтгэтлээ Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн нэгэн гэрийн сүүдэрт суухаар урьцгаав. Энэ хооронд хоол унд ч дайлахаа илэрхийлэн бодсоноо хийхээр төлөвлөв. Орчлонгуудын Эзэн дээр, сүүдэрт нь суусан гэрийн дээврээс томоохон хад унагаж Түүний ариун амийг хороох болов. Тэд нар , ийм хүн алах үйлсийг өмнөх пайгамбарчуудаас заримд нь ч хийсэн тулдаа энэ тухай туршлагатай байцгаав.

Тэр хооронд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- гэнэтхэн суусан газраас босоод тэндээс хурдан холдов. Аллах Таала Элчдээ юу болохыг мэдээлсэн байв. Аугаа Эрх Элчийгээ хамгаалах аргаар итгэгчдэд дайлсан бэлгээ ингэж сануулна:

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُواْ اذْكُرُواْ نِعْمَتَ اللّهِ عَلَيْكُمْ إِذْ هَمَّ قَوْمٌ أَن يَبْسُطُواْ إِلَيْكُمْ أَيْدِيَهُمْ فَكَفَّ أَيْدِيَهُمْ عَنكُمْ وَاتَّقُواْ اللّهَ وَعَلَى اللّهِ فَلْيَتَوَكَّلِ الْمُؤْمِنُونَ

“Аяа итгэгчид ээ! Аллахын танд олгосон шимийг мартуузай! Тэр нэгэн нийгэм танд гараа хүргэхээр хөдөлсөн боловч, Аллах тэдний гарыг танаас татсан байв. Аллахаас айцгаа! Итгэгсэд нь (үүнээс сургаал аваад) **зөвхөн Аллахад найдацгаааг!”** (эл-Маида, 11)

Амь хорох төлөвлөгөө нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг зорьсон боловч ает-и кэримэ дэх үг **“танд гараа хүргэхээр хөдөлсөн”** гэгчээр илэрхийлсэн нь, Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн итгэгчдийн амь настай тэнцүү, түүнчлэн илүү үнэтэй байсны үнэнтэй хамаатай юм.

Гу амь хорох төлөвлөгөөний тухай Аугаа Эрх ингэж айлдав:

وَإِمَّا تَخَافَنَّ مِن قَوْمٍ خِيَانَةً فَانبِذْ إِلَيْهِمْ
عَلَى سَوَاء إِنَّ اللّهَ لاَ يُحِبُّ الخَائِنِينَ

“(Гэрээ хийсэн) **нэгэн ардын урвахаас айвал, Чи ч** (тэдэнтэй хийсэн гэрээг) **тэр чигээр нь эвдсэнээ тэдэнд мэдүүл. Учир нь Аллах урвагчдад дургүй.”** (эл-Энфал, 58)

وَإِن جَنَحُواْ لِلسَّلْمِ فَاجْنَحْ لَهَا وَتَوَكَّلْ عَلَى اللّهِ إِنَّهُ
هُوَ السَّمِيعُ الْعَلِيمُ وَإِن يُرِيدُواْ أَن يَخْدَعُوكَ فَإِنَّ
حَسْبَكَ اللّهُ هُوَ الَّذِيَ أَيَّدَكَ بِنَصْرِهِ وَبِالْمُؤْمِنِينَ

“Хэрэв тэд энх тайванд дөхвөл, Чи ч тэрэнд дөхөөд Аллахад бууж өг! Учир нь Тэрээр сонсогч, мэдэгч мөн. Хэрэв Чамд мэх хиймээр байвал, Аллах Чамд хүрнэ гэдгийг мэд. Тэрээр Чамайг тусламж болон итгэгчдээр дэмждэг.” (эл-Энфал, 61-62)

Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Бэний Надирт элч илгээж гэрээг шинэчлэхийг, эс тэгвээс арван хоногийн дотор Мадинагаас гараад явах тухай тэдэнд сануулга айлдав. Харин мүнафикчууд энэ хооронд хоосон байлгүй Мадинаг орхихоор бэлдэж байсан Бэний Надирт нууцаар өөр мэдээлэл илгээв. Тэдэнд олуулаа туслахаа, Мадинаг битгий орхи гээд тэднийг өдөөв. Энэ нууц захидлыг ч Аугаа Эрх Кур’ан-и Кэримдээ ингэж илрүүлэв:

أَلَمْ تَر إِلَى الَّذِينَ نَافَقُوا يَقُولُونَ لِإِخْوَانِهِمُ الَّذِينَ كَفَرُوا مِنْ أَهْلِ الْكِتَابِ لَئِنْ أُخْرِجْتُمْ لَنَخْرُجَنَّ مَعَكُمْ وَلَا نُطِيعُ فِيكُمْ أَحَدًا أَبَدًا وَإِن قُوتِلْتُمْ لَنَنصُرَنَّكُمْ وَاللّٰهُ يَشْهَدُ إِنَّهُمْ لَكَاذِبُونَ

“Мүнафикчуудын номын ардаас үгүйг андууддаа: «Хэрэв таныг нутгаас тань гаргавал, андашгүй нь бид ч таны хамт гарна; таны эсрэг хэнтэй ч ерөөсөө нэг газар суух үгүй. Хэрэв та байлдвал, бид заавал тусална!» гэснийг дуулаагүй юу? Аллах нь тэдний худалч буйг гэрчилнэ.” (эл-Хашр, 11)

Мүнафикчуудын энэ мэхэнд итгэсэн еврейчүүд өөрсдийгөө аюулгүйд гэж бодоод Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д эсэргүүцэв. Үнэндээ бол мүнафикчүүд амласандаа хүрсэнгүй. Үүнийг Аугаа Эрх ингэж илэрхийлнэ:

لَئِنْ اُخْرِجُوا لَا يَخْرُجُونَ مَعَهُمْ وَلَئِنْ قُوتِلُوا لَا يَنْصُرُونَهُمْ وَلَئِنْ نَصَرُوهُمْ لَيُوَلُّنَّ الْاَدْبَارَ ثُمَّ لَا يُنْصَرُونَ

“Тангараглая, хэрэв тэднийг гаргавал, тэдний хамт гарахгүй; байлдсан ч тэдэнд туслахгүй; тусалсан ч хойшоо эргэж зугтана, дараа нь тэдэнд хэн ч туслахгүй.” (эл-Хашр, 12)

Учир нь, мүнафикчууд хэдий бузар бодлоороо хойгуур нь худаг малтсан ч, итгэгчдээс хэт айдаг байцгаав. Энэ үнэнийг ч Кур’ан-и Кэрим ингэж мэдүүлнэ:

لَأَنتُمْ أَشَدُّ رَهْبَةً فِي صُدُورِهِم مِّنَ اللّٰهِ ذَلِكَ بِأَنَّهُمْ قَوْمٌ لَّا يَفْقَهُونَ

“Тэдний дотроо танд мэдэрсэн айдас нь Аллахад мэдэрсэн айдаснаас илүү хүчтэй байдаг. Тийм байна, учир нь бол тэд ухаангүйчүүд юм.” (эл-Хашр, 13)

Бэний Надир еврейчүүдийн хил хязгаараа нэлээд давсныг анзаарсан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-өөр хийх юмгүй болсон учраас тэдний нутгийг бүслэв. Еврейчүүдийн өөр аймаг Бэний Курайза ч гэрээгээ цуцалж Бэний Надирын дэргэд зэрэгцэв.[161]

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- еврейчүүдийг хаалга ба гэрийнх дэрээ гараад байлдсаныг, хожигдохдоо ч эдгээрийн хойно нуусныг харав. Тэгэхлээр нь хамгийн ойроос эхлээд еврейчүүдийн гэрийг нэг нэгээр нураахыг, хасарваны модны заримыг ч огтлох эсвэл шатаахыг тушаав. Еврейчүүд:

“–Мухаммед аа! Чи бузрыг хориглож түүнийг хийгсдийг буруушаадаг байлаа. Одоо модыг огтлох шатаах нь юу болж байна вэ?!” гээд хашхирцгаав. Еврейчүүдийн ийм үгч мусульманчуудаас заримыг сэжигт автуулав. Тэгэхлээр нь Аллах Таала:

مَا قَطَعْتُم مِّن لِّينَةٍ أَوْ تَرَكْتُمُوهَا قَائِمَةً عَلَى
أُصُولِهَا فَبِإِذْنِ اللهِ وَلِيُخْزِيَ الْفَاسِقِينَ

“Хасарвааны модноос аль нэгийг огтлох эсвэл шатаах таны бүгд Аллахын зөвшөөрлөөр бөгөөд Тэрээрийн замаасаа гарагсдыг гэсгээхийн төлөө юм,” (эл-Хашр, 5) хэмээн

161. Бухарий, Мэгазий, 14.

айлдаж итгэгчдийн эргэлзээг хангав.[162] Ингээд еврейчүүдийн мэхний эсрэгээр арга хэмжээ авах хэрэгтэйг мэдүүлэв.

Ойролцоогоор хорин хоногийн дараа Бэний Надир аймаг нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн төгс төгөлдөр дайны арга ба мүнафикчуудын амласан тусламжийг ирээгүйн дүнгээр бууж өгцгөөв. Аллахын Элч нь Бэний Надирыг Мадинагаас цөллөж, Бэний Курайзаг бол шинэ нэгэн гэрээг зөвшөөрсөнд нь байрандаа үлдээв. Тэдэнд сайхан хандаж дайлав.[163]

Бэний Надир нь нутгаасаа гарахаас өмнө эвдрээгүй гэрүүдээ мусульманчуудад үлдээхгүйн тулд өөрийнх гараараа нураагаж, зарим нь Хайбарт, зарим нь ч Дамаскын тийш нүүж явав.[164]

Аллах Таала нь уг газвад итгэгчдэд хүргэсэн тусламжаа энэ ает-и кэримэгээр илэрхийлнэ:

هُوَ الَّذِي أَخْرَجَ الَّذِينَ كَفَرُوا مِنْ أَهْلِ الْكِتَابِ مِن دِيَارِهِمْ لِأَوَّلِ الْحَشْرِ مَا ظَنَنتُمْ أَن يَخْرُجُوا وَظَنُّوا أَنَّهُم مَّانِعَتُهُمْ حُصُونُهُم مِّنَ اللّٰهِ فَأَتَاهُمُ اللّٰهُ مِنْ حَيْثُ لَمْ يَحْتَسِبُوا وَقَذَفَ فِي قُلُوبِهِمُ الرُّعْبَ يُخْرِبُونَ بُيُوتَهُم بِأَيْدِيهِمْ وَأَيْدِي الْمُؤْمِنِينَ فَاعْتَبِرُوا يَا أُولِي الْأَبْصَارِ

“Эхл-и китабаас үгүйсгэгчийг анх цөлж нутгаас нь гаргасан нь Тэрээр мөн. Та тэндийг гаргах гэж бодоогүй байв. Тэд ч хэрэм тэднийг Аллахаас хамгаална гэж бодсон байв.

162. Бухарий, Тэфсир, 59/2; Ибн-и Хишам, III, 192.

163. Бухарий, Мэгазий, 14; Мүслим, Жихад, 62.

164. Ибн-и Хишам, III, 191-194; Вакидий, I, 363-380.

Гэтэл Аллах тэдэнд хаанаас ч аль ч газраас хүрнэ. Тэрээр тэдний зүрхэнд айдас буулгав. Тэгээд гэрээ өөрийнх гараараа ч итгэгчдийн гараар ч эвдэж байцгаав. Аяа ухааны эзэмшигчид ээ, сургаал авцгаа!” (эл-Хашр, 2)

Бэний Надираас хойно үлдсэн барааг, зэвсэг хэрэглэхгүйгээр гардсан учраас “фэй” гэсэн нэр олгож зэвсэг хэрэглэн олсон олзноос өөр нэгэн шийдвэрт оруулав:

مَّا أَفَاء اللَّهُ عَلَى رَسُولِهِ مِنْ أَهْلِ الْقُرَى فَلِلَّهِ وَلِلرَّسُولِ وَلِذِي الْقُرْبَى وَالْيَتَامَى وَالْمَسَاكِينِ وَابْنِ السَّبِيلِ كَيْ لَا يَكُونَ دُولَةً بَيْنَ الْأَغْنِيَاء مِنكُمْ وَمَا آتَاكُمُ الرَّسُولُ فَخُذُوهُ وَمَا نَهَاكُمْ عَنْهُ فَانتَهُوا وَاتَّقُوا اللَّهَ إِنَّ اللَّهَ شَدِيدُ الْعِقَابِ. لِلْفُقَرَاء الْمُهَاجِرِينَ الَّذِينَ أُخْرِجُوا مِن دِيارِهِمْ وَأَمْوَالِهِمْ يَبْتَغُونَ فَضْلًا مِّنَ اللَّهِ وَرِضْوَانًا وَيَنصُرُونَ اللَّهَ وَرَسُولَهُ أُوْلَئِكَ هُمُ الصَّادِقُونَ

“Аллахын Пайгамбартаа олгосон олз хишиг нь Аллах, Пайгамбар, Түүний хамаатан, өнчид, ядуучууд ба замд үлдэгсдийн төлөө байдаг. Энэ нь тэр барааг зөвхөн баячуудын хооронд эргэсэн нэгэн төр болохгүйн төлөө юм. Пайгамбар танд юу өгвөл түүнийг авцгаа, танд юуг хориглосон байвал түүнээс болгоомжилцгоо. Аллахаас айцгаа. Учир нь Аллахын тамлал нь ширүүн юм. Бас нутаг болон хөрөнгө зоориосоо салгадаг тул хижрэт хийсэн ядуучуудад харъяалдаг. Тэд Аллахын хайр ба тааламжийг хайна, Аллах болон Элчид нь тусална. Үнэнчид нь тэд нар мөн.” (эл-Хашр, 7-8)

Ает-и кэримэд Аллахын эрх гэгчээр ялгасан фэй нь Каба болон бусад мэсжидүүдийг засахаар хэрэглэдэг. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- бол өөртөө оносон фэйг асхабын ядуучуудын хооронд тараав. Фэйг ингэж хуваахын учир нь -дээрх ает-и кэримэд тайлбарласнаар- хөрөнгө баялагийн зөвхөн хэсэг хүмүүсийн гарт цуглараад, зөвхөн тэдний дунд эргэхэд саад болох юм. Исламын эдийг засаг дахь зарчим бол хүмүүсийг бие биедээ тусалцаж, өөртөө буй шимийг ядуу зүдүү хүмүүст ч хүртээх, хуваалцах юм. Ингээд нийгмийн ялгаатай ангиудыг нэг нэгэнд нь ойртуулсан эрх тэгш нэгэн нйигэм байгуулсан болоод, энэ нийгэмд бусдыг мөлжих анги байж болохгүй.

Ийм учраас Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Бэний Надираас амсан олзыг Мухажирчуудад хуваалцуулж, Энсараас ч хэрэгцээт байсан гурван хүнээс бусдад өгөөгүй. Олзыг хуваахаас өмнө Энсарт хандан:

“–Та хүсвэл өмнө нь таны Мухажирчуудад өгсөн нь тэдэнд үлдэнэ, та ч энэ олзноос хувь авна. Хүсвэл өгсөнөө хойш нь тавиад энэ олз бүхнийг тэдэнд үлдээнэ,” хэмээв.

Тэгэхлээр нь Энсар -радъяллахү анхүм эжмаин- нь энэ гайхалтай хариуг өгөв:

“–Бараа таваар болон тэдэнд өгсөнөө ч буцааж авахгүй, олзыг ч тэдэнд үлдээн, тэдэнтэй булаацалдахгүй .”

Энсар-и кирамын толилуулсан ухаанд багтамгүй энэ явдлыг, уг ает-и кэримэд буусны нэгэн учир болов:

وَالَّذِينَ تَبَوَّؤُوا الدَّارَ وَالْإِيمَانَ مِن قَبْلِهِمْ يُحِبُّونَ مَنْ هَاجَرَ
إِلَيْهِمْ وَلَا يَجِدُونَ فِي صُدُورِهِمْ حَاجَةً مِّمَّا أُوتُوا وَيُؤْثِرُونَ

عَلَى أَنفُسِهِمْ وَلَوْ كَانَ بِهِمْ خَصَاصَةٌ

"Өмнө нь Мадинад нутагладаг итгэлтэй суурьшсан хүмүүс, тэнд нүүж ирэгсдэд дуртай; тэдний аливаа юманд атаархахгүй; өөрсдөө хэрэгцээтэй байсан ч тэдэнд хэрэгтэй бол түрүүлж өгнө..." (эл-Хашр, 9) (Разий, XXIX, 250; Куртубий, XVIII, 25)

Согтууруулах Ундаа ба Мөрийг Хориглосон нь

Олноор мэдэгдсэнээр архи ба мөрийн тухай шийдвэр нь Исламын анхны жилүүдэд биш, тусгай нэгэн учраар хойшлуулсан байв. Согтуурах ундааг харам болгох нь ийм шатуудын дараа л хэрэгжив:

1. Маккад:

وَمِن ثَمَرَاتِ النَّخِيلِ وَالأَعْنَابِ تَتَّخِذُونَ مِنْهُ سَكَرًا
وَرِزْقًا حَسَنًا إِنَّ فِي ذَلِكَ لآيَةً لِّقَوْمٍ يَعْقِلُون

"Хасарваан ба усан үзмээр, согтуурах ундаа ч сайхан хүнс ч гаргаж авна. Андашгүй нь үүнд ухаанаа хэрэглэдэг хүмүүст авах сургаал байдаг," (эн-Нахл, 67) ает-и кэримэ нь буусан байв. Уг аетад хасарваан ба усан үзмээр, сайхан хүнснээс гадна согтууруулах бодис ч олдгийг мэдүүлсэн байдаг. Ингээд согтууруулах зүйлсийг сайхан ундаагаар тоологдоогүйг мэдрүүлээд, цаашид нь хориглохыг тэмдэглэсэн байдаг. Маккагийн эринд архины тухай өөр ает буугаагүй.

2. Пайгамбар Эзэн маань Мадинад нүүсний дараа хүмүүсийн асууснаар Аллах Таала ингэж айлдав:

يَسْأَلُونَكَ عَنِ الْخَمْرِ وَالْمَيْسِرِ قُلْ فِيهِمَا إِثْمٌ كَبِيرٌ
وَمَنَافِعُ لِلنَّاسِ وَإِثْمُهُمَا أَكْبَرُ مِن نَّفْعِهِمَا

“Чамаас архи ба мөрийн тухай асууна. Ингэж хэл: Эдгээр зүйл их нүгэлтэй, өчүүхэн ашигтай. Харин архи мөрий хоёрын нүгэл ашгаасаа ямагт их байдаг…” (эл-Бакара, 219)

Уг ает буусны дараа мусульманчуудын ихэнх нь архинаас гараад, хэсэг нь бол уусаар байв.

3. Асхаб-и кирамаас нэг нь үдшийн мөргөлийг үйлдүүлэхдээ, нэгэн аетын утгыг нь эвдэхээр буруу уншив. Тэгсэнд нь:

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُواْ لاَ تَقْرَبُواْ الصَّلاَةَ وَأَنتُمْ
سُكَارَى حَتَّى تَعْلَمُواْ مَا تَقُولُونَ

“Аяа итгэгчид ээ! Та согтуу байхдаа, юу хэлж байгаагаа мэдэхгүй бол мөргөл бүү үйлд !..” (эн-Ниса, 43) гэсэн ает буув.

Үүний дараа мусульманчуудаас архи уугчид нь улам бүр багасав. Мөргөл үйлдэх цагт Аллахын Элчийн зарлагч:

“Согтуу хүмүүс мөргөлд бүү ойрт!” гэдэг болов. Мусульманчууд одоо согтууруулах ундааг лав хориглохыг ойлгосон ба үүнд бэлэн болсон байв.

4. Эцэст нь мусульманчуудын ихэнх хэсэг нь архинаас гарсан байв. Зарим нь бол архинаас болж тааралдсан эвгүй байдлаас дургүй нь хүрсэн байв. Хазрат-и Умар -радъяллахү анх-:

“Аллах минь! Согтууруулах ундны тухай бидэнд илэрхий баттай нэгэн зар илгээх болтугай!” гэж залбирч байв. Гэтэл

нэгэн хоол, дайлалгын дараа гарсан замбараагүй байдлаар архины муу тал нь бүр илэрч, энэ тухай хориг амархан хүлээж авахаар болохлоор, энэ байдал нь буух учир болж тэнгэрлэг хориг хэрэгжив. Аллах Таала:

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُواْ إِنَّمَا الْخَمْرُ وَالْمَيْسِرُ وَالأَنصَابُ وَالأَزْلاَمُ رِجْسٌ مِّنْ عَمَلِ الشَّيْطَانِ فَاجْتَنِبُوهُ لَعَلَّكُمْ تُفْلِحُونَ. إِنَّمَا يُرِيدُ الشَّيْطَانُ أَن يُوقِعَ بَيْنَكُمُ الْعَدَاوَةَ وَالْبَغْضَاء فِي الْخَمْرِ وَالْمَيْسِرِ وَيَصُدَّكُمْ عَن ذِكْرِ اللّهِ وَعَنِ الصَّلاَةِ فَهَلْ أَنتُم مُّنتَهُونَ

“Аяа итгэгчид ээ! Дарс, мөрий, шавар баримал, **мэргэ ба азын сум бүгд бохир юм. Эдгээрээс холдож авралд баг- таарай. Шэйтан нь архи ба мөрийн аргаар таны хооронд өс өшөө оруулж, таныг Аллахаас холдуулмаар байдаг. Одоо** (энэ бүхнийг) **болио биз дээ?”** (эл-Маида, 90-91) аетуудыг буул- гав.

Пайгамбар Эзэн маань Хазрат-и Умарыг дуудаж түүнд эдгээр аетуудыг уншив. **“Одоо болио биз дээ?”** гэсэн хэсэгт ирэхэд тэр:

“–Болилоо! Болилоо аяа Раб!” гэж байв. Зөвхөн Хазрат-и Умар -радъяллахү анх- биш, бүх мусульманчууд ч:

“–Одоо архинаас, мөрийнөөс гарлаа, аяа Раб маань!” гэж байцгаав.

Эдгээр аетуудыг буухлаар, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тушаалаар нэгэн зарлагч:

“–Согтууруулах ундаа уухыг хориглосны мэдэж аваарай!” гэж хашхирав.

Тулмыг нь цоолж хоосруулсан, ваарыг нь хагалж асгасан согтууруулах ундаа нь Мадинагийн гудамжид үер шиг урсав!..

Хоригийн энэ аетын дараа, дарс ууж байсан мусульманчууд, гартаа байсан хамаг ундаагаа асгаж үгүй болгов. Дахиад ч уугаагүй. Дараа нь Эзэн маань:

“Андашгүй нь Аллах дарсыг, түүнийг шүүрснийг, шүүрсэн газар, уусныг, уулгасныг, зөөснийг, зарсныг, худалдаж авсныг, үнийг эсвэл ашгийг нь идснийг хараасан байдаг!” хэмээв. (Ахмад, I, 53; II, 351; Нэсаи, Эшрибэ, 1-2; Хаким, II, 305/3101)

Энэс -радъяллахү анх- ингэж ярина:

Эбү Талхагийн гэрт намайг хүмүүст дарсаар дайлж байхад согтууруулах ундаа нь харам болов. Аллахын Элч нэгэн зарлагчид тушаал өгөөд тэр ч үүнийг хүмүүст дуулгав. Биднийг гэрт байхад зарлагчийн дуу сонсогдов. Эбү Талха:

“–Гараад нэг харчих, энэ нь юуны дуу вэ?” гэв. Би гараад нэг харвал:

“–Нэгэн зарлагч «Анхаараарай; согтууруулах ундаа нь хориг болсон юм!» гэж хашхирна,” гэлээ. Надад:

“–Тийм байвал очоод түүнийг асга!” гэв. Тэр үеэс хойш Мадинагийн гудамжаар дарс урсав. (Бухарий, Тэфсир, 5/11)

Энэ байдал нь Асхаб-и кирамын Аллах Таалагийн тушаалыг дагахдаа хэр их чамбай байсны сайхан нэгэн жишээ юм. Ямар ч эсэргүүцэл эсвэл шалтгаан илэрхийлэхгүйгээр ба хүлээхгүйгээр шууд гар дахь дарсны ваар сав бүхнийг асгасан, энэ тэнгэрлэг тушаалд ч бууж өгч чин сэтгэлээрээ дагаад Аллахын тааламжид багтахаар гүйцгээв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- хадис-и шарифдаа ингэж айлдана:

“Согтууруулах бүх юм нь харам юм. согтууруулах чанар нь бага ч харам юм.” (Ибн-и Мажэ, Эшрибэ, 10; Нэсаи, Эшрибэ, 24, 48)

“Согтууруулах ундаа нь муу муухайн эхлэл юм.” (Ахмад, V, 238)

“Аллах болон ахират өдөрт итгэн үнэмшсэн хүн, дээр нь согтууруулах ундаа тавьсан ширээнд битгий суу!” (Тирмизий, Эдэб, 43/2801)

“Миний үммэтээс зарим нь согтууруулах ундаанд өөр нэр өгөөд уух юм!” (Ахмад, IV, 237)

Согтууруулах ундаа ба мөрийг хориглоход шат шатаар хэрэгжүүлэх нь Исламд тэблиг, боловсруулах ба муу муухайтай тэмцэх аргыг тогтооход гол нэгэн түшиг болно. Аллах Таала нь мөнх ба бүрэн бүтэн мэдлэгтэй байсан боловч, Исламын дүрэм журмыг тогтоохдоо, хандаж буй хүмүүсийг хүч чадлыг ба энэ шийдвэрийг дагахад дэвших хугацаанд анхаарал хандуулсан байдаг. Үүний хамгийн чухал илрэл нь бол, итгэл үнэмшилтэй хамаатай аетуудыг, Маккагийн эринд , хамгийн эхэнд буулгасан нь юм. Кур’ан-и Кэримийн нь бууж эхлэхээс өмнө ч **Лэвх-и Махфуз**ад бэлэн байсныг бодвол, энд түүнийг буулгахад цаг үеийг тааруулсан нь ойлгомжтой.

Уг арга нь бие хүний Кур’аныг дагах талаарх шийдвэр ба хүч чадлыг ба дэвшлийг үзэхээр бүрддэг. Яг хүүхдийн хариуц-лага ч түүний өсөх тусам ихсэх нь шиг...

Хамгийн төгсөөр жаргалын үед хэрэгжүүлсэн буй шат шатын харилцааны зарим нь тэнгэрлэг нэгэн энэрлийн илрэл шиг Аугаа Эрхийн тогтсон хэт том учиртай нэгэн сүннэтуллах мөн. Уг сүннэт нь Исламыг тэблигт байнга хүчин арга байснаар

үл барам, хүн гэсэн үнэний шинжид ч хамгийн зохимжтой нэгэн арга юм. Учир нь хүн Исламд эхлээд итгэл үнэмшлээ засаад л ордог. Энэ шатыг эзэмшиж шингээсний дараа үйлсийн дараалал ирнэ. Үйлсийг хэрэгжүүлэхэд бол хүний хүч чадлын хамаатай шатын харьцааг л дагана. Энэ байдал нь зөвхөн Исламын тэблигийн төлөө биш, бүх хүний чиглүүлэх ажиллагаанд ч зохимжтой юм. Ийм учраас Аллахын Адам -алэйхиссэлам- аар эхэлсэн тэнгэрлэг тэблигт ч -итгэл үнэмшлийн дүрэм өөрчлөгдөөгүй боловч- нийгмийн дүрэм журамд хүний дагасан хөгжлийн төвшинтэй тэнцүү нэгэн дэвшил болсон ба энэ дэвшил нь Ислам шашинд төгс төгөлдөр болсон байдаг. Энэ шинж нь хүний зан ба чадалд анхаарал үзүүлэхийг хэр их чухал нэгэн арга буйг заадаг.

Затү'р-Рика[165] (5 Мухаррам / 626 оны 6 сар)

Гатафаны аймгуудаас Мухарибынхан ба Са'лэбынхны нэгдэж мусульманчуудад дайн зарлахаар бэлдэхлээр нь Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- дөрвөн зуун цэргээр тэдэн дээр дайрав.

Итгэгчдийг өөдөөсөө харж олсон мүшрикчүүд нь айгаад ухрав. Хэсэг хугацааны дараа итгэгчид нь цаг нь болсон байсан үдийн мөргөлөө үйлдэв. Холоос тэднийг ширтэж байсан дайсан нь үүнд санаа зовоод мөргөлийн үеэр довтлоогүйдээ гэмшив. Тэдний дундаас нэг нь:

"–Санаа зовуузай! Тэдэнд нэгэн мөргөл байдаг бөгөөд, тэр мөргөл нь тэдний хувьд аав болон хөвгүүдээс ч үнэт юм. Энэ нь оройн мөргөл юм," гэв. Тэд хүлээж эхлэв.

165. Энэ газваг Хэндэк эсвэл Хайбарын дараа болсны тухай ч яриа байдаг. Харин бид Сиер эрдэмтдийн ихэнх нь баталгааг дагаж энд дурдав.

Аугаа Эрх нь тэр хооронд Жэбраил -алэйхиссэлам-ыг илгээв. Дайсны төлөвлөгөөг үр ашиггүй болгосон уг тэнгэрлэг тушаал илрэв:

وَإِذَا كُنتَ فِيهِمْ فَأَقَمْتَ لَهُمُ الصَّلاَةَ فَلْتَقُمْ طَآئِفَةٌ مِّنْهُم مَّعَكَ وَلْيَأْخُذُواْ أَسْلِحَتَهُمْ فَإِذَا سَجَدُواْ فَلْيَكُونُواْ مِن وَرَآئِكُمْ وَلْتَأْتِ طَآئِفَةٌ أُخْرَى لَمْ يُصَلُّواْ فَلْيُصَلُّواْ مَعَكَ وَلْيَأْخُذُواْ حِذْرَهُمْ وَأَسْلِحَتَهُمْ وَدَّ الَّذِينَ كَفَرُواْ لَوْ تَغْفُلُونَ عَنْ أَسْلِحَتِكُمْ وَأَمْتِعَتِكُمْ فَيَمِيلُونَ عَلَيْكُم مَّيْلَةً وَاحِدَةً

“Аяа Элч минь! **Чамайг ч тэдний хамт болоод тэдэнд мөргөл үйлдүүлж байхад, тэдний хэсэг нь Чамтай хамт мөргөлд зогсч, зэвсгээ** хажуудаа **авцгааг, ингээд** мөргөлөө үйлдэж **байхад** бусад нь **таны хойно байж байг! Дараа нь арай мөргөлд эхлээгүй байсан нөгөө хэсэг нь ирээд Чамтай хамт мөргөлөө үйлдэж, тэд ч арга хэмжээ болон зэвсгээ авцгааг! Тэр кафирчууд таныг зэвсэг болон бараандаа хүрч чадахааргүй байхыг ба гэнэтхэн тан дээр дайрч дарахыг хүснэ...”** (эн-Ниса, 102) (Тирмизий, Тэфсир, 4/3035)

Ингэж үйлдсэн мөргөлийг “Салат-и хавф” айдастай мөргөл гэцгээв.[166] Яаж үйлдэхийг Жэбраил -алэйхиссэлам- зааж өгөв.

166. **Айдасны Мөргөл** нь дайсан дайрах мэтийн чухал аюул байхад чуулгын хоёр хуваагдан имамын ард фарз мөргөлийг ээлжээр үйлдэх нь юм. Хоёр рэкаттай мөргөлийн анхны рэкатыг, дөрвөн рэзаттай мөргөлийн анхны хоёр рэзатыг имамын хамт үйлдсэн нэгдүгээр хэсэг нь анхны суултын дараа чуулгаас салж үүрэгтээ харина. Хоёрдугаар хэсэг нь ирээд имамын хамт бусад рэзатыг бүтээж үүрэгтэй харина. Имам өөрөө салам өгнө. Дараа нь нэгдүгээр хэсэг нь кираатгүйгээр, хоёрдугаар хэсэг бол зирааттайгаар

Тэр өдөр оройн мөргөлөө ингэж үйлдэж, дайрахаар завшаан хүлээж байсан дайсны хүлээлт нь дэмий болов. Аян дайн нь арван таван орчим хоног явсны дараа дайсан айгаад буцсанаар дуусав.[167]

Эбү Муса эл-Эш'арий -радъяллахү анх- ингэж ярина:

"Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хамт аянд гарсан байлаа. Зургуулаа ээлжлэн нэгэн тэмээг унаж байлаа. Алхсаар улдаж бидний хөл цоорсон байв. Миний хөл ч улдаж, хумс унасан байв. Хөлдөө давуу ороов. Давуун ороолтоос болж тэр аяныг Затү'р-Рика гэсэн нэр өгөв."

Энэ үгийг дамжуулсан Эбү Бүрдэ ингэж хэлнэ:

"Эбү Муса эл-Эш'арий эдгээрийг хэлээд, харин дараа нь хийсэндээ дургүйцэж: «Эдгээрийг хэлээд огт сайн хийгээгүй юм,» гээд гэмшлээ илэрхийлэв. Магадгүй тэр нь Аллахын төлөө хийсэн баатарлаг үйлээ илрүүлснээсээ болж санаа зовов." (Бухарий, Мэгазий, 31)

Ядуу ба боломжгүй байдал нь Асхаб-и кирамыг үүргээ хэрэгжүүлэх ба Аллахын замд жихадаас холдуулаагүй юм. Гэтэл тэд хийсэн салих үйлсээ нууц байлгах, Аллахад бууж өгөх утгаар даасан бэрхшээл илрүүлэхгүй байхаар нямбай ханддаг байв. Ийм зүйлсийг зөвхөн хэрэг болбол ба ямар нэгэн зорилгыг хэрэгжүүлэхээр, жишээлбэл сургаал болох, дагаж үйл хийх эсвэл төвөгтэй хүмүүст тайтгаруулга болгох гэж ярьдаг байв.

ээлжтэй мөргөлөө бүтээнэ. Ингэхдээ мөргөлөө чуулгаар үйлдсэн бөгөөд үүргээ таслаагүй байх болно. (Комисс, *Diyânet İlmihâli,* I, 334; Хамди Дөндүрэн, *Delilleriyle İslâm İlmihâli*, х. 377-378)

167. Ибн-и Хишам, III, 214-221; Ибн-и Са'д, II, 61.

Энэ аянд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь абдэст авахаар ус нэхсэн байв. Харин хэнд ч ус олдоогүй. Тэгээд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ариун гараа, ёроолд нь маш бага ус байсан нэгэн саванд оруулахлаар нь хуруунаас нь гайхамшгийн гоожуур гоожив. Энэ усаар хамаг цэрэг усанд ханав. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг гараа гаргасанд аяга нь хэвээрээ усаар дүүрэн байв.[168]

Затү'р-Рикагийн Газвагаас буцахдаа, үдийн үеэр модтой нэгэн хөндийд хүрэхдээ, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- буусан, мүжахидчууд ч сүүдэрлэхээр эргэн тойронд тарсан байв. Эзэн маань "Сэмүрэ" гэгч битүү навчтай нэгэн модон доор амарч эхлээд, сэлмээ ч модонд өлгөсөн байв. Асхаб нь түр унтсан байхдаа Расулаллахын тэднийг дуудсаныг сонсоод шууд гүйгээд дэргэд нь очив. Тэнд нэгэн бадавий зогсч буйг харцгаав. Аллахын Элч ингэж айлдав:

"–Намайг унтахад энэ бадавий миний сэлмийг авчээ. Сэрэхэд сэлмийг сугалсан барьж байв. Надаас:

«–Чамайг одоо миний гараас хэн аврах вэ?» гэв. Би ч гурван удаа:

«–Аллах!» гэж хариулав." (Бухарий, Жихад, 84, 87; Мүслим, Фэдаил, 13)

Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм- амийг нь хороох юмсан энэ бадавийг яллахыг сонгоогүй, эсрэгээр нь түүнийг Исламд урив. Уг агуу хандлаганд бараг хайлсан бадавий нь, ардынхаа дэргэд харихдаа:

"Би хүмүүний хамгийн буянтын дэргэдээс ирж байна," гэхээс аргагүй болов. (Хаким, III, 31/4322)

168. Бухарий, Вүдү, 32; Мэнакиб, 25; Мүслим, Фэдаил, 5.

Дахиад Мадинад эргэхдээ буусан нэгэн газар Пайгамбар Эзэн маань:

"–Өнөө шөнө биднийг хэн манах вэ?" хэмээн асуув. Мухажирчуудаас Аммар бин Яасир ба Энсараас Аббад бин Бишр нь шууд:

"–Бид манана, аяа Расулаллах!" гэцгээв.

Аббад -радъяллахү анх- Аммарт:

"–Чи шөнийн аль хэсэгт, эхэнд манах уу, эсвэл сүүлд нь манах уу?" гэж асуув. Аммар -радъяллахү анх-:

"–Сүүлийн хэсэгт манамаар байна!" гээд хажуулан хэвтээд унтчихав. Аббад ч мөргөл үйлдэж эхлэв. Тэр хооронд нэгэн мүшрик ирэв. Босоо нэгэн дүрс харвал, мануул буйг нь ойлгож шууд сум харвав. Сум нь Аббадыг онов. Аббад сумыг авч хаяад мөргөлөө үргэлжлүүлэв. Нөгөө хүн хоёр ба гурав дахь удаа харваад дахиад онов. Удаа бүрт ч Аббад -радъяллахү анх- тогтвортой босоо байж сумыг татан гаргаж, мөргөлөө үргэлжлүүлж байв. Гэхэд рүкүү ба сэждэ хийх буюу бөхийж мөргөсөн. Мэнд өгсний дараа найзыгаа сэрээж:

"–Бос! Би шархадлаа!" гэв. Аммар үсэрч босов. Мүшрик нь тэднийг харангаа өөрийгөө анзаарсныг ойлгож зугтав. Аммар нь Аббадыг цусанд автсаныг харангаа:

"–Сүбханаллах! Анх харвахад нь намайг сэрээгээгүй яасан бэ!" гэв. Аббад нь мөргөлд хэр их хайртай буйгаа харуулсан энэ гайхалтай хариуг өгөв:

"–Би нэг сура уншиж байлаа, түүнийг дуусгалгүй мөргөлөө эвдэх гээгүй юм. Харин сум нь дараалаад ирэхлээр нь уншихаа байж рүкүүд бөхийв. Аллахад тангараг өргөе, Аллахын Элчийн хамгаалахыг тушаасан энэ боломжийг алдах айдас

байгаагүйсэн бол бас, сураг дуусгалгүй мөргөлөө тасалснаас үхэхээ илүүд үзэх байв." (Эбү Давуд, Тахарэт, 78/198; Ахмад, III, 344; Ибн-и Хишам, III, 219; Вакидий, I, 397)

Аяны явдалд Жабир -радъяллахү анх- нь тэмээ нь туранхай тул найзуудаа гүйцэж чаддаггүй байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнийг дэргэдээ аваад:

"–Жабир аа! Чамд юу болоод хойно үлдээ вэ?" хэмээн асуув. Хазрат-и Жабир байдлаа ярихлаар Эзэн маань нэгэн таяг аваад тэмээнд хэдхэн удаа зөөлхөн илэв. Тэмээ нь Аллахын Элчийн тэмээтэй уралдахаар болов.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- замдаа Хазрат-и Жабиртай ярилцаж байв. Түүнийг саяхан гэрлэсэн ба ийм учиртай нэлээд өртэй байсныг мэдсэн Аллахын Элч нь Жабираас ямар хөрөнгө буйг нь асуув. Тэр ч гагцхуу нэгэн тэмээтэй байснаа хэлэв. Тэгэхлээр нь Орчлонгуудын Эзэн -алэйхиссалатү вэссэлам- түүнийг өрөөс аврахаар тэмээг нь өөртөө зарахыг нэхэв. Хазрат-и Жабир -радъяллахү анх- нь Мадина хүртэл унах шаардлагаар тэмээгээ Аллахын Элчид зарав. Мадинад хүрэхдээ тэмээг гардуулж өгөхөөр Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд очив. Тэр хооронд түүнийг маш их баясгасан нэгэн үйлтэй тааралдав. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэмээний мөнгийг төлсөн шигээ тэмээг ч түүнд бэлэглэж өгөв. (Бухарий, Жихад, 49; Бүюү' 34; Мүслим, Мүсакат, 109)

Жабир -радъяллахү анх- ингэж ярина:

"Аллахын Элч миний тэмээний төлбөрийг өгөөд тэмээг ч надад бэлэглэхлээр, би таньдаг нэгэн еврейтэй тааралдлаа. Энэ байдлыг түүнд ч ярив. Еврей нь гайхсандаа: «–Тэгвэл тэмээний мөнгийг өгөөд, бас түүнийг чамд бэлэглэсэн, аан?!» гэсэн үгээ

давтсаар хэлэв. Би ч удаа бүрт нь: «–Тийм!» гэлээ.” (Ахмад, III, 303)

Аллахын Элчийн ийм эелдэг үйл нь мусульманчуудыг хэтэрхий мэдэршүүлсэн тулд, тухайн шөнийг “Лэйлэтү’л-Баир” буюу “Тэмээнйи Шөнө” гэж дурдахаар болцгоов.

Бэдр-и Сугра (4 Зилкадэ / 626 оны 4 сар)

Ухудын өдөр хийсэн гэрээний ёсоор Маккагийн мүшрикчүүд ба мусульманчууд жирийн дараа дахиад байлдах байв. Энэ гэрээний дагуу Эбү Сүфьяан цэргээ тэргүүлэн Мэррү’з-Захран гэсэн газар хүрч ирээд, харин зүрхийг нь гэнэт нэгэн айдас дарж харихаас аргагүй болов. Гэтэл нэр алдраа ч хардуулмааргүй байсан тул Мадинад нэгэн эр илгээв. Өөрсдийгөө олон цэргээр замд гарсныг хэлүүлж, ухаандаа итгэгчдийг айлгаад дайнд явахгүй байхыг нь батлахыг бодож байв.

Мэдээлэл нь Мадинад хүрэхэд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- дайны бэлтгэлээ аль хэдийн хангасан, замд гарах тушаал ч олгосон байв. Буухиа нь Эбү Сүфьяны айгаад харьсныг мэдсэндээ, мусульманчуудыг бүр эвгүй болгож дайны аянд гарахад нь саад болохоор чадах бүхнийг юмаа хийж байв. Түүнд сургасан худал дээр шинэ худал нэмээд, хэрэв мусульманчууд Маккачуудтай хотын гадаа байлдвал, хувь заяа маш тааруу болохыг хэлээд байв. Тэр болон мүнафикчуудын хичээсний дүнгээр зарим мусульманчуудын зүрхэнд айдас ороод дайнд явмааргүй санагдаж эхлэв. Тэгсэнд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

“Миний биеийг хүчит гараараа барьсан Аллахад тангараг өргөе, миний дэргэд хэн ч байгаагүй ч би ганцаараа Бэдирт очно!” Үүний дараа Аллах Таала нь мусульманчуудад тусалж,

зүрхэнд нь тайвныг хайрлаж өгөв. (Ибн-и Са’д, II, 59; Вакидий, I, 386-387)

Эцэст Исламын цэрэг Бэдирт хүрэв. Харин дайсны ямар нэгэн мөр байгаагүй. Тэнд байгуулсан нэгэн яармагаас гадна юутай ч тааралдаагүй. Ийм тохиолдолд итгэгчдэд наймаа хийхээс өөр ажил байгаагүй байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Бэдирт найм хоноод Эбү Сүфьяан ба цэргийнх нь ирэхийг хүлээсний дараа ямар ч таагүй юмтай тааралдалгүй, олсон наймааны ашгаар Мадинад буцав.[169]

Итгэгчдийн ийм зоригийг Кур’ан-и Кэрим ингэж магтсан байдаг:

الَّذِينَ قَالَ لَهُمُ النَّاسُ إِنَّ النَّاسَ قَدْ جَمَعُواْ لَكُمْ فَاخْشَوْهُمْ فَزَادَهُمْ إِيمَاناً وَقَالُواْ حَسْبُنَا اللّهُ وَنِعْمَ الْوَكِيلُ. فَانقَلَبُواْ بِنِعْمَةٍ مِّنَ اللّهِ وَفَضْلٍ لَّمْ يَمْسَسْهُمْ سُوءٌ وَاتَّبَعُواْ رِضْوَانَ اللّهِ وَاللّهُ ذُو فَضْلٍ عَظِيمٍ

“Хэсэг хүмүүс итгэгчдэд:

«–Таны дайснууд таны эсрэг цугларав; мартваа, тэд нараас болгоожил!» гэхэд нь энэ бол тэдний итгэл үнэмшлийг нэг дахин нэмсэн бөгөөд:

«–Аллах бидэнд хүрэмжтэй. Тэрээр нь маш гоё итгэмжит төлөөлөгч юм!» гэсэн байцгаав. Ийм учиртай тэдэнд ямар ч муу муухай нь хүрэлгүй, Аллахын шим ба шагналаар буцацгаав. Ингээд Аллахын тааламжийг дагасан нь зөв болцгоов. Аллах нь том шагналтай, соёрхолтой мөн.” (Ал-и Имран, 173-174)

169. Ибн-и Хишам, III, 221; Ибн-и Са’д, II, 59; Вакидий, I, 384-389.

Абдуллах бин Аббас -радъяллахү анхүмаа-гийн дамжуулснаар:

“Аллах бидэнд хүрэмжтэй, Тэрээр маш гоё итгэмжит төлөөлөгч мөн” гэсэн үгийг Ибрахим -алэйхиссэламнь галд хаягдаж байхдаа хэлсэн болой. Пайгамбар маань ч энэ үгийг “Мүшрикчүүд бидний эсрэг цугларав, биеэ бодож аргаа олцгоо!” гэхэд нь хэлсэн болой. Тэгэхлээр нь мусульманчуудын итгэл үнэмшил нь нэмэгдсэн ба бүгдээрээ; **“Аллах бидэнд хүрэмжтэй, Тэрээр нь маш гоё итгэмжит төлөөлөгч мөн!”** гээд Аллахад бууж өгсний том нэгэн үлгэр жишээ толилуулцгаав.[170]

170. Хар. Бухарий, Тэфсир, 3/13.

ХИЖРЭТИЙН ТАВ ДАХЬ ЖИЛ

Сэлман-и Фарисий Мусульман Болсон ба Эрх Чөлөөндөө Хүрсэн нь

Мадинагийн нэгэн еврейгийн боол байсан Сэлман-и Фарисий -радъяллаху анх- нь Исламын шимтэй учирсныхаа олон сургаалаар дүүрэн туульсаа Ибн-и Аббас Хазратад ингэж ярив:

“Би Исбаханы Жэйй гэсэн хөдөө амьдарсан нэгэн байлаа. Манай аав хөдөөний хүндэт хүмүүсийн байлаа. Амьдралдаа түүний хамгийн хайрт нь би байлаа. Ийм хэт хайрынхаа улмаас намайг хажуугаасаа огт салгадаггүй, охин шигээ байнга гэртээ байлгадаг, гадагш гаргадаггүй байв. Би аавын шашин байсан Мэжүүсий буюу Галын шүтээнд өөрийгөө маш их автуулсан тул, голомтыг сахиж, гал түлэх ажлыг ч би өөртөө даалгасан байв. Голомт дахь гал хоромхон унтрахыг ч би зөвшөөрдөггүй байлаа. Манай аав том гакар хөрөнгөтэй байв. Өөрөө нэгэн өдөр барилгын ажил хийж байв. Надад:

«–Миний хүү! Би өнөөдөр очоод барилга дээр оч оролц, хөрөнгөдөө очиж чадахгүй байна. Тэнд чи оч!» гээд хийх хэрэгтэй ажлыг надад хэлж өгөв. Дараа нь надад:

«–Тэнд очоод удвал надад санаа зовж болохгүй шүү! Хэрэв оройтвол би чамаас юу болсныг сохирхоно!» гэв.

Хөрөнгө рүү явахаар замдаа гарлаа. Христийн нэгэн сүмтэй дайралдлаа. Тэдний дууг сонссон, тэд дотор залбирч байцгаав. Аав намайг байнга гэртээ байлгадаг тул би хүмүүсийн ямар байдалтай байсныг мэддэггүй байлаа. Ийм учраас шохоорхож, юу хийж байсныг нь харахаар дэргэд нь одлоо. Тэдний хийснийг үзээд өөртөө; «Валлахи энэ нь бидний шашнаас буянтай,» гэлээ. Нар жаргатал тэндээс салаагүй. Хөрөнгөд бол огт очоогүй. Тэднээс:

«–Энэ шашны үндэс нь хаана вэ?» гэж асуулаа:

«–Дамаскад юм» гэцгээв. Орой аавын дэргэд харилаа. Аав минь ажлаа хаяад өдөр жингөө намайг хайжээ. Намайг түүний дэргэд очиход:

«–Миний хүү! Чи хаана байв? Би чамд юу хийх хэрэгтэйг хэлээгүй билүү?» гэв.

Түүнд:

«–Аав аа! Сүмдээ залбирч байсан зарим хүмүүстэй тааралдлаа. Тэдний залбирал үйлсийг хараад, надад маш их таалагдлаа. Нар жаргатал тэдний дэргэдээс салж чадаагүй,» гэлээ.

Аав минь:

«–Миний хүү, тэр шашинд буян үгүй. Чи болон овог дээдсийн чинь шашин түүнээс буянтай,» гэв.

Аав намайг зугтах гэж айснаасаа хөлд минь гав уяж, дараа нь намайг гэрт хорив. Сүм дэх Христчүүдэд:

«–Танай дэргэд Дамаскаас наймааны жин ирэхлээр надад мэдээ илгээгээрэй!» гээд хүн явууллаа. Дамаскаас Христийн шашинтай наймаачид ирэхэд тэд надад мэдээлэв. Хөлөөсөө төмөр гавын тайлж хаялаа. Тэдний хамт Дамаскын замыг барилаа. Тэнд хүрэхлээрээ:

«–Шашны хүмүүсээс мэдлэгээрээ хамгийн давуу нь хэн бэ?» гэж асуулаа:

«–Сүм дэх пископос юм,» гэцгээв. Дэргэд нь очоод түүнд:

«–Би энэ шашинд орж, чиний дэргэд байж, сүмд үйлчилж, Христийн шашныг чамаас сурч аваад чиний хамт залбирмаар байна,» гэлээ.

Надад:

«–Сүмд ор!» гэв.

Түүнийг дагаж сүмд орлоо. Дамаскын пископос нь муу хүн байв. Христчүүдэд хандив өгөхийг тушааж, цугласан юмыг өөртөө хадгалж, ядуучуудад юу ч өгдөггүй байв. Ингээд долоон ваар дүүрэн алт мөнгө цугласан байв. Үйлсийг нь харах тусам түүнд улам бүр хилэгнэж байлаа. Эцэст нь тэр хүн нас барав. Христчүүд түүнийг оршуулахаар цугларав. Би тэдэнд:

«–Энэ нь муу нэгэн хүн байв. Таныг хандив өгөхийг тушаа-аж урамшуулж, харин таны авчирсан зүйлсийг өөртөө хадгалж, ядуучуудад юу ч өгдөггүй байв!» гэлээ.

Надаас:

«–Чи үүнийг хаанаас мэдээ вэ?» гэж асууцгаав.

Тэдэнд:

«–Танд түүний санг үзүүлж чадна,» гэлээ.

Миний заасан газраас алт мөнгөөр дүүрэн долоон ваар олов. Үүнийг хараад:

«–Валлахи бид түүнийг ерөөсөө оршуулахгүй,» гэцгээв. Шарилыг нь өлгөж чулуугаар шидлэв! Түүний оронд сүмд өөр нэгнийг авчрацгаав. Таван удаа мөргөл үйлддэггүйчүүдийн

дунд түүнээс эрдэмтэй, түүн шиг дэлхийг тоодоггүй, ахиратыг илүүд үздэг, өдөр шөнөгүй залбирч үйлчилсэн хэнийг ч би хараагүй. Дараа нь энэ хүн үхэх гудсандаа унав. Түүнд:

«–Хэн ээ! Би чиний дэргэд байлаа. Чамаас өмнө хэнийг ч чамайг хайрласан шигээ хайрлаагүй! Чиний ч харснаар чамд Аллахын тушаалаар ирсэн байна. Надад юу хийхийг, хэнд очихыг санал болгох вэ?» гэлээ.

«–Миний хүү! Би өнөөдөр миний замаар явагч хэнийг ч танихгүй байна. Салих хүмүүс бүгд яваад өнгөрлөө. Амьд нь ч шашны дээр үеэс ирсэн дүрмийг өөрчлүүлж, ихэнхийг ч орхив. Зөвхөн Мусулд нэгэн хүн бий. Тэр нь миний барьсан зам дээр юм. Чи түүний дэргэд од!» гэв.

Энэ хүндэт хүнийг нас барахлаар би Мусул дахь андынх нь дэргэд одов. Түүнийг ч нас барахлаар, санал болгосноор нь **Нусайбин** дахь, түүний дараа ч Аммурияа дахь нэгэн хүний дэргэд очлоо. Аммурияад бага сага ч юм оллоо. Түүнчлэн жаахан хонь ба үхэртэй ч боллоо. Эцэст нь Аммурияагийн хүнд ч Аллахын тушаал таараад:

«–Миний хүү! Валлахи өнөөдөр дэлхий даяарх хүмүүсээс, дэргэд нь очихыг чамд тушаах буюу санал болго, бидний бодолтой хэнийг ч би мэдэхгүй! Харин Төгсгөл Үеийн Пайгамбарын ирэх цаг их дөхөж, сүүдэр нь манай дээр туссан байдаг! Тэр Пайгамбар нь Ибрахим -алэйхиссэлам-ын шашин дээр илгээгдэнэ. Өөрөө Арабын оронд илэрч, хоёр харчулуутын хооронд хасарвааны талбайт нэгэн газар нүүж очно. Тэр нь бэлгээс идэж, хандиваас идэхгүй. Түүний хоёр далын хооронд пайгамбарын тамга байдаг. Хэрэв тэр оронд очихоор хүч хүргэж чадвал, шууд замдаа гар!» гэв.

Эцэст нь тэр ч нас барав. Аллахын хүссэн хугацаагаар би тэнд суусаар байлаа. Дараа нь Кэлб аймгаас зарим наймаачидтай тааралдлаа. Тэдэнд:

«–Намайг Арабын оронд аваачаарай, би ч үүний хариуд энэ малаа танд өгье,» гээд, тэд зөвшөөрөв. Малаа тэдэнд өгөөд, тэд намайг дагуулав. Вади’л-Курад хүрэхдээ намайг тамлаад, боол болгож нэгэн еврейд зарцгаав. Хэсэг хугацаагаар еврейгийн дэргэд байлаа. Вади’л-Кура дахь хасарвааны модыг харахдаа «Энд нь Аммурияа дахв эзний маань надад тайлбарласан, Төгсгөл Үеийн Пайгамбарын нүүх газар болох уу?» гэж найдсан ч, сэтгэл минь үүнд бүрэн ханаагүй.

Вади’л-Курад байсан хугацаанд, миний эзний Курайзагийнхнаас байсан хамаатан нь ирээд намайг худалдаж аваад Мадинад авчрав. Валлахи Мадинаг харангуутаа Аммурияа дахь эзний минь тайлбарласан, Төгсгөл Үеийн Пайгамбарын нүүх газар энд буйг би ойлголоо. Тэр үеэс хойш Мадинад суугаад хүлээлээ. Үнэндээ Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- пайгамбар болж илгээгдээд, хэсэг хугацаагаар Маккад байжээ. Харин би боолчлогдоод завгүй байсан тулдаа Түүний тухай юу ч сонсоогүй байлаа. Дараа нь Тэр Мадинад нүүж ирээд, би хэвээрээ мэдээгүй. Нэгэн өдөр би хасарвааны модон дээр ажиллаад, миний эзэн модны сүүдэрт сууж байв. Тэр хооронд авга ахын хүү ирээд миний эзэнд:

«–Хэн ээ! Аллах Кайлэгийнхныг (Эвс ба Хазражийг) гэсгээг! Валлахи тэд Куба Маккагаас тэдний дэргэд ирсэн ба пайгамбар гэгч хүний дэргэд цугларсан байна!» гэв.

Үүнийг сонсонгуутаа би нэг чичирч эхлээд, бараг эзэн дээрээ унахаар боллоо:

«–Юу гэсэн? Яасан бэ?» гээд шууд хасарвааны модноос буулаа. Эзэн уурлаад надад алгаараа ширүүн нэг цохиод:

«–Чамд ямар хамаатай юм бэ? Чи ажлаа хий!» гэв.

Би ч:

«–Зүгээр ээ! Зөвхөн түүний юу гэснийг ойлгох гэсэн юм,» гэлээ. Дэргэдээ цуглуулсан жаахан идээ байв. Үдэш үүнийг аваад Кубад байсан Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- дээр очлоо. Түүнд:

«–Чамайг салих нэгэн хүн гэдгийг би сонслоо. Бас Чиний дэргэд хэрэгцээт, хэн хүнгүй хүмүүс байж гэнэ! Хажуудаа хандив болгохоор зарим хүнс авчирлаа. Таны байдлыг мэдэнгээ ингэсэн нь илүү зохимжтой гэж үзлээ!» гээд хүнсийг түүнд өргөв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- асхабтаа:

«–Аваарай, үүнийг идээрэй!» хэмээж түүнээс юм идээгүй. Би өөртөө; «Энэ нь нэг!» гэлээ. Дараа нь Түүнээс салж байрандаа харив. Дахиад зарим идээ цуглууллаа. Тэр хооронд Аллахын Элч ч Мадинад ирсэн байв. Дэргэд нь очоод:

«–Чамайг хандив идэхгүй байхыг харлаа. Энэ бол чамд дайлахаар бэлтгэсэн бэлэг юм!» гэлээ. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- энэ удаа түүнээс идээд асхабтаа ч идэхийг хэлэв. Өөртөө «Энэ нь хоёр!» гэлээ.

Дараа нь Хүндэт Элч Эзэн маань Бакийу’л-Гаркадад байхад би дэргэд нь очлоо. Тэнд асхабаасаа нэгний оршуулахын ёслолд очсон бөгөөд асхабынхаа дунд сууж байв. Дээрээ хоёр талаа бүрсэн нэгэн хувцастай байв. Түүнд мэндээ хүргэлээ. Дараа ч Аммурия дахь хүний надад тайлбарласан **Пайгамбарын Тамгыг** харж чадах болуу гэж хойно нь суулаа. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- миний зорилтыг ойлгож нөмрөгөө тайлав. Пайгамбарын тамгыг харангуутаа

танилаа! Шууд очоод үнсч, уйлж эхэллээ. Орчлонгуудын Эзэн надад:

«–Нааш ирээд суу!» хэмээв. Яваад өмнө нь суулаа."

Дараа нь Сэлман -радъяллахү анх- нь Ибн-и Аббас Хазратад ингэж хэлэв:

"Ибн-и Аббас аа! Чамд ярьсан шигээ надад тохиолдсон явдлыг Аллахын Элчид ч ярилаа. Миний энэ туульсыг сонссон нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д ихээр таалагдав. Боолчлол нь уг Сэлманыг оролдуулж байсан тул Бэдир ба Ухудын Дайнд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хамт явахыг минь зөвшөөрөөгүй." (Ахмад, V, 441-444; Ибн-и Хишам; I, 233-242; Ибн-и Са'д, IV, 75-80)

Сэлман -радъяллахү анх- нь насаараа хайж байсан Аллахын Элчид хүрсэн байв. Одоо түүний гагцхуу хүсэл нь байнга Пайгамбар Эзний маань дэргэд байх, Түүний тушаалаар амьдрах байв. Тэгээд Хазрат-и Сэлман -радъяллахү анх-ын энэ хүслийг үзсэн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэгэн өдөр түүнээс:

"–Сэлман аа! Боолчлолоос аврагдахын төлөө эзэнтэйгээ гэрээ хийвэл болохгүй юу?" хэмээн асуув. Тэгэхэд нь Сэлман -радъяллахү анх- нүхийг нь ч малтаж хасарвааны гурван зуун мод тарих ба дөчин укайяа[171] алт өгөх шалтгаанаар эзэнтэйгээ гэрээ хийв. Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч асхабтаа:

"–Дүүдээ туслаарай!" хэмээв. Зарим нь арав, зарим нь арван тав, зарим нь хорин зулзган мод гээд хүн бүр нь чадах

171. 1 укйя нь ойролцоогоор 128 грамтай тэнцэх жингийн хэмжүүр юм.

чинээгээрээ тусламж үзүүлээд Сэлман -радъяллахү анх-ад хэрэгтэй хасарвааны гурван зуун зулзага цугларав.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Сэлман аа! Моддын төлөө нүх малт! Малтахаа дуусахдаа надад мэдүүлээд, тэднийг гараараа би өөрөө тарья,” хэмээв.

Сэлман-и Фарисий -радъяллахү анх- цаашийг нь ингэж ярина:

“Хасарвааны зулзганы төлөө нүх малтаж эхэллээ. Манай найзууд ч надад туслав. Дуусахад нь би мэдээ хүргэж, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- мод тарих газар миний хамт явав. Бид модыг Түүнд өгөөд, Тэр ч тарьж байв. Миний биеийг хүчит гараар барьсан Аллахад тангараг өргөе, Аллахын Элчийн тарьсан хасарвааны модноос өсөөгүй нь болоогүй. Ингээд би модны өрөө төлсөн боллоо. Мод нь жилдээ жимс ургуулж эхлээд, хүмүүс ч жимсийг нь идэв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэгэн дайнаас тахианы өндөгний хэмжээт алтны ембүү авчирсан байв.

«–Сэлман яасан бэ?» хэмээн асуув.

Намайг Аллахын Элчийн дэргэд очиход надад:

«–Сэлман аа! Үүнийг аваад өрөө төл!» хэмээв.

«–Аяа Расулаллах аа! Миний дээрх тийм том өрт иймхэн алтны өөдөс нь яаж хүрэх вэ?!» гэлээ.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- алтыг бариад үлээж дараа:

«–Үүнийг ав! Аллах Таала чиний өрийг үгээр төлөх болно!» хэмээв.

Би алтыг авав. Авлагад нь түүнээс жинлэж жинлэж өглөө. Сэлманы биеийг хүчит гараар барьсан Аллахад тангараг өргөе, тэр алтныембүүнээс дөчин укайяа жинлэв. Тэр нь маш элбэг бөгөөд хэрэв Ухуд Уулаар жинлэсэн бол, заавал түүнээс ч хүнд татах байв!"

Сэлман -радъяллахү анх- боолчлолоос чөлөөлөгдсөний дараа Хэндэк Дайнд эрх чөлөөт буйгаараа оролцоод, түүний дараа ямар ч дайнд Пайгамбар Эзний маань дэргэд байх завшаанаа алдаагүй.[172]

Сэлман-и Фарисий -радъяллахү анх- хамаг байдлаараа маш сайхан жишээ хүн ба анхаарал татах төв болсон тул Энсар ч Мухажир ч:

"–Сэлман нь бидний хүн юм," гээд түүний хуваалцаж чадахааргүй болцгоов.

Тэгэхлээр нь Оршигчдын Туяа Эзэн маань:

"–Сэлман нь биднээс, Эхл-и Бэйтийн хүн юм," хэмээж тэр ариун сахабийгаа хамгийн сайхан бэлгээр шагнав. (Ибн-и Хишам, III, 241)

Энэ ариун сахабий нь амьдралынхаа турш Исламын ёс суртахууны гоо сайхныг ойлгох оргилын олон үйл толилуулж итгэгчдэд үлгэр жишээ нэгэн хүн болов.

Түүний эрдмийг ойлгох өөр нэгэн жишээ нь ийм байна:

Ислам Гүрэн нь олсон ялалтаараа уужим өргөн нутаг эзлэхлээр нь, дээр үед нэгэн еврейгийн боол асан Сэлман -радъяллахү анх- нь Мидианы тойрогт даргаар томилогдов. Тэр хооронд Дамаскаас Тэймийнхний аймгийн харьяа нэгэн хүн

---

172. Хар. Ахмад, V, 443-444; Ибн-и Эсир, *Үсдү'л-Габэ,* II, 419; Ибн-и Абдилбэр, II, 634-638.

Мидианд ирэв. Хажуудаа ачааны инжир жимс авчирсан байв. Сэлман -радъяллахү анх-ын биед маш даруй нэгэн хувцас байв. Дамаскын хүн нь Хазрат-и Сэлманыг таньдаггүй байв. Түүний ийм байдалд харахлаараа:

“–Ирээд үүнийг зөө!” гэв. Сэлман -радъяллахү анх- очоод ачааг үүрэв. Ард нь түүнийг харахдаа танив. Нөгөө хүнд:

“–Чиний ачааг зөөсөн энэ хүн нь тойргийн дарга юм!” гэцгээв.

Дамаскынх нь шууд:

“–Чамайг таньсангүй,” гээд уучлал гуйж ачааг түүний нуруунаас авахаар хандав. Сэлман бол:

“–Асуудал үгүй, ачааг танайд хүргэтэл буулгахгүй,” гэв. (Ибн-и Са’д, IV, 88)

Тэбэнний буюу өргөхийг Цуцалсан нь

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д номлох үүрэг ирэхээс өмнө ариун эхнэр Хазрат-и Хатижагийн бэлэглэсэн Зэйдийг Хазрат-и Пайгамбар чөлөөлсөн байв. Зэйд -радъяллахү анх- нь аавынхаа дэргэд очилгүй хэвээрээ Расулаллахын дэргэд байхыг сонгосон, Хазрат-и Пайгамбар ч түүнийг өргөж авсан байв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- н Зэйдэд их дуртай байсан тул, түүнийг эхлээд чөлөөт боол нь Үммү Эймэнтэй, дараа ч авга эгчийнхээ охин Зэйнэб бинт-и Жахштай гэрлүүлэв. Хазрат-и Зэйнэб нь түүнийг өөртөө тэгш гэж үзээгүй тул эхлээд Зэйд -радъяллахү анх-тай гэрлэх гээгүй байсан ч, Хазрат-и Пайгамбар гуйсан ба:

إِنَّ أَكْرَمَكُمْ عِندَ اللهِ أَتْقَاكُمْ

“...Аллахын онгонд таны хамгийн үнэт тань таквагаа-раа хамгийн давуу нь юм...” (эл-Хужурат, 13)

وَمَا كَانَ لِمُؤْمِنٍ وَلَا مُؤْمِنَةٍ إِذَا قَضَى اللّٰهُ وَرَسُولُهُ أَمْرًا أَنْ يَكُونَ لَهُمُ الْخِيَرَةُ مِنْ أَمْرِهِمْ وَمَنْ يَعْصِ اللّٰهَ وَرَسُولَهُ فَقَدْ ضَلَّ ضَلَالًا مُبِينًا

“Аллах ба Элч нь нэгэн ажил нэгэн шийдвэр гарга-хад нь итгэн үнэмшсэн эрэгтэй эсвэл эмэгтэйд тэр ажлыг өөрийнх дураар сонгох эрх үгүй. Хэн ч Аллах ба Элчид эсэргүүцвэл, ил далангүй төөрсөн болой,” (эл-Ахзаб, 36) гэсэн ает-и кэримэнүүд буусан тулд зөвшөөрсөн байв. Харин сэтгэл нь Зэйдэд яасан ч халаагүй, гэрлэлт нь хэсэг хугацааны дараа дуусах цэгт хүрсэн байв. Зэйд ч түүнд гомдсон байв. Түүнчлэн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д ирээд байдлыг ярихад нь:

“–Эхнэрээ хажуудаа байлгаж, Аллахаас ай!” хэмээсэн хариу авсан байв.

Үнэндээ Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-тэр хооронд ирсэн тэнгэрлэг вахийгаар Аллахын Зэйнэбийг Түүнд эхнэр болгож өгөхийг мэдэж, харин хүмүүсийн дундах мүнафикчуудын “Мухаммед өргөмөл хүүгийн салсан эмэгтэй-тэй гэрлэв!” гээд замбараа алдуулахаас татгалзаж байсан тул хүлээж байв. Учир нь, тэр үеийн ёсоор хэн нэгэн хүү өргөж авбал, хүмүүс өргөмлийг түүний нэрээр нэрлэдэг, түүнд төрсөн хүү шиг ханддаг ба өвөөс хувь өгдөг байв.

Эцэст нь Хазрат-и Зэйд ба Зэйнэб -радъяллахү анха- сала-хад араас нь шинэ нэгэн вахий ирэв. Тэнгэрлэг зарлиг нь Аллахын Элчид Хазрат-и Зэйнэбийг эхнэр болгохыг ч тушааж,

энэ тухай анхны үйлийг ч Хазрат-и Пайгамбарт хийлгээд, мунхаг үеийн заншил хүү өргөх асуудлыг шийдэж байв:

وَإِذْ تَقُولُ لِلَّذِي أَنْعَمَ اللهُ عَلَيْهِ وَأَنْعَمْتَ عَلَيْهِ أَمْسِكْ عَلَيْكَ
زَوْجَكَ وَاتَّقِ اللهَ وَتُخْفِي فِي نَفْسِكَ مَا اللهُ مُبْدِيهِ وَتَخْشَى
النَّاسَ وَاللهُ أَحَقُّ أَنْ تَخْشَاهُ فَلَمَّا قَضَى زَيْدٌ مِّنْهَا وَطَرًا
زَوَّجْنَاكَهَا لِكَيْ لَا يَكُونَ عَلَى الْمُؤْمِنِينَ حَرَجٌ فِي أَزْوَاجِ
أَدْعِيَائِهِمْ إِذَا قَضَوْا مِنْهُنَّ وَطَرًا وَكَانَ أَمْرُ اللهِ مَفْعُولًا

“Аяа Элч минь ээ! **Аллахын шим олгосон, Чиний ч сайн сайхан хийсэн хүнд Чи «Эхнэрээ хажуудаа байлгаж, Аллахаас ай!» гэж байлаа. Аллахын илрүүлэх юмыг татгалзан дотроо нууж байв. Харин айвал зохих нь Аллах юм. Зэйдийг тэр эмэгтэйтэйгээс салахад, Бид түүнийг Чамтай гэрлүүлж, өргөмөл хүүхдүүд нь эхнэртэйгээ харьцаагаа салахад,** (тэр эмэгтэйтэй гэрлэмээр байвал) **итгэгчдэд ямар нэгэн төвөг эс болог. Аллахын тушаал хэрэгжсэн мөн.”** (эл-Ахзаб, 37)

Уг тэнгэрлэг тушаалаас болж Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-тэй гэрлэсэн Хазрат-и Зэйнэб эх маань:

“–Миний гэрлэлтийг Раб минь зарлав!..” гээд Аугаа Эрхэд талархдаг байв. (Тирмизий, Тэфсир, 33/3213)

Харин ийм болоход мүнафикчуудын ширүүн хов яриaнд учир болов. Мунхаглал ба нифакаар дүүрэн амаараа Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг:

"–Хүүгийнхээ салсан эхнэрийг авав!" гэж буруушааж үүнийг эсэргүүцэв. Үүний хариуг бол Кур'ан-и Кэрим ингэж өгөв:

مَّا كَانَ مُحَمَّدٌ أَبَا أَحَدٍ مِّن رِّجَالِكُمْ وَلَكِن رَّسُولَ اللَّهِ
وَخَاتَمَ النَّبِيِّينَ وَكَانَ اللَّهُ بِكُلِّ شَيْءٍ عَلِيمًا

"Мухаммед нь таны эрчүүдээс хэний ч аав биш юм. Харин Тэр нь Аллахын Элч ба пайгамбарчуудын сүүлч нь юм. Аллах бүхнийг ёсоор нь мэдэгч мөн." (эл-Ахзаб, 40)

Товчоор нь энэ явдлаар, мунхаг харанхуй үеэс нааш үргэлжилж байсан "хүү өргөх" заншилыг цуцлав.

Өнөөдрийн үгүйсгэгч ба мүнафикчуудын ч "Хазрат-и Пайгамбар нь Зэйнэбийн гоо сайхныг бишрэн түүнтэй гэрлэв," гэсэн яриа нь, үнэхээр мунхаглалын яриа юм. Угаасаа Зэйнэб -радъяллахү анха- нь Аллахын Элчийн авга эгчийн охин байсан ба Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- түүнийг өмнө нь ч хардаг байв. Хэрэв Пайгамбар Эзэн маань ийм хүсэлтэй байсансан бол, Хазрат-и Зэйнэбийг Зэйдээс өмнө өөртэйгөө гэрлүүлж болох байв. Хазрат-и Зэйнэб ч үүнийг дуртай зөвшөөрөх байв.

Гэрлэлтийг зөвхөн хүсэл тачаалын өнгөн талаас ойлгодог гүехэн ухаантнууд нь Пайгамбарын маань гэрлэлтийн үнэнийг ойлгоход ухаан дутах юм. Ухаан ба сэтгэлээ бие махбодийн хүслийн дагуу дүүргэгчдийн гаргах эрхгүй ба тэнэг шийдвэр нь бол тэдний л хувьд байх зүйл. Учир нь, Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн гэрлэлтийн залуу чийрэг үетэй тааралдсан анхны 24 жил нь ганцхан Хазрат-и Хатижа -радъяллахү анха- эхтэй маань өнгөрсөн байдаг. Түүний дараах гэрлэлт нь бол ерөөсөө Исламын, улс төрийн ба нийгмийн

зарим хэрэгтэй хамаатай байв. Тэдний ихэнх нь Түүнээс настай ба бэлбэсэн эмэгтэйчүүд байв. Тэдний дундаас залуу ба ариун буйгаар нь гэрлэсэн зөвхөн Хазрат-и Аиша -радъяллахү анха- байв. Энэ бол эмэгтэйчүүдтэй хамаатай асуудлыг илрүүлэх учиртай байв. Хазрат-и Аиша нь үнэхээр оюун ухаанаараа эмэтгтэйчүүдтэй хамаатай шашны хэргийг хамгийн төгсөөр ойлгосон ба Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэл- лэм- өөд болсны дараа ч олон жил мусульман эмэгтэйчүүдыг боловсруулсан, шашны дүрэм журмаас хэсгийн бат суурийг хэрэгжсэн байдаг. Сахабагийн дундаас гарсан долоон эрдэм- тний нэгэн байсан тул, эмэгтэйчүүдийн хооронд фиких хэмээн ухаан нь ихэнхдээ түүний дэлгэрүүлсэн ёсон билээ.

Өшөөт хүмүүсийн санал болгосноор эдгээр гэрлэлтүүдийн учир нь тачаал байсансан бол, Орчлонгийн Хүндэт Эзэн маань амьралынхаа хамгийн залуу ба хамгийн чийрэг үеийг өөрөөсөө арван тав эгч, бэлбэсэн ба хүүхэдтэй нэгэн эмэгтэй- тэй өнгөрөөхгүй байв. Эдгээр гэрлэлтүүдийг ямар агуу учиртай хэрэгжсэнийг, зөвхөн итгэл үнэмшлийн санааг эзэмшсэн мэд- лэг ба мөстэй хүмүүс л үнэлж чадна.

Тэсэттүр буюу Хувцаслан Далдлах Фарз Болсон нь

Исламаас өмнө Арабчуудад тэсэттүр гэсэн зан байгаагүй. Исламын анхны жилүүдэд ч энэ нь хэвээрээ явж байв. Харин дээр согтууруулах ундаа ба мөрийн сэдэвт илэрхийлсэн шат шатын аргын хэргээр энэ байдал ингэж явахгүй байх нь тодорхой байв. Эцэст нь тэсэттүрийн ает бууж, уг аетаар эмэг- тэй хүний байр суурийг дээшлүүлэв. Нэр алдрыг нь хамгаалж нэмэв. Түүнийг ариун байдлын хөшөө болгов.

Нөгөө талаас тэсэттүртэй хамаатай шийдвэр нь зөвхөн эмэгтэй хүнтэй хамаатай биш, эрэгтэй хүнд ч хандлаг. Өөрөөр

хэлбэл энэ тухай тушаал нь эр-эм итгэгч бүрийн хамаарна. Аллах Таала айлдана:

قُل لِّلْمُؤْمِنِينَ يَغُضُّوا مِنْ أَبْصَارِهِمْ وَيَحْفَظُوا فُرُوجَهُمْ ذَلِكَ أَزْكَى لَهُمْ إِنَّ اللهَ خَبِيرٌ بِمَا يَصْنَعُونَ. وَقُل لِّلْمُؤْمِنَاتِ يَغْضُضْنَ مِنْ أَبْصَارِهِنَّ وَيَحْفَظْنَ فُرُوجَهُنَّ وَلَا يُبْدِينَ زِينَتَهُنَّ إِلَّا مَا ظَهَرَ مِنْهَا وَلْيَضْرِبْنَ بِخُمُرِهِنَّ عَلَى جُيُوبِهِنَّ

“Элч минь ээ! **Итгэгч эрэгтэйчүүдэд хараагаа хүргэхгүй, нэрээ ч хамгаалахыг хэл! Учир нь энэ нь тэдний төлөө илүү цэвэр юм. Андашгүй нь Аллах тэдний хийдэг бүхнийг мэддэг. Итгэгч эмэгтэйчүүдэд ч хэл: Хараагаа хамгаалцгааг; нэр алдраа хамгаалцгааг. Ил хэсгээсээ** (нүүр, гар, хөл) **гадна гоо сайхнаа бүү ил гаргацгааг. Алчуураа зах дээрээ** хүртэл **буулгацгааг...”** (эн-Нур, 30-31)

Эмэгтэй хүн биеэ далдалж нэр хүндээ хамгаална. Эмэгтэй хүний даруу төлөв хувцаснь бусдад эелдэг харагдана. Бусад тохиолдолд эмэгтэй нь бие махболийн хүслийг хөдлүүлдэг тачаалын багаж мэт сэтгэгдэлтөрүүлнэ. Энэ байдал нь эмэгтэй хүний нэр алдрыг доошлуулж, ээж болох хүндийг багасгана.

Энд ялангуяа тэмдэглэх хэрэгтэй цэг нь бол, туурвилын шинжээрээ эмэгтэй ба эрэгтэйн нэфс нь ялгаатай байдаг. Энэ бол эмэгтэй ба эрэгтэйн тэнгэрлэг томилолтоор авсан үүрэг ба үүнтэй хамаатай шинжийн ялгаанаас үүссэн байдаг. Ийм учраас тэсэттүрийн эмэгтэйтэй хамаатай бүтэц нь эрэгтэйтэй хамаатай бүтэц нь ялгаатай байдаг. Учир нь эмэгтэй хүн эрэгтэй хүнээс илүү анхаарал татдаг. Тэсэттүрийг хаяад биеэ

нийгэмд нэг төрлийн тайлбал, эелдэг үзвэр нь гэмтэгдэнэ. Ээж болох шинж ба удмыг хамгаалах шинж нь аюулд орно. Ийм учиртай тэсэттүрийн тушаал нь түүний анхаарал татам шинжийг зөвхөн өөрт нь зориулсан байдаг. Эмэгтэй эрэгтэй хоёрын хооронд удмын үргэлжлэлийн төлөө өөрчлөгдөхгүй туурвилаас нэгэн эрмэлзэл байдаг бөгөөд, тэсэттүрийн тушаалыг дагахгүй тохиолдолд энэ эрмэлзэл нь тэнгэрлэг хилийг зөрчих мэтийн гамшигт автуулах чинээ аюултай ёс суртахууны уналтын учир болно. Энэ тухай Аугаа Эрхийн:

وَلاَ تَقْرَبُواْ الزِّنَ

"Зинад дөхүүзэй!.." (эл-Исра, 32) хэмээсэн тэнгэрлэг тушаал дахь нэгэн учир ч "Тэсэттүрийг зөрчиж зинад зам нээгүүзэй; түүнд боломж олгуузай!" гэсэн утга агуулна. Энэ нь лав нэгэн шийдвэр юм. Анхаарал хандвал, Ислам нь гаднаасаа анхаарал татмааргүй эмэгтэйд ч тэсэттүрийг тушаасан байдаг. Өөрөөр хэлбэл "Энэ эмэгтэй нь толгойгоо, гараа, булчнаа нээсэн ч ялгаагүй, угаасаа анхаарал татдаггүй," гэж болохгүй. Энд эмэгтэй хүний хүндээ тэсэттүрээр хамгаалах нь гол юм.

Хүний туурвилаас үүссэн фитратад анхаарал үзүүлж түүний дагуу шийдвэр тогтоосон Ислам нь эмэгтэй ба эрэгтэйн шаардлагыг ч боддог. Ийм учраас Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- эмэгтэйг дуурайсан эрчүүд ба эрэгтэйг дуурайсан эмчүүдийг хараасан байдаг.[173] Өөрийгөө ийм аюулаас хамгаалахаар эмэгтэйчүүд нь салиха эмэгтэйчүүдийн нийгэмд болохдоо хичээх хэрэгтэй юм. Учир нь хүн бол хэнтэй хамт явбал, түүний байдлыг дагана. Энэ нь сэтгэл зүйн нэгэн дүрэм юм. Эмэгтэй нь эрэгтэйчүүдийн хамт гудамжийн амьдралд

173. Хар. Бухарий, Либас, 61.

орохлоороо эмэгтэ йхүний сэтгэл ба эмэгтэй хүний тэр сайхан шинжээ алдах болно.

Эмэгтэй эрэгтэй хоёрын хувцаслахдаа ч нэг нэгэнтэй төсөөт болох нь ч хориглосон байдаг. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь эмэгтэй шиг хувцасласан эрчүүд болон эрэгтэй шиг хувцасласан эмчүүдийн тэнгэрлэг энэрлээс хол байхыг мэдүүлсэн байдаг.[174] Учир нь хоёр тал ч эрэгтэй ба эмэгтэй хүний нэр алдраа хамгаалах хэрэгтэй юм.

Мөн нөгөө хүйсний хувцасыг дуурайых нь зангийн замбараагүйд ч учир болдог. Жишээлбэл өөрийнх хүйсний шаардсан хувцаснаас байтугай, -яамар нэгэн учраар- нөгөө хүйсний хувцаслах аргыг эзэмшсэн хүмүүсийн үйл хандлага нь ч цаг хугацааны дотор тэр чигээр өөрчилдөг. Энэ ч фитрат эвдэрсэн гэсэн утгатай байдаг юм.

Мүрэйсийгийн Газва (5 оны Шабан-Рамазан сар / 627 оны 1-2 сар)

Уг дайныг Бэний Мусталикын Дайн ч гэдэг. Мусталикынхан нь Маккагийн мүшрикчүүдийн өдөөснөөр Мадина руу довтлохоор олон цэргийн хүмүүсийг цуглуулж эхэлсэн байв. Энэ мэдээллийг авсан Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь долоон зуун цэргээ авч тэдэн рүү хөдлөв. Аллахын Элч нь Хазрат-и Умарт Мусталикынханд: “Ла илахлэ иллаллах гээд амь ба бараагаа хамгаалцгаа!” гээд дуудахыг тушаав. Гэтэл Мусталикынхан уг саналыг зөвшөөрөөгүй бөгөөд анхны сум харавсан нь тэдний талаас болов.[175]

174. Хар. Эбү Давуд, Либас, 28/4098.

175. Хар. Вакидий, I, 407.

Мусульманчууд нь Мүрэйсий усан дээр хийсэн ширүүн дайралтаар дайснаа ялав. Дайснаас арвыг алаад, мусульманчуудаас ч нэг нь шэхид болов.

Дайны сүүлд маш олон олз олоод, олон хүн барив. Барьцааны хүмүүсийн хооронд аймгийн тэргүүний охин Жүвэйрие ч байв.

Олзны хүмүүсийг барьцааны мөнгөөр чөлөөлдөг байв. Жүвэйрие бол Сабит бин Кайсын хувьд оносон байв. Авралтын мөнгөөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс лавлав. Тэр хооронд охины аав ч ирээд, язгууртан байснаа дурдан охин нь шивэгчин байж болохгүй илэрхийлж, нэр алдрыг нь хамгаалахыг гуйж байв. Хажуудаа авчирсан хэдэн тэмээг зааж:

“–Эдгээр тэмээнүүд миний охины төлбөр юм. Түүнийг чөлөөлөөч!” гэж байв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч түүний огт санаагүйгээр:

“–Чиний нуусан хоёр тэмээ хаана? Тэдгээрийг яагаад авчраагүй вэ?” хэмээн асуув.

Манханд нуусан хоёр тэмээг өөрөөс нь гадна хэн ч мэдэхгүйг бодож байсан Харис нь гайхан:

“–Валлахи үүнийг надаас өөр мэдсэн хэн ч байгаагүй!..” гэв. Ийм гайхмаар мэдрэмжийг ойлгоод хамт ирэгсэдтэйгээ хамт мусульман болов.[176]

Тэгэхлээр нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Жүвэйриегээс саналыг нь асуув. Түүнийг өөрийнх нь дэргэд баймаар буйг ойлгоод мөнгийг нь өөрөө төлөөд чөлөөлөв. (Ибн-и Са’д, VIII, 118) Чөлөөлсөн Жүвэйрие ч өөрийнхөө хүслээр мусульман болов. Дараа нь Аугаа Эрхийн хайрласнаар

176. Хар. Ибн-и Хишам, III, 340.

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-тэй гэрлэх нэр хүндийг хүртэв. Ингэхдээ түүний өмнө нь харсан зүүд нь хэрэгжсэн болов. Угаасаа аавыг нь барьцааны мөнгийг нь төлөөд чөлөөлөх боломж байсан ч Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд байхаа сонгосон нь ийм учиртай байв.

Жүвэйриегийн Хазрат-и Пайгамбартай гэрлэснийг мэдсэн Асхаб-и кирам хазратчууд ч:

"–Пайгамбарын садан хамаатан нь олз болсон нь зохимжгүй!" гээд барьцааны хамаг хүмүүсийг төлбөргүйгээр чөлөөлцгөөв. Энэ тухай Хазрат-и Аиша -радъяллахү анха- ингэж хэлэв:

"–Ардынхаа төлөө Жүвэйриегээс илүү буянтай эмэгтэйг бид хараагүй; түүний улмаас Бэний Мусталикаас зуун гэр бүл чөлөөлөгдөв." (Эбү Давуд, Итк, 2/3931)

Энэ үгээс ойлгосноор нь Пайгамбар Эзний маань Жүвэйрие эхтэй гэрлэсэн нь бүрэн улс төрийн зорилготой бөгөөд:

وَمَا يَنطِقُ عَنِ الْهَوَى إِنْ هُوَ إِلَّا وَحْيٌ يُوحَى

"Тэр нь өөрийнх дураар биш, вахийн дагуу л ярина (ба хандана)**"** (эн-Нэжм, 3-4) гэсэн аетын илэрхийлснээр нэфсийнхээ дагуу биш, Аллахын Элчийн сэтгэлд төрсөн тэнгэрлэг шийдвэрийн чиглэлд хэрэгжсэн байдаг. Тэгээд уг гэрлэлтийн дараа Бэний Мусталикаас олзны олон хүмүүс эрх чөлөөндөө хүртсэн, түүнээс ч чухал нь, хамаш аймаг мусульман болсон байв.

Бэний Мусталикын дайн
Эвс ба Хазрэж
Жухэйнэ
МАДИНА
Зү'л-Хулэйфэ
Мүзэйнэ
Сүлэйм
Гифар
Эбвэ
Бэдир
Жухфэ
Рабиг
МҮРЭЙСИ
Хуза'а
Кудайд
УЛААН ТЭНГИС
Эмэж
Эдэл ба Кара
Хүзэймэ
Үздэн
Худэйбие
МАККА
Курайш
Арафат
Хэвзин
Таиф
Сэкиф
Мазин
Эзд

Тэеммүм

Аиша -радъяллахү анха- эх маань ингэж ярина:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-тэй (Мүрэйсий) аянд хамт явж байлаа. Бэйда гэгч дурдсан нэгэн газар эсвэл Зату’л-Жэйш гэдэг газар ирэхэд, миний зүүлт тасрав. Расулаллах түүнийг хайхаар хэсэг хугацаагаар тэнд байж байгаад, Түүний хамт бусад хүмүүс ч хүлээв. Тэр хавьд ус олдоогүйгээр үл барам, тэдэнд ч ус үлдээгүй байв. Хэсэг хүмүүс Эбү Бэкир дээр очоод:

«–Аишагийн хийснийг харав уу! Расулаллахыг ч бусад хүмүүсийг энд саатуулав. Тэд усан дээр биш, хажууд нь ус ч үгүй!» гэцгээжээ. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- толгойгоо өвдгөн дээр минь тавиад унтаж байхад аав Эбү Бэкир ирэв.

«–Чи Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг ч хүмүүсийг ч энд хорив. Энэ хавьд ус байхгүй шиг байна тэдэнд ч ус алга !» гээд намайг загнаж зөндөө олон үг хэлэв. Хилэнгээ ялж ядан, гараараа намайг цохив. Расулаллахын толгой нь миний өвдгөн дээр байсан тул хөдлөхгүй байхыг хичээлээ.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг өглөө босоход ус огт байгаагүй. Хэсэг хугацааны дараа Аллах Таала тэеммүмийн аетыг буулгав:

وَإِن كُنتُم مَّرْضَى أَوْ عَلَى سَفَرٍ أَوْ جَاء أَحَدٌ مَّنكُم مِّنَ الْغَائِطِ
أَوْ لاَمَسْتُمُ النِّسَاء فَلَمْ تَجِدُواْ مَاء فَتَيَمَّمُواْ صَعِيدًا طَيِّبًا فَامْسَحُواْ
بِوُجُوهِكُمْ وَأَيْدِيكُم مِّنْهُ مَا يُرِيدُ اللّهُ لِيَجْعَلَ عَلَيْكُم مِّنْ حَرَجٍ
وَلَكِن يُرِيدُ لِيُطَهَّرَكُمْ وَلِيُتِمَّ نِعْمَتَهُ عَلَيْكُمْ لَعَلَّكُمْ تَشْكُرُونَ

«...Өвчин эсвэл аян замд байвал, эсвэл танай хэн нэгэн биеэ засаад ирвэл, эсвэл эмэгтэйдээ хүрсэн ба ийм тохиолдолд ус олж чадаагүй байвал, цэвэр хөрстэйгөөр тээммүм хийгээд нүүр болон (тохой хүртлээ) **гараа түүгээр мэсх хийцгээ! Аллах танд ямар нэгэн төвөг учруулмааргүй; харин таныг цэвэр болгох ба танд** (хайрласан) **шимээ бүтээмээр байдаг; таныг талархах нь найдвартай.»** (эл-Маида, 6)

Үсэйд бин Худайр -радъяллахү анх- ингэж хэлэв:

«–Эбү Бэкирийн гэр бүл ээ! Энэ нь үммэтийн төлөө таны тоолшгүй элбэгээс зөвхөн нэг нь юм.»

Унасан тэмээгээ босговол зүүлт түүний дороос гарав.” (Бухарий, Тээммүм, 1; Асхабу’н-Нэбий, 5, 30)

Үсэйд -радъяллахү анх- Аиша эхэд маань:

“Аллах чамайг буянаар шагнах болтугай! Валлахи хэзээ ч чамд бидний дургүй нэг хэрэг тааралдвал, Аллах түүнийг чиний төлөө ч мусульманчуудын төлөө ч буян болгоно,” гэв. (Бухарий, Тээммүм, 1)

Ифк (Гүтгэлэг) Асуудал

Мүрэйсийн Дайнаас буцах замд байв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ариун эхнэр Хазрат-и Аиша -радъяллахү анха-[177] нь цэргийн хоносон газраас жаахан холдсон байв. Харихад нь бол цэрэг аль хэдийн хөдөлсөн байв. Учир нь тэр хооронд тэсэттүрийн аег буусан ба итгэгчдийн эх нь нэгэн тийш явж байхдаа тэмээн дээр тавьдаг ба хэвдэш

177. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- явсан дайн бүрт сугалаагаар ариун эхнэрээс нэгийг ч хамт авч явдаг байв. Мүрэйсий Газвад ч сугалаа нь Хазрат-и Аиша эхэд маань таарсан, түүнтэй хамт явсан байв.

гэж нэрлэдэг нэгэн өрөөнд суухаар болсон байв. Ийм учраас цэргийг хөдлөхөд хүмүүс итгэгчдийн эх Хазрат-и Аиша -радъяллахү анха-г тэмээн дээрх хэвдэш дотор буй гэж бодсон байв.

Хазрат-и Аиша эх маань цэргийн араас яваад алга болсноосоо буй газар хүлээхийг илүүд үзэв. Зүүрмэглэж эхлэв. Тэр хооронд хамт олноос хоцрогсдыг цуглуулах үүрэгтэй байсан Сафван бин Муаттал -радъяллахү анх- нь Хазрат-и Аишаг анзааран:

إِنَّا لِلّٰهِ وَإِنَّا إِلَيْهِ رَاجِعونَ

“...Бид Аллахад харьяалагдах ба дахиад Тэрээрт л харина,” (эл-Бакара, 156) гэсэн аетыг уншиж өөрөө тэнд буйг дуулгав.

Энэ дуугаар Хазрат-и Аиша эх маань сэрэв. Сафван -радъяллахү анх- нь ганц үг ч хэлэлгүй тэмээгээ сөхрүүлэв; Хазрат-и Аиша эх маань ч унав. Үд болоход тэд цэрэгт гүйцсэн байв. Үүнийг харсан мүнафикчууд нь олдошгүй завшаан гардсан шиг энэ удаа ч амаа муухай нэгэн гүтгэлгийн төлөө л нээв:

“–Валлахи Аиша ч түүнээс, тэр ч Аишагаас аврагдсан бололгүй,” гэцгээв. Түүнчлэн Абдуллах бин Үбэй бүр хэтрүүлэн итгэгчдэд:

“–Харцгаа, Пайгамбарын тань эхнэр нэгэн эртэй өглөө болтол хонов...” гээд шоглов.

Фитнэ буюу самуун нь гэнэтхэн хамаг цэргийг эргэв. Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх- маш их зовж шаналав:

“–Валлахи бид ийм гүтгэлэгтэй мунхаглалын үед ч учраагүй!..” гэв.

Хазрат-и Сафван -радъяллахү анх- бол гүнзгий гунигт автсан байв. Тэр нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн:

“Түүний тухай буянаас өөр юм би мэдэхгүй!..” хэмээсэн шилмэл нэгэн сахабий байв.

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг асуувал; хамгийн том гуниг, андашгүй нь Түүний ариун сэтгэлд унасан байв. Ихэнхдээ гэртээ суугаад, хүмүүстэй ихээр уулздаггүй байв. Энэ тухай жижигхэн нэг судалгаа хийлгэв. Хазрат-и Аишагийн гэмтэй байсны тухай өчүүхэн тэмдэг ч байгаагүй. Харин мүнафик цуурхал дарагдахгүй байв.

Энэ байдлыг хамгийн сүүлээр сонссон нь Аиша эх маань болов. Энэ хүнд гүтгэлгийг сонсонгуутаа санаа айхтар зовов. Тайлбарлашгүй нэгэн зовлонгоор Пайгамбар Эзнээс маань зөвшөөрөл аваад аавынхаа гэрт, энэ тухай мэдээлэл олохоор очив. Дуулсан хов яриаг тэднээс сонсохдоо бараг хайлж, намрын навч шиг шарлаж одов.

Энэ хооронд Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- энэ байдлыг Аиша эхтэй маань ярилцах юмсан. Эбү Бэкир -радъяллахү анх-ын гэрт очоод ариун эхнэрээсээ:

“–Аяа Аиша! Чиний тухай надад зарим үг хүрэв. Хэрэв чи гэмгүй байвал Аллах чамайг цэдэрт гаргана,” хэмээв.

Орчлонгуудын Эзний ч уг гүтгэлгээр өчүүхэн сэжигтэй буйг мэдэрсэн харийхан сэтгэлтэй Хазрат-и Аиша эх маань аав ээж хүүгээ харав. Тэдний дуугаа буйг харахлаараа, нойтон нүдээрээ Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д эдгээрийг хэлэв:

“–Валлахи, таныг энэ яриаг сонсч бараг итгэснийг би сайхан ойлголоо. Одоо би гэмгүй байна гэвэл, -угаасаа Аллах үүнийг мэддэг- итгэхгүй байж мэднэ. Эсрэгийг нь хэлбэл шууд итгэж мэднэ. Харин Аллах гэмгүй буйг миньь мэддэг. Тэгвэл би, тэр үгийн хариунд Аллахаас тусламж гуйя.”

Тухайн өдрүүдэд Эбү Эйюб эл-Энсарий Хазратын эхнэр Үммү Эйюб нь нөхрөөсөө:

“–Хүмүүсийн Аишагийн эсрэгээр хэлсэн юмыг сонсов уу?” хэмээн асуув.

Эбү Эйюб:

“–Тийм! Сонслоо. Тэд бүхэн худал ба зохиомол юм!” гэв. Дараа нь эхнэрээсээ:

“–Чи ийм муу юм хийх үү?” гэж асуув.

Тэр ч:

“–Үгүй! Валлахи би тийм муу юм ерөөсөө хийхгүй!” гэв.

Тэгэхлээр нь Эбү Эйюб -радъяллахү анх-:

“–Чамайг ийм байхад, валлахи Аиша чамаас илүү буянтай юм!” гэв. (Ибн-и Хишам, III, 347; Вакидий, II, 434)

Одоо хэргийн үнэнийг мэдэхээр тэнгэрлэг вахийг хүлээх хэрэгтэй болсон байв. Угаасаа их удахгүй Аугаа Эрх нь энэ тухай aет-и кэримэнүүдийг буулгав. Дам яриа мүнафикчуудын гүтгэлгээр бүрдсэн нь ил болов. Тэнгэрлэг зарлал нь Аиша эхийг маань ч цэвэрт гаргаж, мүнафикчуудын эрхгүй гүтгэлгийг ч царайнд нь тодруулж тэдэнд тамыг мэдүүлж, энэ гүтгэлгийг ам дамжуулсан ухаангүйчүүдийг ч сануулж байв.

Аугаа Эрх энэ тухай aет-и кэримэнүүдэд ингэж айлдаж байв:

إِنَّ الَّذِينَ جَاؤُوا بِالْإِفْكِ عُصْبَةٌ مِّنكُمْ لَا تَحْسَبُوهُ شَرًّا لَّكُم بَلْ هُوَ خَيْرٌ لَّكُمْ لِكُلِّ امْرِئٍ مِّنْهُم مَّا اكْتَسَبَ مِنَ الْإِثْمِ وَالَّذِي تَوَلَّى كِبْرَهُ مِنْهُمْ لَهُ عَذَابٌ عَظِيمٌ

“ Пайгамбарын цэвэр ариун эхнэрийг **ингэж гүтгэгсэд нь андашгүй нь таны дундаас хэсэг хүмүүс юм. Та энэ** гүтгэлгийг **өөрийнхөө тухай муу гэж бодуузай, эсрэгээр нь тэр нь таны төлөө буянтай юм. Гүтгэгчдээс тус бүр нь олсон нүгэлийн** ачаагаа үүрнэ. **Тэднээс уг нүгэлийн томыг үүрсэн бол том нэгэн тамлал байдаг.**

لَوْلَا إِذْ سَمِعْتُمُوهُ ظَنَّ الْمُؤْمِنُونَ وَالْمُؤْمِنَاتُ بِأَنفُسِهِمْ خَيْرًا وَقَالُوا هَذَا إِفْكٌ مُّبِينٌ. لَوْلَا جَاؤُوا عَلَيْهِ بِأَرْبَعَةِ شُهَدَاء فَإِذْ لَمْ يَأْتُوا بِالشُّهَدَاء فَأُوْلَئِكَ عِندَ اللَّهِ هُمُ الْكَاذِبُونَ. وَلَوْلَا فَضْلُ اللَّهِ عَلَيْكُمْ وَرَحْمَتُهُ فِي الدُّنْيَا وَالْآخِرَةِ لَمَسَّكُمْ فِي مَا أَفَضْتُمْ فِيهِ عَذَابٌ عَظِيمٌ. إِذْ تَلَقَّوْنَهُ بِأَلْسِنَتِكُمْ وَتَقُولُونَ بِأَفْوَاهِكُم مَّا لَيْسَ لَكُم بِهِ عِلْمٌ وَتَحْسَبُونَهُ هَيِّنًا وَهُوَ عِندَ اللَّهِ عَظِيمٌ

Энэ гүтгэлгийг сонсоод эр эм итгэгчдээс, хүн чнарын сайхан санаа төрүүлж «Энэ нь ил нэгэн гүтгэлэг!» гэх нь хэрэггүй байв уу? Гүтгэгчид ч энэ тухай дөрвөн гэрч авчрах нь хэрэггүй байв уу? Гэрч авчраагүй байвал, тэг-

вэл тэд Аллахын санаанд чин худалч хүмүүс юм. Хэрэв дэлхий болон ахиратад Аллахын хайр ба энэрэл танай дээр байгаагүйсэн бол, дотуур нь живсэн уг гүтгэлгээс болж танд заавал том нэгэн тамлал онох байв. Учир нь та энэ гүтгэлгийг нэг нэгэндээ дамжуулж, тухайн мэдээгүй юмыг амандаа хэвсээр байв. Үүнийг чухалгүй ба нүгэлгүй **нэгэн үйл гэж бодож байцгаав. Үнэндээ бол энэ нь Аллахын онгонд маш том** гэм нүгэл **мөн.**

وَلَوْلَا إِذْ سَمِعْتُمُوهُ قُلْتُم مَّا يَكُونُ لَنَا أَن

نَّتَكَلَّمَ بِهَذَا سُبْحَانَكَ هَذَا بُهْتَانٌ عَظِيمٌ

Түүнийг сонсохдоо «Үүнийг ярьж тараах нь бидэнд зохихгүй. Үгүй! Энэ нь маш том гүтгэлэг юм!» гэх ёстой байгаагүй юу?

يَعِظُكُمُ اللهُ أَن تَعُودُوا لِمِثْلِهِ أَبَدًا إِن كُنتُم مُّؤْمِنِينَ.

وَيُبَيِّنُ اللهُ لَكُمُ الْآيَاتِ وَاللهُ عَلِيمٌ حَكِيمٌ

Аллах танд сургаал хэлээд, хэрэв та итгэн үнэмшсэн байвал үүнтэй төсөөт үйлийг дахин хийхгүй. Мөн Аллах аетуудыг танд тайлбарладаг. Аллах бүхний дотор талыг **маш сайн мэддэг, шийдвэр ба эрдмийг эрхлэгч мөн.**

إِنَّ الَّذِينَ يُحِبُّونَ أَن تَشِيعَ الْفَاحِشَةُ فِي الَّذِينَ آمَنُوا لَهُمْ

عَذَابٌ أَلِيمٌ فِي الدُّنْيَا وَالْآخِرَةِ وَاللهُ يَعْلَمُ وَأَنتُمْ لَا تَعْلَمُونَ.

وَلَوْلَا فَضْلُ اللهِ عَلَيْكُمْ وَرَحْمَتُهُ وَأَنَّ اللهَ رَؤُوفٌ رَحِيمٌ

Итгэгчдийн хооронд муухай юмыг тараахыг хүсдэг хүмүүст дэлхийд ч ахиратад ч гашуун нэгэн тамлал хүлээж байдаг. Аллах мэддэг, та мэддэггүй. Хэрэв танай дээр Аллахын хайр ба энэрэл байгаагүйсэн бол, Аллах их халамжтай ба энэрэлтэй байгаагүйсэн бол байдал ямар болохсон бэ**!..**

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُوا لَا تَتَّبِعُوا خُطُوَاتِ الشَّيْطَانِ وَمَن يَتَّبِعْ

خُطُوَاتِ الشَّيْطَانِ فَإِنَّهُ يَأْمُرُ بِالْفَحْشَاءِ وَالْمُنكَرِ وَلَوْلَا

فَضْلُ اللهِ عَلَيْكُمْ وَرَحْمَتُهُ مَا زَكَا مِنكُم مِّنْ أَحَدٍ أَبَدًا

وَلَكِنَّ اللهَ يُزَكِّي مَن يَشَاءُ وَاللهُ سَمِيعٌ عَلِيمٌ

Аяа итгэгчид ээ! Шэйтаны алхмыг бүү дага! Хэн ч шэйтаны алхмыг дагаж явбал, андашгүй нь тэр муу муухайг тушаана. Хэрэв таны дээр Аллахын хайр ба энэрэл байгаагүйсэн бол, таны дундаас хэн ч огт цэвэр гарч чадахгүйсэн. Харин Аллах хүссэнээ ариутгана. Аллах сонсдог, мэддэг.” (эн-Нур, 11-21)

Ийм агуу үнэний дараа Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь мишээгээд Хазрат-и Аиша эхэд маань:

“–Ашгүй еэ Аиша! Аллах чамайг цэвэрт гаргав!” хэмээв.

Аиша эх маань ает-и кэримэгээр цэвэрт гарсны дараа:

“–Над шиг өчүүхэн боолын тухай ает буухыг би огт таахгүй байлаа. Би бол Аллахын Элчийн зүрхэнд онгон нь төрөөд намайг гэмгүй буйг ингэж ойлгоно гэж бодож байлаа,” гээд Аугаа Эрхэд хамдаа илэрхийлэв. Түүнийг толгойд

нь үнсээд Расулаллахын дэргэд очихыг заасан аав Эбү Бэкир -радъяллахү анх-даа ч:

"–Би Аллахаас өөр хэнд ч хамд эсвэл талархлаа илэрхийлэхгүй. Миний тухай буулгасан нь Аллах юм!" гээд гомдлоо илэрхийлэв.

Тэгэхэд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- баяртайгаар мишээв. Сар шахам хугацаанд үргэлжилсэн төвөг нь Аллахын хайр ба энэрлийг ачаар барагдав. (Бухарий, Шэхадат 15, 30, Жихад 64, Мэгазий 11, 34; Мүслим, Тавба 56; Ахмад, VI, 60, 195)

Гүтгэгдсэн нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн эхнэр, үммэтийн эх, Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хамгийн дотно найзын охин ба мөн үммэтийн хамгийн ариун явдалтай хатагтай нарын нэг нь байв. Гагцхуу энэ явдал ч, пайгамбарчуудын тунигтай тааралдахдаа хэр их тэвчээртэй буйг заахад хангалттай юм. Энэ нь киямат хүртэл гүтгэгдсэн аргагүй хүмүүст том нэгэн тайтгарал юм.

Ийм ухааны ба түүхийн үнэн бүхэн ба Кур'ан-и Кэримийн үүнийг "ифкүн мүбин: ил гүтгэлэг" ба "бүхтанун азим: том гүтгэлэг" хэмээн илэрхийлэн Хазрат-и Аиша эхийг маань тодорхой зарлан ариун гэдгийг баталсныг, түүнийг дараа нь Жэмэл Явдалд оролцсоноос нь болж буруушааж байсан ухаангүй хүмүүст юу гэвэл зохих юм бэ!?.

Ифк явдалд учир болсон гэмтнүүд, ариун явдалт нэгэн эмэгтэйд зина үүрүүлсэн учраас яллагдлаа. Ингээд гүтгэгч бүрийг наян удаа саваадав.[178]

Ибн-и Аббас -радъяллахү анхүмаа-гийн хэлснээр Аллах Таала нь дөрвөн хүний нэр төрийг сэргээн цэвэрлэсэн байдаг:

178. Ахмад, VI, 35.

1. Юүсүф -алэйхиссэлам-ыг түүнийг гүтгэсэн эмэгтэйн гэрээс нэгэн гэрчийн хэлээр,[179]

2. Муса -алэйхиссэлам-ыг еврейчүүдийн хов ярианаас,[180]

3. Хазрат-и Мэрьемийг тэвэр дэх нялх төрсөн хүүгий нь яриулаад,[181]

4. Хазрат-и Аишаг ч киямат хүртэл унших болсон Кур'ан-и Кэримийн тэр агуу аетууд шиг ийм сайхан хэл найруулгатай зарлал өмнө нь үзэгдээгүй ба Аллах Таала Элчийнхээ хэр агуу төвшин байр суурь эзэлснийг илтгэхээр хийсэн байдаг. (Зэмахшэрий, IV, 121)

Энэ хэцүү бухимдалтай үед вахий удаан оройтсон нь Пайгамбарын маань расул ба нэбий байсан ч хүн буй тэмдгийг нь илрүүлэх, вахийн Түүний ухаан ба нэфсээс үүссэн нэгэн байдал байдаггүйг заах ба мусульманчуудын үнэнч сэтгэлийг шалгах зорилготой юм.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх- нь Мистах гэсэн нэртэй нэгэн ядууд байнга тусламж үзүүлдэг байв. Энэ Ифкийн Хэрэгт түүнийг ч гүтгэгчдийн дунд байгааг хараад дахиад түүнд болон гэр бүлд нь туслахгүйгээр тангараглав. Хазрат-и Эбү Бэкирийн тусламж тасрахад Мистах ба гэр бүл хүнд хэцүү байдалд оров. Аугаа Аллах уг тусламж тасарсны араас уг ает-и кэримэг буулгав:

179. Хар. Юүсүф, 26-29.

180. Хар. эл-Ахзаб, 69.

181. Хар. Мэрьем, 29-33.

وَلَا يَأْتَلِ أُوْلُوا الْفَضْلِ مِنكُمْ وَالسَّعَةِ أَن يُؤْتُوا أُوْلِي الْقُرْبَى وَالْمَسَاكِينَ وَالْمُهَاجِرِينَ فِي سَبِيلِ اللَّهِ وَلْيَعْفُوا وَلْيَصْفَحُوا أَلَا تُحِبُّونَ أَن يَغْفِرَ اللَّهُ لَكُمْ وَاللَّهُ غَفُورٌ رَّحِيمٌ

“Таны дундаас эрдэм ба хөрөнгө баялагтай хүмүүс садан хамаатандаа, ядуучуудад, Аллахын замд гарагсад бараагаасаа **өгөхгүйн төлөө тангараг бүү өргөг; уучилж, өршөөж орхиг. Аллах таныг өршөөхийг та хүсэхгүй юү? Аллах нь их өршөөгч, их энэрэлт мөн.”** (эн-Нур, 22)

وَلاَ تَجْعَلُواْ اللّهَ عُرْضَةً لِّأَيْمَانِكُمْ أَن تَبَرُّواْ وَتَتَّقُواْ وَتُصْلِحُواْ بَيْنَ النَّاسِ وَاللّهُ سَمِيعٌ عَلِيمٌ

“Тангаргаасаа болж Аллахын төлөө, сайн сайхныг хийхдээ, Түүнээс болгоомжлохдоо ба хүмүүсийн харьцааг засахдаа саад болгуузай! Аллах бүхнийг сонсогч, бүхнийг мэдэгч мөн.” (эл-Бакара, 224)

Эдгээр ает-и кэримэнүүд Аугаа Эрхийн боолчууддаа хэр их энэрэлтэй буйн хамгийн бодит жишээ юм. Нөгөө талаас ч эрдмийн хүмүүст ч оргилд хүргэх нэгэн зорилго үзүүлнэ.

Аетууд буусны дараа Эбү Бэкир -радъяллахү анх-:

“–Би мэдээж Аллахын намайг өршөөхөд дуртай!” гэв. Дараа нь тангаргийнхаа төлбөрийг өгөөд, өмнө нь хийж байсан буянаа үргэлжлүүлж хийв. (Бухарий, Мэгазий, 34; Мүслим, Тавба, 56; Табэрий, *Тэфсир*, II, 546)

Өөрөөр хэлбэл Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх- нь өөрийнх охиныг гүтгэсэн хүнд ч тусламжаа харамлаагүй. Энэ ч тэр ариун сахабийн агуу эрдмийг илтгэх нэгэн жишээ юм.

Дайснаас Болгоомжил!

Мүнафикчуудын Мүрэйсийгийн Дайнд гаргасан цуурхал нь Ифкийн Явдлаар дуусаагүй. Мухажирчууд ба Энсараас хоёр хүний хэрүүлээс болж тэргүүн мүнафик Абдуллах бин Үбэй нь Мухажирчуудыг зааж эргэн тойрны хүмүүст:

“–Тэдний хийснийг харцгаав уу? Бидний нутагт биднийг дарлаж, дараа нь биднийг таньсангүй. Хэрэв Мадинад буцвал, ямбатан нь ядуугаа тэндээс гаргах болно,” гэв. Тэр хооронд сонсогчдын хооронд байсан салих итгэгч Зэйд бин Эркам үнэнийг хашхирав:

“–Ардынхаа дотор дорой буй нь чи юм! Аллах Таала нь Элч Мухаммед -алэйхиссалатү вэссэлам-ыгаа хүндэт болгосон байдаг!”

Энэ байдлын мэдээ Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д хүрэхэд мүнафикчууд ам буцаж хэлсэн үгсээ тангараг өргөж үгүйсгэв. Бараг Хазрат-и Зэйдийг худалч хэмээн зарлах гэж байв. Тэгэхэд нь Хазрат-и Зэйд хэтэрхий санаа зовов. Хазрат-и Умар бол Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс, Абдуллах бин Үбэйгээс эхлэн мүнафикчуудыг алах зөвшөөрөл эрэв. Харин Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэгэн ирээдүйн том санаа толилуулан:

“–Умар аа! Ажлын жинхэнэ хэргийг мэдээгүйчүүд нь «Мухаммед асхабаа алж байна!» гэж ярих болно. Үгүй! Ийм юм би хийхгүй! Чи яаралтай мусульманчуудыг дууд, замын бэлтгэл хийцгээг!” хэмээв.

Тэгээд мусульманчууд замд гарав. Пайгамбар Эзэн маань тэр өдөржин шөнөжин замд явав. Өглөө болоод нарны халуун ихэсч байхад буув. Мусульманчууд ядарсан ба унтаагүй тул газар суумагц шууд унтаж эхлэв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ингэсэн нь мусульманчуудыг Абдуллах бин Үбэйгийн хэлсэн үгээр холдуулах учиртай байв.[182] Пайгамбар Эзний маань энэ чигийн цаад бодлого нь тэр хүний биеийн бүтцийг сайн мэддэгийн илрэл юм.

Хэсэг хугацааны дараа мүнафикчуудын байдлын ает-и кэримэнүүд ингэж мэдээлэв:

إِذَا جَاءكَ الْمُنَافِقُونَ قَالُوا نَشْهَدُ إِنَّكَ لَرَسُولُ اللهِ وَاللهُ يَعْلَمُ إِنَّكَ لَرَسُولُهُ وَاللهُ يَشْهَدُ إِنَّ الْمُنَافِقِينَ لَكَاذِبُونَ. اتَّخَذُوا أَيْمَانَهُمْ جُنَّةً فَصَدُّوا عَن سَبِيلِ اللهِ إِنَّهُمْ سَاء مَا كَانُوا يَعْمَلُونَ. ذَلِكَ بِأَنَّهُمْ آمَنُوا ثُمَّ كَفَرُوا فَطُبِعَ عَلَى قُلُوبِهِمْ فَهُمْ لَا يَفْقَهُونَ

“Аяа Элч минь ээ! **Мүнафикчууд Чам дээр ирэхдээ «Чамайг Аллахын Элч гэдгийг бид гэрчилнэ!» гэцгээнэ. Чамайг андашгүй Аллахын Элч гэдэг. Харин Аллах, тэр мүнафикчуудын худалч буйг ч мэддэг. Тэд худал тангаргаа бамбай болгож Аллахын замаас төөрөв. Үнэхээр тэдний хийсэн үйлдэл ямар муухай юм бэ! Яагаад гэвэл тэд эхлээд итгэж, дараа нь үгүйсгэсэн юм. Ийм учраас тэдний зүрх тамгалагдсан байдаг. Харин одоогоос тэднийг огт ойлгохгүй.**

وَإِذَا رَأَيْتَهُمْ تُعْجِبُكَ أَجْسَامُهُمْ وَإِن يَقُولُوا تَسْمَعْ لِقَوْلِهِمْ

182. Хар. Ибн-и Хишам, III, 335-336.

كَأَنَّهُمْ خُشُبٌ مُّسَنَّدَةٌ يَحْسَبُونَ كُلَّ صَيْحَةٍ عَلَيْهِمْ
هُمُ الْعَدُوُّ فَاحْذَرْهُمْ قَاتَلَهُمُ اللَّهُ أَنَّى يُؤْفَكُونَ

Тэднийг харвал, төрх нь таалагдана. Тэд яривал үгийг нь сонсоно. Харин тэд бараг хувцасны өлгүүр мэт болжээ. Бүх шуугианыг өөрсдийгөө дэмжигч гэж бодно. Чиний дайсан нь тэд юм; тэднээс болгоомжил! Аллах тэдний амийг аваасай! Тэд яаж үнэнээс **зайлж чадах вэ?**

وَإِذَا قِيلَ لَهُمْ تَعَالَوْا يَسْتَغْفِرْ لَكُمْ رَسُولُ اللَّهِ لَوَّوْا رُؤُوسَهُمْ
وَرَأَيْتَهُمْ يَصُدُّونَ وَهُم مُّسْتَكْبِرُونَ. سَوَاء عَلَيْهِمْ أَسْتَغْفَرْتَ لَهُمْ أَمْ
لَمْ تَسْتَغْفِرْ لَهُمْ لَن يَغْفِرَ اللَّهُ لَهُمْ إِنَّ اللَّهَ لَا يَهْدِي الْقَوْمَ الْفَاسِقِينَ

Тэдэнд «Ирээрэй, Аллахын Элч таны төлөө өршөөл гуйг!» гэхлээр тэд нүүрээ эргүүлж харна харин чи тэдний байдлаас ямар их их зан гаргаж байгааг мэдэрнэ! Тэдний төлөө өршөөл гуйсан ч гуйгаагүй ч адил юм. Аллах тэднийг хэзээ ч өршөөхгүй. Учир нь Аллах санаатай замаа төөрсөн олныг авралдаа багтаахгүй.

هُمُ الَّذِينَ يَقُولُونَ لَا تُنفِقُوا عَلَى مَنْ عِندَ رَسُولِ اللَّهِ حَتَّى يَنفَضُّوا
وَلِلَّهِ خَزَائِنُ السَّمَاوَاتِ وَالْأَرْضِ وَلَكِنَّ الْمُنَافِقِينَ لَا يَفْقَهُونَ.
يَقُولُونَ لَئِن رَّجَعْنَا إِلَى الْمَدِينَةِ لَيُخْرِجَنَّ الْأَعَزُّ مِنْهَا الْأَذَلَّ وَلِلَّهِ
الْعِزَّةُ وَلِرَسُولِهِ وَلِلْمُؤْمِنِينَ وَلَكِنَّ الْمُنَافِقِينَ لَا يَعْلَمُونَ

Тэд «Расулаллахын дэргэд байгаа хэнд ч юм битгий зарцуул, тэд тарж явцгаана!» гэгчид юм. Гэтэл тэнгэрүүд ба газрын баялаг сангууд нь Аллахынх юм. Харин мүнафикчууд үүнийг ойлгохгүй. Тэд «Тангараглая, хэрвээ Мадинад буцвал, давуу нь хүчгүйг тэднээс заавал гаргах болно» гэж байцгаав. Харин жинхэнэ давуу тал нь, зөвхөн Аллахын, Элчийн хамт зөв зам дээрх **итгэгчдийнх юм. Гэтэл мүнафикчууд үүнийг мэддэггүй.”** (эл-Мүнафикун, 1-8)

Мүнафикун Сураг буухад Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Зэйд бин Эркамыг дуудаж энэ аетуудыг уншаад:

“–Зэйд ээ! Аллах Таала чамайг нотлов!” хэмээв. (Бухарий, Тэфсир, 63/1-2; Мүслим, Сифату’л-Мүнафикийн, 1)

Дараа ч Зэйдийн чихийг барин:

“–Энэ нь Аллахын замд үүргээ чихээрээ хийсэн залуу мөн,” хэмээв. (Ибн-и Хишам, III, 336)

Сонин нь, мүнафикчуудын тэргүүн Абдуллах бин Үбэйгийн Абдуллах гэгч нэгэн хүү байсан бөгөөд тэр нь чин үнэн нэгэн итгэгч байв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д ч хэтэрхий үнэнч байв. Тэр аавынхаа хийсэн үйлсэд ихээр санаа зовдог, тэсч чаддаггүй байв. Сүүлийн хэрэг ч сэтгэл дэх энэ зовлонг бүр нэмсэн тул Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- дээр ирээд:

“–Аяа Аллахын Элч ээ! Хэрэв хүсвэл, би аавыгаа алъя!” гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- үүнийг зөвшөөрөөгүй:

"–Үгүй! Эсрэгээр нь зөөлхнөөр хандаарай. Түүнийг бидний дунд байх хугацаанд сайхнаар харилцаарай!" хэмээв. Тэгэхлээр нь Абдуллах, Исламын цэргийн дунд байсан аавынхаа дэргэд гүйж, тэмээний ногтыг нь бариад чанга дуугаар:

"–Хүч ба мэдэл Аллах ба Элчид байдгийг зөвшөөрөх хүртэл чамайг хөдөлгөхгүй!.."

Мүнафикчуудын тэргүүн сандрав. Ийм олон хүний дунд хүүгийнхээ ийнхүү авирлахыг доромжлох мэтээр санаж шингээж ядан:

"–Чи одоо ийм олон хүний дунд намайг Мадина руу орхихгүй юу?" гэв.

Хүү нь үнэн сэтгэлийн агуу итгэл хүчтэй байдлаар:

"–Тийм ээ, өнөөдөр хүмүүсийн дундаас хамгийн дорой ба хамгийн хүндэт хэн гэдгийг ойлготол чамайг орхихгүй. Үнэнийг хэлэхгүй бол чиний толгойг би цавчина..." гэв.

Мүнафик эцгийн гар бараг хөдлөхгүй хүлүүлсэн мэт болов. Хүүгийнхээ хэлснээс нэгэн чухал буйг ухаарангаа жихүүцэх мэт болов. Ингээд өмнө хэлснээ буцааж аваад, хүсээгүй байсан ч үнэнийг илэрхийлэн:

"–Хүндлэл ба мэдэл Аллахад, Элчид нь итгэгчдэд харъяалсныг би гэрчилнэ," гэхээс аргагүй болов.

Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам- нь Абдуллахад:

"Аллах чамайг Элчээсээ болон итгэгчд буянаар шагнах болтугай!" гээд залбираад, аавынхаа замыг нээхийг тушаав. (Ибн-и Хишам, III, 334-337; Ибн-и Са'д, II, 65; Хэйсэмий, IX, 317-318; Зэмахшэрий, VI, 117)

Сахаба-и кирам нь Орчлонгуудын Эзэн Хазрат-и Мухаммед Мустафад, Түүний биед биш, ширхэг үсэнд нь ч аюул хүрэхэд тун дургүй байх чинээ хайртай байцгаав. Хэн нэгний Түүнд нүд үзүүрлэн харах эсвэл хүндлэлгүй хандсан нь тэднийг галзууруулдаг, тэр хүн тэдний аав байсан ч түүнийг нүд ирмэлгүй алахыг ч бодож чаддаг байцгаав.

Тэвчээрийн Цаанах Төвөг ба Зовлон Дээр Зовлон: ХЭНДЭК ГАЗВА (5 оны Шэввал-Зилкадэ / 627 оны 3 сар)

Хэндэк буюу Шуудууны Дайн нь мүшрикчүүдийн мусульманчуудад зарласан хамгийн аймшигтай ба хэцүү нэгэн дайн юм. Энэ дайныг мусульманчууд болон Мадинагийн Ислам Гүрнийг түүхээс арчихаар өдөөсөн юм.

Цөллөгдсөн Бэний Надир еврейчүүдээс зарим тэргүүлэгчид нь Хайбарт хоргодсон байв. Мусульманчуудаас өшөөгөө авах галаар шатсаар байцгаав. Курайшчуудад хамтран ажиллахыг санал болгоцгоов. Түүнчлэн, тэдний баримал шүтээнийг Исламаас давуу байсныг хэлээд баримлалд мөргөж залбирцгаав. Тэгэхэд нь Аллах Таала ингэж айлдав:

أَلَمْ تَرَ إِلَى الَّذِينَ أُوتُواْ نَصِيبًا مِّنَ الْكِتَابِ يُؤْمِنُونَ بِالْجِبْتِ وَالطَّاغُوتِ وَيَقُولُونَ لِلَّذِينَ كَفَرُواْ هَؤُلاء أَهْدَى مِنَ الَّذِينَ آمَنُواْ سَبِيلاً. أُوْلَـئِكَ الَّذِينَ لَعَنَهُمُ اللّهُ وَمَن يَلْعَنِ اللّهُ فَلَن تَجِدَ لَهُ نَصِيرًا

“Номоос хувь олгосон хүмүүсийг хараагүй юү? Баримал ба зурагт итгэж, дараа нь кафирчуудын тухай «Эд нар Аллахад итгэн үнэмшигсдээс илүү зөв зам юм,» гэцгээнэ. Эд нар Аллахын хараал хүрсэн хүмүүс мөн. Аллахын энэрлээс холдсон хүнд жинхэнэ туслагч олддоггүй.” (эн-Ниса, 51-52)[183]

Мүшрикчүүд угаасаа ийм завшаан хүлээж байсан тулдаа шууд хөдлөв. Мусульманчуудын Ухудын Дайнд үнэн ялалтад хүрээгүй бусад Араб аймгуудыг ашиглан олон холбоот аймаг Курайшчууд, түм гаран цэрэг цуглуулж чадав.[184]

Энэ тухай мэдээ авсан Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- асхабтайгаа зөвлөлцөв. Тэд Аллахыг эсэргүүцээгүй, Аллахын замд тохиолдох төвгийг тэвчвэл тэнгэрлэг тусламж хүрэхийг амлав. Аллах болон Элчид нь бууж өгөхийг тушаав.

Аллах Таала нь Пайгамбар Эзэнд маань шуудуу ухах санаа төрүүлэв. Тэгээд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- асхабаасаа Мадинагаас гараад байдлыг эсвэл хамгаалахаар хотын эргэн тойронд шуудуу малтахыг илүүд үздэгийн тухай асуув. Сэлман-и Фарисий -радъяллахү анх-:

“–Аяа Расулаллах аа! Бид ч Фарс нутагт дайсны морьтдын дайралтаас айсан үед эргэн тойрноо шуудуугаар хүрээлдэг байлаа,” гэв.

Сэлман -радъяллахү анх-ын Пайгамбар Эзний маань сана-аг дэмжсэн энэ үг нь мусульманчуудад таалагдав.[185]

Асхаб-и кирам нь бас Аллахын Элчийн Ухудын Дайнд хотоос гаралгүй Мадинад хамгаалалт хиймээр байсныг санасан

183. Хар. Вахидий, х. 160.

184. Хар. Вакидий, II, 444; Ибн-и Са’д, II, 66.

185. Ибн-и Хишам, III, 231; Вакидий, II, 445.

байв. Ингээд Мадинагийн эргэн тойронд шуудуу малтахаар шийдвэр гарав.

Мадина нь зөвхөн нэг талаас нээлттэй ба аюултай байв. Бусад тал нь бол янз бүрийн байшингаар бараг хэрэм шиг хүрээлсэн байв. Мөн хасарвааны өтгөн модоор хүрээлсэн нэвтрэх аргагүй байв. Расулаллах -алэйхиссалатү вэссэлам- шуудууг дайсанд нээлттэй талд малтахыг шийдэв. Шэйхайны Хэрмээс Мэзад гэсэн газар хүртэл нэгэн зураас татаад арван хүн бүрт *"Эндээс энд хүртэл,"* гэж заагаад шуудуу малтах тодорхой хэсэг ялгав.[186]

Шуудуу малтах ажилд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч өөрөө ажиллав. Түүнчлэн хүнсний ховор болсон тул, ариун хэвлийдээ чулуу уяхаас аргагүй болов.[187] Харин Пайгамбарчуудын Хаан Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- ийм тохиолдолд ч Рабдаа шүкүр хийхээ мартахгүй байв.

Бэра бин Азиб -радъяллахү анх- ярина:

"Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Ахзаб өдөр[188] бидэнтэй хөрс зөөхөд би харлаа. Тэр хооронд Абдуллах бин Рэвахагийн шүлгийг дуулж байв:

اَللّٰهُمَّ لَوْلاَ اَنْتَ مَا اهْتَدَيْنَا

وَلاَ تَصَدَّقْنَا وَلاَ صَلَّيْنَا

فَأَنْزِلَنْ سَكِينَةً عَلَيْنَا

186. Табэрий, *Тарих,* II, 568; Диярбэкрий, I, 482.

187. Бухарий, Мэгазий, 29.

188. Хэндэк дайнд элдэв аймгууд мусульманчуудын эсрэг цугласан тул уг дайныг Ахзаб гэсэн нэр ч олгосон байдаг.

وَثَبِّتِ الْأَقْدَامَ إِنْ لاَقَيْنَا

إِنَّ الْأُلٰى قَدْ بَغَوْا عَلَيْنَا

وَإِنْ أَرَادُوا فِتْنَةً اَبَيْنَا

«Аллах минь, Та биднийгээ авралдаа багтаагаач бидний байдал хүнд хэцүү байгаа учраас өргөл өргөж, мөргөл үйлдэж чадахгүй байна. Аяа Аллах минь, дайсантай нүүр тулах үед бидэнд итгэл хайрла, бидний бат зогсох чадвар хайрла. Тэд дайрна. Хармн та бидэнд зориг хүч хайрла. Бид ялна.»

Шүлгийн сүүл дэх «эбэйна: зугтахгүй, тулна» хэсгийг уншихдаа ч дуугаа ихэсгэдэг байд." (Бухарий, Мэгазий, 29)

Асхаб-и кирам нь бэрхшээлд санаа зовнин хоол ч идэхээ болив. Энэс -радъяллахү анх- энэ байлдыг ингэж илэрхийлжээ:

"Сахабийчууд идэг гэж нэгэн атга арвай ирнэ; түүнийг амт ба үнэр орсон тоосонд хуураад өмнө нь тавьдаг байв. Хүн бүр нь өлсч байсан ч уг тосны хатуу ба муухай амтыг амандаа мэдэрдэг байв. Хоол хүнд ба тааламжгүй үнэртэй байв." (Бухарий, Мэгазий, 29)

Бага томгүй хамаг мусульманчууд шуудуу малтахад ажиллаж байв. Арван тав орчим насны хүүхэд байсан Зэйд бин Сабит -радъяллахү анх- нь хэсэгхэн нойрсож эхэлсэн байв. Мусульманчууд түүнийг шуудууны дэргэд унтаж байхад нь үлдээж явсан байв. Хажууд нь очсон Умарэ бин Хазм -радъяллахү анх- тоглоомоор түүний зэвсгийг аваад нуув. Зэйд сэрээд зэвсгээ олоогүйдээ сандран айв. Пайгамбар Эзэн маань

-саллаллахү алэйхи вэ сэллэм- үүнийг сонсохдоо Зэйдийг дуулгаад түүнд:

"–Ээ унтагч аа! Чи унтаад чиний зэвсэг ч алга болж явав!" хэмээсний дараа:

"–Энэ хүүхдийн зэвсэг хаана буйг мэдсэн нь бий юү?" хэмээн асуув.

Умарэ -радъяллахү анх-:

"–Аяа Расулаллах аа, би мэднэ, зэвсэг нь надад," гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Зэвсгийг нь түүнд гардуулж өг!" хэмээн айлдаж, тоглохоор байсан ч мусульманчуудыг айлгах ба тэдний ямар нэгэн барааг аваад нуухыг хориглов. (Вакидий, II, 448)

Шуудуунд Сонссон Сайхан Мэдээ

Энэ хооронд Асхаб-и кирам нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д маш том ба хатуу нэгэн хадтай тааралдаад буталж чадаагүйгээ мэдүүлэв. Орчлонгуудын Эзэн нь хүнд лануугаар бэсмэлэг хэлж хаданд гурван удаа цохив. Түүнийг элч шиг тараав.[189] Мөн цохих бүртээ итгэгчдэд том сайхан мэдээ хэлээд өгөв. Анхны цохихдоо Дамаскын (Бизанс), хоёр дахид Ираны, гурав дахь цохихдоо ч Йемений түлхүүр өөртөө гардуулсныг, эдгээр орнуудын хааны ордныг буй газраасаа харсныг илэрхийлэв. Энэ газруудын Аллахын үгийн нэр хүнд олоод мэдээлэн, ирээдүйн ялалтын бишрэлээр итгэгчдийн сэтгэлд найдвар төрөв.[190] Ойрын үед мухар сүсгийг заавал устга-

189. Бухарий, Мэгазий, 29.

190. Хар. Ахмад, IV, 303; Ибн-и Са'д, IV, 83, 84.

хыг мэдээлэн, болохгүй гэж боддог маш олон үйлийг болгохоор түгээмэл авралын замын зургийг зурав.

Оршигчдын Туяа Эзэн маань Хосровын Тэдаин дахь цагаан ордныг тайлбарлахад, Сэлман-и Фарисий -радъяллахү анх-:

“–Зөв айлдлаа! Чамайг үнэн шашин ба номоор илгээсэн Аллахад тангараг өргөе, тэр нь яг чиний тайлбарласан шиг юм! Чиний Расулаллах буйг (дахиад) гэрчлэе!” гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Сэлман аа! Аллах эдгээр ялалтуудыг миний дараа танд хайрлах болно! Дамаск заавал эзлэгдэнэ! Эракли нутгийнхаа хамгийн хол цэг хүртэл зугтана! Та хамаг Дамаскын эзэн болно! Хан ч таныг эсэргүүцэж чадахгүй. Йеменийг заавал эзэлж авна! Дараа нь Хосровыг ална!” хэмээв.

Эхэ тухай Сэлман -радъяллахү анх-:

“–Би эдгээр бүхний хэрэгжсэнийг харлаа!” гэсэн байдаг. (Вакидий, II, 450)

Эдгээр газрууд нэг нэгээр эзлэгдэх тусамд Эбү Хүрэйрэ -радъяллахү анх- ч:

“–Эдгээр ялалт тань таны хувьд зөвхөн эхлэлт юм! Эбү Хүрэйрэгийн оршигчийг хүчит гараараа барьсан Аллахад тангараг өргөе, таны эзэлсэн ба киямат хүртэл эзлэх хот бүрийн түлхүүрийг Аллах Таала нь Мухаммед -алэйхиссалатү вэссэлам-д өмнө нь өгсөн байв!” гэдэг байлаа. (Ибн-и Хишам, III, 235)

Аллахын Элчийн ийм сайхан мэдээлэл нь мусульманчуудын бэрхшээлийг даван туулахад сэтгэл санааны маш их дэмжлэг түшиг болов. Үр дүн нь ялалт итгэгчдийн талд, Исламын дайсны эсрэг болох нь урьдчилан мэдэгдсэн нь итгэл

үнэмшилтэйгээр тэмцэх тэсвэр тэвчээрийг ихэсгэв. Учир нь, Шуудуу нь төвөг, зовлон, ядаргаа, өлсгөлөн, хүйтэн ба харанхуйн эсрэг хийсэн байлдаан байсны улмаас дийлшгүй нэгэн байдал байв. Мөн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"Аллах минь! Амьдралын үнэтэй нь зөвхөн ахиратын амьдрал мөн. Энсар болон Мухажирт тусалж хайрлагтун!.." (Бухарий, Мэгазий, 29) хэмээн гуйн, энэ насны хамаг зовлон ядаргаа, үүрд мөнхийн жаргалаар дүүрэн амьдралтай зүйрлэвэл огт үнэгүй гэдгийг илэрхийлэн, асхабтаа ахиратыг зорилго болгохыг зааж байв.

Хазрат-и Жабирын Элбэг Хоол

Хазрат-и Жабир -радъяллахү анх- ингэж ярина:

Бид Шуудууны Дайны үед хамгаалалт малтаад байв. Бидний өмнө хэт хатуу нэгэн хад гарч илрэв. Сахабийчууд Нэбий -саллаллахү алэйхи вэ сэллэм-д очоод:

"–Бидний малтаж байсан шуудуунд хатуу нэгэн хад гарав," гэцгээв.

Хүндэт Элч Эзэн маань:

"–Би шуудуунд бууна," хэмээн, дараа нь боссон, өлссөнөөсөө хэвлийдээ чулуу уясан байв. Бид юу ч амсалгүй тэнд гурван хоносон байлаа. Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- жоотууг гардаад хатуу хадыг цохиж, тэр хад нь бүр бутарч элсэн овоогоор эргэв. Би:

"–Аяа Расулаллах! Би гэртээ очоод ирье, зөвшөөрөөч!" гэлээ. Гэртээ очоод эхнэртээ:

“–Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг хараад сэтгэл тэвчихгүй байна байдалд харлаа, идэх юм бий юү?” гэж асуулаа. Манай эхнэр:

“–Жаахан арвай, бас нэгэн ишиг бий,” гэв.

Ишгийг төхөөрч, арвайг ч нүдлээ. Махыг тогоонд хийв. Талх болоод тогоо ч чулуун дээр буцалж байхад Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд очоод:

“–Аяа Аллахын Элч ээ! Надад жаахан хоол бий, хэдэн хүний хамт манайд хүрээд ирэгтүн,” гэлээ.

Хүндэт Элч Эзэн маань:

“–Хол нь хэр чинээ вэ?” хэмээн асуув. Би ч хэмжээг нь хэллээ. Тэгэхэд минь:

“–Их ч бас сайхан ч байна. Эхнэртээ хэлчих, намайг иртэл тогоог гал дээрээс битгий буулгаг, талхыг ч шарах шүүгээнээс битгий гаргаг!” хэмээн айлдав. Дараа нь асхабтаа:

“–Шуудууны хүмүүс! Жабир бидэнд баяр бэлтгэжээ, бүгдээрээ ирээрэй!” хэмээн чанга дуугаараа дуудав. Тэндэхийн бүгдээрээ босов. Би сандран эхнэрийн дэргэд гүйгээд:

“–Бидэнд хайран юм аа! Пайгамбар маань Мухажир ба Энсарыг дагуулан ирж байна,” гэлээ.

Манай эхнэр бол:

“–Аллахын Элч чамаас бидэнд хэр чинээ хоол буйг асуув уу?” гэв.

Би:

“–Тийм” гэсэн. Тэгэхэд:

“–Тэгвэл битгий сандраад бай, Тэр чамаас сайн мэддэг,” гэв.

Хэсэг хугацааны дараа тэднийг ирэхэд, Хүндэт Элч Эзэн маань сахабийчуудад:

“–Яаралгүйгээр, өргөн ороорой!” хэмээв. Тэд арав арваар оров. Манай Эзэн талхыг тасалж, дээр нь мах тавиад, удаа бүрт нь тогоо ба шарах шүүгээг хааж, авсан хэсгийг асхабтаа өгч байв. Дараа нь дахиад нэгийг хийж байв. Ирэгсэд нь мянгуулаа байв. Тэндэх бүхийг цадтал, үргэлж талхыг тасалж дээр нь мах тавив. Эцэст нь хэсэг хоол ч үлдэв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь миний эхнэрт хандан:

“–Үүнийг идээд хөршүүдтээ ч дайл, учир нь өлсөлөн хүмүүсийг сандааж хаяв!” хэмээв. (Бухарий, Мэгазий, 29; Мүслим, Эшрибэ, 141; Вакидий, II, 452)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ил нэгэн гайхамшиг буйгаар хэдхэн хүний хоолоор -Аллахын зөвшөөрснөөр- мянга нь цадсан, түүнээс илүүгээр нь хөршүүдээ дайлсан билээ.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- олсон хамаг барааг Аллахын замд зарцуулсан тул, гартаа их бараа үгүй байв. Хэрэгцээт буйдаа үүнийг асхабаасаа нуудаг, хэнд ч ачаа болмооргүй байв. Гэтэл Асхаб-и кирам нь Орчлонгуудын Эзний байдалд хэт их анхаардаг, ямар нэгэн хэрэгцээт байсныг мэдрэнгүүтээ шууд тухайн юмыг хангахыг хичээдэг байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн өлссөнөөсөө дуу нь хүчгүй гарсныг мэдрэхдээ, шууд гэртээ очоод идэх юм юу байвал даруй Түүнд аваачиж дайлдаг байв.[191] Хүндэт Элч Эзний маань зүс царайг цонхийсныг харвал идэх юм олохыг

191. Хар. Бухарий, Эт’имэ, 6; Мүслим, Эшрибэ, 142.

хичээдэг, олж чадахгүй бол, тэмээ услах төлбөр байсан ч хэдхэн хасарваан олоод Түүнд авчирдаг байв.

Нэгэн өдөр Орчлонгийн Хүндэт Эзэн маань асхабынхаа дэргэд гараад ирсэн байв. Энсараас нэгэнтэй тааралдав. Тэр хүн:

"–Аяа Расулаллах аа! Аав ээж минь Чамд золиос болог, таны царайг ийм байхыг харах маш хэцүү байна. Юу болсон бэ?" гэв.

Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- тэр хүний нүүр лүү харснаа:

"–Өлсөөд" хэмээн айлдав. Сахабий нь шууд гарч, гүйгээд гэртээ очоод идэх юм хайж, харин олж чадсангүй. Шууд Бэний Курайза дээр очив. Худгаас татаж асван ховооны ус бүрийн хариугаар нэгэн хасарваан авахаар тохиров. Нэгэн алган хасарвааныг цуглуулахдаа тэднийг аваад Хүндэт Нэбий -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн онгонд гарав. Пайгамбар Эзэн маань тэр газар байв. Сахабий нь:

"–Аяа Аллахын Элч ээ, үүнийг идээрэй!" гэв.

Орчлонгуудын Эзэн хасарваан хаанаас авсныг асууж, тэр ч яаж олсноо ярив. Тэгэхлээр нь Хазрат-и Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-:

"–Миний бодлоор чи Аллах ба Элчид нь хайртай!" хэмээв.

Тэр хүн:

"–Тийм, Чамайг үнэнээр илгээсэн Аллахад тангараг өргөе, би Чамд аминаасаа, хүүхдүүдээсээ, гэр бүлээсээ ба эд хөрөнгөнөөсөө илүү хайртай," гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

"– Ядуу байдалдаа битгий санаа зов, тэвчээртэй бай, энэ бэрхшээлийг даван туулахад өөрийгөө бэлд! Намайг үнэнээр илгээсэн Аллахад тангараг өргөсөн хүнд эдгээр зовлон юу ч биш, ус давааны уруу урсах мэт хөнгөн байх болно. (Хэйсэмий, X, 313; Зэхэбий, *Сиер,* III, 54; Ибн-и Хажар, *эл-Исаба,* III, 298)

Шуудуунд туулсан зовлон

Өвөл болоход, мүшрикчүүд Мадинаг бүсэлсэн байв. Харин тэдний хошуулагчид шуудуунд тулан гайхаж улмаар Мадинад орж чадаагүй.

Мүшрикчүүдийг ирээд хуарангаа барихад, Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Мадинад Ибн-и Мэктүмийг төлөөлөгчөөр үлдээж Исламын гурван мянган мүжахидын хамт шууд Хэндэк рүү хөдлөв. Сэл' Уулын хойноо аваад хуарангаа уулны хормойд барив. Хойно үлдсэн хүүхэд ба эмэгтэйчүүдийг цайзад оруулахыг тушаав.[192] Арван тав хүрээгүй хүүхдүүдийг цайз буюу гэр бүлийнх нь дэргэд илгээв. Арван тав хүрсэн Ибн-и Умар, Зэйд бин Сабит ба Бэра бин Азиб мэтийн сахабийчуудад бол зөвшөөрөл олгов.[193]

Энэ хооронд Бэний Курайзагийн еврейчүүд ч бослого гарган Расулаллахтай хийсэн гэрээгээ эвдэв. Энэ нь тэдний хувьд хоёр дахь удаа хэлсэндээ хүрээгүй том урвалт байв. мусульманчууд хоёр галын хооронд үлдэв. Еврейчүүд нь мүшрикчүүдийн тэргүүн Эбү Сүфьяанд элч илгээж:

192. Ибн-и Хишам, III, 235.

193. Вакидий, II, 453.

“–Та нар тэвчээрэй! Бид мусульманчуудыг хойноос нь дайрна, тэднийг арчиж хаяна!” гэцгээв.[194]

Энэ урвалт нь Аллахын Элчид маш хэцүү санагдав. Гэтэл Тэр, байнга Аллахад итгэсэн ба бууж өгсөн байв. ийм учраас ийнхүү хэцүү байдалдаа ч:

“Хасбүналлах вэ ни’мэ’л-мэкил: Аллах бидэнд хүртээлтэй! Тэрээр маш гоё Төлөөлөгч мөн” хэмээв. (Вакидий, II, 457; Ибн-и Са’д, II, 67)

Дараа ч:

“–Бидэнд Бэний Курайзагаас мэдээ авчрах хэн нэгэн хүн байна уу?” хэмээн асуув.

Зүбэйр бин Аввам -радъяллаху анх-:

“–Би байна аяа Расулаллах!” гээд явав.

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- нь байдлыг хүндэрч маш аюултай болохлоор нь еврейчүүд үүнийг мэдэхгүйн тулд Хазрат-и Зүбэйрийг дахиад хэдэн удаа илгээв. Зүбэйр -радъяллаху анх-ын уг үйлчилгээнээс мэдэрсэн сэтгэлийн ханамжаа ч:

“–Пайгамбар бүр нь нэгэн хаварийтай байдаг. Миний хаварий бол Зүбэйр мөн!” хэмээж илэрхийлэв. (Ахмад, III, 314)

Дараа нь Пайгамбар Эзэн маань еврейчүүд рүү хэд хэдэн хүн илгээв. Илгээсэн хүмүүст ч ингэж захив:

“–Очоод хараарай! Бидэнд ирсэн мэдээлэл зөв үү, үгүй юу? Хэрэв зөв байвал надад нууцаар мэдүүлээрэй. Ил хэлээд хүмүүсийг айлгаж, итгэл найдвараа алдахад хүргэж болохгүй.

194. Абдуррэззак, V, 368.

Хэрэв тэд бидний хоорондын гэрээнд үнэнч байвал, үүнийг хүмүүст зарлаж болно!" хэмээв.

Элч нар Бэний Курайза дээр очоод өмнө дуулснаасаа ч эвгүй байдалд олов. (Ибн-и Хишам, III, 237)

Пайгамбар Эзэн маань дайралтаас Мадинаг хамгаалахаар Сэлэмэ бин Эслэм -радъяллахү анх-ын хоёр зуу, Зэйд -радъяллахү анх-ыг ч гурван зуун хүний хүчээр хүлээв. Тэд Мадинад хүлээж, чанга дуугаар тэкбир хэлээд Маднагийн гудамжаар явж байцгаав.[195]

Бэний Курайза еврейчүүд дайрахгүйгээр өглөө болбол итгэгчид амар тайван амьсгаа авдаг байв. Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх-:

"Мадинад хүүхдүүдийнхээ төлөө Бэний Курайзагаас мэдэрсэн айдас маань, бидний Курайш ба Гатафаныхнаас мэдэрсэн айдаснаас том байв. заримдаа Сэл' Уулан дээр гараад Мадинагийн гэрүүдийн харж, тэднийг амар тайван харахаар Аллахад хамд ба талархлаа илэрхийлдэг байлаа!" гэсэн байдаг. (Вакидий, II, 460)

Үммү Сэлэмэ эх маань ч ингэж хэлсэн байдаг:

"Би Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд тулалдаан ба айдас мэдэрсэн Мүрэйсий, Хайбар, Хүдэйбие, Маккагийн ялалт, Хүнэйн мэтийн олон дайнд оролцсон. Эдгээрээс алин ч Расулаллахын хувьд Хэндэзээс төвөгтэй ба аймшигтай болоогүй байв. бэний Курайзагийнхан довтлохгүй гэх баталгаа байхгүй байлаа " (Вакидий, II, 467)

195. Ибн-и Са'д, II, 67.

Нөгөө талаас Хэндэкийн хавьд мүшрикчүүд удаа дараа дайралт хийж, шөнө орой болтол ширүүн байлдаан үргэлжилж, заримдаа Аллахын Элчийн майханд ч сум тусч байв.

Мүшрикчүүд нэгэн өдөр Аллахын Элч байсан газар луу хамаг хүчээрээ дайралт хийв. Тэр өдөр Пайгамбар маань ч, Асхаб-и кирам ч мөргөлөө үйлдэх завшаан олж чадаагүй. Үдэш болж цэрэг нь ухарвал, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хазрат-и Билалд эзан уншихыг тушаав. Удаа бүрийн төлөө камэт уншаад , орой ба үдшийн мөргөлийг каза хийлгэв.[196] Үүнд маш их санаа зовсон Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь “миний нүдний туяа” хэмээн дурдсан мөргөлөөс холдуулсан мүшрикчүүдийн тухай:

“Тэд биднийг нар жаргатал яаж зав чөлөө өгөхгүй мөргөлөөс саатуулсан шиг, Аллах ч тэдний гэрийг, гэдсийг, булшийг галаар дүүргэг!” хэмээн хараав. (Бухарий, Мэгазий, 29; Ибн-и Са’д, II, 68-69; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* IV, 112)

196. Энэ нь цагтаа үйлдээгүй мөргөлийг каза хийж болохын баталгаа болов.

Шуудуунд байгуулсан баатарлаг гавьяа

Том багагүй хүн бүр дайнд үүрэг хүлээсэн, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- шуудууны нарийн нэгэн хэсэгт өөрөө манаж байв.[197]

Үммү Сэлэмэ -радъяллахү анха- эх маань ингэж хэлдэг:

“Би Хэндэкэд Расулаллахын хамт байлаа. Тэнд ба Түүний очсон өөр газар Түүнээс огт салаагүй. Аллахын Элч шуудууг өөрөө манаж байв. Тэнд үнэхээр ширүүн хүйтэн буув. Би Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг харж байлаа. Тэр мөргөл үйлдэж байв. Дараа нь очоод тэр хараад:

«–Тэд мүшрик морьтод бололтой, шуудуугаар явж байна! Тэднийг хэн угтах вэ?» хэмээв. Дараа нь:

«–Аббад бин Бишр ээ!» хэмээн дуудав. Аббад -радъяллахү анх-:

«–Лэббэйк: Айлдаарай аяа Расулаллах!» гэв.

Хүндэт Элч Эзэн маань түүнээс:

«–Чиний дэргэд хэн нэгэн бий юү?» хэмээн асуув.

Аббад -радъяллахү анх-:

«–Тийм! Би болон таны асхабаас зарим нь таны майхны эргэн тойронд байна!» гэв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Найз нарынхаа хамт шуудуу даган яваарай! Энэ харагдсан морьтод нь дайснууд бололтой, таныг хайж байна,

197. Вакидий, II, 463-464.

таны анхааралгүй завшааныг ашиглан гэнэтийн дайралт хийгээд заримыг алахаар найдаж байгаа хэрэг!» хэмээгээд:

«Аяа Аллах минь ээ! Тэдний хорт муухайг биднээс холдуул! Тэдний эсрэг бидэнд тусалж биднийг ялуулаач! Биднийг ялагч болгох Чамаас өөр хэн ч үгүй!» хэмээн залбирав.

Аббад бин Бишр -радъяллахү анх- найз нарынхаа хамт явав. Тэр хооронд мүшрикчүүдийн тэргүүн Эбү Сүфьяан нь морьтодын нэгэн ангийн шуудууны нарийн хэсгээр явж байв. мусульманчууд амжиж тэдэн рүү чулуу ба сум харвав. Би ч тэдний хамт зогсоод, мүшрик морьтдод чулуу ба сум харавлаа. Эцэст нь тэднийг ядраалаа. Намайг Расулаллахын дэргэд харихад, Тэр мөргөж байв… Аллах нь Аббад бин Бишрт рахмэтаа буулга! Тэр нь байнга Аллахын Элчийн майхныг манасан асхаб байв.” (Вакидий, II, 464)

Аллахын Элчийн авга эгч Хазрат-и Сафийя нь энэ хооронд эмэгтэй ба хүүхдүүдийн хамт Хассан бин Сабитын Фарий гэгч ордонд нь байв. Еврейчүүдээс арван хүний нэгэн анги ирээд ордонд сум харваж дотогш орохыг хичээцгээв. Тэднээс нэг нь ордныг тойрч, нээлттэй газар хайж байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ба асхаб нь бол энэ хооронд Шуудуунд дайсантай байлдаж байв.

Хазрат-и Сафийя -радъяллахү анха- нь аргагүй энэ төвгийг зайлуулах өөрөөс нь гадна хэн ч байгаагүйг хараад, толгойгоо өргөн нэгэн алчуураар бат уяад, нэгэн урт саваа бариад ордноос буув. Хаалгаа нээж тэнд тойрсон еврейн араас чимээгүйгээр дөхөв. Барьсан саваагаар толгойг нь цохиод түүнийг алав. Нэгийгээ үхсэнийг харсан еврейчүүдийн сэтгэлд аймшиг төрөөд:

“–Бидэнд эндэх эмэгтэйчүүдийг хамгаалалтгүй гэсэн үгүй байна” гээд тарж явцгаав. (Хэйсэмий, VI, 133-134; Вакидий, II, 462)

Хазрат-и Аиша -радъяллахү анха- эх маань ч асхабын жихад чин хүсэлтэй байсны тухай гэрчийг ингэж илэрхийлэв:

“Хэндэкийн Дайны өдөр би хүмүүсийн араас дагав. Хойноосоо нэгэн дуу сонсов. Эргэд харвал Са’д бин Муаз ба дүүгийнх хүү Харисэ бин Эвсийг харлаа. Би байсан газар дээрээ суув. Са’д бариу нэгэн хуяг өмссөн, хоёр гар нь хуягаас гадагш гарсан байв. Жихадад оролцохыг урамшуулах ба цаг барахад үхэхийн ямар гоё буйг мэдүүлсэн нэгэн шүлэг уншиж байв. Ээж нь түүнд:

«–Хүү минь! Гүйгээд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д амж! Валлахи хоцорч байна шүү!» гэж байв.

Би Са’дын ээжид:

«–Би Са’дын хуяг түүний хуруу хүртэл нь хамаг биеийг нь дэвсэхийг нь хүсч байлаа,» гэлээ. Түүний чөлөөтэй гараар харвагдаж мэднэ гэж эмээсэн байлаа.

Са’дын ээж:

«–Аллах шийдвэрээ гүйцэтгэнэ!» гэв. Са’д тэр өдөр шархтав.” (Ахмад, VI, 141; Ибн-и Хишам, III, 244)

Са’д -радъяллахү анх- гарынхаа хүнд ба алагч буйг ойлгохлоороо:

“Аллах минь! Хэрэв Курайшийн мүшрикчүүдийн хамт дахиад нэгэн байлдахаар шийдсэн бол, намайг тэрэнд ч байлдуулахаар амьд үлдээх болтугай! Учир нь Элчид чинь харгислал ба муугаар хандсан, Түүнийг үгүйсгэсэн ба нутгаас нь гаргасан тэр Курайшийн ардтай байлдахаа хүссэн шигээ өөр ямар ч ардтай байлдахыг хүсэхгүй байна. Хэрэв бидний хоо-

рондын байлдаан нь ийм байвал, шархыг минь шэхид болохын арга болгож хайрла! Намайг онгондоо хүлээж авах болтугай! Курайзагийнхныг ялласныг харж баясах хүртэл амийг минь битгий ав!" гэж залбирав. (Вакидий, II, 525; Ибн-и Са'д, III, 423)

Са'д -радъяллаху анх- залбирлаа дуусгангуут нь цус нь тогтож, өөр нэгэн дусал ч гоожоогүй.[198]

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Са'д -радъяллаху анх-ад мэсжидэд нэгэн майхан бариулав. Зорилго нь түүнтэй ихээр уулзаж түүнтэй ойр байхын тулд байв.[199]

Гүн шуудууг зөвхөн хэдхэн мүшрик давж чадсан байв. Эд нараас нэгэн байсан Амр бин Абд нь хамаг Арабын хамгийн алдарт бөхийн нэгэн байв. Өөдөөс нь Хазрат-и Али -радъяллаху анх- гараад Аллахын зөвшөөрлөөр түүнийг алав. Бусдын хувь заяа ч тийм болов.

Дайн нь удаан үргэлжилж байв. итгэгчид маш хэцүү байдалд үлдэж, тэнгэрлэг тусламж нь хэзээ ирэхийг хүлээж эхэлцгээв. Энэ байдлыг Аллах Таала ает-и кэримэнүүддээ ингэж тайлбарлана:

إِذْ جَاؤُوكُم مِّن فَوْقِكُمْ وَمِنْ أَسْفَلَ مِنكُمْ وَإِذْ زَاغَتْ الْأَبْصَارُ وَبَلَغَتِ الْقُلُوبُ الْحَنَاجِرَ وَتَظُنُّونَ بِاللهِ الظُّنُونَا. هُنَالِكَ ابْتُلِيَ الْمُؤْمِنُونَ وَزُلْزِلُوا زِلْزَالًا شَدِيدًا

198. Тирмизий, Сиер, 29/1582; Ахмад, III, 350.

199. Бухарий, Мэгазий, 30.

“Тэд таны дээрээс ч доороос ч тал бүрээс чинь дайрахад айсандаа зүрх амаараа гарах шахаж Аллахын тухай янз янзын бодолд автсан байхад; тэнд итгэлт хүмүүсийг бид шалгаж ширүүн сэгсэрсэн байв.

وَإِذْ يَقُولُ الْمُنَافِقُونَ وَالَّذِينَ فِي قُلُوبِهِم مَّرَضٌ مَّا وَعَدَنَا اللّٰهُ وَرَسُولُهُ إِلَّا غُرُورًا وَإِذْ قَالَت طَّائِفَةٌ مِّنْهُمْ يَا أَهْلَ يَثْرِبَ لَا مُقَامَ لَكُمْ فَارْجِعُوا وَيَسْتَأْذِنُ فَرِيقٌ مِّنْهُمُ النَّبِيَّ يَقُولُونَ إِنَّ بُيُوتَنَا عَوْرَةٌ وَمَا هِيَ بِعَوْرَةٍ إِن يُرِيدُونَ إِلَّا فِرَارًا. وَلَوْ دُخِلَتْ عَلَيْهِم مِّنْ أَقْطَارِهَا ثُمَّ سُئِلُوا الْفِتْنَةَ لَآتَوْهَا وَمَا تَلَبَّثُوا بِهَا إِلَّا يَسِيرًا. وَلَقَدْ كَانُوا عَاهَدُوا اللَّهَ مِن قَبْلُ لَا يُوَلُّونَ الْأَدْبَارَ وَكَانَ عَهْدُ اللَّهِ مَسْؤُولًا. قُل لَّن يَنفَعَكُمُ الْفِرَارُ إِن فَرَرْتُم مِّنَ الْمَوْتِ أَوِ الْقَتْلِ وَإِذًا لَّا تُمَتَّعُونَ إِلَّا قَلِيلا

Тэгэхэд мүнафикчууд ба зүрхний хийтэй нэг нь; «–Тэгвэл Аллах ба Элч нь бидэнд худлаа юм амласан байна!» гэж байцгаав. Тэднээс хэсэг хүмүүс ч ингэж хэлсэн байв: «–Мадинагийнхан! **Одоо таны зогсох цаг биш, харьцгаа!» Тэдний хэсэг хүмүүс бол; «–Манай гэр үнэхээр аюулгүй биш!» гээд Пайгамбараас зөвшөөрөл эрдэг байв. харин тэдний гэр аюулд байгаагүй, зөвхөн тэд зугтахыг хүсдэг байв. Хэрэв фитнэ гаргахыг** (шашнаас халахыг) **хүссэнсэн бол, андууралгүй тэгэх байцгаав. Тангараг өргөе, тэд өмнө нь хойшоо эргэж зугтахгүйнхээ талаар Аллахад амласан байв.**

Аллахад өгсөн амлал нь хариуцлага шаардана! (Элч минь ээ!) **Ингэж хэл: «–Хэрэв үхэхээс эсвэл алагдахаас зугтаж байвал, зугтах нь танд ашиг ерөөсөө болохгүй!..»”** (эл-Ахзаб, 10-16)

وَلَمَّا رَأَى الْمُؤْمِنُونَ الْأَحْزَابَ قَالُوا هَذَا مَا وَعَدَنَا اللَّهُ وَرَسُولُهُ وَصَدَقَ اللَّهُ وَرَسُولُهُ وَمَا زَادَهُمْ إِلَّا إِيمَانًا وَتَسْلِيمًا

“Итгэгчид бол дайсны ангиудыг харахдаа; «–Энэ нь Аллах ба Элчинх нь бидэнд амласан нь! Аллах ба Элч нь зөв хэлжээ!» гэцгээв. Энэ (дайсан ирсэн) **нь тэдний итгэл үнэмшлийг л ихэсгэв.”** (эл-Ахзаб, 22)

Дайн нь Мэх юм

Ингээд итгэгчид нь хамаг хүчээрээ байлдав. Гатафан аймгийн тэргүүлэгчдээс мусульман болсон, харин өөрийгөө Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн *“Дайн нь Мэх юм,”* (Бухарий, Жихад, 157; Муслим, Жихад, 17) гэсэн зааварчилгааны дагуу далдалсан Нуайм -радъяллахү анх- нь мүшрикчүүдтэй Бэний Курайзагийн харьцааг эвдэж чадав. Мадинаг бүсэлсэн аймгуудын хагарал гарав. Хүн бүр нь нэг нэгээсээ эмээдэг байв. эцэст нь еврейчүүд Нуаймын мэхэд ханаад цайздаа харив. Талбайд дайсны талаас зөвхөн мүшрикчүүд үлдэв. Харин итгэгчид нь нэлээд хэцүү байдалд байцгаав. Пайгамбар Эзэн маань ба асхабынх нь мүшрикчүүдийн бүслэлт доор хүнд нэгэн шалгалт өгсөн ба бараг “зүрх амаар гартал айсан” энэ үед уг ает-и кэримэ буув:

أَمْ حَسِبْتُمْ أَن تَدْخُلُواْ الْجَنَّةَ وَلَمَّا يَأْتِكُم مَّثَلُ الَّذِينَ خَلَوْاْ مِن قَبْلِكُم مَّسَّتْهُمُ الْبَأْسَاء وَالضَّرَّاء وَزُلْزِلُواْ حَتَّى يَقُولَ الرَّسُولُ وَالَّذِينَ آمَنُواْ مَعَهُ مَتَى نَصْرُ اللّهِ أَلا إِنَّ نَصْرَ اللّهِ قَرِيبٌ

“Эсвэл та, танаас өмнө өнгөрөгсдийн байдал танд учралгүй диваажинд орчихоо бодов уу? Тэдэнд хэцүү ядуурал, хэцүү төвөг хүрээд, тэд ихээр донсолсон, түүнчлэн пайгамбарын хамт итгэгсэд нь «Аллахын тусламж хэзээ вэ?» гэдэг байцгаав. Хараарай! Үнэхээр Аллахын тусламж ойр юм.” (эл-Бакара, 214)[200]

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- гараа агуу онгон дээр дэлгэж ингэж залбиран гуйв:

“Аяа Раб минь! Аяа Кур’ан-и Азимүшшаныг илгээсэн Аллах минь! Аяа дайсантай тооцоогоо хурдан хийгч Раб минь! Чи Мадинагийн өмнө нь цугласан Арабын тэр аймгуудыг тараа! Аллах минь! Тэдний холбоог тасал, мэдлийг эвд, тэгээд тэд байрандаа зогсч чадахгүй байх болтугай!” (Бухарий, Мэгазий, 29)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- уг залбирлаа дөнгөж дуусcан байхад, ариун царайг нь цэвэр нэгэн мишээл илэрч тэнгэрлэг тусламж хэрэгжив. Хатуу ба ширүүн нэгэн шуурга дайсны тийш үлээж эхлэв. Өмнөөс нь юу тааралдсан ч сарваганууулсан айхтар нэгэн шуурга нь Мадинагийн хөндийн тоос хөрсийг мүшрикчүүдийн нүүр нүдгүй булав. Тэндий майхныг тайлж хийсэв. Хоолны тогоог нь нурааж, галыг нь унтраав. Ачааны тэмээ болон давхих морийг нь алдуулав.[201]

200. Хар. Табэрий, *Тэфсир,* II, 464.

201. Хар. Ибн-и Са’д, II, 71.

Уг тэнгэрлэг гамшиг ба тамлалын дээр нь буусан мүшрикчүүд нь замбараа алдав. Дайсны хамгийн хүчтэйгийн нэг Эбү Сүфьяан ч аргагүйгээр цэрэгтээ:

"–Би ухарч байна. Та ч замдаа гараарай!" гээд тэмээгээ унангуутаа Маккагийн замыг хайж эхлэв.[202]

Аугаа Эрх нь итгэгчдэд тусламжаа илгээсэн байв. Ает-и кэримэнүүдэд ингэж айлдана:

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُوا اذْكُرُوا نِعْمَةَ اللهِ عَلَيْكُمْ إِذْ جَاءَتْكُمْ جُنُودٌ
فَأَرْسَلْنَا عَلَيْهِمْ رِيحًا وَجُنُودًا لَّمْ تَرَوْهَا وَكَانَ اللهُ
بِمَا تَعْمَلُونَ بَصِيرًا

"Еэ итгэгчид ээ! Аллахын таны дээрх ачийг санаарай; дайсан этгээд довтлох үед танд тэдний эсрэг нэгэн салхи ба таны үзээгүй цэрэг илгээсэн байлаа. Аллах таны юу хийснийг маш сайн харж байв." (эл-Ахзаб, 9)

وَرَدَّ اللهُ الَّذِينَ كَفَرُوا بِغَيْظِهِمْ لَمْ يَنَالُوا خَيْرًا وَكَفَى
اللهُ الْمُؤْمِنِينَ الْقِتَالَ وَكَانَ اللهُ قَوِيًّا عَزِيزًا

"Аллах тэр үгүйсгэгчдийг ямар ч ашиг ололгүй уур хилэнгээр нь буцааж илгээв. Дайнд Аллахын тусламж **итгэгчдэд хүрэмжтэй болов. Аллах нь хүчит, андашгүй ялагч мөн."** (эл-Ахзаб, 25)

202. Хар. Ибн-и Хишам, III, 251.

Замбараагүйгээр тарж зугтсан мүшрикчүүд замдаа маш олон унаа хөлөг, байлдааны багаж, хүнс ба хэрэгсэл үлдээсэн байв. эдгээрийн ачаар Мадина дахь хомсдол ч үгүй болов. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- энэ тэнгэрлэг шагнал ба том ялалтын араас асхабтаа:

"–Одоо таны ээлж эхлэв! Үүний дараа Курайш таны дээр ирж чадахгүй!" хэмээн айлдав. (Бухарий, Мэгазий, 29)

Ингээд одоогоос хойш хамгаалалт биш, довтолгоо ч хийж чадахаар болсноо илэрхийлж байв. учир нь мүшрикчүүдийн бардам зан нугарчээ. дайрах хүч ч мууджээ. Одоо итгэгч бүрийн сэтгэлд Аллахын Элчийн уг үнэнийг илэрхийлсэн үг нь дуулдаж байв:

"Одоогоос хойш бид тэднийг арчина!"

Бэний Курайзагийн Дайн (5 оны Зидкадэ сарын 23 / 627 оны 4 сарын 15)

Исламчууд ийнхүү Хэндэкийн Дайнд ялж, дайсан нь Маккад тарсан байв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч жаргалын гэртээ хариад, ёсоор нь хуягаа тайлж усанд орсон байхад, Жэбраил -алэйхиссэлам- нь гарч ирэв. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-д:

"–Зэвсгээ тавив уу? Бид арай орхиогүй!" гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Тэгвэл дайн дуусаагүй гэсэн үг; хаашаа?" хэмээн асуув.

Жэбраил -алэйхиссэлам- ч дайны үед урвасан Бэний Курайзагийн нутгийг заан:

"–Тэнд ..!" хэмээв. (Бухарий, Мэгазий, 30)

Учир нь өмнөх еврейчүүд шиг Бэний Курайза ч Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-тэй хийсэн гэрээгээ дагаагүй, хамгийн хэцүү үед нь уравсан бацгаав. Уул нь хийсэн гэрээгээр Мадинад дайрсан мүшрикчүүдийн эсрэг хамгаалалт хийх ёстой байцгаав. Харин яг эсрэгээр нь, завшаан олох бүртээ туслаагүй, ингэхдээ өөрсдийгөө гамшиг руу чирээд байцгаав.

Тэнгэрлэг тушаалыг авсан Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь мусульманчуудын даруй цуглуулан Бэний Курайза руу довтлов. Түүнчлэн:

“–Сонссон ба дагасан хэн ч оройн мөргөлөө Бэний Курайзагийн нутагт хүрэлгүй битгий үйлд!” хэмээн айлдаж, еврейчүүд цуглахаас өмнө хөдлөв. (Бухарий, Мэгазий, 30)

Еврейчүүд нь Хазрат-и Али тэргүүлсэн түрүүлэгч хүчийг хараад хийсэн үйлдээ гэмшин бүр хилэгнэж Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тухай учир ухаангүй үг зарцуулав.[203] Харин их удалгүй Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн өөрөө тэргүүлсэн гурван мянгат Исламын цэргийг хараад бараг хэл амаа нээж чадаагүй. Аллахын Элчийн сүр жавхлангаас хэлсэн юмаа үгүйсгэцгээв.

Үсэйд бин Худайр -радъяллахү анх-:

“–Еэ Аллахын дайснууд! Таныг өлссөнөөсөө үхтэл бид таны хэрмийг бүсэлсээр байх болно! Та гэртээ хавчигдсан үнэг шиг юм!” гэв.

Бэний Курайзагийн еврейчүүд айдсанд автсан:

“–Ибн-и Худайр! Бид Хазражийн биш, та Эвсийн холбоот юм аа!” гэцгээв.

203. Хар. Вакидий, II, 499.

Үсэйд -радъяллахү анх-:

"–Одоо тантай бидний хооронд амлалт ч гэрээ ч үгүй!" гэв. (Вакидий, II, 499)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- еврейчүүдтай байлдахаас өмнө хэрмийнхээ ёроол хүртэл дөхөөд тэднийг Исламд урив. Харин тэд хүлээж аваагүй.[204]

Бүслэлт нь удаж еврейчүүд бүр зовбол, тэргүүлэгчдээс нь Ка'б бин Эсэд:

"–Аяа еврей нийгэм ээ! Энэ харж буй чиь гамшиг бидэнд учрав. Би танд гурван юм санал болгоё, алийг нь хүсвэл тэрийг л хийцгээ!" гэв.

"–Тэд юу вэ?" гэж асууцгаав.

Ка'б:

"–Нэг нь энэ хүнийг дагаад, пайгамбар буйг нь батална! Валлахи, тодорхой илэрснээр нь, Тэр нь таны төлөө илгээсэн нэгэн пайгамбар ба судартаа шинж тэмдгийг нь бичсэн буйгаар олсон хүн мөн. Түүнд итгэн үнэмшвэл цусаа, бараагаа, хүүхдүүдээ ба эмэгтэйчүүдээ хамгаалсан байх болно!" гэв.

"–Бид хэзээ ч Тэвратын шийдвэрээс ч салахгүй, түүнийг өөр номтой ч солихгүй!" гэцгээв.

Үүний дараа Ка'б нь хүүхэд ба эмэгтэйчүүдийг алаад байлдаанд орохыг эсвэл Бямба гаригийн шөнө буюу мусульманчуудын довтолгоо хүлээхгүй нэгэн мөчид дайрахыг санал болгов. Тэд алийг ч зөвшөөрөөгүй.[205] Учир нь Аллах тэдний зүрхнээс айдсыг салгасан байв.

204. Хар. Абдүррэззак, V, 216, 370.

205. Ибн-и Хишам, III, 254.

Са’лэбэ, Үсэйд ба Эсэд гэсэн нэртэй гурван залуу нь еврей эрдэмтдийн Сүүлийн Пайгамбарын тухай ярьсан бэлгэ тэмдгийг Аллахын Элчид буйг хараад мусульман болцгоов. Шөнө хэрмээс бууж Эзний маань дэргэд ирцгээв.[206]

Еврейчүүд тэр өдөр шалтгаангүй бууж өгөх ёстой болов. Бэний Курайза еврейчүүд нь Эвс аймгийн хамгаалалт доор байснаас, Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-, тэр аймгийн ахмад байсан Са’д Хазратыг шүүгч хийхээр дуулгав. Хазрат-и Са’д нь байлданд шархагдсан ч Пайгамбарын тушаалыг бишрэлттэйгээр дагаж тэнд ирэв. Учир нь дайнд Аугаа Эрхэд ингэж залбирсан байв:

“Аяа Раб! Бэний Курайзагаас өшөө авалгүй амийг минь битгий ав!” Хазрат-и Са’д -радъяллахү анх- нь еврейчүүдийн хүслээр тэдний тухай Муса -алэйхиссэлам-ын шэриатын дагуу шийдвэр гаргав.[207] Түүний гаргасан шийдвэрийг Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч батлан:

“–Са’д аа! Тангараг өргөе, чи Аллахын долоон давхарт тэнгэр дээрх шийдвэрийн дагуу шийдэв!” хэмээв. (Бухарий, Мэгазий, 30; Ибн-и Са’д, III, 426)

Хазрат-и Са’дын чин сэтгэлээрээ хийсэн залбирал хэрэгжиж, дайнд мусульманчуудыг араас нь харавсан урвагч еврейчүүдийн тухай шийдвэрээ гаргасны дараа шарх нь дахиад дэлбэрэв. Пайгамбарт хайрт уг сахабий нь хэсэг хуга-

206. Ибн-и Хишам, III, 256.

207. Тэвратын шийдвэрээр ингэж хандсан хүмүүсийн ял бол гараараа зэвсэг барихуйц эрчүүдийг алах, барааг нь олзлох, эмэгтэй ба хүүхдүүдийг боол болгож авах байв. (Хар. Хуучин Гэрээслэл, Тэнсие, 20/10-15)

цааны дараа амиа шэхид болж бууж өгөөд тэнгэрлэг энэрлийг хүртэв.[208]

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"Са'д бин Муаз нас барсны улмаас Рахманы огторгуй чичрэв," хэмээв. (Бухарий, Мэнакибу'л-Энсар, 12; Мүслим, Фэдаилү'с-Сахаба, 125)

Са'д -радъяллахү анх- хүдэр чийрэг биет байсан ч, хүмүүс түүний шарилыг зөөж байхдаа маш хөнгөн байсныг үзэв. Аллахын Элч үүний учрыг ингэж зарлав:

"–Түүнийг бусад нь зөөж байна! Миний биеийг хүчит гараараа барьсан Аллахад тангараг өргөе, мэлэкчүүд Са'дын амьтай уулзсандаа баяртай байна!" хэмээв. (Ибн-и Хишам, III, 271; Тирмизий, Мэнакиб, 50/3848)

Пайгамбар Эзэн маань Са'д -радъяллахү анх-ын оршуулах мөргөлийг үйлдүүлж түүнийг булшид нь хийгээд дээр нь хөрсөөр далдалсны дараа удаан эрхий татав. Асхаб-и кирам ч Аллахын Элчийг даган эрхий татав. Дараа нь Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- тэкбир авчрав. Асхаб ч тэкбир авчрав. Дараа нь асхаб:

"–Аяа Расулаллах аа! Яагаад эрхий татаад тэкбир авчраа вэ?" гэцгээв. Аллахын Элч:

"–Аллах түүнд уужмыг хайрлатал, булш нь тэр салих боолыг давчдуулаад байв," хэмээв. (Ахмад, III, 360) Дараа нь яриагаа ингэж үргэлжлүүлэв:

"–Хэрэв хэн нэгэн булшийн хуурамчаас аврагдах байсансан бол, андашгүй нь тэр Са'д болохсон. Харин булш нь түүнийг

208. Хар. Ибн-и Хишам, III, 271.

эхлээд давчдуулав, дараа нь Аллах түүнд ууҗмыг хайрлаж өгөв." (Табэраний, *Мү'жэмү'л-Кэбир,* X, 334)

Энэс -радъяллахү анх- ингэж ярина:

"Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д нэгэн хувцас бэлэг ирсэн байв. Энэ хувцас хүмүүст их таалагдаад, өнгө ба зөөлөн эдэд нь дурлацгаав. Аллахын Элч:

«Мухаммедын нэфсийг хүчит гараараа барьсан Тэрээрт тангараг өргөе, Са'д бин Муазын диваажин дахь алчуур нь үүнээс илүү гоё ба илүү буянт байдаг,» хэмээв." (Бухарий, Бэд'ү'л-Халк, 8; Мүслим, Фэдаил, 126)

Хэндэкийн Газвад тэнгэрлэг шагналаар хүртсэн амжилтыг Кур'ан-и Кэрим ингэж зарлана:

وَأَنزَلَ الَّذِينَ ظَاهَرُوهُم مِّنْ أَهْلِ الْكِتَابِ مِن صَيَاصِيهِمْ وَقَذَفَ
فِي قُلُوبِهِمُ الرُّعْبَ فَرِيقًا تَقْتُلُونَ وَتَأْسِرُونَ فَرِيقًا. وَأَوْرَثَكُمْ
أَرْضَهُمْ وَدِيَارَهُمْ وَأَمْوَالَهُمْ وَأَرْضًا لَّمْ تَطَؤُوهَا وَكَانَ
اللهُ عَلَى كُلِّ شَيْءٍ قَدِيرًا

"Аллах эхл-и китабаас тэдэнд туслагсдыг хэрмээс нь буулгаж зүрхэнд нь айдас оруулав; та тэдний заримыг алаад, заримыг ч бариад авч байцгаав. (Ингээд) **Аллах тэд-ний орон нутагт, бараанд ба таны хөл гишгээгүй хөрсөнд таныг өвлөгч болгов. Аллахын хүч бүх юмд хүрэмжтэй!"** (эл-Ахзаб, 26-27)

ХИЖРЭТИЙН ЗУРГАА ДАХЬ ЖИЛ

Ялалтын Түлхүүр: Хүдэйбиегийн Гэрээ

Кабагийн Санаагаар Гарсан Зорчил

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэгэн зүүдэндээ харсны дагуу мусульманчуудыг Кабад очоод таваф буюу тойрох үйлчилгээнд урив.[209] Уг урилгыг дагасан мянга дөрвөн зуун[210] сахабийтайгаа хамт Хижрэтийн зурга дахь жилд Зилкадэ гэдэг сарын анхны Даваа гаригт Макка руу хөдлөв. Дайнд яваагүй учраас зөвхөн зорчигчийн зэвсгээ авцгаав. Бас дал орчим тахил болгох тэмээ тууж явцгаав.[211]

Хазрат-и Умар -радъяллахү анх-:

"–Аяа Расулаллах аа! Эбү Сүфьяан ба түүний дагагчид бидэн рүү дайрна гэж санаа зоволтгүй юү? Хэрэг гарвал тэдэнд-тэй байлдахаар зэвсэг авсан нь дээр биш үү?" гэж асуув.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

209. Вакидий, II, 572.

210. Ибн-и Са'д, II, 95. Дараа нь уг тоог, бадавий Арабчуудын замд оролцсоноор мянга таван зуун, түүнчлэн мянга долоон зуун хүртэл өссөн нь ч дамжуулсан байдаг.

211. Ибн-и Са'д, II, 95.

"–Мэдэхгүй! Би үмрэ хийхээр зорьж явахдаа зэвсэглэмээргүй байна!" хэмээв. (Вакидий, II, 573)

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь хажжийн ихрам гэсэн хувцсыг өмсөх микат гэсэн газар буй "Зүлхүлэйфэ"д ирэхдээ ихрама өмсөөд үмрэгийн ниет хийв. Асхаб-и кирам ч түүнийг дагав. Чанга дуугаар тэлбие авчирч эхэлцгээв. Сэтгэл бүр нь Каба-и Муазаасад яаралтай учрахаар догдолж байв. Сүнсний бишрэлт нь итгэгчдийг алхам алхмаар нь тэнд дөхүүлж байв.

Харин мусульманчуудыг Макка руу хөдөлсөн тухай мэдээлэл авсан Курайшчуудын санаа зовж эхлэв. Тэд зөвлөлдөөд итгэгчдийг Маккад оруулахгүйгээр шийдвэр гаргав. Халид бин Вэлид ба Икримэ хоёрын тэргүүлсэн яаралтай бэлтгэсэн хоёр зуун хүнтэй эсэргүүцэгчид замд гарав.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Сэнийе гэсэн газар ирэв. Тэндээс Курайшчууд буй газар буух нь боломжтой байв. Харин Эзний маань тэмээ Касва нь сөгдөв. Хүмүүс:

"–Бос, бос, яв, яв!" гэсэн ч тэмээ босоогүй.

Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

" Аллах түүнийг зогсоолоо–хэмээв.

Дараа нь Пайгамбар Эзэн маань үгээ ингэж үргэлжлүүлэв:

"–Нэфсийг минь хүчит гараараа барьсан Тэрээрт би тангараг өргөе, Курайшийн мүшрикчүүд нь Аллахын Харамдаа (байлдах, цус гоожуулах ба садан хамаатнаа үл тоох мэт) хийхийг хориглосон юмыг хүндэтгэх зорилгоор надаас хэдий олон юм нэхсэн ч, (энх тайвны төлөө) заавал хүлээн зөвшөөрнө!"

Үүний дараа үсэрч босов. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- чигээ Курайшаас өөр тийш эргүүлэн бага устай нэгэн худгийн дэргэд очив. Энд бол Хүдэйбие гэсэн газрын хамгийн хол цэг байв. Худаг нь ус багатай байв. Их удалгүй энэ ус ч хатав. Аллахын Элчид усгүй боллоо хэмээн гомдлоо илэрхийлцгээв. Пайгамбар Эзэн маань саадгаасаа нэг сум гаргаж, худгийн ёроолд хатгахыг айлдав. Их удалгүй -Аллахын зөвшөөрснөөр- ус оргилж эхлээд, асхабыг тэндээс явтал урссаар байв.

Тэднийг ийм байдалд байхад Хузаа аймгийн тэргүүн Бүдэйл нь аймгаасаа хэсэг хүмүүсийн хамт гарч ирэв. Маккачуудын сандраад байлдахад бэлтгэснийг ярив. Тэднийг ийм сандарч байхад, Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- бол ирэх зорилгоо Бүдэйлд ингэж яриад өгөв:

"Бид хэнтэй ч байлдахаар ирээгүй. Бидний зорилго бол Бэйтуллахыг зочлох, үмрэ хийх юм. Дайн нь Курайшийг туйлдуулж, тэдэнд маш аюул учруулсан байдаг. Тэд хүсвэл бидний хоорондын байлдааныг болихоор тэдэнтэй тодорхой хугацааны гэрээ хийцгээе. Ийм байдал тэд надтай хүмүүсийн дундаас гарна. Хэрэв би бусдыг хожбол, хүсвэл бусдын орсон Исламд Курайшчууд ч орно. Хэрэв би хожиж чадахгүй бол Курайшчууд надтай байлдах төвгөөс чөлөөлөгдөж тэнийнэ. Хэрэв Курайш уг саналыг минь эс зөвшөөрвөл, валлахи би, энэ шашны төлөө толгой минь биеэсээ салтал байлдана. Аллах амалснаа заавал хэрэгжүүлнэ."

Бүдэйл Маккад хариад Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн энэ үгсийг Курайшид дамжуулав. Тэгэхлээр нь Үрвэ бин Мэс'үд босоод:

"–Энэ хүн танд сайн сайхан ба буяны замыг заана. Түүнийг хүлээж аваад намайг гэрээ хийхээр Түүнд илгээцгээ!" гэв.

Курайшчууд:

“–Тэгвэл за, яв!” гэцгээв. Үрвэ нь Аллахын Элч дээр ирэв. Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- түүнд ч Будэйлд хэлсэнтэй төсөөтэй юм хэлэв… Үрвэ нь энэ хооронд нүд салгахгүй Расулаллахын асхабыг хянаж байв. Харихдаа харс-наа Курайшчуудад ингэж ярив:

“–Ард минь ээ, сайхан сонсоцгоо! Валлахи би олон хааны онгонд элч болж орсон, гарсан; Хосровын, Кайсарын, Нэжашийгийн хажууд орлоо. Харин мусульманчуудын Мухаммед үнэн хүндэт нэгнийг өөр газар оронд ямар ч улсад харж үзээгүй… Тэр ямар нэгэн юм тушаавал бүгд дуулгавар-тай биелүүлнэ. Абдэст авбал, ус хийж өгөхөөр булаацалдана. Түүнийг үг дуугарвал бүгд нам дуугүй болцгооно. Түүний царай өөд эгцлэн харж ч чадахгүй ,толгой бөхийн зогсоно. Толгойноос нь нэг ширхэг үс унасан ч авч хадгална. Энэ хүн танд зөв санал оруулж байна, хүлээн зөвшөөрцгөө!”[212]

Үрмэг ингэж тайлбарласны дараа Кинанэгийнх аймгаас нэг нь:

“–Та зөвшөөрвөл, би ч очмоор байна!” гэв. Түүнийг Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- болон асхабт нь дөхөхөд Эзэн маань:

“–Тэр ирлээ! Тэр нь хаж ба үмрэд зориулсан тахилын тэмээг хүндэлдэг аймгийн хүн юм. Бидний тахилын малыг өмнөөс нь тавьцгаа, тэгээд тэр үзэг!” хэмээв. Асхаб тэр хүнийг тэлбие үгээр угтав. Тэр хүн үүнийг харахдаа сандран:

212. Өрнөдийн зохиолч Томас Карлайл уг үнэнийг ингэж илчлэхээс аргагүй болсон байв:
“Толгой дээр титим тавьсан хэн нэгэн император нь, өөрийнх гараараа нөхсөн цамцыг өмссөн Хазрат-и Мухаммед чинээ хүндэлсэн үгүй юм.”

“–Энэ хүмүүст Бэйтуллахын замыг хаах нь зохимжтой болохгүй!” гэв. (Бухарий, Шурут, 15; Ахмад, IV, 323-324)

Гэтэл мүшрикчүүд энэ хоёр элчийг сонсолгүй дайрахаар хүмүүсийг илгээв. Ангийг мусульманчууд барьсан ч Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- байлдахаар ирээгүй бөгөөд зөвхөн үмрэ хийгээд буцах тухай зорилтоо ойлгуулжи олзолж авсан мүшрикчүүдийг чөлөөлж буцаав.[213]

Пайгамбар Эзний маань майхан нь Хүдэйбиед Маккагийн Харамын гадна талд барьсан байв. Харин Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэнд байсан хугацаанд бүх мөргөлөө Маккагийн Харамын хилд орсон хэсэг очоод үйлддэг байв.[214] Учир нь Мэсжид-и Харамд үйлдсэн нэгэн мөргөл бусад газар үйлдсэн мөргөлөөс зуун мянган дахин эрдэмтэй байдаг.[215]

---

213. Мүслим, Жихад, 132, 133.

214. Вакидий, II, 614; Ахмад, IV, 326.

215. Хар. Ибн-и Мажэ, Икамэ, 195.

Бий'атү'р-Ридван: Аллахын Таатай Болсон Бий'ат

Энэ хооронд мүшрикчүүдээс хэдхэн элч ирээд явцгаав. Харин алинд ч гэрээ ба энх тайвны талаар лав нэгэн дүн олдоогүй тулд, энэ удаа Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хазрат-и Усман -радъяллахү анх-ыг Маккад, мүшрикчүүдтэй уулзаад асуудлыг шийдэхээр илгээж түүнд:

"–Курайшчуудад оч! Тэдэнд бидний энд хэнтэй ч байлдахаар ирээгүйг мэдээл! Бид зөвхөн энэ Бэйтуллахыг зочлохоор, түүний харамыг дагаж хүндлэхээр ирцгээв. Авчирсан тэмээгээрээ тахил өргөөд буцна! гэж хэл. Дараа нь тэднийг Исламд ч урь!" хэмээв. Мөн тэндэхийн эр-эм итгэгч бүртэй уулзаад, Маккаг удахгүй эзлэх мэдээг хүргэж, Аллах Таалагийн шашиндаа туслагч болоод, Маккад итгэж үнэмшсэнээ илээр зарлах өдөр дөхснийг мэдээлэхийг ч тушаав. (Ибн-и Са'д, II, 97; Ибн-и Кайям, III, 290)

Хазрат-и Усман -радъяллахү анх- нь Расулаллахын тушаалын дагуу шууд хөдөлж Маккад очив. Мүшрикчүүдэд үмрэ хийж харих зорилттой буйгаа ярив. Мүшрикчүүд тэгсэн ч зөвшөөрөл олгоогүй. Хазрат-и Усманыг нүд салгалгүй:

"–Хүсвэл чи таваф хийж болно!.." гэцгээв. Харин өөрийгөө Аллах болон Элчид нь зориулсан ариун сахабий Хазрат-и Усман -радъяллахү анх-:

"–Хазрат-и Пайгамбар Кабаг таваф хийгээгүй байхад би ч хийж чадахгүй! Би Бэйтуллахыг Түүний л араас зочилно..." гээд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д үнэнч буйгаа илэрхийлэв. (Ахмад, IV, 324)

Ингэж удаан ярилцсанаас болж Усман -радъяллахү анх-ыг буцахдаа оройтсон тул түүнийг үхсэн хэмээн худал мэдээ гарав. Тэгээд дахин мусульманчууд мүшрикчүүдийн хоорон-

дын харилцаа хүйтэрч эхлэв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- өөрийгөө оролцуулсан энэ худал цуурхал яриаг сонсоод яаралтай асхабаа цуглуулан:

“–Үүнээс харвал мүшрикчүүдтэй байлдахгүйгээр эндээс салж чадахгүй!” хэмээв. (Ибн-и Хишам, III, 364)

Дараа нь Аллахын замд амиа золихоор хамаг асхабаас бий’ат хэлэв. Эр-эм хамаг итгэгчид:

“–Аллахын Элчийн сэтгэлд ямар хүсэл байвал, түүгээр бий’ат хийе,” гээд Расулаллахын уг хүслийг дуртай хэрэгжүүлэв. (Вакидий, II, 603)

Итгэгчид Аллахын замд үхэн үхтлээ байлдахаар ам өгцгөөв. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ариун гарыг бариад бий’ат хийцгээв. Бий’атын эцэст Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэг гараараа нөгөө гараа барин:

“–Энэ ч Усманы бий’ат мөн!” хэмээгээд Усман -радъяллахү анх-ад итгэж ба хайрлаж буйгаа үйлээрээ үзүүлэв. (Бухарий, Асхабү’н-Нэбий, 7)

Нэгэн модон доор хийсэн уг бий’атыг “Бий’атү’р-Рядван” эсвэл “Хүдэйбиегийн Бий’ат” гэцгээв. Тэр өдөр нэгэн мүнафикаас гадна хамаг асхаб бий’ат хийсэн байв. Уг бий’ат нь Асхаб-и кирамын Аугаа Эрхийн агуу тааламжийг олохын учир болов:

لَقَدْ رَضِيَ اللّٰهُ عَنِ الْمُؤْمِنِينَ إِذْ يُبَايِعُونَكَ تَحْتَ الشَّجَرَةِ

فَعَلِمَ مَا فِي قُلُوبِهِمْ فَأَنزَلَ السَّكِينَةَ عَلَيْهِمْ

“Тангараг өргөе, тэр модон доор Чамд бий’ат хийж байхад нь Аллах тэр итгэгчдээс таатай болсон байдаг. Тэдний

зүрхэнд болсныг мэдсэн, тэдэнд тайван амгаланг буулгасан байдаг...” (эл-Фэтих, 18)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэгэн өдөр Хазрат-и Хафса эхийн маань дэргэд:

“–Инша аллах модон доор бий’ат хийсэн асхабаас хэн ч тамд орохгүй!” хэмээв.

Тэгсэнд нь ухаандаа нэгэн асуулт төрсөн Хафса эх маань:

“–Аяа Расулаллах аа! Аугаа Эрх:

وَإِن مِّنكُمْ إِلَّا وَارِدُهَا

«Таны дундаас хэнийг ч гажилт болгохгүйгээр хүн бүр нь заавал тамд хүрнэ...» хэмээдэг. (Мэрьем, 71) Энэ нь яаж болох вэ?” гэв.

Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Аллах Таала ингэж ч айлдав,” хэмээж дараах аетыг уншив:

ثُمَّ نُنَجِّي الَّذِينَ اتَّقَوا وَّنَذَرُ الظَّالِمِينَ فِيهَا جِثِيًّا

“Дараа нь мүттакийчүүдыг бид аварч, харгисчуудыг өвдгөн дээр сөхрүүлж тэнд орхичихно.” (Мэрьем, 72)

Араас нь ч эндэх “тамд хүрэх” гэхээр дотуур нь орох биш сират гүүрээр явж байхдаа тамын хажуугаар өнгөрөх утга илэрхийлмээр буйг тайлбарлав. (Мүслим, Фэдаилү’с-Сахаба, 163)

Хазрат-и Жабир -радъяллахү анх- ярина:

“Хүдэйбиегийн өдөр хүмүүс манай Эзэн дээр ирцгээв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн өмнө арьсаар хийсэн усны сав байв. эзэн маань абдэст авав. Ард нь Түүнд дөхөв. Тэгэхлээр нь:

«–Та нар яасан бэ?» хэмээн асуув.

«–Абдэст авах ба уухаар таны өмнөхөөс өөр ус үлдээгүй,» гэцгээв.

Аллахын Элч гараа шууд саванд хийв. Гэхэд хурууны дундуур ус урсч эхэлж, булаг шиг харагдаж байв. бид бүхэн түүнээс ууж абдэст авцгаав.”

Хазрат-и Жабираас:

“–Тэр өдөр та нар хэдүүлээ байв?” гэж асуувал:

“–Хэрэв живаа байсан ч ус хүрэхээр байсан, гэтэл бид мянга таван зуугуулаа байв!” хариуг өгөв. (Бухарий, Мэнакиб, 25)

Хүдэйбиегийн Гэрээ: Урилгын Шинэ Шат

Амиа зориулах шаардлагаар хийсэн Бий’атү’р-Рядваны тухай мэдээлэл авсан мүшрикчүүд хэт сандрав. Уг хэрэг нэлээд чухал шинжид орсон нь тэдний зүрхэнд том айдас оруулсан байв. яаралтай энх тайвны шийдвэр гаргаж Сүхэйл бин Амрыг Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-д илгээцгээв. Пайгамбар Эзнийг маань Сүхэйлийг харахад, тэр бол нэрээ “хялбаршил” гэсэн утгатай буйг сануулан:

“–Таны ажил одоо амар болов, танд Сүхэйл ирлээ,” гэв. Тэгэхлээр нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч Эрх Таалагийн:

وَإِن جَنَحُواْ لِلسَّلْمِ فَاجْنَحْ لَهَا

“Тэд энх тайванд дөхвөл, Чи ч тэдэнд дөх!..” (эл-Энфал, 61) хэмээсэн тушаалын дагуу хандав.

Мүшрикчүүдийн анхны зорилго тэр жил мусульманчуудад үмрэ хийлгэхгүй байв. Гэтэл гаднаас хүнд харагдсан зарим шаардлага ч байв. Удаан ба халуун маргалдааны дараа энх тайвны шаардлагаа хүлээн авцгаав.

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- гэрээний шаардлагыг бичих үүргийг Хазрат-и Алид олгов. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тушаалаар Хазрат-и Али -радъяллахү анх- эхлээд “Бэсмэлэ-и Шарифа”г бичиж гэж байтал Сүхэйл эсэргүүцэв. Бэсмэлэгийн оронд; « بِاسْمِكَ اللّٰهُمَّ » бичүүлэв.

Энэ үгийн дараа Сүхэйл Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тухай Аллахын Элч гэсэн үгийг бичихэд ч эсэргүүцэв:

“–Чамайг Аллахын Элч буйг бид зөвшөөрсөнсөн бол Чамтай байлдах байв уу, өнөөдөр Кабаг зочлоход саад болох байв уу?” гэв.

Тэгэхлээр нь угаасаа энх тайвны шаардлагаас нь болж асхаб нь улам бүр хилэгнэв. Хазрат-и Али -радъяллахү анх- нь барьсан үзгийг орхиж:

“–Аллахад тангараг өргөе, би «Аллахын Элч» гэсэн үгийг арилгаж чадахгүй, аяа Расулаллах!..” гэв.

Тэгэхэд нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- Сүхэйлд:

“–Та үгүйсгэсэн ч би Аллахын Элч мөн,” хэмээгээд бичсэн өгүүлбэрийг нэхэв. Тэр хэсэг дээр ариун гараараа зураас татаад байранд нь Мухаммед бин Абдуллах хэмээн алдраа бичүүлэв.

Тэр өдөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- олон нууц учрын улмаас гэрээнд гарын үсгээ зурав. Гэрээний зарим зүйл нь ийм байв:

1. Гэрээний хугацаа нь арван жил юм.

2. Мусульманчууд Кабаг энэ жил айлчилж чадахгүй; уг айлчлалаа дараа жилд хийцгээнэ. Ирэх жил айлчлахаар ирэгчид Маккад гурав хоноод, тэр хугацаанд мүшрикчүүд Маккагаас гараад, мусульманчуудтай холбоо барихгүй.

3. Курайшчуудаас нэг нь, мусульман болсон ч Мадинад хоргодвол түүнийг буцааж өгнө, харин Мадинагаас ирээд Маккад хоргодогчдыг бол Мадинад буцааж өгөхгүй.

4. Арабын бусад аймгууд нь хүсвэл мусульманчуудын талд, хүсвэл Курайшийн талд орж болно.

Гэрээний зүйлийг бичээд дуусгасан байхад Курайшийн төлөөлөгч Сүхэйл бин Амрын хөвүүн Эбү Жэндэл нь хөлийнхөө гинжийг чирээд аажим аажмаар Пайгамбар Эзний маань дэргэд хүрээд ирэв. Эбү Жэндэл -радъяллахү анх- мусульман болсон учраас мүшрикчүүд маш их тамласан байв. Завшаанаар тэднээс зугтаж, өөрийгөө мусульманчуудын дунд арай гэж авчирсан байв. Сүхэйл гэрээ ёсоор авсан анхны хүн өөрийнх нь хүү байгааг хараад барьсан саваагаар Эбү Жэндэлийн нүүрэнд буулгав. Энэ явдлыг харамсан харж байсан Энэрлийн Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эбү Жэндэлийг гэрээнээс гаргаад түүнийг өөртөө бэлэглэхийг Сүхэйлээс гуйв. Харин чулуун зүрхт мүшрик үүнд дөхөхгүй байв. Эбү Жэндэл -радъяллахү

анх- ч мүшрикчүүдэд баригдаад байхдаа мусульманчуудаас залбиран тусламж гуйж байв. Хэтэрхий зовлонтой байдлаар:

“–Намайг дахиад галд хаяx юм уу?” гэж тэднээс асуухад нь тэдний элэг эмтэрч байв. мусульманчууд түүний иим байдлыг хараад тэсэлгүй нулимс унагав. Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эбү Жэндэлд:

“–Эбү Жэндэл ээ! Дахиад жаахан тэсээрэй! Аллах Таала харж байгаа тэр чамайг шагнах болно! Андашгүй нь аугаа Аллах чи болон чиний дэргэд байгаа хүчгүй, мусульманчуудад нэгэн уужим гарах зам зааж өгөх болно. Бид тэдэнтэй энх тайвны гэрээ хийсэн бөгөөд тэдэнд Аллахын үгээр ам өгсөн. Тэд ч бидэнд Аллахын үгээр ам өгцгөөв. Бид амласнаа зөрчиж болохгүй. Зөрчих нь бидэнд зохимжгүй юм!” хэмээж түүнийг тайтгаруулав. (Ахмад, IV, 325; Ибн-и Хишам, III, 367)

Дараа нь энэрлийн далай Эзэн маань Сүхэйлд:

“–Битгий ингэ дээ, түүнийг надад өгчих!” хэмээн дахин хэлэв. Харин Сүхэйл ямар ч саналыг хүлээж авахгүй байв. Орчлонгуудын Эзэн:

“–Тийм түүнийг миний нэрээр хамгаалалтанд ав!” хэмээн гуйв. Сүхэйл үүнийг ч зөвшөөрөөгүй. Түүнийг ингэж харахдаа Курайшийн төлөөлөгчдөөс Хувэйтаб ба Микрэз:

“–Еэ Мухаммед аа! Чиний нэр алдраар бид түүнийг хамгаалалтандаа авлаа, түүнийг хэн ч тамлахгүй,” гэв. (Вакидий, II, 608; Бэлазурий, I, 220)

Ингээд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн санаа өчүүхэн ч гэлээ амарч харив.

Мүшрикчүүдийн иим зөрүүд ба ихэмсэг занг тэсч чадахааргүй байсан ч Хазрат-и Умар -радъяллахү анх- тэр өдөр

сэтгэлийн тэвчээрээр зарим хэмжээлшгүй үйлс хийж, арай гэж тайвширч чадсан байв. Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анхаас гадна бусад сахабийчууд ч Хазрат-и Умарын адил байсан юм. Гаднаас нь харахад хожигдсон шиг харагдах уг гэрээг Хазрат-и Умар пайгамбарын тушаалын эсрэг саналаа илэрхийлэхэд Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Би Аллахын Элч мөн, Түүнийг эсэргүүцэж болохгүй. Миний туслагч минь Тэр мөн!” хэмээж, хийсэн үйлийн Аллахын залснаар буйг заав. (Бухарий, Мэгазий, 35; Мүслим, Жихад, 90-97)

Гэрээг баталсны дараа Сүхэйл хүүгээ дагуулан баяр хөөртэй Макка руу харьж байхад, Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч шилмэл асхабтаа ингэж айлдав:

“–За, одоо тахилаа төхөөрч, үсээ авцгаа!..”

Гэтэл Сахаба нараас хэн ч уг тушаалыг хэрэгжүүлэхээр хөдөлсөнгүй. Тэд нууцыг нь тайлж чадаагүй нэгэн хэргийн манан дотор гунигтай байцгаав. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- тушаалаа гурав давтав. Дахиад хэн ч хөдлөөгүй. Энэ нь ерөөсөө эсэргүүцэх үйл биш, Кабаг айлчлах бишрэлт зүрхийг догдлуулсан, саяхан хийсэн гэрээг цуцлах байх гэсэн жижигхэн найдвартай нэгэн хүлээлт байв. Эс тэгвээс дөнгөж түрүүний өдөр:

“–Аллахын Элчийн сэтгэлд ямар хүсэл байвал түүн дээр бий’ат хийе,” гээд Пайгамбар Эзэнд маань үнэнч байхаар тангараг өргөсөн байцгаав.

Асхабыг ингэж хөдлөхгүй байхад Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ийн санаа их зовов. Гунигтайгаар халамжит

эхнэр Үммү Сэлэмэгийнхээ майханд одов. Юу болсныг Үммү Сэлэмэд мэдүүлэхэд нь ариун эх маань Аллахын Элчийг тайтгаруулан энэ үгсийг хэлэв:

"–Аяа Аллахын Элч ээ! Та асхабтаа юу ч хэлэлгүй тахилаа төхөөрч, үсээ хусаарай! Ингэвэл тэд өөрсдөө хэцүү байсан ч, гунигтай байсан ч таны хийснийг л дагана. Та тэднийг өршөөгөөрэй!"

Үүний дараа майхнаас гарсан Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- үнэхээр байдлыг өөрөө үлгэрлэн үзүүлжээ. Үүнийг харсан асхаб гэрээ өөрчлөхгүйг ойлгож, бүгдээрээ Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хийснийг дагав. Тахилаа төхөөрч, үсээ хусуулав. Үүнийг харсан Үммү Сэлэмэ -радъяллахү анха-:

"–Мусульманчууд тахил руугаа нэг үсрээд, би тэднийг нэг нэгээр гишгэнэ гэж айлаа," гэсэн байв. (Бухарий, Шүрүт, 15; Ахмад, IV, 326, 331; Вакидий, II, 613)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- болон асхаб нь тахилаа төхөөрч үсээ хусуулсны дараа Аллах Таала нэгэн шуурга илгээв. Асхабын үсийг хөөрүүлж Харамын дотогш үлээв. Сахабийчууд үүнийг үмрэгээ хүлээн авсаны тэмдэг гэж тоолов.[216] Дараа нь Мадина руу хөдлөв.

Мусульманчууд хийсэн гэрээний нууц учрыг эхлээд ойлгож чадаагүй тул тавгүйгээ үзүүлсэн ба ажил үйлээ удаж хийсэн учраас нэгэн айдсанд автав. вахий бууж, мөхөхөө бодож эхлэв. Тэр хооронд "Фэтих" буюу "Ялалт Сура" буув:

216. Ибн-и Са'д, II, 104; Халэбий, II, 713.

إِنَّا فَتَحْنَا لَكَ فَتْحًا مُّبِينًا. لِيَغْفِرَ لَكَ اللّٰهُ مَا تَقَدَّمَ
مِن ذَنبِكَ وَمَا تَأَخَّرَ وَيُتِمَّ نِعْمَتَهُ عَلَيْكَ وَيَهْدِيَكَ
صِرَاطًا مُّسْتَقِيمًا. وَيَنصُرَكَ اللّٰهُ نَصْرًا عَزِيزًا

“Аяа Элч минь ээ! **Мэдээж Бид Чамд ил нэгэн ялалт хайрлав. Ингэхдээ Аллах Чиний өнгөрсөн ба ирээдүйн алдааг өршөөж; Чамд өгөх үр шимээ бүтээж Чамайг** байнга **зөв зам руу залах болно. Мөн Чамд цуут нэгэн ялалтаар туслах болно.”** (эл-Фэтих, 1-3)

Мүжэммий бин Жария -радъяллахү анх- нь Фэтих Сураг бууж байхад асхабын ямар аймшигтай байсныг ингэж ярьжээ:

“Хүмүүс айж тэмээнийхээ дэргэд тарсан байв. Нэг нэгнээсээ:

«– Юу болж байна?» гэж асууж байцгаав.

«–Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д вахий иржээ!» гэцгээв. Бүгд айж сандарсан байдалтай Аллахын Элчийн тийш явлаа. Асхаб цуглараад Орчлонгуудын Эзэн Фэтих Сураг уншив.” (Ибн-и Са’д, II, 105)

Хазрат-и Умар -радъяллахү анх- ч ингэж хэлдэг:

“Тэр өдөр Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн эсрэг хэлсэн үгээсээ мэдэрсэн аймшгаас болж, заяа минь буян болох тулд байнга мацаг барьж, хандив тарааж, нафилэ мөргөл үйлдэж маш олон боол чөлөөллөө.” (Ибн-и Сэйеддиннас, II, 167)

Фэтих Сура нь итгэгчдэд Хүдэйбиегийн хамт нээсэн ялалтын анхны сайхан мэдээг хүргэж байв. Тэгээд их удалгүй мэдээлсэн зүйлс нь нэг нэгээр хэрэгжиж эхлэв: Эргэн тойрны аймгу-

уд Расулаллахын Кабаг айлчлахаар гарсан уг аяныг “буцахгүй аян” гэж тэмдэглэсэн байв. Харин Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн өчүүхэн ч гэсэн аюултай тааралдалгүй, эсэн мэнд харьсныг харан сандраад Түүнээс уучлал гуйцгаав. Аллах Таала тэдний ийм байдлыг аят-и кэримэнүүдэд ингэж илэрхийлэв:

بَلْ ظَنَنتُمْ أَن لَّن يَنقَلِبَ الرَّسُولُ وَالْمُؤْمِنُونَ إِلَى أَهْلِيهِمْ أَبَدًا
وَزُيِّنَ ذَلِكَ فِي قُلُوبِكُمْ وَظَنَنتُمْ ظَنَّ السَّوْءِ وَكُنتُمْ قَوْمًا بُورًا.
وَمَن لَّمْ يُؤْمِن بِاللَّهِ وَرَسُولِهِ فَإِنَّا أَعْتَدْنَا لِلْكَافِرِينَ سَعِيرًا

“Үнэндээ та нар Пайгамбар болон итгэгчдийн гэр бүлдээ дахиад хэзээ ч эргэж ирэхгүй гэж бодсон. Энэ таны сэтгэлд сайхан харагдаад та мууг бодож мөхөх зохимжтой нийгэм болов. Хэн ч Аллах болон Элчид нь итгэсэн бол Бидний кафирчуудад догшин нэгэн гал бэлтгэснийг мэдэж аваг.” (эл-Фэтих, 12-13)

Тэр өдөр Хүдэйбиед мүшрикчүүдтэй хийсэн энх тайвны гэрээнд гаргасан шийдвэрүүд нь гаднаас харвал мусульманчуудын эсрэг байв. Харин Фэтих Сура нь бууж; энэ үйлийн агуу нууц учир ба сайхан мэдээ нь мэдэгдэв. Дараа нь хүмүүс анх харахад хожигдол ба гутамшиг гэж бодсон уг зүйл ил нэгэн ялалт буйг ойлгов... Аят-и кэримэнүүдэд айлдсанаар:

وَعَسَى أَن تَكْرَهُواْ شَيْئًا وَهُوَ خَيْرٌ لَّكُمْ وَعَسَى أَن تُحِبُّواْ شَيْئًا
وَهُوَ شَرٌّ لَّكُمْ وَاللّهُ يَعْلَمُ وَأَنتُمْ لاَ تَعْلَمُونَ

“…Заримдаа та нэгэн юмд дургүй боловч, тэр таны төлөө буян юм. Заримдаа ч та нэгэн юмд дурлаж хүснэ, харин тэр таны төлөө бузар юм байдаг харин үүнийг Аллах мэддэг, та мэддэггүй.” (эл-Бакара, 216)

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн өмнө тайлбарлахад хэцүү байсан уг байдал, хоёр жилийн хугацаанд л ил гарав. Тэгээд энэ гэрээгээр бий болсон энх тайвны орчимд олон хүн Исламд ороод алдар олж, хоёр жилийн хугацаанд мусульман бологсдын тоо, тэр өдөр хүртэл мусульман бологсдын тоог давсан байв.

Магадгүй тэр жил мусульманчууд үмрэ хийж чадахгүй ба зарим хэцүү нөхцөлд тэвчих ёстой байв. Харин үүний араас урсч ирэх ашиг олдвор нь илүү том болох байв. учир нь уг гэрээгээр Ислам албан ёсоор танигдсан байв. Жилийн дараа Кабад айлчлах байв. Араб аймгуудаас хүссэн нь мусульманчуудын хамгаалалтад орж чадах байв. Энэ бол Курайш нөлөөгөө алдаж, Исламын урилгыг амархан хийх гэсэн утгатай байв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн уг энх тайвныг сонгосны нэгэн учир ч Маккад тэр үед мусульман болсон, харин буй байдлаас болж үүнийг зарлаагүй олон хүн байсан нь байв. Хэрэв мүшрикчүүдийн дунд байлдаан гарсан бол, тэдний ил гарах ба амь насаа алдах ч магадгүй юмаа.

Эцэст нь “энэрлийн пайгамбар” байсан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Макка болон Арабын бусад аймгуудын дундаас шинээр мусульман болох хүмүүст энэ үйлээрээ нууц дохио мэдээлэл өгч, тэднийг Исламд дасгаж байв. Тэгээд үүний үр дүн удахгүй ил харагдах байв.

Фэтх-и Мүбин: Дахин дахин нэмсэн элбэг аврал

Хүдэйбиегийн гэрээний шаардлагыг гаднаас хараад баяссан мүшрикчүүд үнэндээ анзааралгүй итгэгчдэд учирсан саадыг холдуулж, тэднийг өөрсдөөсөө илүү давуу оронд тавьсан байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс гадна бараг сахабий бүр энэ гэрээг тэдний эсрэг гэж ойлгон хүлээн зөвшөөрсөнгүй нь ч мүшрикчүүдийн нүдийг бас хааж, том амжилт олсон юм шиг бодохгүйгээр гарын үсэг зурахад хүргэсэн байв. Энэ гэрээний далд утга нь эхлээд нууц нь итгэгчдэд ч хаалттай байсан бол гэрээний жинхэнэ агуулга нь түүнийг хэрэгжүүлэх тусам аажим аажмаар ил гарч эхлэв.

Уг гэрээний ач тусыг бүр эхнээс нь мэддэг байсан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Хүдэйбиегин Гэрээний шаардлагад нэлээд анхаарал тавьж, түүний нээлтийг ашиглахаас ч татгалздаггүй байв. Жишээлбэл Маккагийн зарим итгэгч эмэгтэйчүүд Мадинад хоргодох үед мүшрикчүүдийн татаасыг үгүйсгэв. Учир нь гэрээний зүйл зөвхөн эрчүүдийг хамарч байв. Угаасаа Аугаа Эрх ч эмэгтэйчүүдийг буцааж өгөхгүй байхыг тушааж байв:

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُوا إِذَا جَاءكُمُ الْمُؤْمِنَاتُ مُهَاجِرَاتٍ فَامْتَحِنُوهُنَّ
اللَّهُ أَعْلَمُ بِإِيمَانِهِنَّ فَإِنْ عَلِمْتُمُوهُنَّ مُؤْمِنَاتٍ فَلَا تَرْجِعُوهُنَّ إِلَى
الْكُفَّارِ لَا هُنَّ حِلٌّ لَّهُمْ وَلَا هُمْ يَحِلُّونَ لَهُنَّ وَآتُوهُم مَّا أَنفَقُوا
وَلَا جُنَاحَ عَلَيْكُمْ أَن تَنكِحُوهُنَّ إِذَا آتَيْتُمُوهُنَّ أُجُورَهُنَّ وَلَا

تُمْسِكُوا بِعِصَمِ الْكَوَافِرِ وَاسْأَلُوا مَا أَنفَقْتُمْ وَلْيَسْأَلُوا مَا أَنفَقُوا

ذَلِكُمْ حُكْمُ اللهِ يَحْكُمُ بَيْنَكُمْ وَاللهُ عَلِيمٌ حَكِيمٌ

“Аяа итгэгчид ээ! Итгэгч эмэгтэйчүүдийг нүүж танайд ирэхэд тэднийг шалгацгаа! Аллах тэдний итгэл үнэмшлийг илүү сайн мэднэ. Хэрэв та ч тэднийг итгэсэн эмс буйг ухаарвал, тэднийг кафирчуудад битгий буцааж илгээ! Эд нар тэдэнд халал биш юм. Тэд ч эд нарт халал байж болохгүй. Тэдний нөхрүүдийг **буцааж өг. тэд гэрлэхэд танд ямар нэгэн нүгэл үгүй. Кафир эмсийг** бол **гэрлэлтдээ хүлээлгүүзэй, зарцуулснаа нэхэцгээ! Тэд ч зарцуулснаа нэхэцгээг. Аллахын шийдвэр ийм юм. Таны оронд Тэрээр л шийднэ. Аллах бүхнийг мэдэгч, эрдэмт мөн.”** (эл-Мүмтэхинэ, 10)[217]

Энэ хооронд Эбү Басир гэсэн нэртэй, мусульман болсон нэгэн Маккагийн ч Мадинад хоргодсон байв. Гэтэл Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- гэрээний дагуу түүнийг мүшрикчүүдэд буцаах ёстой байв. Эбү Басир ч эхлээд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ингэсний утгыг ойлголгүй:

“–Намайг баримлын шүтээнд эргүүлсээр байна уу?” гээд сандарснаа илэрхийлэв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- тайван яриагаараа түүнийг тайтгаруулав:

“–Еэ Эбү Басир аа! Бид амласнаа эвдэхгүй. Харин чи жаахан тэвчээд бай; Аллах Таала нь чамд болон чам шиг хүмүүст заавал авралын нэгэн заам зааж өгнө.”

217. Хар. Бухарий, Шурут, 15; Вакидий, II, 631-632.

Энэ үгсийн дараа Эбү Басир үг дуугүй Пайгамбарын шийдвэрийг дагав. Ерөнхий мусульманчуудын байдлыг бодоод мүшрикчүүдэд бууж өгөв. Харин түүнийг Маккад биш, үхэл рүү нь аваачив. Үүнийг мэдсэн тул нэгэн завшааныг ашиглан дайраад өөрийгөө хамгаалав. Түүнийг авч явсан хоёр Хүнэйсийг алаад нөгөөг нь барьж чадаагүй. Эбү Басир нь Хүнэйсийг хувцас, бараа болон сэлмийг нь авч, Аллахын Элчид авчраад:

“–Аяа Расулаллах аа! Эдгээрийн тавны нэгийг , өөртөө ав!” гэв. Эзэн маань:

“–Би үүний тавны нэгийг авбал тэдэнтэй хийсэн гэрээгээ зөрчсөн байх болно. Харин чиний юу хийсэн нь ч, алсан хүний бараа ч чамтай хамаатай,” хэмээв. (Вакидий, II, 626-627)

Зугтсан мүшрик ч ирээд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс дахиад түүнийг нэхэж байв. Энэ удаа Эбү Басир:

“–Аяа Аллахын Элч ээ! Та намайг эд нарт буулгаж өгөөд гэрээг дагасан. Харин би амиа тэднээс аварлаа,” гэв.

Дараа нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн айлдсан үгсийн нууц эрдмийг ухаарч Мадинагаас гарав. Тэнгисийн эрэгт, Макка Дамаск хоёрын хооронд Ийс гэдэг нэгэн газар суурьшив. Удалгүй тэнд нь талгүй бүс болоод хоргодох орон болов. Эбү Жэндэлийн ч өөрийгөө авраад хоргодсон энэ газар дахь мусульманчуудын тоо их удалгүй гурван зууд хүрэв. Маккачуудын Дамаск наймааны зам аюулд оров. Тэгэхлээр нь Маккагийн мүшрикчүүд аргагүй болоод Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс энэ тухай зүйлийг цуцлахыг шаардав. Өөрөөр хэлбэл Маккагаас мусульман болоод зугтагсдыг Мадинад хүлээж авахыг гуйв. Ингээд мусульманчуудын эсрэг байсан уг зүйл нь их удалгүй итгэгчдийн талд эргэв.[218]

218. Хар. Бухарий, Шурут, 15; Ибн-и Хишам, III, 372.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эбү Басирынханд захидал илгээв. Харин Эбү Басирийн бие их муу байв. захидлыг уншаад тус захидлыг барьж байхдаа амьсгал хураажээ. Эбү Жэндэл түүний нас барсан газар оршуулж булшийнх дэргэд нэгэн мэсжид барив. Эбү Жэндэл дэргэдэх мусульманчуудын хамт Мадинад ирээд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг дагаад олон жихадад оролцов.[219]

Хүдэйбиед хэрэгжсэн энх тайвны тухай Исламын тэблигийг хурдлуулахад эргэлтийн цэг болов. Угаасаа Аллах Таала үүнийг "Фэтх-и Мүбин" буюу Ил Ялалт хэмээн тайлбарласан байв.[220]

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хүдэйбиег том нэгэн ялалт буйг мэдүүлэхэд асхабаас нэгэн:

"–Бидний Бэйтуллахыг таваф хийхэд зөвшөөрөл олгоогүй, бид тахилаа Харамд төхөөрч чадаагүй. Мусульман болоод бидэнд ирээд хоргодсон хоёр хүнийг ч Расулаллах буцааж өгөв. Энэ нь ямар ялалт юм бэ?" гэж хэлэлцэв.

Түүний ийм үгс Эзэнд маань хүрэхлээр Хүндэт Элч энэ гэрээний ямар талаараа ялалт буйг ингэж тайлбарлаж өгөв:

"–Тийм! Энэ гэрээ нь хамгийн том ялалт мөн. Мүшрикчүүд таныг тэдний нутагт явах ирэхийг, ажлаа хийхийг зөвшөөрсөн бөгөөд ингэхдээ аюулгүй байхыг тань хүссэн байдаг. Тэд одоо хүртэл хүсээгүй, дурлаагүй Исламыг ингээд танаас үзэж аваад сурах болно. Аллах таныг ялагч болгож, та явсан газраасаа

219. Хар. Вакидий, II, 629.

220. Хар. эл-Фэтих, 1.

аюулгүй ба ашигтайгаар буцна. Энэ бол ялалтын хамгийн том нь юм." (Халабий, II, 715)

Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх- ч Хүдэйбиегийн гэрээний тухай бодлоо ингэж илэрхийлсэн байв:

"Исламд Хүдэйбиегийн ялалтаас том ялалт болоогүй. Харин ард нь богино ба нарийн үзэлтэй байдаг тулдаа уг гэрээг эсэргүүцсэн байв. Хүмүүс Аллах ба Пайгамбарынх нь хоорондын ажилд яарагч байдаг. Аллах Таала бол тэдэн шиг яардаггүй, хүссэн ажлыг хугацаа болохгүй бол хийдэггүй." (Вакидий, II, 610; Халабий, II, 721)

Хүдэйбиегийн гэрээний анхны эерэг дүгнэлт нь Исламчуудын дунд хурдан тарав. Энх тайвны уг эринд Исламын тэблигт шинэ завшаан ба улам дэлгэрэх нөхцөл бүрдэв. Үүний ачаар мусульманчууд мүшрикчүүдтэй уулзаж, тэдэнд Кур'ан-и Кэрим уншаад Исламын тухай илээр ярьж эхэлсэн байдаг. Мусульман болсноо нуугсад ч одоо шашнаа айхгүйгээр зарлаж чаддаг болов.[221]

Үүнээс өмнө бол хоёр тал нэг нэгтэйгээ санаа амар уулзаж чаддаггүй байв. Гэрээний дараа мүшрикчүүд Мадинад чөлөөт ирээд, мусульманчууд ч Маккад чөлөөтэй очдог байв. Тэндэх айл, анд болон бусад хүмүүстэй уулзаж ярих завшаан олддог байв. Пайгамбар Эзний маань байдал ба хандлага, гайхамшиг, ёс суртахуун ба замын гоо сайхны тухай мусульманчуудын ярьсан мэдээ болон сургаалыг хүмүүс сонсохоор болсон, ингэ-эд мүшрикчүүдийн зүрх зөөлөрч Исламд хэлбийж эхэлсэн байв. Угаасаа цөлд суудаг Арабчууд ч мусульман болохоор Курайшийн мүшрикчүүдийн итгэн үнэмшихийг хүлээн байц-гаав. Энэ хугацаанд мүшрикчүүдийн тэргүүдээс Амр бин Ас,

221. Хар. Ибн-и Кайям, III, 309-310.

Халид бин Вэлид ба Усман бин Талха мэтийн хүмүүс ч мусульман болсон байв.[222]

Исламын төлөөлөгчид аюулгүйгээр янз янзын нутгаар явсан, арга бүрт хүмүүст Исламыг ярих завшаан олсон байцгаав. Энэ уринд мусульман бологсдын тоо олон дахин ихсэв.

Имам Зүхрий нь Хүдэйбиегийн Гэрээний үр дүнг, Аллахын Элчийн энэ тухай хадис-и шарифуудыг ашиглан ингэж товчилно:

"Үүнээс өмнө мумульманчууд болон мүшрикчүүд тааралдсан газар бүрт тулалдаж байлддаг байв. Хүдэйбиегийн гэрээгээр дайн ба байлдаан дуусав. Хоёр талын хооронд итгэмжтэй орчин бий болов. Нэг нэгтэйгээ уулзаж санал бодол солилцох завшаан олцгоов. Түүнчлэн зарим хэрэгт тусалцаж эхэлцгээв. Энэ хугацаанд хэнд ч Исламын тухай үг хэлбэл, түр бодсоны дараа үнэнийг ухаарч, шууд мусульман болж байв. Жишээлбэл, Хүдэйбиегээс Маккаг эзэлтэл хоёр жилийн хугацаанд мусульман бологсдын тоо нь Хүдэйбие хүртэл өнгөрсөн есөн жилийн Исламын урилгаар мусульман бологсдын тооноос илүү болсон байв."

Ибн-и Хишам үүнд энэ үгсийг нэмнэ:

"Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хүдэйбие рүү явж байхдаа мянга дөрвөн зуун хүний хамт замдаа гарсан байв. Үүнээс хоёр жилийн дараа, Маккаг эзлэхэд бол хажууд нь түм, өөр нэгэн яриагаар бол замд оролцсон хоёр мянга хүний хамт арван хоёр мянган мусульман бэлэн байв. Эдгээр тоонууд Зүхрийгийн дүгнэлт хэр зөв буйг заадаг юм." (Хэйсэмий, VI, 170; Ибн-и Хишам, III, 372)

222. Хар. Вакидий, II, 624.

ХИЖРЭТИЙН ДОЛОО ДАХЬ ЖИЛ

Эзэн Хаадыг Исламд Урьсан нь

Хамаг хүн төрөлхтөнд илгээгдсэн "Расул" байсан Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хүдэйбиегийн Гэрээний дараа хол-ойр хүрч чадах хамаг улсуудыг Исламд урьж эхлэв. Угаасаа энэ тухай тэнгэрлэг тушаал ирсэн байв:

قُلْ يَا أَيُّهَا النَّاسُ إِنِّي رَسُولُ اللهِ إِلَيْكُمْ جَمِيعًا
الَّذِي لَهُ مُلْكُ السَّمَاوَاتِ وَالأَرْض

" Расул минь! **Ингэж хэл: Хүмүүс ээ! Үнэхээр би та бүхэнд, тэнгэрүүд ба газрын эзэн буй Аллахын элч мөн..."** (эл-А'раф, 158)

يَا أَيُّهَا الرَّسُولُ بَلِّغْ مَا أُنزِلَ إِلَيْكَ مِن رَّبِّكَ وَإِن لَّمْ
تَفْعَلْ فَمَا بَلَّغْتَ رِسَالَتَهُ وَاللّٰهُ يَعْصِمُكَ مِنَ النَّاسِ

"Аяа Расул аа! Раббынхаа Чамд буулгасныг хамаг хүн төрөлхтөнд **тэблиг хий! Хэрэв үүнийг хийхгүй бол, Түүнийг хийхгүй бол** Чамд олгосон **номлогч үүргийг хийгээгүйгээр тоологдоно! Аллах Чамайг хүмүүсээс хамгаалах болно..."** (эл-Маида, 67)

وَمَا أَرْسَلْنَاكَ إِلَّا كَافَّةً لِّلنَّاسِ بَشِيرًا وَنَذِيرًا
وَلَكِنَّ أَكْثَرَ النَّاسِ لَا يَعْلَمُونَ

“Бид Чамайг хамаг хүмүүст сайхан мэдээч ба Аллахын тамлалыг ойлгуулагчаар илгээв. Харин хүмүүсийн ихэнх нь үүнийг мэддэггүй.” (Сэбэ’, 28)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- дэлхийн улсудыг Исламд урихдаа захидал бичээд илгээв. Энэ захидлуудын хамгийн алдартай нь, зургаа эсвэл найман ширхэг байдаг. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- захидал бүрийг шилдэг сахабийгаасаа нэгэнд өгөөд илгээсэн байдаг. Орчлонгийн Хүндэт Эзнийг маань эзэн хаадад захидал бичүүлмээр байхад Асхаб-и кирам:

“–Аяа Расулаллах! Тэд захидлыг тамгагүй байхад уншдаггүй,” гэцгээв. Тэгэхлээр нь Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- мөнгөн нэгэн бөгж хийлгэв. Дээр нь гурван мөрт “Аллах-Расул-Мухаммед” үгсийг сийлгүүлээд уг бөгжийг захидалдаа тамгаар хэрэглэв.[223]

Бөгж дээр “Мухаммедүн Расулаллах” гэж бичсэн боловч, хүндэтгэх санаагаар “Аллах” хэмээн нэр хамгийн дээд, “Расул” нь дунд ба “Мухаммед” хэмээн нэр нь доод мөрт оршиж байв.

Асхаб-и кирамаас Дихъетү’л-Кэлбий -радъяллахү анхнь Бизансын импэратор Эраклид Аллахын Элчийн захидлыг хүргэв. Пэрсийг ялсан Бизантийн импэратор Эракли нь ялал-

223. Хар. Бухарий, Илим, 7; Мүслим, Либас, 57, 58; Ибн-и Са’д, I, 258.

таасаа харихдаа Сирид байсан хооронд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн Исламд урьсан захидал түүнд хүрэв. Энэ захидалд уурлахаас байтугай сонирхож ялангуяа энэ тэблигийн агуулгыг шохоорхсон Бизансын импэратор, энэ тухай юм асуухаар Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн иргэдээс заримыг хажуудаа ирэхийг хүсэв.

Тэр хооронд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хамгийн догшин дайсны нэг байсан Эбү Сүфьяан ч Маккагийн наймаачдыг тэргүүлэн Дамаскад очсон нэгэн жинд явж байв. Тэр үед Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- ба Курайш нь гэрээ хийсэн байв. Эраклигийн хүмүүс тэдэнтэй тааралдаад тэднийг импэраторын онгонд гаргав. Эракли ба алба нь Илъяа буюу Бэйтү'л-Макдист байв. Хажууд нь Римийн чухал хүмүүс байхад, Эракли тэднийг онгондоо хүлээж аваад нэгэн орчуулагч ирэхийг тушаав. Эраклигийн тушаасны дагуу орчуулагч нь:

"–Өөрийгөө пайгамбар гэсэн энэ хүний удмаас хамгийн ойр тань хэн бэ?" гэж асуув.

Эбү Сүфьяан:

"–Хамгийн ойр нь би байна!" гэв.

Тэгэхэд нь Эракли:

"–Түүнийг ба найзуудыг нь миний дэргэд аваад ир! намайг түүнтэй ярьж байхад найзууд нь хажууд нь байг!" гэв. Дараа нь орчуулагчид эргээд ингэж хэлэв:

"–Эд нарт ингэж хэл; би Тэр хүний тухай зарим юм асууна. Хэрэв худал хэлдэг юм бол надад, «Худал хэлдэг!» гэцгээг!"

Хариугаар нь "Валлахий миний найзууд намайг худал хэлснийг энд тэнд хэлэхээс ичихгүйсэн бол Түүний тухай худал

хэлэхсэн!" гэсэн Эбү Сүфьяан нь дараах яриаг ингэж дамжуулжээ:

Үүний дараа Эраклигийн надаас асуусан анхны асуулт энэ болов:

"–Та нар хэр зэрэг ойрхон ах дүүс вэ?"

Би:

"–Тэр бидний удмынхан дунд их том байр суурьтай байдаг!" гэлээ. Тэр:

"–Танаас өмнө Пайгамбар болсон саналаа хэлсэн хэн нэгэн байв уу?" гэв. Би:

"–Байгаагүй" гэлээ. Тэр:

"–Түүний овог дээдсээс хан болсон нь байв уу?" гэв. Би:

"–Үгүй!" гэлээ. Тэр:

"–Түүнийг дагагчид нь ардын тэргүүлэгчид үү, эсвэл доод ангийн хүмүүс үү?" гэв. Би:

"–Доод ангийнхан," гэлээ. Тэр:

"–Түүнийг дагагчид ихэсч байна уу, эсвэл хасагдаж байна уу?" гэв. Би:

"–Нэмэгдэж байна..." гэлээ. Тэр:

"–Тэдний дунд Түүний шашинд ороод буцаж гарсан хэн нэгэн бий юу?" гэв. Би:

"–Үгүй!" гэлээ. Тэр:

"–Үүнээс өмнө Түүнийг хэзээ нэгэн цагт худалч хэмээн буруутгаж байсан уу?" гэв. Би:

"–Үгүй!" гэлээ. Тэр:

“–Хэзээ нэгэн цагт амласандаа хүрээгүй удаа байв уу?” гэв. Би:

“–Үгүй! Хэзээ хэлсэн амандаа хүрдэг. харин бид одоо Түүнтэй хугацаат гэрээ хийсэн байна. Энэ хугацаанд юу хий-хийг нь бид мэдэхгүй!” гэлээ. Түүнийг буруутгах өөр үг олж чадсангүй! Тэр:

“–Түүнтэй байлдав уу?” гэв. Би:

“–Тийм” гэлээ. Тэр:

“–Энэ дайн яаж дүгнэв?” гэв. Би:

“–Заримдаа Тэр биднийг ялдаг, заримдаа бид Түүнийг!” гэлээ. Тэр:

“–Тэгвэл, танд юу тушаадаг вэ?” гэв.

“–Бидэнд «Зөвхөн Аллахыг шүт, ямар ч юмыг Түүнтэй үл зэрэгцүүл; өвөг дээдсийнхээ өвлүүлсэн баримал шүтээнээ орхицгоо!» гэж байдаг. Мөргөлийг, үнэнч байдлыг, ёс суртаху-унтай болоод нутагтай холбоотой байхыг тушаадаг,” гэлээ.

Тэгэхэд минь Эракли нь орчуулагчид ингэж хэлэв:

“–Түүнд ингэж хэл: Түүний удмыг асуувал, таны дунд маш өндөр удамтай буйг хэлсэн. Пайгамбарчууд угаасаа ардынхаа язгууртнуудаас сонгогддог.

Таны дундаас Түүний өмнө ийм саналтай хэн нэгэн бий юу гэж асуувал, чи үгүй гэсэн. Түүний өмнө ийм саналтай хэн нэгэн байсансан бол, түүнээс жишээ авсан гэх байлаа.

Өвөг дээдсээс нь хан байсан уу гэж асуувал; чи үгүй гэлээ. Хэрэв дээдсээс нь хан нэгэн байсансан бол, аавынхаа хөрөнгийг буцааж авахыг хичээдэг гэх байлаа.

Ийм саналаа илэрхийлэхээс өмнө Түүнийг хэзээ ч худал хэлэхийг харав уу гэж асуувал, чи үгүй гэсэн. Би хүмүүст худал хэлээгүй хүн Аллахын тухай худал хэлэхгүйг би мэднэ!

Түүнийг дагагчид ардын тэргүүлэгчдээс үү эвсэл доод төвшний хүмүүсээс үү гэж асуувал, чи доод хэсгийнх гэлээ. Угаасаа эхэнд пайгамбарчуудыг дагагчид тийм хүмүүс байдаг.

Түүнийг дагагчид нэмэгдэж байна уу, хасагдаж байна уу гэж асуувал, чи нэмэгдэж байна гэсэн. Үнэн шашны нэгэн шинж бол, дагагчид нэмэгдэж буй нь юм.

Түүний шашинд ороод гарсан нь бий юү гэж асуувал, чи үгүй гэсэн. Итгэл үнэмшлээс болж илэрсэн өргөтгөл ч сэтгэлд орж үндэс салгавал ийм л байдаг.

Хэзээ ч амласнаа алдсан удаатай юу гэж асуувал, чи үгүй гэсэн. Пайгамбарчууд ч тийм байдаг, амалснаасаа буцахгүй.

Түүнтэй хэзээ ч байлдав уу гэж асуувал, байлдсанаа ба заримдаа Тэр таныг хожоод, заримдаа та Түүнийг хожсоноо хэлэв. Угаасаа пайгамбарчууд ч ийм л байдаг: Тэд муухай байдалтай тааралдуулаад, дараа нь сайхан төгсгөл тэдний байх болно.

Танд юу тунгаасныг асуувал, чи зөвхөн Аллахыг шүтэж Түүнд ямар ч юмтай зэрэгцэхгүйг тушаасныг, барималд шүтэхийг хориглосныг, мөн мөргөлийг, үнэнч занг, ёс суртахууныг тушаасныг хэллээ.

Хэрэв чиний энэ хэлсэн нь зөв юм бол, Тэр хүн ойрдоо энэ миний хөл гишгэсэн газрыг ч эзэлнэ. Угаасаа би энэ Пайгамбар илрэхийг мэддэг байсан, гэтэл танаас болохыг таахгүй байв. Түүний онгонд хүрч чадахаа мэдвэл, Түүнтэй уулзахын тулд ямар ч бэрхшээлийг тэснэ. Түүний дэргэд байсансан бол, хөлийг нь угаах байв.”

Үүний дараа Эракли нь Дихъе -радъяллахү анх-аар Бусрагийн ноёнд илгээсэн ба өөртөө дамжуулсан Хазрат-и Пайгамбарын захидлыг нэхэв. Захидлыг авчирсан хүн түүнийг Эраклид өгөв. Эракли түүнийг уншив. Захидалд ингэж бичиж байв:

“Аллахын боол ба Элч Мухаммедаас, Римийн агуу Эраклид!..

Авралыг дагагчдад мэнд хүргэе! Би чамайг Исламд урьж байна. Исламд ороод мэнд сайхныг хүртээрэй, тэгээд Аллах чамд буяныг чинь хоёр дахин өгөх болтугай! Хэрэв эс зөвшөөрвөл, чиний ард буй тариачин хүмүүсийн нүгэл чиний хүзүүн дээр юм.

قُلْ يَا أَهْلَ الْكِتَابِ تَعَالَوْاْ إِلَى كَلَمَةٍ سَوَاء بَيْنَنَا وَبَيْنَكُمْ أَلاَّ نَعْبُدَ إِلاَّ اللّهَ وَلاَ نُشْرِكَ بِهِ شَيْئًا وَلاَ يَتَّخِذَ بَعْضُنَا بَعْضاً أَرْبَابًا مِّن دُونِ اللّهِ فَإِن تَوَلَّوْاْ فَقُولُواْ اشْهَدُواْ بِأَنَّا مُسْلِمُونَ

«Ингэж хэл: Аяа номын хүмүүс ээ! Тантай бидний хооронд дундын буй үгэнд Кэлимэ-и Тэвхидэд **ирцгээ. Аллахаас бусдыг эс шүтье; Тэрээрт ямар ч юмыг түнш зэрэгцэхгүй ба зарим маань Аллахыг орхиж өөр заримаа бурхан болгохгүй! Хэрэв царайгаа эргүүлбэл, тэгээд «Та нар гэрчлээрэй, бид мусульманчууд мөн!» гэцгээ!»** (Ал-и Имран, 64)”

Эбү Сүфьяан ингэж хэлнэ:

“Эракли хэлэхээ хэлээд захидлыг унших ажил дууссаны дараа нэгэн шуугиан гараад, дуу чагнав. Тэгээд биднийг гадагш гаргацгаав. Би найзууддаа ингэж хэлэв:

«–Эбү Кэбшэгийн Хүүгийн[224] хэрэг бүр ихсэв. Хараач, Бэний Асфарын Хан Эракли ч Түүнээс айна!..» Тэр үеэс хойш Түүний амжилтад хүрэх итгэлээ хэзээ ч алдаагүй. Тэгээд эцэст нь Аллах надад ч Исламыг хайрлаж өгөв...”

Эракли нийгмийнхээ хүндэт хүмүүсийн шүтээндээ урив. Түүний ордны нэгэнд хурцгаав. Тэдэнд:

“–Римийн нийгэм ээ! Үүрд мөнхийн авралт энэ хааны улс төр эгнэгт болохын тухай юу гэх вэ?” гэв. Тэдэнд Исламд орохыг санал болгов. Тэгэхэд нь бүгдээрээ зэрлэг илжиг шигээ үргэж хаалга руу гүйцгээв. Харин хаалга бүр хаагдсан байв. Эракли эргэн тойрны төрийн хүмүүсийг Исламд орох хүсэлгүй буйг ойлгохдоо тэднийг хойш нь дуудаж хэлсэн үгийн үнэнийг өөрчлүүлэн:

“–Би таны Христийн шашин дахь үнэнч эсэхийг үзэхээр шалгалаа. Таны энэ байдал надад таалагдлаа!” гэв. Тэгэхлээр нь төрийн хүмүүст түүнд мөргөж түүнийг шагшив. (Бухарий, Бэд’ү’л-Вахй 1, 5-6, Иман 37, Шэхадат 28, Жихад 102; Мүслим, Жихад 74; Ахмад, I, 262)

Византын Импэратор Эракли өмнө нь ирсэн Исламын шимийг өөрөө хараад яг үнэнийг ухаарсан байхдаа, дэлхийн ашиг хүнд санагдсан тул уг том завшааныг ашиглан мөнхийн төр ба жаргалыг үзэв.

Ираны Хосровт илгээсэн захидлыг ч Абдуллах бин Хузафэ -радъяллахү анх- аваачив. Харин Хосров нь Эракли шиг хандаагүй. Захидалд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн нэрийг өөрийнх нэрээс өмнө нь бичсэнд ч уур-

224. Пайгамбарын маань тухай хэрэглэсэн уг нэрийн тухай Хар. б. 1, х. 284

лаж тэр ариун захиаг урж, элчийг муу муухай үгээр дооромжлов.

Абдуллах -радъяллахү анх- нь Хосров болон түүний хамтрагчдад ингэж хандав:

"–Аяа Пэрсийн нийгэм ! Та нар пайгамбаргүй, номгүй ба дэлхийн зөвхөн таны гарт буй хэсгийг эзэлж тоот өдрөө өнгөрөөж зүүдний амьдралаар амьдарч байна! Харин дэлхийн таны эзлээгүй хэсэг нь илүү юм.

Аяа Хосров оо! Чамаас өмнө дэлхийг ба ахиратыг хүссэн олон эзэн хаан морилж удирдсан байдаг. Тэднээс ахриатыг хүсэгсэд дэлхийд ч хувиа авсан байдаг. Дэлхийг хүсэгсэд бол ахиратын хувиа алдсан байдаг. Бидний чамд санал болгосон энэ шашныг чи багасгаж байвч, валлахи хаа байсан ч багасгасан юм чинь ирэхэд түүнээс айгаад өөрийгөө хамгаалж чадахгүй!"

Хосров бол хариулан хөрөнгө ба хааны суудлаа өөртэйгөө хамаатай буйг, хожигдох буюу өөрт нь нэгэн түнш гарахаас айгаагүйгээ хэлэв. (Сүхэйлий, VI, 589-590) Дараа нь эрчүүддээ Абдуллах бин Хузафэг гадагш гаргахыг тушаав.

Абдуллах -радъяллахү анх- нь Хосровын шүтээнээс гарангуутаа унаагаа унаж Мадинагийн замд гардаг. Өөртөө:

"Валлахи, миний төлөө хоёр замаас үхэх эсвэл аврах аль нь байсан ч санаа зовохгүй. Би Расулаллахын захидлыг байранд нь хүргэж үүргээ биелүүлсэн байна," гэв. (Ахмад, I, 305; Ибн-и Са'д, I, 260, IV, 189; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* IV, 263-6; Хамидуллах, *эл-Вэсаик,* х. 140)

Абдуллах бин Хузафэ -радъяллахү анх-ын ухаан авташгүй эрдмийг ба итгэлийн зоригийг толилуулах олон сургаалаар дүүрэн нэгэн туульс байдаг:

Хазрат-и Умар -радъяллахү анх-ыг калиф байхад Дамаскын Кайсария талд Рим дээр Исламын цэргийг илгээсэн байв. Абдуллах бин Хузафэ -радъяллахү анх- ч тэдний дунд байжээ. Римчүүд түүнийг олзолж авав. Хаандаа аваачаад “Энэ нь Мухаммедын асхабын нэг!” гэцгээв.

Хан нь Хазрат-и Абдуллахыг нэгэн гэрт хаалгаад олон хоног идээ, ундаагүй хорьсны дараа түүнд жаахан дарс ба гахайны мах илгээв. Түүнийг гурван хоног ширтэв. Абдуллах -радъяллахү анх- нь дарсанд ч гахайны маханд ч ойртсонгүй. Хаанд:

“–Түүний хүзүү бүр хугарлаа, Тэндээс гаргахгүй бол үхэхнээ!” гэцгээв.

Хан түүнийг авчруулаад:

“–Идэх уухаас чамайг холдуулсан нь юу вэ?” гэж асуув.

Абдуллах -радъяллахү анх-:

“–Үнэндээ хэрэгцээ нь идэж уухыг надад зөвшөөрсөн боловч, би өөртөө ба Исламд үнэнч байлаа!” гэв.

Хан түүний ийм эрхэмсэг үйлийн хариуд:

“–Чамайг Христийн шашинд орвол хөрөнгийнхөө талыг , бас хан суудалдаа суулгаж , охиноо ч чамтай гэрлүүлбэл яах вэ?” гэв.

Абдуллах -радъяллахү анх-:

“–Чи надад Мухаммед -алэйхиссэлам-ын шашнаас нүд ирмэх зуураар халхлаад хөрөнгөө бүгдийг ба хамаг Арабын хөрөнгийг өгсөн ч би өөрийн шашнаас огт гарахгүй,” гэв.

Хан:

“–Тэгвэл би чамайг ална,” гэв.

Хазрат-и Абдуллах:

“–Тэр чиний мэдэх зүйл!” гэв.

Абдуллах -радъяллахү анх-ыг загалмайд өлгөв. Харвагчид нь эхлээд түүнийг онохгүйгээр, айлгахаар сум харвав. Дараа нь түүнд дахиад Христийн шашныг санал болгов. Тэр ариун сахабий өчүүхэн ч няцсангүй.

Хан:

“–Чи Христийн шашинд орно, эсвэл би чамайг халуун буцалсан тогоонд чанана,” гэв. Зөвшөөрөөгүйд нь зэсэн нэгэн тогоо авчруулаад, дотуур нь чидуны тос эсвэл ус хийгээд буцлав. Хан нь мусульманчуудаас нэгэн боол авчруулав. Христийн шашинд орохыг санал болгов. Боолыг энэ саналыг хүлээж аваагүйд тогоонд хаяхыг тушаав. Боол мусульманыг тогоонд хаяцгаав. Абдуллах -радъяллахү анх- түүнийг харж байв. мах нь огцом яснаас нь салж мулзрав.

Хан нь Абдуллах -радъяллахү анх-ад дахиад Христийн шашинд орохыг санал болгов. Зөвшөөрөөгүйд нь түүнийг ч тогоонд хаяхыг тушаав. Хазрат-и Абдуллах тогоо руу шидэх тэр үед уйлав. Хан түүний саналаа өөрчилсөн гэж бодоод Абдуллах -радъяллахү анх-ыг хажуудаа авчруулаад дахиад Христийн шашинд орохыг санал болгов. Хатуу үгүйсгэсэн хэвээрээ байгаад гайхан:

“–Тэгвэл яагаад уйлаа вэ?” гэж асуув.

Хазрат-и Абдуллах бин Хузафэ -радъяллахү анх- ийм гайхамшигт хариуг өгөв:

“–Чиний надад тулгах шийтгэл тамлалаас айгаад уйллаа гэж битгий бод! Би Аллахын төлөө өгч чадах ганцхан амь-

тай буйдаа уйлав. Өөртөө: «Чи одоо нэгэн амьтай байна, энэ тогоонд хаягдаж, Аллахын замд огцом үгүй болчихно. Харин үнэндээ би үснийхээ тоогоор амьтай байсан бол, тус бүрийг нь ийм тамлалыг давж Аллахын төлөө зориулахыг хүсдэг байлаа,» гэв.”

Хазрат-и Абдуллахын итгэлийн хүндээр толилуусан энэ аймшигт үйл Ханд маш их таалагдаад түүнийг чөлөөлж тавих юмсан.

“–Миний толгойг үнсвэл чамайг чөлөөлье,” гэв.

Абдуллах -радъяллахү анх-:

“–Миний хамт хамаг мусульман боолчуудыг ч чөлөөлнө үү?” гэв.

“–Тийм, чөлөөнө,” гэв. Тэгээд:

“–Одоо л болно,” гэв.

Хазрат-и Абдуллах -радъяллахү анх- ингэж хэлдэг:

“Би өөртөө: «Өөрийнхөө амийг ч мусульман боолчуудын амийг ч аврахын тулд Аллах дайсдаас нэгний толгойг үнсэхэд ямар буруу болох вэ? Үнсээд орхи!» гэлээ.”

Тэр өдөр наян мусульман чөлөөлөгдөв. Хазрат-Умарын дэргэд ирэхдээ үүнийг түүнд ярьж өгцгөөв. Хазрат-и Умар -радъяллахү анх-:

“–Абдуллах Бин Хузафэгийн толгойг үнсэх нь хамаг мусульманчуудад үүрэг болов! Үүнийг анх би хэрэгжүүлье,” гэв. Босоод түүний дэргэд очиж толгойг нь үнсэв. (Ибн-и Эсир, *Усдү'л-Габэ,* III, 212-213; Зэхэбий, *Сиер,* II, 14-15)

Уг ариун сахабий нь Аллахын Элчийн Исламд урих захидлыг Ираны Хосровт аваачих нэр хүндийг хүртсэн, эзний нэгэн

тэмдгийг хүлээсэн алуурчдын өмнө итгэлийн том зориг толилуулан Хосров ба түүний хүмүүст Исламыг тэблиг хийсэн байв.

Хосровын захидлыг урж Исламын урилгад сөрөг хандсаныг мэдсэн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Аллах минь! Чи ч түүний хөрөнгийг тиймэрхүү тархай бутархай болгох болтугай!” хэмээв. (Бухарий, Илим, 7; Ибн-и Эсир, *Үсдү’л-Габэ,* III, 212)

Тэгээд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн уг гайхамшиг нь “Хүлэфа-и Рашидийн”ий эринд хэрэгжиж Хосровын хөрсийг мусульманчууд бүрэн эзлэв.

Хосров нь Йемений дарга Базанд нэгэн бичиг илгээж Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-ыг өөртөө авчрахыг нэхэв. Базаны элч нар Аллахын Элч дээр ирэв. Байдлыг мэдүүлж нэгэн захидал гардуулав. Орчлонгуудын Эзэн захидлыг уншаад мишээв. Элч нарыг Исламд урив. Базаны элч нар Пайгамбар Эзэнд маань:

“–Хэрэв бидний хамт ирэхгүй бол, дарга Базаны захидалд нэгэн хариу бич!” гэцгээв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Аугаа Эрхийн вахийнх дагуу тэдэнд ингэж айлдав:

“–Аллах Таала нь Кисрад хүү нь Ширэвэйхийг оролцуулав. Ширэвэйх түүнийг тэр сарын тэр шөнийн тэр цаг өнгөрөхөд алав!”

Элч нар гайхан:

“–Бид Чамаас сонссон эдгээр үгсийг бичээд даргад мэдээлэх үү?” гэцгээв.

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Тийм! Надаас сонссоныг түүнд мэдээлээрэй! Мөн түүнд ингэж хэлээрэй: «Миний шашин ба улс төр минь Хосровын хөрөнгө ба улс төр хүрсэн газар очоод, адуу тэмээний хөл гишгэх хамгийн хол газар хүрэх болно!» түүнд үүнийг ч мэдээлээрэй: «Хэрэв чи мусульман болбол чиний удирдлага доорх газрыг би чамд өгнө! Чамайг Эбна буюу Йемен дэх Пэрсчүүдээс бүрдсэн арддаа эзэн болгоно!»" хэмээв.

Базан нь эдгээрийг сонсохдоо:

"–Валлахи Түүний үг нь хааны үг биш юм! Миний ойлгосноор энэ хүн, хэлсэн шигээ нэгэн пайгамбар мөн! Түүний Хосровын тухай хэлсэн үгсийн дүнг хүлээж байя. Хэрэв тэр тухай хэлсэн нь зөв гарвал, Тэр үнэхээр Аллахын хүмүүст илгээсэн нэгэн пайгамбар юм. Хэрэв хэлсэн нь зөв гарахгүй бол, Түүний тухай хэргийг бодно!" гэв. Элч нартаа эргэн:

"–Та Түүний тухай юу бодоо вэ?" гэж асуув.

"–Бид Түүнээс хүдэр ба даруй, Түүн шиг юунаас ч айдаггүй, хамгаалагчгүй ба хүмүүсийн дунд алхаж явдаг эзэн хаан харж үзээгүй! Асхаб нь Түүний дэргэд дуугаа чагнадаггүй, бага дуугаараа ярина..." гээд харснаа гайхмаар яриад эхлэв.

Ширэвэйнийн аавыгаа алсны тухай захидлыг ирэхэд, тэд нэг харвал Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн мэдүүлсэн цаг минут хүртэл таарч байв. Дарга Базан нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тухай:

"–Энэ хүн андашгүй нь Аллахын хүмүүст илгээсэн нэгэн пайгамбар мөн!" гээд мусульман болов. Үндсэндээ Пэрс боловч Йеменд суурьшсан Эбначууд ч мусульман болцгоов. (Ибн-и Са'д, I, 260; Эбү Нуайм, *Дэлаил,* II, 349-350; Диярбэкрий, II, 35-37)

Аллахын Элчийн урилгын захидал ба түүнийг авчирсан Пайгамбарын элчийг хамгийн сайн угтсан нь Абиссинийн Нэжаший болов. Амр бин Үмэйе -радъяллаху анх-аар Нэжашийд хүрсэн захидалд Исламд урихын зэрэг Хазрат-и Мэрьем ба Хазрат-и Эсүсийн тухай ч богинохон мэдээ байв. Исламыг өмнө нь Абиссинид нүүсэн мусульманчуудаас бага сага ч сурсан бөгөөд энэ тухай бүр эхнээс нь зэрэг хандсан Нэжаший нь уг захидлаар итгэл үнэмшлийн хязгаарт жигүүр дэвэв. Тэр хооронд хажууд нь байсан Эбү Талибын ууган хүү Хазрат-и Жафарын дэргэд кэлимэ-и шэхадэт авчраад мусульман болов. Дараа нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хүссэнээр, тэндэх мусульманчуудыг ч хоёр онгоцонд суулгаж илгээв. Мөн Хазрат-и Пайгамбар -саллаллаху алэйхи вэ сэллэм-д итгэж үнэмшсэнээ мэдүүлсэн нэгэн захидал илгээв. Захидал нь ийм юм:

“Аллахын Элч Мухаммед -саллаллаху алэйхи вэ сэллэм-д Нэжагаас.

Аяа Расулаллах аа! Салам Чамд болог, Аллахын энэрэл ба элбэг нь ч Чам дээр болог! Өөрөөс нь гадна өөр бурхан үгүй Аллах намайг Исламд хүргэж оруулав.

Аяа Расулаллах! Хазрат-и Эсүсийн тухай дурдсан захидал тань надад хүрэв. Газар ба тэнгэрийн Рабд тангараг өргөе, Хазрат-и Эсүс ч өөрийнхөө тухай таны дурдсанаас илүү юм хэлээгүй. Түүний тэблиг ч бүгд таны айлдсан шиг юм. Таны бидэнд тэблигт томилогдсон Исламын гол үндэснүүдийг бид сурлаа. Авга ахын таны хүү (Жафар-и Тайяр) ба бидний нутагт нүүсэн асхабыг нь зочноо болгов. Би гэрчилж байна, Чи Аллахын Элч мөн. Үгэндээ үнэнч мөн. Чи үнэн ба баталсан мөн.

Аяа Расулаллах! Би Чамд, Чиний төлөөлөгч буй авга ахын чинь хүүгээр бий'ат хийлээ. Түүний өмнө Орчлонгуудын Раб буй Аллахад бууж өглөө. Чамд хөвүүн Эрхагаа илгээж байна. Би зөвхөн өөрийгөө удирдана, хэрэв Чамд ирэхийг минь хүсвэл аяа Аллахын Элч ээ, шууд хүрээд очно. Би гэрчилж байна, хэлсэн бүхэн чинь үнэн. Аяа Аллахын Элч ээ, Чамд мэнд болог!.." (Ибн-и Са'д, I, 259; Ибн-и Кайям, III, 689; Хамидуллах, *эл-Вэсаик,* х. 100, 104-105)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- дахиад нэгэн өдөр:

"–Аяа хүмүүс ээ! Шагнал ба буяныг нь Аллахаас найдан энэ захидлыг Александриягийн Эзэн Мукавкаст[225] *хэн аваачих вэ?"* хэмээн асуухлаар, Хатиб Эбий Бэлтаа -радъяллахү анх- ухасхийн босч Эзний маань шүтээнд хүрэв:

"–Аяа Расулаллах! Би аваачна," гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Хатиб аа! Аллах энэ үүргийг чиний төлөө ариун болгох болтугай!" хэмээв.

Хатиб -радъяллахү анх- Эзний маань захидлыг Александриягийн Мукавкист аваачив. Захидалд ингэж бичсэн байв:

225. Бизантийн императорчуудын төлөө Кайсар ба Римийн Кайсар, Дерсийн эзний төлөө Кисра буюу Хосров, Абиссинийн эзний төлөө Нэжаший, Египетийн эзний төлөө Фарон, Александрын эзний төлөө Мукавкис, Йемен ба Шиххирийн эзний төлөө Түбба', Энэтхэгийн эзний төлөө Батлимус нэгэн цол хэрэглэсэн байв. Эдгээр нь нэр биш, эздэд ерөнхийд олгосон цол юм. (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* XI, 228)

"Бисмиллахиррахманиррахим.

Аллахын боол ба Элч Мухаммедаас, Кибтийчүүдийн тэргүүн Мукавкист. Авралаар сэрж, зөв замыг баригчдад мэнд хүргэе.

Чамайг Исламд урья. Чи мусульман болж, эсэн мэндийг олоод Аллах чамд буян ба шагналаа хоёр дахин өгөх болтугай. Хэрэв миний энэ урилгыг хүлээж авахгүй бол Кибтийчүүдийн нүгэл чам дээр байх болно.

قُلْ يَا أَهْلَ الْكِتَابِ تَعَالَوْاْ إِلَى كَلَمَةٍ سَوَاء بَيْنَنَا وَبَيْنَكُمْ أَلاَّ نَعْبُدَ إِلاَّ اللّهَ وَلاَ نُشْرِكَ بِهِ شَيْئًا وَلاَ يَتَّخِذَ بَعْضُنَا بَعْضاً أَرْبَابًا مِّن دُونِ اللّهِ فَإِن تَوَلَّوْاْ فَقُولُواْ اشْهَدُواْ بِأَنَّا مُسْلِمُونَ

«Ингэж хэл: Аяа Исламын хүмүүс ээ! Тантай бидний хооронд дундын нэгэн үгэнд (Кэлимэ-и Тэвхидэд) **ирцгээ. Аллахаас бусдыг бүү шүт. Түүнтэй ямарч юмыг зэрэгцүүлж болохгүй бас Аллахаас бусдыг бурхан гэж бүү бод! Хэрэв тэд нүүрээ буруулбал «Та гэрчилцгээ, бид мусульманчууд мөн!» гэцгээ!»** (Ал-и Имран, 64)"

Пайгамбар Эзний маань захидлыг уншихдаа Мукавкис нь Хатиб -радъяллахү анх-ыг дуудаж шашны хүмүүсийг ч цуглуулав. Үүнээс хойшийн Хатиб -радъяллахү анх- ингэж ярьжээ:

Мукавкис надад:

"–Ойлгомоор буй зарим зүйлсийг чамаас асууж, чамтай ярилцана," гэв.

Би түүнд:

“–Айлдаарай, ярилцъя,” гэлээ.

Мукавкис:

“–Чиний Эзэн пайгамбар биш юм уу?” гэж асуув. Би:

“–Мөн, Тэр Аллахын Элч мөн,” гэлээ.

“–Тэр нь үнэхээр ийм нэгэн пайгамбар бол өөрийгөө эх орноос нь гаргаж өөр нэгэн газар хоргодохоос аргагүй болгосон ардынхаа эсрэгээр яагаад Аллахад залбираагүй вэ?” гэж асуухад, би түүнд:

“–Чи Эсүс бин Мэрьемийн Аллахын нэгэн боол байсныг гэрчлэх биз дээ? Түүнийг үнэхээр пайгамбар байхад, ард нь Түүнийг бариад өлгөмөөр байхад, өөрийгөө дэлхийн тэнгэрт өргөснөөсөө, ардыг нь мөхөөх төлөө Аллахад залбирсан нь дээр байгаагүй юм уу?” гэлээ.

Мукавкис хэлэх үг олж чадаагүй. Түр дуугүй байсны дараа:

“–Үгээ дахиад хэл!” гэв. Би дахилаа. Мукавкис дахиад дуугүй байв. Дараа нь:

“–Сайхан хэллээ. Чи нэгэн шүүгч, ёсоор нь ярьж байгаад шүүгч хүний хажуугаас ирж байна,” гэв.

Би ч үүний дараа Мукавкист:

“–Чамаас өмнө энд нэгэн эр өөрийгөө агуу бурхан гэж зарласан байв. Аллах Таала тэр Фароныг дэлхий болон ахиратын тамлалаар барьж яллав. Чи өөрөөсөө өмнөхийг сургаал аваад өөрөө сургаал болуузай!”[226] гэлээ.

226. Энэ шинжийг шүлэгч ингэж илэрхийлнэ:
Хүн өнгөрснөөс сургаал авахгүй бол,
Ирээдүйн сургаал болох түүний ажил…

Мукавкис:

“–Бидэнд нэгэн шашин бий, түүнээс буянтыг хараагүй байхдаа түүнийг орхихгүй!” гэв.

Би бол:

“–Ислам нь чиний холбогдсон шашнаас андашгүй илүү давуу юм! Бид чамайг Аллах Таалагийн хүмүүст шашин болгож сонгосон Исламд урьж байна. Мухаммед Мустафа -саллаллахү алэйхи вэ сэллэм- зөвхөн чамайг биш, хамаг хүн төрөлхтнийг урьж байна. Тэднээс Түүнд хамгийн хатуу ба бүдүүлэг хандагсад нь Курайшчууд байв. түүнд хамгийн хатуу дайсан бол еврейчүүд болов. Хүмүүсээс хамгийн дотно хандагсад бол Христчүүд болов. Яг Хазрат-и Муса Хазрат-и Эсүсийг мэдээлсэн шиг, Тэр ч Хазрат-и Мухаммед -алэйхиссалатү вэссэлам-ыг мэдээлсэн байв. бидний чамайг Кур’анд урьсан маань, чиний Тэвратад холбоотой Инжилд урьсантай адил юм. Хүн бүр нь өөрийнхөө эринд ирсэн пайгамбарт үммэт болох хэрэгтэй юм. Чи ч Хазрат-и Мухаммед -алэйхиссалатү вэссэлам-ын эринд хүрэгчдээс мөн. Тийм болохоор бид чамайг Исламд урихдаа Эсүс -алэйхиссэлам-ын шашнаас холдуулсан болохгүй. Эсрэгээр нь Түүний номлохтой зохимжтой үйл хийхийг чинь санал болгож болно,” гэлээ.

Мукавкис:

“–Би энэ пайгамбарын шашныг шинжиллээ. Түүнд дэлхийн хэргээс гараа татахыг ч тушаахгүй, сайхан ба зохимжтой зүйлсийг ч хориглохгүй буйг харсан. Тэр нь замаа төөрөөгүй илбэчин ч биш, далдаас мэдээ авснаа санал болгосон худалч биш. Эсрэгээр нь өөртөө нууцыг нээж мэдээлэх мэтийн номлогчийн бэлгэ тэмдэгтэй байдаг. Гэвч би дахиад түр бодмоор байна,” гэв.

Дараа ч Пайгамбар Эзний маань ийм нэгэн хариу бичүүлэв:

“Бисмиллахиррахманиррахим.

Мухаммед бин Абдуллахад, Мукавкисаас.

Чамд мэнд болог! Захидлыг чинь би уншлаа. Дурдаж намайг урьсаныг ойлголоо. Дахиад нэгэн пайгамбар ирэхийг мэдээд, харин түүнийг Дамаскаас гарна гэж бодож байсан. Чиний элчийг угтаж хүндэллээ. Чамд Кибтийчүүдийн нүдэнд өндөр нэртэй хоёр шивэгчин ба хувцас хунар илгээлээ. Унуулахаар Чамд бас нэг луус бэлэглэе. Чамд мэнд хүргэе!”

Мукавкис үүнээс илүүг ч хийгээгүй, мусульман ч болоогүй. Надад ч: “Болгоомжил! Кибтийчүүд чиний амнаас ганцхан үг ч бүү сонсог!” гэж анхааруулав. (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* IV, 266-267; Ибн-и Са’д, I, 260-261; Ибн-и Хажар, *эл-Исаба,* III, 530-531)

Үүнээс үзвэл Мукавкис нь Аллахын Элчийн урилгыг сайнаар угтав. Тэр сүүлийн нэгэн пайгамбар гарахыг мэдэж байвч, түүний Дамаскын хавиас гарахыг бодож байв. Энэ бодол түүний үнэнийг дагахад хөшиг болж, Мукавкис итгэж үнэмшээгүй. Харин захидлыг авч ирсэн Хатибын хамт янз бүрийн бэлэг, нэгэн унаа ба хоёр шивэгчин (Хазрат-и Мария ба дүү нь Сийринийг) илгээв.

Хатиб -радъяллахү анх- замдаа уг хоёр дүүд Исламыг яриад тэднийг мусульман болоход урамшуулав. Тэд ч итгэлийн нэр хүндийг хүртэв.[227] Ингэхдээ Мадинад хүрэлгүй мөнхийн үнэнийг ухаарцгаав.

Хатиб -радъяллахү анх-ыг Мукавкисын үгсийг дамжуулахад Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

227. Ибн-и Са’д, VIII, 212.

"Тусгүй нөхөр, ноёны суудлаа алдахаас айв! Түүний харамласан суудал нь бол түүнд үлдэхгүй!" хэмээв. (Ибн-и Са'д, I, 260-261; Диярбэкрий, II, 38)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- шивэгчин Сийринийг Хассан бин Сабиттай, Хазрат-и Мариятай өөрөө гэрлэсэн ба хүү нь Ибрахим юм. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тэнгэрлэг хүслээр хэрэгжүүлсэн энэ гэрлэлт ч улс төрийн талаар олон ашиг бий болгожээ. Ийнхүү байдал Египетчүүдэд их эерэг нөлөөтэй болоод, дараа жилүүдэд явсан Ислам- Бизанс хоёрын дайнуудад, Египэтчүүд Бизансыг ганцаар нь орхиод Исламын цэргийн ялалтад илүү итгэмжтэй явах шалтгаан болсон байдаг.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- садан хамаатандаа хандахын сайхан нэгэн жишээг толилуулан асхабтаа ингэж айлдав:

"Та кират гэдэг хэмжүүр хэрэглэдэг Египетийг эзэлж авна. Би тэндэхийн хүмүүст сайнаар хандахыг зөвлөнө; миний гэрээсийг бариарай. Та тэдэнтэй удмаараа ч хадмаараа ч садан хамаатан болж байдаг." (Мүслим, Фэдаилү'с-Сахаба, 226-227)

Сайхан мэдэгдсэнээр нь Аллахын Элчийн удам Хазрат-и Исмаилаас үүсдэг. Исмаил -алэйхиссэлам-ын ээж Хазрат-и Хажар нь Египетийнх байсан тул Орчлонгуудын Эзэн Египетчүүдийг садан хамаатнаар тоолно. Хадмын харилцаа бол Мария эхээс маань үүсдэг.[228]

228. Ибн-и Хишам, I, 4.

Сирийн Зассаний Арабчуудын тэргүүн байсан Харис бол Шужа' бин Вэхб -радъяллахү анх-ын авчирсан Пайгамбарын захидлын хариунд ихэмсэг зангаар хандав. Түүнслэн мусульманчууд дээр дайрахаар Бизантын императороос зөвшөөрөл гуйв. Харин император үүнийг үгүйсгэв.[229]

Сэлит бин Үмэйр -радъяллахү анх-ын Пайгамбарын захидлыг аваачсан Емамэгийн Хан Хэвзэ ч тэнгэрлэг урилгыг зөвшөөрөөгүй. Түр зуурын дараа ч ийм ухамсаргүй байсаар үхээд өнгөрөв.[230]

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- илгээсэн элч нартаа анхаарах хэрэгтэй зүйлсийн тухай чухал зөвлөгөө өгсөн байв. Жишээлбэл Аллахын Элч нь Химьерт байсан хэсэг хүмүүст нэгэн захидал бичсэн байв. Захидлыг Хазрат-и Ияш -радъяллахү анх-аар илгээж байхдаа түүнд ингэж зөвлөв:

"Тэнд очихдоо шөнө битгий ор, өглөө болохыг хүлээ. Дараа нь хамгийн сайхнаар абдэбстаа аваад хоёр рэкат мөргөл үйлд. Чамайг амжилттай болгох нь ба сайхнаар хүлээж авахуулахын тулд Аллах Таалад залбир. Дараа нь бэлтгэлээ сайн хийгээд, захидлыг минь баруун гартаа авч, баруун гараараа тэдний баруун гарт өг. ингэвэл тэд чамайг хүлээж авна…"

Ияш -радъяллахү анх- ингэж хэлдэг:

"Би Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тушааснаар хийгээд, тэд Исламыг хүлээж авав. Дараах явдлууд ч Аллахын Элчийн мэдүүлснээр хэрэгжив." (Ибн-и Са'д, I, 282-283)

229. Ибн-и Са'д, I, 261.

230. Ибн-и Са'д, I, 262.

1	Дихье бин Халифа	Бизантийн хаан Ираклий	Кудс, Илия	Улсыг ээлэхээс айж Исламыг зөвшөөрөөгүй
2	Абдуллах бин Хузафэ	Хосров	Мэдаин	Пайгамбарын захидлыг урж, Аллах ч түүний улсыг урав
3	Амр бин Үмэйе	Нэжаший	Абиссини	Исламыг хүлээн зөвшөөрөв
4	Хатиб бин Бэлтэа	Мукавкис	Египет	Мусульман болоогүй, Элчид хүндэтгэж хандав
5	Ала бин Хэдрэмий	Бахрейны ван Ал-Мунзир бин Сава	Бахрейн	Мусульман болов
6	Салит бин Эмир	Йэмамэгийн ноён	Йэмамэ	Өөрөө пайгамбар болохыг нэхэв
7	Шужэа бин Вэхб	Гассаны ноён Харис эл-Гассаний	Хавран	Мадинад довтлохоор сүрдүүлэв
8	Мухажир бин Үмэйе	эл-Харис эл-Химьерий	Йемен	Мусульман болов
9	Амр бин эл-Ас	Оманы ван Жүлэнди	Оман	Мусульман болов

Энэ урилгууд Исламын Мадинагаас хамаг хорвоог тэврэх чигт анхны алхмууд болсон байв. Мөн Арабын хойгт сэрсэн Ислам өдөр тутам тарсаар явав. Учир нь том ялалтуудын суурийг Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- өөрийн ариун гараараа тавьж байв.

Еврейчүүд Пайгамбар Эзэнд маань Хараал Хийсэн нь

Еврейчүүдийн ахмадууд нь мусульман болсноо зарласан боловч мүнафикаар ханддаг ба илбэнд их авъяастай байсан еврей Лэбид бин А'самд:

"–Чи бидний хамгийн ухаантай илбэчин мөн! Мухаммед бидний эрчүүд болон эмчүүдийг илбэдэв. Бид түүний эсрэг юу ч хийж чадаагүй. Чи түүний бидэнд юу хийснийг, яаж манай шашны эсрэгээр хандсаныг, биднээс хэн алсныг эсвэл цөлснийг үзлээ. Бид хийсэн хамаг үйлийн хариунд Түүнийг илбэдэж яллахаар чамайг томиллоо!" гээд Оршигчдын Туяанд илбэ хийх тулд гурван (алтан) динар өгцгөөв.

Лэбид нь Пайгамбар Эзний маань үснээс хэдэн ширхэг аргаар хайж эхлэв. Хүссэнээ олохоор түүнд хэдэн зангиа зангидаж үлээв. Зангидаж үлээсэн энэ үсийг эрэгтэй хасарвааны цэцгийн хатсан хавтсан дотор хийв. Дараа нь түүнийг аваад нэгэн худгийн доторх шатны чулуун доор тавив. Лэбидийг илбэ-хараал хийсний дараа Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- өвдөв. Нүдний гэрэл багасав. Өвчин нь олон хоног үргэлжлэв. Идэж-уухаа байв.

Аллах Таала нь Элчдээ энэ илбийг хэн, яаж хийснийг ба хаана нуусныг зааж өгөв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хазрат-и Али ба Аммарыг Зарваны худагт илгээв. Худгийн ус улайж, хажуугийн хасарвааны моднуудын толгой ч чөтгөрийн толгой шиг болсон байв. Хазрат-и Али ба Аммар

худгийн усыг татаж хоосруулаад, доторх шатын чулууг өргөж хараалын илбийг олцгоов.

Энэ хооронд Жэбраил -алэйхиссэлам- Фэлак ба Нас хоёр сураг авчрав. Ает бүрийг уншихад нэг зангиа тайлж байв. хамгийн сүүлийн зангиа тайлахад, Пайгамбар Эзэн маань уяанаас авргадсан мэт наашлав. Хоол идэж, ус ууж эхлэв. Аллахын Элч Зарваны худгийг хаалгав. Илбэ-хараал хийсэн еврей Лэбидийн царайг ч хараагүй, энэ гэмийг нь дурдаж буруутгаа ч үгүй. Амийг нь хороохоор хандсан Лэбид болон түүнийг харъяалсан Бэний Зурайк еврейчүүдээс хэнийг ч хороосонгүй.[231]

Хазрат-и Нэбий -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэгэн өдөр:

“–Мөхөөгч долоон юмаас болгоомжилцгоо!” хэмээн айлдав.

Сахабийчууд:

“–Аяа Аллахын Элч ээ! Тэд юу вэ?” гэж асууцгаав.

Орчлонгийн Хүндэт Эзэн маань:

“–Аллахад түнш зэрэгцүүлэх, илбэ-хараал хийх, Аллахын (гар хүрэхийг) харам болсон амийг эрхгүйгээр алах, мөнгөний хүү идэх, өнчний бараан идэх, дайны талбараас зугтах, ариун ба гэмгүй эмсийг хүчирхийлэх” хэмээв. (Бухарий, Васаяа, 23; Мүслим, Иман, 145)

Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- өөр хадис-и шарифууддаа ч ингэж айлдав:

231. Хар. Ибн-и Са’д, II, 197; Бухарий, Тибб, 47, 49; Мүслим, Салам, 43; Нэсаи, Тахрим, 20; Ахмад, IV, 367, VI, 57; Айний, XXI, 282.

“Хэн нь нэгэн уяа зангидаж дараа нь түүнд үлээвэл, илбэ-хараал хийсэн байх болно. Хэн нь илбэ хараал хийвэл ширкэд унана...” (Нэсаи, Тахрим, 19)

“Хэн нь хулгайны эсвэл барааны газрыг мэдээлсэн хүн дээр (арааф дээр)[232] *очоод түүнээс юм асууж, хэлснийг баталбал, дөчин хоног тэр хүний ямар ч мөргөл хүчинтэй болохгүй.”* (Мүслим, Сэлам, 125)

Урвагч Еврейд Буулгасан Сүүлийн Цохилт: ХАЙБАРЫН ЯЛАЛТ (7 оны Сафэр-Рабиулэввэл / 628 оны 6-7 сар)

Мусульманчуудтай Таккагийн мүшрикчүүдийн хооронд хийсэн Хүдэйбиегийн Гэрээг, гаднаас харахад Исламын талын хүчгүй буйгаар ойлгосон мүнафикчуудад Хайбарын еврейчүүд ч итгэсэн байв. Хэсэг хугацааны дараа ч, өмнө нь цөлөгдсөн аймгуудаас тэдний дунд нэмэгсдийн өдөөснөөр Хайбарт муу муухайн том нэгэн гал шатав. Евречүүд нь Гатафан аймагт, хамт хөдлөхийн хариунд жилийн ургамлынхаа талыг өгөхөөр амлав. Тэдэнд Гатафан аймаг ч орохдоо хамтдаа муухай зорилтоо үйлдүүлэхээр хөдөлцгөөв. Мадинад цэрэг илгээхийг төлөвлөв.[233]

Еврейчүүдийн ийнхүү хандсанд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- асхабаасаа Абдуллах бин Рэвахаг энх тайва-

---

232. **Кахин** нь ирээдүйгээс мэдээ өгснөө санал болгосон мэргэч гэсэн утгатай юм. **Арраф** ч нэг талаараа кахин гэсэн утгатай байдаг. Гэтэл арраф гэж ихэнхдээ хулгайлсан буюу алга болсон зүйлсийн байрыг мэдээлэх хүмүүсийг л хэлдэг. Мөн **мүнэжжим** гэж байдаг бөгөөд тэр ч үнэндээ кахин мөн. Гагцхуу мүнэжжим нь болох үйлсийг оддыг хараад мэдсэнээ илэрхийлдэг.

233. Хар. Вакидий, II, 530-531, 566, 640; Ибн-и Са’д, II, 92.

ны төлөө Хайбарт илгээв. Гэтэл үгүйсгэх хариу ирэхлээр нь, асхабтаа Хайбарын Газвад гарахаа зарлан:

"–Зөвхөн жихадыг хүсэгчид л бидний хамт ирцгээг!.." хэмээв. (Ибн-и Са'д, II, 92, 106)

Дайн нь гарцаагүй болсон байв. Нөгөө талаас Мадина нь Хайбар Макка хоёрын хооронд оршдог байв. тийм болохоор мүшрикчүүдтэй хэзээ ч дайн хийвэл, Хайбар нь мусульманчуудын ард том аюулыг төлөөлж байв.

Пайгамбарын тушаалыг сонссон Асхаб-и кирам нь газвагийн урилгыг дуртай дагав. Гэтэл Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэг талаас асхабаа жихадад дуулж байхдаа, нөгөө талаас Хүдэйбиег байгаагүй хүмүүсийг цэрэгт аваагүй. Учир нь өмнө тэдний хооронд олз авах зорилгоор мүнафикчуудын хамгийн хэцүү үед хийсэн урвалтууд, цэргүүдийн итгэл үнэмшлийг   нэлээд туйлдуулж бууруулсан байв. Одоо ч тэр хүмүүс, баян еврейчүүдийн нүд гялбуулах хөрөнгөөс хувь авах санаагаар дайнд оролцохоор төлөвлөж байв. Үүний төлөө Хүдэйбиед байгсдын гаднаас ирсэн дайнд оролцох хүслийг үгүйсгэв. Угаасаа Аугаа Эрхийн тушаал ч ийм чиглэлтэй байв:

قُل لَّن تَتَّبِعُونَا

"…Аяа Элч минь ээ! Тэдэнд **ингэж хэл: Та ерөөсөө биднийг дагахгүй!.."** (эл-Фэтих, 15)

Мусульманчуудын Хайбарт очихоор бэлтгэл хийж байсан нь, Пайгамбар Эзэнтэй маань гэрээ Мадинагийн еврейчүүдийг их бодлоготой хөдлөхөд хүргэв. Тэд нар Эзний маань Кайнука, Надир ба Курайзагийн еврейчүүдийг хожсон шигээ Хайбарын еврейчүүдийг ч хожихыг ухаарав. Тэр хооронд мусульман-

чуудаас их бага авалгатай бол түүнийг авахаар итгэгчдийн явах газрыг хянаж байв. Доорхи туульс үүнийг бүр илрүүлснээр үл барам, мөн Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн боолын эрхийн тухайд хэр их чамбай хатуу байсныг ч харуулдаг:

Еврей Эбү Шахмын Абдуллах бин Хадрад -радъяллахү анх-аас таван дирхэм авалгатай байв. Абдуллах -радъяллахү анх- гэр бүлийнхээ төлөө энэ еврейгээс арвай худалдаж авсан байв. Эбү Шахмыг замд барьж авахад тэр:

“–Надад жаахан хугацаа өг. Иншааллах өрөө төлөх болно. Учир нь Аллах Таала нь Пайгамбартаа Хайбарт олзтой явахыг баталсан. Эбү Шахм аа! Бид Хижазын идээ ба хөрөнгөөр хамгийн баян хот руу явж байна,” гэв.

Еврей Эбү Шахмын атаархал ба догшин нь бүр хөөрч:

“–Чи Хайбарын еврейчүүдийг өмнө нь байлдсан Арабчууд шиг гэж боддог уу? Тэвратаар тангараг өргөе, тэнд түмэн байлдагч бий,” гэв.

Абдуллах:

“–Еэ Аллахын дайсан аа! Чи бидний хамгааллалт доор байна. Валлахи чамайг Расулаллахын шүтээнд гаргана!” гээд түүнийг Аллахын Элчийн шүтээнд авчрав:

“–Аяа Расулаллах аа! Энэ еврейг юу ярьсныг сонс!” гээд Эбү Шахмын хэлснийг мэдээлэв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- дуугүй, юу ч хэлээгүй. Зөвхөн уруул нь хөдөлж харагдаад, юу хэлснийг хэн ч дуулаагүй.

Еврей:

“–Еэ Эбү’л-Касим! Энэ миний эрхийг зөрчив, өрөө төлөөгүй,” гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Абдуллахад:

"–Түүний эрхийг өг!" хэмээн айлдав.

Абдуллах бол ядуу буйгаа, Хайбарын олзоор өрөө төлөхөө мэдүүлсэн ч, Оршигчдын Туяа Эзэн маань ижил үгсээ хоёр дахин хэлэв. Тэгэхлээр нь Абдуллах -радъяллахү анх- босоод (ayırmayalım ya da "c"den önce) зах руу явав. Нөмрөгөө тайлж, толгойн ороолтоо аваад еврейд:

"–Энэ хувцсыг минь ав!" гэв.

Еврей нь арван дөрвөн дирхэмээр худалдаж авав. Абдуллах -радъяллахү анх- үлдсэн өрөө ч төлөв. (Ахмад, III, 423; Вакидий, II, 634-635)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- цэрэгтэйгээ хөдөлсөнд, өмнө дайн бүрт болсон шигээ Аугаа Эрхэд ийнхүү залбирч аврал эрж байв:

أَللّٰهُمَّ رَبَّ السَّمَاوَاتِ السَّبْعِ وَمَا أَظْلَلْنَ وَرَبَّ الْاَرْضِينَ السَّبْعِ
وَمَا أَقْلَلْنَ وَرَبَّ الشَّيَاطِينَ وَمَا أَظْلَلْنَ وَرَبِّ الرِّيَاحِ وَمَا ذَرَيْنَ
أَسْأَلُكَ خَيْرَ هَذِهِ الْقَرْيَةِ وَخَيْرَ أَهْلِهَا وَخَيْرَ مَا فِيهَا وَنَعُوذُ بِكَ
مِنْ شَرِّهَا وَشَرِّ أَهْلِهَا وَ شَرِّ مَا فِيهَا

"Аяа долоон давхар тэнгэр ба түүний доорхийн, долоон давхар газар ба түүний доторх, шэйтанчууд ба тэдний төөрүүлснийг, салхи ба тэдний үлээсний Раб буй Аллах минь! Бид Чамаас энэ нутгийн, түүний ардыг ба дотор буй зүйлсийн буяныг гуйя! Энэ нутгийн, түүний ардын ба дотор

буй зүйлсийн муу муухайнаас Чамд хоргодоё!"[234] (Ибн-и Хишам, III, 379; Вакидий, II, 642)

Замдаа явж байхдаа мусульманчууд чанга дуугаар; "Аллахү экбэр! Аллахү экбэр! Ла илахэ иллаллахү валлахү экбэр!" гээд нэг доор тэкбир авч эхэлцгээв. Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

"Амьдаа энэрэлтэй байцгаа! Учир нь та нар дүлий нэгэнд хандахгүй байна, хандсан тань алга ч биш. Та харагч, сонсогч, (хаана байсан ч) тантай хамт буй Нэгэнд, Аллахад хандаж байна. Таны залбирсан Нэгэн, таны тус бүрт унааны хүзүүнээс ч ойр юм," (Бухарий, Дэават 50, 67; Мүслим, Зикр, 44)

Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- Хайбарт шөнө хүрээд тэнд хүлээв. Учир нь Оршигчдын Туяа Эзэн маань шөнө дайсныг ч айлгадаггүй, өглөөг хүлээдэг байв. Өглөө болохоор еврейчүүд жоотуу, хүрз ба зэгсэн сагстайгаа гадаа гарав. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг харахдаа:

"–Мухаммед, Валлахи Мухаммедийн цэрэг байна!" гээд бархираад хэрэмдээ орцгоов. Тэгэхлээр нь Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"Аллахү экбэр, Аллахү экбэр! Мөхөж яваа Хайбар! Биднийг дайсан нэгэн ардын нутагт дайраад орвол, сануулга хэлсэн тэр кафирчуудын байдал тааруу байх болно!" хэмээв. (Бухарий, Мэгазий, 38; Ибн-и Хишам, III, 380)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ордноо Гатафан Хайбар хоёрын хооронд буй Рэжийд барив. Ингээд хоёр холбоотон нэг нэгэндээ тусалж нэгдэхэд саад болж байв.

---

234. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ямар нэгэн суурьшмал газар орох болоход, тэр газрыг харангаа байнга энэ залбирлыг уншдаг байв. (Хаким, I, 614/1634)

Тэгээд Хайбарын еврейчүүдийн тусламж нэхэхээр хөдөлсөн Гатафанчууд, зам хаагдсаныг хараад айж сандрав. Ингээд дайнд ганцаараа орох ёстой болсон Хайбарын еврейчүүд ч хэрэмдээ хаагдаад байлдахаас аргагүй болцгоов.

Бүслэлт болоход ховч нэгэн хүн еврейчүүдийг өдөөхөөр худал юм ярьсан байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Еврейчүүүдэд нэгэн шэйтан ирээд «Мухаммед таны барааг авахаар л тантай байлддаг!» гэжээ. Тэдэнд «Ла илахэ иллаллах гэцгээ, үүнтэйгээр бараа болон цусаа хамгаалцгаа. Таны ахират дахь тооцоо бол Аллахтай хамаатай!» гэж дуудаарай,” хэмээв.

Еврейчүүдэд ингэж дуудав. Тэд бол:

“Мусагийн бидний дундах ном Тэвратаар тангараг өргөе, бид таны хүссэнийг ч хийхгүй, шашнаа ч орхихгүй!” гэж хариу өгцгөөв. (Вакидий, II, 653)

Бүслэлт олон хоног үргэлжлэв. Мусульманчуудын хүнс дуусах шахсан байв. Байлдах нөхцөл нь нэлээд хэцүү болов. Мусульманчуудаас шэхид бологсод, шархдагдсад нь болоод, маш олон төвөгтэй учирч байцгаав. Харин Аллахын Элч завшаан бүрт хүмүүсийг Ислам болон Аллахад урихаас татгалздаггүй байв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Исламд урих тухай хэнийг ч бага эсвэл дорой гэж үздэггүй байв. Жишээлбэл Хайбарын Ялалт болоход үүний нэгэн үлгэр жишээ илэрч, Аллахын Элч нь нэгэн еврейгийн хонийг маллаж байсан нэгэн

боолд ч Исламыг урт удаан яриад боолын авралын учир ойлгуулсан байв.[235] Энэ явдал нь ингэж хэрэгжив:

Еврейчүүдийн ахмадуудаас хүний хонийг маллаад амьдралаа авч явдаг Есар нь нэгэн өглөө хэрмийн гадаа хонио маллаж байхдаа Пайгамбар Эзэнтэй маань тааралдсан байв. Түр ярилцсаны дараа Есар Исламыг хүлээн зөвшөөрөв. Аллахын Элч түүнийг нэрийг Эслэм болгов. Дараа энэ малчин нь хонийг яах хэрэгтэйг Пайгамбар Эзнээс маань асуув. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч:



"–Тэднийг эргүүлээд хөө! Бүгдийн заавал эзэндээ очих эсэхэд санаа зовох хэрэггүй" хэмээв. Эслэм чулуу шидэж хонийг туугаад:

"–Эзэндээ харьцгаа! Валлахи үүний дараа би үүрд мөнх тантай хамт болохгүй," гэв. Хоньд хамт яваад, тэднийг залсан хэн нэгэн байгаа юм шиг хэрэмд орцгоов. Малчин ч мусульманчуудтай хамт байлдахаар хэрэм рүү алхав.[236]

235. Ибн-и Хишам, III, 398.

236. Ибн-и Хишам, III, 397-398; Ибн-и Хажар, *эл-Исаба,* I, 38-39.

Мусульман болонгуут шууд жихадад оролцсон Эслэм -радъяллахү анх- нь түр дараа шэхид болоод хүмүүс түүнийг Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д авчрав. Аллахын Элч хэсэг асхабынхаа хамт түүн рүү чиглэсэн байхдаа, гэнэтхэн нүүрээ өөр тийш эргүүлэв. Учрыг нь асуухад:

"–Одоо Хүри'л-Ийнээс хоёр эхнэр нь түүний дэргэд байна!" хэмээв. (Ибн-и Хишам, III, 398; Ибн-и Хажар, *эл-Исаба,* I, 38-39)

Мусульманчуудад нэлээд хэцүү болсон, дайралтыг нь ухраасан, туйлдаж байсанд нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь ингэж айлдав:

"–Маргааш би тугаа тийм нэгэнд өгөөд, Аллах түүний гараар дамжуулан Хайбарын ялалтыг хайрлах болно. Тэр хүн Аллах болон Элчид нь хайртай, Аллах ба Элч нь ч түүнд хайртай!"

Газвад оролцогчид нь тугийг хэнд өгөхийг бодож ярилцаад шөнийг өнгөрөөв. Өглөө болохлоор Аллах болон Элчийнх нь хайрыг хүртэх найдвараар тугийг авахаа хүссэн хамаг сахабийчууд Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн шүтээнд гүйгээд ирцгээв. Хазрат-и Умар -радъяллахү анх-:

"Би эмир болохыг тэр өдөр шиг хэзээ ч хүсээгүй. Намайг дуудна гэж найдан Расулаллахад өөрийгөө харуулахыг хичээгээд хандав," гэжээ.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- тугийг гардуулахаар Хазрат-и Али -радъяллахү анх-ыг дуудав. Хазрат-и Алигийн нүд өвдөж байсан тулд түүнийг гараар нь тулаад авчрав. Өвдөж байсан тулд хөл гишгэсэн газраа ч харж чадахааргүй байдалд байв. Хазрат-и Пайгамбар -саллаллахү

алэйхи вэ сэллэм- нь Али -радъяллахү анх-ын ийм байдлыг харахдаа түүний өвдсөн нүд рүү унших ариун амьсгаагаараа үлээв. Аллахын Арслан Хазрат-и Али Аллахын зөвшөөрснөөр сайжрав. Үүний дараа Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнд хуяг өмсүүлж тугийг гардуулан ингэж айлдав:

"–Аяа Али! Урагшаа яв! Аллах ялалтыг хэрэгжүүлтэл ийш-тийш бүү хар!"

Хазрат-и Али -радъяллахү анх- даруй хөдөлж, дараа нь зогсоод хойшоо эргэлгүй дуудав:

"–Аяа Аллахын Элч ээ! Тэдэнтэй юуны төлөө байлдах вэ?"

Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

"–Тэдэнтэй, Аллахаас өөр бурхан үгүй ба Мухаммедын Аллахын Элч буйг гэрчилтэл нь байлд. Үүнийг хийнгүүтээ -шашны хоригийг зөрчихгүй бол- цус болон бараагаа чамаас хамгаалсан байх болно. Жинхэнэ тоцоо(г нь асуух бол) Аллахад харъяалагдана. Яарахгүйгээр, боломжоороо тайвнаар тэдэн рүү дөх. Эхлээд тэднийг Исламд урь! Хэрэв энэ урилгаар чинь ганцхан хүн мусульман болсон ч, энэ нь чамд улаан тэмээ бэлэглэж өгснөөс илүү буянтай юм!.." (Бухарий, Асхабү'н-Нэбий, 9; Мүслим, Фэдаилү'с-Сахаба, 32-34; Хэйсэмий, VI, 151)

Тэр өдөр еврейчүүдийн хамгийн цуутай байлдагчид нь алагдав. Хайбар эзлэгдэв. Хайбар нь найман хэрэмтэй байв. Эднээс хоёр нь огт байлдахгүйгээр бууж өгцгөөв. Ингээд Пайгамбарын гайхамшиг хэрэгжих болов. Энэ дайнд еврейчүүдээс ерэн гурав нь алагдаад, итгэгчидээс арван тав нь шэхид болов.[237]

---

237. Сэйед Сэйфуллах нь үүнийг дурдан ингэ хэлнэ:
"Нэгэн умх талхны төлөө муухай мунхаг хүмүүсийг битгий магт; жинхэнэ мунхаглал нь энэ мөн. Хайбарын хэрэм шиг хүчтэй буй нэфсээ хожвол Хазрат-и Али шиг баатар болоорой."

Эбү Хүрэйрэ -радъяллахү анх- ярина:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хамт Хайбарын Дайнд бэлэн байцгаалаа. Мусульман болсноо хэлсэн нэгэн эрийн тухай Аллахын Элч:

«–Тэр нь галын хүмүүсийн нэг юм!» хэмээв. Дайныг эхлэх-лээр тэр хүн баатар шиг байлдаад шархдав. Асхабаас зарим нь:

«–Аяа Аллахын Элч ээ! Саяы таны галын хүмүүсээс буйг мэдээлсэн эр нь маш ширүүн байлдаад үхэв!» гэцгээв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- дахиад:

«–Тэр тамд л очоо биз!» хэмээв.

Энэ хариултын дараа мусульманчуудаас зарим нь бараг сэжигт автуулж дөхөв. Цэргийг ийм байхдаа Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-д:

«–Тэр эр нь арай үхээгүй, харин маш хүнд шархаджээ!» гэцгээв. Шөнө болоход эр нь шархны өвчнийг дийлж чадаагүй. Сэлмээрээ амиа хорлов. Үүнийг Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д мэдүүлцгээв. Тэгэхлээр нь:

«–Аллахү экбэр! Би өөрийгөө Аллахын боол ба Элч гэд-гийг гэрчлэе!» хэмээв. Дараа нь Билал -радъяллахү анх-ад, хүмүүсийн хооронд үүнийг зарлахыг тушаав:

«Диваажинд зөвхөн мусульман болсон хүмүүс л орно. Андашгүй нь Аллах энэ шашныг аргагүй хүнээр ч дэмжүүлнэ.»” (Бухарий, Жихад 182, Мэгазий 38, Кадэр 5; Муслим, Иман 178)

Хайбарын ялалтын дараа еврейчүүд өөрийнхөө хөрөнгийн хагасыг авч үлдмээр байцгаав. Ийм учраас Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь хамаг еврейчүүдийн цөллөөгүй. Хүссэн үед гаргах нөхцөлтэйгөөр энэ өгөөж хөрсөнд ажиллаж жилийн ашгийнхаа талыг өгөхөөр еврейчүүдийг болгож зөвшөөрөв. Энэ еврейчүүд Хазрат-и Умарын калиф байсан эрин хүртэл энэ байдлаараа байрандаа байцгаав.[238]

Абдуллах бин Рэваха -радъяллахү анх- нь жил бүр тэнд очдог, гарсан ургамлын хэмжээг тааж талынх үнийг тэднээс авдаг байв. Еврейчүүд нь Абдуллахыг таахдаа чамбай хандсанд дургүйцэв. Түүнчлэн нэгэнд тэдний талыг дэмжүүлэг гээд түүнд авилга өгөх юмсан. Абдуллах бин Рэваха -радъяллахү анх- тэдэнд:

"–Валлахи та надад (ингэж сөрөг хандсан учраас) Аллахын туурвисны хамгийн дургүй нь юм. Гэсэн ч миний танд дургүй буй минь танд эрх тэгшээр хандахад минь саад биш. Таны надад санал болгосон нь авилга юм. Авилга бол харам юм, бид түүнийг идэхгүй!" гэв.

Еврейчүүд нь Абдуллах -радъяллахү анх-ыг шагшиж:

"–Ийнхүү эрх тэгш ба үнэн байдлаар тэнгэрүүд ба газар эмх цэгцтэй босоо байх болно," гэцгээв. (*Муватта*, Мүсакат, 2)

Боолын Эрхийн Тухай Хатуу Чанга Чамбай Байх нь

Хайбарын олзыг, тэнд байсан байгаагүй , Хүдэйбиегийн аянд оролцогсдод хуваав. Учир нь Аллах Таала Хайбарын олзыг Хүдэйбиегийн аянд оролцсон мусульманчуудад Фэтих Сурагийн хорьдугаар аетаар амласан байв.[239]

238. Мүслим, Мүсакат, 5; Эбү Давуд, Хараж, 23-24/3007.

239. Вакидий, II, 684.

Умар бин Хаттаб -радъяллахү анх- ингэж ярив:

“Хайбарын Дайны өдөр байв. Нэбий -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн асхабаас хэсэг хүмүүс ирээд:

«–Тэр нь шэхид, тэр ч шэхид!» гэцгээв. Дараа нь нэгэн эрийн хажуугаар явж байхдаа:

«–Тэр хүн ч шэхид болжээ!» гэцгээв.

Эзэн маань -алэйхиссалату вэссэлам-:

«–Үгүй! Би түүнийг олзны бараанаас эрхгүйгээр авсан хүрэм өмссөнөөр тамд харлаа,» хэмээв.” (Мүслим, Иман, 182)

Шэхид цол авах нь маш их нүгэлийг ариутгах гавьяа алдар мөн боловч бусдын эд хөрөнгө юмыг зөвшөөрөлгүй авах, эсвэл боолоос чөлөөлөгдөнө гэсэн үг биш. Ийм учраас Пайгамбар Эзэн маань амь алдсан хүн бүр шэхид биш болохыг мэдэ-элж сахабийгийн, олзны барааг хуваагаагүй байхад тэднээс авсан нэгэн бол тамд унаад хулгайчийн өмсөн шатаж байхыг мэдүүлсэн, бөгөөд үммэтдээ сургасан байдаг.

Пайгамбар Эзэнд үйлчилдэг байсан Мид’ам гэсэн нэртэй хар арьст нэгэн боол байв. Түүнийг Рифаа бин Зэйд бэлэглэсэн байв. Эзнийг маань ачаагаа буулгаж байхад хаанаас ирсэн нь тодорхойгүй нэгэн сум оноод түүнийг алав. Мусульманчууд:

“–Еэ Мид’ам аа! Диваажин чамд мүбарак болтугай! Аяа Расулаллах аа, надад үйлчилсэн чамд ариун шэхид цол хүртэх болтугай!” гэхэд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Үгүй! Тийм биш юм. Миний биеийг хүчит гараараа барьсан Аллахад тангараг өргөе, Хайбарын өдөр олзны барааг хуваалцахаас өмнө түүний авсан нэгэн хивс нь одоо түүн дээр галаар шатаж байна!” хэмээв.

Үүнийг сонссон мусульманчууд ихээр айцгаав. Нэгэн эр Хүндэт Элч Эзэнд маань гутлын хос үдээс авчраад:

“–Аяа Расулаллах аа! Би ч олзны барааг хуваахаас өмнө гуталдаа энэ үдээсийг авсан байлаа,” гэв.

Пайгамбар Эзэн маань:

“–Чи тамд үүнтэйгээ тэнцэх шийтгэл амсах болно гэв. (Бухарий, Эйман, 33; Мүслим, Иман, 183)

Хайбарыг эзэлсэн өдөр, хэн нэгэн Пайгамбар Эзэн дээр маань ирээд:

“–Аяа Аллахын Элч ээ, өнөөдөр би маш их олзтой, ийм их ашгийг тэр хөндийгөөс хэн ч олоогүй байх ” гэв.

Эзэн маань:

“–Үүнийг хараарай! Юу юу олоо вэ?” хэмээн асуув.

Эр:

“–Би тасралтгүйгээр худалдаа хийгээд, гурван зуун укайе ашиг олж авлаа,” гэв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Чамд хамгийн буянт ашгийг би мэдээлэх үү?” хэмээн асуув.

Эр:

“–Юу вэ, аяа Аллахын Элч ээ?” гэв.

Хүндэт Нэбий Эзэн маань энэ хариултыг өгөв:

"–(Фарз) мөргөлийн дараа үйлдэх хоёр рэкат нафилэ мөргөл юм." (Эбү Давуд, Жихад, 168/2785)

Мухажирчууд Хайбарын олзноос тэдний хувьд оносон бараа ба хасарвааны талбайг авсны дараа тэдний эдийн засгийн байдал нэлээд сайжрав. Тэгээд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Энсарын тэдэнд өмнө бэлэглэсэн эсвэл ашиглахаар хадгалуулсан хасарвааны талбай болон моднуудыг Энсарт буцааж өгөв.[240]

Дэвсчүүд Мадинад Ирсэн нь

Энэ хооронд Дэвс аймгаас нэгэн хэсэг бүлэг хүн Мадинад ирэв. Эднийг тэргүүлсэн Түфэйл бин Амр нь Исламын анхны жилүүдэд Маккад ирсэн, Оршигчдын Туяа Эзэнтэй маань уулзаад мусульман болсон нэгэн байв. Дараа нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс зөвшөөрөл аваад аймагтаа харьж тэднийг Исламд урьсан байв. түүний урилгыг анх дагасан нь Эбү Хүрэйрэ Хазрат болов.[241] Дараа нь мусульманчуудын тоо ихсээд дал, ная хүрэв. Эд нар Хайбарыг эзлэх үеэр нүүж Мадинад ирцгээв. Тэндээс Хайбарт очоод Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д учирч жихадад оролцов.

Аян болоход Эбү Хүрэйрэ -радъяллахү анх- ихээр санаа зовж, яаралтай Орчлонгуудын Эзэнд хүрэхээр тэсвэргүй хандаж байв. Нэг талаас ч:

"Аяа аяны шөнө! Чиний урт ба уйтгартай байснаас би залхав!

240. Ибн-и Кайям, III, 359.

241. Ибн-и Хажар, *эл-Исаба,* II, 226.

Харин намайг күфүр ба үгүйсгэхээс аварсан нь ч Чи мөн!" гэсэн шүлгийг уншаад байв. (Бухарий, Мэгазий, 75; Вакидий, II, 636)

Эбү Хүрэйрэ -радъяллаху анх-ыг Дэвсчүүдийн хамт Хайбарт очиход Пайгамбар Эзэн маань Хайбарыг эзэлж авсан байв.[242] Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Эбү Хүрэйрэг харахдаа:

"–Чи хэний тал вэ?" хэмээн асуув.

Эбү Хүрэйрэ -радъяллаху анх-:

"–Дэвсийнх!" гэв.

Пайгамбар Эзэн маань -алэйхиссалату вэссэлам-:

"–Би Дэвсээс хэнтэй тааралдсан ч түүнээс буяныг үзэж явлаа!" хэмээв. (Тирмизий, Мэнакиб, 46/3838)

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Дэвсчүүдэд Хайбарын олзноос хувь өгөв.[243]

Абиссинийн Нүүдэлчид Харьсан нь

Хайбарыг бүрэн эзлэх үед Абиссинийг арван зургаан хүнтэй нүүдэлчид Хазрат-и Жафарын тэргүүлснээр Мадинад харив. Тэр нүүдэлчид Расулаллахын Хайбарт очсоныг мэдмэгцээ зогсолтгүй яваад Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-д хүрэв. Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм- Хазрат-и Жафарыг харахдаа:

"–Чиний байдал төрх болон ёс суртахуун надтай маш их төсөөтэй юм!" хэмээв. Дараа нь Хазрат-и Жафарын духыг үнсч:

242. Ибн-и Са'д, IV, 328.

243. Ибн-и Са'д, I, 353.

"–Хайбарыг эзэлсэн, Жафар ирсэн хоёроос алинд илүү баясахаа мэдэхгүй байна!" хэмээв. (Ибн-и Хишам, III, 414)

Жафар -радъяллахү анх- нь пайгамбарын ийм магтаалын хариуд бишрэн сандрав. Баясан хөөрч жаахан хүүхэд шиг нэг хөл дээрээ дэгдэн Оршигчдын Туяа Эзнийг маань тойрч эхлэв.[244]

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Жафар -радъяллахү анх- ыг ингэхэд нь хориглоогүй. Зарим тарикатчуудад бишрэлтийн ийм байдлыг такрир-и сүннэт гэж үзээд вэждийн учир гэж үзсэн байдаг.[245]

Абиссинийн нүүдэлчдийн хамт Йемений аймгуудаас байсан Эш'арийчууд ч Хайбарт ирсэн байв. Эд нарын нэгэн байсан Эбү Муса эл-Эш'арий ингэж хэлдэг:

"Бид Эш'арийчууд Йеменд байхдаа Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн илэрснийг мэдсэн байв. Тэгээд манай ардаас 52- 53 хүний хамт Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд очихоор замдаа гарлаа. Замд агаарын байдал эвдсэн тул, манай онгоцоо бид Абиссинийн Нэжашийгийн нутагт орхив. Тэнд Жафар -радъяллахү анх- ба түүний хамт найзуудтай нь учирлаа.

Жафар -радъяллахү анх-:

«–Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- биднийг энд илгээгээд түр энд байхыг бидэнд тушаав. Та ч бидний хамт байгаарай!» гэв.

244. Ахмад, I, 108; Ибн-и Са'д, IV, 35.

245. Мэвлэвий сургуульд зикир үйлд вэждэд орсны дараа эхэлдэг сэма ч үүнээс үүсдэг.

Эцэст нь тэндээс онгоцонд сууж замд гарав. Бүгдээрээ Мадинад ирцгээв. Хайбарыг эзэлж байхад нь Аллахын Элчид хүрцгээв. Пайгамбар Эзэн маань бидэнд ч Хайбарын олзноос хувь өгөв.” (Бухарий, Мэгазий, 38; Мүслим, Фэдаилү’с-Сахаба, 169)

Еврейчүүд Пайгамбарыг Хорлосон нь

Энэ хооронд еврейчүүд мусульманчуудаас хүн чанар ёс суртахуунаас суралцсан болович урвах нь хэвээрээ байв. Нууц нэгэн төлөвлөгөө хийгээд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг алахаар шийдэв. Энэ азгүй хүмүүс өмнөх гэмээ цайруулаагүй байхад, өөрсдийгөө бусад еврей аймгууд шиг цөллөлгүй өршөөсөн агуу Пайгамбарт тэрслэн амласандаа дахиад хүрсэнгүй.

Энэ бузар төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр еврей цэргүүдээс Харисын охин Зэйнэб нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг асхабынх нь хамт хоолонд урив. Нэгэн хонь шараад бүхлээр нь хордуулав. Эзэн маань малын даланд илүү дуртай буйг мэдээд тэр хэсгийг арай илүү хордуулав. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- махнаас өчүүхэн амсангуут буцааж гаргаад асхабтаа:

“–Энэ мах хортой гэдгийг мэдлээ, бүү ид!” хэмээв. Гэтэл асхабаас Бишр бин Бэра нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- , Хазрат-и Пайгамбар сануулахаас өмнө зажлаад залгисан байв. Бусад нь хоолонд гараа хүргээгүй байцгаав.

Их удалгүй урвагч эмэгтэйг бариад Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн шүтээнд авчрав. Пайгамбар Эзэн маань түүнээс:

“–Энэ хоолыг чи хордуулав уу?” хэмээн асуув.

Зэйнэб:

“–Хордуулсан гэж Чамд хэн хэлэв?” гэв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Энэ миний өмнө буй дал мэдээлсэн,” хэмээв.

Зэйнэб:

“–Тийм, би хордуулсан !” гээд гэмээ илчлэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- үүнийг яагаад хийснийг асуувал:

“–Чи миний аавыг, авга ахыг бас нөхрийг алав! Ард түмэн бүгдийг мэддэг.Тэр үнэхээр Аллахын элч юм бол түүнд миний хийсэн нүглийг мэдүүлж тэр хорлогдохгүй байх болно, үгүй бол тэр хордож үхээд бид тэр худалчаас өөрсдийгөө аврах болно гэж бодсон,” гэв.

Пайгамбар Эзэн маань:

“–Аллах үүнийг хийх хүчийг чамд олгоогүй юм!” хэмээв.

Эмэгтэй нь нэг талаас гэмт хэргээ илчилж байхдаа нөгөө талаас ч гэрчилсэн гайхамшгийн нөлөөгөөр итгэж үнэмшээд гэмшсэнээ илэрхийлэв. Өршөөл гуйв. Орчлонгуудад энэрэл болохоор илгээгдсэн Пайгамбар Эзэн маань өөрт нь хийсэн энэ амь хорлох үйлийг өршөөв. Харин түр дараа Бишр -радъяллахү анх-ын хорын нөлөөгөөр нас барснаар түүнээс ар гэрийнхэн үлдэгсэд хариу нэхэв. Ингээд Харисын охинд ижил хорыг уулгаад кисас буюу хариуг авцгаав.

Пайгамбар Эзэн маань -алэйхиссалату вэссэлам- ч хорын нөлөөг арилгахаар хоёр мөрийнхөө дундаас цус авахуулав. (Бухарий, Жизье, 7; Мүслим, Сэлам, 45; Ибн-и Хишам, III, 390; Вакидий, II, 678-679; Хэйсэмий, VI, 153)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- гурван жилийн дараа өөд болоход, тэр хор нөлөөлсөн гэж үздэг. (Хаким, III, 242/4966)

Мут'а гэрлэлтийн тухай

Хайбарын ялалтын үед, өмнө нь ямар нэгэн хорио зарлаагүй ба "мут'а гэрлэлт" гэдэг түр зуурын гэрлэлтийг хориглов.

Хазрат-и Али -радъяллахү анх- ингэж хэлсэн байдаг:

"Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хайбарын Газвад эмэгтэйчүүдтэй мут'а гэрлэх ба тэжээвэр илжгийн махыг идэхийг харам болгов." (Бухарий, Мэгазий 38, Никах31, Зэбаих 28, Хиел 3; Мүслим, Никах 29-32; Муватта, Никах 41; Нэсаи, Никах 71)

Мут'а нь нэгэн эмэгтэй хүнтэй, тодорхой үнээр тодорхой хугацааны гэрлэхийг хэлдэг юм. Жахилие буюу мунхаг үеэс үлдсэн гэрлэх нэгэн төрөл юм. Мут'а гэрлэлт нь өмнө нь тохирсон хугацаа дуусахаар цуцлагдана. Өв, баталгаа, гэх мэтийн энгийн гэрлэлтээр үүсдэг эрхүүд мут'ад байдаггүй. Ийм учраас Хайбарын ялалтаас эхлээд маш олон хадис-и шарифаар харам болгосон байдаг. Энэ тухай нэгэн үг ч ийм байдаг:

"...Одоо Аллах -жэллэ жэлалүхү- түүнийг Киямат өдөр хүртэл харам болгосон байдаг. Хэний дэргэд мут'а гэрлэсэн нэгэн эмэгтэй байвал, одоо түүнийг чөлөөл! Тэдэнд өгснөө буцааж авч болохгүй!" (Мүслим, Никах, 21; Ибн-и Мажэ, Никах, 44; Даримий, Никах, 16; Ахмад, III, 406)

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- Тэбүкийн Аян Дайнд байхдаа Сэнийетү'л-Вэда гэсэн газар завсарласан байв. Тэнд уйлж буй эмэгтэйчүүдийг хараад тэдний яагаад уйлсныг асуув. Хариулан:

"–Эд нар мут'а гэрлэлт хийсэн эмэгтэйчүүд юм!" гэцгээв. Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Мут'аг Исламын никах, талак, иддэт ба өвтэй хамаатай дүрэм журам нь харам болгосон байдаг!" хэмээв. (Ибн-и Бэлбан, VI, 178; Даракутний, III, 259)

Үүнээс харвал мут'а аргаар гэрлэсэн эмэгтэй нь эхнэр ч биш, шивэгчин ч биш. Мут'а нь эхл-и сүннэт эрдэмтдийн олонхын зарласнаар "зина"гийн нэг хэлбэр гэж үздэг юм.

Ибн-и Аббас -радъяллахү анхүмаа- ярихдаа:

"Исламаас өмнө мут'а байв. Хүн танихгүй нутагт ирэхдээ, тухайн нутгийн нэгэн эмэгтэйтэй, тэнд байх хугацаандаа гэрлэсэн мэт амьдрахыг никах гэдэг байв. Энэ нөхцөлд эмэгтэй нь түүний олсон зөөснийг хамгаалаад, хэрэгтэй ажлыг нь хийдэг байв. Ийм байдал:

وَالَّذٖينَ هُمْ لِفُرُوجِهِمْ حَافِظُونَ اِلَّا عَلٰى اَزْوَاجِهِمْ اَوْ
مَا مَلَكَتْ اَيْمَانُهُمْ فَاِنَّهُمْ غَيْرُ مَلُومٖينَ

«Тэд ариун нэрээ хамгаална. Харин эхнэр болон шивэгчдээсээ гадна, тэдэндтэй ойр харьцаатай буйд нь хэн ч тэднийг буруушаахгүй.» (эл-Мү'минун, 5-6) аетыг буутал үргэлжлэв. (Энэ аетыг ирэхлээр нь мут'а харам гэж зарлав.) Энэ хоёроос (эхнэр ба шивэгчин) гадны бүх харьцаа нь харам юм." (Тирмизий, Никах, 29/1122)

Мут'агийн нийгмийн аймшигт хор хөнөөл нь :

а. Хүүхдүүдийг дэмий үрэх. Энэ хүүхдүүд аавгүйгээр өсдөг тул зинагийн, хүчирхийллийн нөлөөтэй боловсролгүй өснө. Охидод энэ байдал илүү хүнд муу нөлөөтэй байдаг.

б. Мута гэрлэлт нь зөвхөн нэг үед биш олон үе удам дамжин цус ойртох нөхцөл бий болгодог. Эцэг нэгтэй хүүхдүүд гэрлэх ойр цусан төрлийн ах дүүс нэг эгч дүүсийн гэрлэх байдал бий болдог. Энэ нь цөөхөн биш олон олноор давтагдаж аюул болдог байна. Ийм гашуун жишээ маш их байдаг.

в. Олон удаагийн мут'а гэрлэлтийн хүүхдүүд өв хөрөнгө хуваалцаж чадахгүй. Учир нь тухайн эцгийн өв залгамжлагчдын тоог ч нэрийг ч орон нутгийг ч арга үгүй юм.

Мут'а никахын эцсийн үр дүн аюул нь үнэхээр маш гунигтай юм. Хэдийгээр үр өсгөж байгаа боловч тэр эмэгтэйн сэтгэл зүрх хоосон гунигтай нэр алдар нь газарт унасан, түүний хүүхдүүд ямар байх нь ойлгомжтой охид үргэлжлүүлэх болно. [246]

Хайбараас Буцахдаа

Хайбарын Ялалтын дараа Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Мадинад хоёр өдрийн зайтай байсан Фэдэкийн харангад нэгэн төлөөлөгч илгээв. Тэр газрыг байлдахгүйгээр Исламын газар нутагт нийлүүлэв.

Эцэст нь Хайбараас харих замд орших еврейчүүдийн багахан нэгэн суурин байсан Вади'л-Кураг ганц хоногт бүслэн эзлэв. Тэднийг ч Хайбарчууд шиг нутагтаа суугаад хагас төлбөр төлөгчид болгож үлдээв.

Тэймагийн еврейчүүд өөрсдөө ирээд татвар өгөхөөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-тэй гэрээ хийцгээв. Ингээд нутагтаа байх бөгөөд газар нутаг нь тэднийх болов. Энэ

246. Мут'а асуудалтай хамаатай дэлгэрэнгүй мэдээлэл авахаар Хар. Ибрахим Жанан, *Nâmus Fitnesi Mut'a,* Исланбул, 1993.

еврей аймгууд өмнө нь Хайбарын еврейчүүдтэй гэрээ хийгээд Мадина руу довтлохоор шийдвэр гаргасан байв.[247]

Хайбар ба эргэн тойрныг эзэлснээрээ, мусульманчуудын хувьд Маккагийн Ялалтын хаалга нээгдсэн гэсэн үг. Учир нь Бэний Кайнука, Бэний Надир, Бэний Курайза ба эцэст нь Хайбарын еврейчүүдийг ялсан нь хүмүүсийн нүдийг нээсэн ба, Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн амжилтад хүрнэ гэдэгт одоо хэн ч эргэлзээгүй болсон байв. Учир нь тэр үед Хижазын хамгийн баян ба хүчтэй нь еврейчүүд бөгөөд тэдний эрэлхэг зориг нь үлгэр домог болсон байв. Тэд давшгүй, нэвтэршгүй хэрэм цайзын болон үржил шимт хасарвааны талбайнуудын эзэн байв. Хамаг Арабчууд тэднийг өмгөөлж хамгаалах хүчтэй байцгаав. Гэтэл Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэднийг буулган авч чадсан нь тэдний зүрх зориг үлгэр дуурайлал хэр туйлдаж байсныг, нөхцөл байдал хэр хэцүү болж байгааг хүн бүр мэдэх болов. Ийнхүү мусульманчуудын талд салхи үлээж байв.[248]

Мөн Хайбарын Ялалтын дараа Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- нөхөр нь дайнд нас бараад бэлбэсэн болсон Сафийя эхтэй маань гэрлэв.[249] Сафийя нь Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-ыг Хайбарт ирэхээс хэдхэн хоногийн өмнө хүндэт еврейчүүдээс авч гэрлэсэн нэгэн бүсгүй байв. Гэрлэсэн шөнөдөө зүүдэндээ Мадинагийн талаас нэгэн хүн ирсэн нь, түүний нөхөр бөгөөд хилэгнэж:

“–Чи Хижазын эзэн Мухаммедад очмоор байна уу!” гээд алгадсан байв. Хазрат-и Сафийяг Аллахын Элчтэй гэрлэхэд,

247. Хар. Ибн-и Хишам, III, 391; Вакидий, II, 707, 711.

248. Хар. Вакидий, II, 729-731; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* IV, 234.

249. Ибн-и Са’д, VIII, 121-126.

тэр цохилтын мөр хэвээрээ байж л байв. Оршигчдын Туяа Эзэн маань:

“–Энэ юу вэ?” хэмээн асуухлаар нь Хазрат-и Сафийя юу болсныг ярьж өгөв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнд Исламыг яриад:

“–Бид чамайг өөрийн шашинд оруулах гэж албадахгүй ! Хэрэв чи Аллах болон Элчийг нь сонговол чамайг эхнэрээ гэж авна. Хэрэв хэвээрээ еврей болохыг сонгох болбол, чамайг чөлөөлье, чи аймагтаа харь,” хэмээв. Сафийя эх маань Исламыг сонгож итгэгчдийн эхчүүдийн тоонд оров. (Вакидий, II, 674, 707; Ибн-и Са’д, VIII, 123; Ахмад, III, 138)

Орчлонгийн Хүндэт Эзний маань хүндтэй еврейчүүдээс Хүейгийн охин Сафийятай гэрлэсэн нь Хайбарын еврейчүүдтэй ойрын харилцаа тогтоох, өс хонзон багасгах, найрамдлыг дэвшүүлэхэд маш их хувь нэмэр болсон байдаг. Сафийя эх маань еврейчүүдийн гомдол санал, хүсэлт гуйлт гэх мэт юм бүхэнд ойр дотноор хандаж, бараг тэдний жаргалын гэр бүл дэх төлөөлөгч болсон байв.

Нэгэн өдөр Хазрат-и Сафийя -радъяллахү анха-гийн шивэгчин, калиф байсан үед Хазрат-и Умарт:

“–Аяа итгэгчдийн ноён оо! Сафийя нь Бямба гаригт дуртай бөгөөд еврейчүүдтэй харилцаа нь үргэлж байна,” гэж хэлсэн байв.

Тэгсэнд нь Хазрат-и Умар -радъяллахү анх- нэгэн эр илгээж байдлыг хянав. Хүндэт эх маань:

“–Чи Бямба гаригийг асууна. Аллах түүний оронд надад Баасанг хайрласны дараа би тэр өдөрт дургүй. Еврейчүүдийн

тухай асуултыг бодвол, тэдний дунд миний садан хамаатан бий, би сила-и рахим хийж байна," гэсэн хариуг өгөв. (Ибн-и Хажар, *эл-Исаба,* IV, 347)

Сафийя эх маань дараа нь шивэгчиндээ эргэж яагаад ингэж гүтгэснийг нь асуув. Тэр бол:

"–Би шэйтаныг дагалаа," гээд буруугаа илчлэв.

Сафийя эхийн маань хариу бол түүний Исламын ёс суртахууныг хэр сайхан эзэмшсэнийг заах гайхамшигт байв. Өөрийгөө эрхгүйгээр буруушаасан энэ боолдоо:

"–Яв, чамайг чөлөөллөө!" гэв. (Ибн-и Хажар, *эл-Исаба,* IV, 347)

Үмрэтү'л-Каза (7 оны Зилкадэ сар / 629 оны 3 сар)

Жилийн өмнө ихрамаа өмссөн ч Маккагийн мүшрикчүүд зөвшөөрөөгүй тул хийж чадаагүй үмрэгийн оронд хийсэн учраас энэ үмрэг "үмрэтү'л-каза" хэмээдэг юм.

Хүдэйбиед хийсэн гэрээний хүрээнд жилийн дараа хийх үмрэгийн үе ирсэн байв. Хижрэтийн тооллын долоон оны Зилкадэ сар ирэхлээр нь Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- Хүдэйбиегийн Аянд оролцогсод бүхнийг үмрэд оролцохыг тушаав. Ардад ч бэлгэл хийхийг мэдүүлэв. Ойроос ирээд тэр хооронд Мадинад байсан Арабчууд:

"–Валлахи аяа Расулаллах, бидний идээ ч биднийг тэжээх хүн ч үгүй!" гэцгээв.

Оршигчдын Туяа Эзэн маань Мадиначуудад Аллахын төлөө хандив өгөх ба тэднийг хамгаалахыг тушаав. Тэднээс тусламжийн гараа татсаны тохиолдолд мөхөхийг нь мэдүүлэв. Мадиначууд ч:

"–Аяа Расулаллах аа! Юу ч олж чаддаггүй, юу ч байхгүй, бид хандив болгож юу өгөх вэ?" гэцгээв.

Орчлонгийн Хүндэт Эзэн маань:

"–Юу байгаагаа өгч болно. Хагас хасарваан ч байвал өг!" хэмээв. (Вакидий, II, 731-732)

Пайгамбар Эзэн маань хоёр мянга асхабынхаа хамт үмрэ хийхээр Мадинагаас хөдлөв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь дуулга, хуяг, жад зэрэг цэргийн бараа ба зуун орчим морийг ч авч явав.

Асхаб-и кирам:

"–Аяа Расулаллах! Курайш нь аянчдын зэвсгээс өөр зэвсэг авахгүй байхыг шаардсан байв!" гэцгээв.

Орчлонгуудын Эзэн:

"–Бид Харамд тэр зэвсэгтэйгээр орох биш. Харин тэднийг нэгэн довтолгооны магадлалд хажуудаа байлгана!" хэмээгээд хоёр зуун хүний хамт зэвсгийг Маккад гурван мил ойрын Батн-и Е'жэж рүү илгээв. (Вакидий, II, 733-734)

Замдаа Эбвад орцгоов. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Аугаа Эрхээс зөвшөөрөл авч ээжийнхээ булшид айлчлав. Булшийг нь гараараа засч гуниглан уйлав. Түүний уйлж байсныг харсан мусульманчууд ч нулимсаа барьж чадаагүй. Дараа нь яагаад ингэснийг асуухад Хайрт Пайгамбар маань:

"–Ээж минь надад ямар их халамжтай энэрэлтэй байсныг санаад уйллаа," хэмээв. (Ибн-и Са'д, I, 116-117)

Хүдэйбиегийн Гэрээний дагуу мүшрикчүүд Маккаг хоосруулж гурван хоног хамаг холыг итгэгчдэд орхицгоов. Өөрсдөө ч ууланд гараад мусульманчуудыг юу хийх вэ гэж сонирхон

ширтэж эхлэв. Долоон жил мэт удаан хугацааны дараа Кабаг харсан итгэгч сэтгэл бишрэлийн нэгэн дуугаар:

لَبَّيكَ، أَللّٰهُمَّ لَبَّيكَ، لَبَّيكَ لاَ شَرِيكَ لَكَ لَبَّيكَ، إِنَّ الْحَمْدَ وَالنِّعْمَةَ لَكَ وَالْمُلْكَ، لاَ شَرِيكَ لَكَ

гээд тэкбир авчирч эхэлцгээв.

Ибн-и Аббас -радъяллахү анх-ын мэдүүлснээр Хазрат-и Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-ыг Маккад ирэхэд Түүнийг Мутталибынхнаас бага хүүхдүүд угтав. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэднээс нэгийг дүүрээд, нөгөөг сундлав. [250]

Хүндэт Элч Эзэн маань Мадинагийн хижгээс болж бие өвдсөн гэсэн хов яриа гаргасан мүшрикчүүдэд тийм биш гэдгийг харуулахаар цовоо сэргэлэн хүчтэй алхаж явахыг тушаав.[251]

“Өнөөдөр өөрийгөө Курайшчуудад хүчтэй үзүүлсэн хүнд Аллах энэрэл үзүүлэх болтугай!..” хэмээв. (Ибн-и Хишам, III, 424-425)

Тэр өдрийн нөхцөл доор Мадинагаас Макка хүртэл дөрвөн зуун гаруй километр зам яваад ирсэн мусульманчууд, ядарсан боловч Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн сануулснаар үмрэгээ нэлээд ихэмсэг зан ба харууштайгаар хэрэгжүүлэв. Түүнчлэн тавафын анхны гурван тойрогт ба са’й хийж байхдаа ч өнөөдрийн хоёр баганын хооронд гүйгээд явцгаав.

250. Бухарий, Үмрэ, 13; Либас, 99.

251. Бухарий, Хаж, 55; Мүслим, Хаж, 240; Ахмад, I, 305-306.

Нөгөө талаас мүшрикчүүд холоос мусульманчуудыг ширтэж байв. Хэрвээ тэдэнд ямар нэгэн ядаргаа эсвэл сул байдал харсансан бол, өөр юм бодож мэдэх байцгаав. Харин тэд харсан амьд ба хөдөлгөөнт байдлын хариунд сандрахаас аргагүй болоод:

“–Хижиг өвчинд нэрвэгдсэн хүмүүс ийм байна гэж үү? Тэд биднээс ч амьд чийрэг юм!” гэцгээв. (Мүслим, Хаж, 240)

Мөн, тэр өдөр Билал-и Хабэшийгийн Кабагийн дээвэр дээр гараад уншсан Эзан-и Мухаммедийгийн сэтгэл хөдлөх ая нь итгэгч сэтгэлийг хөөрүүлж байхад, мүшрикчүүд сандраад үзэж байв.

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг асхабынхаа хамт таваф хийж байхад Абдуллах бин Рэваха -радъяллахү анх- шүлэг уншиж эхлэв. Хазрат-и Умар -радъяллахү анх- түүнд:

“–Чи Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн онгонд ба Аллахын Харамд энэ шүлгийг хэлсээр байх уу?” гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хазрат-и Умарт:

“–Түүнд саад битгий хий! Миний биеийг хүчит гараараа барьсан Аллахад тангараг өргөе, түүний үгс Курайшийн мүшрикчүүдэд сум харвахаас ч илүү нөлөөтэй юм. Ибн-и Рэваха, уншаад бай!” хэмээсний дараа, Абдуллахад:

لاَ إِلَهَ إِلاَّ اللهُ وَحْدَه أَنْجَزَ وَعْدَه وَنَصَرَ عَبْدَه

وَأَعَزَّ جُنْدَهُ وَهَزَمَ الْاَحْزَابَ جُنْدَه

"–Аллахаас өөр ямар ч бурхан болон шүтээн үгүй юм. Тэрээр нь цорын ганц юм. Амласнаа хэрэгжүүлэгч нь Тэр юм. Энэ боолдоо туслагч нь Тэр юм. Цэргээ хүчирхэгжүүлэгч нь Тэр юм. Хуйвалдагч аймгуудыг мөхөөгч нь ч зөвхөн Тэр юм, гэв!" хэмээн айлдав.

Абдуллах бин Рэваха -радъяллахү анх-ын ингэж хэлж эхлэхлээр нь мусульманчууд ч түүний хэлснийг дахиж давтав. (Вакидий, II, 736; Ибн-и Са'д, II, 122-123)

Гурав хоногийн дараа Мадина-и Мүнэввэрэд харихдаа хүн бүрийн царайнд өөр нэгэн баяр хөөр байв. кабагийн анхны айлчлалаа хийсэн, Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн жилийн өмнө зөгнөж мэдүүлсэн зүүд нь хэрэгжсэн байв. Энэ үнэнийг Аллах Таала нь хэрэгжсэн Хайбарын Ялалтыг зааж, удахгүй хайрлах Маккагийн Ялалтыг зарлах утгаар Кур'ан-и Кэримд ингэж мэдүүлсэн байдаг:

لَقَدْ صَدَقَ اللّٰهُ رَسُولَهُ الرُّؤْيَا بِالْحَقِّ لَتَدْخُلُنَّ الْمَسْجِدَ الْحَرَامَ إِن
شَاء اللّٰهُ آمِنِينَ مُحَلِّقِينَ رُؤُوسَكُمْ وَمُقَصِّرِينَ لَا تَخَافُونَ فَعَلِمَ مَا لَمْ
تَعْلَمُوا فَجَعَلَ مِن دُونِ ذَلِكَ فَتْحًا قَرِيبًا. هُوَ الَّذِي أَرْسَلَ رَسُولَهُ
بِالْهُدَى وَدِينِ الْحَقِّ لِيُظْهِرَهُ عَلَى الدِّينِ كُلِّهِ وَكَفَى بِاللّٰهِ شَهِيدًا

"Тангараг өргөе, Аллах элчийнхээ зүүдийг үнэн буйг илрүүлэв. Аллах хүсвэл, та нар аюулгүйгээр үсээ хуссан эсвэл тайруулсан буйгаар, айлгүй Мэсжид-и Харамд орцгооно. Аллах таны мэдээгүйг мэддэг. Үүнээс өмнө танд ойр нэгэн ялалтыг хайрлав. Шашин бүрээс давуу болгохоор

Пайгамбарыгаа авралт ба үнэн шашнаас илгээсэн нь Тэр юм. Гэрчтэйгээрээ Аллах нь давуу юм!” (эл-Фэтих, 27-28)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн асхабтайгаа хийсэн каза үмрэ нь Маккачууд дээр том нэгэн нөлөө үлдээв. Их удалгүй Курайшийн ахмадуудаас ирээдүйн Сирийг эзлэгч Халид бин Вэлид, Усман бин Талха, ирээдүйн Египетийн эзлэгч Амр бин Ас мэтийн хүмүүс итгэгчдийн эгнээнд орцгоов.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Маккагаас гарч байхад Хазрат-и Хамзагийн охин Үмамэ -радъяллахү анха- нь дагаад:

“–Агаа, агаа!” гэж дуудав. Хазрат-и Али түүний гарыг бариад Фатима -радъяллахү анха-д:

“–Ах минь, охиноо хажуудаа ав!” гэв. Мадинад ирэхдээ Үмамэг сахих тухай Хазрат-и Али, Зэйд ба Жафар -радъяллахү анхүм эжмаин- маргалдав. Хазрат-и Али:

“–Тэр миний авга ахын охин юм!” гэж байв.

Жафар -радъяллахү анх-:

“–Тэр миний авга ахын охин, мөн би түүний нагац эгчтэй сууж байна!” гэж байв.

Зэйд бол:

“–Тэр минйи дүүгийн охин юм!” гэж байв. (Хүндэт Элч Эзэн маань түүнийг Хамза -радъяллахү анх-тай дүү болгосон байв.)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Үмамэгийн нагац эгчийнхээ дэргэд байхаар шийдээд:

“–Нагац эгч нь ээжийн оронд юм!” хэмээв. Дараа нь Хазрат-и Али -радъяллахү анх- руу эргэж:

“–Чи надаас, би ч чамаас мөн!”

Жафар -радъяллахү анх- руу эргэж:

“–Чиний төрх ба зан надтай маш их төсөөтэй.”

Зэйд -радъяллахү анх- руу эргэж:

“–Чи бидний дүү ч мэвла (чөлөөт) ч мөн!” хэмээж тус бүрийг нь тус тустай шагшив. (Бухарий, Мэгазий 43, Үмрэ 3; Мүслим, Жихад, 90)

Хазрат-и Али -радъяллахү анх- ингэж хэлнэ:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Зэйдийг шагшсанд Зэйд хэт их баясч, босоод нэг хөл дээрээ Пайгамбар Эзний маань эргэн тойронд дэгдэж эхлэв. Жафарыг шагшсанд тэр ч Зэйдийн араас тэр чигээр явав. Намайг шагшсанд нь би ч Жафарыг дагаж хөөрснөөсөө нэг хөл дээрээ дэгдэж эхэллээ.” (Ахмад, I, 108; Вакидий, II, 739)

ХИЖРЭТИЙН НАЙМ ДАХЬ ЖИЛ

Пайгамбар Эзний маань Охин Хазрат-и Зэйнэб Нас Барсан нь

Хазрат-и Зэйнэб -радъяллахү анха- Маккагаас авчрахад тэмээнээс унасан тул өвдөөд дахиад сэхэхгүй байсаар. Хижрэтийн тооллын найман оны эхээр нас барав. Түүнийг Үмму Эймэн, Энсарын эмч нар Үмму Атийя ба эх маань Хазрат-и Сэвдэ болон Үмму Сэлэмэ угаацгаав. Тэр хооронд Орчлонгуудын Эзэн тэдний дэргэд очоод:

"–Түүнийг угаахдаа баруун талаас нь ба абдэстийн эрхтнүүдээс нь эхлээрэй! Ум ба сидрээр[252] сондгой тоогоор; гурав, тав эсвэл долоон удаа, хэрэгтэй гэж үзвэл илүү угаагаарай! Сүүлчийн усанд кафур хийгээрэй! Угаах үйлийг дуусахад надад мэдүүлээрэй!" хэмээв.

Хазрат-и Зэйнэбийн үсийг самнацгаав, гуравт хувааж тус бүрийг нь нэгэн сүлжээ болгоцгоов. Сүлжээ хоёр нь Хазрат-и Зэйнэбийн хоёр талаас, нэг нь өмнөх талын үснээс байв. Угаал дуусахад нь Аллахын Элч нуруундаа уясан хормойгоо тэдэнд өгөөв:

252. **Сидр:** Арабстанд ургадаг, өргөн сүүдэртэй, нарийн ба хөнгөн нэгэн төрлийн тооч мод юм. Сидр модны навчаар шарил угаана. (Асим Эфэнди, *Камус*, II, 385)

“–Үүнийг Зэйнэбт дотуур цамц болгоорой!” хэмээв.[253] (Бухарий, Жэнаиз, 9, 13, 17; Мүслим, Жэнаиз, 36; Ибн-и Са’д, VIII, 34-36)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- оршуулах мөргөлийг үйлдүүлсний дараа гунигтайгаар булшнаас уруудав. Түр хүлээсний дараа баяртай гадаа гараад:

“–Зэйнэбийг хүчгүй буйг бодоод түүнд булшийн төвөг ба илчийг хөнгөлөх тулд Аллахад залбирлаа. Аллах Таала энэ хүслийг минь хүлээн зөвшөөрч булшийн төвгийг түүнд хөнгөлөв,” хэмээв. (Ибн-и Эсир, *Усдү’л-Габэ,* VII, 131)

Сахабий Бичсэн Домог: МҮТЭГИЙН ДАЙН (Жэйшү’л-Үмэра) (8 оны Жэмазиелэввэл сар / 629 оны 8-9 сар)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн Исламд урихаар захидлаар эзэн хаад болон дээдэст илгээсэн элч нар, очсон газрын хаад тэдэнд сайнаар хандаагүй байсан ч, “Элчид төвөг үзүүлж болохгүй” гэсэн зарчмаар мэнд сайхан Мадинад буцаж байв. Харин эд нараас Бумрагийн ноёнд очсон Харис бин Үмэйрийн явдал ийм болоогүй. Харис -радъяллахү анх-ыг Мүтэд хүрэхэд Гассаний ноёдоос Шурахбил бин Амр замыг нь хааж хааш явж буй нь асуув. Харис -радъяллахү анх- нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн элч буйгаа хэлэх-лээр, азгүй харгис Шурахбил нь, элчийн тархан буй зарчмыг зөрчин, тэр ариун сахабийг энэрэлгүйгээр шэхид болгов.[254]

253. Сүннэт буй кэфэн буюу шарилын ороолт нь эрэгтэй хүнд хормой, цамц ба ороолт болоод гурван хэсэг байдаг. Эмэгтэйчүүдэд бол хормой, толгойн алчуур, ороолт, хөх болон хэвлийг нь уях нэгэн даавуу ба цамц таваас бүрддэг.

254. Вакидий, II, 755; Ибн-и Кайям, III, 381.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Хазрат-и Харисын ингэж шэхид болсонд ихээр санаа зовов. Исламын эсрэг ил нэгэн довтолгоо байсан энэ үйл мусульманчуудыг үл тоох утга агуулсан тул, даруй гурван мянган цэрэг бэлтгэв. Эс тэгвээс Мадинагийн Ислам гүрний нэр хүнд балраад, муу үр дүн гарч мэдэх байв.

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь мунхаг үеийн ангийн ялгааг нураасан Исламын түгээмэл дүрэм журмыг дагаж, чөлөөлсөн боол нь Зэйд -радъяллахү анх-ыг бэлдсэн цэргийг тэргүүлэх даргаар томилов. Дараа нь ийм зааварчилгаа хэлж өгөв:

"Хэрэв байлдаанд Зэйд шэхид болбол Жафар дарга болно! Жафар ч шэхид болбол, Абдуллах бин Рэваха цэргийн дарга болно! Тэр ч шэхид болбол, мусульманчууд хоорондоо зөвлөн хэн нэгийг даргаа болгохоор шийдэцгээг!.."

Энэ үгсийг сонссон нэгэн еврей нь зааварчилгааг нас барах зар гэж үнэлэв. Дараа нь Хазрат-и Зэйд -радъяллахү анх-ын дэргэд очоод:

"–Гэрээслэлээ бич! Хэрэв Мухаммед пайгамбар бол, чи Түүний дэргэд харьж чадахгүй! Учир нь Бэний Исраилын пайгамбарчуудын нэрийг нь дурдсан хүмүүс ч дайнд үхээд, амьд харьдаггүй байцгаав..." гээд энэ шилдэг хүний зүрхэнд айдас унагаахыг хүссэн ч Хазрат-и Зэйд -радъяллахү анх- үүнийг тоогоогүй. Харин ч баясав. (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* IV, 238)

Тэр өдөөн хатгагч еврей нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хамаг асхаб нь шиг Хазрат-и Зэйд -радъяллахү анх-ын ч шэхид болох хүслээр шатсаар байсныг мэддэггүй байв.

Бэлтгэлээ хийсэн Абдуллах бин Рэваха -радъяллахү анх- нь сарнайн царайг үгүйлэх Аллахын Элчийн дэргэд ирээд салах ёс хийсний дараа:

“–Аяа Расулаллах аа! Надад цээжилж тогтоож чадах юм зөвлөөрэй,” гэв.

Пайгамбар Эзэн маань түүнд:

“–Чи маргааш Аллахад маш ховор мөргөдөг нэгэн нутагт очно. Тэнд мөргөлөө нэм,” хэмээв.

“–Аяа Расулаллах аа! Надад жаахан сургаал үг хэлээрэй!” гэв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Аллахыг байнга дурд! Учир нь Аллахыг дурдах нь найдсандаа хүрэхэд чамд туслагч байх болно!” хэмээв. (Вакидий, II, 758)

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- цэргийг Мадинагийн гадаа байсан “Сэнийетү’л-Вэда” гэсэн газар хүртэл үдэж залбираад дайсан дээр илгээв. Харисын алагдсан газар хүртэл яваад, тэнд буй хүмүүсийн Исламд урихыг, Исламыг хүлээж аваагүй тохиолдолд Аллахаас тусламж гуйж тэдэнтэй байлдахыг тушаав.[255]

Исламын цэргийн хөдөлгөөний мэдээг авсан харгис Шурахбил ч Бизансын дэмжилгээр зуун мянгат нэгэн хүч бэлтгэв. Христийн шашинтай Арабчуудаас зуун мянгат нэгэн хүч ч ирээд тэдэнд нэмэгдэв.[256]

255. Ибн-и Са’д, II, 128.

256. Ибн-и Хишам, III, 429.

Дайсан ийм өнөд байсны мэдээг Исламын цэрэг Сирийн нутагт орсны дараа л мэдэж амжив. Ийм юмыг бодоогүй тул хоорондоо зөвлөлцөв. Ихэнх нь байдлыг Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-д мэдүүлж Түүнээс ирэх заавры дагуу хандахыг дэмжиж байв. Учир нь хоёр талын хүч нь зүйрлэхийн аргагүй зөрөөтэй байв. Түүхэнд ийм нь харагдаагүй байв. Ийм учиртай тэднийг бараг байдлыг Аллахын Элчид мэдүүлэх тухай санаа нийлэх гэж байхад Абдуллах бин Рэваха:

“–Одоо бидний татгалзсан зүйл нь үнэндээ замд гарсан зүйл биш үү? Бид дайсантай тооны их ба хүчний давуугаараа байлдаад байдаг уу? Үгүй! Бид Аллахын хайрласан энэ шашны хүчээр байлддаг. Юунд хүлээж байна вэ; биднийг хүлээсэн нь хоёр гоё дүнгээс нэгэн юм: шэхид болно, эсвэл ялалтаар газий болно!”

Тэгэхлээр нь байлдах шийдвэр гаргаад замдаа хурдан үргэлжлэв.

Зэйд бин Эркам -радъяллахү анх- ингэж ярина:

“Би Абдуллах бин Рэвахагийн нэгэн өнчин байлаа. Мүтэгийн аянд гарахдаа намайг ч тэмээндээ ачуулсан байв. Шөнө түр явсны дараа энэ шүлгийг уншсаныг сонслоо:

«Тэмээ минь ээ! Намайг болон ачааг минь, элстийн худагт хүрээд дараа нь дөрвөн буудал цааш аваачвал, чамайг өөр аянд гаргахгүй! Чи эзэнгүй ба чөлөөт байх болно! Би, магадгүй гэр бүлдээ харихгүй! Шэхид болно гэдэгт найдна! Мусульманчууд ирээд, миний үүрд мөнх энд үлдэх хүслээр Дамаскын хөрсөнд булна. Одоо хасарваан нь илэрсэн, бороонд усалсан моднуудыг ч, усанд ханасан, ёроолоор нь усалсан хасарвааны моднуудыг ч тоохгүй!»

Энэ шүлгийг сонсоод би уйллаа. Абдуллах -радъяллахү анх- намайг ташуураар цохиж:

«–Сахилгагүй минь! Аллахын надад шэхид цол олгох ба чамайг мал дээр, барааны дунд харих нь чамд ямар аюултай юм бэ? Ингээд би энэ дэлхийн асуудал ба гунигаас аврагдсан байх болно!» гэв.

Шөнө буугаад хоёр рэкат мөргөл үйлдэв. Мөргөлийн дараа урт удаан нэгэн залбирал хийгээд:

«–Энэ аянд бурхан минь надад шэхид цол хайрлаач!» гэв.” (Ибн-и Хишам, III, 431-432; Вакидий, II, 759)

Мүтэ тосгонд алган чинээ Исламын цэрэг нь Хазрат-и Зэйдийн тэргүүлэн нүд цавчилгүй дайсны өөд дайрав. Тэвхидэд хайртайчууд одоо ч Аллахын замд амиа өгөгчид тэмдэг олоод байв. Дайнд бүр улайрсан Аллахын Элчийн нүдний хараа ба Маккагийн анхны найман мусульманаас нэгэн байсан дарга Зэйд -радъяллахү анх- нь дайсны жадаар шэхид болов.

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тушаасны дагуу тугийг Жафар -радъяллахү анх- барьж авав. Тэр ч баатар шиг дайсны дунд дайрав. Сэлэм цавчсанаар хоёр гараа алдав. Расулаллахын далбааг унагаахгүйн тулд шархтай гараараа түүнийг цээжиндээ ороохыг хичээв. Удалгүй шэхид болов. Хазрат-и Жафар -радъяллахү анх- нь Аллах ба Элчийнх нь хайраар хөөрсөн байдалд байв. Тэгээд өнө замд амиа үрээд тэнгэрлэг тааламжийг хүртэв.

Одоо Абдуллах бин Рэвахагийн ээлж болов. Тэр ч ижил өөрийн хүслээр тугийг бариад дайсны өөд хийсгэв. Амиа магадгүй гэж хажуугийн хүмүүс гэрээслэл хэлэв:

“–Та нар гэрч болоорой, Мадина дахь хамаг хөрөнгөө бэйтүлмалд үлдээлээ!”

Дараа нь шэхид болтлоо баатарлаг байлдав. Абдуллах бин Рэвахаг ч шэхид болохлоор нь, дөнгөж мусульман болсон бөгөөд анх удаа Исламын эгнээнд дайнд оролцсон Хазрат-и Халид бин Вэлид -радъяллахү анх- нь далбааг бариад байлдааныг үргэлжлүүлэв. Алган чинээ сахабийгийн хамт царцааны сүрэг шиг өнөд байсан дайсанд том эсэргүүцэл үзүүлэв.

Тэр хооронд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- мэсжидийн суудлаасаа явдлын хамаг шатыг мөч мөчөөр нь асхаб-и кирамд дамжуулан ярьж байв. Дайны талбай нь түүний нүдний өмнө байв. Тэнд дараалалтай хэрэгжсэн шэхадэтуудыг, гунигтайгаар ингэж мэдээлж байв:

“Зэйд бин Хариса далбааг гардаж авав. Шэйтан шууд түүний дэргэд ирэв. Амьдрал болон дэлхийг түүний хөөрхий, үхлийг ч харуулав. Зэйд бол:

«–Энэ хором нь итгэгчдийн зүрхэндээ итгэл үнэмшлээ улам бэхжүүлсэн хором юм! Чи бол надад дэлхийг хайрлуулмаар байна!» гээд урагшлав. Байлданд ороод эцэст нь шэхид болов. Түүний төлөө Аллахаас өршөөл гуйгаарай.”

Дараа нь ингэж үргэлжлэв:

“Тэр одоо диваажинд ороод, тэнд гүйгээд байна! Дараа нь далбааг Жафар авав. Шэйтан шууд түүний дэргэд очив. Амьдрал ба дэлхийг хөөрхөн, үхлийг ч муухай шиг харуулах юмсан. Жафар бол:

«– Энэ хором нь итгэгчдийн зүрхэндээ итгэл үнэмшлээ бэхжүүлсэн хором юм!» гээд урагшлав. Дайсны цэрэгт дайрч, байлдаад эцэст нь тэр ч шэхид болов. Би түүний шэхид болсонд гэрчилнэ.”[257]

257. Ибн-и Умар -радъяллахү анхүмаа- ингэж хэлдэг:

Дараа нь:

“Дүүгийнхээ төлөө Аллахаас өршөөл гуйгаарай. Тэр шэхид болоод диваажинд оров. Одоо тэр диваажинд маргад хоёр далавчтай хүссэнээрээ ниснэ,” хэмээв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“Жафарын дараа далбааг Абдуллах бин Рэваха авав!” гэсний дараа түр дуугүй болов. Энсарын царай нь хувиран шарлав. Абдуллах бин Рэвахагийн Аллах болон Элчид нь таалаглахгүй нэгэн юм хийж байсныг бодож эхэлцгээв. Тэр хооронд Хазрат-и Абдуллах бол тугийг аваад мориндоо мордон дайсны өөдөөс дайрч байхдаа, нэг талаас танхай нэфсийгээ хожихоор оролдож байв.

“–Нэфс минь ээ! Би чамайг үгэндээ оруулахаар тангараг өргөлөө. Чи үүнийг эсвэл өөрөө дагана, эсвэл чамайг хүчээрээ би дагуулна! Миний харснаар чи диваажинд нэг их дургүй юм! Чи чинь бие гэсэн тулман дотор нэгэн дусал ус байснаас өөр юу юм бэ? Нэфс минь ээ! Чамайг одоо алахгүй бол, үхэхгүй юм уу? Хэрэв тэр хоёр хүний хийснийг хийгээд шэхид болохыг сонго-вол, зөв ажил хийсэн байх болно! Хэрэв оройтвол аз жаргалгүй байх болно!”

Энэ хооронд хуруу нь шархдагдсан Абдуллах -радъяллахү анх- мориноосоо бууж, шархтай хуруугаа хөл доороо тавьж:

“Бид Жафарыг хайв. Түүнийг шэхидчүүдийн хооронд олов. Шарилынхаа өмнө талд ер гаруй сум ба жадны шарх тооллоо. Араас бол ямар ч шарх аваагүй байв.” (Бухарий, Мэгазий, 44)

Жафар -радъяллахү анх- шэхид болохдоо гучин гурван настай байв. (Ибн-и Хишам, III, 434) Үүнээс үзвэл Абиссинид очоод Нэжашийгийн онгонд ухаан, эрдэм ба зоригтойгоороо ярихдаа арван долоон насны залуу байв.

“–Чи ерөөсөө ханаж буй нэгэн хуруу биш юм уу? Мөн энэ осолд Аллахын замд орсон байна!” гэсэн утгын шүлгийг унша-ад гараа хурдан татаад унжиж санжигнасан хурууны холбоосыг таслав. Дараа нь байлдахаа үргэлжлүүлэв. Нэг талаас дайсны эсрэг жижиг жихад хийж байхдаа нөгөө талаас нэфсийнхээ эсрэг их жихадаа үргэлжлүүлж байв:

“–Еэ нэфс минь ээ! Хэрэв чи эхнэрээ алдах тулдаа санаа зовсон бол, одоо түүний гурван удаа иж бүрэн салсан байна. Хэрэв боолчуудаас хол байх тулдаа бол, тэднийг ч чөлөөлөв. Үгүй, хэрэв талбай тариалан үгүй болох тулд бол тэднийг ч Аллах болон Элчид нь орхиж хандив болгоё.”

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм-дайсны үзвэрийг дамжуулаад байв:

“Абдуллах бин Рэваха зоригоо чангалан, гартаа далба-аг барьсаар, дайсантай байлдаад шэхид болов. Эсэргүүцсэн буйгаар диваажинд оров. Түүний төлөө ч Аллахаас өршөөл гуйцгаа!” хэмээв.

Абдуллах -радъяллахү анх-ын диваажинд эсэргүүцсэн буй-гаар орсон нь Энсарт маш хэцүү санагдав:

“–Аяа Расулаллах аа! Түүний эсэргүүцсэн нь юу байв?” гэж асууцгаав.

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Өөрөө шархдаад дайсантай байлдахаар зүтгэв. Дараа нь нэфсээ буруушааж, зоригоо хурааж шэхид болов! Диваажинд оров. Тэднийг надад диваажинд алтан суудал дээр харагдав. Абдуллахын суудал найзуудынхаас доош ба тахир буйг би харлаа. Учрыг нь асуувал:

«–Абдуллах байлдаанд орохдоо зарим эрмэлзэл өнгөрөөсөн, дараа нь байлдаанд орсон байв!» гэцгээв,” хэмээв.

Хазрат-и Абдуллахын шэхид болоод диваажинд орсонд Энсар хөөрч санаа амрав.

Эдгээрийг дахжуулсан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн сэтгэлийн гуниг нэмэгдэж нэмэгдэж ариун нүднээс нь сувдан ширхэг шиг нулимс гоожиж эхлэв. Дараа нь:

“Одоо далбааг Аллахын сэлмүүдээс нэгэн сэлэм барьж авав. Эцэст нь Аллах мүжахидчуудад ялалтыг хайрлав,” хэмэ-эв. (Бухарий, Мэгазий, 44; Ахмад, V, 299; III, 113; Ибн-и Хишам, III, 433-436; Вакидий, II, 762; Ибн-и Са’д, III, 46, 530; Ибн-и Эсир, *Үсдү’л-Габэ,* III, 237)

Дараа нь нулимстай нүдээрээ тэнгэр өөд гараа дэлгэн:

“Аллах минь! Халид нь чиний сэлмүүдээс нэгэн сэлэм юм. Та түүнд тусламж хайрлагтун!” хэмээн залбирав. (Ахмад, V, 299)



Халид бин Вэлидийн Удирдах Мэдэл

Хазрат-и Хадид бин Вэлид нь орой болоод цэрэг нь харьтал дайныг төгс төгөлдөр удирдав. Шөнө нь дайчдын байршлыг бүрэн солив. Баруун гарыг зүүнд, зүүн гарыг баруун тийш, өмнөхүүдийг хойш, хойшхиудыг урагш авав. Дараах өдөр дайсан ингэж өөрчлөгдсөнийг хараад сандрав. Өмнө байгаагүй зүс царайнуудыг хараад мусульманчуудад дэмжих хүчин иржээ гэж ойлгон нэлээд тэвдэв. Аллахын сэлэм Хазрат-и Халид -радъяллахү анх- ч энэ байдлыг зөв сайхан үнэлж, ширүүн довтолгоо хийв. Ийм дайралт болно гэж бодоогүй байсан дайсан нь итгэл үнэмшлийн үерийн өмнө тэсч чадаагүй. Эвдрэх ялагдах шинж тэмдэг үзүүлж эхлэв. эцэст нь ухрахаас өөр аргагүй болов.

Тэр өдөр гарт нь нийт есөн сэлэм бутарсан Хазрат-и Халид -радъяллахү анх-[258] энэ завшааныг ч ашиглан өөрөө ч дайсанд мэдрүүлэхгүйгээр цэргээ ухраав. Энэ шийдвэр хөдөлгөөн нь, түүний цэргийн суут удирдагч болохыг батлах хоёр дахь үйл болов. Ингээд хоёр талын цэрэг нэг нэгээ хожихгүйгээр байлдахаа байснаар ухарсан байв. Хазрат-и Халид -радъяллахү анх- олон хүн алдахгүйгээр цэргээ Мадинад авчрав. Долоон хоног үргэлжилсэн дайнд шэхид бологсдын тоо нь арван дөрөв байв. Дайснаас алсан нь бол маш олон байв. Мусульман цэрэг нь хажуудаа их-багагүй олз ч авчирсан байв. (Вакидий, II, 764, 768; Ибн-и Са'д, III, 407)

Пайгамбар Эзэн маань мусульманчуудад:

258. Халид бин Вэлид Хазрат ингэж хэлэв:
"Тангараг өргөе, Мүтэ Дайны өдөр миний гарт есөн сэлэм хугарав. Зөвхөн Йемений бараа, өргөн иртэй нэгэн сэлэм тэвчив." (Бухарий, Мэгазий, 44)

"–Цуглараад дүү нараа угтаарай!" хэмээн айлдахлаар, хэт халуун өдөр байсан ч хамаг мусульманчууд цугларав. Аллахын Элч ч унаагаа унаад мүжахидчуудыг уггахаар гарав. Хүүхдүүд тэднийг дагахад Оршигчдын Туяа Эзэн маань:

"–Хүүхдүүдийг сундлан суулгаж аваарай! Жафарын хүүг надад өгөөрэй!" хэмээв. Абдуллахыг аваад өмнөө суулгав. (Ахмад, V, 299; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* IV, 244)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хазрат-и Халидын энэ амжилтыг шагшив. Мадинад харьсан байлдагчдыг -явдлыг бүрэн мэдээгүй тулдаа- "зугтагсад" гэж нэрлэсэн хүмүүст Аллахын Элч өөрөө:

"–Тэд Аллахын замд байлдахаас зугтагсад биш, дахин дахин дайраад байлдагч болох хүмүүс юм!" хэмээн хариу өгөв. (Ибн-и Хишам, III, 438; Вакидий, II, 765)

Учир нь энэ дайнд тоогоор маш бага цэргээр том нэгэн хүчийг бүрэн сүрдүүлсэн байв. Аллахын мэдүүлсэн энэ агуу үнэн хэрэгжсэн байв:

كَم مِّن فِئَةٍ قَلِيلَةٍ غَلَبَتْ فِئَةً كَثِيرَةً بِإِذْنِ اللّٰهِ وَاللّٰهُ مَعَ الصَّابِرِينَ

"…Тоогоор бага олон анги нь Аллахын зөвшөөрлөөр олон тоот олон ангийг ялсан байдаг. Мэдээж **Аллах нь тэвчигчдийн хамт мөн."** (эл-Бакара, 249)

Мүтэгийн Дайн нь эхл-и китабаас буй Христчүүдтэй хийсэн Исламын анхны дайн болов. Гурван мянга хүнтэй итгэлийн хүчит нь зуун эсвэл хоёр зуун мянгат төөрөгч хүчийг хожиж яллаа.

Хазрат-и Жафарын хань Эсма бинт-и Үмэйс ингэж хэлнэ:

“Жафар ба андууд нь шэхид болоход, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- бидний дэргэд ирэв. Тэр өдөр би дөчин арьс элдсэн байв. Талхны гурилаа зуурсны дараа хүүхдүүдийнхээ нүүрийг угаасан, үсийг нь самнаж тосолсон байлаа. Аллахын Элч надад:

«–Аяа Эсма! Жафарын хүүхдүүд хаана вэ?» хэмээв. Тэднийг элгэндээ тэвэрч, үнсч үнэрлэв. Тэр хооронд нүднээс нь нулимс урсаж эхлэв:

«–Аяа Расулаллах аа! Аав ээж минь чамд золиос болог! Яагаад уйлж байна вэ? Яагаад миний хүүхдүүдэд өнчдөд хандсан шигээ хандаж байна вэ? Эсвэл Жафар ба найзуудаас нь гашуун мэдээ ирээ юү?» гэлээ.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Тийм! Тэд өнөөдөр шэхид болцгоов!» хэмээв.

«–Ёо эзэн минь! Ёо Жафар минь!» гээд би орилж эхлэв.

Оршигчдын Туяа босоод охин Фатимагийнхаа дэргэд очив:

«–Жафарын гэр бүлд хоол хийгээрэй! Тэд өнөөдөр тохиолдсон зовлонд гашуудаад завгүй байна,» хэмээв.”

Жафар -радъяллахү анх-ын гэрт гурван хоног хоол авааачив. Орчлонгуудын Мөнхийн Хүндэт нь Жафарын гэрт гурван хоног очоогүй, тэднийг өөрийнхөөр нь орхив. Дараа нь тэдний дэргэд очоод:

“–Одоогоос хойш миний дүүг битгий уйлуулаарай! Өнөөдрөөс хойш дүүгийнхээ хүүхдүүдийг би хамгаална!” хэмээв.

Хазрат-и Жафарын хөвүүн Абдуллах -радъяллахү анхүмаа- ингэж хэлнэ:

“Аллахын Элч биднийг ангаахай шиг гэртээ авчраад:

«–Надад нэгэн үсчин дуудаарай!» хэмээв. Үсчин ирээд бидний үсийг тайруулав. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- гараа өргөн:

«Аллах минь! Жафарын гэр бүлийг буянаар залгаамжил! Абдуллахын гарыг худалдаанд азтай болго!» хэмээн залбираад үүнийг гурав дахив.

Ээж минь ирэхэд би үүнийг түүнд ч яриад өгөв, тэр ихээр баясав. Хүндэт Элч Эзэн маань түүнд:

«–Чи энэ хүүхдүүдийн аж ахуй ба хүмүүжлийн тухайд санаа бүү зов! Дэлхийд ч ахиратад ч тэднийг би хамгаална!» хэмээв.” (Ахмад, I, 204-205; Эбү Давуд, Тэрэжжүл, 13/4192; Ибн-и Хишам, III, 436; Вакидий, II, 766; Ибн-и Са’д, IV, 37)

Абдуллах бин Жафар -радъяллахү анх- нь Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тэдэнтэй дотно байсныг заасан ийм сайхан дурсамжаа үлдээжээ:

“Би сайн санана; би ба Хазрат-и Аббасын хоёр хөвүүн нь Күсэм ба Үбэйдуллахтай бага байхдаа нэгэн өдөр гудамжид тоглож байлаа. Аллахын Элч нэгэн морьтой бидний дэргэд гарч ирэв. Намайг зааж:

«–Үүнийг надад өргөөд өг!» гээд намайг өмнөө дүүрэв. Күсэмийг ч зааж:

«–Үүнийг ч бас!» гээд. Түүнийг ч ардаа сундлав.

Аллахын Элчийн авга ах Аббас -радъяллахү анх- хүүхдүүдийнхээ дунд Үбэйдуллахад Күсэмээс илүү хайртай

байв. Тийм байсан ч Расулаллах -алэйхиссалатү вэссэлам- авга ахаа бодолгүй Күсэмийг сундлав. Дараа нь гурван удаа толгойг минь илээд илэх бүртээ:

«Аллах минь! Жафарын хүүхдүүдийг Чи хамгаал!» хэмээн залбирав."[259] (Ахмад, I, 205; Хаким, III, 655/6411)

Үнэн Ирээд Төөрөг нь Нурав: МАККАГИЙН ЯЛАЛТ
(8 оны Рамазан сарын 20 / 630 оны 1 сарын 10)

Мадинагийн мусульманчуудтай Маккагийн мүшрикчүүдийн хооронд хийсэн Хүдэйбие Гэрээний дагуу энх тайвны хугацаа арван жил байв. Харин мүшрикчүүдийг Исламыг өдөр тутам Арабын хамаг хойгоор тарахад дургүйцээд байв. ийм учраас аажим аажмаар энх тайвны зүйлсийг зөрчиж эхэлцгээв. Цаг өнгөрөх тусам энх тайвны зүйлсийг үл тоох байдал бүр ихсэв. Хүдэйбие Гэрээний дараа 17-18 сар орчим хугацаа өнгөрсөн байхад, өөрсдийгөө дагасан Бэний Бэкир аймгийг өдөөж мусульман буй Хузаачууд руу дайруулав. Тэдний дундаас зарим нь ч энэ бузар хүн алах үйлд оролцов.[260]

Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-д холбоотой байсан Хузаа аймаг нь, довтлоход мөргөл үйлдэж байв. Харгис нэгэн дайралтаар зарим нь мөргөж, зарим нь бөхийж, зарим нь босоогоороо шэхид болов. Түүнчлэн Харамд хоргодсон ч Курайш ба Бэний Бэкирчүүд тэр газрын харамыг зөрчиж хүн

259. Хадисыг дамжуулагчдаас нэг нь ингэж хэлнэ:
"Би Абдуллах бин Жафараас асуув:
«–Күсэм дараа нь яасан бэ?» Тэр ч:
«–Шэхид боллоо,» гэв. Тэгэхлээр нь би:
«–Аллах ба Элч нь илүү буянтыг хамгийн сайн мэддэг,» гэлээ. Тэр ч:
«–Тийм!» гэв. (Хаким, III, 655/6411)

260. Ибн-и Хишам, IV, 4; Бэйхакий, *Дэлаил,* V, 6.

алсаар явав. Энэ байдлыг даруй Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д мэдүүлэв.[261]

Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-ыг өөрт нь гашуун мэдээллийг авчирсан Амр бин Салим -радъяллахү анх-ыг сонсч байхад ариун нүднээс нь шүүрсэн сувдан ширхэг шиг нулимс нь сарнайн царайг нь гутааж байв. Пайгамбарчуудын Хаан Эзэн маань хэтэрхий гунигтай болсон байв. Шархадсаны сэтгэлтэй сахабий Амр бин Салимдаа тайтгаруулах үүднээс:

"–Чи тусламжийг хүртэв, еэ Амр!" хэмээв. (Ибн-и Хишам, IV, 12; Вакидий, II, 784-785)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь юу болсон ч мүшрикчүүдтэй хоорондоо хийсэн гэрээг тоож, Хузаачуудад хийсэн довтолгооноос болж Маккачуудад эхлээд нэгэн элч илгээв. Учир нь тэд Хүдэйбиегийн Гэрээг маш хүндээр зөрчсөн байв. Үүнээс харвал алагдсан Хузаачуудын мөнгийг төлөх, эсвэл Бэний Бэкир аймгийг хамгаалахаа байх, эсвэл энэ хоёр саналыг ч зөвшөөрөхгүй тохиолдолд Хүдэйбие Гэрээг хүчингүй гэж тоолох ёстой байв.

Нүдэнд нь цус ба өшөө хурсан алуурч мүшрикчүүд нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн мэдээлсэн энэ гурван саналаас сүүлийн зүйл буюу гэрээг албаар цуцлахыг зөвшөөрөв.[262] Харин энэ нь мусульманчуудыг Маккагийн Ялалтад урих гэсэн утгатай байв.

Мүшрикчүүд нь дараа нь ухаан орсон байвч, хугацаа нь өнгөрсөн, гэрээг хоёр тал цуцалсан байв. энэ байдлыг засахаар Курайшийн тэргүүн Эбү Сүфьяан нь аргагүй ба хэт гэмшсэн байхдаа Мадинагийн замд оров. Түүний энх тайвныг дахих

261. Ибн-и Хишам, IV, 11; Вакидий, II, 783.

262. Вакидий, II, 787.

зорилгоор Маккагаас гарсныг, Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэнгэрлэг вахийгаар тэр мөчид асхабтаа мэдүүлэв.[263] Угаасаа дайралтад хүн алах үйлд бүр түгшсэн байсан Мадинад, Эбү Сүфьянд хэн ч царай өгөөгүй. Жишээлбэл Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн эхнэрүүдээс Үммү Хабиба нь Эбү Сүфьяны охин байсан боловч, гэрт нь хүрээд ирсэн аавын суух гэсэн дэрийг доороос нь татаад авав. Эбү Сүфьяан сандран:

"–Миний охин, дэрийг надад зохисгүй гэж үзээ юү, намайг дэрэнд зохимжгүй гэж үзээ юү?" гэж асуув.

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хайранд мөнхийн болсон Үммү Хабиба эх маань ингэж хариулав:

"–Энэ дэр нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д харьяалагдана. Ийм учраас чи бохир нэгэн мүшрик буйгаараа түүн дээр суухад зохимжгүй!"

Эбү Сүфьяан сонссон үгэндээ итгэхгүйы хөшиж үлдэв:

"–Миний охин, чи биднээс салсны дараа нэг сонин болсон байна!" гэв.

Харин Үммү Хабиба:

"–Үгүй, Аллах намайг Исламтайгаар хүндлэв," гээд итгэл үнэмшлийн бүхнээс дээр буй агуу үнийг нь сануулав. (Ибн-и Хишам, IV, 12-13)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- түрүүлэн хамаг асхабын үзүүлсэн ийм хандлагатай тааралдсан учраас Маккад харихаас аргагүй болсон Эбү Сүфьяан нь түүнийг эргэж тойр-

263. Ибн-и Хишам, IV, 12.

сон Маккачуудад энх тайвны боломж арга үгүйг ярихдаа сандарснаа нууж ядан:

“–Би зүрх нь ганц нэгэн зүрхэн дээр буй нэгэн ардын хажуугаас ирж байна. Валлахи, тэднээс ашиг олно гэж найдаж байсан бага-том, эм-эр хүн бүртэй яриад, харин ямар ч дүгнэлт олж чадсангүй!” гэж байв. (Абдүррэззак, V, 375)

Энэ хооронд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- аяны байдлаар тушаал буулгав. Ойрын аймгуудыг Мадинад дуудаж байхдаа, холынхныг бол байрандаа хүлээгээд, цэргийн замд нь оролцохыг зааварчлав. Хэтэрхий нууцаар хөдөлж байцгаав. Дайсныг Мадина дахь ийм халуун үйлээс сэжиггүйн тулд бол Сирийн тийш нэгэн анги илгээсэн Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- бүх талыг бат хянаж байв. Аугаа Эрхийн тусламжтайгаар том ялалтыг цусгүйгээр дүгнэх хүсэлдээ шахаж байв. Ийм учиртай стратегийн олон арга хэмжээ авсан байв:

Эхлээд асхабтаа аянд бэлтгэхээ тушаасан ч хааш явахыг нууц байлгаж зорилтоо тайлбарлаагүй.[264] Түүнчлэн хамгийн дотно найз ба нууц мэдэгч нь Эбү Бэкир -радъяллахү анх- гэсэн ч Макка руу явахыг ойлгоогүй, өөрийнхөө охин Расулаллахын эхнэр Хазрат-и Аиша -радъяллахү анха-гаас аян хааш болохыг асуусан байв. Тэр ч:

“–Мэдэхгүй. Магадгүй Бэний Сүлэйм дээр, магадгүй Сакифчуудад магадгүй Хэвазинчууд руу явах байж мэднэ!” гэсэн байв. (Ибн-и Хишам, IV, 14)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Маккачуудын ямар нэгэн дайны бэлтгэл хийхгүй ба энх тайвны замаар ялалтыг хэрэгжүүлэх тулд замуудыг хаалгасан, Маккад ямар ч

264. Ибн-и Са’д, II, 134.

мэдээлэл ба тагнуул очиход завшаан боломж олгоогүй ба ингэж залбирсан байв:

"Аллах минь! Нутагт нь гэнэтхэн очтол, Курайшийн тагнуул ба мэдээлэгчдийг барь, тэднийг харахааргүй ба сонсохоорогүй болго. Кцрайшийн нүдийг уя, тэгээд тэд намайг гэнэт өмнөөсөө харж олог." (Ибн-и Хишам, IV, 14)

Пайгамбар Эзнийг маань Мадинагаас хөдлөхөд ч, дахиад Курайшчуудыг андуурахаар эсрэг тийш холбоот аймгуудаар очоод, дугуйвтар нэгэн зам дагаад зорилтынхоо юу байсны тухай балархай байдлыг бүр ихэсгэсэн байв. Маккагийн хавьд хүрэхдээ цэрэг тус бүрийн тустай нэгэн гал түлж сэтгэлийн нөлөөгөөр олон тоотой ирсний санаа төрүүлсэн нь ч ийм учиртай байв.[265]

Дахиад ижил зорилтоор, микатын цэг байсан Зүлхулэйфэд ихрамаа өмсөлгүй, аяны чиглэлийн тухай балархай байдлыг үргэлжлүүлсэн байв.[266]

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- хүчийг олсны дараа, энэ хүчийг хүмүүсийг алаад орнуудыг эзлэхээр биш, тэдний сэтгэлийг Аллахад нээх, жинхэнэ жаргал буюу авралтад хүрэхийг нь хангахаар хэрэглэсэн байдаг. Учир нь Тэр орчлонгуудад энэрэл ба аврал болохоор илгээгдсэн нэгэн "Энэрлийн Пайгамбар" байв.

Аллах Таала мусульманчуудын дайн ба энх тайвны тухай тус ойлголтыг ает-и кэримэд ингэж илэрхийлсэн байдаг:

الَّذِينَ إِن مَّكَّنَّاهُمْ فِي الْأَرْضِ أَقَامُوا الصَّلَاةَ وَآتَوُا الزَّكَاةَ
وَأَمَرُوا بِالْمَعْرُوفِ وَنَهَوْا عَنِ الْمُنكَرِ وَلِلَّهِ عَاقِبَةُ الْأُمُورِ

265. Хамидуллах, I, 264-265.

266. Нэби Бозкурт, *ДИА,* "Макка" зүйл, XXVIII, 557.

“Биднийг итгэгчдэд дэлхий даяар улс төрийн засаг хүч гардуулаад өгөхөд, тэд мөргөлөө үнэнчээр үйлдэнэ, зэкатаа өгнө, сайн сайхныг тушааж муу муухайг хориглоно. Хамаг үйлсийн үр дүн бол зөвхөн Аллахад л харьяалагдана.” (эл-Хаж, 41)

Хамаг асхаб-и кирам хазарат нь энэ нууцыг дагаж байхад, Бэдирийн газийчуудаас Хатиб бин Эбий Бэлтаа нь Маккад үүнийг мэдүүлэх нэгэн захидал бичээд нэгэн эмэгтэйгээр илгээсэн байв. Үүнийг Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- вахийгаар мэдээд, эмэгтэйн байгаа газрыг айлдаж, Хазрат-и Али, Зүбэйр ба Микдад -радъяллахү анхүм эжмаин-ыг тэр эмэгтэйг барьж авчрахаар томилов. Эмэгтэй нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн заасан газар баригдав. Дээрх нь захидлыг аваад Расулаллахад авчрав. Захидалд ингэж бичиж байв:

“Еэ Курайш аа! Аллахын Элч, тан дээр маш бодон хүчээр ирээд, шөнийн харанхуй шиг энэ цэрэг нь үер шиг урсах болно. Аллахад тангараг өргөе, Расулаллах тан дээр ганцаараа ирсэн ч Аллах Түүнд таныг хожуулан, амалснаа хэрэгжүүлэх болно. Одоогоос өөртөө аврах арга олцгоо!” (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* IV, 278)

Үнэндээ энэ үгс нь үнэний эсрэг ч, урвах санаатай байгаагүй. Харин нууц байх хэрэгтэй нэгэн үнэнийг дайсанд илрүүлж байв. Ийм учраас Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- энэ үйлийг хийсэн Хатибыг даруй дуудаж асуув:

“–Хатиб аа! Яагаад ингэсэн бэ?”

Бэдирийн газийчуудаас байсан Хатиб нь том нэгэн гэмшилтэйгээр:

"–Аяа Расулаллах аа! Таны дэргэд буй Мухажирчуудын гэр бүлийг Маккад хамгаалах хүмүүс бий. Харин надад тийм хүмүүс үгүй. Би ч захидлаараа тэдний талархлыг олоод гэр бүлээ, хүүхдүүдээ хамгаалах гэсэн юмсан. Эс тэгвээс валлахи би тэдний тагнуул биш. Би энэ үйлийг шашнаас халах мэтийн муу санаагаар ч хийгээгүй. Мусульман болсны дараа би ерөөсөө күфүрийг зөвшөөрөхгүй. Валлахи миний Аллах болон Элчид нь итгэл үнэмшил минь дуусашгүй юм. Ерөөсөө шашнаа сольсон биш..." гэв.

Тэгэхлээр нь энэрлийн далай байсан Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Хатиб өөрийгөө зөв хамгаалав," хэмээж түүнийг өршөөв.

Хатибын хүзүүг цавчмаар байсан Хазрат-и Умарт ч Аугаа Эрхийн Бэдирийн Дайнд оролцогсдын хийсэн алдааг өршөөснийг сануулан ийн хариулав:

"–Харин тэр Бэдирийн Дайнд оролцов. Магадгүй Аллах Таала Хазратын Бэдирийн хүмүүсийн байдлыг мэдсэн тулдаа: «Хүссэнээ хийцгээ, та нарыг өршөөлөө!» хэмээн айлдсныг санахгүй байна уу." (Бухарий, Мэгазий, 9; Мүслим, Фэдаилү'с-Сахаба, 161)

Гэтэл Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэр хооронд буусан уг ает-и кэримэнүүдийн дагуу, Аллахын дайсантай найрамдаж болохгүйг, Хатибаас эхлээд хамаг асхаб-и кирамдаа зарлав:

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُوا لَا تَتَّخِذُوا عَدُوِّي وَعَدُوَّكُمْ أَوْلِيَاء تُلْقُونَ

إِلَيْهِم بِالْمَوَدَّةِ وَقَدْ كَفَرُوا بِمَا جَاءكُم مِّنَ الْحَقِّ يُخْرِجُونَ

الرَّسُولَ وَإِيَّاكُمْ أَن تُؤْمِنُوا بِاللَّهِ رَبِّكُمْ إِن كُنتُمْ خَرَجْتُمْ جِهَادًا
فِي سَبِيلِي وَابْتِغَاء مَرْضَاتِي تُسِرُّونَ إِلَيْهِم بِالْمَوَدَّةِ وَأَنَا أَعْلَمُ بِمَا
أَخْفَيْتُمْ وَمَا أَعْلَنتُمْ وَمَن يَفْعَلْهُ مِنكُمْ فَقَدْ ضَلَّ سَوَاء السَّبِيلِ

“Аяа итгэгчид ээ! Хэрэв Миний замд байлдааад миний тааламжийг олохоор гарсан байвал, Миний ч дайсан, таны ч дайсан буй хүмүүст хайраа үзүүлэн, нууцаар өрөвдөөд анд олуузай! Тэд бол танд ирсэн үнэнийг үгүйсгэсэн байдаг. (Тэд) **таныг Раб Аллахдаа итгэн үнэмшсэн тулд Пайгамбарыг ч таныг ч нутгаас тань гаргацгаав. Би таны нууц болгосныг ч илрүүлснийг ч маш сайн мэдэгч мөн. Танаас хэн ч ингэвэл** тэднийг андаа болговол, **зөв замаас төөрсөн байх болно.**

إِن يَثْقَفُوكُمْ يَكُونُوا لَكُمْ أَعْدَاء وَيَبْسُطُوا إِلَيْكُمْ أَيْدِيَهُمْ وَأَلْسِنَتَهُم
بِالسُّوءِ وَوَدُّوا لَوْ تَكْفُرُونَ. لَن تَنفَعَكُمْ أَرْحَامُكُمْ وَلَا أَوْلَادُكُمْ
يَوْمَ الْقِيَامَةِ يَفْصِلُ بَيْنَكُمْ وَاللَّهُ بِمَا تَعْمَلُونَ بَصِيرٌ

Үүнийг мэдээрэй **хэрэв тэд таныг гартаа оруулбал, танд өшөөт хандаж, танд гар болон хэлээ муугаар уртасгана. Угаасаа** тэд, андашгүй нь таны итгэл үнэмшихээ байж **үгүйсгэхийг л хүсдэг.** Үүнийг ч мэдээрэй **Киямат өдөр таны садан хамаатан ба хүүхдүүд танд ашиг олгохгүй. Учир нь, Аллах та нарыг салгана. Аллах таны хийснийг харагч мөн.”** (эл-Мүмтэхинэ, 1-3)[267]

267. Бухарий, Тэфсир, 60.

Энэ ает-и оэримэнүүдээр мусульманчуудын хүүхэд, эд бараа мэтийн учраар кафирчуудтай анд болохыг нь хориглосон байдаг. Жишээлбэл Хазрат-и Нух -алэйхиссэлам-ын хөвүүн Кэнан нь итгэж үнэмшээгүйчүүдийн хооронд байсан тулд мөхсөн байв. Тэр чигээр нь Лут -алэйхиссэлам-ын эхнэр ч төөрөгчидтэй хамт хандсан тул өөрөө төөрсөн ба тэнгэрлэг хохирол хүртсэн байдаг. Тийм учраас тэдний нэгэн пайгамбартай биеэрээ ойр байсан нь ямар ч үнэ цэнэ агуулаагүй байв.

Хижрэтйин найм дахь жилд Рамазан Сарын аравны өдөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- түмний содон цэргийн хамт Мадинагаас салав. Жихад дээр байсан тулдаа мацгийн ам нээх хоолоо замдаа идэв. Асхабтаа ч тэгэхийг тушаав.[268]

Жүфхэ гэсэн оронд хүрэхдээ Хазрат-и Аббастай тааралдав. Өмнө нь мусульман болсон Аббас -радъяллахү анх- нь үүнийг нууж Маккад үлдсэн, тэндээс Курайшийн байдлыг байнга Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д мэдээлсэн байв. Маккад суугаад байсны өөр нэгэн учир ч, түүний хариуцлага байсан хажийчуудад ус тараах үүргээ хэрэгжүүлэх байв. Эцэст нь цаг болсныг бодоод тэр ч нүүхээр гэр бүлийнхээ хамт замд гарсан байв.[269] Үүнд маш их баяссан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Намайг пайгамбарчуудын сүүлч байсан шиг, чи ч Мухажирчуудын сүүлч боллоо!..” хэмээв. (Али эл-Муттакий, XI, 699/33387)

268. Бухарий, Мэгазий, 47.

269. Ибн-и Хишам, IV, 18.

Маккаг Эзлэхээр хийсэн энэ агуу аяны хугацаанд гайхалтай нэгэн зураг гарсан байв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн цэрэг үер шиг урсч байв. Арабстаны бүх талаас шинээр мусульман болсон аймгууд нь цувран ирж Исламын цэрэгт нэмэгдэж байв. Бараг махшэрийн цуглалт болж байна гэмээр юм. Орчлонгуудын Эзэн энэ гайхамшигт цэргийн хамт Арж гэсэн орноор хөдөлж Талуб руу явж байхад, замд үр төлөө хөхүүлж буй нэгэн нохой харав. Шууд асхабаасаа Жухайл бин Сүракаг дэргэдээ дуудаж түүнийг энэ нохой болон гөлгийг мануулахаар босгов. Эх нохой ба зулзагуудыг нь ялалтын баяраар өнгөрж буй Исламын цэрэг үргээхгүй байхыг анхааруулан тушаав.[270]

Хүн төрөлхтний түүх энэрлийн ийм учралтай өмнө нь хэзээ ч тохиолдсон болов уу?[271]

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Маккагийн Ялалт шиг түүхийн талаар чухал нэгэн эргэлтийн цэг буй том нэгэн явдалд ч магадгүй дэлгэрэнгүй жижиг зүйл гэж тоолууштай хамгийн нарийн хэрэгтэй оролдсон, өөрийгөө эх нохой ба түүний зулзаганд хариуцлагатай мэдэрсэн шиг байв. Тийм болохоор үүнээс бидний авах өөр нэгэн хичээл ч, удирдах орон эзэмшсэн хүмүүсийн ч хамгийн нарийн зүйл хүртэл нь бүхнээс

270. Вакидий, II, 804.

271. Ийм байхад Исламын хэсэг дайсан нь агуу Исламыг манай эринд хүний гутамшгаас нэгэн буй терор гэсэн үгтэй хамт хэрэглэдэг болов. Гэтэл терор ба анархизм нь зүрх сэтгэлгүй байдал дээр байгуулсан бөгөөд, тэдэнд ёс суртахуун шиг агуу мэдрэмж хэзээ ч хэрэг үгүй байдаг. Ислам бол төрсөн өдрөөс эхлээд бүх төрлийн терор ба анархизмийн эсрэг хандсан бөгөөд байнга итгэгч байсан ч байгаагүй ч хүн бүрийн, түүнчлэн амьд амьгүй хамаг оршигчдын эрх ба хуулийг хамгаалахыг зарчим болгосон байдаг. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хорин гурван жилийн номлох хугацаа нь терортой байлдаж өнгөрсөн байдаг.

хариуцлагатай буйгаа ухаарах ба магадтай явдалд байнга бэлэн байх ёстой юм.[272]

Тэр хооронд Маккачууд юу болж буйг мэдэхгүй байцгаав. Исламын цэргийн тэдний нутагт нэгэн буудлын зайтай буй Мэррү'з-Захран Хөндийд буусныг мэдээд, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тушаалаар анги бүрийн тус тусдаа гал түлснээр илэрсэн гайхамшигтай үзэсгэлэнг харахдаа айснаасаа санаа алдацгаав.

Эбү Сүфьяан дэмжигчид нь байсан Хаким бин Хизам ба Бүдэйлийг дагуулаад эргэн тойрныг сонирхож хянахаар Маккагаас гарсан байв. Исламын цэргийн түлсэн олон мянган галыг хараад гайхацгаав. Тэдний ямар улс эсвэл аймаг байсныг таахыг хичээцгээв. Харин тэнд буугсдын Пайгамбар Эзэн маань болон асхаб нь байж мэдэх нь ерөөсөө тэдний санаанд ороогүй юм. Макка нь бүх талаар нь хүрээлсэн тул, Эбү Сүфьяан ба түүний дэргэд хүмүүсийг их удахгүй бариад Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд авчрав.[273]

Хазрат-и Умар -радъяллахү анх- нь Эбү Сүфьяаны алах шийдвэр гаргахыг хүлээж Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн эргэн тойронд алхаж байхад, авга ах нь Аббас -радъяллахү анх- ч түүнийг өршөөхийг гуйж байв. Улс төрийн ижилгүй суут ухаанаараа дайны гайхалтай тактик ашиглаж байсан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- авга ахдаа хандан:

272. Шүлэгч Мэхмэд Акиф Эрсой нь Хазрат-и Умар -радъяллахү анх-ын удирдагчийн гайхамшигт хариуцлага мэдрэмжийг шүлгэндээ маш сайхан илэрхийлсэн байдаг.

273. Бухарий, Мэгазий, 48.

“–Эбү Сүфьяныг аваад цэргийн нэвтрэх газар хүргэж өгөөрэй! Исламын цэргийн гайхамшгийг үзүүл!” хэмээв.

Энэ бол Курайшийн тэргүүн Эбү Сүфьяныг, мүшрикчүүдийн эсрэг дэмий хичээхийг саад хийх нэгэн сэтгэл зүйн бэлтгэл гэсэн утгатай байв. Ингээд мүшрикчүүд нь эсэргүүцэхгүй бөгөөд, цус асгахыг ч саатуулсан болох байв.

Хазрат-и Аббас -радъяллахү анх- Эбү Сүфьяныг дагуулан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн заасан газар аваачив. Тэр хооронд Исламын цэрэг хөдөлж, анги ангиараа урагшилж байв. Анги бүрийн итгэл үнэмшилтэй зүрхнээс цалгисан итгэл бишрэлтйн (اَللّٰهُ أَكْبَرْ) дуу нь тэнгэр өөд өгсч байв.

Ийм үзвэрт Эбү Сүфьяны нүд гялбав. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ангийг өнгөрч байхад гайхлаа нуухгүйгээр:

“–Аббас аа! Чиний дүүгийн хүү, ноёрхлоо маш их ихэсгэсэн юм байна!..” гэв.

Аббас -радъяллахү анх- оролдож:

“–Үгүй, энэ нь ноёрхол биш, номлол л юм...” гэв.

Эбү Сүфьяан ч:

“–Зөв, зөв!” гэж батлав. (Бухарий, Мэгазий, 48; Хэйсэмий, VI, 164; Ибн-и Са’д, II, 135; Ибн-и Эсир, *эл-Камил,* II, 242)

Дараа нь тэндээс салаад Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд ирцгээв. Орчлонгуудын Эзэн асуун:

“–Эбү Сүфьяан аа! Одоо ч чиний (لَا اِلٰهَ اِلَّا اللّٰهُ) гэх (буюу итгэл нэмшлээ батлах) цаг чинь болоогүй юү?”

Эбү Сүфьяан түр бодсоны дараа кэлимэ-и тэвхидийг хэлэв. Харин Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн батлах үгийг хэлээгүй байв. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- дахиад асуув:

“–Намайг Аллахын Элч буйг хэлэх цаг чинь ирээгүй юү?”[274]

Эбү Сүфьяан энэ асуултыг хариулахаар түр түдгэлзсэн ч Хазрат-и Аббасын сануулгаар кэлимэ-и шэхадэтыг бүтнээр нь хэлэв. Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнийг шагших ба зүрхийг нь Исламд татах учраар Маккагийн ардын аюулгүй болох газруудыг тоолохдоо Эбү Сүфьяаны гэрийг дурдан ингэж айлдав:

“Мэсжид-и Харамд орсон нь аюулгүй юм. Гэрээсээ гараагүй нь аюулгүй юм. Эбү Сүфьяаны гэрт хоргодсон нь ч аюулгүй юм!” (Эбү Давуд, Хараж, 24-25/3021-3022; Хэйсэмий, VI, 164-166; Ибн-и Хишам, IV, 22)

Чөлөөт тавьсан Эбү Сүфьяаныг Маккад харихад Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч амхабтаа сүүлийн тушаа-лаа айлдаж байв:

---

274. Аугаа Эрхийн Кур’ан-и Кэрим дэх:

قُلْ اَطِيعُوا اللّٰهَ وَالرَّسُولَ فَاِنْ تَوَلَّوْا فَاِنَّ اللّٰهَ لَا يُحِبُّ الْكَافِرِينَ

“(Аяа Элч минь!) **Ингэж хэл: Аллах болон Расулын үгэнд орцгоо! Хэрэв царайгаа эргүүлбэл, андашгүй нь Аллах кафирчуудад дургүй!”** (Ал-и Имран, 32) хэмээт зарласнаас ч зөвхөн Аллахад итгэж үнэмшихийн хүрэмжтэй болоогүй нь илээр ойлгомжтой байдаг. Тийм учраас зөвхөн Аллахад эсвэл зөвхөн Элчид нь итгэж үнэмшисэн ба бууж өгсөн хүмүүс, уг аетын дагуу Аллахын дургүй кафирчууд хэмээн нэрлэдэг. Гол юм нь боолын хүч чадалгүй ухааны дагуу биш, тэнгэрлэг ухааны дагуу илгээх үнэмших нь байдаг.

"Танд ямар нэгэн дайралт болохгүй байхад хэнд ч сэлмээ бүү сугал!" (Ибн-и Хишам, IV, 28)

Үүний дараа Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- дөрвөн гараар хуваасан Исламын цэрэгт хөдлөх тушаалаа олгов. Ингээд Макка нь бүх талаар нь цуурайтсан тэкбирийн дуугаар дүүрэв.

Найман жилийн өмнө Маккагаас хоёр тэмээ болон гурван хүний хамт гунигтайгаараа салсан Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- өнөөдөр Аллахын хайрласнаар түмний гайхалтай хүчний хамт ариун оронд орж байв. Тэр өдөр нутгаас нь гаргасан аргагүй нэгэн хүн, өнөөдөр нутгаа эзэлсэн ялагч байв. Харин Тэр үүнд ерөөсөө их зан гаргалгүй, тэмээнийхээ хүзүүн дээр мөргөсөн байдалтай, өөрөөр хэлбэл уг шимийг хайрласан Аллахад талархлаа илэрхийлсэн байдалд Маккад орж байв. Толгойгоо Аллах Таалад даруй зангаа үзүүлэн хэт их бөхийлгөөд, сахлынхаа үзүүр нь бараг тэмээний тохошид хүрч байв. Тэр хооронд зогсолтгүйгээр:

أَللّٰهُمَّ لاَ عَيْشَ إِلاَّ عَيْشُ الْآ خِرَةِ

«Аяа Аллах минь! Амьдрал бол ахиратын амьдрал л юм!» гээд байв.[275] (Вакидий, II, 824; Бухарий, Рикак, 1)

275. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- дэлхийн амьдралтай харьцуулбал ахиратын хэр их чухал буйг илэрхийлсэн энэ үгийг насаараа олон удаа давтдаг байв. Дамжуулсан мэдээллүүдэд Мэсжид-и Нэбэвийг барьж байхад, шуугуйд малтаж байхад, Ялалтын өдөр Маккад орж байхад ба Салах Хажжийн хугацаан дахь Арафа буюу битүүний өдөр итгэгчдийн өнөр олноор харахдаа хэлсэн нь тогтмол юм. (Хар. Бухарий, Жихад 33, 110, Мэнакибу'л-Энсар 9, Мэгазий 29; Мүслим Жихад, 126, 129; Тирмизий, Мэнакиб, 55; Ибни Мажэ, Мэсажид, 3)

Номлогчийн ёс суртахуунаар боловсорсон асхаб-и кирамын байдалд ч Аллахын Элчийн байдлаас нэг их ялгаатай байгаагүй.

Исламын цэрэг бараг ямар нэгэн эсэргүүцэлтэй учраагүй. Энэ тухай Эбү Сүфьянд үзүүлсэн тактикийн ачаар, Маккачуудын мусульманчуудад эсэргүүцэхгүйн төлөө түүний хичээсэн нь эерэг дүгнэлт гаргасан, хэн ч Исламын содон цэрэгт эсэргүүцэхээр зориг үзүүлж чадаагүй байв. Зөвхөн Халид бин Вэлидийн Маккад орсон цэгт жижиг нэгэн тулалдаан болсон, тэр ч хурдан гийсэн байв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Фэтих Сураг уншаад асхаб-и кирамын хамт Каба-и Муаззаса өөд чиглэв. Тэмээнээсээ буулгүйгээр Кабаг таваф хийсний дараа:

جَاءَ الْحَقُّ وَزَهَقَ الْبَاطِلُ

“…Хак (үнэн) **ирээд, худал нь үгүй болов!..”** (эл-Исра, 81) ает-и кэримэг уншиж гартаа барьсан таягаар Каба дахь баримлуудыг өөрөө нурааж эхлэв. (Бухарий, Мэгазий, 48; Мүслим, Жихад, 87; Вакидий, II, 831-832)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Бэйтуллахад дүрс хараад дотогш ороогүй. Эхлээд тэднийг устгахыг тушаав. Сахабийчууд тушаалыг даруй хэрэгжүүлэв.

Дотуур Хазрат-и Ибрахим ба Хазрат-и Исмаил -алэйхисэссэлам-ын гарт мэргэний сум байсан дүрсийг харахдаа Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- ингэж айлдав:

“Аллах энэ дүрснүүдийг хийсэн мүшрикчүүдийн амийг аваг. Валлахи энэ пайгамбарчууд сумаар ерөөсөө хувь заяа хайгаагүй юм. (Эсрэгээр нь тэгэхийг хориглоцгоов.)” (Бухарий, Энбияа 8, Хажж 54, Мэгазий 48)



Мусульманчууд Маккаг эзэлсэн өдөр өглөө болтол тэкбир ба тэхлил авчраад, эгнэгт Кабаг таваф хийцгээв. Үүнийг харсан Эбү Сүфьяан эхнэр Хинддээ:

“–Чи үүнийг Аллахаас санаа авсан уу?” гэж асуув.

Хинд:

“–Тийм! Энэ нь Аллахын нэгэн үйл юм!” гэв.

Дараа өдөр Эбү Сүфьяан эртхэн Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд очив. Аллахын Элч түүнд үдэш эхнэртэйгээ юу ярьсныг дамжуулав.

Эбү Сүфьяан:

“–Би Чамайг Аллахын Элч гэдгийг гэрчлэе! Миний биеийг хүчит гараараа барьсан Аллахад тангараг өргөе, энэ үгийг минь Аллах Хинд хоёроос өөр хэн ч дуулаагүй юм!” гэв. (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* IV, 296)

Ялалтын дараа Маккачууд хүүхдүүдээ Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д аваачаад, Тэр ч тэдний толгойг илж тэдний төлөө залбирч байв. (Ахмад, IV, 32)

Өршөөлийн Баяр

Энэ хооронд Курайшчууд Мэсжид-и Харамд орсон, тэдний тухай гаргах шийдвэрийг хүлээж байцгаав. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- зөвхөн тэндэхэд биш, хамаг хүн төрөлхтөнд хандсан энэ түгээмэл яриагаа айлдав:

“Аллахаас өөр бурхан үгүй юм. Зөвхөн Тэр л байдаг. Түүний ямар ч сайд буюу түнш үгүй. Аллах амласнаа хэрэгжүүлсэн, боолдоо тусалж хамаг дайсныг маань тараасан байдаг. Кабагийн үйлчилгээ ба хажийчуудад ус тараах ажлаас гадна хэвийн бүх зан заншил нь, бараа ба цусны өшөө нь өнөөдөр миний энэ хоёр хөл доор юм.

Аяа Курайшчууд аа!

Аллах танаас мунхаглалын бахархлыг, аав ба угсаатайгаа магтан их зан гаргахыг арилгав. Хамаг хүн төрөлхтөн нь Адамаас үүсч, Адам бол шорooноос бүтсэн байдаг.

(Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- үүний дараа уг ает-и кэримэг уншив:)

يَا أَيُّهَا النَّاسُ إِنَّا خَلَقْنَاكُم مِّن ذَكَرٍ وَأُنثَى وَجَعَلْنَاكُمْ شُعُوبًا وَقَبَائِلَ لِتَعَارَفُوا إِنَّ أَكْرَمَكُمْ عِندَ اللهِ أَتْقَاكُمْ إِنَّ اللهَ عَلِيمٌ خَبِيرٌ

«Аяа хүмүүс ээ! Үнэндээ Бид таныг нэгэн эр ба нэгэн эмээс л туурвив. Тэгээд таныг (ихэмсэг зан гаргаж бахархах төлөө биш) **нэг нэгэнтэй танилцах гээд улс аймгаар хуваав. Аллахын онгонд хамгийн давуу тань, андашгүй нь Түүнээс хамгийн их байдаг тань мөн. Андашгүй нь Аллах, бүхнийг мэдэгч мөн.»** (эл-Хужурат, 13)" (Ибн-и Мажэ, Дияат, 5; Ахмад, II, 11; Тирмизий, Тэфсир, 49/3270)

Одоо Макка-и Мүкэррэмэ нь Хүдэйбиегийн нэгэн тэмдэг болоод өршөөл, энх тайван, аюулгүйдэл ба авралаас бүрдсэн сүнсний ялалтаар жинхэнэ эзэд буюу элгэн садан хүмүүст дэлгэсэн байв. хэдэн мянган зовлон, харгислал ба төвгөөр дүүрэн Маккагийн үгүйлэл нь одоо дууссан байв. Олон жилийн гуниг баяраар хувирсан байв. Үүний талархлын хамгийн том тэмдгээр, түүхийн хамгийн том өршөөлийг толилуулахаар Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Маккагийн ардад:

"–Аяа Курайшийн нийгэм ээ! Одоо би та нарын төлөө юу хийхээ бодож байна?" хэмээв.

Курайшчууд:

"–Бид Чамайг буян хийхийг найдан «Буян хийнэ!» гэцгээнэ. Чи сайн сайхныг эзэмшсэн нэгэн дүү мөн! Сайн сайхныг эзэмшсэн дүүги йн хөвүүн мөн!.." гэцгээв.

Тэгэхлээр нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Би ч Хазрат-и Юүсүфийн дүү нартаа хэлсэн шиг:

لاَ تَثْرِيبَ عَلَيْكُمُ الْيَوْمَ يَغْفِرُ اللهُ لَكُمْ وَهُوَ أَرْحَمُ الرَّاحِمِينَ

«...Танд өнөөдөр ямар ч ичгүүр үгүй! Аллах таныг өршөөх болтугай! Андашгүй нь Тэрээр хамгийн энэрэлтэй нь мөн,» (Юүсүф, 92) *гэж байна. За явцгаа, одоо бүгдээрээ чөлөөтэй байна!"* хэмээв.

Өөр нэгэн яриандаа ч:

"–Өнөөдөр өршөөлийн өдөр мөн. Өнөөдөр Аллахын Курайшчуудыг Исламтайгаар хүчтэй болгох, давуу болгох нэгэн өдөр юм," хэмээв.

Үүний үр дүнгээр ялалтаас өмнө маш олон мусульманы бараа болон амийг хороосон хүмүүс ч авралын нэр хүндийг хүртэв. Аллах Таала нь Курайшийн мүшрикчүүдийн Элчийнхээ гарт оруулсан, Түүнд бөхийлгөсөн байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч тэднийг өршөөж чөлөөлсөн байв. Ийм учраас Маккачуудад "Тулэка" буюу "чөлөөлөгдөгсөд" гэсэн нэр өгцгөөв.[276]

Орчлонгийн Хүндэт Эзний маань хамгийн том хүсэл нь хэнийг ч гадаа үлдээхгүйгээр хамаг хүн төрөлхтний мусульман болох нь байв. Маккагийн ялалтын дараа хүчний оргилд хүрсэндээ, дээр өөрт нь бүх төрлийн харгислалыг хийсэн хүмүүсээс өшөө авч чадахуйц байсан ч тэгэхгүйгээр өршөөл зарласан нь оршигчдыг Аугаа Эрхийн хараагаар харсны ер бусын нэгэн илрэл юм.

276. Хар. Ибн-и Хишам, IV, 32; Вакидий, II, 835; Ибн-и Са'д, II, 142-143.

Олон жил шог, доромжлол ба өс хонзонгоос өөр юм үзээгүй байсан Макка нь тэр өдөр толилуулсан том өршөөлийн баяраар үгээр тайлбарлагдашгүй нэгэн хайр ба энэрлийн илрэлтийг амьдарч байв. Харин ийм гоё үзвэрт сүүдэр тусгах юмсан Фэдалэ гэсэн нэртэй нэгэн Маккагийнх нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг алах зорилгоор хажууд нь хүрэв. Түүний зорилгыг сүнсээрээ мэдсэн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ямар ч сандрал ба уур үзүүлэхгүйгээр, халамж ба энэрлийн далавчаа дэлгэн Фэдалэгээс:

"–Чи Фэдалэ мөн үү?" хэмээн асуув.

"–Тийм!" гэв. Дараа нь Тэр Орчлонгуудын Энэрэл:

"–Аяа Фэдалэ! Ухаандаа зохиосон юмнаасаа гэмшиж өршөөл гуй!" хэмээж ариун гараа түүний цээжин дээр тавив. Ингээд яг тэр мөчид ухаанаас нь алах бодол үгүй болсон Фэдалэгийн зүрх зөөлөрч, итгэл үнэмшлийн туяагаар дүүрч, гэнэтхэн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүний санаанд оршигчдын хамгийн хайртай нь болчхов. (Ибн-и Хишам, IV, 37; Ибн-и Кэсир, *эс-Сирэ,* III, 583)

Эбү Сүфьяан бин Харб нь Мэсжид-и Харам суугаад бодож байв. Пайгамбар Эзэн маань түрүүлж, мусульманчууд ч Түүнийг дагахыг харахдаа дотроо:

"–Мухаммедын эсрэг цэрэг цуглаад, эргэж энэ нөхөртэй дахиад байлдах уу, яах вэ?!" гэж өнгөрөөв. Тэр хооронд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ирээд түүний толгой дээр зогсоод хоёр далны хооронд гараараа түлхэж:

"–Тэгвэл Аллах чамайг дарүй болгоно!" хэмээв. Эбү Сүфьяан толгойгоо өндийлгөн Аллахын Элчийг харвал:

"–Одоо хүртэл Чамайг пайгамбар буйд яг шийдээгүй байлаа. Дотроо өнгөрөөсөн бодлоос болж тавба хийж, Аллахаас өршөөл гуйж байна!" гэв. (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* IV, 296)

Ухудын Дайнд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн авга ах Хазрат-и Хамзагийн элгийг шуналаар хазсан Хинд ч Маккагийн Ялалтын өдөр ирээд итгэж үнэмшин агуу өршөөлийн хүртэв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- кэлимэ-и тэвхидийн нэр хүндээр түүнийг өршөөв.[277]

Эбү Жэхилийн хөвүүн Икримэ нь Исламын алдаршсан дайснуудаас байв. Маккагийн ялалтын дараа Йеменд зугтсан байв. Эхнэр нь мусульман болоод түүнийг Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд авчрав. Орчлонгуудад энэрэл болохоор илгээгдсэн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Икримэг дуртай угтаж:

"–Аяа нүүдэлчин морьтон, тавтай морил!" хэмээгээд мусульманчуудад хийсэн харгислалыг илэрхийлэлгүй түүнийг өршөөв. (Хаким, III, 271/5059; Вакидий, II, 851-852)

Хэббар бин Эсвэд ч Исламын дайсдын тэргүүлэгчдээс байв. Маккагаас Мадина руу нүүхэд нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн охин Зэйнэб -радъяллахү анха-д ялнгуяа жадаараа цавчиж тэмээнээс унагаасан байв. Хазрат-и Зэйнэб жирэмсэн байсан тулд үрээ алдсан ба маш хүнд шархадсан байв. Энэ шарх нь дараа нь түүний нас барах шалтгаан болов. Хэббар үүн шиг өөр хэдэн гэмт хэрэг хийсэн байв. Маккагийн ялалтын дараа зугтаад баригдаагүй. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Мадинад асхабтайгаа сууж

277. Вакидий, II, 850.

байхад жаргалын онгонд нь ирээд мусульман болсноо зарлав. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнийг ч өршөөв. Түүнийг доромжлох эсвэл үймүүлэхийг ч хориглов.[278] Учир нь Кур'ан-и Кэримд:

خُذِ الْعَفْوَ وَأْمُرْ بِالْعُرْفِ وَأَعْرِضْ عَنِ الْجَاهِلِينَ

"(Аяа Расул минь!) **Чи өршөөлийн замыг барь, өршөөж, зохимжтойг тушаа, мунхагчуудыг үл тоо, тэднээс нүүрээ буруул!"** хэмээн айлдсан байв. (эл-А'раф, 199)

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь амьд нэгэн Кур'ан байв. Кур'аны ёс суртахууныг ч хамгийн сайхнаар нь Тэр л толилуулж байв. Өөрт нь хандаж хийсэн хамаг гэмт хэргийг огт андахгүйгээр чин сэтгэлээрээ өршөөдөг байв. Харин ард түмэнд хийсэн гэмт хэргийн талаар, эрхийг бариад, эрхийн эзний эрхийг автлаа, Түүнийг хэн ч тайвшруулж чаддаггүй байв.

Жишээлбэл Маккад түгээмэл өршөөл толилуулсны зэрэг, боловсрохгүй зарим урвагчдыг ч илэрсэн газар алах тухай Пайгамбар тушаалаа зарласан байв.[279]

Маккагаас олз болгож юу ч аваагүй.[280] Оршигчдын Туяа Эзэн маань Исламын цэргийн нэлээд өндөр хэрэгцээг хангахаар Маккагийн баячуудаас мөнгө ба хуяг зээлдэж авав. Дараа нь үүнийг Хэвазинаас авсан олзоор бүтнээр нь төлөв:

278. Вакидий, II, 857-858.

279. Эбү Давуд, Жихад, 117/2683; Нэсаи, Тахриму'д-Дэм, 14.

280. Эбү Давуд, Хараж, 24-25/3023.

"–Зээлийн хариу нь талархлаа илэрхийлэх ба түүнийг төлөх юм!" хэмээв. (Вакидий, II, 863; Эбү Давуд, Бүюү', 88/3562; *Муватта,* Никах, 44)

Маккачууд нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хамаг хүн төрөлхтөнд жишээ болгож толилуулсан өршөөлийн баяр хөөрийг мэдэрч байхад үд болсон байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- хэвээрээ Хазрат-и Билалд эзан уншихыг тушаав. Билал -радъяллахү анх- дээр боол байхад ухаанд багтаашгүй тамлалаар "Эхад, Эхад" гэж гасалсан өдрүүдийг санав. Одоо бол харгислал нь дууссан байв. Одоо өөрөө чөлөөт бөгөөд ялалтыг хүртсэн итгэлийн цэргийн хамт Маккад байв. Аллахад шүкүрээ илэрхийлэн Каба-и Муаззама дээр гарав. Элгэн дуугаараа эзан уншиж эхлэв. Тэр нь эзаныг маш гоё дуудаж байгаад, Маккагийн хамаг уулнууд ба тэнгэр нь уг агуу дуугаар цуурайтаж байв. Тэр өдөр дуудсан Эзан-и Мухаммедий нь итгэгчдэд мөнхийн дурсамж байв. Үүнийг харсан мүшрикчүүдээс цөөн хэд нь:

"–Бидэнд хайран юм!.. Боолчуудын чинээ болж чадаагүй! Тэд хаана хүрээд, бид ямар байдалд хоцров?" гээд өмнө нь хийсэндээ буюу тэр үе хүртэл үнэнээ анзаараагүйдээ гэмшив.

Маккачуудын Бий'ат

Үдийн мөргөлийг үйлдсэний дараа Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Сафа Даваан дээр гарав. Маккачуудын бий'атыг хүлээж авав. Эхлээд эрчүүд "мусульман болох ба жихад хийхээр" Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-д бий'ат хийцгээв. Дараа нь эмэгтэйчүүд

бий’ат хийцгээв.[281] Эмэгтэйчүүдийн бий’атын тухай Аллах Таала нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д ингэж айлдсан байв:

يَا أَيُّهَا النَّبِيُّ إِذَا جَاءكَ الْمُؤْمِنَاتُ يُبَايِعْنَكَ عَلَى أَن لَّا يُشْرِكْنَ بِاللهِ شَيْئًا وَلَا يَسْرِقْنَ وَلَا يَزْنِينَ وَلَا يَقْتُلْنَ أَوْلَادَهُنَّ وَلَا يَأْتِينَ بِبُهْتَانٍ يَفْتَرِينَهُ بَيْنَ أَيْدِيهِنَّ وَأَرْجُلِهِنَّ وَلَا يَعْصِينَكَ فِي مَعْرُوفٍ فَبَايِعْهُنَّ وَاسْتَغْفِرْ لَهُنَّ اللهَ إِنَّ اللهَ غَفُورٌ رَّحِيمٌ

“Аяа Пайгамбар аа! Итгэсэн эмэгтэйчүүд Чамд ирээд Аллахад түнш зэрэгцэх түнш байхгүй, хулгай хийхгүй, зинад орохгүй, хүүхдүүдээ алахгүй, гар хөл хоёрын хооронд нэгэн гүтгэлэг зохиохгүй (болоогүй худлыг зохиож гэтгэхгүй, бусдын үрийг нөхрийнх гэж хэлэхгүй эсвэл ёсгүй хүүхэд төрүүлж түүний нөхрийнх гэж зарлахгүй), **ямар ч сайхан үйлд Чамайг эсэргүүцэхгүй байхаар бий’ат хийвэл тэдний бий’атыг хүлээж ав; тэдний төлөө Аллахаас өршөөл гуй!.. Андашгүй нь Аллах, Уучилдаг, Энэрдэг.”** (эл-Мүмтэхинэ, 12)

Эмэгтэйчүүд бий’атаа үгээр ба гараа Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн гараа дүрсэн усны саванд дүрээд л өгөөд, тэдэнтэй гар хэзээ ч барьсан удаагүй юм.

Үмэймэ бинт-и Рукайка -радъяллахү анха- ингэж ярина:

“Энсараас хэсэг эмэгтэйн хамт Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-д очоод:

281. Ахмад, III, 415; Бухарий, Мэгазий, 53.

«–Аллахад ямар ч түнш байхгүй, хулгай хийхгүй, зина хийхгүй, хүүхдүүдээ алахгүй, хэзээ ч гүтгэхгүй, ёст тушаалдаа Чамд эсэргүүцэхгүй байхаар бий'ат хийцгээлээ,» гэхлээр Орчлонгуудын Эзэн шууд:

«–Таны хүч хүрэхээр үйлсэд!» хэмээв. Халамж ба энэрлээр авсан ийм үгсийн хариунд бид:

«–Аллах ба Элч нь бидэнд бид өөрөөс ч илүү энэрэлтэй юм, одоо бий'ат хийцгээе!» гэцгээлээ.

Эмэгтэйчүүд бий'атыг гар бариад хийх юмсан. Харин Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Би тэдэнтэй гар барихгүй! Миний зуун эмэгтэйд нийтэд хэлсэн нэгэн үг, эмэгтэй бүрт тусдаа хэлснээр тоологдоно," хэмээв. (*Муватта,* Бий'ат, 2; Тирмизий, Сиер, 37/1597)

Итгэмжтэй Хүнд Өгөөрэй!

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Кабад ирэхдээ Мэсжид-и Харамын нэгэн буланд суусан байв. Мүжахидчууд бол Түүнийг тойрч сууцгаав. Аллахын Элч нь Кабагийн түлхүүрийг авчрахаар Хазрат-и Билалыг Усман бин Талхад илгээв. Хазрат-и Билал нь Усман -радъяллахү анх- дээр очоод:

"–Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Кабагийн түлхүүрийг авчрахыг тушаана!" гэв. Усман:

"–Болно!" гээд ээж Сүлафэгийнхээ дэргэд очив. Тэр үед түлхүүр түүний дэргэд байв:

"–Ээж ээ! Түлхүүрийг надад өг! Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- надад хүн илгээж түлхүүрийг аваачихыг тушаав," гэлээ.

Сүлафэ:

“–Ардынхаа алдар олоод бахарсан юмыг аваачаад гараараа бууж өгөхөөс чинь би Аллахад хоргодъё! Тэр үүнийг авбал дахиад хэзээ ч буцааж өгөхгүй!” гэв. Усман -радъяллахү анх- түр хичээсний дараа ээжийгээ ятган түлхүүрийг аваад Пайгамбар Эзэнд маань авчирч:

“–үүнийг Чамд Аллахын бараа гэж хадгалахаар л өгч байна!” гэв. Түлхүүрийг түүнд буцааж өгөхгүй гэж айсан байв. (Вакидий, II, 833; Хэйсэмий, VI, 177)

Орчлонгуудын Эзэн Кабаг онгойлгов. Дотогш ороод хаалгыг хаахыг тушаав. Нэлээд удаан тэнд байгаад хоёр рэкат мөргөл үйлдэв. (Вакидий, II, 835; Ибн-и Са’д, II, 137)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Кабагаас гарав. Ялалтын хутбагаа айлдсаны дараа:

“–Усман хаана вэ?” хэмээн асуув. Усман бин Талха босов. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

إِنَّ اللّٰهَ يَأْمُرُكُمْ أَن تُؤدُّواْ الأَمَانَاتِ إِلَى أَهْلِهَا وَإِذَا

حَكَمْتُم بَيْنَ النَّاسِ أَن تَحْكُمُواْ بِالْعَدْلِ إِنَّ اللّٰهَ نِعِمَّا

يَعِظُكُم بِهِ إِنَّ اللّٰهَ كَانَ سَمِيعًا بَصِيرًا

“Аллах танд хадгалах зүйлсээ итгэмжтэй хүмүүст өгөхийг, хүмүүсийн хооронд эрх тэгшээ шийдэхийг тушаана. Аллах танд ингэж маш сайхан сургаал өгнө. Андашгүй нь Аллах сонсогч (ба) **үзэгч мөн,”** (эн-Ниса, 58) аетыг уншсаны дараа:

“–Эбү Талхагийн Хөвүүд ээ! Аллах Таалагийн хадгаламжийг байнга танд байх ба шударга хандахаар хүлээж авцгаа!

Түүнийг харгис болохгүй бол хэн ч таны гараас татаж авч чадахгүй! Өнөөдөр сайн сайхны ба амласнаа хүлээх өдөр мөн," хэмээв. (Ибн-и Хишам, IV, 31-32; Вакидий, II, 837-838; Ибн-и Са'д, II, 137)

Энэ явдлаас ч үзсэнээр хадгаламжийг чадвартай хүнд өгөх гэдэг нь маш чухал нэгэн хэрэг юм. Учир нь хадгаламжийг чадвартайд нь өгсөн тохиолдолд бие хүнд, гэр бүлд ба улс төрд энх тайван үргэлжилж, эсрэг тохиолдолд бол том ээзнт гүрнүүд ч нурсан байдаг. Түүх нь үүний олон жишээгээр дүүрэн байдаг.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- хадгаламж гэсэн сэдвийн нарийн учрыг хадис-и шарифдаа маш сайхан ойлгуулна:

"Хадгаламжийг чадвартай хүнд өгдөггүй болохлоор, тэгээд виямат болохыг хүлээ!" (Бухарий, Илим, 2; Ахмад, II, 361)

Товчоор нь хадгаламжийг чадварт нь өгөхгүй нь Кияматын бэлгэ тэмдгээс хамгийн чухал нэгэн байдаг.

Түрүүнээс нь сикая (хажийчуудад усаар дайлах) үүрэгтэй байсан Хазрат-и Аббас -радъяллахү анх- нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс Хижаба[282] үүргийг ч нэхсэн байв. Пайгамбар Эзэн маань авга ахдаа:

"–Би танд хүмүүсийн Бэйтуллахад илгээх дэвсгэр мэтийн зүйлсээр амьдралаа авч явах биш, хажийчуудын усны хэрэгцээг хангахаар хөрөнгөөсөө зарцуулаад ингэж буянд хүрэх төвөгтэй үүргийг олгож байна!" хэмээж хажийчуудад ус дайлах үүргээ үргэлж хийхийг нь айлдав.

Аббас -радъяллахү анх-ын Таифад усан үзмийн баг байлаа. Исламаас өмнө ч дараа ч тэндээс хатсан үзэм зөөж, Зэмзэмд холиод хажийчуудыг дайлдаг байв. Түүний дараа хөвүүд нь ба

282. Хижабэгийн тухай Хар. боть 1, х. 42

ач нар нь ч хэвээрээ ингэж үргэлжлүүлэв. (Ибн-и Хишам, IV, 32; Ибн-и Са'д, II, 137; Вакидий, II, 838)

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- ялалтын хоёр дахь өдөр үдийн мөргөлийн дараа хүмүүсийн дунд босов. Аллах Таалад хамдаа илэрхийлсний дараа ингэж айлдав:

"Аяа хүмүүс ээ! Андашгүй нь Аллах тэнгэр болон газрыг, нар болон сарыг туурвисан өдөр Маккаг харам буюу гар хүргэшгүй болгосон байдаг! Киямат өдөр хүртэл ч харам ба гар хүргэшгүй байх болно! Андашгүй нь Аллах Зааны цэргийн Маккад оруулаагүй, Элчийгээ ба итгэгчдийг бол үүний амжилтад хүргэсэн байдаг. Макка нь миний дараа хэнд ч халал биш юм. Маккагийн гөрөөсийг үргээж, өргөсийг нь хэрчиж болохгүй, олсон хүн эзнийг нь хайхаар авснаас гадна алдсан барааг авах ч халал болохгүй. Хэн нэгний садан хамаатан алагдвал, хоёроос аль нь илүү буянтай байвал түүнийг л нэхэж мэднэ: Диет буюу мөнгө эсвэл кисас буюу амь."

Тэгэхлээр нь Хазрат-и Аббас -радьяллахү анх-:

"–Изхир (өвсийг түүхээс) гадна болог. Бид булш болон гэртээ түүнийг ашиглана," гэв.

Пайгамбар Эзэн маань:

"–Изхирээс гадна!" хэмээв.[283] (Бухарий, Луката, 7; Мэгазий, 53; Ахмад, IV, 31-32; II, 238)

283. **Изхир** нь Макка-и Мүкэррэмэд гардаг, өргөн навчтай, сайхан үнэртэй нэгэн ургамал юм. Мал амьтдад идээгээр өгснөөс үл барам гэр болон булшуудад ч хэрэглэдэг. Фиких эрдэмтэд Харамын тойрогт огтлох хориотой моднуудыг "өөрөө ургагчид" гэж тэмдэглэсэн байдаг. Хүний хөдөлмөрөөр

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Мэсжид-и Харамд сууж байхад Хазрат-и Эбү Бэкир аав Эбү Кухафаг авчрав. Аллахын Элч түүнийг харахлаар:

“–Эбү Бэкир ээ! Хөгшин аавыгаа энд хүртэл ядраагүй, би түүний дэргэд очсон нь дээр байлаа!” хэмээв.

Эбү Бэкир -радъяллахү анх-:

“–Аяа Расулаллах аа! Түүний Чамд ирсэн нь, Чиний түүнд очсоноос илүү зохимжтой юм,” гэж хариулав.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эбү Кухафаг өмнөө суулгаж гараа зүрхэн дээр нь тавиад:

“–Эбү Кухафа! Мусульман бол, мэнд олно!” гэв. Тэр ч мусульман болж, чин сэтгэлээрээ шэхадэт авчрав. (Ибн-и Са’д, V, 451)

Эбү Кухафа -радъяллахү анх- бий’ат хийхээр гараа Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ариун гарт уртасгавал Пайгамбарт хайрт Эбү Бэкир -радъяллахү анх- бие барьж ядан уйлж эхлэв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- сандраад яагаад уйлж буйг нь асуувал Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх- нулимсанд бүрдсэн:

ургасны огтлох талаар маргалдаан болсон, ихэнх нь жаиз буюу боломжтой буйг нь шийдсэн байдаг. Мисвак огтлох ба модыг хохируулахгүйгээр навч ба жимсийг нь түүх жаиз буйг илэрхийлсэн байдаг. (Хар. Ибрахим Жанан, *Хадис Нэвтэрхий Толь,* XII, 525-526)

Мадинагийн харам тойрогт ногоон мод эсвэл өвсийг огтлох н хэрэгцээ болохоор жаиз гэж үздэг. Мадина нь тариалангийн бүс буй тул Хазрат-и Пайгамбараас энэ тухай зөвшөөрөл эрсэн ба тэдэнд Маккагийн харам дахь зарим ургамлыг хэрэгцээ болохоор огтлоход зөвшөөрөл олгосон шигээ Мадинад илүү өргөн чөлөө олгосон байдаг. Мөн Мадинагийн гадаа авлах нь чөлөөлсөн байдаг. (Хар. Хамди Дөндүрэн, *Шамил Ислам Нэвтэрхий Толь,* “Харам” зүйл.)

"–Аяа Расулаллах аа, Чамд бий'ат хийхээр гараа уртасгасан тэр гар миний аавынх биш, Чиний авга ах Эбү Талибын гар болоод, түүгээр Аллах Таала миний оронд Чамайг баясгасан бол, Чамайг хэр их баяр хөөрт хүрэхийг тайлбарлах аргагүй байх. Чамайг түүндээ их хайртай байсныг би мэднэ," гэв. (Хэйсэмий, VI, 174)

Энэ нь тэр агуу Пайгамбарын өндөр ёс суртахуунаар ашиглаж Түүнд үгүй болохын хараад ханашгүй нэгэн үзэсгэлэн...

Ижилгүй Өгөөмөр Сэтгэл

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ялалтын дараа Маккад арван тав хонов. Энэ хооронд Энсараас зарим нь санаа зовсон, Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дахиад Мадинад харих эсэхийг бодож байв. Аллах Таала нь Түүнд төрж өссөн ариун газрын эзлэхийг хайрласан байв. Сафа Даваан дээр залбирч байсан Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- Энсар-и Кирамын энэ санааг мэдрэв. Залбирал нь дууссаны дараа тэдний дэргэд ирээд:

"–Юу ярьж байв?" хэмээн асуув.

Тэд ч юунд санаа зовсноо илэрхийлбэл, Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- том нэгэн өгөөмөр зан гарган ингэж айлдав:

"–Аяа Энсар аа! Тийм юм хийхээс Аллахад хоргодъё. Би таны нутагт нүүсэн. Бидний амьдрал таны амьдрал; үхэл маань ч таны дэргэд юм."

Энэ үгсийн дараа Энсарын зовлон алга болов. (Мүслим, Жихад, 84, 86; Ахмад, II, 538)

Хүндэт Элч Эзэн маань Маккагийн ялалтын араас Аллахад шүкүр ба хамдаа бүр ихэсгэж:

سُبْحَانَ اللهِ وَ بِحَمْدِهِ أَسْتَغْفِرُ اللهَ وَ أَتُوبُ إِلَيْهِ

“Би Аллахын сүбхан оршлыг бүх талаар нь буюу оршилд нь, бэлгэ тэмдэгт нь, үйлсэд нь, нэрүүдийнх алдарт зохимжгүй хамаг дутагдлаас өөд өргөе. Тэрээрт зохимжтой бүх төрлийн магтаал ба хүндэтгэлээр хамдаа хийе. Аллахаас намайг өршөөхийг ерөөж нүгэлээсээ тавба хийе,” хэмээсэн үгсээ мөргөлдөө, ялангуяа бөхийж мөргөхдөө ихээр уншиж эхэлсэн байв. Хазрат-и Аиша -радъяллахү анха- үүний учрыг асуухлаар Эзэн маань:

“Раб минь надад үммэтдээ нэгэн тэмдэг хараад, түүнийг харахдаа энэ үгийг ихээр хэлэхийг тушаасан байв. би тэр тэмдгийг харлаа,” хэмээв. (Мүслим, Салат, 220)

Мөн Наср Сурад ч өөрт нь тусламж ба ялалт ирээд хүмүүсийг олноор Исламд орохыг хараад тэсбихээ бүр ихэсгэх ба өршөөл гуйх нь их байв.

Наср Сураг өнгөрдөг “наср: тусламж” гэсэн үгийн хамаг Арабчуудад давуу болох, “фэтх” гэсэн үгийн бол Маккагийн ялалтыг заасан нь илэрхийлсэн байдаг. “Фэтх” гэсэн үгийн “нээх, онгойлгох” гэсэн утгаар хөдөлж Ибн-и Аббас -радъяллахү анх- Маккагийн ялалтыг “Фэтхү’л-Футүх” гэж нэрлэсэн байдаг. Учир нь эндэх фэтх нь зөвхөн дайсны эзэлсэн хотыг авахаар биш, Мэсжид-и Харамыг удирдах ба Кабаг эзлэх гэсэн утга ч агуулна. Мөн зүрх Аллахын шашинд, Исламын хаалгыг хамаг хүн төрөлхтөнд нээхийг ч илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл Пайгамбар маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэр өдөр орсон хотоос байтугай сэтгэлүүдийг эзэлсэн байдаг. Ийм учра-

ас Маккагийн ялалт нь Исламын ялалтын эхлэл гэж тоолдог. Даруй хамаг Арабстан ба тэндээс хорвоод тарсан Исламын эд ба сүнсний ялалт нь, Кабагийн хаалгыг нээснээр эхлэв. Учир нь бүгд аймгууд Исламд орохоор Маккагийн ялалтыг ширтэж:

"Түүнийг аймагтайгаа хамт үлдээгээрэй, хэрэв тэднийг хожиж чадвал, Тэр нь пайгамбар мөн," гэдэг байцгаав. (Бухарий, Мэгазий, 53)

Хасан-и Басригаас дамжуулснаар, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Маккаг эзлэхэд Арабчууд:

"Аллах Таала нь Маккачуудыг Зааны цэргээс хамгаалсан байхад, Мухаммед -алэйхиссалатү вэссэлам- Маккачуудыг хожсоныг харвал, таны гар Түүнд хүрч чадахгүй," гээд олноор Аллахын шашинд орцгоов. (Элмалылы, IX, 6236-6238)

Хүнэйний Газва (8 оны Шэввал сарын 11 / 630 оны 2 сарын 1)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Маккагийн ялалтын дараа зөвхөн Каба дахь баримлыг нурааснаар үл барам, ойр хавийн бусад баримлыг үгүй болгохоор мүжахид хамтлагууд байгуулаад ширкийн амьгүй чулуудыг устгахаар илгээв. Өөрөөр хэлбэл тэвхидийн цэвэрлэгээ эхлүүлсэн байв.[284] Харин үүнийг Хүнэйн амьдарч байсан Хэвазин аймаг

284. Вакидий, III, 873. Халид бин Вэлид -радъяллахү анх- Узза баримлыг нурааж Маккад харихад, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнийг 350 хүнтэй цэргийн ангийн тэргүүнээр, Аллахад итгэх үнэмшихэд урихаар Бэний Жэзимэ Аймаг дээр илгээв. Хазрат-и Халид энэ аянд нэгэн алдааны дүнгээр гучин хүнийг алав. Мэдээллийг Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д хүрэхлээр нь Орчлонгуудын Эзэн ихээр санаа зовов. Гараа тэнгэр өөд дэлгэн хоёр удаа:
"–Аллах минь! Халидын хийсэн үйлээс хол буйгаа Чамд илэрхийлье!" хэмээж Аллахад хоргодов. Хазрат-и Алиг чухал нийтийн мөнгөтэйгөөр

ба Таифад суусан Бэний Сакиф хүлээн зөвшөөрөөгүй. Тэд мусульманчууд руу дайрахаар шийдэв. Үүний төлөө өнөр цэрэг бэлтгэв. Төгсгөлийн дайнд гарсан юм шигээ хамаг юмаа хамтдаа авцгаав.[285]

Тэдний энэ хөдөлгөөнийг мэдэж авсан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч өөрийнх цэрэгт Маккагаас хоёр мянга нэмээд тэдэнд дээр явав. Хувь заяаны учраар цэргийн дунд олон жил ширкийн төлөө мусульманчуудтай байлдсан ба тэднийг янз янзын төвөг учруулсан Эбү Сүфьяан ч байв. Одоо бол Исламын эгнээний ялалтын төлөө байлдах байв. Түүнчлэн Маккагаас ная орчим мүшрик ч цэрэгт оролцсон байв.[286]

Исламын цэрэг бүх талаараа гайхамшигтай байв. Нүд гялбуулам сүр бараагаараа Хүнэйн рүү урагшилж байв. хүн бүр бүрэн зэвсэглэсэн цэргийг Арабстанд харагдаагүйг бодож байв. Энэ байдал нь Асхаб-и кирам хазратын сэтгэлийг гэнэтхэн бахархалд залан:

Бэний Жэзимэ аймагт илгээж, алагдсан хүмүүсийн диетийг төлүүлэв. Хазрат-и Али нь олзоор авсан ба аюул туссан хамаг барааны мөнгийг, нохойн услах шуудуу хүртэл төлөв. Үлдсэн мөнгийг ч магадтай аюулын төлөө Бэний Жэзимэ аймагт үлдээв. Али -радъяллахү анх- хариад хийснээ Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д ярихад Хорвоогийн Энэрэл буй Эзэн маань:

"–Сайхан боллоо, чиний зөв!" хэмээв. (Бухарий, Мэгазий, 58, Ахкам35; Нэсаи, Адабу'л-Кудат, 16; Ибн-и Хишам, IV, 53-57; Вакидий, III, 875-884)

Энэ явдал нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн эзэмшсэн ужим өргөн халамж ба энэрлийн хязгаарыг заадаг ба Түүний туурвигсдад Туурвигчийн нүдээр яаж харсныг толилуулдаг. Нохойн хагарсан услах савны мөнгийг ч төлөөд амьтадын эрхийг дагасан нь бидний хувьд оргил үлгэр жишээ юм.

285. Ибн-и Хишам, IV, 65; Ибн-и Са'д, II, 150.

286. Ибн-и Хишам, IV, 68; Вакидий, III, 890.

“Ийм цэрэг хэзээ ч ялагдахгүй!” гээд дайснаа багасгахад ба эд барааны хүчээр ялалтыг лав гэж үзэхэд учир болов. Ийм үеийн бахархал нь мусульманчуудаас тэнгэрлэг шалгалт авахын учир болов:

Исламын цэргийн газарч хүч нь Хүнэйн орох нарийн замд өөртөө итгэлтэй урагшилж байхдаа, өглөөний бараанд гэнэтхэн хавханд унав. Том нэгэн айдас илрэв. Мусульманчууд дээр нь бороо шиг харвасан сумны өмнө зогсчихов. Исламын цэрэгт сандарсны улмаас эвдрэх задрах тэмдэг илрэв. Энэ нь хойноос ирэгчдэд ч шилжихлээр, мусульманчуудын эгнээ нь суларч ухрав. Хуваүин ба Сакиф аймгууд ч тэднийг нэхээд дагаж эхлэв.

Тэр аймшигт өдөр сэтгэл санаа нь түгшин, ямагт урагш тэмүүлэн, өөрийгөө бусдын төлөө золиослоход бэлэн байсан хүн бол зөвхөн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- болов. Тэр өдөр Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ижилгүй зориг ба домгийн гэмээр үлгэр жишээ толилуулав. Түүнчлэн авга ах нь Хазрат-и Аббас ба Эбү Сүфьяан бин Харис -радъяллахү анхүмаа- нар Түүний ариун амийг аюулд оруулахгүй гэж унааны жолоог барьсан, цааш урагшлахад нь саад болохыг хичээж байцгаав.[287]

Нөгөө талаас Исламын цэргийн үймээн үргэлжилж байв. Хоорондоо:

“–Өнөөдөр шид нь эвдрэв,” гэж орилогсдоос:

“–Энэ хожигдлоо далай хүртэл хариулж чадахгүй!” гэгсэд хүртэл найдвар алдсан маш олон хүн байв. Маккачуудын заримын дунд:

287. Мүслим, Жихад, 76.

“–Хазрат-и Пайгамбар өөд болов. Арабчууд өмнөх шашиндаа буцна!” мэтийн яриа хүртэл гарч байв.

Харин Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- амьдаар барахгүй дайсантай тулалдан эсэргүүцэж морин дэл дээр явж байв. Аллахад бууж өгсөн байдлаараа асхабтаа дуудан:

“–Аяа Энсар аа! Аяа Мухажирчууд аа! Аяа Аллахын боолчууд! Нааш ирцгээ! Би Аллахыг боол ба пайгамбар мөн!..”

Дараа нь хүчит дуутай авга ах Аббас -радъяллахү анх-даа дохиж Исламын цэргийг дуудахыг нь нэхэв. Хазрат-и Аббас ч чанга дуугаараа:

“–Аяа Акабад бий’ат хийгсэд ээ! Аяа Рыдван модон доор ам өгөгсөд өө! (Гүйцгээ), Аллахын Элч энд байна!..” гэж дуудаж эхлэв.

Энэ урилгыг сонссон сахаба нь (لَبَّيْكَ لَبَّيْكَ) Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд ирэв. Ийнхүү эрвээхий дэнгийн гэрэлд татагдан эргэлдэн нисэхтэй адил Оршигчдын Туяаны дэргэд эгнээнд орж эхэлсэн итгэгч сэтгэлүүд, унасан айдаснаас авраагдаад энх тайванд хүрцгээв. Аажим аажмаар Аллахын тусламжаар Исламын хамаг эгнээ нь эмх цэгцдээ оров. Үүний дараа Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- хоёр гараа агуу онгонд дэлгэн:

“Аллах минь! Надад амласан ялалтаа хайрлах болтугай!” хэмээн залбирав.

Яг Бэдирийн дайн шиг газраас ариун гараараа атган хөрс аваад дайсны эгнээний тийш хаяж шилмэл асхабтаа:

“–За, одоо үнэнчээр довтлоорой!” хэмээв. (Мүслим, Жихад, 76-81; Ахмад, III, 157, V, 286; Ибн-и Хишам, IV, 72; Вакидий, III, 897-899)

Энэ удаа Исламын цэрэг дайнд шинээр орсон шиг хурдаар мүшрикчүүд руу дайрав. Хийсэн ширүүн довтолгоогоор богино хугацаанд дайсныг мөхөөж тараав. Зөвхөн дөрөв нь шэхид болж, үүний хариунд мүшрикчүүдээс далан хүнийг хороожээ. Дайсан маш муухайгаар ялагдаж, хажууд нь дайснаас олзолсон бүх юм мусульманчуудад үлдсэн байв. Дайны олзыг тоолох арга байгаагүй.[288]

Андашгүй нь энэ байдал нь аугаа Аллахын итгэгчдэд хайрласан том нэгэн тусламж байв. Учир нь тэд эхлээд ялагдаж байхдаа, дүгнэлтэд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн зориг, бууж өгөх ба Аугаа Эрхэд чин сэтгэлээрээ залбирснаар ялалтыг хүртэв. Аллах Таала энэ үнэнийг Кур'ан-и Кэримдээ ингэж зарлана:

لَقَدْ نَصَرَكُمُ اللّٰهُ فِي مَوَاطِنَ كَثِيرَةٍ وَيَوْمَ حُنَيْنٍ إِذْ أَعْجَبَتْكُمْ
كَثْرَتُكُمْ فَلَمْ تُغْنِ عَنكُمْ شَيْئًا وَضَاقَتْ عَلَيْكُمُ الأَرْضُ بِمَا
رَحُبَتْ ثُمَّ وَلَّيْتُم مُّدْبِرِينَ. ثُمَّ أَنَزلَ اللّٰهُ سَكِينَتَهُ عَلَى رَسُولِهِ
وَعَلَى الْمُؤْمِنِينَ وَأَنزَلَ جُنُودًا لَّمْ تَرَوْهَا وَعذَّبَ الَّذِينَ كَفَرُواْ
وَذَلِكَ جَزَاء الْكَافِرِينَ

"Андашгүй нь Аллах олон газар (дайсны талбайд) **болон Хүнэйний Дайнд танд туслав. Нэг удаа таны олон байсан нь таныг бахархуулаад, харин таныг хожигдохоос аварч чадсангүй байв. Дэлхий нь хэдий өргөн байсан ч танд уйтан давчуу санагдаж байв. Эцэст нь та бүр хойшоо эргэсэн байв.**

288. Ибн-и Хишам, IV, 79.

Дараа нь Аллах нь Элч болон итгэгчид дээрээ сэкинэтээ буулгав; таны хараагүй цэрэг (мэлэкчүүд) **илгээж кафирчуудыг мөхөөв. Энэ нь тэр кафирчуудын ял мөн.”** (эт-Тавба, 25-26)

Энэ тухай, тэр өдөр мүшрикчүүдийн эгнээнд эс болович дараа нь итгэж үнэмшигчид нь, Аллах Таалагийн итгэгчдэд тусалсны үүднээс, өөрсдөд тэр өдөр хүртэл хэзээ ч хараагүй хүмүүс дайрсныг гайхаж байснаа илэрхийлсэн байдаг.[289]

Хэвазины хожигдсон цэргийн хэсэг нь Таиф руу, хэсэг нь Нахлж руу яваад, хэсэг нь ч Эвтаст хуаран байгуулав.[290]

Хүнэйний Дайныг ялсан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- зугтсан дайсныг дагахыг тушааж, олзолж авсан хүн ба эд барааг Жиранэд залуулав. Дараа нь хийсэн хөдөлгөөнөө



289. Ахмад, V, 286; Хэйсэмий, VI, 182-183; Ибн-и Хишам, IV, 79.
290. Ибн-и Хишам, IV, 84.

бүтээхээр Эбү Муса эл-Эш’арийгийн авга ах Эбү Амир даргалсан хүчнийг Эвтасын хөндийд илгээж, өөрөө ч Исламын цэргийн хамт Таиф руу чиглэв.

Эвтасын Дайн (8 оны Шэввал сар / 630 оны 2 сар)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн Таиф руу хөдөлсний улмаас өөрөө оролцоогүй уг дайнд Исламын хүчний дарга Эбү Амир -радъяллахү анх- шэхид болж, харин дайсны дарга ч алагдав.

Эбү Амир -радъяллахү анх- нь шархдаж амиа алдахаас өмнөхөн ач Эбү Мусадаа:

“–Аяа дүүгийн хүү! Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д надаас мэнд дамжуулчих! Миний төлөө Аллахаас өршөөл гуйж өгөөсэй!” гэв.

Авга ах нь шэхид болоход удирдах үүргийг дааж авсан Эбү Муса -радъяллахү анх- цэргийн тарагдахыг саад болж довтолгоог төгс төгөлдрөөр удирдаж Исламын далбааг Эвтаст ялалтаар хийсгэв. Харихдаа Аллахын Элчид авга ахынхаа шэхид болсныг ба амиа бууж өгөхдөө хийсэн гэрээсийг нь мэдээлэв. Тэгэхлээр нь Орчлонгийн Хүндэт Эзэн маань ус нэхэж абдэст аваад, гараа дэлгэн:

“Аллах минь! Боол Эбү Амирыг өршөө! Түүнийг киямат өдөрт энэ хүмүүсийн ихэнхээс дээгүүр оронд байлга!” хэмээн залбирав. Эбү Мусаг хүссэнээр түүний төлөө ч залбирав. (Бухарий, Мэгазий, 55)

Таифын Бүслэлт (8 оны Шэввал / 630 оны 2 сар)

Хижаз тойргийн дэлхий дээрх диваажин хэмээн тоолохуйц нэгэн хот байсан Таиф нэгэн даваан дээр барьсан бат бэх нэгэн

цайзтай байв. Ийм учраас Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хийсэн бүслэлт нэлээд хэцүү өнгөрсөн байдаг.

Уг бүслэлт нь Хүнэйний Дайны үргэлжлэлийн шинжтэй байв. Учир нь, Хүнэйнээс зугтагсад ба тэдний залуу тэргүүн Малик бин Авф бүгд Таифын хэрэмд орсон байв. Тэд Бэний Сакифын хамт шинэ нэгэн хамгаалах дайнд бэлдсэн байв.

Бүслэлтэд дайны олон тактик хэрэгжүүлж, дайны шинэ багаж хэрэглэв. Харин Таиф нь маш бэхжүүлсэн цайз байсан тул дайралтад үнэхээр тэсвэртэй байв. Нөгөө талаас дайсан ч хэрмийн гадаа гарахгүй байв. Түүнчлэн Халид бин Вэлид тэднээс байлдахаар эр нэхэхэд тэд хариулан:

“–Чиний эсрэг зогсох хүн бидний цайзанд үгүй!” гээд байсан газраасаа нэгэн хүн ч гаргаагүй байцгаав. Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Дайсан нь үнэг шиг агуйдаа орсон байна. Одоо тэднийг ингэж үлдээвэл, тэднээс ямар ч аюул үүсэхгүй!” хэмээж бүслэлтийг цуцалбал ямар нэгэн аюул болохгүйг заав. Учир нь Тэр дайрагч биш, рахмат ба энэрлийн пайгамбар байв. Маккад болсон шигээ Таифчуудын чавралтад хүрэхэд арга болохыг хүсдэг байв. Тэгээд удахгүй бүслэлтийг цуцлав.

Асхаб-и кирам нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс Таифын бүслэлтэд мусульманчуудад олон хохирол учруулсан Сакиф аймгийнханд хараал хийхийг гуйсан байв. Энэрлийн Пайгамбар бол тэдний аврахын төлөө л залбирав:

“Аяа Раббий! Сакифад хидаят хайрлах болтугай! Тэднийг бидэнд илгээ!..” хэмээн Аллахад хоргодож ерөөн тэндээс салав. Эцэст нь энэ залбирлын элбэгээр богино хугацаанд Сакифчууд мусульман болох тулд Аллахын Элчид хүрээд ирцгээв. (Ибн-и Хишам, IV, 134; Тирмизий, Мэнакиб, 73/3942)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хижрэтээс өмнө өөрт нь муугаар хандсан, чулуу хаяад бүх талыг нь цусаар булсан аймагт хараагүйгээр үл барам, тэдний аврахыг чин сэтгэлээрээ хүссэн байдаг. Тэгээд их удахгүй тэднийг ирээд мусульман болоход нь үгээр тайлбарлашгүй баярт автан, тэднийг дайлан олон хоног цагаа тэдэнд зориулав.

Уг бүслэлтийн, тэр мөчид хамгийн чухал орлого нь, Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн цайз дахь боолчуудад мусульман болсны тохиолдолд эрх чөлөөт болохыг амласны дагуу олон боолын дайсны эгнээг орхиж Исламыг сонгоод аврал хүрсэн нь болов.[291]

Эбү Зүр’а -радъяллахү анх- ингэж ярина:

“Элч нарын Тэргүүн Эзэн маань Таифын аянд Карн-и Мэназил гэсэн газраас салахдаа хөлгөө унах юмсанд нь би Түүний тэмээ Кавсаг бэлтгэлээ. Кавсагийн ногтыг гараараа бариад, дээр нь суухлаар нь Түүнд гардуулж, унасны дараа би ч хойно нь сундаллаа. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- алхуулахаар тэмээний ташааг , ташуурдах бүрт нь ташуур нь надад ч хүрч байв. Дараа нь над руу харан:

«–Эсвэл ташуур чамд хүрч байна уу?» хэмээн асуув.

«–Тийм! Аав ээж минь Чамд золиос болог!» гэлээ.

Жиранэд буухлаар, нэгэн буланд бог мал байв. Олзны бараан дээрх албанаас тэдний тухай юм асуув. Алба нь ч асуусан юмын тухай мэдээлэл олгов. Үүний дараа Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Эбү Зүр’а хаана вэ?» хэмээн дуудав.

291. Бухарий, Мэгазий, 56.

«–Энд байна!» гэлээ.

«–Энэ малыг ав! Орой чамд хүрсэн тагуурын хариулт!» хэмээв. Тоолоход зуун хорь байсныг харлаа. Миний олсон ба хамгийн их ашигласан бараа нь энэ байв.” (Вакидий, III, 939)

Энэ хэрэгт Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хүний эрхийн тухай үзүүлсэн үлгэр жишээ нь олон эрнийг гийгүүлэх шинжтэй байдаг.

Олз Хуваах

Таифын бүслэлтийг цуцалсан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Исламын цэргийн хамт олзолсон бараа болон хүний цугласан Жиранэд ирэв. Тэр хооронд Эбү Муса эл-Эш’арий ч Эвтасын Дайныг хожиж тэнд хүрсэн байв. Исламын цэрэг хамаг дайснаа арилгасан байв. Хийсэн дайнуудад хорин лөрвөн мянга тэмээ, дөчин мянга бог мал, дөрвөн мянга укайя мөнгө ба зургаан мянга хүн олзолсон байв.[292]

Олзыг хуваaж эхлэхээс өмнө Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

“Хажуудаа олзны бараа авагсад нь зүү хүртэл нь буцааж өгөг! Олзны барааг авсан хүн киямат өдөр ичгүүртэй бөгөөд дорд унахыг сайн мэдээрэй!” (*Муватта*, Жихад, 22; Ахмад, V, 316)

Энэ хооронд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-д баригдсан хүмүүсийн хооронд Түүний сүүний дүү Хазрат-и Шэйма байсны мэдээлэл ирэв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- шууд түүний дэргэдээ авчраав нөмрөгөө тайлж Хазрат-и Шэймагийн доор дэвсэв. Этрэд хамт өссөн энэ үнэт сүүний дүүдээ өгөөмөр зангаараа халамжтайгаар хандаж:

292. Ибн-и Са’д, II, 152.

“–Тавтай морил!” гэв. Хуучныг дурсч нүд нь нулимсаар дүүрэв. Ээж болон аавыгаа асуув. Шэйма тэдний өмнө өнгөрснийг мэдээлэв. Аллахын Элч бусад хамаатны тухай ч мэдээлэл авав. Дараа нь:

“–Хүсвэл хайр ба хүндэтгэл үзээд миний дэргэд суу! Хүсвэл чамд олон бараа өгөөд аймгийнх чинь дэргэд илгээе? Чамд чиний хүссэнээр тусалъя,” хэмээв. Шэйма:

“–Чи надад бараа өгөөд бидний дэргэд ир,” гэв. Дараа нь мусульман болов. Аллахын Элч нь Шэйма Хатан ба гэр бүлээсээ амьд үлдсэнд нь тэмээ ба хонь өгөв. Шэйма Хатанд мөн нэгэн эр нэгэн эм боол өгөв. Шэйма ч тэднийг нэг нэгэнтэй гэрлүүлэв. (Ибн-и Хишам, IV, 91-92; Вакидий, III, 913)

Үүний дараа Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- олзыг хуваахыг түр хүлээлгэв. Үүний учрыг ойлголгүй бууж өгөхдөө ядуу байгсад нь үүний тухай гомдлоо ярив. Бадавий Арабчууд олзыг яаралтай хуваахыг нэхэж эхэлцгээв. Эцэст нь Пайгамбар Эзнийг маань Сэмүрэ төрлийн модон доор зогсоов. Гадны хувцас нь модонд тээглээд үлдэв. Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэмээгээ зогсоож:

“–Хувцыг минь надад өгцгөө! Хэрэв надад энэ таны харсан ой модны чинээ бараа байсансан бол, тэд бүхнийг танд хуваах байлаа. Тэгээд та ч намайг хараамж, худалж ба аймхай байгаагүйг харахсан!” хэмээв. (Бухарий, Жихад, 24)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- олзыг хувааж байхад дээр нь цуглараад Түүнийг маш их үймүүлсэн тулд эцэст нь (түрүүний нэгэн пайгамбарыг дурдан):

“Аугаа Аллах боолчуудаас нэгийг ардад нь илгээсэн байв. ард нь түүнийг зодоод толгойг нь ч хагалсан байв. Тэр боол бол духнаас урссан цусыг гараараа арчих зэрэг:

«Аяа Раббий ардыг минь өршөө! Тэд юу хийснээ мэддэггүй,» гээд залбирч байлаа,” хэмээв. (Ахмад, I, 456; Мүслим, Жихад, 105)

Эзний олзыг тараахад удаан хандсаны учир Жиранэд ирсний арав дахь өдөрт л ил гарав. Хожигдсон Хэвазин аймгаас нэгэн хамт олон Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д ирсэн мусульман болсноо мэдүүлж байв. Ийм учиртай бариг-дсан хүмүүс ба бараагаа буцааж авахыг нэхэж байцгаав. Энэ хооронд Са’дынхнаас нэг нь босоод:

“–Аяа Расулаллах! Тэр сүүдэртэд буй нь Чиний сүүний авга нагац эгч нар чинь болон Чамд сүү хөхүүлж хамгаалсан эмэгтэйчүүд мөн! Хэрэв бид Дамаск эсвэл Иракын ханыг хөхүүлсэн боловч одоогийн байдалд ороод тэднээс халамж гуйсансан бол, биднээс харамлахгүй байцгаав. Харин Чи сүү хөхүүлсэн хамгаалагчдын хамгийн буянт нь мөн!” гэв.

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

“–Би олзыг тараах ажлыг өнөөдөр хүртэл хүлээлгэв. Гэтэл та нэлээд оройтов! Одоо барьсан хүмүүс эсвэл олзны бараанаас нэгийг сонгоорой!..”

Тэгэхлээр нь хамт олон хүмүүсээ сонгов. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч:

“–Би надад ба Абдүлмутталибынханд оносон хүмүүсийг л танд буцааж өгнө. Бусдын төлөө ч маргааш үдийн мөргөлийн дараа надад ирээрэй!” хэмээв.

Дараа өдөр Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- асхабаа цуглуулан тэдэнд энэ хэргийг ярив. Өөртөө оносон боолчуудаа чөлөөлснөө ч мэдүүлж ингэж айлдав:

“–Танаас хэн нэгэн олзны хүнээ төлбөргүйгээр, сэтгэл ханамжаар өгөөд дүү нараа баярлуулахыг хүсвэл, тэгж хийгээрэй! Хэн ч өөрийнх хувиа үнэгүйгээр өгмөөргүй байвал, үүнийг Аллахын хайрлах анхны олзноос төлөх болно. Хүссэн нь ч тэгж болно!..”

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- асхабтайгаа зөвлөлцсөн нь боолчууд тэдний эрх байсны учиртай юм.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн өөрийнхөө боолчуудыг чөлөөлж тэднээс ч тэгэхийг хүсэхэд нь хамаг сахабий ч ижил эрдмийг ашиглахаар сэтгэл ханамжтайгаар:

“–Бид ч боолчуудаа Аллахын Пайгамбарт нь бэлэглэв!” гэцгээв. (Бухарий, Мэгазий, 54; Ибн-и Хишам, IV, 134-135)

Ингээд тэр өдөр Хэвазинд олон мянган дайны барьцааг ямар ч төлбөргүйгээр буцааж өгцгөөв. Түүх нь ийм үзвэрийг хэзээ ч гэрчлээгүй байв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн үммэтдээ тарьсан Исламын ёс суртахууны ачаар зургаан мянган боол нэгэн минутад ямар ч үнэгүйгээр чөлөөлөгдсөнийг дэлхий одоо л гэрчилж байв.

Энэ ижилгүй эрдмийн үр дүнд хамаг Хэвазинчууд нэг дор Исламыг хүлээж зөвшөөрөв. Түүнчлэн тэр хооронд Таифад байсан амгийн тэргүүн Малик бин Авф ч үүнийг мэдэхдээ гайхаад Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн жижиг нэгэн урилгаар тэр ч Исламд орох нэр хүндийг олов. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнд зуун тэмээ соёорхож дахиад аймгийн тэргүүн болохыг нь зарлав.[293]

Эндээс авах сургаал нь, хамгийн сайхан тэблиг сайхан ёс суртахуунаар байсан нь юм. Мөн фирасатаар хийсэн шинжлэх ухаант бодлогын хэдий том элбэгийн учир болох нь юм.

293. Ибн-и Хишам, IV, 137-138.

Эсрэгээр нь ухаангүйгээр хандахын илрүүлэх аюулын ч төдий том болохыг заадаг юм.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- олзыг хамгийн сайхнаар тараасан байв. Олзыг тав хувааж, дөрвийг цэрэгт өгөөд, нэгэн хувийг улсын санд үлдээсэн байв. Улсын сангийн удирдлага бол хүссэнээр нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн эрх байв. Тэгээд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- тараахаас өмнө үүнийг өмнөх тэмээнээс нэгэн хялгас түүж асхабт ингэж зарласан байв:

"Би таны олзтой нэгэн тэмээ биш, тэмээнйи хялгасны чинээ ч холбоотой биш... Та нар юунд тэвчээр алдсан юм бэ? Олзны бараа нь тэр хөндийн (чулуу болон) модны чинээ байсан ч, тэднийг танд тараана. Үүнээс тавны нэгийг ялгаж байвал, тэрийг ч таны ядуучуудын төлөө л зарцуулна." (*Муватта,* Жихад, 22; Ахмад, V, 316)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэнгэрлэг зарлалын дагуу олзноос өөрт нь оносон тавны нэгнээс мүэллэфэ-и күлүб буюу зүрхийг нь Исламд дасгамаар байгаа хүмүүст ихээр хувь олгосон байв. Эд нараас Хаким бин Хизам -радъяллахү анх- ингэж ярина:

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс надад олзны бараанаас хэсгийг өгөхийг гуйлаа, Тэр зуун тэмээ өгөв. Дахиад гуйвал дахиад зуун тэмээ өгөв. Дахиад гуйж дахиад зуун тэмээ өгөв. Дараа нь:

"–Хаким аа! Бараа нь үнэхээр сэтгэл татам ба амттай байдаг. Түүнийг хэн ч шуналгүйгээр авбал тэр бараа түүнд элбэгийг учруулна. Хэн ч түүнд нүд үзүүрлэн шунаж харвал, тэр бараанд элбэг болохгүй. Энэ нь идээд идээд яасан ч

цаддаггүй хүнтэй адил. Өгсөн гар нь авсан гараас буянтай юм," хэмээв.

Тэгэхлээр нь би:

"–Аяа Аллахын Элч ээ! Чамайг үнэнээр илгээсэн Аллахад тангараг өргөе, амьд байх хугацаагаар Чамаас өөр хэнээс ч юм авахгүй," гэлээ.

Хаким -радъяллахү анх- нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн өгсөн анхны зуун тэмээг аваад бусдыг нь үлдээв. Өдөр ирээд Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх- олзны бараанаас хувь өгөхөөр Хакимыг дуудав. Гэтэл Хаким түүнийг авахаас татгалзав. Дараа нь Хазрат-и Умар -радъяллахү анх- түүнийг юм өгөхөөр урив. Хаким -радъяллахү анх- дахиад аваагүй. Тэгэхлээр нь Хазрат-и Умар -радъяллахү анх-:

"–Аяа мусульманчууд аа! Би таныг Хакимд гэрч болгоё. Би түүнд тэр олзноос Аллахын түүнд олгосон хувийг өгөөд, харин тэр авахгүй байна," гэв. Эцэст нь Хаким нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг өөд болсны дараа, өөрөө нас бартлаа хэнээс ч юм аваагүй. (Бухарий, Вэсаяа, 9; Вакидий, III, 945)

Курайшийн мүшрикчүүдийн тэргүүлэгчдээс Сафван бин Үмэйе нь мусульман болоогүй боловч Хүнэйн ба Таифын дайнд Аллахын Элчийн дэргэдээс салаагүй байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Жиранэд цугласан олзны хооронд алхаад нүд гүйлгэж байхад Сафван ч Аллахын Элчийн дэргэд байгаад, тэмээ, хонь ба малчдаар дүүрэн хөндийд гайхснаараа харж байв. Пайгамбар Эзэн маань түүний энэ байдлыг нүд үзүүрлэн хараад байв. Түүнд хандан:

"–Эбү Вэхб ээ! Хөндий их таалагдав уу?" хэмээн асуув.

Сафван:

“–Тийм!” гэв.

Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Тэр хөндий ч түүний агуулсан нь ч чинийх болог!” хэмээв.

Тэгэхлээр нь Сафван биеэ барьж ядан:

“–Пайгамбараас өөр хэний зүрх ч ийм өгөөмөр байж болохгүй,” гээд шэхадэтийг хэлээд мусульман болов. (Вакидий, II, 854-855)

Дараа нь Сафван -радъяллахү анх- Курайшийн дэргэд хариад:

“–Ард минь ээ! Мусульман болцгоо. Валлахи Мухаммед ядуурлаас огт айхгүйгээр бараа соёорхож байна,” гэв. (Мүслим, Фэдаил, 57-58)

Эбү Сүфьяан, Акра бин Хабис, Үейнэ бин Хисн, Аббас бин Мирдас, Малик бин Авф мэтийн дөч орчим мүэллэфэ-и күлүбт ийм нүд гялбуулах бараа тараагдав.[294]

Аббас бин Мирдас нэртэй шүлэгч нь өөртөө олгосон олзны барааг бага гэж бодон Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д хандсан гомдлоо илэрхийлэх нэгэн шүлэг хэлэв. Орчлонгуудын Эзэн энэ мэдээг сонсохдоо түүнийг дуудан:

“–Чиний хэлийг би зүссүгэй!” гэв. Пайгамбар Эзэн маань Билал Хабэшийд өмнө нь:

“Чамд түүний хэлийг зүсэхийг хэлбэл түүнд нэгэн хувцас өг!” хэмээж сургасан байв. Дараа нь:

“–Билал аа! Үүнийг аваад хэлийг нь зүс!” хэмээв.

Билалыг Аббасын гарыг барин аваачихад Аббас:

294. Вакидий, III, 944-947.

“–Аяа Расулаллах аа! Миний хэлийг зүснэ гэнэ үү! Мухажирчууд аа, хэлийг минь зүснэ гэж үү! Энсар аа, миний хэлийг зүснэ гэж үү!” гэж орилж эхлэв. Билал -радъяллахү анх- бол Аббасыг татаж аваачаад байв. Аббас дуугаа ихэсгэвэл Хазрат-и Билал:

“–Дуугаа! Расулаллах нэгэн хувцас өгөөд чамайг дуугүй болгохыг тушаав,” гэв. Эцэст нь Билал Хабэший тайвширсан Аббаст нэмэлт өөр нэгэн хувцас ч өгөв. Аллахын Элч түүний хувийг зуун тэмээ өгөв. (Ибн-и Са’д, IV, 273; Мүслим, Зэкат, 137)

Энэ хооронд Са’д бин Эбий Ваккас -радъяллахү анх-:

“–Аяа Расулаллах аа! Жуайл бин Сүрака (шиг явуу нэгийг) орхиж Үейнэ, Акра (мэт баян ба аймгийнхаа тэргүүн хүмүүст) зуу зуугаар тэмээ өгөв!” гэлээ.

Оршигчдын Туяа Эзэн маань:

“–Биеийг минь хүчит гараараа барьсан Аллахад танга-раг өргөе, Үейнэ ба Акра мэтийн хүмүүсээр дэлхий дүүрсэн ч, Жуайл тэд бүхнээс илүү буянтай мөн! Гэтэл би эд нарыг Исламд дасгах тулд хамгаалж, Жуайлыг бол бат уягдсан Исламд нь ба ахиратад түүнд бэлтгэсэн агуу шагналтад илгэ-эж байна!” хэмээв. (Ибн-и Хишам, IV, 143; Ибн-и Са’д, IV, 246)

Түэллэфэ-и клүбт олзноос илүү олгосныг зарим нь буруу ойлгосон тул, асхабын хооронд үймээн гарав. Түүнчлэн Тэмимийнхнээс Зү’л-Хувайсра нэртэй нэг нь давран:

“–Аяа Аллахын Элч ээ! Эрх тэгшийг ханга!” гэж санаа үзүүлэв. Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэл-лэм- гунигтайгаар :

"–Тийм үү? Би ч эрх тэгшийг хангахгүй бол, эрх тэгшийг хэн хангах вэ?" хэмээж үгүйсгэсэн хүнийг зэмлэв. (Мүслим, Зэкат, 148)

Их удахгүй ает-и кэримэ буув:

وَمِنْهُم مَّن يَلْمِزُكَ فِي الصَّدَقَاتِ فَإِنْ أُعْطُواْ مِنْهَا رَضُواْ وَإِن لَّمْ
يُعْطَوْاْ مِنهَا إِذَا هُمْ يَسْخَطُونَ. وَلَوْ أَنَّهُمْ رَضُوْاْ مَا
آتَاهُمُ اللّهُ وَرَسُولُهُ وَقَالُواْ حَسْبُنَا اللّهُ سَيُؤْتِينَا اللّهُ
مِن فَضْلِهِ وَرَسُولُهُ إِنَّا إِلَى اللّهِ رَاغِبُونَ

"Элч минь ээ! **Тэднээс хандивыг** хуваах **тухай Чамайг буруушаагсад ч бий. Хандиваас тэдэнд ч** хувь **олговол тэд дуртай зөвшөөрнө, хэрэв тэдэнд хандиваас олгохгүй бол, шууд уурлана. Хэрэв тэд Аллах болон Элчийнх нь тэдэнд өгсөнийг зөвшөөрч; «Аллах бидэнд хүрэмжтэй. Ойрдоо бидэнд Аллах ч хайрлана, Түүний Элч ч. Бид зөвхөн Аллахыг сонгогчид мөн!» гэсэн нь,** (дээр болохсон)." (эт-Тавба, 58-59)

Энэ аетуудад Аллахын Элчийн гараар хийсэн олзыг хуваах ажлын, үнэндээ зөв хуваах байсныг мэдээлж, ухаангүй сэтгэл эрүүл сэтгэл хоёрын ялгааг тогтоож байдаг.

Үгүйсгэгчдийн ихэнх нь Энсараас байв. Харин Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- энэ өгөөмөр соёорхлоо олзны барааны бүтнээс биш, "фэй" гэдэг ба удирдлага нь зөвхөн Расулаллахад харъяалсан тавны нэгэн хэсгээс тараасан байв. Харин энэ ч Энсараас зарим залуусыг өдөөсөн

байв.[295] Илэрсэн ийнхүү эсэргүүцлийг зогсоохоор Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-, хэрэг бүр өсөхөөс өмнө хамаг Энсарыг цуглуулав. Тэднээс өөр хэнийг ч хажуудаа оруулаагүй энэ цуглалтад, хэргийн жинхэнэ цөмийг ойлгуулахаар Аугаа Эрхийн тэдэнд хайрласан шимүүдийг сануулаад ингэж хандав:

“–Аяа Энсар аа! Миний тухай сэтгэлдээ төрүүлсэн гомдлыг тань би дуудлаа. Харин та хэлээрэй, та нарыг замаа төөрсөн мүшрикчүүд байхад Аллах Таала миний аргаар танд зөв замыг үзүүлээгүй юү? Та нарыг ядуу хүмүүс байхад намайг таны дэргэд ирснээр Аугаа Эрх та бүхнийг баян болгоогүй юү? Таны хооронд өс өшөө таныг мөлжиж байхад, намайг ирснээр Хазрат-и Аллах, таны сэтгэлийг засаад нэгдүүлээгүй юү?”

Эдгээр асуултууд бүхэнд ч Энсараас:

“–Хамаг талархал ба шим Аллах болон Элчийнх нь төлөө юм!” гэж хариу авсан Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- учир утгатай яриагаа үргэлжлүүлэв:

“–Аяа Энсар аа! Та надад, «Чиний ард Чамайг үгүйсгэсэн байхад бидний хооронд ирлээ! Чамайг бид баталсан! Чиний ард Чамайг орхисонд Чамд бид тусалсан! Чиний ард Чамайг хөөж, бид Чамайг элгэндээ дарцгаав! Чи ядуу байсан, бид Чамайг бараандаа түнш болголоо!..» гэсэнсэн бол, би ч таныг баталж; «Та маш зөв хэлж байна!» гэх байсан...

Энсар аа! Зарим хүмүүст миний өгсөн дэлхийн бараанаас болж таны хувьд хэлсэн үгс нь үнэн үү? Миний зарим хүмүүсийн сэтгэлийг Исламд дасгах тулд өгсөн ба таны шүтлэгийн хүч ба хүндэд итгэсэн тулд танаас харамласан дэлхийн бараанаас болж санаа зовоод, ийм учиртай таны нэфист давчуу санагдав уу?..

295. Камил Мирас, *Тэжрид Орчуулсан нь,* X, 341.

Энсар аа! Хүн бүрийг авсан барааны хамт гэртээ харьж байхад нь та ч Пайгамбарынхаа хамт гэртээ харихыг хүсэхгүй байна уу?"

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн иим үгсийн дагуу Энсарын нүдэнд хурсан нулимс нь үер шиг урсч эхлэв. Одоо тэд цурхиран уйлаад:

"–Аяа Расулаллах аа! Бид нар Чиний хамт харимаар байна!" гээд хайраа шинэчилж байв. Тэдний хамт Аллахын Элч ч уйлав. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Энсарын ингэж бууж өгсөнд нь тэднийг магтах утгаар:

"–Энсар аа! Хэрэв хижрэтийн нэр алдар ба эрдэм байсансангүй бол, би заавал Энсарын нэгэн болмоор байлаа... Энсар аа! Хэрэв хүн бүр нэгэн зам бариад явбал, би Энсарын замаар явах байлаа!.." хэмээв.

Энэ гунигтай цуглааны дараа Энсарын эгнээнээс зөвхөн «Аллахын Элч бидэнд хүрэмжтэй юм!» гэсэн үг дуулдаж байв. Ингээд нэгэн буруу ойлголтын нээсэн шархыг Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ариун яриа нь ороосон байв. (Бухарий, Мэгазий, 56; Мүслим, Зэкат, 135; Хэйсэмий, X, 31)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн энэ үлгэр жишээ хандлагаас бидний авах олон сургаал байдаг. Хүн нь байгалиараа сайн сайханд хожигдоно. Сайнаар хандсан хүн нь дайсан байвал, дайсан болохоо болино; дунд байвал ойртоно; ойр байвал хайр нь нэмэгдэнэ.

Товчоор нь, Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хамгийн сайхан үлгэр жишээ хүн байсны нэгэн илрэл ч энэ олзны хуваах үеэр илээр харагдсан байдаг.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Жиранэд арван гурав хоносны дараа үмрэ хийхээр ихрамд ороод тэндээс салав.[296] Ийм учраас Макка болон түүний эргэн тойрны хүмүүсийн Жиранэд ихрамд ороод хаж үмрэ хийсэн нь илүү эрдэмтэй гэж тоологдсон байдаг.

Нэгэн Мусульман Алсны Ял

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Мадина-и Мүнэввэрэгээс хөдлөхөөс өмнө зорилгоо андууруулахаар Эбү Катадэг бага хүчээр Нэжидийн тийш илгээсэн байв. Энэ анги нь "Изам" гэдэг газар хүрэхдээ Амир бин Адбат нэртэй хүнтэй тааралдав. Амир нь мусульманчуудад мэнд өгч, кэлимэ-и шэхадэт авчирч мусульман болсныг мэдээлэв. Гэтэл Эбү Катадэгийн хамт ирэгчдээс Муаллим бин Жэссамэ нь өнгөрсөнд хэрэгжсэн хувийн нэгэн хэргээс болж Амирын үнэхээр мусульман болоогүйг илчилж түүнийг алаад барааг нь олзолж авав.

Эбү Датадэ болон анги нь Нэжидээс харихад Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хүнэйний Хөндийд үдийн мөргөлөө дөнгөж үйлдсэн, эргэн тойрондоо асхабынхаа хамт нэгэн модон доор суусан байв. Энэ явдлыг Түүнд мэдээлэхлээр нь уг ает-и кэримэ буув:

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُواْ إِذَا ضَرَبْتُمْ فِي سَبِيلِ اللّهِ فَتَبَيَّنُواْ وَلاَ تَقُولُواْ
لِمَنْ أَلْقَى إِلَيْكُمُ السَّلاَمَ لَسْتَ مُؤْمِنًا تَبْتَغُونَ عَرَضَ الْحَيَاةِ الدُّنْيَا
فَعِندَ اللّهِ مَغَانِمُ كَثِيرَةٌ كَذَلِكَ كُنتُم مِّن قَبْلُ فَمَنَّ اللّهُ
عَلَيْكُمْ فَتَبَيَّنُواْ إِنَّ اللّهَ كَانَ بِمَا تَعْمَلُونَ خَبِيرًا

296. Бухарий, Үмрэ, 3; Тирмизий, Хаж, 92/935.

“Аяа итгэгчид ээ! Аллахын замд жихадад гарахдаа итгэгчийг кафирaас ялгах тулд сайхан шинжлээрэй. Танд мэнд өгсөн хүнд, дэлхийн ашгийг бодож «Чи мусульман биш битгий!» гээрэй. Аллахын онгонд элдэв олз байдаг. Исламд анх орохдоо та ч тийм байцгаав. Дараа нь Аллах танд хайрлав. Тийм учраас сайхан шинжлээрэй. Андашгүй нь Аллах таны хийсэн үйлсийг мэдэгч мөн.” (эн-Ниса, 94)

Тэр хооронд Амирын садан хамаатан ирээд Мухаллимаас зарга мэдүүлэв. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн онгонд урт удаан шүүхийн дараа Амир нарын зөвшөөрлөөр диет буюу ижил хариу шийдвэр гаргаад тэд:

“–Мухаллим ирээд Аллахын Элч түүний төлөө Аллахаас истигфар буюу өршөөл гуйгаасай!” гэцгээв.

Мухаллимыг ирэхлээр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- асуув:

“–Амир мусульман болсны хэлсэн атлаа чи түүнийг алав, мөн үү?”

Энэ удаа Мухаллим:

“–Аяа Аллахын Элч ээ! Миний төлөө истигфар гуй!” гэхээс аргагүй болов. Мухаллимын ингэж хэлсэн нь хэргийг мэдээд хийснийг нь илчилсэн байв. Тэгэхлээр нь, мусульман байсан бөгөөд ямар ч гэмт хэрэггүй хүнийг алсан тул түүнийг өршөөх гэж байгаагүй. Хэрэв энэ тухай өчүүхэн хүлцэл үзүүлбэл, дараа нь нийгэм дотор ийнхүү хүн алахад саад болох боломжгүй болох байв. Ийм учраас орчлонгуудад энэрэл болохоор илгээгдсэн Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Мухаллимын хийсэн энэ хүнд гэмээс үүссэн истигфарын нэхэмжийг татгалзаж түүнчлэн:

“–Аллах чамайг битгий өршөөгөөсэй!” хэмээн илэрхийлэв.[297]

Үүнээс сургаал гаргаж авсан шүлэгч Кэмал Эдиб Күркчүоглу нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тааллыг алдуулах бүх төрлийн үйлээс холдох утга-ар сануулан маш сайхан хэлжээ:

Түүний магтаалаас холдсон нь хайран,
Хоёр хорвоод ч ухаан хүрэхгүй зовлон!..

Тэгээд Пайгамбарын хилэнд автаж Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэдээс салсан Мухаллим гэртээ хориг-дов. Долоо хоногийн дараа гунигласаар үхэв. Хамаатан нь түүнийг булахад, хөрс энэ шарилыг хүлээн аваагүй. Дахин дахин булсан ч газар нь удаа бүрт түүнийг гадагш хаяж байв. Аргагүй ба гайхсан буйдаа Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-д хүрээд байдлыг илэрхийлцгээв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч:

“–Энэ хөрс нь түүнээс ширүүн олныг ч тэвэртээ авсан байдаг, гэтэл Аллах Таала танд сургаал заах ба «Ла илахэ иллаллах»ын үнэ цэнийг мэдүүлмээр байна!” хэмээж Мухаллимыг дахиад ба булш дээр нь чулуу тавиулж булахыг айлдав. (Ахмад, V, 112; Ибн-и Мажэ, Фитэн, 1; Ибн-и Хишам, IV, 302; Вакидий, III, 919)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- “Ла илахнэ иллаллах”ын эрх болон хүндийг үл үзэхийн хэдий том гутам-

297. Уг байдлыг дамжуулсан сахабий ингэж хэлнэ:
“Бид хоорондоо «Расулаллах түүний төлөө өршөөл гуйв. Харин түүний хийсэн үйлийн хэр их муу буйг тодруулах ба нэг нэгээ алахыг нь саатуулах тулд ингэж хандав,» гэж ярьдаг байв.” (Ахмад, V, 112; Ибн-и Хишам, IV, 304)

шиг ба нэгэн мусульманд эрх бус хандахыг, түүний дэлхийн ашгийн төлөө алахын хэдий том нүгэл буйг заахаар ингэж хандсан, хүмүүсийг ийнхүү хүн алахаас хатуу болгомжлуулсан байдаг.

Энэ явдал нь дэлимэ-и тэвхидийг хэлсэн хүнийг мусульман гэж таних хэрэгтэйг мэдүүлнэ. Ийм байдал дахь хүн, ил күфүр хийгээгүй тохиолдолд, түүний төлөө муугаар бодох нь харам юм.

Энэ явдал мусульманчуудын шийдвэр гаргахдаа илийг харах хэрэгтэйг ба энэ нь ямар чухал хэрэг буйг ч харуулдаг. Учир нь, хүний гадны байдлаар шийдвэр гаргахдаа ч андуурах магадлал байхад, мөн түүнд тогтох аргагүй дотор байдлаар хандах мэдэл олгосонсон бол, хүмүүс хувийн бодлоор олон эрх бус шийдвэр гаргаж чирэгдэхээс аргагүй болох байсан.

Илээр шийдвэр гаргах зөвшөөрлийн өөр нэгэн учир ч, дутуу үйлтэй хүмүүсийн «Чи миний зүрхийг хар!» мэтийн шалтгаан барихыг саад болох юм. Манай эрин ихээр хандсан энэ тактикыг Ислам тавьсан энэ дүрэм ба түүнийг Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хэрэгжүүлснээр хүчингүй болгосон байдаг. Илээр шийдвэр гаргах нь мүнафикчуудын хэсэг хугацаагаар толилуулсан зөв үйлсээрээ өөрсдийгөө далдалж нифакаа илүү нөлөөтэйгөөр хэрэгжүүлэхийг боломжтой болгох нэгэн дутагдал шиг харагдсан ч, эрх тэгшийг санаагаараа хэрэгжүүлэх мэтийн буруу сэтгэгдэл төрүүлэх байдлыг саатуулдаг.

Маккад Захирал ба Багш Томилогдсон нь

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Маккагаас салахаас өмнө хотыг удирдах ба Мусульманчуудын хаж үйлсийг захируулахаар Аттаб бин Эсидийг захирлаар томилов. Өмнө нь

Хүнэйний Дайнд гарахдаа ч түүнийг Маккад захирал болохоор үүрэг өгсөн байв. (Ибн-и Хишам, IV, 69, 148) Аттаб -радъяллахү анх- нь тэр хооронд дөнгөж хориод настай байв.[298] Харин тэнд настай ба эрдэмтэй хүмүүс байв. Үүнээс харвал орон суудлыг болзол хангасан чадвартай буюу салих, ухаантай, эрдэмтэй ба такватай хүмүүст олгох хэрэгтэйг ойлгох болно.

Тэр чигээр нь Исламыг үе үеэр дамжуулан авралын бамбар шиг манай өдөрт хүргэхэд хамгийн том үүргийг даасан сахабийчуудын ерөнхийдөө Аттаб бин Эсид шиг эрдэмтэй залуус байсан нь илэрч байдаг. Жишээлбэл хамгийн олон хадис дамжуулсан сахабийчуудаас Абдуллах бин Умар ба Ибн-и Аббас нар, Эзнийг маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- өөд болоход арван гуравтай, Хазрат-и Энэс, Ибн-и Мэс'үд ба ялангуяа эмэгтэйчүүдийн Исламыг сурахад маш чухал үүрэг даасан Хазрат-и Аиша нар арван наймтай байцгаав. Тэр чигээр нь Акабагийн Бий'атуудад оролцсон сахабийчууд ихэнхдээ залуусаар бүрдсэн байв. Дахиад Исламыг тэблиг учиртай Би'р-и Маунэд шэхид болсон Кур'аны багш нарын ихэнх нь ч залуу байв. Энэ нь Исламын ирээдүйд чухал үйлчилгээ даах залуусыг чухалчилж тэдний боловролд нямбай анхаарал үзүүлэх хэрэгтэйг тэмдэглэх чухал баримт юм.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- шинээр мусульман болсон хэн нэгнийг цаг алдалгүй Кур'ан болон сүннэтийг сурахыг нь хүсдэг байв. Ийм учиртай хажууд нь ирсэн хүмүүсийг цөөн хэдэн хоногоор байсан ч асхбаынхаа дэргэд бараг өнөры нэгэн боловсролын багт оруулдаг байв. Өглөө болоод хажууд нь ирэхэд тэднийг шалгаж, хэрэв хангалттай

298. Ибн-и Эсир, *Усдү'л-Габэ,* III, 556.

гэж үзэхгүй бол тэднийг өөр сахабийчуудад илгээж Исламыг сайхан эзэмшихийг нь хүсдэг байв.

Пайгамбар Эзэн маань энэ чамбай хандлагынхаа нэгэн тэмдгээр Маккачуудад шашны дүрэм журам ба Кур'ан-и Кэримийг сургахаар Муаз бин Жэбэл[299] ба Эбү Муса эл-Эш'арий[300] -радъяллахү анхүмаа-г тэнд үлдээв. Энэ ч бидний шашны сургаал ба боловсролыг хэр их чухалчлах хэрэгтэйг заасан бодит нэгэн баталгаа мөн.

299. Ибн-и Хишам, IV, 148-149; Хаким, III, 303/5181.

300. Вакидий, III, 959.

ХИЖРЭТИЙН ЕС ДЭХ ЖИЛ

Хэлэн Сэлэм

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь зэкат өгмөөргүй байсан Бэний Тэмим аймаг дээр Хазрат-и Үейнэг хэсэг цэргийн хамт илгээсэн байв. Үейнэ -радъяллахү анх- ч Тэмим аймаг дээр гэнэтхэн хийсэн дайралтаар тэднийг ялж, маш их олз ба боолтойгоор Мадина-и Мүнэввэрэд харив.[301]

Тэгэхлээр нь Тэмимийн ахмадууд боолчуудаа аврахаар өнөр нэгэн хамт олноороо бас шүлэгчээ дагуулан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д ирцгээв. Мэсжидэд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг хүлээж байхдаа тэсч ядан:

“–Одоохон гараад ир гэх зэргээр!” хүндэтгэлгүй бүдүүлэг хандацгааж байв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь тэдний ингэж орилсонд үймрэв. Тэгэхлээр нь буусан аетад ингэж айлдав:

إِنَّ الَّذِينَ يُنَادُونَكَ مِن وَرَاءِ الْحُجُرَاتِ أَكْثَرُهُمْ لَا يَعْقِلُونَ

Элч минь! **Чамд өрөөний ард талаас орилогсдын ихэнх нь ухаангүй хүмүүс юм.”** (эл-Хужурат, 4) (Ибн-и Хишам, IV, 223, 233)

---

301. Ибн-и Са’д, II, 160.

Оршигчдын Туяа Эзэн маань үдийн мөргөлөө үйлдсэний дараа мэсжидийн хашаан дотор суув. Бэний Тэмимийн хамт олон:

“–Чамтай шүлэг хэлэлцье хэмээн шүлэгчээ ч авчирлаа!” гэцгээв.

Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Би шүлэг уншихаар илгээгдээгүй. Харин та нар нэг хэлэ-эд үз!” хэмээв. (Ибн-и Эсир, *Үсдү’л-Габэ,* I, 128)

Бэний Тэмимээс нэг нь босоод уран үг хэлэв. Тэгэхлээр нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг асхаба-ас Сабит бин Кайс -радъяллахү анх-ад дохихлоор тэр ч босоод Аугаа Эрх хэр агуу бөгөөд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн номлолын тухай төгс төгөлдөр үг хэлээд Тэмимийн хүнийг хожив.

Үүний дараа Тэмимийнхнээс Зибрикан бин Бэдрийн унш-сан шүлэгт ч алдарт шүлэгч Хассан бин Сабит -радъяллахү анх- хариу өгөөд Ислам шашны цуу алдрын тухай шууд маш сайхан шүлэг хэлэв.

Асхабын уг ялалт нь Кур’ан-и Кэрим шиг хэлний гайхшиг буй тэнгэрлэг Номд сэтгэл өгөөд, мөн түүнчлэн “Жэвамиү’л-кэлим: Цөөн үгээр олон утга илэрхийлэгч” ба хамаг хүмүүсийн хамгийн гоё яригч буй Аллахын Элч -саллаллахү алэй-хи вэ сэллэм-ийн боловсрол нь мэдэгдэж байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс энэ эрдмийг үр дүнг шүлэгч маш сайхан өгүүлжээ:

Түүнийг хоромхон харагч нь сарнай болно,
Үгийг нь сонсогч нь гургалдай болно...

Тэгээд уг үнэнийг анзаарсан Тэмимийн шүлэгч Акра бин Хабич:

“–Энэ хүний үг хэлэгч бидний үг хэлэгчээс, шүлэгч нь ч бидний шүлэгчээс давуу юм. Тэдний дуу нь бидний дуунаас дээш юм!..” гээд найз нарынхаа хамт итгэж үнэмшив. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч хамт олны гишүүдэд олон янзын бэлэг гардуулав. (Ибн-и Хишам, IV, 232)

Тэр хооронд Хазрат-и Эбү Бэкир Хазрат-и Умар хоёрын хооронд Аллахын Элчийн онгонд жижигхэн нэгэн маргаан болов. Тэгэхлээр нь уг ает-и кэримэнүүд буув:

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُوا لَا تُقَدِّمُوا بَيْنَ يَدَيِ اللّٰهِ وَرَسُولِهِ وَاتَّقُوا اللّٰهَ إِنَّ اللّٰهَ سَمِيعٌ عَلِيمٌ. يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُوا لَا تَرْفَعُوا أَصْوَاتَكُمْ فَوْقَ صَوْتِ النَّبِيِّ وَلَا تَجْهَرُوا لَهُ بِالْقَوْلِ كَجَهْرِ بَعْضِكُمْ لِبَعْضٍ أَنْ تَحْبَطَ أَعْمَالُكُمْ وَأَنْتُمْ لَا تَشْعُرُونَ

“Аяа итгэгчид ээ! Аллах болон Элчийг нь битгий давцгаа! Аллахаас айцгаа! Андашгүй нь Аллах сонсогч, мэдэгч мөн. Аяа итгэгчид ээ! Дуугаа Пайгамбарын дуугаас дээш битгий гарга. Нэгэн нэгэндээ бархирах шигээ Пайгамбарт чанга дуугаар битгий бархир; эсвэл таныг анзааралгүй таны үйлс дэмий үрэгдэнэ.” (эл-Хужурат, 1-2)

Үүний дараа Хазрат-и Умар -радъяллахү анх- нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд ярихдаа дуугаа маш их багасгаад, Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам- түүний үгийг сонсч чадахгүй, юу хэлснийг түүнээс асуухаас аргагүй болох байв.[302]

302. Бухарий, Мэгазий, 68.

Бусад сахабийчууд ч Оршигчдын Туяа Эзнийг маань ихэд хүндэтгэдэг байв. Түүнийг үймүүлэхгүйн тулд ихээр хичээдэг байв. Тэгээд хүчит хоолойт нэгэн сахабий Пайгамбар Эзнийг маань үймүүлснээсээ айгаад том гунигтайгаар өөрийгөө гэртээ хаасан, Аллахын Элчийн тайтгаруулснаар тайвширсан байв.[303]

Асхаб-и кирам нь Орчлонгуудын Эзний хамт хоолонд суувал хэзээ ч Түүнээс өмнө гараа хоолонд сунгадаггүй байв.[304] Өрөөний хаалгыг нь хумсныхаа үзүүрээр тогшдог, Түүнийг үймүүлэх ямар ч хандлагаас хатуу болгоомжилдог байв.[305] Түүнийг дурдахдаа хэлсэн үгээ маш нямбай сонгоод, Аллахын Элчийг сар болон нараар төсөөлдөг байв.[306] Түүний хадисыг дамжуулахдаа ч хэтэрхий чамбай хандаж, дамжуулж байхдаа тэдний зүс өөрчилж, нүүрнээс нь хөлс урсч, нүд нь нулимсаар дүүрч хүзүүний судас нь гүрийдэг байв.[307] Мэсжидийн эргэн тойронд байсан гэрүүдийн аль нэгэнд гадас эсвэл хадаас хадсаныг дуудвал даруй "Расулаллахыг битгий үймүүлээрэй!" гээд мэдээ илгээдэг байв. Зарим нь ч гэрийнхээ хаалгыг Мадинагийн гадаа хийлгэдэг байв.[308]

Ка'б бин Зүхэйр өмнө нь Исламд дайн зарласан шүлэгчдээс байв. Бичсэн шог шүлгээс нь болж, илэрсэн газар алах тухай цус нь халал болгосон байв. Харин мусульман байсан дүү нь Бүжэйр түүнд сургаал болох нэгэн шүлэг бичээд, ингэж

303. Бухарий, Тэфсир, 49/1.

304. Эбү Давуд, Эт'имэ, 15/3766.

305. Бухарий, *Эдэбү'л-Муфрэд,* х. 316; Хэйсэмий, VIII, 40.

306. Мүслим, Фэдаил, 109.

307. Ибн-и Са'д, III, 156; Ибн-и Мажэ, Мукаддима, 38; Даримий, Мукаддима, 28.

308. Касталланий, II, 386.

үргэлжилбэл дүгнэлтийг нь гунигтай болохыг мэдээлэв. Ка'б ч ихээр сандраад Асхаб-и кирамаас нэгийг дагуулан Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн онгонд гараад нэрээ хэлэлгүй бий'ат хийв. Сөхөрч суугаад:

"–Аяа Аллахын Элч ээ! Ка'б бин Зүхэйр тавба хийж мусульман болоод аюулгүйн итгэмж авахаар таны агуу онгонд ирмээр байна, хүлээж авна уу?" гэж асуув. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс *"Тийм!"* гэсэн хариу гарахлаар нь баяраар:

"–Ка'б нь би байна, аяа Расулаллах!.." гэв. (Ибн-и Хишам, IV, 152; Хаким, III, 675/6480; Хэйсэмий, IX, 393)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн уг өршөөлд талархлын илэрхийлэл болохоор Пайгамбарын онгонд ирэхээс өмнө зохиосон "Банэт Сүад" гарчигтай магтаалаа уншиж эхлэв. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- үүнд ихээр дурлаж ариун мөрөн дээрх Хирка-и Шарифыг тайлж Ка'б -радъяллахү анх-ад өмсүүлэв. Ингээд магтаалын гарчиг, Араб хэлэнд хүрэм гэсэн утгын "бүрдэ" гэсэн үгээр дурдаж **"Касидэ-и Бүрдэ"** болов.

Ка'бт бэлэглэсэн Хирка-и Шарифыг түүнийг нас барсны дараа Хазрат-и Муавия худалдаж авав. Эзэн хаадад нэгнээс нөгөөд нь залгамжлуулан манай эринд хүрээд ирсэн бөгөөд Топкапы Өргөөнд хамгаалсан Хикоа-и Саадат нь энэ мөн.

"Касидэ-и Бүрдэ" гэсэн нэрээр алдаршсан өөр нэгэн магтаал бөгөөд, түүнийг ч Имам Бүсирий Хазрат зохиосон байдаг.[309] Гэтэл энэ хоёр дахь магтаалын жинхэнэ нэр нь "Касидэ-и Бүр'э" юм. Бүр'э нь өвчинд анагаах арга олох гэсэн утгатай бөгөөд Имам Бүсирий уг магтаалын элбэгээр саа өвчнөөс

309. Мухаммед бин Саид эл-Бусирий нь Египетийн хүн бөгөөд XIII зунд Мамлук гүрний үед амьдарсан байдаг. (608/1211-694/1296) (Х. Ибрахим Шэнэр, *Касидэ-и Бүрдэ Касидэ-и Бүр'э ба Усны Касидэ, х.* 32, 60)

авраргдсаны улмаас ийм нэр авсан байдаг. Тухайн явдал нь ийм байдаг:

Имам Бүсирий Хазратын биеийн тал нь саа дайрчээ. Тэр ч Касидэ-и Бүр'эг бичээд Аугаа Эрхээс анагаахын тулд гуйна. Магтаалыг бичихээ дуусгасан шөнө зүүдэндээ Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг хараад энэ магтаалыг Түүнд уншина. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч үүнд таатай болоод ариун гараараа Имам Бүсирийгийн саа дайрсан эрхтнүүдийг шавна. Имам Бүсирий сэрэхдээ өвчнөөсөө ямар ч тэмдэг үлдээгүйг гэрчлэн Аугаа Эрхэд талархана. Өглөөгүүр баяр баясгалантай мэсжид рүү явахдаа том вэлий Шэйх Эбү'р-Рэжа Хазраттай тааралдана. Шэйх Хазрат нь:

"–Имам аа! Хорвоогийн Хүндэтийг магтсан касидэг уншина уу?" гэнэ.

Имам Бүсирий:

"–Надад олон магтаал бий. Та алийг асууж байна вэ?" гэхлээр Шэйх Эбү'р-Рэжа:

"–Өнөө шөнө Расулаллахад уншсан магтаалыг чинь хүсье. Чамайг түүнийг уншихад би Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-д маш их таалагдсаныг харлаа," гэнэ.

Имам Бүсирий андуурсан асууна:

"–Уг магтаал болон зүүднийхээ тухай хэнд ч яриагүй байхад та хаанаас мэдээ вэ?.."

Шэйх Эбү'р-Рэжа хариулан:"–Имам аа! Би ч тэнд байлаа!.." гээд магтаалын анхны бэйтийг уншина:

أَمِنْ تَذَكُّرِ جِيرَانٍ بِذِى سَلَمِ
مَزَجْتَ دَمْعاً جَرَى مِنْ مُقْلَةٍ بِدَمِ

Сэлемийн[310] *андаа ухаандаа авсан учраас,*

Цусыг нулимсанд холио юм уу?..

“Еэ сэтгэл ээ, Сэлемчүүдийг санасан учраас нүднээсээ цуст нулимс урсгаж байдаг уу?”

Хэлээд дамжуулснаар уг магтаалыг Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн онгонд уншиж байхад Орчлонгуудын Эзэн нь тааламжаасаа болж ариун биеэ нэгэн модны навч найгах шиг ганхаж мишээж байжээ.

Ийм учиртай энэ магтаалыг, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн сүнсийг илрүүлэх тулд өвчтөнийг анагаахаар унших нь заншил болоод, уг магтаалаар Аллахын Элчийг аргалан Аугаа Эрхэд хоргодсон байдаг.[311]

Фасикын Мэдээг Сайхан Судал!

Хижрэтийн ес дэх жилд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн Мусталикынхнаас зэкат хураахаар илгээсэн Вэлид бин Үкбэ нь түүнийг угтахаар цугласан өнөр хүмүүсийг харахдаа айгаад, мунхаг үеийн нэгэн маргаанаас болж өөрийгөө алахыг нь бодов. Эргээд Мадинад ирж үүнийг Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг үнэнээс ялгаатайгаа буюу тэднийг гүтгэж ярив:

“–Аяа Аллахын Элч ээ! Тэд шашнаасаа халжээ. Зэкат өгөөгүй. Бараг намайг алах гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Мусталикынх дээр илгээхээр цэргийн анги бэлтгэв. Бэний Мусталик үүнийг

310. **Сэлем**: Мадина-и Мүнэввэрэд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн заримдаа асхабынхаа хамт ярилцсан модтой газрын нэр.

311. Илхан Армутчуоглу, *Касидэ-и Бүрдэ,* Конья 1983, х. 8-11.

мэдэнгээ Вэлидийг угтахаар цугласан хамт олон яаралтай Мадинад ирэв. Мадинад өөрсөд дээр илгээх гэж байсан Исламын ангитай тааралдав. Жинхэнэ хэрэг ил гарав. Энэ хооронд Аугаа Эрх нь хамаг итгэгчдэд ямар нэгэн явдалд судалгаа хийхгүй байгааг сануулахаар вахийгаа илгээв:

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُوا إِن جَاءكُمْ فَاسِقٌ بِنَبَأٍ فَتَبَيَّنُوا أَن تُصِيبُوا قَوْمًا بِجَهَالَةٍ فَتُصْبِحُوا عَلَى مَا فَعَلْتُمْ نَادِمِينَ. وَاعْلَمُوا أَنَّ فِيكُمْ رَسُولَ اللهِ لَوْ يُطِيعُكُمْ فِي كَثِيرٍ مِّنَ الْأَمْرِ لَعَنِتُّمْ وَلَكِنَّ اللهَ حَبَّبَ إِلَيْكُمُ الْإِيمَانَ وَزَيَّنَهُ فِي قُلُوبِكُمْ وَكَرَّهَ إِلَيْكُمُ الْكُفْرَ وَالْفُسُوقَ وَالْعِصْيَانَ أُوْلَئِكَ هُمُ الرَّاشِدُونَ

“Аяа итгэгчид ээ! Хэрэв нэгэн фасик танд ямар нэгэн мэдээ авчирвал, түүний зөв байх эсэхийг судал! Эсвэл мэдэхгүйгээр нэгэн нийгэм муу муухай хийгээд, дараа нь хийсэндээ гэмших болно. Мөн таны хооронд Аллахын Элч буйг мартуузай. Хэрэв Тэр ихэнх хэрэгт таныг дагасансан бол, та нар төвөгт автах байв. Гэтэл Аллах танд итгэл үнэмшлийг хайрлуулсан бөгөөд түүнийг таны сэтгэлд чимэглэсэн байдаг. Күфүр, фиск болон бослогыг ч танд муухай гэж үзүүлсэн байдаг. Эд нар зөв замд байгчид мөн.” (эл-Хужурат, 6-7)

Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-:

“–Аббад аа! Тэдний хамт яв! Зэкатыг нь ав! Барааных нь хамгийн сайныг сонгоод авахаас болгоомжил!” хэмээв. Аббад бин Бишр нь Мусталикынхны дэргэд арав хонов. Тэдэнд

Кур'ан-и Кэрим уншуулж Исламыг сургав. (Ахмад, IV, 279; Ибн-и Хишам, III, 340-341; Ибн-и Са'д, II, 161)

Заримдаа нэгэн фасикын гаралтай буруу мэдээлэл нь амаар дамжуулан эцэст нь фасик байгаагүй нь лав, магадгүй жаахан гэнэн нэгэнд хүрээд, тэр ч энэ мэдээллийг сайхан сэтгэлээрээ танд хүргэсэн байж мэднэ. Ийм тохиолдолд хэлсэн нь фасик байгаагүй ч худал ярианаас үүссэн мэдээг итгэж тараасан ч хариуцлага хүлээхийг мэдэх хэрэгтэй. Учир нь мэдээг эерэг байхад үүнээс ямар нэгэн асуудал төрөхгүй байсан ч, сөрөг байхад хэн нэгний эрхийг хүчирхийлэх болон гайбат мэтийн том нүгэлд автах аюул байдаг. Ийм учраас хорт үгийн үүсэлтэй ба дамжуулан ирсэн сөрөг мэдээний эсрэг байнга сэргэг байх хэрэгтэй.

Итгэл Үнэмшлийн Шалгуур: ТЭБҮКИЙН АЯН ДАЙН (9 оны Рэжэб сар / 630 оны 10-11-р сар)

Тэбүк нь Мадина Дамаск хоёрын яг дунд нэгэн хотын нэр бөгөөд тэнд хийсэн аян нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн оролцсон сүүлийн аян болсон байдаг. Энэ аян нь Мүтэгийн Дайны үргэлжлэл шиг байдаг. Византийн император нь Мүтэгийн Дайны түүнд үлдээсэн нөлөөнөөс болж хугацаа өнгөрж мусульманчууд илүү хүч олохоос өмнө хамаг Арабстаныг эзлэх зорилттой байв. Ийм учраас Христийн шашинтай Арабчуудтай хамтрах хэрэгтэй байв. Үүнд нэр дэвшүүлэгч гэж үзсэн Гассанийчууд ч үүнд аль хэдийнэ бэлэн байцгаав. Байдал нь ийм л байхад Мадина руу явдаг наймааны жингүүд дайсны бэлтгэлийг мусульманчуудад мэдээлж их удахгүй тэдний нутагт довтолгоон болохыг хэлцгээв.

Тэгэхлээр нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ерөнхий нэгэн дайн зарлав. Тэр үе хүртэл хийсэн цэргийн

үйлсийг нууц байлгаж, дайсны үүнийг мэдэхийг хүсдэггүй байв. Гэтэл Тэбүкийн Аян ялгаатай болов. Учир нь зуны улирлын хамгийн халуун өдрүүд байв. Дайсан хүчтэй, явах газар нь хол байв. Түүнчлэн тэр жил Мадинад илэрсэн ган гачигаас болж мусульманчууд эдийн засгийн талаар ч хэцүү байдалд байцгаав.[312]

Эдгээр бүхнийг завшаан гэж үзсэн мүнафикчууд дахиад хуучин фитнэдээ буцаад итгэгчдийн сүнсний байдлыг эвдэхийг хичээхээр оролдоцгоов. Тэргүүн мүнафик Абдуллах бин Үбэй:

"–Мухаммед Римийн гүрнийг хүүхдийн тоглоом гэж бодож байна уу? Би Түүний асхабынхаа хамт боолчилсныг нүдээрээ харах юм шиг боллоо!" гэж байв.

Хэсэг мүнафикчууд ч:

"–Ийм халуунд аянд гарах гэж байдаг уу?" гэж эхэлцгээв. Эд нарыг хариулан ает-и кэримэ нь ингэж айлдав:

فَرِحَ الْمُخَلَّفُونَ بِمَقْعَدِهِمْ خِلاَفَ رَسُولِ اللّهِ وَكَرِهُواْ أَن
يُجَاهِدُواْ بِأَمْوَالِهِمْ وَأَنفُسِهِمْ فِي سَبِيلِ اللّهِ وَقَالُواْ لاَ تَنفِرُواْ
فِي الْحَرِّ قُلْ نَارُ جَهَنَّمَ أَشَدُّ حَرًّا لَّوْ كَانُوا يَفْقَهُونَ

"Аллахын Элчийг эсэргүүцэхээр хойно үлдэгсэд нь аянд гараагүй **суусандаа баясцгаав; бараагаараа, амиараа Аллахын замд жихад хийхийг муухай гэж үзээд «Ийм халуунд аянд битгий гарцгаагаарай!» гэцгээв. Ингэж хэл: «Тамын гал нь илүү халуун юм!» Тэд нэг ойлгох болоосой!"** (эт-Тавба, 81)

---

312. Ибн-и Са'д, II, 165; Бухарий, Тэфсир, 66/2.

Бадавийчуудаас зарим нь ч Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-д зохиомол шалтгаан илэрхийлж зөвшөөрөл авав. Үүнийг ает-и кэримэ нь ингэж мэдээлэв:

وَجَاء الْمُعَذِّرُونَ مِنَ الأَعْرَابِ لِيُؤْذَنَ لَهُمْ وَقَعَدَ الَّذِينَ كَذَبُواْ اللّهَ وَرَسُولَهُ سَيُصِيبُ الَّذِينَ كَفَرُواْ مِنْهُمْ عَذَابٌ أَلِيمٌ

“**Бадавийчуудаас** шалтгаантай байснаа **санал болгогчид нь зөвшөөрөл авахаар ирцгээв. Аллах ба Элчид нь худал хэлэгчид ч суугаад үлдэв. Тэднээс кафир буйд нь гашуун нэгэн тамлал хүрэх болно.**” (эт-Тавба, 90)[313]

Үүний дараа Кур’ан-и Кэрим итгэгчид ба мүнафикчуудыг ялгахаар зарим хэмжүүр тогтоов:

لَوْ كَانَ عَرَضًا قَرِيبًا وَسَفَرًا قَاصِدًا لاَّتَّبَعُوكَ وَلَـكِن بَعُدَتْ عَلَيْهِمُ الشُّقَّةُ وَسَيَحْلِفُونَ بِاللّهِ لَوِ اسْتَطَعْنَا لَخَرَجْنَا مَعَكُمْ يُهْلِكُونَ أَنفُسَهُمْ وَاللّهُ يَعْلَمُ إِنَّهُمْ لَكَاذِبُونَ

“Аяа Элч минь! **Хэрэв дэлхийн ойр нэгэн ашиг ба амар нэгэн аян байсансан бол,** тэр мүнафикчууд **заавал Чамайг дагаж араас чинь явах байцгаав. Харин хэцүү зам тэдэнд хол санагдав. Хэдий тэд «Бидний хүч хүрсэнсэн бол заавал таны хамт замд гарахсан!» гээд биеэ үртлээ Аллахад тангараг өргөнө. Гэтэл Аллах тэдний андашгүй худалч буйг мэддэг.**” (эт-Тавба, 42)

313. Вакидий, III, 993-996; Ибн-и Са’д, II, 165.

لاَ يَسْتَأْذِنُكَ الَّذِينَ يُؤْمِنُونَ بِاللّهِ وَالْيَوْمِ الآخِرِ أَن يُجَاهِدُواْ بِأَمْوَالِهِمْ وَأَنفُسِهِمْ وَاللّهُ عَلِيمٌ بِالْمُتَّقِينَ. إِنَّمَا يَسْتَأْذِنُكَ الَّذِينَ لاَ يُؤْمِنُونَ بِاللّهِ وَالْيَوْمِ الآخِرِ وَارْتَابَتْ قُلُوبُهُمْ فَهُمْ فِي رَيْبِهِمْ يَتَرَدَّدُونَ

“Аяа Элч минь! **Аллах болон ахират өдөрт итгэж үнэмшигчид бол бараа болон амиараа байлдахаас** хойно үлдэхээр **Чамаас зөвшөөрөл эрдэггүй. Аллах такват хүмүүсийг маш сайн мэддэг. Зөвхөн Аллах болон ахират өдөрт итгээгүйчүүд, зүрх нь сэжигт автаад ийм сэжиг дотроо тээнэгэлзэгчид нь Чамаас зөвшөөрөл эрнэ.”** (эт-Тавба, 44-45)

Мүнафикчууд аяны төлөө ямар ч бэлтгэл хийгээгүй байцгаав. Энэ бол тэдний дайны зорилттой байгаагүйг илээр тодруулж байв. Аугаа Эрх ингэж айлдана:

وَلَوْ أَرَادُواْ الْخُرُوجَ لأَعَدُّواْ لَهُ عُدَّةً

“Элч минь! **Хэрэв тэд** Чамтай хамт дайнд **гармаар байсансан бол, мэдээж үүний төлөө бэлтгэл хийх байцгаав...”** (эт-Тавба, 46)

Мүнафикчуудын ингэж ил гараад цэрэгт оролцоогүй нь тэнгэрлэг нэгэн бэлэг байв. Жишээлбэл Абдуллах бин Үбэй энэ аянд ч Ухудад хийснийг дахиж буцсан байдаг. Энэ тухай Аугаа Эрх ингэж айлдана:

وَلَكِن كَرِهَ اللّهُ انبِعَاثَهُمْ فَثَبَّطَهُمْ وَقِيلَ اقْعُدُواْ مَعَ الْقَاعِدِينَ. لَوْ خَرَجُواْ فِيكُم مَّا زَادُوكُمْ إِلاَّ خَبَالاً ولأَوْضَعُواْ خِلاَلَكُمْ

يَبْغُونَكُمُ الْفِتْنَةَ وَفِيكُمْ سَمَّاعُونَ لَهُمْ وَاللّٰهُ عَلِيمٌ بِالظَّالِمِينَ

“...Аллах тэдний үйлсийг муухай гэж үзээд тэднийг хойно үлдээв. Тэдэнд: «Суугчдын эмэгтэй болон хүүхдүүдийн **хамт суугаа!» гэв. Хэрэв таны хамт** тэд ч дайнд **гарсансан бол, танд үймээн дэгдээхээс өөр ашиг олгохгүй бөгөөд таны дунд заавал фитнэ өдөөхөөр явах байцгаав. Таны дунд тэдэнд чихээ өгөх хүмүүс ч байдаг. Аллах харгисчуудыг маш сайн мэддэг.”** (эт-Тавба, 46-47)

Одоогоос үймээн гаргасан мүнафикчууд үнэхээр дайны явдалд маш аюултай болоод, фитнэ, худал, гүтгэлэг ба аймхай зангаараа Исламын хамаг цэргийн тавыг эвдэж, тус бүр нь бараг нэгэн шарх шиг мусульманчуудад зовлон учруулдаг байв. Ийм л учраас Аугаа Эрхийн хайрлал хүрээд мүнафикчууд, энэ аяны агуулах олон төвгөөс айгаад энэ аянд оролцож чадаагүй. Асхаб нь тэдний фитнэгээс аврагдав.

Мүнафикчууд тус бүр нь нэгэн шалтгаан зохиож дайнаас зөвшөөрөл эрж байв. Энэ зөвшөөрлийн асуудлыг маш их хэтрүүлж, зарим нь тэр хавьд Римийн бүсгүйчүүдийн харахаад өөрөө фитнэд автахаас айснаа илэрхийлэхээс татгалзаагүй. Ингээд ухаандаа зөв талд харагдаад мүнафик буйгаа далдлахыг хичээж байцгаав. Гэтэл Аллах Таала тэдний ийм байдлыг ч илрүүлэв:

وَمِنْهُم مَّن يَقُولُ ائْذَن لِّي وَلاَ تَفْتِنِّي أَلاَ فِي الْفِتْنَةِ
سَقَطُواْ وَإِنَّ جَهَنَّمَ لَمُحِيطَةٌ بِالْكَافِرِينَ

“Тэднээс зарим нь «Надад зөвшөөрөл өг, намайг фитнэд битгий автуул!» гэнэ. Тэдний угаасаа фитнэд автсан

буйг мэдэцгээ. Там нь кафирчуудыг заавал бүслээд авна.” (эт-Тавба, 49)

Нэг талаас мүнафикчуудыг гашуун тамлалаараа сүрдүүлсэн Аугаа Эрх нөгөө талаас тэдний нөлөөнд автаж жаахан суларсан итгэгчдийг ч сануулж байв:

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُواْ مَا لَكُمْ إِذَا قِيلَ لَكُمُ انفِرُواْ فِي سَبِيلِ اللّهِ اثَّاقَلْتُمْ إِلَى الأَرْضِ أَرَضِيتُم بِالْحَيَاةِ الدُّنْيَا مِنَ الآخِرَةِ فَمَا مَتَاعُ الْحَيَاةِ الدُّنْيَا فِي الآخِرَةِ إِلاَّ قَلِيلٌ. إِلاَّ تَنفِرُواْ يُعَذِّبْكُمْ عَذَابًا أَلِيمًا وَيَسْتَبْدِلْ قَوْمًا غَيْرَكُمْ وَلاَ تَضُرُّوهُ شَيْئًا وَاللّهُ عَلَى كُلِّ شَيْءٍ قَدِيرٌ

“Аяа итгэгчид ээ! Танд юу болоод«Аллахын замд дайнд явцгаа!» гэхлээр газар хадагдаад үлдэж байна вэ? Эсвэл **дэлхийн амьдралыг ахиратаас илүү үзэж байна уу? Харин** үүнийг мэдээд битгий мартаарай, **дэлхийн амьдралын** түр зуурын **ашиг нь ахиратын** мөнх ашгийн **дэргэд маш бага юм. Хэрэв** хэрэгтэй байхад дайнд **гарахгүй бол,** Аллах **таныг нэлээд зовлонтой тамлалаар яллаж таны оронд танаас өөр нэгэн ард авчирна. Та** дайнд гарахгүйдээ **Тэрээрт аюул хүргэж чадахгүй. Аллах бүхнээс чадалтай мөн.”** (эт-Тавба, 38-39)

انْفِرُواْ خِفَافًا وَثِقَالاً وَجَاهِدُواْ بِأَمْوَالِكُمْ وَأَنفُسِكُمْ فِي سَبِيلِ اللّهِ ذَلِكُمْ خَيْرٌ لَّكُمْ إِن كُنتُمْ تَعْلَمُونَ

“Аяа итгэгчид ээ! **Хэцүү санагдсан ч, амар санагдсан ч** Аллахын замд **гарцгаа! Бараа болон амиараа Аллахын замд**

жихад хийцгээ! Хэрэв мэдвэл, энэ нь таны төлөө мэдээж **илүү буянтай юм.”** (эт-Тавба, 41)

Ийм сануулгын дагуу итгэгчид дахиад нэг сэргэв. Сэтгэл дэх сул байдлын оронд гэмшлээр дүүрэн хөдөлгөөн ирэв. Итгэлийн хөөрсөн үйл ажиллагаа эхлэв. Учир нь дайсны исламын оронд довтолсны тохиолдолд Жихад нь фарз-и бөгөөд хамаг итгэгчид үүнийг дагах хариуцлагатай байдаг. Гэтэл энэ фарзыг хариуцахаар даасангүй жихадаас гадаа болохуйц хүмүүсийг бол ает-и кэримэ нь ингэж мэдүүлэв:

لَّيْسَ عَلَى الضُّعَفَاء وَلاَ عَلَى الْمَرْضَى وَلاَ عَلَى الَّذِينَ لاَ
يَجِدُونَ مَا يُنفِقُونَ حَرَجٌ إِذَا نَصَحُواْ لِلّٰهِ وَرَسُولِهِ مَا عَلَى
الْمُحْسِنِينَ مِن سَبِيلٍ وَاللّٰهُ غَفُورٌ رَّحِيمٌ

“Аллах ба Элчид нь чин сэтгэлээрээ холбоот байсаар байхад , хүчгүйчүүдэд, өвчтөн болон байлдаанд **зарцуулах юм олж чадаагүйчүүдэд нүгэл үгүй. Сайхан үйл эзэмшигчдийн эсрэг нэгэн зам** хариуцлага **үгүй. Аллах Гафур мөн, Рахим мөн.”** (эт-Тавба, 91)

Ает-и кэримэгийн зарласнаар, дайнаас чөлөөт болгогсод нь нутагтаа фитнэг зөвшөөрөхгүй, худал мэдээ тараахгүй, дайнд оролцсон байлдагчдын гэр бүлд туслагч болоод сайхан үйлс үйлдвэл байлдаанд оролцоогүй улмаас тэдэнд нүгэл бичигдэхгүй. Харин эдний дайнд оролцохыг хориглосон ямар нэгэн тушаал гараагүй тул, хүсвэл, цэрэгт ачаа болохгүйгээр дайнд оролцож мэднэ.

Тэбүк Аяны бэлтгэл хийж байхад Асхаб-и кирам нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хамт Аллахын

замд амиа зориулах аянд гарахын агуу бишрэлтээр бүрдсэн байв. Гэтэл Асхаб-и кирамын ядуучуудаас долоон хүн аянд оролцоохоор унаа олж чадаагүй байцгаав. Ихэнхдээ хоёр цэрэг, заримдаа гурван цэрэг нэгэн тэмээг унадаг бөгөөд тэмээг ээлжээр унана. Харин дайнд оролцох ба байнга Аллахын Элчийн хамт байхыг чин сэтгэлээрээ хүссэн боловч ээлжээр байсан ч унах тэмээ олж чадаагүй ядуу сахабийчууд ч байв. Тэд ч Аллахын Элчид ирээд байдлаа илтгэв. "Унуулах тэмээ үгүй" хариултыг авахдаа уйлаад харьцгаав. Аллахын замд асгасан уг нулимс нь тэнгэрлэг тааламжийг хүртээд ает-и кэримэ нь:

وَلاَ عَلَى الَّذِينَ إِذَا مَا أَتَوْكَ لِتَحْمِلَهُمْ قُلْتَ لاَ أَجِدُ مَا أَحْمِلُكُمْ عَلَيْهِ تَوَلَّواْ وَّأَعْيُنُهُمْ تَفِيضُ مِنَ الدَّمْعِ حَزَنًا أَلاَّ يَجِدُواْ مَا يُنفِقُونَ

"Аяа Элч минь ээ! **Өөрсөд нь унаа хангах гэж Чамд ирэхэд нь** Чи **«Таныг унуулах унаа би олж чадахгүй байна,» гэхлээр, зарцуулах юм олж чадаагүй улмаас гунигаар нүд нь нулимс гоожуулаад хүмүүст** ямар нэгэн хариуцлага үгүй!" хэмээн айлдав. (эт-Тавба, 92)

Аетад тэнгэрлэг магтаалыг хүртсэн хүмүүсээс Абдуррахман бин Ка'б ба Абдуллах бин Мугаффэл нь Аллахын Элчийн дэргэдээс уйлаад харьж байхад Ибн-и Яамин тэднээс:

"–Та юунд уйлж байна вэ?" гэж асуув.

"–Бидэнд унаа хангах гэж Расулаллахад очсон . бидэнд унуулах юм олж чадаагүй. Бидэнд ч унаж Аллахын Элчийн хамт унааны мал үгүй!" гэцгээв.

Ибн-и Яамин тэр хоёрт нэгэн тэмээ, хоол болох жаахан хасарваан өгөв. Хазрат-и Аббас нулимс гоожуулагчдаас хоёрт,

Хазрат-и Усман ч гуравт нь унаа хангав.[314] Зарим хэрэгцээт хүмүүст ч дараа нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- унаа олгов.[315] Дайнаас чөлөөт байсан боловч Аллахын Элчээс тустай болох нь тэдэнд хэцүү санагдсан ба зүрх нь Аугаа Эрхийн хайраар дүүрэн байсан энэ сахабийчууд ийм хичээнгүй үйлс болон хайрынхаа үр дүнд аянд оролцох шим болон алдрыг хүртэцгээв.

Ийм байдал нь Асхаб-и кирамын бараа болон амиараа Аллахын замд ямар өгөөмөр хандсаныг ба тэдний сэтгэлийн байдлыг толилуулсан тоолшгүй жишээнээс нэгэн юм.

Тэбүкээс сургаалаар дүүрэн өөр нэгэн дурсамжийг Василэ бин Эска -радъяллахү анх- ингэж ярина:

“Тэбүкийн дайнд гарах болсон өдрүүдийн нэгэнд би Мадинад ингэж хашхирлаа:

«–Олзны хувиа өгөхийн хариунд намайг унаагаа хэн унуулах вэ?»

Энсараас настай нэгэн хүн, ээлжээр унах унаа гаргаж чадахаа мэдүүлэв. Намайг шууд «Тохиролдлоо!» гэхлээр:

«–Тэгэхээр Аллахын буянаас хүртэг!» гэв. Ингээд буянт нэгэн андтайгаар замд гарлаа. Аллах олз ч хайрлав; миний хувьд хэдэн тэмээ олов. Тэднийг аваад тэр хүнд очлоо. Тэр надад:

«–Тэмээгээ аваад яв,» гэв.

«–Эхэнд хийсэн гэрээний маань дагуу эдгээр чиний,» гэлээ. Харин Энсарий:

314. Ибн-и Хишам, IV, 172; Вакидий, III, 994.

315. Бухарий, Мэгазий, 78.

«–Дүү минь ээ! Олзоо ав, би чиний эд барааны энэ хувийг нэхээгүй байв, Би буянд чинь, өөрөөр хэлбэл сүнсний ашигт чинь түнш болохыг бодсон байлаа» гэв.” (Эбү Давуд, Жихад, 113/2676)

Энэ сургаалаар дүүрэн аянд, амь болон бараагаа ахиратын хөрөнгөөр эргүүлэн диваажинг худалдаж авах бишрэлт хэт мэдэрч, Киямат хүртэл үммэтэд жишээ болох үзвэрүүд толилуулдаг байв. Асхаб-и кирам нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн эргэн тойронд үйлчлэхээр бараг удган эрвээхий болж, Аллахын замд хамаг юмаараа үзүүлсэн өгөөмөр зангаа **“Аав ээж амь минь Чамд золиос болог, аяа Расулаллах!”** гээд хашхираад илэрхийлж байцгаав.

Шүлэгч нь асхабын Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг бараг нэгэн удган эрвээхий шиг хамаг юмаа зориулан тойрсныг маш сайхан дуулжээ:

Чиний Хазрат хөлийн мөрийн өөдөс бүрт,
Амиа ч, биеэ ч, өөрийгөө ч золиосолъё!..

Ийнхүү бишрэлт Асхаб-и кирамд дараа ч үргэлжилсэн, Ибн-и Үмм-и Мэктүм -радъяллахү анх- дээрх аетад айлдсан такваг сонгож хоёр нүд нь ч сохор байсан ч Кадисиягийн Дайнд оролцсон, түүнчлэн Исламын цэргийн дунд тугаа ч барьсан байдаг.

Буусан ает-и кэримэнүүд дэх сануулгын нөлөөгөөр богино хугацаанд Исламын үзэсгэлэнт цэрэг бэлтгэв. Too нь гурван түмэн гаруй байв.[316] Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-нь Малик бин Нэжаарынхны далбааг Умарэ бин Хазмад өгсөн байв. Дараа нь Зэйд бин Сабитын харахдаа далбааг Умарэгээс аваад түүнд өгөв. Умарэ -радъяллахү анх-:

316. Вакидий, III, 1002; Ибн-и Са’д, II, 166.

“–Аяа Расулаллах аа! Надад уурлав уу?” гэж асуухлаар Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам-:

“–Үгүй! Валлахи уурлаагүй! Гэтэл, Кур’аныг та нар ч илүүд үзээрэй! Тэр Кур’аныг чамаас илүү цээжилсэн юм! Цээжиндээ Кур’ан илүү байсан нь, хамар нь хассан хар боол байсан ч илүүд үзнэ!” хэмээв.

Эвс ба Хазраж аймгуудад далбаагаа Кур’аныг илүү цээжилсэндээ бариулахыг тушаав. Тэгэхлээр нь Авфынхны далбааг Эбү Зэйд, Бэний Сэлимэгийн далбааг ч Муаз -радъяллахү анх- өргөв. (Вакидий, III, 1003)

Инфакын Хөдөлгөөн

Аянд гарах болоход Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- цэргийн хэрэгцээний төлөө асхабаа эхлээд инфакын хөдөлгөөнд дуудсан байв. Харин тэр хооронд Мадинад маш их ган халуун болж байв. Тийм байсан ч Асхаб-и кирам нь том хүслэн ба итгэл үнэмшлийн бишрэлтээр түр зуурын дэлхийн ашгийн бодлоо хаяад том нэгэн инфак ба өгөөмрийн уралдаанд оров. Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх- бараа бүхнийг авчрав. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн:

“–Би Эбү Бэкирийн барааг ашигласан чинээ өөр хэний барааг ч ашиглаагүй...” хэмээсний хариунд нулимсанд автсан Эбү Бэкир -радъяллахү анх-:

“–Би болон бараа минь зөвхөн чиний төлөө биш үү аяа Расулаллах?!” (Ибн-и Мажэ, Мукаддимэ, 11) гээд өөрийгөө хамаг юмаараа Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-д зориулан түүнд өөд болсныг батлав.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн:

“–Хүүхэд гэр бүлийнхэндээ юу үлдээгээ вэ, Эба Бэкир ээ?” хэмээн асуусанд ч итгэлийн том бишрэлттэйгээр:

“–Аллах болон Элчийг үлдээлээ аяа Расулаллах!..” гэж хариу өгөв. (Тирмизий, Мэнакиб, 16/3675)

Хазрат-и Умар -радъяллахү анх- барааны талыг авчирсан байв. Энэ удаа инфак хийхдээ Хазрат-и Эбү Бэкирийг хожихоо бодсон байв. Харин дахиад гүйцэж чадаагүй байв.

Хазрат-и Усман -радъяллахү анх- ч 300 тэмээг тоног төхөөрөмж бүрэн бэлтгэж цэрэгт бэлэглэж, түүнчлэн 1000 динар мөнгө хандив болгов. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүний тухай ч:

“–Усманд ийм өгөөмөр инфакаас нь болж үүний дараа хийх юу ч аюул хүргэхгүй!” (Тирмизий, Мэнакиб, 18/3700; Ахмад, V, 63) хэмээн айлдаж түүнийг магтав.

Мөн Хазрат-и Усман -радъяллахү анх-ын гэр бүл ч хамаг эрдэнээ Аллахын замд инфак болгов. Эмэгтэй сахабий бүр нь ч хэдий зүүлт ба эрдэнэ байвал бүхнийг Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн өмнө авчирцгаав.[317] Арван нэгэн насны багахан нэгэн итгэгч охин ч, багадаа чихэнд зүүсэн ээмгээ тайлаагүйдээ, сандраад тэднийг чихээ ураад авав. Энэ цустай ээмгээ Аллахын Элчийн өмнө тавив.

Баян болоогүй тул өгөх юм олж чадаагүй сахабийчууд ч бараа болон амиараа өгөөмөр зангаа илэрхийлэхийн бишрэлээр хөөрсөн байцгаав. Эд нараас Эбү Акил -радъяллахү анх- шөнөжин ажиллаад хоёр жин хасарваан олсон байв. нэгыийг нь гэр бүлийнхэндээ өгөөд, нэгэн хэмжүүрийг ч цэрэгт хандив болгов. Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

317. Вакидий, III, 992.

“–Аллах чиний авчраад өгснийг ч өөртөө авч тавьсныг ч элбэгжүүлэх болтугай!” хэмээж ирсэн хасарвааныг цугласан тусламжийн дотор асгахыг тушаав. (Табэрий, *Тэфсир,* X, 251)

Мүнафикчууд бол ийнхүү хандивыг хэлэндээ эргүүлээд Эбү Акилыг ч хоёр нүүртэн хэмээн буруушаав. Үкбэ бин Амр -радъяллахү анх- ингэж хэлнэ:

“Садакагийн аетыг[318] буухлаар бид нуруундаа ачаанаасаа инфак хийж эхэллээ. Гэхэд нэгэн хүн ирээд олон хандив өргөв. Мүнафикчууд «Үзвэр хийж байна,» гэцгээв. Өөр нэгэн ирээд нэгэн хэмжүүр хасарваан хандив өргөв. Мүнафикчууд дахиад «Аллах ганц жин хасарваанаар яах вэ» гэцгээв. Тэгэхлээр нь:

الَّذِينَ يَلْمِزُونَ الْمُطَّوِّعِينَ مِنَ الْمُؤْمِنِينَ فِي الصَّدَقَاتِ
وَالَّذِينَ لاَ يَجِدُونَ إِلاَّ جُهْدَهُمْ فَيَسْخَرُونَ مِنْهُمْ
سَخِرَ اللّٰهُ مِنْهُمْ وَلَهُمْ عَذَابٌ أَلِيمٌ

«Садакагийн тухай итгэгчдээс дураараа өгөгсөд ба хүч хүрэхээс өөр юмыг олж чадаагүйчүүдийг татлаад шоглогч бий биз, Аллах тэднийг жинхэнэ шогтоор эргүүлсэн байдаг. Мөн тэдний төлөө зовлонтой нэгэн тамлал байдаг,» (эт-Тавба, 79) ает-и кэримэ нь буув.” (Бухарий, Зэкат, 10; Мүслим, Зэкат, 72)

---

318. Садака ает нь ихэнх нь Тэбүктэй хамаатайгаар буусан Тавба Сурагийн 103-р ает юм:

خُذْ مِنْ اَمْوَالِهِمْ صَدَقَةً تُطَهِّرُهُمْ وَتُزَكِّيهِمْ بِهَا وَصَلِّ عَلَيْهِمْ اِنَّ صَلاَتَكَ سَكَنٌ لَهُمْ وَاللّٰهُ سَمِيعٌ عَلِيمٌ

“(Расул минь!) **Тэдний бараанаас садака ав, ингээд тэднийг цэвэрлэх болно. Мөн тэдний буяны төлөө залбир. Учир нь Чиний залбирал тэдний төлөө үнэ цэнийн эх юм. Аллах сонсогч, мэдэгч мөн.”**

Уг хадисын тусдаа дамжуулсан ойлголтоор, их мөнгө авчирсан хүн Абдуррахман бин Авф -радъяллахү анх-, нэгэн хэмжүүр авчирсан хүн ч адилхан Эбү Акил -радъяллахү анх- байцгаав.

Дахиад ядуу мусульманчуудаас Үлбэ бин Зэйд -радъяллахү анх- шөнийн хэсэг өнгөрөхөд босоод мөргөл үйлдэж ингэж залбирав:

“Аяа Аллах минь! Чи жихадад гарахыг тушааж урамшуулав. Гэтэл намайг дээр нь сууж Элчийнх чинь хамт жихадад гарахуйц малын эзэн болгоогүй! Элчийнх чинь гар доор ч намайг унуулах амьтан байлгаагүй! Би хэзээ ч бараа, бие болон хөрөнгөөс өөртөө оносон хандиваа өгсөн байдаг. Аяа Аллах минь! Боолуудын дунд надад хайрласан уг хэсэг бараанаа хандив болгоё!”

Өглөөгүүр Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд ирээд:

“–Аяа Расулаллах аа! Миний гарт хандив болгох юм үгүй. Энэ өчуухэн бараагаа хандив болгоё! **Үүний тухай намайг гомдоох эсвэл надад муухай юм хэлэх эсвэл намайг шоолох хүнд халал болно!”** гэв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- хайраар дүүрэн байсан чинээ өршөөл ба энэрлийн ийм үгсийн хариунд зөвхөн:

“–Аллах хандивыг чинь хүлээн авах болтугай!” хэмээж өөр юм хэлээгүй. Дараах өдөр түүнд:

“–Би чиний хандивыг хүлээн авлаа. Чамд сайхан мэдээ олгоё! Мухаммедын биеийг хүчит гараар барьсан Аллахад тангараг өргөе, чи хандив нь хүлээн авагчдын оронд бичигд-

лээ," хэмээв. (Ибн-и Хажар, *эл-Исаба,* II, 500; Ибн-и Кэсир, *эс-Сирэ,* IV, 9; Вакидий, III, 994)

Мүнафикчуудын нэг хэсэг нь хэвээрээ мусульманчуудаас нимгэн итгэлтнүүдийг нөлөөнд оруулаад дайнд оролцоход нь саад болохоор хичээгээд байцгаав. Эд нар Сүвэйлим нэртэй нэгэн еврейн гэрийн төв болгосон байв. Үүний мэдээг авсан Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Хазрат-и Талхаг хэдэн сахабийн хамт илгээж Сүвэйлимийн гэрийг шатаалгав. Ингээд мүнафикчуудад тараагаад дахиад ийм үйлд оролцохоор зориг үзүүлж чадаагүй.[319]

Нөгөө талаас мүнафикчуудын хийсэн ийм хөдөлгөөнтэй хамаатай буусан сануулгын аетуудын дагуу сэтгэлийг нь тэнгэрлэг тамлалын аймшиг эргэсэн итгэгчид цөмөөрөө дайнд оролцсон байв. Тэгээд Мадина-и Мүнэввэрэ хов хоосон үлдсэн байв. Гэтэл дайн удаж, энэ хугацаанд улс төрийн төвд илрэх боломжтой хэргийн учраас улс төрийн байдал хэцүү болж мэдэх байв., цэргийн хүнсийг ч хангаж ядах болов. Түүнчлэн улсуудын буйгаа үргэлжлүүлэх удирдах хүмүүс алга болбол, улс төр үгүй болж мэдэх байв. Үүнд завшаан олгохгүйн тулд дайнд оролцох талаар Аллах Таала нэгэн хэмжүүр мэдүүлэв:

وَمَا كَانَ الْمُؤْمِنُونَ لِيَنفِرُواْ كَآفَّةً فَلَوْلاَ نَفَرَ مِن كُلِّ
فِرْقَةٍ مِّنْهُمْ طَآئِفَةٌ لِّيَتَفَقَّهُواْ فِي الدِّينِ وَلِيُنذِرُواْ
قَوْمَهُمْ إِذَا رَجَعُواْ إِلَيْهِمْ لَعَلَّهُمْ يَحْذَرُونَ

"Итгэгчид бүр нь цөмөөрөө дайнд гарах нь зөв биш юм. Тэдний тойрог бүрээс хэсэг хүмүүс шашинд буюу шашны

319. Ибн-и Хишам, IV, 171.

ухаанд **өргөн ба гүн мэдлэг эзэмшиж** дайнаас **харихад тэднийг сэнхрүүлэхээр сануулахаар хойно үлдэх ёстой. Тэгээд тэд болгоомжтой байх хэрэгтэй.”** (эт-Тавба, 122)

Уг тэнгэрлэг тушаалын дагуу Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- дайны дараах аюулгүй байдлын төлөө Хазрат-и Али -радъяллахү анх- ба Мухаммед бин Мэслэмэ -радъяллахү анх-ыг Мадинад үлдээв.

Саатү’л-Үсрэ: Бэрхшээлийн Цаг

Эцэст нь олон хэцүү нөхцөл ба төвөг байсан ч цэрэг нь үнэхээр жавхлантай хөдлөв. Гэтэл цэрэг нь олон төвөгт тэсвэр тэвчээр үзүүлэх хэрэгтэй байв. Учир нь нөхцөл нь нэлээд хэцүү хүнд байв. Уг аян хэцүү байх шалтгаан нь:

1. Хатуу ширүүн ган гачиг.

2. Явган туулахад барагдамгүй их цөл.

3. Ургамал ба жимс түүх улирал байсан нь.

4. Хэт халуун.

5. Бизантийн цэрэг тоогоор давуу их хүчтэй байсан нь.

Тэгээд ийм олон бэрхшээлээс болж энэ газваг “Газватү’л-Үсрэ” буюу бэрхшээлийн дайн, цэрэгт ч “Жэйшү’л-Үсрэ” буюу бэрхшээлийн цэрэг, аяны хугацаан дахь өдрүүдийг ч “Саатү’л-Үсрэ” буюу бэрхшээлийн цаг гэсэн байдаг.

Цэргийг хөдөлснөөс хэсэг хугацааны дараа Хазрат-и Али -радъяллахү анх- нь мүнафикчуудын фитнэгээс болж Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д гүйцэж дайнд оролцохоор зөвшөөрөл эрэв:

“–Аяа Расулаллах аа! Мүнафикчууд таныг надад дургүй учраас намайг хойно үлдээснийг хэлээд байна! Надад ч аянд оролцох зөвшөөрөл олгоорой!” гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч:

“–Аяа Али! Тэд худал хэлцгээжээ. Би чамайг үлдээсэн нь төлөөлөгчөөр томилсон хэрэг. Даруй харь; өөрийнхөө гэр бүлийг ч миний гэр бүлийг ч сахин хамгаалж бай, тэдэнд миний төлөөлөгч бол! Али! Миний дэргэд чи Мусагийн дэргэдэх Харуны оронд болохыг хүлээн зөвшөөрөхгүй юү? Нэгэн ялгаа нь бол, миний дараа пайгамбар ирэхгүй юм,” хэмээв. (Ибн-и Хишам, IV, 174; Бухарий, Мэгазий, 78; Мүслим, Фэдаилү’с-Сахаба, 31)

Ийм магтаалыг хүртсэн Хазрат-и Али -радъяллахү анх- маш их баяр баясгалантайгаар үүрэгтээ харив.

Аянд гараад нэлээд хоног өнгөрөөсөн байв. Нэлээд цаг өнгөрсний дараа Асхаб-и кирамаас Эбү Зэрр -радъяллахү анх- цэрэгт амжиж ирэв. Туранхай унаа нь замыг дийлээгүй тулд хойно үлдээгээд, эцэст нь малаа орхиж хэцүү байсан ч алхаж ирсэн байв. Үүнийг харсан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- мишээгээд:

“–Аллах нь Эбү Зэррт рахмат олгоосой! Тэр нь ганцаараа амьдарч, ганцаараа үхээд ганцаараа сэрнэ,” хэмээв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ийм гайхамшигт үг нь цаг болоход хэрэгжиж Эбү Зэрр -радъяллахү анх- ганцаараа амьдарч ганцаараа нас барсан байдаг. (Вакидий, III, 1000)

Исламын цэргийн аян хэтэрхий төвөгтэй явж байв. Халуун бүгчим байв. гурван хүнд нэгэн тэмээ оногдсон тул тэмээгээ ээлжээр унаж, энэ ч нэлээд хэцүү болж байв. Нэг хасарвааныг хоёр хүн хуваалцаж байв. Заримдаа ус олдохгүй байв. Ийм

учраас абдэст авахдаа нэг л удаа угааж байцгаав. Мэст дээр суурьшмал хүн нэг, зорчигч хүн гурван өдөр мэсх хийх тушаал буув.[320] Нэг удаа Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- залбираад зөвхөн Исламын цэрэг буй газар бороо оров.[321]

Исламын цэрэг зам дээр байсан Сэмүд ардын мөхсөн Хижр хэмээдэг газраар өнгөрч байхад Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Асхаб-и кирамд:

"–Энэ нь зугтмаар хөндий юм!" хэмээв. (Вакидий, III, 1008)

Дараа нь:

"–Өөрсдөө харгислагсдын нутагт уйлаад орцгоо. Эсвэл тэдэнд тохиолдсон нь танд ч тохиолдож мэднэ," хэмээв. Дараа нь толгойгоо далдаж тэр хэсгийг өнгөрөв. Тэндээс авсан усыг асгуулав. Хэмнэх талаар маш нямбай байсан боловч, тэр усаар хийсэн гурилыг ч хаяулав. (Бухарий, Энбияа, 17; Тэфсир, 15/2; Мүслим, Зүхд, 39)

Учир нь тамлалын орнууд дайралдсан гамшгийн хувийг киямат хүртэл үргэлжлүүлдэг. Тийм болохоор тамлал илэрсэн нутгуудад боcлого ба нүглээр дүүрэн орнүүдэд сүнсээр үргэлжилдэг тамлалын сөрөг ойлголд автахгүйн тулд, Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн айлдсаны дагуу хурдлах шаардана.[322]

---

320. Ибн-и Мажэ, Тахарэт, 45; Ахмад, VI, 27.

321. Ибн-и Хишам, IV, 177.

322. Байдлын бараанд ойлгосны тухай нэгэн жишээ:
Ядоны эрдэмтэн Масару Эмото нь хөлдсөн усны болор дээр хийсэн судалгаандаа, тэдний гоё, зургаалжин дүрсээр бүрдсэнийг ба энэ болруудын хүний гар хүрээгүй байгалийн булгуудад хүний гайхуулах чинээ гоё хэлбэртэй буйг анзаарав. Уг уснаас хоёр тустай саванд аваад сорил хийв. Дээр нь хайр, халамж, залбирал ба талархал үгс шивнэсэн нэгдүгээр савтай усны болрын байгалийн бүтцээ хамгаалсныг; харин дээр нь хараал үгс ба

Хижрийн хавьд байсан нэгэн шөнө Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“Өнөө шөнө маш ширүүн шуурга гарна. Хүн бүр тэмээгээ бат уяад байсан газар сууж битгий босог!” хэмээв. Үнэхээр тэр шөнө маш ширүүн нэгэн шуурга гарав; абдэст авахаар боссон нэгийг шуурга газарт цохиод, тэмээгээ эрэхээр явсан өөр нэгийг ч Тай Уулан дээр хийсгэв. (Бухарий, Зэкат, 54; Мүслим, Фэдаил, 11)

Тэбүкт нэгэн өдрийн зай байхад Исламын цэрэг дахиад усгүй үлдсэн байв. Муаз бин Жэбэл -радъяллахү анх- ингэж ярина:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«Та маргааш иншааллах Тэбүкийн булагт хүрцгээнэ!» хэмээв.

Дараа өдөр булагт хүрэхлээрээ байсан усыг алга алга-ар нэгэн туламд цуглуулав. Хазрат-и Пайгамбар түүгээр гар нүүрээ угааж булагт хойш нь цацав. Дараа нь төмөр үзүүртэй гурван саваг булагт хатгав. Даруй болор шиг гурван булаг оргилж эхлэв. Хамаг мүжахидчууд усанд ханав. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- (надад):

“чөтгөр”ийн нэрийг хэлсэн болрын бол хагарсныг ба хамаг гоо сайхнаа алдаж баларсныг харав. Тус сорилд ус нь сайхан аятай хөгжим болон үймүүлэхүйц цохилтуудад ч тустай хариу заасан байв.

Масару Эмото нь хүрсэн уг үнэнийг батлахаар төсөөт нэгэн судалгаа тустай лонхонд хийсэн чанасан будаан дээр ч хийв. Нэгний дотор “баярлалаа” нөгөөний дотор “мангар” гэж бичсэн цаас хийгээд лонхнуудаа сарын турш энэ үгсийг хэлэхлээр, нэгдүгээр лонхны будаа цагаан өнгө ба анхны байдлаа хадгалж байтал нөгөө лонхны будаа муухай үнэртэж муудсаныг тогтоов (Сафвэт Сэних, “Усны Болрын Нууц”, *Sızıntı,* 2002.12, тоо 287; М. Акиф Дэниз, *İlk Adım,* 2003.2)

«–Муаз аа! Урт настай байхсан бол их удахгүй энэ усаар энэ хавийн усан үзмийн ба бусад цэцэрлэгээр дүүрэн болсныг харах байсан!» хэмээв.” (Мүслим, Фэдаил, 10; Ахмад, V, 238)

Тэбүкийн Дайнд хүнд өлсгөлөн даасан сахабийчууд:

“–Аяа Аллахын Элч ээ! Та зөвшөөрөөд бид тэмээгээ төхөөрж идээд бас өөхтэй болъё,” гэцгээв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–За тэгцгээ!” хэмээв. Гэтэл Умар -радъяллахү анх- ирэв:

“–Аяа Аллахын Элч ээ! Хэрэв тэмээгээ төхөөрөхийг зөвшөөрөл өгвөл цэргийн унаа цөөрнө. Харин та хүсвэл тэдэнд гартаа буй идээг авчрахыг тушааж дараа нь түүнд элбэг олгохын тулд Аллахад залбираарай. Аллахын буяныг хайрлах нь найдвартай,” гэв.

Тэгэхлээр нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–За тэгье!” хэмээж арьсан дэвсгэр дэлгүүлэв. Дараа нь бэлэн буй идээг авчрахыг тушаав. Зарим цэрэг нэгэн алган чинээ тариа, зарим нь нэгэн алган чинээ хасарваан, зарим нь ч талхны өөдөс авчрав. Дэвсгэр дээр үнэхээр маш бага юм цугларсан байв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- элбэг олгохын тулд Аллахад залбираад дараа нь:

“–Сав суулгаа авчраад үүнээс авцгаа!” хэмээв. Цэрэг сав суулгаа дүүргэв. Дүүргээгүй ганц сав үлдээгээгүй. Дараа нь цадталаа идээд, тэгсэн ч нэлээд идээ үлдэв. Тэгэхлээр нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж айлдав:

“–Аллахаас өөр бурхан үгүйд бол намайг Аллахын Элч буйд гэрчлэе. Аллахын цорын ганц бөгөөд Мухаммедын пайгамбар байсанд сэжиггүйгээр итгэсэн байхдаа Аллахад хүрээгүй хүн нь диваажинд орох эрхээ алдана.” (Мүслим, Иман, 45)

Исламын цэрэг хуарангаа Тэбүкт барьсан боловч дайсны өчүүхэн ч хөдөлгөөн харагдахгүй байв. Учир нь ийм өнөр Ислам цэргийг харсан Араб аймгууд өмнө нь Мүтэд гурван мянгат итгэлийн цэргийн толилуулсан баатарлаг үйлсийг ч санаад байлдах хүслээ алдсан, дайнаас татгалзсан байв. Бизанти бол Арабстаныг эзлэх санаагаа аль хэдийнээ больсон байв. Учир нь Бизантийн император тэр хооронд Хумуст өөрийнхөө нутгийн дотоод хэрэгтэй оролцож байв. Ингээд тэдний Арабстаныг эзлэх мэдээллийн, Христийн шашинтай Гассаний Арабчуудын худал байсан нь ил гарав.

Гэтэл энэ аянаар Ислам болон мусульманчууд том нэр алдрыг олов. Арабстаны хойд хилийг бүрэн аюулгүйд оруулав. Эйлэгийн эзэн, Жэрба ба Эзрүх ардууд, Мэкнагийн еврейчүүд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс жизье буюу татвар төлөөд аюулгүй байхыг нэхэж мусульманчуудын хамгаалтад оров. Хазрат-и Халид бин Вэлид дөрвөн зуун хорин морьтны хамт Дүмэтү’л-Жэндэлд дайраад, христийн шашинтай эзэн Үкэйдэр бин Абдүлмэликийг барьж Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д авчрав. Түүнд ч жизьегийн хариунд аюулгүйг хандуулав. (Ибн-и Хишам, IV, 180-182; Ибн-и Са’д, I, 276-277; Ахмад, V, 425)

Исламын цэрэг Тэбүкэд хорь хонов. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- цааш явах юмсангүй. Учир нь Тэр Исламыг хүмүүст сэлмийн хүчээр хүргэх хүсэлтэй байгаагүй. Мөн Бизанти гүрнийг хэрэгтэй чинээ айлгахаар сүрдүүлсэн ба, тэдний өмнөөс ямар ч дайсан гарч чадаагүй байв. Түүнчлэн Сирийг тэр хооронд таун гэдэг өвчин бүрсэн байв. Таун бол халдвартай ба алуурч нэгэн өвчин байсан тул Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“Нэгэн тойрогт таун байсныг дуудвал тэнд битгий очоорой! Та тэнд байвал тэндээс ерөөсөө битгий гараарай!” хэмээв. (Бухарий, Тиб, 30)

Дараа нь Асхаб-и кирамтай зөвлөлцөж Мадинад харихаар шийдвэр гаргав.

Энэ хооронд Эбү Хайсэмэ -радъяллахү анх- нь цэрэгт амжив. Тэр нь эхлээд аяны бэрхшээлээс болж Мадинад үлдсэн байв. Нэгэн өдөр эхнэр нь цэцэрлэг дэх усан үзмийн саравчинд түүнд аятай хоолны ширээ тавиад, идэхээр дуудсан байв. Эбү Хайсэмэ үүнийг харахлаараа ухаанд нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ба асхабынх нь байдал төрөөд сэтгэл хатгаж өөртөө:

“Тэднийг ийм халуунд Аллахын замд бэрхшээлийг дааж байхад миний энэ хийсэн нь болох зүйл юм уу?!” гэлээ. Ингэж гэмшсэнээрээ түүнд зориулан бэлдсэн хоолд гараа огт хүрэлгүй шууд замд гараад, Тэбүкэд Исламын цэрэгт нэмэгдэв. Түүний ирснийг харсан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ийм хандсанд нь таатай болоод:

“–Аяа Эбаа Хайсэмэ! Чи бараг мөхөх дөхсөн байв!..” хэмээж түүнийг өршөөхөөр Аугаа Эрхэд залбирав. (Ибн-и Хишам, IV, 174; Вакидий, III, 998)

Аугаа Эрх боолчууддаа тэдний хүчнээс илүүг даалгахгүй. Харин хүч хүргэхүйц үйлсийг хэрэгжүүлэхээр ч хариуцуулна. Эбү Хайсэмэгийн хийсэн нь ч энэ хүч чадлын үнийг төлөхийн тоонд орно.

Эдгээр явдлууд бидний хувьд амьд нэгэн сургаал юм. Эд барааны ба сүнсний боломжоороо Аугаа Эрхийн замд хэдий зарцуулж чадсанаа хэмжих ба итгэгч болохын хариуцлагыг бодох нэгэн шалтгаан юм.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Тэбүкэд өглөөгүүр нэгэн хасарвааны модонд тулаад хутба айлдав. Аллахад хамд ү сэна өргөсний дараа ингэж айлдав:

“Хүмүүсийн буянт нь морь эсвэл тэмээн дээр эсвэл хоёр хөл дээрээ үхтэлээ Аллахын замд жихад хийсэн (Аллахын шашныг авралтыг хүлээдэг хүмүүст тэблиг хийсэн хүн) юм! Хүмүүсийн муу бол Аллахын Сударыг уншаад түүнээс огт ашигладаггүй фасик зоригтой хүн юм.

Үүнийг сайн мэдээрэй, хамгийн зөв үг нь Аллахын ном мөн! Наалдах хамгийн бат сэнж нь таква мөн! Шашны буянт нь Ибрахим -алэйхиссэлам-ын шашин (Ислам) мөн! Сүннэтийн буянт нь Мухаммедын сүннэт мөн! Ярианы цуутай нь зикруллах мөн. ***Туульсын гоё нь куран мөн.***[323] *Үйлсийн буянт нь Аллахын нэхсэн фарзууд мөн. Үйлсийн муу нь бид’атууд юм. Хамгийн гоё зам ба явдал нь Пайгамбарын зам ба явдал мөн. Үхлийн нэртэй нь шэхид мөн.*

---

323. Кур’ан-и Кэримийн гуравны нэгээс илүү хэсэг нь туульсаар бүрддэг. Аугаа Эрх нь Кур’аны туульсны чухал талын мэдүүлэн тэдэнд зарласан үнэнийг ойлгохыг, хэрэгтэй сургаалыг аваад эдгээрийг өөрийнхөө байдлыг хэмжихдээ хэрэглэхийг тушаадаг. Ает-и дэримэнүүд ингэж айлдана:

نَحْنُ نَقُصُّ عَلَيْكَ اَحْسَنَ الْقَصَصِ بِمَٓا اَوْحَيْنَٓا اِلَيْكَ هٰذَا الْقُرْاٰنَ

“Расул минь! Бид уг Кур’аныг вахий болгохдоо Чамд хамгийн гоё туульсыг ярьж байна…” (Юүсүф, 3)

فَاقْصُصِ الْقَصَصَ لَعَلَّهُمْ يَتَفَكَّرُونَ

“…Туульсыг ярь; тэд бодож магадгүй.” (эл-А’раф, 176)

وَلَقَدْ ضَرَبْنَا لِلنَّاسِ فِي هٰذَا الْقُرْاٰنِ مِنْ كُلِّ مَثَلٍ لَعَلَّهُمْ يَتَذَكَّرُونَ

“Тангараг өргөе, Бид сургаал аваг гэж энэ Кур’анд хүмүүст бүх төрлийн жишээг олгов.” (эз-Зүмэр, 27)

Сохрохын хамгийн муу нь зөв замыг олсны дараа түүнээс төөрөх юм. Бага бөгөөд хүрэмжтэй юм нь их бөгөөд завгүй болгож Аллахаас холдуулахгүй буянтай мөн. Уучлал гуйхын муу нь яг үхэхдээ ойлгох үе юм. Гэмшлийн муу нь Киямат өдрийнх мөн. Хүмүүсийн буянгүй нь Жума (мөргөл)д хамгийн сүүлд ирээд Аллахыг муухай хэлээр дурдсан нь юм. Хамгийн олон буруутай нь хэлээрээ хамгийн олон худал хэлэгч нь юм.

Эд хөрөнгийн буянт нь сэтгэлийн баялаг мөн. Хүнсний буянт нь таквагийн хүнс мөн. Эрдмийн эх нь Аллахаас айх юм. Эрдэмгүй үг ба шүлэг Иблис буюу чөтгөрийн үйлсээс юм. Согтууруулах ундаа нь нүгэл бүрийг нэг дор цуглуулагч юм. (Фасик) эмэгтэйчүүд нь чөтгөрийн хавх юм. Боловсроогүй залуус нь галзуурлын хэсэг юм. Риба мөнгө хүүлж олсон мөнгө хамгийн муу нь юм. Идээний хамгийн муу нь өнчний хувийг идэх нь юм. Баяртай хүн өөрөөс гадны хүмүүсийн байдлаас сургаал гаргагч нь юм.

Та бүхэн дөрвөн тохой газар (булшид) очно. Үйлсийн тоо-цоо бол ахиратад үлдэнэ. Үйлсний хувьд хамгийн гол нь үр дүн юм. Бодлын муу нь буруу худал бодол юм. Итгэгчидийг хараах нь нүгэл юм. Итгэгчийг алах нь күфүр юм. Итгэгчийн хойгуур нь ярих нь Аллахын тушаалыг эсэргүүцэх юм.

Худлаар Аллахын нэрээр тангараг өргөсөн хүнийг үгүйсгэнэ. Өршөөл гуйсан хүнийг Аллах өршөөнө. Хэн нүгэлээ тэвчинэ, Аллах түүнийг шагнана. Тохиолдсон аюулд тэссэн хүнд Аллах хариулт олгоно. Аллах бэрхшээл тэвчсэн хүнд буяныг нь дахин дахин нэмнэ. Аллахыг эсэргүүцсэн хүнийг Аллах тамд унагана!

Аяа Аллах минь ээ! Намайг болон үммэтийг минь өршөөх болтугай!

Аяа Аллах минь ээ! Намайг болон үммэтийг минь өршөөх болтугай!

Аяа Аллах минь ээ! Намайг болон үммэтийг минь өршөөх болтугай!

Өөрийнхөө болон та нарын төлөө Аллахаас өршөөл гуйя!" (Вакидий, III, 1016-1017; Ахмад, III, 37; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* V, 13-14)



Тэбүкийн Шэхид

Тэбүкийн Аянд зөвхөн нэг л сахабий шэхид болсон байдаг. Энэ сахабий нь мүшрик нэгэн аймгийн дотор Исламын нэр алдарт хүн болох Абдуллах эл-Мүзэний -радъяллахү анх- мөн. Аав нь нас барахдаа түүнд ямар ч өв хөрөнгө үлдээгээгүй. Баян авга ах нь түүнийг хажуудаа аваад өсгөж хөрөнгөтэй болгосон байв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн Мадинад нүүсэн үед Абдуллах мусульман болох юмсан ч мүшрик авга ахаасаа болж чадаагүй байв. Пайгамбар Эзнийг маань Маккаг эзэлж Мадинад харихад Абдуллах авга ахдаа:

“–Ах аа! Би чамайг мусульман болохыг хүлээгээд байлаа. Чиний одоо ч Мухаммедыг хүссэнийг би харахгүй! Ядаж надад мусульман болохыг зөвшөөрөөч?” гэв.

Авга ах нь:

“–Хэрэв чи Мухаммедыг дагах бол дээрх хувцас хүртэл чамд өгсөн хамаг юмаа буцааж авна!” гэв.

Абдуллах:

“–Би, валлахи Мухаммедыг дагалаа! Чулууг, баримлыг шүтэхээ аль хэдийнэ больсон билээ! Миний зүйлсийг авбал ав!” гэв.

Авга ах нь хувцас хүртэл нь хамаг юмыг нь авав. Абдуллах -радъяллахү анх- хувцасгүйгээр ээжийнхээ дэргэд очив. Ээж нь зузаан хивсээ хоёр хуваав. Абдуллах талыг нь дээгүүр талыг нь ч доогуур ороов. Шийдсэн тул, цаг алдалгүй Мадинад очоод Аллахын Элчид хүрэхийг хүсч байв. Өмнөх хамаг саад нь нүдэнд үгүй шиг харагдаж байв. Дахин хүлээж чадаагүй, түүнийг гадуурхсан аймгаасаа гарч тэр шөнө нууцаар замд гарав. Урт ба төвөгтэй нэгэн аяны дараа гар хөл нь шархадсан,

өлссөн ба цангаснаасаа хүч бяр нь дууссан ядарч зүдэрсэн тааруу байдалтай Мадинад дөхөв. Итгэл бишрэл нь хэтийдсэн байв. Гэтэл гэнэт бүдүүн хивсэн нөмрөгтэй Орчлонгийн Тэргүүний онгонд бараалхаж болохгүйгээ бодов. Аллахын Элчид хүрэх бишрэлтээрээ ухаан балартсан залуу сахабий нь, харагчдын гайхсан хараан доор ухасхийн Мэсжид-и Нэбэвийд оров. Үүр болтол мэсжидэд хэвтэв. Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам- өглөөний мөргөлийг үйлдүүлэв. Цуглааныг гүйлгэж гэртээ харих гэж байхдаа Абдуллахыг харав. Хэн ч байхгүй, ганцаардсан аргагүй хүмүүсийн нөмөр нөөлөг өмөг түшиг болсон Энэрлийн Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь тэр ариун сахабийг халамж энэрлийн элгэндээ тэвэрч авав. Нэрийг нь Абдүлузза байсныг мэдэнгээ:

“–Чи Абдуллах Зү’л-Бижадэйн (хос хивст) мөн! Надад ойр газар бай! Миний дэргэд ирээд шадарла!” хэмээв. Абдуллах -радъяллахү анх- сүффэд суугаад, Кур’ан-и Кэрим сурч байв. Кур’ан-и Кэримээс олон сураг уншиж цээжилсэн байв.

Аллахын Элчид хайраар холбосон энэ ариун сахабий нь Түүний дэргэд өөр жихадад гуйж, шэхид болоод Раббынхаа замд амиа золиослох л түүний гол хүсэл байв. Тэбүкийн Аянд гарч байхад түүнд шэхид болох нь онох тулд Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс дахин дахин залбирал гуйв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“Аяа Аллах минь! Түүний цусыг кафирчуудад харам болго!” хэмээн залбирав.

Абдуллах -радъяллахү анх-:

“–Аяа Расулаллах аа! Би тэгж хүссэнгүй!” гэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Чи Аллахын замд дайнд гараад хижиг тусаад нас барсан ч шэхид мөн! Унаа чинь чи унаад хүзүү чинь хугарсан ч дахиад шэхид мөн! Санаа битгий зов! Эдгээрээс аль нь ч болсон чи шэхид болно!” хэмээв.

Үнэхээр түүний шэхадэт нь гайхамшгаар яг Аллахын Элчийн айлдсанаар хэрэгжив. Цэрэг харих бэлтгэлээ хийиж байсан нэгэн шөнө, нэг нь Пайгамбарчуудын Тэргүүн, нөгөө хоёр нь бол Аллах болон Элчийнх нь анд гурван хүн, нэгэн бамбарын гэрэл доор шарил зөөж байв. Энэ гурван хүн Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-, Хазрат-и Эбү Бэкир ба Хазрат-и Умар -радъяллахү анхүмаа- байв. Зөөсөн шарил бол Абдуллах Зү’л-Бижадэйн -радъяллахү анх- байв.

Абдуллах бин Мэс’үд -радъяллахү анх- атаархан үзсэн энэ үзвэрийг ингэж ярина:

“Шөнийн харанхуйд мүжахидчуудын майхан барьсан талбайн нэгэн буланд гэрэл харлаа. Босоод дагаж явлаа. Нэг харвал, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-, Эбү Бэкир ба Умар -радъяллахү анхүмаа- нь Абдуллах Зү’л-Бижадэйн -радъяллахү анх-ын шарилыг зөөж байна. Тэд нэгэн газар хүрээд булш малтав. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь малтсан булшид буув. Эбү Бэкир ба Умар -радъяллахү анхүмаа- шарилыг Эзэнд маань буулгахаар бэлтгэв.

Аллахын Элч:

«–Дүүгээ над руу дөхүүлцгээ,» хэмээв; тэд дөхүүлэв. Шарилыг тэвэрч авсан Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүнийг булшид хэвтэх орон ба чигт оршуулсны дараа босоод ингэж гуйв:

«–Аяа Раб! Би түүнтэй хамт байхдаа таатай, байнга таатай байсаар байлаа, Та ч таатай байх болтугай ...»”

Абдуллах бин Мэс'үд -радъяллахү анх- үгээ үргэлжлүүлэн ингэж хэлнэ:

"Үүнийг харангаа сэтгэл минь бүр хөөрөв. Зү'л-Бижадэйныг атаархлаа. Тэр мөчид:

«Уг булшийн эзэн би байсан бол яасан сайхан бэ! Тэнд Пайгамбарын магтаалаар оршуулсан нь би байхыг!» ихээр хүслээ." (Ибн-и Хишам, IV, 183; Вакидий, III, 1013-1014; Ибн-и Эсир, *Усдү'л-Габэ,* III, 227)

Мүнафикчуудын Урвалт ба Мэсжид-и Дирар

Харьж эхлэхэд мүнафикчуудаас хэд нь шөнө гатлах бариу нэгэн хоолойд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн амийг хорлохыг төлөвлөсөн байжээ. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- үүнийг мэдээд Хүзэйфэтү'л-Еманийг тэдэн дээр илгээв. Хүзэйфэ -радъяллахү анх- тэнд хүрээд:

"–Еэ Аллахын дайснууд! Холдооч!" гээд хашхиран мүнафик бүхнийг тараав. (Ахмад, V, 453)

Гэтэл Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг мүнафикчуудын хоёр дахь хавх хүлээж байв. Исламыг сайхан суурьшсанаар Мадина ба Маккагаас салсан Эбш Амир Фасик нэртэй Хазражийн нэгэн Христ шашинтан Бизантид хоргодсон, байнга мүнафикчуудыг өдөөсөөр байв. Уг буруу холбооны цэг болохоор ч Куба Мэсжидээс жаахан доор нэгэн мэсжид бариулсан байцгаав. Энэ нь алдарт Дирар Мэсжид байв...

Төлөвлөсөн энэ амь хорлох үйлийн төлөө ч Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Тэбүкийн Аянаам өмнө энд урьсан боловч Түүний:

"–Аянаас харихдаа !" хэмээхлээр нь Исламын цэргийн харихыг хүлээж байв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Мадинад нэг хоногийн газар дөхөхөд, Жэбраил -алэйхиссэлам- ирээд, гадны төрхөөр мэсжид шиг барьсан уг бузар байрны доторх үнэнийг мэдээлэв. Ингээд мэсжидээс эсрэг мэсжид буюу шашны эсрэг шашныг ашиглан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д, Түүний улмаас хамаг мусульманчуудад мүнафикчуудын бэлтгэсэн энэ хавх нь зорьсондоо хүрээгүй. Учир нь Аугаа Эрх илээр энэ үнэнийг мэдээлж байв:

وَالَّذِينَ اتَّخَذُواْ مَسْجِدًا ضِرَارًا وَكُفْرًا وَتَفْرِيقًا بَيْنَ الْمُؤْمِنِينَ
وَإِرْصَادًا لِّمَنْ حَارَبَ اللّهَ وَرَسُولَهُ مِن قَبْلُ وَلَيَحْلِفَنَّ إِنْ أَرَدْنَا
إِلاَّ الْحُسْنَى وَاللّهُ يَشْهَدُ إِنَّهُمْ لَكَاذِبُونَ. لاَ تَقُمْ فِيهِ أَبَدًا لَّمَسْجِدٌ
أُسِّسَ عَلَى التَّقْوَى مِنْ أَوَّلِ يَوْمٍ أَحَقُّ أَن تَقُومَ فِيهِ فِيهِ رِجَالٌ
يُحِبُّونَ أَن يَتَطَهَّرُواْ وَاللّهُ يُحِبُّ الْمُطَّهِّرِينَ

"Мүнафикчууд дунд **бас** итгэгчдэд **хохирол учруулах,** үнэнийг **үгүйсгэх, итгэгчдийн яс хаях ба өмнө нь Аллах ба Элчийнх нь эсрэг байлдсан хүнийг хүлээхээр нэгэн мэсжид бариад** «Үүнд **сайн сайхнаас өөр юм хүсээгүй!» гээд заавал тангараг өргөх хүмүүс ч байдаг. Гэтэл Аллах тэдний лав худалч буйг гэрчилнэ.** Аяа Элч минь ээ! **Түүний дотор** Дирар Мэсжидэд **хэзээ ч битгий мөргөл үйлд! Анхны өдөрт таква дээр барьсан мэсжид дотор** Куба Мэсжидэд **мөргөл үйлдэх нь мэдээж зүйтэй. Түүний дотор цэвэрлэх дуртай хүмүүс байдаг. Аллах цэвэрлэгчдэд дуртай."** (эт-Тавба, 107-108)

Энэ удаа хэрэг нь зөвхөн нифак биш, мөн ил нэгэн хавхын шинж бүрдсэн байв. Ийм учраас мүнафикчуудын багийг хуулж мэсжид гэгч худал гэрийг ч нураах хэрэгтэй байв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэнгэрлэг тушаалын дагуу хандаж Мадинад хүрэхдээ Дирар Мэсжидийг шатаалгав. (Ибн-и Хишам, IV, 185)

Бага Жихадаас Их Жихадад

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн оролцсон сүүлийн аян байсан Тэбүк нь төвгөөр дүүрэн, бэрхшээлт аян байв. Исламын цэрэг мянган километр яваад харьсан байв. Мадинад дөхөж ирэхдээ бараг танигдахгүй дүр төрхтэй болцгоосон байв. Арьс нь ясандаа наалдсан, үс-сахал хэрээс хэтэрчээ. Ийм байхад Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэдэнд:

“–Одоо бид бага жихадаас том жихадад дөхөж байна!” хэмээв. Асхаб нь гайхсанаараа:

“–Аяа Расулаллах! Бидний байдал ил байна! Үүнээс том жихад гэж бий юу?” гэхлээр нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Одоо том жихадад (нэфсийн жихадад) ойртож байна!” хэмээв. (Сүюүтий, II, 73)

Нэфсийн Жихад нь зүрхийг боловсруулах ба сүнсний хүмүүжил юм. Зорилго нь ёс суртахууныг дээшлүүлэх ба хүмүүсийг боловсруулах “имсан-и камил” буюу төгс хүн болгох юм. Үүний арга бол тэнгэрлэг үнэнээр зурсан нэгэн ухаан, иман ба сайхан ёс суртахуунаар чимэглэсэн нэгэн зүрх, Кур’ан ба сүннэтийн сүнсээр титимлэсэн үйлсээр “тэвхидийн мираж өөд өгсөөд” төгс төгөлдөр болох юм.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Мадинад ирэхэд ард түмэн нь Түүнийг ба Исламын цэргийг угтав. Хүүхдүүд ч Оршигчдын Туяа Эзнийг маань Сэнийетү'л-Вэдад тосохоор замд гарсан байцгаав.[324]

Хойно Үлдсэн Гурван Сахабий

Эрчүүдээс Мадинад үлдэж Тэбүкийн Аянд оролцоогүй гурван хэсэг байв:

1. Шалтгаантан: Эд нар, өмнө нь ает-и кэримэд дурдсан хүмүүс бөгөөд, хүссэн ч аянд оролцож чадаагүй хүмүүс юм. Эдний төлөө Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Исламын цэрэгт:

"Мадинад зарим хүмүүс байдаг, бидний очсон ямар ч газар ба гаталсан ямар ч газар тэд байнга бидний хамт байцгаана! Учир нь тэднийг тэдний шалтгаан хойно үлдсэн байдаг," хэмээв. (Бухарий, Мэгазий, 81; Мүслим, Имарэ, 159)

Мөн өөр нэгэн хадис-и шарифдаа:

"Үйлс нь зорилгын дагуу юм!.." хэмээсэн байдаг. (Бухарий, Бэд'ү'л-Вахй, 1)

2. Мүнафикчууд: Эд нар олон учрын хамт Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн энэ аянаас харьж чадаагүйг бодож цэрэгт оролцоогүй хүмүүс байв. Гэтэл Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн эрүүл мэндийн асуудалтай гэж, гүйгээд онгонд нь орж гараад олон мянган худал хэлээд уучлал гуйцгаав. Ная орчим энэ мүнафикчуудын тухай Аллах Таала ингэж айлдав:

324. Бухарий, Жихад, 196.

وَيَحْلِفُونَ بِاللّهِ إِنَّهُمْ لَمِنكُمْ وَمَا هُم مِّنكُمْ وَلَكِنَّهُمْ قَوْمٌ يَفْرَقُونَ. لَوْ يَجِدُونَ مَلْجَأً أَوْ مَغَارَاتٍ أَوْ مُدَّخَلاً لَّوَلَّوْاْ إِلَيْهِ وَهُمْ يَجْمَحُونَ

“Тэр Мүнафикчүүд **заавал Аллахад тангараг өргөдөг. Үнэндээ бол тэд танаас биш юм; гэтэл тэд айдаг нэгэн мөн. Хэрэв хоргодох газар, эсвэл агуй эс нүх олсонсон бол, гүйгээд тийш яваад олох байцгаав.”** (эт-Тавба, 56-57)

يَعْتَذِرُونَ إِلَيْكُمْ إِذَا رَجَعْتُمْ إِلَيْهِمْ قُل لاَّ تَعْتَذِرُواْ لَن نُّؤْمِنَ لَكُمْ قَدْ نَبَّأَنَا اللّهُ مِنْ أَخْبَارِكُمْ وَسَيَرَى اللّهُ عَمَلَكُمْ وَرَسُولُهُ ثُمَّ تُرَدُّونَ إِلَى عَالِمِ الْغَيْبِ وَالشَّهَادَةِ فَيُنَبِّئُكُم بِمَا كُنتُمْ تَعْمَلُونَ. سَيَحْلِفُونَ بِاللّهِ لَكُمْ إِذَا انقَلَبْتُمْ إِلَيْهِمْ لِتُعْرِضُواْ عَنْهُمْ فَأَعْرِضُواْ عَنْهُمْ إِنَّهُمْ رِجْسٌ وَمَأْوَاهُمْ جَهَنَّمُ جَزَاء بِمَا كَانُواْ يَكْسِبُونَ

“Таныг харихад тэд уучлалаа илэрхийлнэ. Ингэж хэл: «хоосон **уучлал битгий гуй! Бид танд хэзээ ч итгэхгүй! Учир нь Аллах таны байдлыг бидэнд мэдээлсэн байдаг.** Үүний дараах **үйлсийг тань Аллах ч харна, Элч нь ч харна. Дараа нь ил ба нууцыг мэдэгч** Аллахад **буцаад таны хийж байсан зүйлсийг танд мэдүүлэх болно.» Тэдний дэргэд харихад танд тэднийг яллахгүйн тулд Аллахын нэрээр тангараг өргөнө. Одоо тэднээс нүүрээ буруулцгаа! Учир нь тэд бузар мөн. Тэдний олж буй муухай үйлсийн хариунд очих газар нь там мөн!”** (эт-Тавба, 94-95)

Энэ ает-и кэримэнүүдийн дагуу мүнафикчууд одоогоос Исламын нийгмээс ялгарсан тэдэнд “бузар” гэсэн тэмдэг нэр

олгож мусульманчуудын тоонд ороогүй. Мөн Исламын төлөө хийх ямар ч жихадаас ч хориглов.

3. Уучлалгүйчүүд. Эд нар ч хоёр хуваагдана:

а. Эд нар ямар нэгэн шалтгаан үгүй байсан ба мүнафикчуудаас ч байгаагүй боловч дайнд оролцоогүй хүмүүс юм. Гэтэл энэ хүмүүс Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг арай Тэбүкээс харихаас өмнө буруугаа ойлгож хэтэрхий гэмшив. Тэгээд хийсэн буруугийн ял болохоор өөрсдийгөө мэсжидийн баганаас уяад Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг тайлахгүй бол иймэрхүү уяатай байхаа тангараг өргөцгөөв. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- аянаас хариад тэдний байдлыг мэдэнгээ:

“Би ч тэдний тухай тушаал автлаа тэднийг тайлахгүйгээ тангараг өргөе,” хэмээв. Тэгэхлээр нь уг ает-и кэримэ нь буув:

وَآخَرُونَ اعْتَرَفُواْ بِذُنُوبِهِمْ خَلَطُواْ عَمَلاً صَالِحًا وَآخَرَ سَيِّئًا
عَسَى اللّهُ أَن يَتُوبَ عَلَيْهِمْ إِنَّ اللّهَ غَفُورٌ رَّحِيمٌ

“Бусад нь бол нүглээ илчлэв; тэд өмнө нь сайн нэгэн үйлийг муу нэгэн үйлтэй андуурсан байцгаав. Тэд тавба хийвэл **Аллах тэдний тавбаг хүлээж авах найдвартай. Аллах нь Гафур Оахим мөн.”** (эт-Тавба, 102)

Уг ает-и кэримэг буусны дараа Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь гэмшсэнээсээ өөрсдийгөө баганаас уясан энэ сахабийчуудыг тайлав.

б. Эд нар ч ямар нэгэн шалтгаан үгүй бөгөөд мүнафикчуудаас ч байгаагүй боловч дайнд оролцоогүй боловч, эртхэн гэм-

шиж өөрсдийгөө баганаас уясан асхабын гадаа гурван сахабий юм. Шүлэгч Ка'б бин Малик, Мүрарэ бин Зэбий ба Хилал бин Үмэйе гэсэн нэртэй энэ гурван сахабий нь мүнафикчууд шиг худал хэлээгүй. Тэд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д шалтгаангүйгээр дайнд оролцоогүйгээ илэрхийлэв. Хийсэндээ тайлбарлахын аргагүй гэмшсэнээсээ ч Пайгамбарын онгонд өршөөл гуйцгаав.

Тэнгэрлэг тушаалыг дагахдаа том анхаарал үзүүлсэн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь энэ гурван сахабийг өршөөгөөгүй. Түүнчлэн тэнгэрлэг вахийг хүлээж байхад тэдний мэндийг ч хариулаагүй. Ямар ч байдалд түүнийг дагасан асхаб нь ч тэр чигээр хандацгаав.

Энэ гурван сахабий нь дайн бүрт оролцсон байцгаав. Тэдний дундаас Ка'баас гадна бусад хоёр нь Бэдирт ч оролцсон байв. Ийм л учраас одоо Тэбүкэд оролцоогүйгээр орсон алдаанаас болж хүмүүсийн тэдэнд хандах аргын хариунд дэлхий тэдний сэтгэлд давчуу санагдаж байв. Ялангуяа Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тэдний мэндийг ч хариулахгүй чинээ тэднээс царайгаа эргүүлсний дүнгээр дэлхий тэдэнд бараг өөр харагдахаар болсон байв. Тэгээд тэдний эхнэр ч тэдэнд өөр санагдаж эхлэв. хийх юм үлдээгүй байв. Ийм учраас тэд ч өдөр шөнөгүй уйлав. Хайлсан лаагаар эргэцгээв. Тэд алдаа хийсэн боловч ихлас, үнэнч зан, дотно сэтгэл, гэмшил ба тавбагаас холдоогүй байцгаав. Ингэж тавин хоног өнгөрөв. Эцэст нь зөв ярьсан ба дотно сэтгэлээр тавба хийсний шагналаар уг ает-и кэримэгээр өршөөлийг хүртэцгээв:

وَعَلَى الثَّلاَثَةِ الَّذِينَ خُلِّفُواْ حَتَّى إِذَا ضَاقَتْ عَلَيْهِمُ الأَرْضُ بِمَا
رَحُبَتْ وَضَاقَتْ عَلَيْهِمْ أَنفُسُهُمْ وَظَنُّواْ أَن لاَّ مَلْجَأَ مِنَ اللّهِ إِلاَّ

إِلَيْهِ ثُمَّ تَابَ عَلَيْهِمْ لِيَتُوبُواْ إِنَّ اللّهَ هُوَ التَّوَّابُ الرَّحِيمُ يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُواْ اتَّقُواْ اللّهَ وَكُونُواْ مَعَ الصَّادِقِينَ

“Тэгээд Аллах шийдвэрийг хойшлуулсан гурван хүний тавбаг хүлээн зөвшөөрөв. **Дэлхий нь хэдий өргөн уужим байсан ч тэдэнд давчуу санагдсан, тэдний хүний мөс нь ийм байдалд хүргэв. Эцэст нь Аллахын тамлалаас дахиад Аллахад хоргодохоос өөр арга үгүйг тэд ойлгов. Дараа нь тэднийг өмнөх байдалд эргэх тулд Аллах тэдний тавбаг хүлээн зөвшөөрөв. Учир нь Аллах тавбаг ихээр хүлээн авагч мөн, Рахим мөн. Аяа итгэгчид ээ! Аллахаас айгаад үнэнчдийн хамт байцгаа!”** (эт-Тавба, 118-119)

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- Ка’б бин Маликад энэ сайхан мэдээг ингэж хүргэв:

“–Чамд төрсөн өдрөөс нааш өнгөрөөсөн хамгийн буянт, баяр баяргалантай нэгэн өдрийн мэдээг хүргэе!..”[325]

Ка’б бин Малик -радъяллахү анх- ч Аллахын агуу өршөөлд талархал болохоор:

“–Аяа Расулаллах аа! Би ч Аллах ба Элчийнх нь таалам-жийн төлөө бараа бүхнээ хандив болгомоор байна!” гэв. Гэтэл Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Барааныхаа хэсгийг өөртөө хадгал! Ийм нь чиний хувьд илүү буянт юм!” хэмээв.

---

325. Хүргэсэн уг сайхан мэдээллийн дараа Ка’б -радъяллахү анх- Оршигчдын Туяа Эзний маань дэргэд ирж байхад, Талха бин Үбэйдуллах -радъяллахү анх- шууд түүн рүү гүйж гар бариад баяр хүргэсэн байв. Ка’б -радъяллахү анх- түүний ийм дотны хандлагыг амьдралынхаа турш мартаагүй байв.

Ка'б бин Малиик:

"–Тийм байвал Хайбар дахь хувийг хадгалъя. Аяа Аллахын Элч ээ! Аллах намайг энэ төвгөөс зөвхөн намайг үнэнч хүн тул аврав. Би одоогоос хойш, насаараа зөвөөс өөр үг хэлэхгүй!.." гэв.

Ка'б -радъяллахү анх- ингэж хэлдэг:

"Аллахад тангараг өргөе, Исламтайгаар хүнд олсны дараа Аугаа Эрхийн надад олгосон хамгийн том шим нь Пайгамбар Эзнийхээ онгонд зөвийг хэлээд, ингэж худал хэлэгчдийн хамт мөхөхөөс аврагдсан минь мөн. Учир нь Аллах Таала нь Тэбүкийн Аянд оролцоогүй шалтгаанаар худал хэлэгчдийн тухай, хэний ч тухай хэрэглээгүй хүнд үгсийг вахий болгож ингэж айлдав:

فَأَعْرِضُواْ عَنْهُمْ إِنَّهُمْ رِجْسٌ

«…Тэднээс нүүрээ буруулцгаа, учир нь тэд бохир юм...» (эт-Тавба, 95)" (Бухарий, Мэгазий 79, Вэсаяа 16, Жихад 103; Мүслим, Тавба 53, Мүсафирийн 74)

Энэ гурван сахабий нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хамт хамаг газвануудад оролцсон боловч зөвхөн нэгэн газванаас хойно үлдсэн тулд ийм хүнд ялыг хүртэв. Энэ явдал нь шалтгаангүйгээр эрдмийг тушааж бузраас болгоомжлох ба Аллахын замд тэвхидийн байлдааны гадаа үлдэгчдэд том нэгэн сануулга мөн.

Үнэхээр хэн нэгний сахабий нэрийг авсан, Исламын хамгийн хүчгүй үед Бэдир шиг олон байлдаанд оролцож үхэлтэй тааралдсан болоод, дараа нь Тэбүк мэт төвөгтэй байсан ч байлдаангүй аянд шалтгаангүйгээр оролцоогүй тулдаа ийм хүнд ял авсан нь их сургаалтай юм!.. Үүнд оюун ухаант хүмүүст

айхтар нэгэн сургаал ба аймшигт нэгэн утга агуулсан байдаг. Эрин бүрт байсан шигээ манай үед ч Исламын ялалтыг ханга-хаар байлдах шаардсаныг анхаарвал, энэ байлдаанд янз бүрийн учиртай удаан хандаж хойш тавигчдын байдал ямар өрөвдмөөр юм. Бэдирийн Дайнд оролцож Бэдирийн газий бологчид, ийм алдаагаа ийм хүндээр төлсөн бол, бидэн шиг хүмүүсийн байд-лыг ямар байхыг бодож Аллах Таалагийн тушаалын дагуу үнэнчдийн хамт байхаар хичээх хэрэгтэй юм.

Аллах Таала итгэгчдийн байнга эерэг нөлөөнд нээлттэй байж сөрөг нөлөөнөөс хамгаалахаар үнэнчдийн хамт байхыг нь тушаасан байдаг. Тэдний итгэлд, амласанд, үнэн шашинд үнэнч байхад, зорилтоор эсвэл үг ба үйлсээрээ зөв ба үнэнч хүмүүсийн хамт байхыг, тэдэнтэй ойрын холбоо барихыг, тэд-ний талыг дэмжихийг, товчоор нь тэднээс тустай болохгүйг тушаасан байдаг. Дэлхийн сэтгэлд уйтан санагдахгүй, мөс хатгахгүй ба Аллахын тамлалаас аврагдаж Тэрээрийн таалам-жийг хүртэхийн тулд энэ нь шаардлагатай юм. Үнэнчдийн хамт байхын ашгийг шүлэгч нь маш сайхан илэрхийлжээ:

Өргөсийн ганцаараа байхад устгахыг хичээцгээнэ,
Харин сарнайн хамт байхад усална…

Энэ тушаалын Тэбүк Газвад буюу бэрхшээлийн аянд буу-сан нь нэлээд учир утгатай байдаг. Зөвхөн амар тайвны үед биш, үнэнчдийн бэрхшээлийг дааж байгаад Аллахын замд жихадаар явж байхад ч тэдний хамт байх хэрэгтэй. Үнэнчдийн дийлсэн бэрхшээлийг даах, тэдний мөрийг дагаж тэдний хойно үл үлдэх хэрэгтэй юм.

Ерөнхийдөө Тэбүкийн Аяны тухай буусан Тавба Сурад ихэнхдээ Аллахын замд бараа болон амиараа жихад хийхийн хэр чухал байсан нь дурдсан байдаг. Учир нь бараа болон амиа-раа жихад мусульманчуудын шашны талаар үнэнч байдгийн

хамгийн том баталгаа юм. Энэ нь бас итгэгч мүнафик хоёрын дундын ялгааг илрүүлнэ. Аугаа Эрх ингэж айлдана:

إِنَّ اللّٰهَ اشْتَرَى مِنَ الْمُؤْمِنِينَ أَنفُسَهُمْ وَأَمْوَالَهُم بِأَنَّ لَهُمُ الجَنَّةَ يُقَاتِلُونَ فِي سَبِيلِ اللّٰهِ فَيَقْتُلُونَ وَيُقْتَلُونَ وَعْدًا عَلَيْهِ حَقًّا فِي التَّوْرَاةِ وَالإِنجِيلِ وَالْقُرْآنِ وَمَنْ أَوْفَى بِعَهْدِهِ مِنَ اللّٰهِ فَاسْتَبْشِرُواْ بِبَيْعِكُمُ الَّذِي بَايَعْتُم بِهِ وَذَلِكَ هُوَ الْفَوْزُ الْعَظِيمُ

“Аллах итгэгчдээс амийг ба барааг нь тэдэнд олгох диваажингийн хариуд худалдаж авсан байдаг. Учир нь тэд Аллахын замд байлдаж, алж, үхэцгээнэ. Энэ нь Тэвратад, Инжилд ба Кур’анд Аллахын өөртөө даалгасан нэгэн амлалт мөн. Амласнаа Аллахаас илүү хэрэгжүүлсэн хэн байдаг вэ? Тийм байвал Тэрээртэй хийсэн энэ худалдаандаа баясцгаагаарай! Энэ нь үнэхээр том нэгэн ашиг мөн.” (эт-Тавба, 111)

Өөр нэгэн чухал сэдэв ч, эрин бүрт мусульманчуудын хувьд хамгийн том аюул нь мүнафикчууд юм. Тэбүкийн Газва болон Тавба Сура нь энэ үнэнийг хамгийн тодорхойгоор илэрхийлж мусульманчуудыг сануулсан байдаг.

Саатү’л-Үсрэгээс ойлгосноор нэгэн мусульман хэзээ ч амар тайван ба тав туханд автахгүй, тааралдсан хамаг бэрхшээлтэй байлдаж Аллахын замд урагшлахаас хойно үлдэхгүй байх ёстой юм.

Тэнгэр Газар Хоёрын Баялаг Сан нь Аллахад Харьяалагдана

Кафирчууд хэдий ихээр хичээсэн ч Аллах шашнаа ээрхүүлсэн, итгэгчдийг тэднээс давуу болгосон байв. Учир нь энэ нь Аугаа Эрхийн Элчдээ ба Тэрээрийн замд дотно сэтгэлээр явагч итгэгчдэд тэнгэрлэг амлалт нь байв. Тийм учраас Аллахын дайсад хүсээгүй ч энэ үнэн заавал хэрэгжих байв. Энэ тухай Кур'ан-и Кэримд ингэж айлдана:

هُمُ الَّذِينَ يَقُولُونَ لَا تُنفِقُوا عَلَى مَنْ عِندَ رَسُولِ اللَّهِ حَتَّى يَنفَضُّوا وَلِلَّهِ خَزَائِنُ السَّمَاوَاتِ وَالْأَرْضِ وَلَكِنَّ الْمُنَافِقِينَ لَا يَفْقَهُونَ

“Тэд үл итгэгчид: «Аллахын элчийн дэргэдийн хүмүүст юм битгий зарцуул, тэгээд тэд тараад явна!» гэгчид юм. Харин тэнгэр ба газрын баялаг сан нь Аллахынх мөн. Гэтэл мүнафикчууд үүнийг ойлгохгүй.” (эл-Мүнафикун, 7)

Үнэхээр хэдэн олон эриний турш кафирчууд мусульманчуудын эдийн засгийн хүчийг сулруулахаар хичээсэн ч тэнгэр газар хоёрын баялаг нь Аллахад харъяалдаг тул Аугаа Эрх итгэгчдэд том бэлэг хайрласан, бодит ба хийсвэр цэргээ хөдөлгөн богино хугацаанд тэднийг ялалтад хүргэсэн ба кафирчуудыг гутамшигт учруулсан байдаг.

Исламын түүхийг харвал Аллахын тусламжтайгаар итгэгчид маш бага хүчээр том амжилтыг хүртсэн байдаг. Бэдир, Мүтэ, Эндүлүс, Малазгирт ба бусад олон ялалт энэ үнэний жишээ юм. Нөгөө талаас хамаг дэлхийд “и'ла-я кэлимэтуллах”ын гарын үсгийг сурсан содон Осман Гүрнийг 400 морьтон байгуулсан байдаг.

Үүнээс үзвэл мусульманчууд итгэл үнэмшлийнхээ хэмжээнд амжилттай болдог. Өөрөөр хэлбэл итгэл үнэмшлээ алдсан нь хүчээ алдана; итгэл үнэмшлээ салаагүй нь ч хүч чадлаараа хожигдошгүй байх болно. Ийм байхад Исламын дайсад яасан ч мусульманчуудад эцсийн цэгт ямар ч аюул хүргэж чадахгүй. Аугаа Эрх ает-и кэримэд энэ тэнгэрлэг занг ингэж мэдээлнэ:

وَإِن تَصْبِرُوا۟ وَتَتَّقُوا۟ لَا يَضُرُّكُمْ كَيْدُهُمْ شَيْـًٔا
إِنَّ ٱللَّهَ بِمَا يَعْمَلُونَ مُحِيطٌ

“…Аяа Итгэгчид ээ! **Хэрэв** танд тохиолдсон бэрхшээлийг тоохгүйгээр Аллахын шашныг авч явах тухай **тэвчиж болгоомжилбол,** өөрөөр хэлбэл таква дээр Аллахад хоргодож мөн хэрэгтэй арга хэмжээг авбал **тэдний мэх нь танд ямар ч аюул хүргэж чадахгүй! Учир нь Аллах тэдний хийснийг бүрэн мэдэж байдаг.”** (Ал-и Имран, 120)

Тэгээд Жаргалын Үе бэ Исламын түүх энэ ает-и кэримэгийн тоолшгүй жишээг гэрчилсэн байдаг.

Мөргөл Үйлчилгээгүй Шашинд Буян Үгүй!

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг зорьсон ялалтуудыг бүтээж Мадинад харихад Таифын тэргүүн Үрвэ бин Мэс’үд амьсгаа авалгүй тэднийг дагаж ирээд мусульман болсон байв. Дараа нь Таифад хариад аймгаа Исламд урьж эхлэв. Харин дээр үед тэдэнд Исламыг мэдээлэхээр ирсэн Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг ч чулуугаар цохилцсон энэ хүмүүсийн Үрвэд үзүүлсэн хариулт нь бүр илүү хатуу болов. Түүнийг сум харваж шэхид болгоцгоов.[326]

326. Ибн-и Хишам, IV, 194; Хаким, III, 713/6579.

Тэгэхлээр нь Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- мусульман болоод өмнөх үүрэг нь даалгасан Хэвазины тэргүүн Малик -радъяллахү анх-ад Таифчуудыг хавчихаар тушаал олгов. Уг тушаалын дагуу Малик заримдаа дайрдаг тул хэрэмдээ хоригдож гадаа гарч чадаагүй Таифчууд эцэст нь бүр залхаад аймгийнхаа ахмадуудыг Мадинад илгээцгээв.[327]

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Сакифын хамт олныг, тэдний зүрхийг зөөлрүүлэх гээд мэсжидэд зочин болгов.[328] Төлөөлөгчид шөнө уншсан Кур'ан-и Кэримийг, асхабын тэхэжжүд мөргөлд уншсан сурануудыг сонсч, мусульманчуудын таван үеийн мөргөлд эгнээнд орохыг үзээд байцгаав.[329]

Сакифын хамт олон нь мөргөлөөс өршөөл авах шаардлагатайгаар итгэж бууж өгөхөө илэрхийлэв. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэдний энэ саналыг:

"Мөргөлгүй шашин буян үгүй," гээд татгалзав. (Эбү Давуд, Хараж, 25-26/3026)

Таифчууд энэ удаа Лат гэсэн нэрт баримлынхаа гурван жил байрандаа байгаа байдлыг толилуулав. Хүлээн зөвшөөрөхгүй байлаа ч "Ядаж нэгэн сар бидний дэргэд байж байг!" гэцгээв. Үүнийг ч зөвшөөрөөгүй. Эцэст нь аргагүй болж итгэн үнэмшив. Энэ удаа ядаж Латын баримлыг нураахад тэднийг оролцуулахгүйг гуйцгаав. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч "Заавал та нар нураана!" гэж албадаагүй, энэ ажлаар Эбү Сүфьяан ба Мугираг илгээв.[330] Баримлыг нурааж байхад Сакиф аймгийн эмэгтэйчүүд гэрээсээ гараад уйлсан нь нэн

327. Ибн-и Хишам, IV, 138, 195.

328. Ахмад, IV, 218.

329. Вакидий, III, 965.

330. Ибн-и Хишам, IV, 197; Вакидий, III, 967-968.

сонин юм. Харин Исламын агуу талыг ба ёс суртахууныг сурах тусмаа бүгдээрээ цэвэр мусульманчууд болж баримлуудын нэрийг ч бүр мартацгаав.

Ингээд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн Маккагийн эриний 9 дэх жилд Таифчуудын хийсэн харгислалын хариунд тэдний авралтын төлөө хийсэн энэрэлт залбирал нь, Аллахын онгонд хүлээн зөвшөөрөгдөн хэрэгжсэн болов.

Сакифын төлөөлөгчдөд Исламын фарзууд болон дүрэм журмыг сургацгаав. Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэдэнд Рамазан сарын үлдсэн хэсэгт мацаг барихыг ч тушаав. Билал-и Хабэший тэдний ифтар болон сахур хоолыг тэдэнд хүргэж өгөв.[331]

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- өөрт нь ирсэн хамт олныхонтой өглөө орой хэзээ ч завтай байвал уулзаад, тэдний хэргийг урт удаан ярилцдаг байв.[332] Сакифын хамт олонтой ч адилхан хэвтүүл мөргөл бүрийн дараа уулзсан Пайгамбар Эзэн маань нэгэн удаа зогсож удаан ярьсан хөлөө ээлжлэн амрааж байхыг мэдэрсэн байв.[333]

Сакифын төлөөлөгчдөөс Эвс бин Хүзэйфэ ингэж ярина:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэгэн шөнө хэвтүүл мөргөлийн дараа удаан хугацаагаар бидний дэргэд ирээгүй:

«–Аяа Расулаллах! Бидний дэргэд ирээгүй яагаад оройтов?» гэж асууцгаалаа.

331. Вакидий, III, 968.

332. Умар -радъяллахү анх- өгүүлрүүн:
“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- мусульманчуудтай хамаатай ямар ч хэргийн тухай Эбү Бэкиртэй шөнийн орой цаг хүртэл ярилцаж, би ч тэдний хамт суудаг байв.” (Тирмизий, Салат, 12/169)

333. Эбү Давуд, Шэхрү Рамазан, 9/1393.

Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-:

«–Өдөр бүр Кур’анаас нэгэн хизб уншихыг өөртөө үүрэг болгосон байдаг. Үүнийг хийхгүй байж болохгүй,» хэмээв.

Өглөө гарахдаа Асхаб-и кирамаас:

«–Та Кур’аныг яаж хизб болгож уншдаг вэ?» гэж асууцгаалаа.

Тэд:

«–Бид сурануудаас анхны гурвыг нэгэн хизб, дараахь таван сураг хоёр дахь хизб, дараа нь долоо, ес, арван нэг ба арван гурван сураг нэгдүүлж тус бүрийг нь нэгэн хизб болгоно. Хамгийн сүүлээр ч Каф Сурагаас дуустал нь нэгэн хизб болгож Кур’ан-и Кэримийг долоон хэсэг болгон уншдаг,» гэцгээв.” (Ахмад, IV, 9; Ибн-и Мажэ, Салат, 178)

Асхаб-и кирам нь Аллах Таалагаас ирсэн зарлиг ба Расулаллах -алэйхиссалатү вэссэлам-ын ч дурсамж байсан тул Кур’ан-и Кэримийг маш их чухалчилдаг байв. Түүнийг мөргөлдөө уншсанаар үл барам, зорчих ба газвад, ярилцлагад, шөнийн мөргөлд ихээр уншдаг байцгаав. Кур’анд хэзээ ч ханадаггүй, Түүнийг уншилгүй нэгэн хоног ч өнгөрөөдөггүй байв.[334] Өдрөө Кур’анаар эхлүүлж, нүдний өвчтэй хүмүүсийг ч Сударын Хуудас харахыг зөвлөдөг байцгаав. Түүнчлэн Хазрат-и Усман -радъяллахү анх- их уншсан тул хоёр Судар хуучруулсан байв.[335]

Сакифын төлөөлөгчдийн хооронд Кур’ан-и Кэримтай хамгийн ихээр сонирхсон нь Усман бин Эби’л-Ас байв. тэдний дунд хамгийн залуу нь тэр байсан тулд түүнийг хойно, малын-

334. Ибн-и Са’д, III, 75-76.

335. Кэттаний, II, 197.

хаа дэргэд үлдээсэн байцгаав. Төлөөлөгчдийг хариад үдийн халуунд нойрмоглож эхлэхлээр, Усман -радъяллахү анх- нь Пайгамбарын маань дэргэд ирээд Түүнээс шашны зүйлсийг асууж, Кур'ан-и Кэрим сонсоод сурдаг байв. Ингээд Аллахын Элчээс зарим сураг уншиж цээжлэв.

Төлөөлөгч найзуудаасаа нууцаар бий'ат хийж мусульман болсон Усман -радъяллахү анх- нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг завгүй олохдоо Эбү Бэкир эсвэл Үбэй бин Ка'бт очоод асуух юмаа асууж, уншмаар буй юмаа уншдаг байв. Түүний ийм байдал нь Расулаллах Эзэнд маань их таалагдаж, Тэр түүнд дуртай байв. Сакифын төлөөлөгчид нутагтаа харих гэсэнд:

"–Аяа Расулаллах! Бидний дундаас нэгнийг бидэнд имамаар томил!" гэцгээв. Тэр ч Усман -радъяллахү анх-ыг, насаараа тэдний хамгийн залуу байсан ч тэдэнд имамаар томилов. (Ибн-и Хишам, IV, 185; Ибн-и Са'д, V, 508; Ахмад, IV, 218)

Тэбүкээс Харьсны Дараах Бусад Явдал

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Египетээс ирсэн Мариягаас Ибрахим нэртэй хөвүүнтэй болсон байв. Хазрат-и Ибрахим нь Тэбүкээс харихад нь өвдөөд хэсэг хугацааны дараа үгүй болов. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- үүнд маш их гунив. Ариун нүднээс нь чимээгүйгээр энэрлийн дусал нь асгарав. Ингэж айлдав:

اِنَّ الْعَيْنَ تَدْمَعُ وَالْقَلْبَ يَحْزَنُ وَلاَ نَقُولُ اِلاَّ مَا يَرْضَى

رَبُّنَا وَاِنَّا بِفِرَاقِكَ يَا اِبْرَاهِيمُ لَمَحْزُونُونَ

"Нүд уйлж, сэтгэл ч гунина, харин бид Раббынх маань таатай болохоос өөр үг хэлэхгүй! Валлахи аяа Ибрахим! Бид чамаас салсандаа маш их гунигтай байна!" хэмээв. (Бухарий, Жэнаиз, 44; Ибн-и Са'д, I, 138)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэгэн чулуу авчрахыг тушааж булш дээр босгов. Ингээд Хазрат-и Ибрахимын булшийг тэмдгээр тогтов. Дээр нь анх ус цацалсан булш түүнийх болов.[336]

Тэр хооронд нар хиртсэн байв. Асхабаас зарим нь үүнийг мунхаг үеийн заншлаар Хазрат-и Ибрахимын үгүй болсонтой холбож үздэг. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- бол тэр тохиолдолд хоёр рэкат мөргөл үйлдэж асхабынхаа ийм бодолд таагүй болсноо илэрхийлэн:

"Нар Сар нь Аллахын аетаас хоёр бэлгэ тэмдэг юм. Тэд хэн нэгэн төрснөөс, эсвэл хэн нэгэн нас барснаас ч хиртэхгүй. Нар эсвэл Сар хиртсэнийг харвал Аллахыг дурдаж эхлээд мөргөл үйлдэцгээ!" хэмээв.[337] (Нэсаи, Күсүф, 14)

Рэжэб сар явахад Абиссинийн Нэжаший нас барав. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- хооронд тэнгис байсан бөгөөд хуурай газраар ч олон өдөр явах зайтай байсан ч Нэжашийгийн нас барсныг асхабтаа тухайн өдөрт мэдээлэн:

---

336. Ибн-и Са'д, I, 144; Ибн-и Абдилбэр, I, 59.

337. Манай эринд ч Нар ба сар хиртэх үед мөргөл үйлдэж залбирч хэнгэрэг цохих, буу буудах мэтийн үйлс үздэг. Энэ нь мухар сүсгээс үүсэлтэй ардын шүтлэг бөгөөд Исламтай ямар ч холбоогүй байдаг. Мөн шар шувууны дуугарахыг бузар гэж нулимах ч тухайн буруу ойлголтоос үүсч байдаг.

“–Алсын оронд нас барсан дүүгийнхээ оршуулах мөргөлийг үйлдэцгээгээрэй!” хэмээв.

Сахабийчууд:

“–Аяа Расулаллах! Тэр хэн бэ?” гэж асуухлаар нь Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Нэжаший Асхама юм! Өнөөдөр Аллахын сайн боол Асхама өнгөрөв! Дүүгийнхээ төлөө Аллахаас өршөөл гуй-гаарай!” хэмээж түүний хойгуурт оршуулахын мөргөлийг үйлдүүлэв. (Мүслим, Жэнаиз, 62-68; Ахмад, III, 319; IV, 7)

Дараа нь Нэжашийг яг Аллахын Элчийн мэдээлсэн өдөр нас барсны мэдээ хүрэв.

Шабан сард ч Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ариун охин Хазрат-и Усман -радъяллахү анх-ын ч хүндэт хатан байсан Үммү Гүлсүм -радъяллахү анха- Рахманы энэрэлд хүрэв.[338]

Тэбүкийн Аянаас хоёр сар орчмын дараа буюу Зилкадэ сард мүнафикчуудын тэргүүн Абдуллах бин Үбэйгийн муу муу-хайгаар дүүрэн амьдрал цэглэв. Түүний нас барснаар мүнафик хөдөлгөөний суурь гуйваад үлдсэн мүнафикчуудын ихэнх нь тавба хийгээд дотно мусульманчууд болцгоов.

Түүнийг нас барахад хөвүүн нь Абдуллах аавынхаа гэрээ-сэлснээр Аллахын Элчид ирээд:

338. Ибн-и Са’д, VIII, 38.

“–Аяа Расулаллах! Абдуллах бин Үбэй нас барав. Цамцаа өгөөрэй, түүнд кэфэн болгоё. Оршуулах мөргөлийг нь үйлдүүлээд түүний төлөө өршөөл гуйгаарай!” гэв. Пайгамбар -алэйхиссалату вэссэлам- цамцаа тайлж гаргаад түүнд өгч, бэлдэхлээр нь ч мөргөлийг нь үйлдүүлэв. Тэгэхлээр нь уг ает-и кэримэ нь буув:

وَلاَ تُصَلِّ عَلَىٰٓ أَحَدٍ مِّنْهُم مَّاتَ أَبَدًا وَلاَ تَقُمْ عَلَى قَبْرِهِ
إِنَّهُمْ كَفَرُواْ بِاللّهِ وَرَسُولِهِ وَمَاتُواْ وَهُمْ فَاسِقُونَ

“Тэднээс үхсэн хүний мөргөлийг бүү үйлд, булш дээр нь ч бүү хүлээ! Учир нь тэд нар Аллах болон пайгамбарыг нь үгүйсгэж, фасик буйгаараа үхэв.” (эт-Тавба, 84) (Бухарий, Жэнаиз, 23; Ибн-и Мажэ, Жэнаиз, 31)

Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс яагаад ингэснийг асуувал:

“–Миний цамц ба түүн дээр үйлдсэн мөргөл нь түүнийг Аллахын тамлалаас хамгаалахгүй! Гэтэл би ингэхдээ түүний аймгаас мянган хүний мусульман болохыг найдаж байна,” хэмээв.

Тэгээд Абдуллах бин Үбэйгийн ингэж Аллахын Элчийн цамц болон дээр нь үйлдэж мөргөн аврал хүссэнийг харсан Хазражчуудаас мянган хүн мүшрик болохоо байж мусульман болцгоов.[339]

Элч Нарын Жил

Маккаг эзэлсэн, Хүнэйний Дайнд ялсан, Таифын ард бүслэлтээс жилийн дараа мусульман болсон ба тэр хооронд

339. Айний, VIII, 54; Диярбэкрий, II, 140-141.

хийсэн бэрхшээлт Тэбүкийн Аян ч амжилттайгаар дууссан байв. Одоо Арабын хойгт Исламын өмнө саад болох юу ч үлдээгүй байв.

Ингээд Исламын агуу содон шинжийг зөв таних боломж ба завшааныг олсон Арабын аймгууд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д хамт олноо илгээж холбогдсоноо илэрхийлж эхэлцгээв. Йемен, Хадрамэвт, Бахрейн, Амман, Сири ба Ираны хилээс ирсэн энэ хамт олнууд нь мусульман болохоор эсвэл мусульман болсноо мэдээлэхээр ирээд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ээс тэдэнд Исламыг сургах багш нар нэхэж байцгаав.

Ирсэн хамт олнуудын Исламыг Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ын өөрөөс нь сураад шууд харихдаа аймгийнхандаа ойлгуулсны сайхан нэгэн жишээ нь Бэний Түжибийнхэн юм. Тэднээс арван гурав дахь хамт олон нь Аллахын Элчийн дэргэд хүрээд ирцгээв. Зэкат бараагаа ч хажуудаа аваад ирсэн байцгаав. Тэдний ийм байдал Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-д маш их таалагдав. Тэдэнд:

"–Тавтай морилцгоо!" хэмээв. Билал-и Хабэшийд тэднийг хамгийн сайхнаар угтахыг тушаав. Бэний Түжибийн хамт олон:

"–Аяа Расулаллах! Аллахын зөвшөөрлөөр Чамд эд бараа авчирцгаалаа," гэцгээв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Тэднийг буцаж аваад ядуучууддаа тараагаарай," хэмээв.

Хамт олон:

"–Аяа Расулаллах! Бид угаасаа ядуучуудад тарааснаас үлдсэнийг л Чамд авчрав," гэцгээв.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх-:

“–Аяа Расулаллах! Араб хамт олнуудын дунд, үнэхээр энэ Түжибийнх шиг нь алга,” гэв.

Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Аврал нь Аллах Таалагийн гарт байдаг. Аллах буяныг нь хүссэн хүний зүрхийг итгэл үнэмшилд нээнэ!” хэмээв.

Түжибийн хамт олон нь Пайгамбараас маань Кур’ан болон сүннэтээс зарим хэргийг асуув. Асуусан зүйлсийн хариуг бичэд тэдэнд өгөв. Ингэж хичээсний улмаас Орчлонгуудын Эзний тэдэнд үзүүлсэн сонирхол ихсэв. Хамт олон нь хэдхэн хоносны дараа явах юмсан. Тэднээс:

“–Яагаад яараад байна вэ?” гэж асууцгаав.

“–Хойно үлдсэн ардынхаа дэргэд хариад Расулаллахаас үзсэн ба асуугаад сурснаа тэдэнд ярина,” гэцгээв. Орчлонгийн Хүндэт Эзний маань дэргэд ирээд салцгаав. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэдэнд Билал-и Хабэшийг илгээж. Тэдэнд бэлэг өгөөд, бусад аймгуудаас илүүг өгөхийг тушаав. (Ибн-и Са’д, I, 323; Ибн-и Кайям, III, 650-651)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- хамт олнуудын Мадинад түр байхыг гуйгаад тэдний Кур’ан-и Кэрим болон шашны гол дүрмийг сурах ба шууд өөрийнхөө яаж хийснийг гэрчилж Исламыг ухааруулахаар шийдсэн байдаг. Жишээлбэл Абдү’л-Кайсын хамт олныг ирэхэд Энсараас тэднийг хүлээж аваад дайлахыг гуйсан байв. Энэ хооронд хэрэгтэй шашны мэдээг сургаж, мөргөлд хэрэгтэй сурануудыг цээжлүүлэхийг сануулсан байв. Өглөөгүүр ирэхэд нь тэдний мэндийг эрж, Энсарын сонирхолд таатай байх эсэхийг асуув. Тэд ч таатай байснаа илэрхийлэв. Дараа нь Аллахын Элч хамт олныг шашныг илүү амархан сурч чадахаар нь асхабын гэр нэг

нэгээр буюу хоёр хоёр тараав. Асхаб хичээсэн ба Абдү'л-Кайсчуудын сурах хүсэлд хэт таатай болсон Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- тэдэнд нэг нэгээр нь сонирхол үзүүлж цээжилсэн Таххиятыг, Фатихаг, бусад сурануудыг ба сурсан сүннэтүүдийг өөрөө л шалгав.[340]

Ингээд Ислам шашин нь өдрөөс өдөрт хамаг Арабстанд дэлгэрэв. Хүмүүс олноороо Исламд ороод байцгаав. Мадина нь өдөр бүр шинээр ирсэн зочидоор дүүрч байв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч ирэгсдийг хамгийн сайхнаар угтаж, тэднийг дайлаад тус бүрийн байдал, хандлага ба заншлын дагуу тэдэнтэй ярилаж, ирсэн нутгийн тухай мэдээлэл аваад, хүсэлтийг нь сонсоод асуусанд нь хариулж, хэргийг нь шийдээд, сэтгэлүүдэд Исламын туяа, амар тайван ба жаргалыг нэвтрүүлж байв.[341]

Одоо хуучны төвөгтэй байдал өөрчлөгдөж элбэг нэгэн таатай байдал бий болсон байв. Тэгээд Аллах Таала өөрийнхөө онгоноос уг соёорхлын талархлыг хэрэгжүүлэх талаар Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- болон Түүний өмнөөс итгэгчдэд ингэж айлдсан байдаг:

إِذَا جَآءَ نَصْرُ اللّٰهِ وَالْفَتْحُ. وَرَأَيْتَ النَّاسَ يَدْخُلُونَ فِي دِينِ اللّٰهِ
أَفْوَاجًا. فَسَبِّحْ بِحَمْدِ رَبِّكَ وَاسْتَغْفِرْهُ إِنَّهُ كَانَ تَوَّابًا

“Аллахын тусламж ба ялалт ирээд хүмүүсийг олноор Аллахын шашинд орохыг харахдаа Рабдаа хамд хийгээд Тэрээрийг тасбих хий, тэгээд Тэрээрээс өршөөл гуй! Учир нь Тэрээр тавбаг ихээр хүлээж авагч мөн.” (эн-Наср, 1-3)

340. Ахмад, III, 402.
341. Хар. Нэсаи, Үмрэ, 5.

Хижрэтийн дараах ес дэх жилд хэрэгжсэн Исламын Арабстанд ийнхүү хурдан дэлгэрсэн ба Мадинад ил шашныг сурахаар аймгуудын элч нар олноор ирснээс болж энэ жилийг “элч нарын жил” гэж нэрлэцгээв.

Хажийн Фарз

Хижрэтийн есөн он хүртэл хаж нь Хазрат-и Ибрахим -алэйхиссэлам-ын Ханиф шашны дагуу хэрэгжүүлдэг байсан боловч, мүшрикчүүд түүнд олон буруу хэрэг ч оруулж хольсон байцгаав. Энэ жил бол Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хазрат-и Эбү Бэкирийг хажийн тэргүүн болгож Ислам шашны Хажийг мусульманчуудад сургахаар гурван зуун хүний хамт Маккад илгээв. Өөрөө ч арав дахь жилд хаж хийхээ мэдээлэв. Тахил болгохоор хүзүүнд нь тэмдэг зүүсэн хорин тэмээг ч тэдний хамт илгээв.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх- хажийн мөргөлчид олноор замд гарахад нь Тавба буюу Бэраэ Сурагийн анхны аетууд буув. Ингээд баримлаас цэвэрлэсэн Аллахын Гэрийг мүшрикчүүдээс цэвэрлэхийг ч тушаав. Учир нь тэр цаг хүртэл мүшрикчүүдийн Кабад залбирахад нь оролцоогүй байв. Харин жинхэнэ шинжээ олсон буй Каба-и Муаззамад мүшрикчүүдийн алгаа ташиж, нүцгэн буйгаараа ёс бус өөрсдийн дураар залбирал үйлс хийсэн нь тэвхидийн шашны талаар зохимжтой болдоггүй, ардын дунд ч андуурлын учир болж байв. Бэраэ Сурагийн тэр үед буусан ийнхүү аетууд нь Кабад тэвхидийн эсрэг илэрсэн хүндэтгүй явдлыг цэглэсэн аетууд болов. Аллах Таала ингэж айлдав:

بَرَاءةٌ مِّنَ اللّهِ وَرَسُولِهِ إِلَى الَّذِينَ عَاهَدتُّم مِّنَ الْمُشْرِكِينَ.
فَسِيحُواْ فِي الأَرْضِ أَرْبَعَةَ أَشْهُرٍ وَاعْلَمُواْ أَنَّكُمْ غَيْرُ مُعْجِزِي
اللّهِ وَأَنَّ اللّهَ مُخْزِي الْكَافِرِينَ. وَأَذَانٌ مِّنَ اللّهِ وَرَسُولِهِ إِلَى النَّاسِ
يَوْمَ الْحَجِّ الأَكْبَرِ أَنَّ اللّهَ بَرِيءٌ مِّنَ الْمُشْرِكِينَ وَرَسُولُهُ فَإِن تُبْتُمْ
فَهُوَ خَيْرٌ لَّكُمْ وَإِن تَوَلَّيْتُمْ فَاعْلَمُواْ أَنَّكُمْ غَيْرُ مُعْجِزِي اللّهِ وَبَشِّرِ
الَّذِينَ كَفَرُواْ بِعَذَابٍ أَلِيمٍ. إِلاَّ الَّذِينَ عَاهَدتُّم مِّنَ الْمُشْرِكِينَ ثُمَّ
لَمْ يَنقُصُوكُمْ شَيْئًا وَلَمْ يُظَاهِرُواْ عَلَيْكُمْ أَحَدًا فَأَتِمُّواْ إِلَيْهِمْ
عَهْدَهُمْ إِلَى مُدَّتِهِمْ إِنَّ اللّهَ يُحِبُّ الْمُتَّقِينَ

"Аллах болон Элчээс нь таны гэрээ хийсэн мүшрикчүүдэд нэгэн сануулга! Мүшрикчүүд ээ! **Дэлхийд дөрвөн өөр дөрвөн сар явцгаа! Үүнийг сайн мэдэцгээ, та Аллахыг орхиж чадахгүй; Аллах бол кафирчуудыг дорой болгох болно. Энэ нь Аллах ба Элчээс нь Агуу Хажийн өдөр бол хүмүүст нэгэн зарлал юм. Аллах ба Пайгамбар нь мүшрикчүүдээс хол юм. Хэрвээ тавба хийвэл энэ нь таны хувьд илүү буянтай. Хэрвээ нүүрээ буруулбал, Аллахыг орхиж чадахгүйгээ сайн мэдэцгээ.** Элч минь ээ! **Кафирчуудад зовлонтой тамлалын мэдээг өг! Гэтэл таны гэрээ хийсэн мүшрикчүүдээс , ямар ч дутуу үлдээхгүй ба таны эсрэг хэнийг ч дэмжихгүй нь энэ шийдвэрт хамаарахгүй. Тэдний гэрээг хугацаа нь дуустал үзээрэй! Аллах муттакийчуудад дуртай!"** (эт-Тавба, 1-4)

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُواْ إِنَّمَا الْمُشْرِكُونَ نَجَسٌ فَلاَ يَقْرَبُواْ

الْمَسْجِدَ الْحَرَامَ بَعْدَ عَامِهِمْ هَذَا وَإِنْ خِفْتُمْ عَيْلَةً فَسَوْفَ يُغْنِيكُمُ اللّٰهُ مِن فَضْلِهِ إِن شَاءَ إِنَّ اللّٰهَ عَلِيمٌ حَكِيمٌ

“Аяа итгэгчид ээ! Мүшрикчүүд бохир юм. Тийм учраас энэ жилээс хойш тэд Мэсжид-и Харамд бүү ойртуул! Хэрвээ ядуурлаас айвал, Аллах хүсвэл таныг өөрийнх соёорхлоор баян болгохыг мэдээрэй. Андашгүй нь Аллах Алим юм, Хаким юм.” (эт-Тавба, 28)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- энэ ает-и кэримэнүүдийн зарлахаар Хазрат-и Али -радъяллахү анх-ыг Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх-ын араас Мадинад илгээв.

Хазрат-и Али -радъяллахү анх- баярын анхны өдөр Акабагийн Жэмрэгийн дэргэд босоод Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн өөрт нь олгосон энэ үүргээ нэгэн хутба хэлээд хэрэгжүүлэв. Тавба Сурагаас тодорхой аетуудыг уншсаны дараа Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн товчилсон энэ дөрвөн зүйлийг хүн бүрт сонсгов:

1. Хүн бүр мэдэг, диваажинд зөвхөн итгэгчид л орж чадна.

2. Кабад хэзээ ч нүцгэн байдлаар таваф хийхгүй.

3. Энэ жилээс эхлэн ямар ч мүшрикийг Бэйтуллахад ойртуулахгүй.

4. Зөвхөн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-тэй гэрээ хийсэн бөгөөд үүнд үнэнч буй мүшрикчүүдийн тухай, тодруулсан хугацааг дуустал гэрээний зүйлс хүчинтэй байх болно.

Энэ жилийн хойш ямар ч мүшрик Хажид ирээгүй ба Кабад нүцгэн таваф хийгээгүй юм.

Энэ жилээс хойш ширкийн өөрсдийнхөө муухай байдлыг анзаарсан адгийн мүшрикчүүд ч эцэст нь итгэл үнэмшлийг сонгосон байдаг.

Энэ жилээс хойш Каба-и Муаззама нь баримлаас цэвэрлэсնээс үл барам мүшрикчүүдээс ч цэвэрлэсэн буйгаар Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хийх том хажид бэлэн болсон байв.[342]

342. Ибн-и Хишам, IV, 201; Тирмизий, Хаж, 44/871; Вакидий, III, 1077.

ХИЖРЭТИЙН АРАВ ДАХЬ ЖИЛ

Адий бин Хатим Мусульман Болсон нь

Өгөөмөр зангаараа домог болсон Хатим-и Таий нь Тайй аймгаас байсан бөгөөд Адийгийн аав байв. Адий нь аймгийн-хаа дотор том, нэр хүндтэй, уран илтгэгч, бэлэн хариут, эрдэмт ба өгөөмөр нэгэн хүн байв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хижрэтийн ес дэх жилд Хазрат-и Алиг Тайй аймгийн баримал Фүлсийг нураахаар илгээсэнд Адий Дамаскад зугтсан байв. Охин дүү нь Сэффанэ бол барьцааны хүмүүсийн дунд Мадинад ирсэн байв.

Оршигчдын Туяа Эзэн маань Сэффанэг чөлөөлж хувцас, унаа, замын хүнс өгөөд аймгаас нь итгэмжтэй зарим хүмүүсийн хамт Дамаскад илгээв.

Адий бин Хатим өгүүлрүн:

“Сэффанэ ухаант эмэгтэй байв. Түүнээс:

«–Уг хүний ажлын тухай чиний бодол юу вэ?» гэж асуулаа. Надад:

«–Валлахи, би чамайг яаралтай Тэнд орохыг зохимжтой гэж үзнэ. Хэрэв өөрөө үнэхээр пайгамбар бол, Түүнийг дагахад бусдаас түрүүлэх нь чиний хувьд эрдэм ба давуу тал байх болно. Нэгэн эзэн хаан байвал Түүний ачаар Йемен дэх хааны

суудлаа алдахгүй, дорой ба доромж байдалд орохгүй! Одоо чиний л шийдвэр!» гэв.

«–Валлахи чиний зөв! Би энэ хүнд очно. Тэр нь худалч байвал тэр нь надад аюул хүргэхгүй. Хэрвээ үнэнч байвал хэлснийг нь сонсоод Түүнийг дагана!» гээд Мадинад ирлээ. Пайгамбар -алэйхиссалату вэссэлам-ын дэргэд садан хамаатан, эмэгтэй ба хүүхдүүдийг нь хараад Түүнд Хосров эсвэл Кайсарын ноёрхол үгүйг ойлголоо!

Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм- минйи гараас хөтлөн намайг гэртээ аваачив. Замд ядуу зүдүү нэгэн эмэгтэй Түүнийг зогсоож хүсэлт гуйлтаа хэлэв. Тэр ч удаан зогсож байгаад эмэгтэйн асуудлыг сонсоод хэргийг нь шийдэв. Гэрт очиход хамарваанаар хийсэн дэр аваад надад :

«–Үүн дээр суу!» хэмээв.

Би:

«–Үгүй! Түүн дээр Чи суу!» гэлээ.

Расулаллах надад:

«–Үгүй, чи суу!» хэмээв.

Дэрэн дээр суулаа, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- бол шалан дээр суув. Дотроо:

«Валлахи энэ нь эзэн хааны хэрэг биш юм!» гэлээ.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Адий аа! Мусульман болбол эсэн мэнд олно,» гэхлээр:

«–Би шашинтай,» гэлээ.

«–Чиний шашныг би чамаас сайн мэднэ!» хэмээв.

«–Минйи шашныг надаас сайн мэднэ гэж үү?» гэлээ.

«–Тийм! Чи Рэкүсий биш үү?[343] *Ардынхаа гардсан олзны дөрөвний нэгийг идэхгүй байна уу?»* хэмээн асуув.

«–Тийм байна,» гэлээ.

«–Үнэндээ энэ нь чиний шашны дагуу чамд халал биш юм!» гээд өөр юм хэлээгүй. Расулаллах үүнийг хэлэхлээр би маш их ичив! Түүнд:

«–Тийм! Валлахи тий мөн!» гэлээ. Түүнийг Аллахын илгээсэн нэгэн пайгамбар мөн гэдгийг ойлголоо. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- намайг ичээсэн үгийг дахиагүй. Үгээ үргэлжлүүлэн:

«–Чиний Исламд ороход саад болсон учрыг би мэднэ. Чи: "Түүнийг хүчгүй, Арабчуудын үнэ цэнэ өгөөгүй эгэл хүмүүс л дагадаг," гэж байна. Чи Хирэг мэддэг үү?» хэмээв.

«–Хараагүй харин сонслоо,» гэлээ.

«–Сүнсийг минь хүчит гараар барьсан Аллахад тангараг өргөе, Аллах энэ хэргээ бүтээнэ. Тэгээд нэгэн эмэгтэй ганцаараа Хирэгээс гарч ирээд Аллахын гэрийг таваф хийнэ. Дараа нь Хосров бин Хурмасын сан эзлэгдэнэ!» хэмээв.

«–Хосров бин Хурмасынх уу?» гэж асуулаа.

«–Тийм, Хосров бин Хурмасынх!» хэмээв. Дараа нь:

«–Их удахгүй, бараа нь маш их элбэгдээд, хэн ч тоохгүй, барааны зэкатыг авах хэнийг ч олж чадахгүй!» хэмээв.

Намайг мусульман болоход Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- их баясч би царайнд нь том нэгэн жаргал гэрчиллээ. Надад Энсараас нэгний гэрт зочин болохыг тушаав. Өглөө-орой

343. **Рэкүсийя**: Христийн шашин ба Сабии шүтлэгийн дунд, хоёрын хольц шашны ойлголт.

Түүний гэрт яваад ирж эхэллээ. Намайг Түүнийг үгүйлээгүй ямар ч мөргөлийн цаг болоогүй!”

Дараад нь үүнийг ярьсан Адий -радъяллаху анх- ингэж хэлэв:

“Валлахи нэгэн эмэгтэйг Хирэгээс тэмээн дээрээ айхгүйгээр замд гараад тэр Бэйтуллахыг Хаж хийснийг би харсан удаатай! Мөн валлахий Хосровын санг эзлэгчдийн дунд би ч байлаа. Сүнсийг минь гараар барьсан Аллахад тангарагг өргөе, гурав дахь нь ч заавал хэрэгжинэ. Учир нь түүнийг Расулаллах л айлдав.” (Бухарий, Мэнакиб, 25; Ахмад, IV, 257, 377-379; Ибн-и Хишам, IV, 246; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* V, 62)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн нөгөө мэдээлэл ч хэрэгжив. Калиф Умар бин Абдүлазиз зэкатын албаа Африкын орнуудад илгээсэн байв. Тушаалт нь барааг тарааж чадахгүйгээр буцааж авчрав. Учир нь зэкат авах хүн олж чадаагүй байв. Тэгэхлээр тэр ч энэ мөнгөөр олон боол аваад чөлөөлөв.[344]

Оршигчдын Туяаны Анхны ба Сүүлийн Хаж: САЛАХ ХАЖ

Хажийг фарз болсны дараа Аллахын Элч -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хийсэн анхны ба сүүлийн хаж нь Салах Хаж юм. Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм- энэ хаждаа мусульманчуудтай салах ёс хэрэгжүүлэхлээр хүмүүс “Энэ нь салах Хаж юм,” гэцгээж энэ нэр алдаршсан байдаг.[345] Пайгамбар Эзэн маань -саллаллаху алэйхи вэ сэллэм- бол үүнийг “Хажжэтү’л-Ислам” гэсэн нэрээр дурддаг байв.[346]

344. Хар. Бүтий, х. 434.
345. Бухарий, Хаж, 132.
346. Хэйсэмий, III, 237.

Арабстаны нэг захаас нөгөө зах хүртэл мусульман болсон ба Исламын ноёрхол хэтэрхий хүч олсон Хижрэтийн арав дахь жилд тааралдсан уг хажид Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- хамаг мусульманчуудыг урив.

Аллах ба Расулаллахын хайраар дүүрч цалгисан сэтгэл энэ урилгад цөмөөрөө хүрэлцэв. Энэ мэдээг Мадинагийн гадаа хүрэхлээр хүмүүс бүх талаас олноор ирэв. Замд буй хүмүүс нэмэгдэгсдийн тоо нь хязгааргүй байв. Нүд харах тал орчныг өнөр хүмүүс бүрсэн байв. Дөрвөн булангаас Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-тэй хаж хийж чадахаар ирсэн итгэгчдийн тоо нь зуун хорин мянга орчим байв. Бүгдээрээ нэгэн зүрх шиг мөрөөдөхийн аргагүй сайхан үзвэр толилуулж байв.

Орчлонгийн Хүндэт Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм- хаж болон ихрам буюу хажийн өмсгөлийн тухай хүмүүст товч мэдээлэл өгсний дараа замд гарав. Оршигчдын Туяа нь хажид тахил болгохоор хажуудаа зуун орчим тэмээ дагуулж байв. Расулаллах -алэйхиссалатү вэссэлам- замын турш мусульманчуудад байнга хажийн тухай ярив. Айлдсан хутбадаа ихрам болон Хажийн важиб болон сүннэтийг нь ярьж өгөв. Зүлхүлэйфэд ирэхэд Акикын Хөндийд мусульманчуудад ингэж айлдав:

"Раббынх минь илгээсэн Жэбраил өнөө шөнө надад ирээд: «Энэ ариун хөндийд мөргөл үйлдэж Хажид ч үмрэд ч ниет хийсэн !» хэмээв." (Бухарий, Хаж, 16)

Тэнд хоёр рэкат ч ихрамын мөргөл үйлдэв. Аллахад хамд ү сэна өргөж тэсбих хийгээд тэкбир авчирсны дараа:

اَللّٰهُمَّ حِجَّةٌ لاَ رِيَاءَ فِيهَا وَلاَ سُمْعَةَ

“Аяа Аллах минь! Үүнийг надад нүд хуураагүй цэвэр ба зөв нэгэн хаж болгогтун!” хэмээн залбирав. (Ибн-и Мажэ, Мэнасик, 4)

Зүлхүлэйфэд ихрамд ороод буюу хувцсаа ороож:

لَبَّيْك ، اَللّٰهُمَّ لَبَّيْك، لَبَّيْك لاَ شَرِيكَ لَكَ لَبَّيْك، اِنَّ الْحَمْدَ والنِّعْمَةَ لَكَ وَالْمُلْكَ، لاَ شَرِيكَ لَكَ

гээд тэлбие хийж эхлэв. (Бухарий, Хаж, 26)

Дараа ч:

“Та нар хэн ч байсан хаж ба үмрэд зорилт хиймээр байвал одоо хийг!” хэмээв.

Аллахын Элч ихрамд ороод тэлбие хийж эхэлсний дараа Жэбраил -алэйхиссэлам-ын ирээд:

“Аяа Мухаммед! Асхабтаа тэлбие дуугаа чагнахыг тушаа! Энэ нь Хажийн бэлгэ тэмдгээс юм!” хэмээснийг мэдүүлэв. (Ибн-и Мажэ, Мэнасик, 16)

Тэнгэр газар нь хэлсэн тэлбиегийн дуугаар хангинаж амар амгалан нь бүх талыг тор шиг сүлжиж байв.

Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам- очсон газруудад мусульманчуудад имам болж мөргөл үйлдүүлж байв. Дараа нь хүмүүс үнэнч зан ба хайрын илрэлээр Орчлонгийн Хүндэт Эзний маань мөргөл үйлдсэн газруудад мэсжид бариулсан байдаг.[347]

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Бэйтуллахыг харахдаа хоёр гараа дэлгэн өргөж:

347. Ибн-и Са’д, II, 173.

“Аяа Аллах минь! Энэ гэрийнхээ алдрыг, содыг, хүндийг ба үзэсгэлэнг өсгө. Түүнийг хаж ба үмрэ хийгээд хүндэлсэн хүмүүсийн ч алдрыг, содыг, үзэсгэлэнг, хүндэтгэх занг ба сайн сайхныг ч өсгө!” хэмээн залбирав. (Ибн-и Са’д, II, 173)

Рида буюу нөмрөгийнхөө нэгэн үзүүрийг баруун суга доогуур аваад зүүн мөр дээрээ тавьсан ба баруун гар нь ил буйгаар Мэсжид-и Харамд ороод Хажар-и Эсвэдийн оронд хүрээд түүнтэй мэндлэв. Энэ хооронд нүд нь нулимсаар дүүрэв. Хажар-и Эсвэдийг үнсэж гараа түүн дээр тавьсны дараа нүүрэндээ хүргэв.

أَللَّهُمَّ اِيمَانًا بِكَ وَ تَصْدِيقًا بِكِتَابِكَ وَاتِّبَاعًا سُنَّةَ نَبِيِّكَ

“Аллах минь! Чамд итгэж үнэмшиж, номыг баталж, пайгамбарчуудын чинь сүннэтийг дагаж эхэлье,” гээд Хажар-и Эсвэдийн булангаас таваф хийж эхлэв. (Хэйсэмий, III, 240)

Тавафынхаа анхны гурван эргэлтэд богиноор алхаж мөрөө сэгсрээд ихэрхэг үзвэрээр явав. Рүкн-и Йэманий ба Хажар-и Эсвэдийн зэрэг хүрэх бүрдээ:

وَمِنْهُم مَّن يَقُولُ رَبَّنَا آتِنَا فِي الدُّنْيَا حَسَنَةً
وَفِي الآخِرَةِ حَسَنَةً وَقِنَا عَذَابَ النَّارِ

“…Аяа Раб маань! Бидэнд дэлхийд ч сайн сайхныг хайрла, ахиратад ч сайн сайхныг хайрла. Биднийг тамын зовлонгоос хамгаал!” (эл-Бакара, 201) аетыг уншиж байв. Оршигчдын Туяа Эзэн маань тавафын энэ хэсгийг бүтээхлээр Хажар-и Эсвэдийг үнсэв, гараа түүн дээр тавьсны дараа царайндаа түрхэв. Үүний дараа хүмүүсийн дундуур арайхий л гаталж Макам-и Ибрахимд хүрэв. Макамыг Бэйтуллахтай хоорондоо

аваад хоёр рэкат мөргөл үйлдэв. Дахиад Хажар-и Эсвэдийг хүндэлсний дараа Хазрат-и Умарт:

"Умар аа! Чи хүчит хүн юм. Хажар-и Эсвэдэд хүрэхийн төлөө хүмүүсийг шахаад хүчгүйчүүдийг битгий зовоо! Таваа алдах ч үгүй, бусдын тавыг ч алдуулах ч үгүй. Хөл багад олбол Хажар-и Эсвэдийг хүндэлж үнс, эсвэл холоос «гараа түрхэж үнсэх» шиг ханд, элимэ-и тэвхид ба тэкбир хэлээд өнгөрч яв!" хэмээв.[348] (Хэйсэмий, III, 241; Ахмад, I, 28)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- үүний дараа Кабагийн Бэний Махзум үүднээс гараад Сафа даваанд одов. Тийш дөхөхдөө:

إِنَّ الصَّفَا وَالْمَرْوَةَ مِن شَعَآئِرِ اللّٰهِ

"Андашгүй нь Сафа Марва хоёр нь Аллахын бэлгэ тэмдгээс мөн..." (эл-Бакара, 158) аетыг уншиж:

---

348. Хазрат-и Умар -радъяллахү анх- ганц хүнийг ч үймүүлэхгүйн тулд холоос мэндэлсэн байдаг. Энэ нь манай эринд Хаж явсан мусульманчуудын ялангуяа нарийн анхаарал үзүүлэх хэрэгтэй нэгэн байдал юм. Хаждаа олсон буяныг мусульманчуудыг үймүүлэн алдахгүй байх хэрэгтэй. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн саналыг дагаж Каба эсвэл Хажар-и Эсвэдэд дөхөхөөр бусад хүмүүсийг түлхэх, тэднийг зовоох мэтийн үйлсээс болгоомжлох хэрэгтэй.
Хазрат-и Умар -радъяллахү анх- нэгэн удаа Хажар-и Эсвэдэд ирээд түүнийг үнссэн ба:
"Би чамайг чулуу гэдгийг мэднэ, чиний ашиг ч аюул ч байдаггүй. Хэрвээ Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн чамайг үнссэнийг хараагүйсэн бол, би ч үнсэхгүй байв" гэсэн байдаг. (Бухарий, Хаж, 50; Мүслим, Хаж, 251)
Асхабын уг ойлголт нь, ямар нэгэн ажлын учрыг ойлгоогүй байсан ч Аллахын Элчийг жишээ болгож авах ба Түүний Сүннэтийг дагах хэрэгтэй буйг заадаг.

“Аллахын аетад анх дурдсанаас эхэлье!” хэмээж са’й хийхэд Сафагаас эхлэхээр тийш чиглэв. Бэйтуллахыг харахдаа түүнд хандаж тэхлил ба тэкбир авчрав. Гурав эсвэл долоон удаа:

لاَ اِلَهَ اِلاَّ اللّٰهُ وَحْدَهُ لاَ شَرِيكَ لَهُ لَهُ الْمُلْكُ وَ لَهُ الْحَمْدُ يُحْيِى وَيُمِيتُ وَهُوَ عَلَى كُلِّ شَيْءٍ قَدِيرٌ لاَ اِلَهَ اِلاَّ اللّٰهُ وَحْدَهُ لاَ شَرِيكَ لَهُ اَنْجَزَ وَعْدَهُ وَنَصَرَ عَبْدَهُ وَهَزَمَ الْاَحْزَابَ وَحْدَهُ

“Цорын ганц буй Аллахаас өөр бурхан үгүй. Тэрээрийн хань түнш үгүй. Хөрөнгө нь Тэрээрийнх, хамд Тэрээрт харъяалагдана. Амь өгөөд амь авна. Тэрээр бүхнээс хүчит мөн. Аллахаас өөр бурхан үгүй. Аллах амласнаа хэрэгжүүлэв; боолдоо тусалж, өст цугласан хамаг цэргийг ганцаараа мөхөөв,” хэмэн айлдав. (Ибн-и Мажэ, Мэнасик, 84)

Дараа нь Сафагаас Марва даваан тийш алхаж уруудав. Аллахын Элч нь са’й хөндийн дунд хүрэхдээ хурдан алхаж, үүнийг өнгөрсний дараа алхмаа хэвийнд оруулж байв. Тэр хооронд:

رَبِّ اغْفِرْ وَارْحَمْ وَاَنْتَ الْاَعَزُّ الْاَكْرَمُ

“Аяа Раб! Намайг өршөөж надад энэрлээ хайрла! Хамгийн азиз хүндэт, хамгийн кэрим өгөөмөр нь Чи мөн!” хэмээж залбирч байв. (Хэйсэмий, III, 248)

Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Марва даваанд хүрэхдээ Сафад хийснийг тэр чигээр дахив. Сафа Марва хоёрын хооронд долооныы удаа явж ирээд са’йг Марвад бүтээв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Маккад дөрөв хонов. Тавдугаар өдөр (Тэврие өдөр) Бэйтуллахыг таваф хийсний дараа тэмээгээ унав. Минад очоод үдийн, оройн, үдшийн, хэвтүүлийн ба өглөөний мөргөлөө тэнд үйлдэв. Нар мандтал хүлээв. Зилхижжэ сарын есөнд өглөөгүүр Арафатын тийш хөдлөв. Минагаас Арафатад хүртлээ тэлбие авчрахаа үргэлжлүүлэв.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь иим байдлаараа үммэтдээ хэрхэн Хаж хийхийг өөрөө зааж хамаг үүргээ хэрэгжүүлсний дараа Арафатад, өнөөдөр Нэмирэ Мэсжид оршдог газарт тэмээн дээрээ, алдаршсан “Салах Хутба”гаа айлдав:

“Аяа хүмүүс ээ!

Үгийг минь анхааран сонсоорой! Мэдэхгүй, би магадгүй энэ жилээс хойш энд үүрд мөнх та нартай хамт байж болохгүй!

Аяа хүмүүс ээ!

Яг танай энэ өдрүүд ариун өдөр, энэ сарууд ариун сар, энэ хот (Макка) ариун хот буй шиг, танай амь, бараа, ариун нэр ч ижилхэн ариун юм; эднийг ямар ч байдлаар хүчирхийлэх нь харам юм.

Асхаб минь!

Та маргааш Рабдаа хүрээд өнөөдрийн үйлс ба байдлаа заавал хариуцна! Миний дараа хуучны төөрөг замд ороод нэг нэгийнхээ хүзүүг цавчихаас болгоомжил! Намайг урдуур яваад Нуурын дэргэд таныг хүлээж байхыг мэдээрэй! Бусад үммэтээс таны өнөр буйгаар би баясна. Нүгэл хийгээд нүүрийг минь улайлгахаас болгоомжил!

Асхаб минь!

Хүний хадгалсан бараа байвал түүнийг эзэнд нь буцааг! Мөнгөний хүүгийн төрөл бүрийг цуцалсан бай; миний хөл доор юм. Харин тавьсан өр төлөөсөө бүрэн бүтэн төлөх хэрэгтэй. Бүү харгисла, бусдын харгислалд бүү өрт! Аллахын тушаалаар мөнгө хүүлэхийг үүнээс хойш хориглож байна. Мунхагийн үеэс үдлсэн энэ муухай зангийн бүр төрөл нь миний хөл доор юм. Миний анх цуцалсан мөнгөний хүү бол Абдүлмутталибын хөвүүн (миний авга ах) Аббасын хүү юм.

Асхаб минь!

Мунхаг үед үргэлжлүүсэн цусан өшөө авалт ч бүр цуцалсан байдаг. Миний цуцалсан анхны цусан өшөө авалт бол (миний омог) Абдүлмутталибын ач (миний авга ахын хөвүүн) Рэбиагийн цусан өшөө юм.

Аяа хүмүүс ээ!

Өнөөдөр шэйтан таны үйлд дахиад нөлөөлөх ба ноёрхох хүчээ үүрд мөнх алдсан байгаа. Харин та миний энэ цуцалсан хэргээс гадны жижиг хэргүүдэд түүнийг дагавал, тэгсэн нь ч түүнийг хангана. Шашнаа хамгаалахаар эдгээрээс болгоомжилцгоо!

Аяа хүмүүс ээ!

Эмсийнхээ эрхийг хангаарай! Тэдэнд халамж ба хайраар хандаарай! Тэдний тухай Аллахаас айхыг тань зөвлөе. Та эмэгтэйчүүдийг Аллахын хадгаламж болгож авсан; тэдний ариун алдрыг Аллахын нэрээр ам өгөөд халал болгоцгоо! Та эмэгтэйчүүд дунд эрхтэй бөгөөд тэд ч таны дэргэд эрхтэй байдаг. Таны эмэгтэйчүүдийн эрх танай гэр бүлийн ариун нэрийг хэнд ч гишгүүлэхгүй нь юм. Эмэгтэйчүүдийн тэдний бүх төрлийн хүнс ба хувцсыг нь хангах нь юм. Нэгэн эмэгтэй

нөхрийнхөө зөвшөөрөлгүйгээр түүний бараагаас ямар ч юмыг бусдад өгсөн нь халал болохгүй!

Таны боолчуудыг дурдвал; тэдэнд идсэнээсээ идүүлж, өмссөнөөсөө өмсүүлэхийг анхаарч хичээгээрэй! Өршөөшгүй алдаа хийвэл тэдэнд зөвшөөрөл олгоорой! Харин тэднийг хэзээ ч бүү харгислаарай! Учир нь тэд ч Аллахын боол мөн.

Аяа итгэгчид ээ!

Миний үгсийг сайхан сонсоод сайхан тогтоогоорой! Мусульман нь мусульманы дүү юм; ингээд бүх мусульманчууд ахан-дүүс юм. Шашны дүүд тань харьяалсан ямар нэгэн эрхийг хүчирхийлэх нь халал биш юм. Тэд танд сэтгэлээрээ өгвөл чөлөөтэй аваарай...

Эрхгүйгээр битгий хандаарай! Эрхгүй байдалд ч битгий бөхийгөөрэй! Хүмүүсийн эрхийг битгий дээрэмдээрэй!

Асхаб минь!

Өөрсдөө ч битгий харгислаарай! Та өөрөө ч өөртөө эрхтэй юм.

Аяа хүмүүс ээ!

Алуурч бүр нь өөрийнхөө гэмийг хариуцна. Ямар ч алуурчийн хийсэн хэргийн ялыг түүний хүү хариуцаж болохгүй! Ямар хүүхдийн ялыг ч ааваас нь хариуцуулж болохгүй!

Аяа хүмүүс ээ!

Аугаа Эрх нь эрхийг эзэнд болгонд нь (Кур'анд) олгосон байдаг. Өвчнийг хамгаалах хэрэг үгүй.[349] *Хүүхэд хэний гудсанд төрсөн байвал түүнд л харъяалагдана. Зина хийгчийг*

349. Гэрээслэл нь өвийн аетаас өмнө фарз байв. Уг ает буусны дараа хамаг эрх тогтсон тулд одоо гэрээслэл нь фарз болохоос гарсан байдаг. Харин хүн, хүвсэл барааныхаа гуравны нэгийг давахгүй хэсэгт гэрээс хийж мэднэ.

гачигдуулна. Аавaасаа бусдад удам зохиосон удамгүй нь эсвэл эзнээсээ бусдын харъяанд ороход оролцсон ач санадаггүй боол нь[350] Аллахын тамлал болон мэлэк ба хамаг мусульманчуудын хараалтай учраг! Аугаа Эрх нь ийнхүү хүмүүсийн тавбаг ч эрх тэгш шийдвэр эсвэл гэрчилгээг ч хүлээн авдаг үгүй.

Аяа хүмүүс ээ!

Танай Раб нэг юм. Танай аав ч нэг юм; бүгдээрээ Адамын хүүхдүүд мөн. Адам бол шорооноос төрсөн юм. Аллахын онгонд танай хамгийн үнэт нь Түүнээс хамгийн их болгоомжлох такват тань мөн. Араб нь Араб бусаас -таквагийн хэмжээнээс гадна- ямар ч тал үгүй.

Аяа Хүмүүс ээ!

Байнга эргэж буй цаг хугацаа нь Аллахын тэнгэр газрыг туурвисан өдрийн байдалд харьсан байдаг. Нэг жил нь сарын хэмжээгээр арван хоёр сар юм. Эдгээрээс дөрөв нь харам сар юм. Эдгээрээс гурав нь дараалалтай Зилкадэ, Зилхижжэ ба Мухаррам, дөрөвдэх нь бол (Жэмазиелахир Шабан хоёрын дунд) Рэжэб юм. Энэ жил харам сарууд хэвийн байранд оров. Хажийн улирал Килхижжэгийн арванд таарав.

Аяа итгэгчид ээ!

Танд би нэгэн дурсамж хадгалж байна, түүнийг бат барьвал замаасаа төөрөхгүй. Тэр дурсамж нь Аллахын судар Кур'ан мөн.

Аяа хүмүүс ээ!

Аллахад залбиран үйлчлээрэй! Таван удаагийн мөргөлөө үйлдээрэй! Рамазан мацгаа бариад тушаалуудад анхаарал үзүүлээрэй! Ингэж л чадвал Раббынха диваажинд орох болно.

350. Боолчлолын тухай тайлбарыг Хар. х. 155-158

Аяа хүмүүс ээ!

Туйлшрахаас болгоомжил! Өмнөх үе, өвөг дээдэс мөхсөний учир нь шашиндаа туйлширсан байв. Хажийн үйлсийг буюу арга ба ёсыг нь надаас мэдэж аваарай! Мэдэхгүй, магадгүй энэ жилээс хойш тантай энд дахиад уулзаж чадахгүй! Энэ сургаалыг энд буй хүмүүс байгаагүй хүмүүст мэдүүлэг! Магадгүй мэдэгдсэн хүн нь миний үгсийг энд сонссоноос сайн ойлгож хадгална.”

Үгсийнхээ энэ хэсэгт Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- бум гаруй асахабаасаа асуув:

“–Аяа хүмүүс ээ! Маргааш танаас миний тухай асууна; юу гэх вэ?”

Асхаб-и кирам цөмөөрөө:

“–Аллахын номлолыг сургав; үүргээ хэрэгжүүлэв, бидэнд гэрээслэл ба сургаал айлдав гэж гэрчилнэ!” гэцгээв.

Энэ гэрчилгээний араас Оршигчдын Туяа Эзэн маань шашныг тэблиг хийх тухай:

“–Асхаб аа! Би тэблиг хийв үү?.. Тэблиг хийв үү?.. Тэблиг хийв үү?..” хэмээн гурван удаа баталгаа авав. Дараа нь хоёр гараа тэнгэр өөд дэлгэн Аугаа Эрхээс гэрчилгээг нь гуйв:

“Гэрчлээрэй аяа Раб!.. Гэрчлээрэй аяа Раб!.. Гэрчлээрэй аяа Раб!..” (Мүслим, Хаж, 147; Эбү Давуд, Мэнасик, 56; Ибн-и Мажэ, Мэнасик, 76, 84; Ахмад, V, 30; Ибн-и Хишам, IV, 275; Хамидуллах, *эл-Вэсаик,* х. 360)

Салах Хутба нь хүний харилцааг зохицуулах, шашны дүгнэлт, тойм бөгөөд мөн нэгэн “Хүний Эрхийн тунхаг” мөн. Жишээлбэл

1789 Францын том хувьсгалын бодлын суурь тавигсдаас нэгэн байсан гүн ухаант Ла Фает алдарт “Хүний Эрхийн тунхаг”ыг нийтлүүлэхээс өмнө хуулийн хамаг системүүдийг шинжилж, Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн Салах Хутбадаа зарласан хамаг хорвоог гийгүүлэх бамбар болохуйц эрх тэгш ба хүн чанарын эдгээр зарчмуудтай танилцуулсан болохоор:

“–Аяа цуут Мухаммед! Чи эрх тэгшид нэгэн оргилд хүрээд, хэн ч тэр төвшнийг давж чадахгүй!..” гэсэн байдаг.[351]

Орчлонгуудын Эзэн энэ хутбадаа хүмүүсийн мэдэх хэрэгтэй ба мэдээгүй тохиолдолд өршөөгдөхгүй дүрэм журмыг тайлбарласан байдаг. Тэнд цугласан өнөрийн ачаар энэ дүрэм журмыг хамаг хүн төрөлхтөнд зарласан байдаг.

Салах Хутбагийн дараа Билал-и Хабэший -радъяллахү анх- Эзан дуудав. Эзэн маань жэм хийх буюу нийлээд эхлээд үдийн мөргөлийн фарзыг, дараа нь дахиад гамэт дуулгаж оройн мөргөлийн фарзыг үйлдүүлэв. Мөргөлийн дараа тэмээ унаж Жэбэлү’р-Рахмэгийн ёроол дахь вакфа хийх газар хүрэв. Касвагийн цээжийг хад руу эргүүлэн киблад харав. Нар жаргаж шар өнгө нь алга болтол вакфа хийв.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- вакфад нэг гараараа тэмээнийхээ ногтыг бариад нөгөө гараа дэлгэж боолчлол ба зүрхний амьдралын мэдрэмжийг илэрхийлсэн уртхан нэгэн залбирал хийв. Уг залбирлын нэгэн хэсэг нь ийм л юм:

“Аяа Аллах минь! Чиний тушааснаар ба бидний хэлснээс давуу болоод Чамд хамд хийе! Аяа Аллах минь! Миний мөргөл, залбирал, амьдрал ба үхэл Чиний л төлөө юм! Чамд ирэх болно!

351. Хар. Камил Мирас, *Тэжрид-и Сарих Орчуулсан нь,* IX, 289.

Аяа Аллах минь! Булшийн тамлалаас, зүрхний хуурамчаас ажлын тааруу байснаас Чамд л хоргодъё! Аяа Аллах минь! Салхины авчирсан гамшигийн муухайнаас Чамд л хоргодъё!

Аяа Аллах минь! Нүдэнд минь нэгэн туяа, чихэнд чинь нэгэн туяа, зүрхэнд чинь нэгэн туяа туурви! Аяа Аллах минь! Цээжийг минь өргөтгөж өг! ажлыг минь хялбаршуул! Аяа Аллах минь! Эрүүл мэндийн өвчнөөр эргэснээс, гэнэтхэн дайрах Чиний тамлалаас ба хамаг хилэнгээс чинь Чамд л хоргодъё! Аяа Аллах минь! Намайг зөв замд хүргэ! Өнгөрснийг, ирээдүйг минь өршөө!

Аяа зэргийг дээшлүүлэгч, элбэгийг буулгагч, аяа тэнгэр газрыг туурвигч Аллах минь! Дуу чимээ янз янзын хэлээр хөөрч Чам өөд өгсөж байна, Чамаас гуйж байна! Миний хүсэл бол дэлхийн хүмүүс намайг мартах шалгалтын оронд Чи намайг санаарай!

Аяа Аллах минь! Чи миний үгийг сонсож, миний буй газрыг харж, надад ил далд юу байсан ч мэддэг! Миний үйлсийн аль нь ч Чамд нууц биш юм! Би аргагүй, ядуу, Чамаас тусламж ба итгэсж гуйж байна! Айгаад дутагдлаа илчилж байна! Нэгэн аргагүй нь Чамаас яаж гуйвал би ч тэрэн шиг гуйж байна! Дорой нүгэлт нь Чамд яаж залбирвал би ч тэрэн шиг залбирч байна! Чиний агуу онгонд хүзүүгээ бөхийлгөсөн, Чиний л төлөө нүднээс нь нулимс гоожсон, Чиний л төлөө хамаг эд хөрөнгөө зориулсан, Чиний л төлөө нүүрээ хөрсөнд түрхсэн боол чинь яаж залбирвал би ч тэрэн шиг залбирч байна! Аяа Раб минь! Залбирлыг минь хүлээж авалгүй намайг битгий үлдээ! Надад Рауф ба Рахим хандаарай, аяа гуйлт бүхний хамгийн буянт ба хамгийн өгөөмөр нь!” (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* V, 166-168; Хэйсэмий, III, 252; Ибн-и Кайям, II, 237)

Салихчуудынн тэргүүний Арафатад хийсэн залбирлын нэгэн хэсэг ч иймл байдаг:

“Илахий! Чиний өмнөөс өөрийгөө хэн магтаж чадах вэ? Илахий! Миний хэл гацсан, миний Чамд хүрэх ашигтай нэгэн үйл ч үгүй, найдвараас өөр аврагч үгүй! Илахий! Би мэднэ; надад дутагдлаасаа болж онгонд чинь орон ч үгүй, Чамаас уучлал гуйх царай ч үгүй! Харин Чи өгөгчдийн хамгийн өгөөмөр нь мөн! Илахий! Би энэрэлд чинь хүрэх зохимжтой биш бол, энэрэл чинь надад хүрч мэднэ! Учир нь, Чиний энэрэл бүхнийг бүслэх чинээ өргөн байдаг! Илахий! Миний дутагдал хэдий том байсан ч Чиний өршөөлийн дэргэд бага л харагдана! Чи тэднээс намайг өршөөгөөрэй, аяа өгөөмөр Аллах минь!

Раб минь! Чи зөвхөн дуулгавартай боолчуудаа өршөөх бол, нүгэлтнүүд нь очоод хэнд хоргодох вэ? Раб минь! Чи зөвхөн такватай боолчууддаа энэрэл үзүүлэх бол, гэмт хэрэгтэд хэнээс туламж гуйх вэ!

Би байнга Чиний хэрэгцээтэй! Чи бол хэзээ ч миний хэрэгцээт үгүй! Чи зөвхөн туурвигч буйгаараа намайг өршөөнө! Намайг энэ зогссон газраас минь хамаг хүслийг гүйцэтгэсэн, гуйлтыг хайрласан, ерөөлийг хэрэгжсэн буйгаар хариулаарай!

Аяа хүсэгчдийн хэрэгцээг ээлж ноёрхох Аллах минь! Аяа дуугаа байгчдын доторхыг мэддэг Аллах минь! Аяа тусламж хүлээх өөр Раб үгүй буй Аллах минь! Аяа дээр нь айх өөр туурвигч үгүй Аллах минь! Аяа хажууд очих сайд, авилга өгөх хаалгачин үгүй Аллах минь! Аяа хүсэл ихсэх тусам өгөөмөр хайрлал нь ихсэх; хэрэгцээ аривжих тусам бэлэг нь элбэгших Аллах минь! Аяа Аллах минь! Чи зочин бүрийн угтана! Бид ч Чиний зочид мөн! Биднийг диваажиндаа угтаарай!

Аяа Аллах минь! Хамт олон бүрт бэлэг, гуйгч бүрт хүссэнийг өгөөд зочин бүрийг дайлдаг зантай! Буян найдсан бүрт буян өгөх зан байдаг! Бид нар цөмөөрөө Чиний Бэйт-и Харамд чинь ирлээ! Энэ газар вакфад зогслоо! Энэ ариун газ-руудад бэлэн хүлээлээ! Бид агуу онгонд чинь буян ба шагналыг хүртэхийг найдна! Найдварыг минь битгий алдаарай Аллах минь!” (Газалий, *Ихяа,* I, 337-338; Бэйхакий, *Шуабу'л-Иман,* II, 25-26)

Хүндэт Нэбий -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Арафатад байсан хугацаанд хажууд нь Нэжид ардаас зарим хүмүүс ирээд:

“–Аяа Расулаллах! Хаж ямар байдаг, юугаар бүтдэг вэ?” гэж асууцгаав.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Хаж нь Арафат юм. Хэн нь Мүздэлифэгийн шөнө өглөөнйи мөргөлөөс өмнө Арафатад ирвэл, тэр Хажид амжсан байх болно. Минигийн өдрүүд нь гурав юм. Яараад тэнд хоёр хоносон хүнд нүгэл үгүй. Оройтсон хүнд ч нүгэл үгүй,” хэмээв. (Ибн-и Мажэ, Мэнасик, 57)

Өнөөдөр Таны Шашныг Төгс Төгөлдөр Болгосугай

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- вакфад байхад нар мандах болсонд буусан ает-и кэримэ шашин төгс төгөлдөр болсныг мэдээлэв:

اَلْيَوْمَ يَئِسَ الَّذِينَ كَفَرُواْ مِن دِينِكُمْ فَلاَ تَخْشَوْهُمْ
وَاخْشَوْنِ الْيَوْمَ أَكْمَلْتُ لَكُمْ دِينَكُمْ وَأَتْمَمْتُ
عَلَيْكُمْ نِعْمَتِي وَرَضِيتُ لَكُمُ الإِسْلاَمَ دِين

“…Өнөөдөр кафирчууд таны шашныг үгүй болгохоос найдвараа алдсан байдаг. Одоогоос тэднээс битгий ай; Надаас л ай! Өнөөдөр таны шашныг төгс төгөлдөр болгосугай; тан дээрх шимээ бүтээж танд шашин болгохоор Исламыг сонгосугай...” (эл-Маида, 3) (Тирмизий, Тэфсир, 5/3043)

Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх- нь уг ает-и кэримэг сонсонгуут өндөр мэдрэмжээрээ бүхнийг ойлгов. “Бүтээсэн шим”ийн утгыг гүнээр нь мэдрэв. “Шашин төгс төгөлдөр болсон”ы дараа ирэх юмыг мэдэрч эхлэв.

Энэ ает нь мэдрэмжийн хүмүүст нэг талаараа Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн харих мэдээлэл байв. Аллах -жэллэ жэлалүхү- нь их удахгүй Оршигчдын Туяаг, Хабиб буюу Хайрыгаа мөнхийн хорвоод урих байв. Эбү Бэкир -радъяллахү анх-ын нүд нулимсаар дүүрээд, арай хэн ч юу ч мэдрээгүй байхад тэр сэтгэлд нь унасан хагацлын гунигаас уйлж эхлэв.[352]

Учир нь хорин гурван жилд ирсэн ариун дурсамж нь киямат хүртэл ирэх үммэтэд энэрэл болохоор хүргэсэн болов.

Нар бүрэн жаргасны дараа Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам- сундлан Үсамэ бин Зэйд -радъяллахү анх-ыг авсан буйд Арафатаас Мүздэлифэ рүү хөдлөв. Тэнд хэвтүүлийн үед нэг эзан ба хоёр гамэтын хамт нийлээд эхлээд үдэш, араас нь ч хэвтүүлийн мөргөлийг үйлдүүлэв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- үүр цайтал Мүздэлифэд хүлээв. Өдөр сайхан гэгээртэл Мүздэлифэ дэх вакфагаас салаагүй. Энэ хооронд тэлбие ба залбирлаа үргэлжлүүлж байв.

352. Элмалылы, III, 1569.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Минад шидэх чулууг Мүздэлифэд цуглуулав. Нар мандахаас өмнө Мүздэлифэгээс салав. Асхабтаа жэмрэд[353] шидэх чулууг цуглуулахыг тушаав. Мөн жэмрэ буюу жижиг чулуунуудыг эрхий долоовор хоёр хурууны дунд чимхэн шидэхийг айлдав. Чулууг яаж шидэхийг ч гараар үзүүлэв.

Зовлон Шаналал Илэрсэн Газар

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- Салах Хаждаа Мина Мүздэлифэ хоёрын хоорон дахь Батн-и Мухассираас хурдлан гатлав. Сахабий нь гайхаад:

“–Аяа Аллахын Элч ээ! Юу болоод та хурдлаа вэ?” гэж асуув.

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Аугаа Эрх энэ газар уулан хараацай шувууг илгээж Эбрахагийн заант цэргийг мөхөөсөн байв. Тэр зовлонгоос нэгэн хувь бүү ирэг гэж хурдаллаа...” хэмээв. (Нэвэвий, *Шэрхү Мүслим,* XVIII, 111; Ибн-и Кайям, II, 255-256)

Тийм учраас хажид энэ газарт вакфа байдаггүй.

Энэрэл ба энэлэл илрэл нь заримдаа эргэн тойронд ч ойлгоно. Ийм учраас энэрэл илэрсэн Каба, мэсжидүүд, салих хүмүүсийн хурал мэтийн орнуудаас ашиглах хэрэгтэй. Үүний эсрэгээр нүгэл ба бослого гарсан бөгөөд зовлон илэрсэн газруудаас ч болгоомжлох хэрэгтэй.

---

353. **Жэмрэ**: Галын цог, оч, жижиг чулуу мэтийн утга агуулдаг. Энд бол Хажид жэмрэ хаядаг газар хэсэг утгатай байдаг. Энэ бол том жэмрэ, дунд жэмрэ ба жижиг жэмрэд, жижиг чулуунуудыг тодорхой үед тодорхой газарт ба тодорхой тоогоор шидэхийг илэрхийлнэ.

Эргэн тойрон ч сэтгэл татах хуулийг дагана. Жишээлбэл Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дээр нь хутба уншиж байсан хасарвааны дүнз нь уг туяат мэдрэмжээр дүүрсэн, Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг өөр газар хутба уншиж эхлэхлээр ч чин сэтгэлээрээ уйлж эхэлсэн байдаг.[354] Энэ байдлыг дамжуулсан хадис-и шарифууд таслалтгүй ирсэн байдаг.

Мэвлана Хазрат энэ тухай ингэж хэлнэ:

"Агаар, хөрс, ус ба гал, бүгд Аллахын боол бөгөөд Тэрээрийн үгийг дагана. Тэд чамд надад амьгүй, харин Аллахын онгонд амьд байдаг."

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Мухассир Хөндийг хурдан гаталсны дараа том жэмрэ буюу Акабагийн Жэмрэд очив. Акабагийн жэмрэг тахил барих өдөр нар мандсаны дараа шидэв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- жижиг чулуунуудыг хоёр хурууны дунд чимхэн нэг нэгээр хаяд байхад хүмүүс ч жэмрэ чулуудыг хаяад, өнөр байсан тул нэг нэгэн дээрээ овоолж эхэлсэн байцгаав. Пайгамбар Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"–Аяа хүмүүс ээ! Нэг нэгээ битгий алаарай! Та жэмрэ чулуугаа хаяхдаа жижгийг нь чимхэн шидээрэй!" хэмээв.[355] (Ахмад, VI, 379)

354. Бухарий, Мэнакиб, 25; Бүюү', 32.

355. Өнөөдөр чөтгөр чулуудах үүрэг нь харамсалтай нь ёсоор нь, залбиралын бишрэлт ба мэдрэмжийн гүнээр хэрэгжүүлдэггүй. Харин уг үйлчилгээг Ибрахим -алэйхиссэлам-ын чөтгөрийг чулуудсан үеийн мэдрэмжээр хийх хэрэгтэй.

Кудамэ бин Абдуллах нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тэр үеийн байдлыг ингэж ярина:

“Хүндэт Элч Эзнийг маань тэмээн дээрээс жэмрэг шидэж байхыг харлаа. Цохих ч, түрхэх ч, «цааш яв!» гэх ч байгаагүй!” (Ибн-и Мажэ, Мэнасик, 66)

Пайгамбар Эзэн маань -алэйхиссалатү вэссэлам- амьдарсан жил бүрт нэгэн тэмээгээр нийт жаран гурван тэмээг өөрийхөө гараараа тахил болгосны дараа хутгыг Хазрат-и Алид өгөөд, цуушийг нь ч тэр төхөөрөв. Аллахын Элч төхөөрсөн тэмээ бүрийн махнаас нэгэн хэсэг авахыг тушаав. Үүнийг нэгэн ваарт хийж чанав. Али -радъяллахү анх-тай хамт үүнээс идэцгээв. Дараа нь Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм- Хазрат-и Алид тэмээний бусад мах, арьс ба ширийг ядуучуудад тараахыг тушаав.

Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- тахилаа барьсны дараа үсчнээ дуудаад үсээ авахуулав.

“Эмэгтэйчүүд үсээ авахуулахгүй, үзүүрээс нь жоохон тайруулна!” хэмээж эмэгтэйчүүдийн толгойгоо халзлахыг хориглов. (Даримий, Мэнасик, 63)

Энэс бин Малик -радъяллахү анх- ингэж мэдээлнэ:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- чөтгөрийг чулуудахыг дуусгасны дараа тахилаа өргөөд үсээ авахуулав. Үсчин баруун гар талын үсийг нь бариад хусав. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эбү Талхаг дуудаж энэ үсийг түүнд өгөв. Дараа нь үсчин зүүн гар талын үсийг барив. Эзэн маань -саллаллахү алэйхи вэ сэллэм-*«Ав!»* гээд тэр ч хусав. Үүнийг ч Эбү Талхад өгөөд:

«–Үүнийг хүмүүст хуваaж тараа!» хэмээв.” (Мүслим, Хаж, 323-326; Бухарий, Вүдү, 33)

Пайгамбар Эзний маань духны үсийг хусахад Халид бин Вэлид:

"–Аяа Расулаллах! Духны үсээ надад өг! Энэ тухай бусдыг надаас өмнө битгий аваарай! Аав ээж минь Чамд золиос болоосой!" гэж гуйв.[356] Үсийг түүнд өгөхөд тэднийг нүдэндээ түрхэж малгайны өмнөх дотор хэсэгт хийв. Үүний ачаар дайнд алдаагүй хожсон билээ. Энэ тухай Халид -радъяллаху анх-:

"–Би түүнийг ямар чигт эргүүлсэн ч тэр газрыг эзлэв!" гэсэн байдаг.[357] (Вакидий, III, 1108; Ибн-и Эсир, *Усдү'л-Габэ,* II, 111)

---

356. Тэр хооронд Хазрат-и Эбү Бэкир нь Халид -радъяллаху анх-ын Ухуд, Хэндэк ба Хүдэйбиед хийсэн үйлсийг бодож, мөн тэр мөчин байдлыг нь хараад гайхаад байв. (Ибн-и Са'д, II, 174)

357. Аллахын Элчийн үс ба сахлаар тааралдах тухай амьд нэгэн жишээг Хикмэт Атан гуай ингэж ярина:
"1983 онд Оф сумын харъяа Али Южэл Гуайгаас үүнийг сонссон байлаа:
Сулуова Сумын Төв Мэсжидэд би имам хатибаар ажилладаг байв. Ойр хавийн хөдөөнөөс нэгэн имам гуай над дээр ирээд, «–Эрхэм ээ, надад нэг явдал тааралдсан, би утгыг нь ойлгоогүй,» гээд ингэж ярив:
«–Нэгэн өдөр надад имамаар ажиллаж байсан тосгоны ойрхон багаас зарим хүмүүс тэвэр дүүрэн ном авчраад:
"–Имам аа, танай аав нас барав. Түүний ном бидэнд үлдэв. Харин бид энэ номуудыг уншиж чадахгүй. Чи имам юм, энэ номуудаас зөвхөн чи ашиглаж чадна. Эдгээрийг чамд бэлэглэнэ," гэцгээв.
Номуудыг аваад тэднийг үдсэнийг дараа шатаж буй зуухны дэргэд номуудыг шинжилж эхлэв. Тэдний дотроос нас барсан имам гуайн захидал дугтуй мэт нь гарав. Хувийн захидал буй тул бүгдийг нь бариад зууханд хаялаа. Шуугиад шатаж байсан зуух нь гэнэтхэн "пасс" гэж унтарчхав. Би хэт айгаад гэрээсээ гадаа зугтав. Юуны дараа л айсан боловч гэртээ орж чадлаа.»
Би ч тэр имам гуайд:
«–Тэр дугтуйн дотор Хазрат-и Пайгамбарын сахал-и шариф байлаа,» гэв.
Хэсэг хугацааны дараа тэр имам гуайтай тааралдахдаа надад ингэж хэлэв:
«–Эрхэм ээ, тэр дугтуйн дотор сахал-и шариф байсныг хаанаас мэдээ вэ?
Номуудыг надад бэлэглэсэн хүмүүс дараа нь ирээд:

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Тахилын баярын анхны өдөр үдээс өмнө тэмээгээ унаж “Ифада Таваф”ыг хийхээр Бэйтуллахад очив. Тавафаа дуусгасны дараа үдийн мөргөлийг үйлдүүлэв. Дараа нь зэмзэмийн худагт очив. Тэр өдөр үдэш болоогүй байхад Минад харив. Тэшрик өдрүүдэд Минад хонов. Эдгээр шөнүүдэд ирээд Бэйтуллахыг ч заавал зочлов.

Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм- тахилын өдрийн арын нэг дэх, хоёр дахь тэшрикийн өдрүүдэд нар өрнөдийн тийш хандахад алхаж Мина мэсжидийн цаана анхны жэмрэд очив. Тэшрикийн адгийн өдөр гурав дахь жэмрэгээ шидэж үдээс хойш Мухассаб[358] руу хөдлөв. Мусульманчуудыг Мухассабаас тарахаар чигэлэхэд:

“–Сүүлийн очих газар Бэйуллах болохгүй бол, хаашаа ч битгий яваарай!” хэмээв. (Даримий, Мэнасик, 85) Зилхижжэгийн аравны өдөр өглөөний мөргөлийн өмнө Бэйтуллахыг тавафад очихоо зарлуулав. Бэйтуллахад очоод “Салах Таваф”аа хийв. Энэ хооронд нэгэн хүн ирээд Маккад хонох тухай асуув. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“–Макка нь хонох газар биш юм. Гаднаас ирсэн хүмүүсийн хаж мөргөлөө хийсний дараа Маккад хонох хугацаа нь гурван өдөр юм!” хэмээв. (Ахмад, IV, 339)

“–Эрхэм ээ, бид андуурчээ, аавын чинь номуудын дотуур дугтуйд сахал-и шариф байжээ. Түүнийг бидэнд өгнө үү?” гэцгээв.»”

358. Мухассаб нь Мина Макка хоёрын хооронд бөгөөд Минад Маккагаас илүү ойр газар юм. Курайшийн мүшрикчүүд күфүр дээр нэгдээд Пайгамбарын маань эсрэгээр хэрэгжүүлсэн бойкотын шийдвэрийг энд гаргасан байв. Аллахын Элч энд ирэхдээ тэд өдрүүдийг санасан байв. (Бухарий, Хаж, 45)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Харам-и Шарифыг хэтэрхий хүндэлдэг байв. юм идэх эсвэл бие засах болбол гадаа гараад хол нэгэн газар очдог байв. Залхах байдал үл төрөх эсвэл хүндлэхэд дутахгүй хэмээн тэнд ч их уддаггүй байв. Учир нь ямар нэгэн орон нутагт байж сэтгэлийн Бэйтуллахад уяатай байсан нь түүний дэргэд байж сэтгэлийн тэр ариун хавийг энгийн орон нутаг шиг харснаас, хүндлэхгүйгээр хандаж эх орноо санаснаас буянтай юм.

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ба мусульманчууд “Салах Таваф”ыг хийсний дараа Мадина-и Мүнэввэрэгийн тийш хөдлөв. (Бухарий, Хаж, 21, 70, 128; Мүслим, Хаж, 147; Ибн-и Мажэ, Мэнасик, 84)

Харин Аугаа Эрх шимээ бүтээж шашин ч төгс төгөлдөр болсон улмаас одоо хамгийн том хагацах ба учрах үе ирсэн байв.

ХИЖРЭТИЙН АРВАН ГУРАВ ДАХЬ ЖИЛ

Учрах ба Хагацал:
“РЭФИК-И А’ЛА” ӨӨД АУГАА ЗОРЧИЛ

Нэбийчүүдийн цувааны анхны ба сүүлийн чагт, Хоёр Туурвилын Эзэн, Хоёр Талын Элч, Хоёр Хотын Имам, Оршигчдын Туяа, Хорвоонуудын Энэрэл Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Салах Хажжийнхаа дараа халуурч эхлэв. Энэ өвчин нь Түүнийг үммэтээс нь салаад амьдралынхаа турш хүссэн Рэфик-и А’ла буюу хамгийн агуу андад нь учруулах хагацаах өвчин байв. Угаасаа “Наср Сура”г бууснаар хагацах цаг дөхсөнийг мэдсэн буй Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- одоо сүүлийн аяндаа бэлдэж байв. Өнгөрөгсөдтэй ч амьдуудтай ч тэмдгийн аргаар салалцаж байв. Жишээлбэл бие өвдөхөөс өмнөх өдөр Мадина дахь Жэннэтү’л-Бакий’ хэмээх оршуулах газар очоод тэдний төлөө:

“–Аяа агуу Аллах минь! Энд хэвтэгчдээс энэрлээ битгий харамла!” хэмээн залбирсан байв. (Ахмад, III, 489)

Оршуулгийн газраас харьсны дараа асхабтаа ч бараг салах үгээр тооцох энэ хутбаг хэлэв:

“Би танаас Кавсарын Шалбаагт анх хүрсэн нь болоод таныг тэнд угтаж авна! Тантай уулзах газар маань Шалбааг

юм. Би одоо түүнийг харж байна! Би таны төлөө гэрчилнэ! Одоохон надад газрын эрдэнэ сангийн түлхүүрийг гардуулж байна. Валлахи таныг миний дараа мүшрикийн замд харина гэж айхгүй! Харин би таныг дэлхийн хүслэнг автаж тийм учиртай нэг нэгээ мөхөөнө, нэг нэгээ ална, танаас өмнөхөн нь үгүй болоод очсон шиг та ч үгүй болоод одно гэж айна!..” (Бухарий, Жэнаиз, 73; Мүслим, Фэдаил, 31)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- индэрээс буусны дараа тамир нь тасарсан байдалтай Жаргалын Гэртээ оров. Өдөр тутам өвчин нь бүр хүндрэв. Бүр хүнд өвчтэй болохлоороо ч эелдэг зангийн төлөөлөгч Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ариун эхнэрүүдээсээ зөвшөөрөл аваад Хазрат-и Аишагийн өрөөнд хэвтэхээр шийдэв. (Бухарий, Тиб, 22; Ахмад, VI, 34, 38; Бэлазурий, I, 545)

Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- тэр цаг хүртэл ийм хүнд өвчин үзээгүй байв. Үнэндээ Түүний явуулсан цэвэр амьдрал өвчнийг дөхүүлдэггүй ижилгүй нэгэн амьдрал байв. Харин хорин гурван жил явсан ба хүний хүчнээс илүүг шаардсан хамгийн аугаа номлох үүрэг нь[359] Түүнийг нэлээд ядраасан, энэ хооронд бүр эхнээс нь янз янзын дайсны мянган олон муу муухай үйлс нь ч ариун биеийг нь туйлдуулсан байв.

359. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-д вахий ирэхэд ариун бие нь ихээр хүнд болдог байв. Жишээлбэл тэмээн дээр байхад нь тэмээ сөхөхөөс аргагүй болдог, босоо баймаар байвал хөл нь тахийж, бараг хугарах дөхдөг байв. (Ахмад, II, 176; VI, 445; Ибн-и Са’д, I, 197)
Зэйд бин Сабит -радъяллахү анх- хэлрүүн:
“Би нэгэн өдөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд байлаа. Хүн олон байсны улмаас, (бид нар сөхөрч суусан тул) өвдөг нь миний өвдөг дээр байв. Гэнэтхэн Тэр вахийн байдалд оров. Валлахи, Расулаллах -алэйхиссэлам-ын өвдгөөс хүнд юм би үзээгүй. Бараг миний өвдгийг бяцална гэж бодсон.” (Ахмад, V, 190-191)

Эдгээр бүхэн ч Түүнд өвчин тусахыг боломжтой болгосон байв.

Нөгөө талаас энэ өвчин нь Түүнийг том нэгэн орон болон агуу төвшинд учруулах байв. Үүнд Хайбар дахь хордуулах явдлын нөлөө ч том болов. Жишээлбэл Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- өвчний хүнд дарсан үед Хазрат-и Аиша эхэд маань:

"–Аяа Аиша! Хайбарт амссан хорт махны зовлонг байнга мэдэрсээр байлаа. Одоо зүрхнийхээ судас тасарсныг мэдэрч байна," хэмээсэн байв. (Бухарий, Мэгазий, 83)

Энэ тухай Энэс бин Малик -радъяллахү анх- ч:

"–Расулаллахын богино хэлэн дээр тус хорын мөр ба нөлөөг би харсаар байлаа!.." гэсэн байдаг. (Мүслим, Салам, 45)

Оршигчдын Туяа -саллаллахү алэйхи вэ сэллэм- энэ хоро-ос болж шэхид болоод таалал төгссөн, Түүнийг номлогчоор хүндэлсэн Аллах Таала нь Түүнийг бас шэхид болгож дээшлүүлсэн байдаг. (Ибн-и Хишам, III, 390; Вакидий, II, 678-679; Хэйсэмий, VI, 153)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- өртсөн хижгийн халуунаас болж халууран хөлөрчээ. Зочлохоор ирсэн Эбү Саид эл-Худрий:

"–Аяа Аллахын Элч ээ! Таны хижиг ямар их хүнд өвдсөн юм бэ!" гэхээс аргагүй болсон байв. Эбү Саид -радъяллахү анхүгээ ингэж үргэлжлүүлнэ:

"Гараа Түүн дээр тавилаа; халууныг нь дэвсгэр дээрээс нь мэдэрч чаддаг байлаа.

«–Аяа Аллахын Элч ээ, та маш их халуунтай байна!» гэлээ.

«–Бид (пайгамбарчууд) ийм юм. Зовлон нь бидэнд олон давхарт хүрнэ, үүний хариугаар шагнал нь олон давхар олгоно,» хэмээв.

«–Аяа Аллахын Элч ээ! Хүмүүсийн хамгийн их осолд автсан нь хэн бэ?» гэж асуулаа.

«–Пайгамбарчууд!» хэмээв.

«–Дараа нь хэн бэ?» гэлээ.

«–Дараа нь салихчууд!» хэмээж ингэж тайлбарлав:

«Тэд үнэхээр хоосон ядуу, өөртөө дэвсэх ганц аба буюу дээлээс өөр юм олж чадахгүй. Тэд таны элбэгт баяссан шигээ зовлонд баясана.»” (Ибн-и Мажэ, Фитэн, 23)

Сүүлийн өдрүүддээ өвчин нь чуулганд гарах боломж олгоогүй. Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх-ыг өөрийнхөө оронд имам болохоор томилов. Нэгэнд өөрийгөө жаахан сайн мэдэрч мэсжидэд гарсан байв. Асхаб-и кирамд сургаал яриад:

“Агуу нэртэй Аллах нэгэн боолоо дэлхий болон түүний чимэг ба өөрийнх онгон дахь шим хоёрын хооронд чөлөөт орхив. Тэр боол ч Аллахын онгон дахь шимийг сонгов!..” хэмээв.

Үүнийг сонсонгоо уяхан сэтгэлт Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх- Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн тэдэнд салах үгээ хэлснийг мэдрэв. Том гунихран гашуудав. Сэтгэл нь сэмэрч нүднээс нь нулимс гоожиж эхлэв. Цурхираад:

“–Аав ээж минь Чамд золиос болоосой, аяа Расулаллах! Чамд аавууд, ээжүүдээ, амиудаа, эд хөрөнгөө ба хүүхдүүдээ золиос болгоё!..” гэв. (Ахмад, III, 91)

Хамт олны дунд түүнээс өөр хэн ч Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн гүн мэдрэмжийг ухаарч, энэ нарийн учрыг мэдэрч чадаагүй байв. Учир нь ает-и кэримэд дурдсан, Сэвр дэх “хоёрын хоёр дах нь” зөвхөн Эбү Бэкир -радъяллахү анх- байв.

Үгээр дамжуулснаар Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- түүний тухай:

“Зүрхэндээ байсан бүх юмд Эбү Бэкирийг ятгалаа!” хэмэ-эсэн байдаг.[360]

Сахабий нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн энэ хүндэт андын уйлсныг харангаа ихээр гайхан нэг нэгэндээ:

“–Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Рабдаа учрахыг сонгосон салих хүний тухай ярьж байхад энэ хөгшин уйлсанд гайхах юү байхав?!.” гэцгээв. (Бухарий, Салат, 80)

Гэтэл Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх-ын уяхан сэтгэл нь том хагацлыг мэдэрсэн ба хагацлын гомдлоо илэрхийлсэн хуур шиг уйлж эхэлсэн байв. Харин Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн өвчин ихээр чухал байдалд орохлоор, бусад асхаб ч дөхсөн том хагацал нулимс гоожуулж эхлэв. Мухажир ба Энсарын цуглаанууд гашуудлаар бүрдэв. Эргэн тойрныхон нь:

“–Аяа Расулаллах! Анагаахын төлөө Аллахад залбираа-рай!” гэхлээр, байнга эрүүл мэндийн төлөө залбирсан Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- энэ удаа залбираагүй.

360. Хар. Ажлуний, *Кэшфу’л-Хафа,* б. 2, х. 419.

Хазрат-и Аиша -радъяллахү анха- ингэж ярина:

“Расулаллах -алэйхиссалатү вэссэлам-ыг өвдсөндөө Муавизэтэйн (Фэлак ба Нас) сурануудыг уншиж гараа үлээж биедээ түрхдэг байв. Өвчин нь ширүүдсэн нэг удаа би ч тэр сурануудыг уншиж гартаа үлээж Түүний ариун биед түрхэж эхэллээ. Жэбраилын Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д өмнөх нэгэн өвчинд уншсан истиаза залбирлыг ч:

«–Аяа хүмүүсийн Раб! Энэ өвчнийг арилга! Анагаах зөвхөн Чиний л гарт байдаг. Чамаас өөр анагаах олгогч үгүй. Надад нэгэн анагаах олгож, ямар ч өвчин битгий үлдэг!» гээд уншлаа. Харин тэгэхлээр минь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Гараа над дээрээс өргө! Энэ уншлага чинь надад ашиг олгохгүй! Би хугацаагаа хүлээж байна...» хэмээв.” (Ахмад, VI, 260-261; Ибн-и Са’д, II, 210)

Хазрат-и Аиша эх маань үргэлжлүүлэн ингэж хэлнэ:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-, хүндэт охин, гүн уяхан сэтгэлт Фатимаг дуудуулав. Түүнийг ирэхлээр *«Сайн уу, миний охин!»* хэмээж түүнийг хажуудаа суулгасны дараа чихэнд нь юм шивнэв. Фатима уйлав. Дараа нь түүнд дахиад юм шивнэв. Энэ удаа Фатима баясч мишээв.

Би инээхийг уйлах, баясахын гунихад ийм ойр байсныг тэр өдрийнх шиг хэзээ ч хараагүй байв. Фатимад энэ уйлах ба мишээхийн учрыг асуувал:

«–Автсан өвчнөөсөө болж өөд болохоо мэдээлэв. Үүнд би уйлав. Дараа дахин анх учрах нь би болохыг мэдээлэв. Үүнд баяслаа,» гэв.” (Бухарий, Мэгазий, 83)

Өвчний хугацаанд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- хөнгөн мэдрэхдээ чуулганд хэдхэн удаа мөргөл үйлдүүлж

чадав. Эдгээрээс нэгэнд, сэтгэл нь пайгамбар нь харих болсонд том гуниг бүрсэн Асхаб-и кирамд ингэж айлдав:

“Аяа хүмүүс ээ!

Миний сонссоноор та нар пайгамбарынх тань нас барахаас айж гэнэ! Надаас өмнө илгээгдэж үммэтийнхээ дотор байнга үлдсэн нэгэн пайгамбар бий юү, тэгээд би ч таны дунд байнга үлдэх вэ? Намайг Рабдаа хүрэхийг сайхан мэдэж аваарай! Тэрээрт та нар ч хүрцгээнэ! Андашгүй нь хамаг үйлс агуу Аллахын зөвшөөрснөөр хэрэгжинэ.

Намайг танаас өмнө яваад таныг хүлээж байхыг сайн мэдээрэй! Үүнд анхаарцгаа; (маргааш ахиратад) тантай учрах газар маань, Кавсар Шалбаагийн дээр юм. Маргааш надтай уулзмаар буй нь гар болон хэлээ нүглээс татаг! Аяа хүмүүс ээ! Нүгэл шимийн өөрлөхөд учир болно. Ард нь сайн байхад тэдний удирдагчид ч сайн болно. Ард нь муу байхад бол удирдагчид нь ч муу болно. Биеийг минь хүчит гараараа барьсан Аллахад тангараг өргөе, би энэ цагт галбааг дээрээ зогсч, энэ буй газраасаа Галбаагаа харж байна...”

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- үгийн энэ хэсэгт цурхиран уйлсан Эбү Бэкир -радъяллахү анх- руу хараад:

“–Аяа Эбү Бэкир ээ! Битгий уйл!..” хэмээж үргэлжлэв:

“Аяа хүмүүс ээ! Хүмүүсээс амиараа, бараагаараа, найрамдлаараа надад Эбү Бэкирээс өгөөмөр хандсан хэн ч үгүй! Хэрэв Раббаасаа гадна хүмүүсээс андтай болсонсон бол, андашгүй нь Эбү Бэкирийг андаа болох байлаа...

Мэсжидэд нээсэн энэ хаалгуудыг хаагаарай! Зөвхөн Эбү Бэкирийн хаалга нээлттэй байг! Би Эбү Бэкирийн хаалган дээр нэгэн туяа харж байна.” (Бухарий, Салат, 80; Ибн-и Са’д, II, 227)

“Асхаб минь!

Эцэст нь би ч нэгэн хүн юм. Таны дунд зарим хүмүүсийн эрх надад туссан магадгүй. Би хэний арьсанд түрхсэн байвал, энэ нь миний арьс! Ирээд тэр ч түрхэг, эрхээ аваг! Хэний сээрт цохисон байвал, энэ нь миний сээр! Ирээд цохиг! Хэний бараанаас андуураад авсан байвал, энэ нь миний бараа! Тэр ч ирээд аваг!

Аяа Аллах минь! Би зөвхөн нэгэн хүн л юм. Мусульманчуудаас хэн нэгэнд хүнд үг хэлсэн, эсвэл цохисон, эсвэл хараасан бол, Чи үүнийг түүний төлөө цэвэрлэгээ, буян ба энэрлийн учир болгоорой!” (Ахмад, III, 400)

“Аллах минь! Хэн нэгэн итгэгчид би хүнд үг хэлсэн бол, Чи тэр үгийг минь Киямат өдөрт тэр итгэгчийн хувьд Чамд ойр болох учир болгоорой!” (Бухарий, Дэават, 34; Даримий, Мукаддима, 14; Ибн-и Са’д, II, 255; Табэрий, Тарих, III, 191; Халэбий, 463-464)

Ингээд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэг талаар үзвэл “эрхийг буцаах” халал авах үйл хэрэгжиж байв. Эдгээрийг хэлсний дараа ядарсан буйгаар дахиад өрөөндөө харив. Дахиад мөргөлд гарч чадаагүй. Зөвхөн нэг удаа өөрийгөө жаахан хөнгөн мэдэрч Хазрат-и Эбү Бэкирийн ард мөргөл үйлдэв.

Эцэст нь сүүлийн удаа Рубиулэввэлийн 12ны Даваа гаригийн өглөө дахиад өөртөө нэгэн хөнгөн мэдэрсэн байв. Харин бие тэнхээ нь чуулганд гарахаар хүрээгүй. Тэгээд өрөөний үүдийг өргөж тэр хооронд Хазрат-и Эбү Бэкирийн имам болсноор өглөөний мөргөлийг үйлдэж буй хайрт асхабаа сүүлийн удаа үзэв. Тэднийг эгнээд орсон хамтдаа мөргөл үйлдэж байхад харахад сэтгэл ханаад жаргалтай мишээв. Нэг талаас ширүүн өвчнөөрөө зовж байхдаа нөгөө талаас салихчуудаас бүрдсэн

чуулгаа орхиж Аллахын олгосон үүргээ гүйцэтгэсний жаргалыг мэдэрч байв. (Бухарий, Мэгазий 83, Эзан 46, 94; Мүслим, Салат 98; Нэсаи, Жэнаиз 7)

Үүнийг ярьсан Хазрат-и Аиша эх маань ингэж хэлнэ:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- асхабынхаа мөргөл үйлдсэнийг мишээж үзэж байв. Аллахын Элчийг хэзээ ч ийм баяр хөөртэй хараагүй байсан.” (Ибн-и Хишам, IV, 331)

Аллах Таала өмнөх пайгамбарчуудаа өгөөгүй том нэгэн шимийг Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-д хайрлав. Аллахын Элч таалал төгсөхөөс өмнө тэблиг үүргийнхээ амжилтыг гэрчлэв. Арабын Хойгийг ширкээс ариутгав. Баримлуудыг өөрөө тэдэнд шүтэгсэд нь үгүй болгов. Охидоо амьдаар хөрсөнд булж байсан хүмүүс энэрлийн оргилоор эргэв. Учир нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- хүний боловсролын оргил болсон ба хүнийг туурвилын гайхамшиг болгох хамгийн том хүмүүжлүүлэгч байв.

Тэр өглөө Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- өмнө бэлдсэн харин өвдсөнөөс нь болж хөдлөхөд оройтсон цэрэгт замд гарахыг тушаав. Томилсон залуу дарга Үсамэ бин Зэйдэд:

“Аллахын элбэгээр замдаа өглөөгүүр гарцгаа!” хэмээн сургав. (Вакидий, III, 1120)

Тэр өдөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Аиша -радъяллахү анха-д байсан зургаа-долоон динар мөнгийг ядуучуудад тараахыг тушаав. Удахгүй ч динар яасныг асуув. Хазрат-и Аишагийн өвчний сандралаар тэднийг тараахыг мартсаныг мэдэхлээрээ тэднийг нэхэж атгандаа авав. Дараа нь:

“Аллахын Пайгамбар Мухаммед эдгээрийг ядуучуудад тараагаагүй, хажуудаа байлгасан буйдаа Рабдаа учрахыг

зохимжтой үзэх биш юм!..” хэмээсний дараа бүхнийг Энсараас ядуу таван айлд тарааж:

“Одоо л санаа амарлаа!..” хэмээж хөнгөн нэгэн нойрт автав.[361] (Ахмад, VI, 104; Ибн-и Са’д, II, 237-238)

Энэ нь огт дуусашгүй хандив тараах үйл...

Тэр өдөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эхл-и Бэйтдээ ингэж хандав:

“Аяа хүмүүс ээ! Гал дөллөв. (Анхаар), харанхуй шөнөд цэргийн ангиуд шиг фитнэ ирнэ!.. (Ирээдүйн явдлуудыг нүдээрээ харсан юм шиг байв.) Би зөвхөн Аллахын Судар буй Кур’аны л халал зарласныг халал, түүний харам зарласныг харам болголоо!

Аяа Расулаллах Мухаммедын охин Фатима! Аяа Сафийя! Аллахын онгонд үнэ цэнэт үйлс хийгээрэй! (Салих үйл үгүй бол надад битгий итгээрэй.) Учир нь би (боолчлолоо хийгээгүй тохиолдолд) таныг Аллахын тамлалаас аварч чадахгүй!” (Ибн-и Са’д, II, 256; Бухарий, Мэнакиб, 13-14; Мүслим, Иман, 348-353)

Тэр өдөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“Анхаар! Мөргөлдөө! Мөргөлөө үргэлжлүүлээрэй! Болгоомжил! Гар доорх хүмүүст сайнаар хандаарай! Тэдний тухай Аллахаас айцгаа! (Тэдний хувцсыг битгий мартаарай! Ходоодыг нь цатгаарай! Тэдэнд зөөлөн үг хэлээрэй!)” хэмээв. (Эбү Давуд, Эдэб, 123-124/5156; Ибн-и Мажэ, Васаяа, 1)

---

361. Ийм учиртай Имам Касталланий ингэж хэлнэ:
“Хорвоогийн Раб буй Аллах Таалагийн Хабиб, пайгамбарчуудын хамгийн агуу, өнгөрсөн ба ирэх хамаг дутагдал нь өршөөсөн буй Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж бодвол, дээрээ мусульманчуудын цус ба өөртөө харам бараа авсан байхдаа Аллахад хүрэгчдийн байдал яаж болохыг нэг бод!” (Касталланий, II, 480-481)

Тэр өдөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- дуртай мисвак хэрэглэж шүдээ сойздов.

Хазрат-и Аиша эх маань ингэж хэлнэ:

“Расулаллахыг шүдээ мисвактаж байхад, өмнө нь Түүний ийм сайхан мисвак хэрэглэснийг хараагүй юм шиг байлаа!” (Бухарий, Мэгазий, 83; Ибн-и Са’д, II, 261)

Мөн Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэргэд жижиг нэгэн усны сав байлаа. Орчлонгийн Хүндэт Эзэн маань заримдаа гараа энэ саванд дүрж нүүрээ шавшаад:

“Ла илахэ иллаллах, андашгүй нь ухэл ухааныг арилгадаг ширүүн даралттай байдаг!” хэмээж байв. (Бухарий, Мэгазий, 83)

Тэр өдөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Аугаа Эрхэд ингэж ерөөв:

“Аяа Аллах минь! Намайг энэрэлтэйгээ бүсэл! Намайг Рэфик-и А’лад хүргэ! Аяа Аллах минь! Намайг энэрэлтэйгээ бүсэл! Надад энэрлээ хайрла! Намайг Рэфик-и А’лад хүргэ!” (Бухарий, Мэгазий, 83; Ахмад, VI, 126)

Тэр өдөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- охин Хазрат-и Фатимагаа тайтгаруулав:

“–Миний охин! Битгий уйл! Намайг өнгөрсний дараа:

اِنَّا لِلّٰهِ وَاِنَّا اِلَيْهِ رَاجِعُونَ” (Ибн-и Са’д, II, 312)

Тэр өдөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Ухудын хамгийн бухимдалт үед “Расулаллах өөд болов” гэсэн мэдээний дараа тарах дөхсөн асхабт сануулгын утгаар буусан энэ ает-и кэримэг уншив:

وَمَا مُحَمَّدٌ إِلاَّ رَسُولٌ قَدْ خَلَتْ مِن قَبْلِهِ الرُّسُلُ أَفَإِن
مَّاتَ أَوْ قُتِلَ انقَلَبْتُمْ عَلَى أَعْقَابِكُمْ وَمَن يَنقَلِبْ عَلَى
عَقِبَيْهِ فَلَن يَضُرَّ اللّهَ شَيْئًا وَسَيَجْزِي اللّهُ الشَّاكِرِينَ

“Мухаммед нэгэн Элч мөн. Түүний өмнө ч олон элч нар ирээд өнгөрөв. Одоо Тэр үхвэл эсвэл алагдвал, өсгий дээрээ хойшоо эргэх нь уу? Хэн ч ийм хоёр өсгий дээрээ хойшоо эргэвэл, мэдээж Аллахад аюул хүргэсэн болохгүй. Аллах талархаж тэсэгчдэд шагнал олгох болно.” (Ал-и Имран, 144)

Тэр өдөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д вахийн мэлэк Жэбраил -алэйхиссэлам- ирээд:

“Чамд мэнд хүргэе аяа Аллахын Элч ээ! Энэ нь чиний төлөө миний дэлхийд сүүлийн удаа хөл гишгэсэн минь юм!” гэв. (Ибн-и Са’д, II, 259)

Тэр өдөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- өмнө нь айлдсан:

“Хэн нэгэн пайгамбарын сүнсийг, диваажин дахь зогсоолыг нь харахгүйгээр авдаггүй! Дараа нь зогсоолдоо очих эсэхдээ өөрөө л шийднэ!” үгсийнхээ илэрснийг амьдрав. (Бухарий, Мэгазий, 83, 84; Ахмад, VI, 89)

Тэр өдөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-д Азраил -алэйхиссэлам- ирээд хажууд орохоор зөвшөөрөл эрэв. Зөвшөөрөл олгосны дараа Орчлонгуудын Эзний өмнө зогсоод:

“–Аяа Расулаллах! Аяа Ахмад! Агуу Аллах намайг Чамд илгээв. Чиний тушаал бүрийг дагахыг ч тушаав. Хэрэв Чи

хүсвэл амийг чинь авна! Хүсэхгүй бол амийг чинь Чамд л үлдээнэ!" гэв.

Тэр хооронд тэдний дэргэд байсан Жэбраил -алэйхиссэлам- ч:

"–Аяа Аллахын Элч ээ! Агуу Аллах Чамайг үгүйлж байдаг!" гэв.

Тэр өдөр Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэмөөрөөс нь зөвшөөрөл асуусан үхлийг мэлэкэд:

"–(Аяа Азраил!) Аллахын онгонд байсан нь илүү буянтай ба үргэлж байдаг! Аяа үхлийн мэлэк ээ! За, одоо тушаалаа хэрэгжүүлээд амийг минь ав!" хэмээв. (Ибн-и Са'д, II, 259; Хэйсэмий, IX, 34-35; Бэлазурий, I, 565)

Дараа нь ариун гараа хажуудах усны саванд дүрж нороод нүүрэндээ түрхээд тэнгэрлэг санаагаар дүүрэн амьдралынхаа учрах үүдийг нэвтрэхэд кэлимэ-и тэвхидийг дуулан:

"Аяа Аллах минь! Рэфик-и А'ла, Рэфик-и А'ла" гээд ариун амиа буулгаж өгөв. Нүүрээ норгосон ариун гар нь хажуугийн усан саванд унав!.. (Бухарий, Мэгазий, 83)

Олон жилийн өмнө буусан:

إِنَّكَ مَيِّتٌ وَإِنَّهُم مَّيِّتُونَ

"Аяа Элч минь ээ! **Чи ч үхнэ, тэд ч үхнэ!"** (эз-Зүмэр, 30) ает-и кэримэ нь илрэв.

Аяа Аллах минь! Манай Эзэн Мухаммед Мустафа -саллаллахү алэйхи вэ сэллэм-д, гэр бүл болон асхабт нь салат хайрла; бүгдийг нь ариун болгож тэдэнд мэнд хайрла!.. Мөн энэ нь байнгын салат ба мэнд болоосой!..

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эзнийг маань шариф амиа буулгаж өгсний дараа гэр бүлийнхэн нулимсны үерт автав. Тэр хооронд хэнийг ч хараагүй байсан ч тэднийг тайтгаруулсан дуу дуулав:

“Аллахын мэнд энэрэл ба элбэг танай дээр болог!”

Эхл-и Бэйт ч тэр чигээр хариулсны дараа тэр дуу дахиад дуулав:

كُلُّ نَفْسٍ ذَآئِقَةُ الْمَوْتِ وَإِنَّمَا تُوَفَّوْنَ أُجُورَكُمْ يَوْمَ الْقِيَامَةِ
فَمَن زُحْزِحَ عَنِ النَّارِ وَأُدْخِلَ الْجَنَّةَ فَقَدْ فَازَ
وَما الْحَيَاةُ الدُّنْيَا إِلاَّ مَتَاعُ الْغُرُورِ

“Амь бүр нь үхлийг амсах болно. Киямат өдөрт таны буяныг дутуугүй танд гардуулна. Хэнийг галаас холдуулаад диваажинд оруулсан бол тэр нь хүссэндээ хүрсэн байдаг. Дэлхийн амьдрал нь хуурамч бараанаас өөр зүйл биш юм.” (Ал-и Имран, 185)

“Төвөг бүрийн Аллахын онгонд нэгэн тайтгаруулга, үхсэн бүрийн нэгэн залгамжлагч ба өнгөрсөн бүрийн нэгэн үнэ цэнэ буйг сайн мэдээрэй! Аллахыг бат бариад найдсан юмаа Тэрээрээс найдаарай! Жинхэнэ төвөгт учирсан нь буянаас дутуу үлдсэн нь юм. Аллахын мэнд, энэрэл ба элбэг нь тан дээр болог!” (Ибн-и Са’д, II, 259)

Ибн-и Умар -радъяллахү анхүмаа-:

“Энэ үгсийг Эхл-и Бэйт, Мэсжид-и Нэбэвийд суугчид ба зам дах хүмүүс бүгдээрээ сонслоо,” гэв. (Бэлазурий, I, 564)

Хазрат-и Али -радъяллахү анх- ч энэ дууны хоолойг Хизир -алэйхиссэлам- буйг мэдээлсэн байдаг. (Ибн-и Са'д, II, 260)

Диваажингийн хатдын эзэн Фатима эх маань ариун аав Энэрлийн Пайгамбарын түр зуурын хагацлаас ихээр гуньж:

"Орчлонгийн Хүндэтийн укбагийн хорвоог хүндэлсний дараа над дээр зарим төвөг асгарч, эдгээр төвгүүд өдрүүд дээр асгарсансан бол тэр туяат өдрүүд хав хар шөнө болох байв," гэв. (Диярбэкрий, II, 173)

Фатима эхийн маань Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дараа амьдарсан зургаан сарын хугацаанд нэгэн удаа инээсэн нь харагдаагүй. (Камил Мирас, *Тэжрид Орчуулсан нь,* XI, 25-26)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн Мадинад эргэсний дараа арван гурван хоног үргэлжилсэн ширүүн өвчний дүнгээр Билгийн тооллын 632 оны 6 сарын 8 өдөр буюу Хижрэтийн тооллын 11-р оны Рабиулэввэл сарын 12ны Даваа гаригт өөрт нь гоо сайхны хязгаар нээгдсэн, Тэр агуу Хабиб нь Рэфик-и А'ла буюу хамгийн агуу анд буй Аллах Таалад хүрсэн байв.

Асхаб-и кирам нь мандаж жаргасан нарны огт өөрчлөгдөхгүй гэрэлд нууц нэгэн юм амьсгалж байсныг мэдэрч байцгаав. Тэгээд тэр өдрөөс хойш Пайгамбарын мүэззин асан Билал-и Хабэший -радъяллахү анх- тэнгэрийг дүүргэх сайхан хоолой-гоороо дахиад эзан дуулаагүй. Хэзээ ч асхаб нь ихээр алба-даж Хазрат-и Билал эзан дуудахаар зорилт хийсэн ч, михрабт Аллахын Элчийг хараагүйдээ цурхиран уйлснаасаа багалзуур нь тээглээд дахиад эзан дуудаж чадаагүй. Дотрыг нь хуурсан хайрын галыг унтрааж чадахаар Мадинагаас холдож Дамаскад

очив. Нэгэн өдөр зүүдэндээ Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг харав. Пайгамбар Эзэн маань:

"–Энэ хагацал нь юу вэ еэ Билал! Над дээр ирэх цаг чинь арай л бологүй юм уу?" гэж зэмлэв. Тэгэхлээр нь Билал -радъяллахү анх- гуниглаж сэрээд шууд замдаа гарав. Хорвоонуудын Эзний Шариф Булш дээр очихоор Мадинад ирэв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн онгонд уйлж нүүрээ булшид нь хүргэж байхад нь Хазрат-и Хасан Хазрат-и Хүсэйн хоёр ирцгээв. Билал -радъяллахү анх- тэднийг элгэндээ тэврээд үнсэж эхлэв. Тэдний:

"–Билал аа! Чиний эзаныг сонсохыг маш их хүсч байна!" гээд албадсанд эзан уншиж эхлэв. тэр мөчид Мадина нь найгав. "Эшхэдү эннэ Мухаммедэ'р-Расулаллах" гэхэд нь эр-эм бүх хүмүүс Аллахын Элчийг сэрсэн гэж бодож Мэсжид-и Нэбэвийгийн замд оров. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн таала төгссөний дараа Мадинад хүмүүсийн ийм их уйлсан нь харагдаагүй байв. (Ибн-и Эсир, *Усдү'л-Габэ,* I, 244-245; Зэхэбий, *Сиер,* I, 357-358)

Энэс бин Малик -радъяллахү анх- ингэж хэлнэ:

"Би хэзээ ч Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эбү Бэкир хоёрын Мадинад ирснээс туяат сайхан өдөр хараагүй! Расулаллах -алэйхиссалатү вэссэлам-ын таалал төгссөн өдрийг ч харлаа! Тэр өдрөөс харанхуй, буянгүй, сэтгэл дурламгүй өдөр хараагүй! Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн Мадинад орсон өдөр Мадинагийн бүх юм гийгүүлсэн, таалал төгссөн өдөр ч Мадинагийн бүх юм харанхуй болсон байв! Түүний хүндэт бие нь таалал төгссөнд нь итгэлгүй, дургүйгээр оршуулцгаав." (Ахмад, III, 221, 268, 287; Тирмизий, Мэнакиб, 1/3618; Даримий, Мукаддима, 14)

Үүний дараах төвгүүд мусульманчуудын хувьд одоо юу ч биш байдаг. Жишээлбэл Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

"Ямар нэгэн төвөгтэй тааралдсан мусульманчууд, намайг нас барснаар тэдэнд таарсан төвгийг бодож өөрсдийгөө тайтгаруулж тэвчицгээг," хэмээсэн байдаг. (*Муватта*, Жэнаиз, 41; Даримий, Мукаддима, 14)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- ингэж айлдсан байдаг:

"Миний эрүүл мэнд таны төлөө нэгэн буян юм: Та надтай ярина; би ч тантай ярина! Миний нас барсан ч таны хувьд буян юм: Таны үйлсийг надад өргөнө, буянт үйлсийг тань харвал тэднээс болж Аллахад хамд хийнэ; муухай үйлсийг тань харвал тэднээс болж таны төлөө Аллахаас өршөөл гуйна," хэмээсэн байдаг. (Хэйсэмий, IX, 24)

Хазрат-и Аиша -радъяллахү анха-гийн дамжуулснаар Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн сүүлийн мөч нь зөвхөн тэсбих, тавба ба хамдын байдалтай байв. Олон удаа:

"Сүбханаллахи вэ би-хамдихий, эстагфируллахэ вэ этүүбү илэйх: Би Аллахыг аугаа оронд нь зохихгүй тэмдгээс дээшлүүлж Тэрээрт хамд хийнэ. Аллахаас намайг өршөөхийг ерөөж нүгэлээсээ тавба хийнэ," хэмээгээд байв. (Бухарий, Эзан, 123, 139; Мүслим, Салат, 218-220; Ахмад, I, 392; Ибн-и Са'д, II, 192)

Түүний номлолтой холбоотой тэнгэрлэг нэгэн тэмдэг байлаа. Олон сахабий нь түүнийг үнсэх хайраар амьдардаг байв. Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эзнийг маань мөнхийн хорвоод нүүсэнд ариун царайнд нь ямар нэгэн

өөрчлөлт харагдаагүй тул, Асхаб-и кирам Түүний ахиратад шилжсэнээс сэжиглэв. Тэгэхлээр нь Эзний маань хамаатнаас Эсма бинт-и Үмэйс -радъяллахү анха- ардахь ариун Номлолын тамгыг эрэв. Алга болсныг харахлаар нөгөө талыг хүндэлсэн нь лав мэдэгдсэн болов.[362]

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- таалал төгссөний дараа бутархай мөнгө ч боол ч үлдээгээгүй. Зөвхөн унаж байсан цагаан луус, зэвсэг ба зорчигчдын төлөө сан болгосон (Фэдэк ба Хайбар дахь) хөрөнгө нь л үлдэв.[363]

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- Даваа гаригт өөд болоод Мягмар гаригт оршуулагдав. Хүмүүс мөргөлийг нь чуулгаар биш тус тустай үйлдэж, хэн ч имам болоогүй. Зарим нь "Индэрийн дэргэд оршуулъя," гэв. Зарим нь ч "Бакийд оршуулъя," гэв. Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх- ирээд:

"Расулаллах -алэйхиссалатү вэссэлам-ын:

«Пайгамбар бүр нь таалал төгссөн газар л оршуулдаг,» хэмээснийг сонссон байлаа," гэв. Тэгэхлээр нь тэнд булшийг малтацгаав.[364]

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг угаах болоход цамцыг нь тайлах юмсан. Гэхэд "Цамцыг нь битгий

---

362. Ибн-и Са'д, II, 272; Ибн-и Кэсир, *эл-Бидая,* V, 231.

363. Бухарий, Мэгазий, 83

364. Кадий Ияаз "Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн булш оршдог газрын дэлхийн хамгийн эрдэмт орон буйд ямар ч маргаан үгүй," гэдэг. *(Шифа, II, 96)*
Имам Бүсирий бол сэтгэгдлээ ингэж илэрхийлнэ:
"Амь ба дэлхийн султан Пайгамбар Эзний маань ариун цогцосыг хэвлийдээ хадгалсан хөрс шиг сайхан үнэртэй юм үгүй. Тэр ариун хөрсийг үнэрлэж үнссэн хүн ямар жаргалтай, ямар азтай хүн юм бэ!" (*Касидэ-и Бүрдэ,* Бэйт №: 58)

тайл!" гэсэн нэг дуу сонсцгоов. Тэгэхлээр нь цамцтайгаар нь угаацгаав.[365]

Абдуллах бин Мэс'үд -радъяллахү анх- ингэж хэлнэ:

"Манай Пайгамбар ба Амраг маань бидэнд таалал төгсөхөө сарын өмнө мэдээлэв.

«–Аяа Расулаллах! Чам дээр оршуулгийн мөргөлийг хэн үйлдэх вэ?» гэж асууж уйлцгаав. Өөрөө ч уйлж:

«–Тайван бай, Аллах танд энэрэл хайрлаг! Таныг Пайгамбараас тань болж буянаар шагнаг! Та намайг угаасан ба кэфэнд бүрдсэнд энэ буйдангийн минь дээр ба гэрийн доторх булшид минь дэргэд тавиарай! Дараа нь хэсэг хугацаа намайг орхиж гараарай! Учир нь над дээр эхлээд миний хоёр анд, Жэбраил ба Микаил, дараа нь Исрафил, дараа ч мэлэкийн цэргийг дагуулан үхлийн мэлэк мөргөл үйлдэнэ! Үүний дараа хэсэг хэсгээр ирээд над дээр мөргөл үйлдэж салат ү салам хэлээрэй! Гэхдээ магтаад буюу хашхиран бархиран намайг битгий үймүүлээрэй!

Дараа нь над дээр мөргөл үйлдэхэд эхлээд миний гэр бүлийн эрчүүд эхлэг! Дараа нь тэдний эхнэрүүд үйлдэг! Тэдний дараа та нар үйлдэнэ!

Асхабаас минь энд байгаагүй хүмүүст мэнд хүргээрэй! Киямат өдөр хүртэл миний шашин дээр намайг дагагч хүмүүст ч мэнд дамжуулаарай!»" (Хэйсэмий, IX, 25; Ибн-и Са'д, II, 256-257)

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хэлснээр хийцгээв. Хазрат-и Али -радъяллахү анх-:

365. *Муватта,* Жэнаиз, 27; Ахмад, VI, 267.

“Хэн ч «Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- дээр имамгүйгээр оршуулгийн мөргөл үйлдэж болох уу?» гэж санаа зовох хэрэггүй! Тэр амьд байхдаа ч өөд болохдоо ч бидний имам мөн!” гээд Пайгамбар -алэйхиссалатү вэссэлам-ын зэрэг зогсоод:

“Аяа Расулаллах! Аллахын мэнд, энэрэл ба элбэг Чам дээр байх болтугай!

Аяа Аллах минь! Бид Түүний, өөртөө буусан зүйлсийг тэблиг хийж хамаг үммэтдээ сургаал хэлсэнд, Аллахын шашныг давуулж үгийг нь бүтээтлээ Аллахын замд байлдсанд гэрчлэе!

Аяа Аллах минь! Биднийг Түүнд буулгасан зүйлсээ дагагчид хүмүүс болго! Түүний дараа бидэнд энэ зам дээр бат болохыг хайрла! Биднийг Түүнд хүргэ!” гээд залбирч, чуулга нь ч “Амин! Амин!” гээд байв. (Ибн-и Са’д, II, 291)

Дэлхийн гадарга нь Орчлонгуудын Эзнийг элгэндээ хадгалсан нь ямар их жаргал юм бэ!

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- шилмэл нэгэн пайгамбар ба хорвоонуудын энэрэл юм. Дэлхий нь «Түүний булш нь надад юм,» гээд тэнгэрт өөрийгөө магтана. Жэбраил -алэйхиссэлам- Аллахын Элчийн Равзад зочилж; «Энд нь Адны Диваажин мөн. Тэнд үүрд мөнх байхаар орцгоо!» гэсэн байдаг.”

М. Раиф Гуай ч тэнгэр газрыг яаж атаархсаныг шүлэгтээ илэрхийлнэ:

“Аяа нарны царайт аа! Тэнгэр нь газрыг Чамаар чимэглэснийг харах тусам чин сэтгэлээрээ ***«Би хөрс болоогүй яасан!»*** (эн-Нэбэ, 40) *гээд санаа зовдог гэнэ.”*

Шашин төгс төгөлдөр болсон, сахабиигаас шашин тэблиг болсны баталгаа нь шууд авагдсан ба гэрчилгээ нь Аугаа Эрхэд өргөсөн байв. Дараа нь Оршигчдын Туяа -саллаллахү алэйхи вэ сэллэм- үүрдийн хорвоод уригдсан байв. Одоо Тэр махшарт, сиратад ба Кавсарын Шалбаагт үммэтээ хүлээж байдаг.

Шэфаат аяа Расулаллах!
Мэдэд аяа Расулаллах!
Дахилэк аяа Расулаллах!..

12 Рабиулэввэл Даваа гаригт төрөөд дэлхийг хүндэлсэн бөгөөд 12 Рабиулэввэл Даваа гаригт Аллах Түүнд номлох үүргийг хандуулсан байв. Эбү Катадэ Хазрат ингэж дамжуулна:

“Хазрат-и Пайгамбараас Даваа гаргийн мацгийг асууцгаав. Тэр ч хариулан:

«–Тэр нь миний төрсөн өдөр ба пайгамбар болохоор томилсон өдөр мөн...» хэмээв.” (Мүслим, Съям, 197-198)

Дахиад өөр нэгэн 12 Рабиулэввэл Даваа гаригийн өглөө, Мадинад ороод саяхан байгуулсан ба Киямат хүртэл үргэлжлэх Ислам гүрний суурийг тавьсан байв. Тэгээд эцэст нь өөр нэгэн 12 Рабиулэввэл Даваа гаригт ахиратын хорвоод одов. Тэр одоо укбад халамжтайгаараа шэфаат хийхээр үммэтээ хүлээж байдаг.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дэлхийгээс жаргалын оронд гаталсан ба Түүнийг алдсан дэлхийн үнэнч сэтгэлгүй занг Азиз Махмуд Хүдаий Хазрат нь ийм шүлгээрээ төсөөлнө:

Чамаас үнэнч сэтгэлийг хэн найдах вэ,
Чи худлын хорвоо биш юм уу?
Мухаммедү'л-Мустафаг
Авсан хорвоо биш юм уу?

Орчлон Дүүрэн Гуниг

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн таалал төгсөхөд Хазрат-и Фатима -радъяллахү анха-:

يَا اَبْتَاهْ مَنْ رَبَّهُ مَا اَدْنَاهُ

يَا اَبْتَاهْ اَجَابَ رَبًّا دَعَاهُ

يَا اَبْتَاهْ مَنْ جَنَّةُ الْفِرْدَوْسِ مَأْوَاهُ

يَا اَبْتَاهْ اِلَى جِبْرِيلَ نَنْعَاهُ

"Аяа Рабдаа илүү ойр хэн ч үгүй аав минь! Аяа Раббын урилгыг дагасан аав минь! Аяа Фирдэвч диваажинд оршсон аав минь! Аяа таалал төгссөнийг Жибрийлд бидний мэдээлсэн аав минь!" гээд уйлав. Эзнийг маань оршуулсны дараа ч Энэс -радъяллахү анх-ад:

"–Энэс ээ! Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- дээр хөрс хийхэд сэтгэл тань яаж зөвшөөрөө вэ!" гэв. (Бухарий, Мэгазий, 83; Даримий, Мукаддима, 14)

Энэс -радъяллахү анх- энэ асуултад хүмүүслээсээ болж хариу өгөөгүй, харин байдлын хэлээрээ: "Үгүй, Фатима! Бидний сэтгэл огт зөвшөөрөөгүй, харин бид Расулаллахын тушаалыг дагаж өөрсдийгөө албадан энэ ажлыг хийцгээв," гэв. (Камил Мирас, *Тэжрид Орчуулсан нь,* XI, 25)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг таалал төгссөнд мусульманчууд мэсжидэд уйлж эхэлцгээв. Хазрат-и Умар -радъяллахү анх-:

“Хэнийг ч «Мухаммед -алэйхиссалатү вэссэлам- өнгөрсөн!» гэснийг би сонсохгүй! Эсвэл сэлмээрээ хүзүүг нь цавчина! Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- нь Муса -алэйхиссэлам-ын ухаан балартсан шиг ухаан балартсан бололтой!..” гээд яриад байв, тэгээд яриад яриад ам нь хөөсөөр дүүрэв.

Хазрат-и Эбү Бэкир -радъяллахү анх- гашуун мэдээг авмагцаа морио унаад Мадинад ирэв. Пайгамбар Эзний маань царайг нээв. Дараа нь дээр нь бөхийж, уйлахдаа духыг нь үнсээд:

“Валлахи, Расулаллах таалал төгсчээ! Инна лиллахи вэ инна илэйхи ражиун: Бид нар Аллахад харъяалагдана! Аллахын боолчууд мөн! Тэгээд бид Тэрээрт л буцна! Аав ээж минь Чамд золиос болог! Аллахад тангараг өргөе, Аллах Чамд хэзээ ч хоёр удааны үхэх гашуун амсуулахгүй! Чи нэгэн удаа өнгөрөөд хувь заяаны гарцыг гаталсан байна! Одоогоос хойш Чамд дахиад өнгөрөх үгүй! Ёо миний пайгамбар минь!” гээд, бөхийж Оршигчдын Туяа Эзний маань царайг үнсэв. Толгойгоо өндийлгөсний дараа:

“Ёо миний анд минь!” гээд бөхийж Орчлонгуудын Эзний духыг үнсэв.

“Ёо миний шилмэл минь!” гээд дахиад духыг нь үнсэж:

“Чи амьддаа ч сайхан байсан, өнгөрсний дараа ч сайхан байна! Чиний амь нас ч үхэл ч маш сайхан!” гээд Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн царайг даавуугаар бүтээгээд гадаа гарав. Хазрат-и Умар -радъяллахү анх- хэвэ-

эрээ Пайгамбарын маань таалал төгссөөгүй тухай яриагаа үргэлжлүүлж байв. Хазрат-и Эбү Бэкир түүнд:

"–Умар аа, одоо суу!" гэв.

Хазрат-и Умар суух юмсангүй. Хазрат-и Эбү Бэкир үгээ хоёр гурав удаа дахиж яриад эхлэв:

"Аллах Таала нь Пайгамбартаа үхэх мэдээг Түүнийг таны дунд байхад хүрсэн байв. Таны ч үхэхийг мэдээлсэн байдаг. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- таалал төгсөв! Танаас хэн ч амьд үлдэхгүй. Хэн нь Мухаммедыг шүтэж байсансан бол, Мухаммед -алэйхиссалатү вэссэлам-ын нас барсныг мэдэж аваарай! Хэн ч Аллахыг шүтэж байвал, андашгүй нь Аллах нь Хайй буюу үхэлгүй юм! Аллах Таала:

وَمَا مُحَمَّدٌ إِلاَّ رَسُولٌ قَدْ خَلَتْ مِن قَبْلِهِ الرُّسُلُ أَفَإِن مَّاتَ أَوْ
قُتِلَ انقَلَبْتُمْ عَلَى أَعْقَابِكُمْ وَمَن يَنقَلِبْ عَلَىَ عَقِبَيْهِ فَلَن
يَضُرَّ اللّهَ شَيْئًا وَسَيَجْزِي اللّهُ الشَّاكِرِينَ

«Мухаммед нэгэн Расул мөн. Түүнээс өмнө ч олон расул ирээд өнгөрсөн байдаг. Одоо Тэр нас бараад эсвэл алагдвал, та нар өсгий дээрээ хойшоо эргэх юм уу? Хэн нь ингэж хоёр өсгий дээрээ хойшоо эргэвэл, мэдээж Аллахад ямар ч аюул хүргэсэн болохгүй. Аллах шүкүр хийж тэвчигсдэд шагнал олгох болно,» (Ал-и Имран, 144) хэмээн айлдсан байдаг."

Хүмүүс уг аетыг сонсохлоороо Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн өөд болсонд бүр сэтгэл ханав. Тэд маш их сандарсан бөгөөд, Эбү Бэкир -радъяллахү анх-ыг унштал энэ аетын буусныг мартсан шиг байцгаав.

Хазрат-и Умар -радъяллахү анх- хэлнэ:

“Валлахи тэр өдөр хүртэл энэ аетыг бараг огт сонсоогүй юм шиг байлаа! Түүнийг Эбү Бэкирээс сонсохлоороо хэт их гайхлаа. Хөл намайг дааж чадаагүй. Өвдгийн минь шөрмөс тайлж байсан газар уначихлаа.” (Ибн-и Са’д, II, 266-272; Бухарий, Мэгазий, 83; Хэйсэмий, IX, 32; Абдүррэззак, V, 436)

Хазрат-и Умар нь Хазрат-и Эбү Бэкирийн ярианы дараа Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм- дээр бөхийж духыг нь үнсэв. Уйлаад ингэж хандаж байв:

“Аав ээж минь Чамд золиос болог аяа Расулаллах! Чиний алж байсан хасарвааны дүнз, индэртэй болсонд чинь Чиний хагацлыг дийлээгүй гэнгэнэж эхэлсэн, гараа түүн дээр тавихад дуугаа болсон байв. Харин үммэт чинь Чиний хагацалд ёслоход түүнээс илүү зохимжтой юм!

Аав ээж минь Чамд золиос болог аяа Расулаллах! Раб чинь:

مَّنْ يُطِعِ الرَّسُولَ فَقَدْ أَطَاعَ اللّٰهَ

«Хэн нь Расулаллахын үгэнд орвол Аллахын үгийг дагаснаар тоологдоно…» (эн-Ниса, 80) хэмээн айлдаж Чамайг дагахыг өөрийгөө дагах гэж тоолохдоо, онгон дахь давуу талыг чинь сүүлийн төвшинд хүргэсэн байдаг!

Аав ээж минь Чамд золиос болог аяа Расулаллах! Аллах Чамайг сүүлийн пайгамбар болгож илгээсэн боловч, Чамайг итгэж үнэмших ба туслах талаар өмнөх пайгамбарчуудаас аман гэрээ авахдаа[366] Чиний өөрийнхөө онгон дахь эрдмийг сүүлийн төвшинд хүргэсэн байдаг!

366. Хар. Ал-и Имран, 81.

Аав ээж минь Чамд золиос болог аяа Расулаллах! Тамын ард тамлал доор байхдаа:

يَا لَيْتَنَا أَطَعْنَا اللّٰهَ وَأَطَعْنَا الرَّسُولَا

«…Хайран юм! Бид Аллахын үгэнд ороогүй яасан, Расулаллахын үгэнд ороогүй яасан!» (эл-Ахзаб, 66) хэмээгээд Чамайг дагах үгүйлэл мэдэрсэн нь Чиний Аллахын онгон дахь эрдмийг сүүлийн төвшинд хүргэсэг байдаг!" (Касталланий, II, 492)

Үммү Сэлэмэ -радъяллаху анха- эх маань ингэж ярина:

"Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн таалал төгссөн өдөр бид эргэнд нь цугласан уйлж байв. Тэр шөнө унтаагүй байлаа. Аллахын Элч манайд байсан, Түүнийг хараад сэтгэлээ тайтгарч байлаа. Үүрийн цагт малтах дууг сонсонгоо хашхирч эхэлцгээв. Мэсжид дэх чуулга ч бархиран уйлж эхлэв. Мадина нь ганцхан хашхирлаар найгав. Ялангуяа Билал -радъяллаху анх-ын эзан дуудаад «Эшхэдү эннэ Мухаммедэ'р-Расулаллах" гэж Расулаллахын нэрийг хэлж байхдаа зогьсон уйлсан нь бидний гунигийг бүр ихэсгэв. Хүмүүсийг булшид орохоор дайрахлаар доторхи хүмүүс хаалгыг хаацгаав. Тэр нь ямар айхтар зовлон байв. Түүнийг дараа ямар нэгэн гайтай тааралдвал Расулаллахын өөд болсныг санан тэр гайг нэг их тоодоггүй боллоо." (Ибн-и Кэсир, *эл-Бидая,* V, 256)

Расулаллах -саллаллаху алэйхи вэ сэллэм-ийн хагацал Сахаба-и кирамд их хүнд санагдсан байв. Учир нь Түүнд юунааас ч хэнээс ч илүү хайртай байцгаав. Ийм учраас асхаб дотор Түүнийг хардаггүй нүдийг, Түүнийг сонсдоггүй чихийг, Түүнийг болоогүй амьдралыг хүсдэггүй хүмүүс байв. Пайгамбар Эзэн маань тэдний энэ байдлыг уг хадис-и шарифтайгаараа өмнө нь мэдээлсэн байв:

"Мухаммедын амийг хүчит гараараа барьсан Аллахад тангараг өргөе, өдөр ирээд та намайг харж чадахгүй. Тэр үед танаас нэгэнд намайг өөрийнхөө хамт харах нь гэр бүлээс эсвэл хөрөнгө бараанаас нь илүү энхрий санагдах болно." (Мүслим, Фэдаил, 142; Бухарий, Мэнакиб, 25)

Тэд дахиад Аллахын Элчтай хамт болох ба Орчлонгуудын Эзнийг дахиад харж чадах өдрүүдийг хүлээгээд амьдралаа барав.

Хазрат-и Усман -радъяллахү анх- ингэж ярина:

Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг таалал төгссөний дараа Асхаб-и кирам дунд Түүний үгүй болсонд хамгаас илүү санаа зовсон нь андашгүй нь би юм. Бусад нь ч гуньсан байв. Түүнчлэн гуньснаасаа хардлаганд автсан хүмүүс болов. Намайг нэгэн хэрмийн сүүдэрт сууж байхад Умар -радъяллахү анх- миний дэргэд өнгөрөөд надад мэнд хүргэжээ. Би гунигаасаа болж түүний явсныг ч мэнд хүргэснийг ч анзаараагүй. Умар нь Эбү Бэкирийн дэргэд очоод ингэж хэлжээ:

"–Усманы хажуугаар яваад мэнд хүргэсэн, харин тэр хариу өгөөгүй. Үүнээс илүү гайхалтай юм байх уу?"

Тэгэхлээр нь Эбү Бэкирийн хамт над дээр ирээд мэнд хүргэцгээв. Дараа нь Эбү Бэкир хэлрүүн:

"–Чиний дүү Умар надад ирээд чамд мэнд хүргэснээ харин чамайг хариу өгөөгүйг хэлэв. Энэ нь юуны учиртай вэ?"

"–Би тийм юм хийгээгүй," гэхлээр Умар даруй ингэж хэлэв:

"–Валлахи чи ингэсэн!"

Би хариу өгөв:

“–Валлахи би чиний явсныг ч мэнд хүргэснийг ч анзаараагүй!”

Эбү Бэкир үгэнд ороод ингэж хэлэв:

“–Усман зөв хэллээ.” (Ахмад, I, 6)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг таалал төгссөний дараа Хазрат-и Эбү Бэкир нь Умар -радъяллахү анх-ад:

“–Бос, Эзний маань хамаатан буй Үммү Эймэн дээр очъё, Расулаллахын хийсэн шиг бид ч түүнд зочин болъё,” гэв. Хажууд нь очиход Үммү Эймэн -радъяллахү анха- уйлж эхлэв. Тэд:

“–Яагаад уйлж байна вэ? Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хувьд Аллахын онгон дахь шимийн илүү буянт буйг мэдэхгүй байна уу?” гэцгээв. Үммү Эймэн:

“–Би түүнд уйлахгүй юм аа. Аллахын онгон дахь шимийн Расулаллах -алэйхиссалатү вэссэлам-ын хувьд илүү буянт буй би мэддэг. Би вахийг огтолсонд уйлна,” гэв. Түүний ийм нарийн санаа нь Эбү Бэкир болон Умар -радъяллахү анхүмаа-гийн сэтгэлийг ч хөөрүүлэв. Үммү Эймэний хамт тэд ч уйлж эхлэв. (Мүслим, Фэдаилү’с-Сахаба, 103)

Умар -радъяллахү анх- нэгэн шөнө байцаах зорилгоор хотын гудамжаар явж байхад нэгэн гэрт чийдэн ассаныг харав. Гэрт дөхөхдөө хөгшин нэгэн эмэгтэйг нэг талаас ноос ээрээд нөгөө талаас ийм утгат шүлэг уншиж байсныг сонсов:

“Салихчуудын мэнд ба залбирал Мухаммед -саллаллахү алэйхи вэ сэллэм- дээр болог. Аяа Расулаллах! Хамаг шилмэл хүмүүс Чамд энэрэл уншиг. Чи шөнө залбиран, үүрийн цагт ихээр уйлдаг байв. Харин үхэл аажим аажмаар хүн бүрт хүрдэг.

Ёо! Ахират орон намайг хайрт Пайгамбартай минь учруулах эсэхийг би нэг мэдэж чадаасай.”

Умар -радъяллахү анх- суугаад хэсэг хугацаагаар уйлав. Дараа нь хаалгыг тогшив. Хагшин эмэгтэй хэн байсныг асуув:

“–Умар бин Хаттаб” гэж хариулав.

Эмэгтэй:

“–Умар надтай хийх ямар ажилтай, энэ цагт энд юу хайна?” гэж санаа зовохлоор:

“–Аллахдаа хайртай байвал хаалгаа нээ, битгий ай!” гэв. Эмэгтэйг хаалгаа тайлахлаар Хазрат-и Умар түүнд:

“–Саяхан хэлсэн шүлгийг дахиад унш!” гэв. Эмэгтэй нь уншив. Адгийн мөрт ирэхэд нь Умар -радъяллахү анх-:

“–Намайг ч хоорондоо оруулахыг гуйя!” гэв. Тэгсэнд нь эмэгтэй нь адгийн мөрийг:

“Ёо! Ахират орон намайг ба Умарыг хайрт Пайгамбартай минь учруулах эсэхийг би нэг мэдэж чадаасай. Аяа Гаффар бэлгэт Аллах минь! Умарыг өршөө!” гэж дуусгав. Умар -радъяллахү анх- ч сэтгэл ханамжтай буцав. (Али эл-Мүттакий, XII, 562/35762)

Энэс -радъяллахү анх-:

“Зүүдэндээ Хайрт Пайгамбарыгаа хараагүй нэг л шөнө ч үгүй юм,” гээд уйлдаг байв. (Ибн-и Са’д, VII, 20)

Энд ч харагдсанаар, Асхаб-и кирам нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг дурдахдаа ялангуяа “хабибий: хайрт”, “халилий: анд” мэтийн хайрынхаа хөгжлийг илэрхийлэх нэр томъёог хэрэглэдэг байв.[367]

367. Бухарий, Тэхэжжүд, 33; Савм, 60; Мүслим, Мүсафирийн, 85; Ибн-и Мажэ, Садакат, 10; Даримий, Самв, 38; Ахмад, V, 159; Ибн-и Са’д, IV, 229.

Тэд салат ү салам илэрхийлж Тэр агуу Пайгамбарт хайр ба холбоосоо үзүүлдэг байв. Харин Түүнийг зөвхөн салат ү саламтайгаар санадаг байгаагүй. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн замыг мөрдөж, сүннэтийг дагасан нь ба хадис-и шарифуудыг зөвлөлцсөн нь ч тэдэнд эгнэгт Хүндэт Элчийг сануулдаг байв.

Эбү Зэрр -радъяллахү анх- хэлнэ:

“Валлахи, Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- ахиратад нүүхдээ биднийг, тэнгэрт нэгэн шувуу далавчаа дэвбэл бидэнд Расулаллахын нэгэн хадисыг сануулах байдалд үлдээсэн байв. Учир нь Орчлонгуудын Эзэн бидэнд *«Диваажинд дөхүүлж тамаас холдуулах юу байсан ч бүгд нь танд тайлбарласан байдаг,»* хэмээсэн байв.” (Ахмад, V, 153, 162; Хэйсэмий, VIII, 263)

Бүгд мусульманчууд ч Хүндэт Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг дэлхийд хүн бүрээс ба юм бүрээс илүү хайрлаж, Түүний тушаал ба хоригийг өөрийнхөө хүслээс илүүд үзэх бөгөөд Түүний хамаг үг ба үйлсийг дагах нь шашны нэгэн үүрэг юм.

ҮСВЭ-И ХАСЭНЭ (Төгс Жишээ)

Туурвигдагчдын дунд Аллахын тэнгэрлэг нэрүүдийн бүхнээс хувь авах нэр хүнд нь зөвхөн хүнд л хайрласан байдаг. Тэгэхдээ Аугаа Эрх тэнгэрлэг шалгалтаас болж хүнийг фиск ба таква зарчмаар төхөөрсөн, түүнд буянд ч муунд ч боломжтой шинж олгосон байдаг.

Үүнээс үзвэл шашны гол зорилго нь ийнхүү эрс тэс илрэлттэй буй хүн дэх нэфсийн сөрөг шинжүүдийг бараг үгүй болгох чинээ багасгах, үүний эсрэгээр туяат шинжийг ч оргилд хүргэх юм. Харин энэ зорилгын хэрэгжихэд хүн бодит нэгэн жишээ, өөрөөр хэлбэл "үсвэ-и хасэнэ" гээд нэрлэсэн хамгийн сайхан үлгэр жишээний хэрэгцээтэй байдаг. Пайгамбарчуудын илгээгдсэний нууц учрыг, тэдний хүмүүсийн дагах төгс зангийн жишээ шинж агуулсан нь юм. Аллах Таала айлдана:

وَمَا أَرْسَلْنَا مِن رَّسُولٍ إِلاَّ لِيُطَاعَ بِإِذْنِ اللّٰهِ

"Бид хэн нэгэн элчийг, Аллахын зөвшөөрлөөр үгийг нь дагахаас өөр зорилгоор илгээгээгүй..." (эн-Ниса, 64)

Энэ шинж нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- Эзэнд маань бараг нэгэн оргил болоод, үүний тухай Аугаа Эрх ает-и кэримэд ингэж айлдсан байдаг:

لَقَدْ كَانَ لَكُمْ فِي رَسُولِ اللّٰهِ أُسْوَةٌ حَسَنَةٌ لِّمَن
كَانَ يَرْجُو اللّٰهَ وَالْيَوْمَ الْآخِرَ وَذَكَرَ اللّٰهَ كَثِيراً

“Тангараг өргөе, Расулаллахад таны хувьд, Аллах болон ахират өдөрт хүрэхийг найдагчдад нэгэн «үсвэ-и хасэнэ» байдаг.” (эл-Ахзаб, 21)

Түүхэнд амьдралынхаа бүхэн хамгийн нарийн зүйл хүртэл нь тогтсон ганцхан Пайгамбар ба ганцхан хүн Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллахү алэйхи вэ сэллэм- юм. Түүний хамаг үйл, үг ба мэдрэмж нь хором хормоор бичигдэж түүхэнд алдрын самбар болж тогтсон байдаг. Амьдрал нь киямат хүртэл ирэх үе удмынханд жишээ юм. Кур’ан-и Кэримийн Калэм Сура нь Түүний тухай ингэж айлдана:

وَإِنَّكَ لَعَلى خُلُقٍ عَظِيمٍ

“Андашгүй нь Чи агуу ёс суртахуунтай нь юм!” (эл-Калэм, 4)

Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн амьдрал ба ариун зан нь зөвхөн хүний ухаанд багтах илэрлээрээ ч хүний хэрэг үйлсийн хамгийн хүршгүй оргилыг төлөөлнө. Учир нь Аллах -жэллэ жэлалүхү- Тэр ариун оршигчийг хамаг хүн төрөлхтөнд нэгэн “үсвэ-и хасэнэ” буюу хамгийн төгс жишээ болгож бэлэглэсэн байдаг. Ийм л учраас Түүнийг хүний нийгмийн дунд боломжоороо хамгийн доод төвшинд буй “өнчин хүүхэд”ээс эхлүүлэн амьдралын хамаг төвшнөөр гатлуулж, хүч чадлаараа хамгийн дээд цэг буюу пайгамбар ба улч төрийн тэргүүний орон хүртэл дээшлүүлсэн байдаг. Тэгээд хүн төрөлхтний тийм төвшнүүдэд буй хүмүүс Түүнээс өөрсдөө хамгийн төгс үйлсийг жишээ болгож аваад, өөрийнх хүч ба болом-

жоороо хэрэгжүүлэхээр эргэлзэх болно. Үүнийг ч Түүнийг хайрлах ба Түүний сүнсэнд бүрдэх зэргээр хэрэгжинэ.

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- шашны тэргүүнээр жишээ мөн; улс төрийн тэргүүнээр жишээ мөн; тэнгэрлэг хайрын цэцэрлэгт орогчдод жишээ мөн; Раббынхаа шимээр дүүрсэндээ шүкүр ба даруу зангаараа жишээ мөн.

Хэцүү үе ба газрууд дахь тэвчээр ба бууж өгөхдөө жишээ мөн. Олз олохдоо өгөөмөр зангаараа жишээ мөн. Гэр бүлийнхэндээ халамж үзүүлснээрээ жишээ мөн. Ядуу зүдүүд, хэн хүнгүйчүүдэд, боолчуудад үзүүлсэн энэрлээрээ жишээ мөн. Гэмт хэрэгтдийг өршөөснөөрөө жишээ мөн:

Хэрвээ чи хөрөнгөөрөө баян хүн бол, хамаг Арабстаныг эзэлж, Арабын хамаг тэргүүдийг өөртөө хайртайгаар буулгаж өгүүлсэн Тэр агуу Пайгамбарын даруу ба өгөөмөр занг бод!

Хэрвээ хүчгүй иргэдийн нэгэн байвал, Маккад харгис ба хулгайч мүшрикчүүдийн захиргаанд амьдарсан Пайгамбарын амьдралаас жишээ ав!

Хэрвээ ялагч нэгэн эзлэгч байвал, Бэдир ба Хүнэйнд дайсныг хожих зориг ба Аллахад бууж өгөх Пайгамбарын амьдралаас жишээ ав!

Аллах хадгалах болтугай, хэрвээ хожигдсон байвал, тийм үедээ ч Ухудын Дайнд шэхид болсон эсвэл шархдаж газар унасан асхабынхаа дунд зоригоороо алхаж явсан Пайгамбарыг сана!

Хэрвээ багш байвал, мэсжидэд Сүффэгийн Асхабт нарийн, мэдрэмжтэй ба уянах сэтгэлийнхээ эрдмийг дамжуулан тэнгэрлэг тушаалыг сургасан Пайгамбарыг бод!

Хэрвээ шавь байвал, өөрт нь вахий буулгасан Жибрийл-и Эминий өмнө суусан Пайгамбарыг төсөөл!

Хэрвээ сургаал өгөгч итгэмжтэй нэгэн ваиз байвал, Мэсжид-и Нэбэвийд асхабтаа эрдмийг цацсан Пайгамбарыг сонс! Түүний уяхан дуунд чих болон сэтгэлээ холбуул!

Хэрвээ эрхийг бариад өргөх, хамгаалах ба түгээх юмсан бол, энэ тухай чамайг түших нэг л туслагч ч үгүй байвал, Маккад бүх төрлийн тулсамж үгүй байхдаа харгисчуудад эрхийг зарлаад тэднийг авралд урьсан Пайгамбарын амьдралыг хар!

Дайсныг дайснаа дарж дархан цолоо мандуулсан бол, харилцагчийнхаа зөрүүд занг дараад түүнийг давсан бол, дарлалыг мөхөөж эрхийг зарласан бол, Маккагийн эзэлсэн өдөр ариун оронд ялагч нэгэн манлайлагч байсан ч агуу даруу зангаараа тэмээн дээрээ мөргөж бөхийсөн талархалт Пайгамбарыг нүдний өмнө сэргээ!

Хэрвээ хөдөө аж ахуйн эзэн бөгөөд тэндэх ажлаа цэгцлэмээр байвал, Бэний Надр, Хайбар ба Фэдэк хөрөнгийг эзэлсний дараа тэднийг хамгийн сайнаар удирдах хүмүүсийг томилсон Пайгамбараас жишээ гаргаж ав!

Хэрвээ хэн хүнгүй ганцаараа нэгэн байвал, Абдуллах ба Алимагийн өнчин, элгэний өөдөс байсан энхрий Гэмгүйг, туяат Өнчнийг бод!

Хэрвээ өсч яваа нэгэн залуу байвал, Маккад мал хариулж пайгамбар болсон залуугийн цэвэр амьдралд анхаар!

Хэрвээ ариун сүнстэй гэр бүлтэй хүссэн нэгэн залуу байвал, Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн гэрийн амьдрал болон зөвлөгөөг анхаар! Такваг сонгоорой, тэгээд хоёр ертөнцийн жаргал хүртэх болно!

Хэрвээ наймааны жинтэйгээр замд гарсан худалдаач байвал, Сириэс Бусрад очсон хамт олны хамгийн агуу байсан хүний байдлыг шинжил!

Хэрвээ шүүгч байвал, Маккагийн хүндэт хүмүүс нэг нэгтэйгээ тулалдах дөхөхөд Хажар-и Эсвэдийг Каба дахь байранд тавих тухай Түүний эрх тэгш ба нарийн ухаантай үйлийг бод!

Мөн нүдээ дахиад түүнд эргүүлээд Мадинад, Мэсжид-и Нэбэдийд сууж, юмгүй ядуу ба хөрөнгөтэй баяныг онгондоо тэгш болгож хүмүүнийг хооронд хамгийн эрх тэгш шийдвэр гаргасан Тэр Пайгамбарыг нэг хар!

Хэрвээ нэгэн нөхөр байвал, Хазрат-и Хатижагийн, Хазрат-и Аишагийн нөхөр байсан Тэр ариун хүний цэвэр амьдралд, гүн мэдрэмж ба халамжид, бүх эхнэрүүдийн хооронд эрх тэгш хандсаныг анхаар!

Хэрвээ хүүхэдтэй аав байвал, Фатиматү'з-Зэхрагийн аав ба Хазрат-и Хасан Хазрат-и Хүсэйн хоёрын өвөө байсан энэ хүний тэдэнд яаж хандсаныг сур!

Чи ямар цолтой байсан ч, ямар ч байдалд байсан ч, өглөө-үдэшгүй байнга Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн өөртөө хамгийн төгс багш ба хамгийн сайхан удирдагчаар олох болно...

Тэр нь сүннэтийнх нь дагуу хамаг буруугаа засах нэгэн багш юм... Замаас төөрсөн ажлаа янзалж, өөрийгөө ч хүмүүжлүүлнэ… Түүний туяа ба удирдамжийн ачаар амьдралын хавхнуудаас аврагдаж жинхэнэ жаргалыг олно!..

Хэрвээ өөрийгөө эд барааны боол болохоос аварч сүнсний амьдрал явуулмаар байвал, Тэр Орчлонгуудын Эзнийн хүмүүжүүлсэн Билал, Ясир ба Сэвбан нарыг ол! Тэдэнтэй хамт байгаад үнэнч болоод, тэгээд уяхан, нарийн, элдэг сэт-

гэлтэй байх болно. Мунхаг үеийн хүмүүсийн Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн удирдамжтайгаарр Түүний эргэн тойронд удган эрвээхий болсон улмаас үнэнч болсныг битгий март. Асхаб-и Кэхфийн Китмийр ч үнэнчдийн хайрын жороос хувиа авсанд ямар том соёорхлыг автсан байв. Үүний эсрэгээр Хазрат-и Лутын эхнэр ба Хазрат-и Нухын хөвүүн Кэнан фасик ба харгисчуудыг дагасны дүгнэлтэд тэнгэрлэг зовлонтой учирсан байцгаав. Тэд ба тэдний адил нар нэфсийн эргэцэд уйжиж харгисчуудын хамт мөхөөлтөд орсон байдаг.

Тийм байвал амьдрал гэсэн тооллыг Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн үнэнч ба салих хайртууд буй зикирийн хүмүүстэй хамт байгаад дүүргэхэд анхаарал үзүүлээд, ухамсаргүй хүмүүсээс битгий бол!

Түүний амьдралын шилмэл, нарийн ба анхилуун үнэртэй сарнайнуудаар чимэглэсэн нэгэн сарнайн цэцэрлэг байсныг мэдээрэй.

Түүний ижилгүй сүнсний бүтцийн төгс байдал шиг биеийн бүтцийн гоо сайхан ч ижилгүй байв. Түүний энэ агуу үнэ цэнэ-эс болж Аллах Таала ингэж айлдана:

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُوا لَا تُقَدِّمُوا بَيْنَ يَدَيِ اللّٰهِ وَرَسُولِهِ وَاتَّقُوا اللّٰهَ
إِنَّ اللّٰهَ سَمِيعٌ عَلِيمٌ. يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُوا لَا تَرْفَعُوا أَصْوَاتَكُمْ
فَوْقَ صَوْتِ النَّبِيِّ وَلَا تَجْهَرُوا لَهُ بِالْقَوْلِ كَجَهْرِ بَعْضِكُمْ
لِبَعْضٍ أَنْ تَحْبَطَ أَعْمَالُكُمْ وَأَنْتُمْ لَا تَشْعُرُونَ

“Аяа итгэгчид ээ! Аллах ба Расулын өмнө битгий түрүүл! Аллахаас ай! Андашгүй нь Аллах нь сонсогч, мэдэгч мөн.

Аяа итгэгчид ээ! Дуугаа Пайгамбарын дуун дээр битгий чагнуул! Нэг нэгэндээ бархирсан шигээ Пайгамбарт чанга дуугаараа битгий бархир! Эсвэл таныг мэдэлгүй таны үйлс дэмий болж мэднэ.” (эл-Хужурат, 1-2)

Энэ ает-и кэримэнүүд хамаг итгэгчдийг Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-д ёс суртахуунтай болоход урьж байдаг.

Тэгээд Кур’ан-и Кэримд бусад пайгамбарчуудад нэрээр нь хандсан боловч, Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-д “Аяа Мухаммед аа!” гэж хандсан удаагүй бөгөөд Түүнд “Аяа Нэбий, Аяа Расул” гэж хандсан байдаг. Тэгээд Аугаа Эрх, хамаг итгэгчдийг ч энэ ёсыг дагахаар ингэж айлдана:

لَا تَجْعَلُوا دُعَاءَ الرَّسُولِ بَيْنَكُمْ كَدُعَاءِ بَعْضِكُمْ بَعْضًا

“Аяа итгэгчид ээ! **Пайгамбарыг хоорондоо нэг нэгээ дуудсан шигээ битгий дууд!..”** (эн-Нур, 63)

Энэ ает-и кэримэ нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн зөвхөн нэрээр нь дурдахын, үммэт болох хүмүүжилд зохидоггүйг мэдүүлж, Түүний нэрийн хамт агуу ба ариун бэлгэ тэмдгийг ч хэлэх хэрэгтэйг зарлаж байдаг. Тийм учраас Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг Нэбий, Расул, Расулаллах, Хабибуллах, Хорвооны Хүндэт, Хүндэт Элч гэх мэтийн бэлгэтэйгээр нь дурдаж, мөн Ахзаб Сурагийн 56-р ает-и кэримэ дэх тэнгэрлэг зарлигийн дагуу шариф нэрийг нь дурдсан газар бүрт Түүнд салат ү салам өргөх хэрэгтэй юм. Энэ нь Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хамаг үммэтэд Аугаа Эрхийн хүсч тушаасан хүмүүжил мөн. Ает-и кэримэ нь ингэж айлдана:

إِنَّ اللّٰهَ وَمَلَائِكَتَهُ يُصَلُّونَ عَلَى النَّبِيِّ يَا أَيُّهَا الَّذِينَ
آمَنُوا صَلُّوا عَلَيْهِ وَسَلِّمُوا تَسْلِيمًا

“Андашгүй нь Аллах ба мэлэкчүүд нь Пайгамбарт ихээр салат илгээнэ. Аяа итгэгчид ээ! Та ч Түүнд салават илгээж иж бүрэн мэнд хүргээрэй!” (эл-Ахзаб, 56)

Тэр нь Кур’аныг зөвхөн үгээр сургасан багш биш, мөн Кур’анаар амьдарсан амьд нэгэн жишээ байв. Жабир -радъяллахү анх-аас дамжуулсан нэгэн хадис-и шарифад Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

“Аллах -жэллэ жэлалүхү- намайг сайхан ёс суртахууныг бүтээхээр илгээв,” хэмээсэн байдаг. (*Муватта,* Хүснү’л-Хулук, 8)

1400 жилийн турш бүтээсэн Исламын хамаг бүтээлүүд нэгэн номыг буюу Кур’ан-и Кэримийг ба нэгэн хүнийг буюу Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг тайлбарлах зорилготой байдаг. Аугаа Эрх зөвхөн Түүний л төлөө: لَعَمْرُكَ : **“Чиний амьдралаар тангараг өргөе…”** (эл-Хижр, 72) хэмээсэн байдаг.

Мухаммедын үнэнд дөхөж чадах нь ухаанаас байтугай хайраар боломжтой байдаг. Хамаг нууц нь Мухаммедын үнэнээр тайлж мэднэ. Энэ ч Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн “үсвэ-и хасэнэ”гээс хувь авч чадах, дэлхийн тааламжаас холдож залбирал үйлчилгээ ба авъясны нууцыг хүртэхээр л боломжтой байдаг. Хүн нь Мухаммедын сүнсний сургаалаас хувь авч эхлэхлээрээ эелдэг үйлсийн цуглалт ба нээлт нь од болоод тэнгэрлэг нууц, туяа ба үнэн нь түүнд нээгдэнэ.

Андашгүй нь Кур’аны нууцууд нь Аллахын Элчийн сүнсний сургаалд бүрсэн зүрхний шинжтэй хамаатай илэрнэ.

Учир нь бидний төлөө ганцхан “үсвэ-и хасэнэ” буй Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг дагах тухай Аллах Таала аетэ-и кэримэнүүдэд ингэж айлдана:

وَمَا آتَاكُمُ الرَّسُولُ فَخُذُوهُ وَمَا نَهَاكُمْ عَنْهُ فَانتَهُوا
وَاتَّقُوا اللَّهَ إِنَّ اللَّهَ شَدِيدُ الْعِقَابِ

“...Расул танд юу өгсөн ч авцгаа! Танд юуг хориглосон ч түүнээс ч болгоомжилж Аллахаас айцгаа! Учир нь Аллахын тамлал нь ширүүн юм.” (эл-Хашр, 7)

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُوا أَطِيعُوا اللَّهَ وَأَطِيعُوا الرَّسُولَ وَلَا تُبْطِلُوا أَعْمَالَكُمْ

“Аяа итгэгчид ээ! Аллахын ч Пайгамбарын үгэнд орцгоо, ингэхдээ үйлсээ дэмий болгохгүй!” (Мухаммед, 33)

وَمَن يُطِعِ اللَّهَ وَالرَّسُولَ فَأُوْلَئِكَ مَعَ الَّذِينَ أَنْعَمَ اللَّهُ عَلَيْهِم. مِّنَ
النَّبِيِّينَ وَالصِّدِّيقِينَ وَالشُّهَدَاء وَالصَّالِحِينَ وَحَسُنَ. أُولَئِكَ رَفِيقاً

“Хэн ч Аллах болон Расулын үгийг дагавал, тэд Аллахын шим олгосон пайгамбарчууд, үнэнччүүд, шэхидчүүд ба салихчуудтай хамт байдаг. Тэд үнэхээр маш сайхан анд юм.” (эн-Ниса, 69)

قُلْ إِن كُنتُمْ تُحِبُّونَ اللَّهَ فَاتَّبِعُونِي يُحْبِبْكُمُ اللَّهُ وَيَغْفِرْ لَكُمْ
ذُنُوبَكُمْ وَاللَّهُ غَفُورٌ رَّحِيمٌ. قُلْ أَطِيعُواْ اللَّهَ وَالرَّسُولَ
فَإِن تَوَلَّوْاْ فَإِنَّ اللَّهَ لاَ يُحِبُّ الْكَافِرِينَ

"Аяа Расул минь ээ! **Ингэж хэл: Хэрэв Аллахыг хайрласан бол намайг дагаарай, тэгээд Аллах ч таныг хайрлаж нүгэлийг тань өршөөнө. Аллах нь Гафур Рахим мөн.** Аяа Элч минь ээ! **Ингэж хэл: Аллах болон Элчийнх нь үгэнд орцгоо! Хэрэв тэд нүүрээ буруулбал, андашгүй нь Аллах кафирчуудад дургүй!"** (Ал-и Имран, 31-32)

وَمَن يُطِعِ اللّٰهَ وَرَسُولَهُ وَيَخْشَ اللّٰهَ وَيَتَّقْهِ فَأُوْلَئِكَ هُمُ الْفَائِزُونَ

"Хэн ч Аллах болон Элчийнх нь үгэнд ороод Аллахаас айж Тэрээрийн тамлалаас болгоомжилбол, тэд авралд хүрэгчид мөн." (эн-Нур, 52)

وَالْمُؤْمِنُونَ وَالْمُؤْمِنَاتُ بَعْضُهُمْ أَوْلِيَاء بَعْضٍ يَأْمُرُونَ بِالْمَعْرُوفِ وَيَنْهَوْنَ عَنِ الْمُنكَرِ وَيُقِيمُونَ الصَّلاَةَ وَيُؤْتُونَ الزَّكَاةَ وَيُطِيعُونَ اللّٰهَ وَرَسُولَهُ أُوْلَئِكَ سَيَرْحَمُهُمُ اللّٰهُ إِنَّ اللّٰهَ عَزِيزٌ حَكِيمٌ

"Итгэгч эрчүүд ба итгэгч эмс нь нэг нэгнийхээ анд мөн; сайн сайхныг тушааж, муу муухайгаас болгомжлуулж, мөргөлөө үйлдэж, зэкатыг өгч Аллах ба Элчийнх нь үгэнд орцгооно. Аллах тэдэнд рахмат ба энэрлээ буулгах болно. Андашгүй нь Аллах Азиз Хаким мөн." (эт-Тавба, 71)

مَّنْ يُطِعِ الرَّسُولَ فَقَدْ أَطَاعَ اللّٰهَ وَمَن تَوَلَّى فَمَا أَرْسَلْنَاكَ عَلَيْهِمْ حَفِيظاً

"Хэн ч Расулыг дагавал, Аллахыг дагасан байх болно. Хэн ч царайгаа эргүүлбэл, (Аяа Элч минь, үүнийг мэд) **Бид Чамайг тэдэнд дээр мануулаар илгээхгүй!"** (эн-Ниса, 80)

أَلَمْ يَعْلَمُواْ أَنَّهُ مَن يُحَادِدِ اللّهَ وَرَسُولَهُ فَأَنَّ لَهُ
نَارَ جَهَنَّمَ خَالِداً فِيهَا ذَلِكَ الْخِزْيُ الْعَظِيمُ

“Тэд хэнийг ч Аллах болон Элчид нь эсэргүүцвэл, түүнд байнга үлдэх тамын гал олгохыг мэдээгүй юү. Энэ нь жинхэнэ гутамшиг мөн.” (эт-Тавба, 63)

وَأَطِيعُواْ اللّهَ وَرَسُولَهُ وَلاَ تَنَازَعُواْ فَتَفْشَلُواْ وَتَذْهَبَ
رِيحُكُمْ وَاصْبِرُواْ إِنَّ اللّهَ مَعَ الصَّابِرِينَ

“Аллах болон Элчийг нь дагацгаа! Нэг нэгтэйгээ битгий маргалд! Эвбэл айдсанд автаж (хүч, чадал, улс төр ба эзэмшсэн шимүүдээ) **алдана. Тэвчицгээ; учир нь Аллах тэвчигчдийн хамт юм.”** (эл-Энфал, 46)

Андашгүй нь итгэгч нь Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хайраар сэтгэл хөөрч, сүнснээсээ нэфстэй хамаатай хамаг зураг ба үзвэрийг хоосруулсан үед, Түүний хайр ба үлгэр жишээ зангаас хувь авах замд орсон байх болно.

Түүний ариун зангаас хувь аваад алга болсон үммэтийн сэтгэлийн цэргүүд нь киямат хүртэл Аллахын Элчийн хайрын маш сайхан жишээ толилуулсан байдаг. Аллахын Элчийн үнэнээр амь олсон байдаг.

Жаран гурван насандаа өөртөө булш шиг газар малтуулж амьдрал ба залбирлаа тэнд үргэлжлүүлэн:

“–Энэ наснаас хойш надад газар дээр явах нь харам юм,” гэсэн, хайрын агуу баатар Сэйед Ахмад Есэбий, энэ замд хөрш

болсон хүмүүсийн нэг юм. Тэр нь амьдарсан нутгийн дагуу "Хазрат-и Түркистан" гэж нэрлэсэн байдаг.

Вэйсэл Каранийд Ухудад Расулаллахын нэгэн шүд хугарсны мэдээ хүрэхлээр, аль нь хугарсныг мэдээгүй тулд бүгд шүдээ авахуулан санаа амарсан байдаг. (Фэридүддин Аттар, х. 23)

Имам Малик -радъяллахү анх- Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-тэй ижил болох бишрэлээр амьдрав. Мадина-и Мүнэввэрэд унаа унаагүй. Мадинагийн харамын дотор бие засаагүй. Равзад имам байхад байнга бага дуугаар ярив. Эриний калиф Эбү Жафар Мансурыг чанга дуугаараа ярихлаар:

"–Аяа Калиф аа! Энэ оронд дуугаа тат! Аллахын сануулга нь чамд олон дахин эрдэмтэй хүмүүс дээр буув!.." гээд уг ает-и кэримэг уншив:

يَا أَيُّهَا الَّذِينَ آمَنُوا لَا تَرْفَعُوا أَصْوَاتَكُمْ فَوْقَ
صَوْتِ النَّبِيِّ وَلَا تَجْهَرُوا لَهُ بِالْقَوْلِ كَجَهْرِ بَعْضِكُمْ
لِبَعْضٍ أَنْ تَحْبَطَ أَعْمَالُكُمْ وَأَنْتُمْ لَا تَشْعُرُونَ

"Аяа итгэгчид ээ! Дуугаа Пайгамбарын дуунаас дээш битгий гаргаарай. Нэг нэгтэйгээ ярьсан шигээ Пайгамбартай ч чанга дуугаараа битгий яриарай; эсвэл та анзааралгүй үйлсээ алдчихна." (эл-Хужурат, 2)

Дахиад Имам Малик Хазрат нь түүнд харгисласан Мадинагийн захиралд эрхээ халал болгосон:

"–Махшарт Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн удам буй хүнд гомдол гаргагч болохоос ичнэ!.." гэсэн байдаг.

Бэзм-и Алэм Эх Султан:
Мухаббатаас Мухаммед төрөв,
Мухаммедгүй хайраас юу төрөв?!

гээд сүнсний идээг зөвхөн Расулаллахын хайр буйг маш сайхан дурссан байдаг.

Хуурч Юүнүс ч Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хайраар шатсанаа ингэж илэрхийлэв:

Хайж хайж чиний мөрийг олъё,
Мөрийн чинь тоосноос нүүрээ түрхье,
Аугаа Эрхээс далдиран нүүрийг чинь харъя,
Аяа Мухаммед миний сэтгэл Чамайг хүсдэг...

Шүлэгч Набий нь 1678 онд, улс төрийн хүмүүсийн хамт хажид явжээ. Хамт олон нь Мадинад дөхөж байхад Набий биширснээсээ нойр нь хулжив. Тэдний нэгэн жанжин хөлөө анзааралгүй Мадина-и Мүнэввэрэйгийн тийш алцайлгасныг хараад. Үүнд санаа зовсон Набий нь магтаалаа бичжээ.

Өглөөний мөргөлийн үе болоход хамт олныг Мадинад орж байхад Набий бичсэн магтаалын Мэсжид-и Нэбийгийн минарад уншсаныг сонсоно:

(Аугаа Эрхийн мөргөлий орон ба Тэрээрийн хайрт пайгамбар Хазрат-и Мухаммед Мустафа -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн суудал ба нутаг буй энэ газар ёсоо алдахаас болгоомжил!..)

(Аяа Набий энэ ёсыг нь дагаад ор! Энд нь мэлэкчүүдийн удган эрвээхий шиг тойрч, хамаг пайгамбарчуудын босгыг нь хүндэтгэн үнсдэг ариун нэгэн орон юм.)

Үүнд ихээр сандарсан Набий нь даруй мүэззинийг олно:

“–Энэ магтаалыг хэнээс яаж сураа вэ?..” гэж асууна.

Мүэззин:

“–Өнөө шөнө Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- зүүдэнд бидэнд:

«–Миний үммэтээс Набий гэгч нэгэн шүлэгч манайд айлчлахаар ирнэ. Энэ хүн миний хэт хайраар дүүрэн юм. Энэ хайрын улмаас түүнийг Мадинагийн минарагаас өөрийнх бичсэн магтаалыг уншиж угтаарай!..» хэмээсэн, бид ч Пайгамбарын энэ тушаалыг хэрэгжүүлэв,” гэнэ.

Набий нь мэгшин уйл, Аллахын Элч түүнийг үммэтээр хүлээн авсанд хэр их баяссанаа илэрхийлнэ.

Мэвлидийн яруу найрагч Сүлэйман Чэлэби:

“Нэгэн гайхалт туяа, нар түүнийг тойрно...” мөрөөр нарны Аллахын Элчийн удган эрвээхий болоод тойрсныг, өөрөөр хэлбэл бодис эрхэсийн Түүнд хайртай буйг маш сайхан илэрхийлнэ.

Мухиббий хучаараа бичсэн Кануний Султан Сүлэйман нь Оршигчдын Туяанаас ингэж гуйна:

Чи хорвоогийн од туяа, бас Аллахын ч амраг
Амрагуудаа хаалганаасаа хоромхон ч битгий холдуул…

Хазрат-и Али -радъяллахү анх- ингэж хэлнэ:

“Би Маккад Аллахын Элчийн хамт явдаг байлаа. Нэгэн өдөр хоёулаа Маккагийн гадаа гарав. Хажуугаар нь өнгөрсөн чулуу ба мод бүр нь Түүнд «Салат ба салам Чамд болог, аяа Аллахын Элч ээ!..» гээд ёсолж эхлэв.” (Тирмизий, Мэнакиб, 6/3626)

Байгаль дахь энэ хайрын өөр нэгэн илрэлт нь ингэж толилуулсан байдаг:

Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм- нэгэн аяндаа тааралдсан нэгэн бадавийд тэвхидийг тэвлиг хийв. Бадавий нь Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн энэ урилгын тухай Түүнээс нэгэн баталгаа нэхэв. Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм- ч цаанах нэгэн модыг зааж түүнийг хажуудаа дуудав. Мод нь шууд Пайгамбарын тушаалыг дагаж хөрсийг хагалан ирээд Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн онгонд кэлимэ-и шэхадэтийг гурав дахив. Дараа нь дахиад Пайгамбарын тушаалаар байрандаа харив. Энэ гайхамшгийг санаа алдан гэрчилсэн бадавий нь аймагтаа харихдаа ингэж хэлж байв:

“–Хэрэв миний аймаг намайг дагаж ирвэл тэднийг Чамд авчирна, эс тэгвэл би дахиад ирээд Чамтай хамт болно.” (Хэйсэмий, VIII, 292)

Зөвхөн эрхэс бодис биш, адгуус ба бусад оршигчид ч Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийг таньж бууж өгдөг байв. Энэ тухай Жабир бин Абдуллах -радъяллахү анхүүнийг дамжуулан ярина:

“Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн хамт нэгэн аянаас харьж байлаа. Мадинад Нэжжарынхны цэцэрлэгийн нэгэнд хэнийг ч дотогш оруулахгүй, орохыг хичээснийг дайрдаг нэгэн тэмээ буйг мэдлээ. Үүнийг Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-д яриад өгөхлөөр Тэр Орчлонгуудын Эзэн нь цэцэрлэгт очоод дотогш орсон ба хэнийг ч ойртуулахгүй тэр тэмээг хажуудаа дуудав. Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн дууг сонссон тэмээ нь уруу-

лаа газар түрхэх чинээ толгойгоо бөхийлгөн Түүний дэргэд ирээд онгонд нь дөхөв. Аллахын Элч -саллаллахү алэйхи вэ сэллэм-:

«–Надад нэгэн ногт авчраарай!» хэмээв.

Ирсэн ногтыг тэмээний хүзүүнд зүүж түүнийг эзэнд нь гардуулав. Дараа нь тэнд буй хүмүүст ингэж айлдав:

«–Жин болон хүмүүсээс гадна тэнгэр газар хоёрт буй хамаг оршигчид намайг Аллахын Элч буйг мэддэг.»" (Ахмад, III, 310)

Байгаль орчин ба адгуусны энэ агуу хайрт байдалтай харьцуулбал бид өөрсдийгөө Аллахын Элчид хэр бууж өгдгөө бодох хэрэгтэй.

Ялангуяа энэ өдрүүдэд Түүний сүнсний байдал бидэнд маш их хэрэгтэй... Бид нар шүлэгчийн: "Бос аяа Орчлонгуудын Эзэн; Киямат тэсэрч эхлэв!.." гээд илэрхийлсэн замбараагүй эрин дотор байна...[368]

Бидний салават буюу Түүнийг ёслох үгс ба Түүний хайр маань бидний хувьд тайтгарлын том булаг юм...

Уяхан зүрхэт элдэг итгэгчид нь Расулаллахын үнэнд дөхөж чадахаар Түүний сүнсний сургаалыг удган эрвээхий мэт тойроод үгүй болохыг дэлхийн хамгийн том шимээр тоолон тэнгэрлэг олон амтыг автсан байдаг.

368. Уг үнэнийг ухаарсан өрнөдийн гүн бодогч Бернард Шоу ингэж хэлнэ: "Олон асуудал дээшээ өргөж овоолсон манай эринд, бид хамаг асуудлыг нэлээд амар ба хялбараар шийдсэн Хазрат-и Мухаммедын хэрэгцээтэй."

Энд үгсийн хязгаарт боломжтойгоор товчлохыг хичээсэн уг агуу туурвилын шинж тэмдэг нь Оршигчдын Туяаны бидний оюун ухаанд дуссан чийг юм. Аллахад хүрэх нууц нь Аллахын ном ба Оршигчдын Туяаны сүннэтэд буюу өндөр ёс суртахуун ба хандлаганд нь чин сэтгэлээрээ дөхөх, Аллах ба Элчийнх нь хайрласныг хайрлах ба хайрлахгүйг хайрлахгүй гэсэн үг юм. Уг хоёрын хоорондын ялгаа нь дээрийн хамгийн дээд ба доорын хамгийн доод хоёрын хоорондын ялгаа шиг эцэсгүй байдаг. Аллахын Элчийн мэдрэмжийг ашиглахын гол арга нь Түүнийг хайрлах ба Түүний эсрэгт нь өших юм.

Түүхийн турш Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн үсвэ-и хасэнэгээс хувь авсан ариун итгэгчид нь итгэл үнэмшилтэй холбоот төгс өгсөхөө оргил болгосон, туурвилын жаргалыг залуужуулан хүн төрөлхтний агуу бамбарууд болсон байдаг.

Тус чадалгүй зохиолчийн Мухаммедын үнэний тухай оюун ухаан ба хэрэглэж чадсан үгсийн хязгаарт хүрээнд багтсан нь эдгээр юм!..

Энэ өчүүхэн бүтээлийн хоёр хавтасны хооронд ба үгээр хандсан хүмүүст мэдэгдсэн нь эцэсгүй нэгэн далайн хэдхэн дусалтай тэнцэх буйг хэлье. Тэгээд эдгээр үгс, ёроолгүй чимээгүйдлийн содон үүдэн дээр ийнхүү барагдав...

Аяа Раббий! Үгсийн хязгаарт боломжоор ярихад зорилго гаргасан энэ сэдвийг бидний тухай нэгэн энэрэл ба элбэгийн учир болгож Мухаммедын үнэнээс хувь авч чадахыг шимлэн хайрлах болтугай! Бид нарыг хайрын цөм ба булаг буй Расулаллах -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн шэфаатад хүртэх болтугай!

Амин!..

ТӨГСГӨЛИЙН ҮГ

Ислам нь дэлхийн түгээмэл нэгэн үзэл бодол байсан улмаас дотроо хууль, ёс суртахуун, эдийн засаг мэтийн хүний харилцааг цэгцэлсэн хамаг ухаантай хамаатай дүрэм журам агуулсан шашин юм. Энэ дүрэм журмын хамгийн эгэлээс нь хамгийн төгс нь, хамгийн хувийнхаас хамгийн түгээмэл нь хүртэл хамаг хэргийг агуулах нь шаардлагатай юм. Исламын эдгээр дүрэм журмын зарим нь хүн бүрийг хамаарах эгэл ба өдөр тутмын хэрэг байсан ч, зарим зарчим ч агуу ухаантныг ч чадалгүй орхих чинээ агуу гүнзгийг агуулсан үнэн юм. Ийнхүү хэргийг -ялангуяа таньдаггүй хүлээн авагчдад хандахыг хангасан ном болгож- шинжлэхийг бэрхийг тайлбарлах хэрэггүй бололтой.

Энэ ажил нь нэг талаараа налууд гарах ба цагнахад бэлэн болох л гэсэн үг юм. Андашгүй нь энэ үнэнийг оюун, шинжлэх ухаан ба хэлний боломжоор илэрхийлэхийг хичээх нь олон хүний больж чадаагүй нэгэн үйл ажиллагаа болсон ч, үүнд төгс утгаар нь амжилтад хүрэх боломжтой биш юм.

Нөгөө талаас энэ сэдвүүд хүний чадварыг давсан ч, бүхний олоогүй юмын бүтнээр нь орхихгүй нь буюу олсныг орхих хэрэггүй нь ч Исламын нэгэн зарчим юм. Хүндэт уншигчдаасаа, биднийг үүнийг дагасныг бодож, тайлбар дутууг өршөөхийг найдан гуйя.

Мөн хүний оюун ухаан нь энэ хорвоогоос авсан үзэгдлээр хэрэгжихийг илэрхийлье. Үүнээс үзвэл лав утгаар нь гэрчлэхийн аргагүй нууц үнэний тухай алдаа хийхгүй эсвэл тэдний тухай дутахгүй нь боломжгүй байдаг шигээ, туурвилын гайхамшиг буй Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэмийн үнэн ба тэнгэрлэг үгсийн төгс илрэл нь буй Кур'аныг энгийн хүний чадвараар төгс төгөлдөр ухаарах ба тайлбарлах нь ч боломжгүй байдаг. Жишээлбэл диваажин, там ба төсөөт ойлголтууд нь үнэнийг нь зөвхөн Аллах Таалагийн оюун ухаанд байдаг зарим байдлыг бидний оюун ухааны дагуу илэрхийлсэн үгс л байдаг юм. Шашны метафизик үнэний тухай ухаан ба чин сэтгэлээр хийсэн хамаг шинжилгээ нь зөв байсан ч дутуу байдаг. Зөв байдаг; энэ хорвоогоос авсан гэрчилгээний дагуу тайлбарлах нь энэ чинээ байж болно. Дутуу байдаг; энэ хорвоод гэрчилсэн төсөөт шинж тэмдэгтэй тэднийг зүйрлэн ухаарснаа бодсон үнэний хоорондын ялгаа нь мөнх үржүүлсэн мөнхтэй тэнцүү байдаг. Ийм үнэний төлөө өөр нэгэн оюун ухаан, тайлбар, боломж ба багаж л хэрэгтэй байдаг. Жишээлбэл "рү'етуллах"... Ахиратад итгэгчдийн төлөө хэрэгжих шинжийг "рү'ет" гэсэн үгээр тайлбарлах буюу илэрхийлэх нь дутуу байдаггүй юү? Аргагүй нь дутуу юм, харин өөр тайлбарлах арга байдаггүй.

Ийм учраас хүмүүсийн, үнэнийг нэгэн далай шиг уужим гэж түүнд живүүлсэн савны хэмжээнээс илүүг авах нь боломжтой биш юм! Нэгэн аяганд тэнгисийг багтаах нь аргагүй байдаг шигээ... Хэл ч нэгэн сав, тархи ч нэгэн сав, үзэхдээ нүд ч нэгэн сав гм... Бүгд чадваргүй!

Энэ тухай Аугаа Эрх ает-и кэримэд хүний оюун ухаанаар ойлгох аргагүй содон байдлаа ингэж илэрхийлдэг:

قُل لَّوْ كَانَ الْبَحْرُ مِدَادًا لِّكَلِمَاتِ رَبِّي لَنَفِدَ الْبَحْرُ
قَبْلَ أَن تَنفَدَ كَلِمَاتُ رَبِّي وَلَوْ جِئْنَا بِمِثْلِهِ مَدَدًا

“Ингэж хэл: Раббын минь үгсийн төлөө далай нь бэх болоод, төдий чинээ мэдсэн ч, Раббын минь үгсийг дуусахаас өмнө далай барах болно.” (эл-Кэхф, 109)

Мөнх үргэлжлэх мөнх тэнгэрлэг суутны дэргэд хүний савны хэмжээс хэд болохыг нэг бодох хэрэгтэй.

Нөгөө талаас оюун ухааны дутагдлаас болж үнэнийг хязгаарлаж ч болохгүй биз!..

Бас үг бүрийн агуулсан утга, түүнийг илэрхийлсний оюун ухааны чинээ ойлголтыг дамжуулж мэднэ. Гэтэл зарим ойлголтын далд утга эцэсгүй гүн байдаг. Жишээлбэл Аллах, хорвоо, сүнс гэх мэт… Эдгээрийг ярих ба бичигт хэрэглэгсэд нь оюун ухааныхаа хэр чинээгээр ойлгож чадна. Уншигчдын ойлголтыг ч үүнтэй харьцуулах хэрэгтэй юм.

Ийнхүү мөрөөдлийн цаад гүн гүнзгий ойлголтын зарим нь ч Хазрат-и Пайгамбар -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн ариун нэрүүд юм. Тэр нэрүүдийн агуулахыг дамжуулах бидний чадваргүйг ба үнэт уншигчдын маань ойлгох хэр хэмжээ хүрэмжгүйг өршөөхийг Раббынхаа энэрлээс найдаж ч хүсч ерөөж ч байна.

Бид ийм байдалд үнэний талаар хамгийн өргөн боломжийг агуулсан чимээгүйдэлд харьж үгийг энд цэглэх ёстой...

Бидэнд Орчлонгийн Хүндэт -саллаллахү алэйхи вэ сэллэм-ийн сүнсний сургаалыг сонсохоос өөр арга үгүй юм! Аргагүй бүрийн ганцхан арга нь Аллах Таала юм.

Хүч чадалгүй далайд “туслаарай аяа Раббий!..”

Дахилэк аяа Расулаллах!..

ГАРЧИГ

ХИЖРЭТИЙН АНХНЫ ЖИЛ / 7

Расулаллах Мадина-и Мүнэввэрэд Анх Суурьшсан нь 7

Михмандар-и Расул:
Эбү Эйюб эл-Энсарий -радъяллахү анх- 9

Энэс бин Малик -радъяллахү анх-
Манай Эзэнд Үйлчилсэн нь 11

Мэхажир болон Энсарын Хоорондох Найрамдлын Гэрээ:
Муахат 14

Мухажирчууд болон Энсарын Эрдмүүд 18

Мадинатү'н-Нэбий ба Мадинагийн Баримт 32

Мадинад Харам Зарласан нь 38

Мадинагийн Зах ба Худалдааны
Харилцааг Зохицуулсан нь 40

Мэсжид-и Нэбий ба Жаргалын Гэр 45

Хамтын Мөргөлийн Урам 56

Анхны Эзан 61

Асхаб-и Сүффэ: Ухаан ба Хүмүүжлийн Сургууль 65

Пайгамбар Эзэн Хазрат-и Аиша Эхтэй Гэрлэсэн нь 73

Мадинагийн Байдал 75

Дайнд Зөвшөөрөл Олгосон нь:
“Танд Дайн Зарлавал Та ч Дайн Зарла!” 80
Аллахад хүрэх жихад зам. 85
Зарим Харуул 94

ХИЖРЭТИЙН ХОЁР ДАХЬ ЖИЛ / 98

Зарим Газванууд ба Батн-и Нахлэгийн Аян Дайн 98
Киблаг Өөрчилсөн нь 102
Мацаг, Фитр Хандив ба Зэкат 107
Итикаф 120
БЭДИРИЙН ТОМ ГАЗВА
(Хижрэтийн тооллын 2 оны Рамазан сарын 17 / 624.3.13) ...122
Мэлэкүүдийн Тусламж 141
Бэдирийн Арслангууд 147
Бэдирээс Харьсан нь 153
Олзны Хүмүүст Хандах нь 155
Олзны Хүмүүсийн Тухай Шийдвэр 167
Шэхадэт Цол 170
Пайгамбарын маань Охин Хазрат-и Зэйнэб
Мадинад Ирсэн нь 177
Еврейчүүд ба Бэний Кайнука Газва
(2 оны Шэввад / 624 оны 4 сар) 180
Сэвикийн Дайн (2 оны Зилхижжэ / 624 оны 5 сар) 187
Хазрат-и Али ба Хазрат-и Фатимагийн Гэрлэсэн нь 188
Эхл-и Бэйт ба Эхл-и Бэйтийн Хайр 194

ХИЖРЭТИЙН ГУРАВ ДАХЬ ЖИЛ / 198

Сургаалаар Дүүрэн Нэгэн Дайн:
УХУДЫН ГАЗВА (3 Оны Шэввал сарын 7 / 625.3.23) 198
Асхабын Шэхид Болох Хайр 201
Шэхидчүүдийн Тэргүүн Хазрат-и Хамза 208
Шалтгааныг Хаасан Сахабий: Са’д бин Рубий 221
Ухудын Шэхидчүүд 222
“Бид Ухудад Хайртай, Ухуд ч Бидэнд Хайртай!” 231
Ухудын Газванаас Гаргах Учир Ухаан 232
Хамрау’л-Эсэд
(3 оны Шэввал сарын 8 / 625 оны 3 сарын 24) 234
Өв Хөрөнгийн Тухай 237

ХИЖРЭТИЙН ДӨРӨВ ДЭХ ЖИЛ / 241

Рэжий Явдал нь (4 оны Сафэр / 625 оны 7 сар) 241
Би’р-и Маунэ Явдал (4 оны Сафэр / 625 оны 7 сар) 247
Бэний Надирын Урвагч Төлөвлөгөө 250
Согтууруулах Ундаа ба Мөрийг Хориглосон нь 258
Затү’р-Рика (5 Мухаррам / 626 оны 6 сар) 263
Бэдр-и Сугра (4 Зилкадэ / 626 оны 4 сар) 269

ХИЖРЭТИЙН ТАВ ДАХЬ ЖИЛ / 272

Сэлман-и Фарисий Мусульман Болсон ба Эрх Чөлөөндөө
Хүрсэн нь 272
Тэбэнний буюу өргөхийг Цуцалсан нь 281
Тэсэттүр буюу Хувцаслан Далдлахыг Фарз Болсон нь 285

Мүрэйсийгийн Газва
(5 оны Шабан-Рамазан сар / 627 оны 1-2 сар) 288
Тэеммүм 292
Ифк (Гүтгэлэг) Асуудал 293
Дайснаас Болгоомжил! 303
Тэвчээрийн Цаанах Төвөг ба Зовлон Дээр Зовлон: ХЭНДЭК
ГАЗВА (5 оны Шэввал-Зилкадэ / 627 оны 3 сар) 308
Шуудуунд Сонссон Сайхан Мэдээ 312
Хазрат-и Жабирын Элбэг Хоол 314
Шуудуунд туулсан зовлон 318
Шуудуунд байгуулсан баатарлаг гавьяа 322
Дайн нь Мэх юм 327
Бэний Курайзагийн Дайн
(5 оны Зидкадэ сарын 23 / 627 оны 4 сарын 15) 330

ХИЖРЭТИЙН ЗУРГАА ДАХЬ ЖИЛ / 336

Ялалтын Түлхүүр: Хүдэйбиегийн Гэрээ
Кабагийн Санаагаар Гарсан Зорчил 336
Бий'атү'р-Ридван: Аллахын Таатай Болсон Бий'ат 341
Хүдэйбиегийн Гэрээ: Урилгын Шинэ Шат 344
Фэтх-и Мүбин: Дахин дахин нэмсэн элбэг аврал 353

ХИЖРЭТИЙН ДОЛОО ДАХЬ ЖИЛ / 359

Эзэн Хаадыг Исламд Урьсан нь 359
Еврейчүүд Пайгамбар Эзэнд маань Хараал Хийсэн нь 382
Урвагч Еврейд Буулгасан Сүүлийн Цохилт: ХАЙБАРЫН
ЯЛАЛТ (7 оны Сафэр-Рабиулэввэл / 628 оны 6-7 сар) 384

Боолын Эрхийн Тухай Хатуу Чанга Чамбай Байх нь 394
Дэвсчүүд Мадинад Ирсэн нь 397
Абиссинийн Нүүдэлчид Харьсан нь 398
Еврейчүүд Пайгамбарыг Хорлосон нь 400
Мут’а гэрлэлтийн тухай 402
Хайбараас Буцахдаа 404
Үмрэтү’л-Каза (7 оны Зилкадэ сар / 629 оны 3 сар) 407

ХИЖРЭТИЙН НАЙМ ДАХЬ ЖИЛ / 414

Пайгамбар Эзний маань Охин Хазрат-и Зэйнэб Нас Барсан нь ..414
Сахабий Бичсэн Домог: МҮТЭГИЙН ДАЙН (Жэйшү’л-Үмэра) (8 оны Жэмазиелэввэл сар / 629 оны 8-9 сар) 415
Халид бин Вэлидийн Удирдах Мэдэл 424
Үнэн Ирээд Төөрөг нь Нурав: МАККАГИЙН ЯЛАЛТ (8 оны Рамазан сарын 20 / 630 оны 1 сарын 10) 428
Өршөөлийн Баяр 444
Маккачуудын Бий’ат 450
Итгэмжтэй Хүнд Өгөөрэй! 452
Ижилгүй Өгөөмөр Сэтгэл 457
Хүнэйний Газва (8 оны Шэввал сарын 11 / 630 оны 2 сарын 1) .459
Эвтасын Дайн (8 оны Шэввал сар / 630 оны 2 сар) 465
Таифын Бүслэлт (8 оны Шэввал / 630 оны 2 сар) 465
Олз Хуваах 468
Нэгэн Мусульманыг Алах Ял 479
Маккад Захирал ба Багш Томилогдсон нь 482

ХИЖРЭТИЙН ЕС ДЭХ ЖИЛ / 485

Хэлэн Сэлэм 485
Фасикын Мэдээг Сайхан Судал! 491
Итгэл Үнэмшлийн Шалгуур: ТЭБҮКИЙН АЯН ДАЙН
(9 оны Рэжэб сар / 630 оны 10-11-р сар) 493
Инфакын Хөдөлгөөн 503
Саатү'л-Үсрэ: Бэрхшээлийн Цаг 508
Тэбүкийн Шэхид 518
Мүнафикчуудын Урвалт ба Мэсжид-и Дирар 521
Бага Жихадаас Их Жихадад 523
Хойно Үлдсэн Гурван Сахабий 524
Тэнгэр Газар Хоёрын Баялаг Сан нь Аллахад Харьяалагдана ...532
Мөргөл Үйлчилгээгүй Шашинд Буян Үгүй! 533
Тэбүкээс Харьсны Дараах Бусад Явдал 537
Элч Нарын Жил 540
Хажийн Фарз 544

ХИЖРЭТИЙН АРАВ ДАХЬ ЖИЛ / 548

Адий бин Хатим Мусульман Болсон нь 548
Оршигчдын Туяаны Анхны ба Сүүлийн Хаж:
САЛАХ ХАЖ 551
Өнөөдөр Таны Шашныг Төгс Төгөлдөр Болгосугай 565
Зовлон Шаналал Илэрсэн Газар 567

ХИЖРЭТИЙН АРВАН ГУРАВ ДАХЬ ЖИЛ / 573

Учрах ба Хагацал:
"РЭФИК-И А'ЛА" ӨӨД АУГАА ЗОРЧИЛ 573

Орчлон Дүүрэн Гуниг 594

ҮСВЭ-И ХАСЭНЭ (Төгс Жишээ) / 603

ТӨГСГӨЛИЙН ҮГ / 620

БЕСПЛАТНЫЕ ИСЛАМСКИЕ КНИГИ В ФОРМАТЕ PDF

ВЫ МОЖЕТЕ СОВЕРШЕННО БЕСПЛАТНО СКАЧАТЬ **900 ИСЛАМСКИХ КНИГ НА 48 ЯЗЫКАХ!**

Наши книги на различных языках ожидают вас на сайте islamicpublishing.net

Вы можете читать наши книги, скачав их БЕСПЛАТНО на ваш компьютер, и переслать своим знакомым по электронной почте. Регистрация не требуется.

Наша бесплатная акция проводится с целью ознакомления и продолжится 1 год.

Русский - Английский - Французский - Немецкий - Арабский - Казанско-Татарский - Киргизский Башкирский - Узбекский - Итальянский - Испанский - Латышский - Литовский - Португальский - Таджикский Уйгурский - Китайский - Украинский - Азербайджанский - Хинди - Малайский - Румынский - Бенгальский Боснийский - Болгарский - Венгерский - Волоф - Крымскотатарский - Голландский - Грузинский - Хауса Казахский - Албанский - Луганда - Турко-Месхетинский - Монгольский - Моуринский - Суахили Традиционный Китайский - Тви - Туркменский - Амхарский - Тигринья - Зарма - Индонезийский

www.islamicpublishing.net

ИЗДАТЕЛЬСВО ЭРКАМ